



ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН
УРАЛДААНЫ ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2024 он



ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН
УРАЛДААНЫ ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2024 он

ГАРЧИГ

Өмнөх үг.....	4
Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажилд хиймэл оюун ухааныг ашиглах боломж.....	5
Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний талаарх зарим асуудал	15
Хоригдлын хугацаанаас өмнө суллагдах боломж, түүнийг боловсронгуй болгох асуудалд	25
Хорих ялын уламжлал, шинэчлэл ба хүний эрхийн зарим асуудал	39
Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, үзэл баримтлал ба хүүхдийн эрхийг хангах асуудал.....	51
Хаалттай дэглэмийн тусгай нэгжид хорих ял эдэлж буй хоригдлын эрх, түүний эрх зүйн зохицуулалт.....	61
Нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарах асуудал.....	71
Хорих ял эдлэх хугацаа дуусаж суллагдах дөхсөн, эсхүл хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох хуулийн шаардлага хангасан хоригдлыг нийгэмшүүлэх тусгай байрыг хорих ангид бий болгох хэрэгцээ шаардлага	83
Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааны хүний эрхийн асуудал.....	94
Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн асуудал	106
Цагдан хорих, баривчлах, саатуулах шийдвэрийг биелүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн тулгамдсан асуудал.....	115
Нийтэд тустай ажил хийлгэх ял, хүний эрхийн зарим асуудал	124
Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаа дахь хүний эрхийн асуудал.....	135
Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоох ажиллагааны эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал	141
Ялын онол, үзэл баримтлал дахь хүний эрхийн асуудал (Зорчих эрхийг хязгаарлах ялын жишээн дээр)	149
Хоригдлын түр болон удаан хугацааны уулзалт авах эрх, тулгамдаж буй асуудал ..	156
Цагдан хорих байранд гарч буй зөрчлийн шалтгаан нөхцөлд хийсэн дүн шинжилгээ	165
Хорих ялаас хугацааны өмнө суллах асуудал ба хүний эрхийн зарим асуудал.....	172

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг орон нутагт эдлүүлэхэд тулгарч буй хүний эрхийн асуудал	177
Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах асуудал..	183
Ял эдлүүлэх үйл ажиллагаан дахь хүний эрхийн зарим асуудал	190
Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн асуудал..	205
Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: Зорчих эрхийг хязгаарлах ял.....	210
Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хийсэн судалгаа.....	218
Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаа дахь хүний эрхийн асуудал.....	232
Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг боловсронгуй болгох зарим арга зам.....	237
Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал.....	243
Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийг хангах асуудал	251
Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах ажиллагааны ач холбогдол.....	262
Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт (Баянзүрх дүүргийн жишээн дээр)	269
Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн зөрчлийг арилгах зарим асуудал	273
Эрх хасах ял эдлүүлэх ажиллагаанд тулгарч буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам.....	280
Нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөөг сайжруулах зарим арга зам	284
Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа ба түүнд тавих прокурорын хяналт, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах нь	289
Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн асуудал.	298

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд прокурорын мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулахаар туссан билээ.

Зорилтын хүрээнд ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих чиглэлээр ажиллаж байгаа прокуроруудын мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх санал, санаачилгыг дэмжих, хяналтын ажлын үр нөлөөг сайжруулах, хүний эрхийг нэг мөр хангуулах арга замыг эрэлхийлэх зорилгоор “Ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн онол, практикийн асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг Улсын ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс, Сургалт, судалгааны хүрээлэн хамтран зохион байгууллаа.

Илтгэлийн уралдаанд аймаг, нийслэл, дүүрэг, сум дундын прокурорын газрын ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих ахлах болон хяналтын прокурорууд бүрэн оролцсоноос гадна бусад прокурор, туслах ажилтнууд идэвхтэй оролцож, удирдамжид заасны дагуу илтгэл бэлтгэн ирүүлжээ.

Ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийг хангах, хамгаалахтай холбоотой онол, арга зүйн болон хууль хэрэглээ, хяналтын ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх, тулгамдсан асуудлын шийдлийг эрэлхийлсэн 50 гаруй илтгэл ирүүлснээс удирдамжид заасан шаардлага хангасан 35 илтгэлийг эмхэтгэл болгон Та бүхэнд толилуулж байна.

Эмхэтгэлд багтсан илтгэлүүдэд хяналтын ажилд шинэлэг арга барилыг нэвтрүүлэх, хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тогтоолын биелэлтийг хойшлуулах, албадлагын арга хэмжээ авах, цагдан хорих, баривчлах шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалахтай холбоотой асуудлыг судалсан судалгааны үр дүн орсон байгаагаас дүгнэн үзэхэд прокурор, ажилтнуудын судалгааны арга зүй сайжирч, цаашид шинжлэх ухаан, судалгааны үр дүнд тулгуурлан хяналтын ажлыг үр нөлөөтэй явуулах эерэг хандлага ажиглагдаж байгаа нь сайшаалтай.

Илтгэлийн уралдаанд илтгэлээ ирүүлсэн, амжилттай оролцсон прокурор, ажилтнууддаа талархал илэрхийлж, ажлын амжилт хүсье.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ТУСЛАХ ПРОКУРОР, ЯЛ ЭДЛҮҮЛЭХ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ
ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.ЭНХТӨР

ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН АЖИЛД ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫГ АШИГЛАХ БОЛОМЖ

Нийслэлийн Прокурорын газрын хяналтын прокурор Г.Чагдар

Хураангуй:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд прокурор хиймэл оюун ухааныг ашиглан дэвшилтэд технологийг хэрэглэх нь ялтан, хоригдлын талаарх холбогдох хууль, Олон улсын гэрээнд заасан эрх, үүргийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, аливаа төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг богино хугацаанд сэргээх, хангах, хамгаалах, нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэгт холбогдохгүй байх, хууль сахиулах байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо сайжирч, төрийн албаны шуурхай байдал хангагдах чухал ажил болно.

Түлхүүр үгс:

Хиймэл оюун ухаан, прокурорын байгууллагад дэлхийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, прокурор хүний мэргэжлийн ур чадвар олон улсын түвшинд танигдах, хорих байгууллагын дэглэм, нөхцөл болон хоригдлын ял эдлэлтийн байдал “smart” болж, нийгэмшүүлэх ажлын чанар, үр дүн сайжрах гэх мэт.

Удиртгал

Хүн төрөлхтөн агнасан ангаа гал ашиглан борлуулж идэж эхэлсэн хүний хөгжил 100 мянган жилийг туулж өнгөрүүлсэн бол шинэ чулуун зэвсгийн үеэс мал аж ахуй, газар тариалан үүсэн хөгжсөн “неолитын эрин үе” 12 мянган жилийг туулжээ.

Бидний амьдарч буй өнөө үе бол 2010 оноос эхэлсэн аж үйлдвэрийн IV дүгээр хувьсгал явж байна. Аж үйлдвэрийн III дугаар хувьсгалын хоёрдугаар хагаст шинжлэх ухаан- мэдээллийн буюу дижитал хувьсгал эхэлж эдүгээ хиймэл оюун ухаанд байр сууриа тавьж өгч эхэлж байна.¹

Хүн ба робот, бодит ба бодит бус хийсвэрийн ялгаа арилж, дэлхий нийтэд шинжлэх ухааны бүх салбарт ямар нэг хэлбэрээр хиймэл оюун ухаан давамгайлах шинжтэй байна. Одоогоос 2.5 мянган жилийн өмнө гүн ухаантан Пифагор “Бүх зүйлийг тоо илэрхийлнэ” гэжээ. Тухайн үед хэн ч ойлгосонгүй. Өнөөдөр бид тоон хувьслын үед амьдарч “Дижитал хүн” болон төлөвшиж байна. Тоон орон зайд тоон иргэн, тоон сургууль, тоон мөнгө, тоон эдийн засаг бий болж, роботууд нэхэмжлэл бичиж, роман уншиж, хөгжим зохиож, аль ч хэлнээс орчуулга хийж, хүний сэтгэшгүй их мэдээллийг боловсруулж байна.

2030 он гэхэд нэг хүний тархи нөгөө хүний тархитай компьютерын тусламжтай холбогдох зарчимд үндэслэсэн шинэ Web 4.0 -р солигдох ирээдүй харагдаж байгааг судлаачид хэлж байна. Мэдээллийн хувьслын энэ үед хүн төвтэй эрин үе үгүй болж мэдээллийн шинэ эрин дунд монголчууд бид дэлхийн энэ хөгжлийн гадна үлдэх боломжгүй юм.

Монгол Улсын Их хурал 2015 оны 11 дүгээр сард “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль” батлан гаргаж, энэхүү хуульд “Төрөөс баримтлах бодлого

¹ “Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн сэтгүүл. 2020 он №03

гэж Монгол улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, түүнд заасан тэргүүлэх чиглэлийн хүрээнд салбарын болон салбар хоорондын хөгжлийн бодлогын зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлно “ гэж заасан.²

Төрөөс “Алсын хараа –2050 “ гэх нэртэй урт хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулж суурь 9 зорилго, хөгжлийн 50 зорилттой бөгөөд Монгол улсын 2050 он хүртэлх ирээдүйн гучин жилийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх чиглэлүүдийг төлөвлөсөн байна.³

Уг зорилтод зааснаар гэмт явдалтай тэмцэх чиглэлээр уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн -нийгмийн амар тайван орчныг хангаж, хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын үүрэг гүйцэтгэх чадавхыг олон улсын түвшинд өрсөлдөх хэмжээнд хүргэх зорилтыг дэвшүүлсэн.

Социалист системийн үед ял бол гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн хэрэгсэл гэж дүгнэн МАХН-н төв хорооноос ялыг чангаруулах замаар гэмт хэргийг бүрэн устгах тухай зорилт дэвшүүлж байсан баримт байгаа. Энэ үзэл санааны нөлөөгөөр хүмүүсийн ухамсарт гэмт хэрэг үйлдсэн хүн бүрийг “шоронд хийдэг “ гэх хатуу ойлголттой байсан, одоо энэ ойлголт бага зэрэг өөрчлөгдсөн.

Гэтэл хөгжингүй зарим орнуудад шоронд ял эдэлж суллагдсан этгээдийг шүүхээс гэм буруугүй, ялтайд тооцохгүй гэсэн шийдвэрийг гаргаж хүний эрхийг хангаж, хорих ангиас суллагдсан хүмүүст зориулсан сургалтын хөтөлбөрүүдэд хамруулах, нийгэмшүүлэх тусгай журмын тухай хууль үйлчилдэг байна. Мөн шоронгоос суллагдсан хүмүүсийг нийгмийн амьдрал руу нь хөтлөн оруулах үүргийг төрийн бус байгууллага, иргэний байгууллага, өрх гэр, хөршийн холбоод шүүх болон шийдвэр биелүүлэх байгууллагуудтай байгуулсан гэрээг үндэслэн хариуцан ажилладаг байна.⁴

Дээрх ажлын хүрээнд прокурорын байгууллагаас олон шинэлэг ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд энэ удаа зөвхөн хорих ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихдаа бид ямар ажлыг төлөвлөн хийж болох талаар санал дэвшүүлэх, ял эдлүүлэх ажиллагааны онол, арга зүй, зарчим энэхүү сэдвийн хүрээнд тодрох мэдээллээр ирээдүйд өөрчлөгдөх хандлагатай тул энэ сэдвийг сонирхон авч сонгон судаллаа.

Энэхүү сэдвийн хүрээ хорих ял эдлүүлэх харилцааг хамрах хэдий боловч хиймэл оюун ухааныг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа эсэх талаар Монгол Улсад өмнө нь төдийлөн сайн судлагдаагүй тул холбогдох материал, мэдээлэл маш хомс байсныг дурдах нь зүйтэй. Иймд хорих ял эдлүүлэх ажиллагаанд прокуророос хэрхэн технологийн дэвшлийг ашиглан хяналт тавьж болох бэ гэдэг асуултад хариулт олохын тулд гадаадын зарим орны хорих байгууллагын үйл ажиллагаанд хиймэл оюун ухааныг яаж ашиглаж, тухайн орны прокурорын байгууллагаас хэрхэн хяналт тавьж байгааг харьцуулан судлах байдлаар, мөн өмнө нь уншиж судалж байсан гадаадын зарим сайт дээр бичигдсэн мэдээ, мэдээлэлд дүгнэлт хийх байдлаар өөрийн саналыг тусган энэхүү илтгэлийг бичлээ.

² Хөгжлийн бодлогын тухай хууль

³ Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого

⁴ <http://www.baabar.mn/article/3986> Амьдралын хулгай нийтлэлээс

Үндсэн хэсэг

AI-н тухай ойлголт Хиймэл оюун ухаан (artificial intelligence - AI) гэж хүний адил тодорхой зорилтыг биелүүлэх чадвар, ухаалаг эргэцүүлэл, учир зүйн үйлдлийг тооцоолон бодох болон бусад хиймэл байгууламжийн тусламжтайгаар мэдээллийг сэргээх, сэтгэн бодох алгоритм бүхий робот -компьютер юм. Өөрөөр хэлбэл одоогоор AI нь харааны мэдрэмж, оюун ухааныг таних, шийдвэр гаргах, хэл хоорондын орчуулга зэрэг хүний оюуны үйл явцыг дуурайхаас илүүг одоогоор хийж чаддаггүй гэнэ. Цаашид тун удахгүй AI –тай робот, машин нь өөрөө сэтгэдэг, өөрийгөө хөгжүүлдэг, сэтгэл хөдлөлийг илэрхийлдэг болно гэж олон улсын судлаачид бичиж байна.

Өндөр хөгжилтэй, богино хугацаанд цахимжсан нийгэмд шоронгийн системүүд мөн хурдацтай дижитал болж байгаа бөгөөд энэхүү хөгжлийн хамгийн сүүлийн жишээ бол аюулгүй байдлын техник, хоригдлуудад чиглэсэн менежментээр хэрэгжсэн AI шийдлүүд байна.⁵

Гадаадын зарим улсын хорих байгууллагад хэрэгжиж буй AI нь 2 үндсэн чиглэлээр хөгжиж байна. Үүнд: Нэгдүгээрт аюулгүй байдал, тандалтын үйл ажиллагааны технологи, хоёрдугаарт хоригдлуудын ял эдлэлтийн байдал, эрүүл мэнд, санхүү гэх мэт мэдээллүүдийг боловсруулах, нэгтгэн дүгнэх программуудыг ашиглаж байна.

Тухайлбал: Өмнөд Солонгос улсад роботуудыг хоригдлуудын хүчирхийлэл, амиа хорлох эрсдэлийг хянах зорилгоор харуул хамгаалалтын ажилтны ажлын ачааллыг бууруулахад ашиглаж байгаа бол АНУ-ын Алабама дахь хорих ангиудад хоригдлуудын утасны яриаг бөөнөөр хянах системийг ашиглаж хэл, яриа таних программаар гэмт хэрэг үйлдэхээр төлөвлөж буй олон төрлийн эрсдэл бүхий аюулыг багтаасан сэжигтэй дуудлагыг илрүүлдэг, ганцаарчилсан хоригдлын хямралыг шийдвэрлэхийн тулд Амазон компанийн Alex-тай адил ухаалаг туслахуудыг хоригдлуудад “Хоригдох хамтрагч” болгон ажиллуулж байна.

Мөн зураг болон хэв маягийг таних технологиуд нь Энэтхэг улсын зарим хорих ангиудад хэрэгжиж байгаа бөгөөд Англи улсын Ливерпүүл дэх хорих ангид AI-д суурилсан видео аналитик платформыг ашиглаж хар тамхи, утас, зэвсэг зэргийг нэвтрүүлэхийг хянаж, бусад сэжигтэй үйлдлийг илрүүлдэг байна.

Үүн дотор хамгийн дэвшилтэт программууд нь Хятад улсад ашиглаж байгаа бөгөөд хоригдлуудыг хорих ангид байх цаг мөч бүрд хянах “ухаалаг” хяналтын системийг бүтээж, камер болон мэдрэгчийн /мэдрэл өөр нэршил/ сүлжээ нь хоригдлуудыг байнга хянаж, AI системээр тэжээгддэг бөгөөд энэ нь хоригдол тус бүрийн нүүр царай, хөдөлгөөн, зан төрхийн өөрчлөлтийг хянаж, шинжилгээний технологийг ашиглан өдөр бүр бичмэл тайлан гаргаж, аливаа хэвийн бус зан үйлийг тэмдэглэдэг байна. Мөн Хонг Конгын шоронд “ ухаалаг “ видео хяналтын системд хоригдол өөрийгөө гэмтээх болон аливаа хууль бус үйлдэл, гаж зан үйлийг илрүүлэх аналитик хяналтын камерууд, хяналтын бугуйвч зэргийг ашиглаж, хоригдлуудын амин

⁵ <https://rm.coe.int/ai-in-prisons-2030-acjournal/1680a40b83> Artificial Intelligence in prisons in 2030: An exploration on the future of AI in prisons

чухал шинж тэмдэг, биометрийн мэдээллийг бүртгэж эрүүл мэнд, сэтгэл хөдлөлийг тогтмол хянадаг байна.

Өнөөдөр "биометр" гэсэн нэр томъёо нь зөвхөн хурууны хээгээр хязгаарлагдахгүй царай, дууны өнгө, биеийн өндөр, жин зэргийг таних программ нэвтэрсэн байна. Шинэ технологийг ашиглан хурууны хээгээр тухайн хүний талаарх бүх төрлийн мэдээллийг авах технологийн сайжруулалт хийгдэж байна.⁶

Зарим улсын шоронд авч хэрэгжүүлж буй ажлыг жаахан дэлгэрүүлэн судалж үзэхэд:

Оросын Холбооны Улсад 2020 оноос эхлэн эрүүгийн ял эдлүүлэх бодлогыг боловсронгуй болгох ажлын хүрээнд хорих ял эдлүүлэх шинэ төрөл бий болгох, хоригдлуудыг нийгэмшүүлэх шинэ төрлийн арга хэрэгслийг нэвтрүүлэхээр судалгаа хийгдэж байна. Мөн албаны үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгож хууль сахиулах бусад байгууллагатай холбогдох, мэдээллийн сан бий болгохын зэрэгцээ мэдээллийн аюулгүй байдлыг хангах, ял эдлүүлэх, цагдан хорих ажиллагаанд цахим дэд бүтцийг бий болгох, хоригдол, хоригдогч нарт цахим шуудан болон бусад үйлчилгээг ашиглах боломжийг олгох, ял эдлүүлэх тогтолцооны хөгжлийг дэмжих шинжлэх ухааны төв лабораториудыг байгуулах, хоригдол болон цагдан хоригдож буй этгээдтэй харьцах олон улсын стандартыг хангах, хяналтын цахим тогтолцооны тусламжтайгаар хоригдлын зан үйлд мониторинг хийх, хиймэл дагуулыг ашиглан хяналт тавих зэрэг ажлуудыг хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.

БНХАУ-н улсад “Шийтгэл, шинэчлэл хоёрыг хослуулж гэмт хэрэгтэнд засрал олгоно” гэсэн зарчим үйлчилж байна. Хорих анги нь харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зорилгоор техник тоног төхөөрөмж болон хяналтын системдээ сайжруулалт хийснээр 2016 оноос хойш хорих ангиас нэг ч хоригдол оргоогүй байна. Мөн гэмт хэрэгтнийг нийгэмшүүлж, тэднийг нийгэмд эргэн ороход бэлтгэхэд хүчин чармайлт гаргаж тусгай сургалтын хөтөлбөр бүхий шинэ төрлийн хорих ангиудыг байгуулж, мэдээллийн технологийн өргөн хэрэглээг дэмжин ажиллаж байна.

Хятадын судлаачид хэргийн материалд дүн шинжилгээ хийж, хүмүүсийг гэмт хэрэгт буруутгах чадвартай дэлхийн анхны хиймэл оюун ухаан (AI) бүтээснээ мэдэгдсэн байна. Орвелийн төхөөрөмж нь төрийн эсрэг "эсэргүүцэл"-ийг тодорхойлж, гэмт хэрэгтнүүдэд ял оноохыг санал болгож байна.⁷

Энэхүү AI машин нь залилах, мөрийтэй тоглох, замын хөдөлгөөний дүрэм зөрчих, жижгээр танхайрах гэх мэт үйлдэгддэг 8 төрлийн гэмт хэргийн материалд дүн шинжилгээ хийж яллах ажиллагаа явуулж байна.

Америкийн Нэгдсэн улсад: Орчин цагийн хорих ангийн аюулгүй байдал, харуул хамгаалалт нь үндсэн гурван зэрэглэлд ангилж үздэг байна.

⁶ <https://le.fbi.gov/science-and-lab/biometrics-and-fingerprints/biometrics/next-generation-identification-ngi>

⁷ <https://www.ozgunlaw.com/en/it-technology-law/china-has-created-the-worlds-first-ai-prosecutor-935> Хятад дэлхийн анхны AI-ийн прокурорыг бүтээлээ.

1. Дээд зэргийн харуул хамгаалалтай хорих анги нь гадуураа 6-8 метрийн өндөртэй хоёр давхар хашаагаар хүрээлэгдсэн, ажиглалтын цамхгууд дээр зэвсэглэсэн харуултай байна.

2. Дунд зэргийн харуул хамгаалалтай хорих анги нь дээгүүрээ өргөст торон хамгаалалт бүхий хоёр давхар хашаагаар хүрээлэгдсэн, ганцаарчлан хорих өрөөнүүдтэй байна.

3. Сул харуул хамгаалалтай хорих анги буюу хашаагаар хүрээлэгдсэн, харуулын постгүй. Дохиолол, камерын тусламжтайгаар хашаан доторх орчноо хянаж байдаг.

Хорих ангид нийгэмшүүлэх ажил хийх нь хоригдлын бодит байдлыг сайтар ойлгуулж, тэднийг хувь заяагаа өөрчлөх шаардлагатайг мэдрүүлэх зорилготой бөгөөд хоригдлуудын утасны ярианд хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийдэг байна. Энэхүү технологи нь хоригдлуудын утасны дуудлагыг автоматаар хуулбарлаж, тэдний харилцааны хэв маягт дүн шинжилгээ хийж, албан тушаалтнуудын системд урьдчилан программчилсан зарим үг, хэллэгийг тэмдэглэж чаддаг байна.⁸

ХБНГУ-ын хорих байгууллага: Тус улсад нээлттэй, хаалттай гэсэн хорих ангийн хоёр систем үйлчилдэг бөгөөд нээлттэй хорих ангид хоригдол өөрийн зав, боломжийг харгалзан саналаараа хоригддог. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгтэн долоо хоногийн эхээр ажил ихтэй байвал долоо хоногийн сүүлээр хорих газарт очихоор шийдвэр гүйцэтгэх байгууллагатай тохиролцох юм уу, эсвэл долоо хоногийн эхээр боломжтой бол тэр хугацаандаа очоод хоригддог, түүнийг нь эрх бүхий байгууллага ялын хугацаанаас хасаж тооцсоноор ялыг бүрэн эдлүүлж дуусгадаг байна.

Хорих ял эдлүүлэх нь хоригдлыг цаашид дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нийгмийн хариуцлагыг ухамсарлуулах, эрх чөлөөт амьдралд нь эргэн ороход туслах зорилготой. Мөн хорих ангид хоригдлыг хөдөлмөрлүүлэх, сургалт орох, мэргэжил олгох нь нийгэмшүүлэх чухал ач холбогдолтой байна. Тухайлбал: Хорих ангид орчин үеийн техникээр тоноглогдсон хэвлэх үйлдвэр ажиллаж, хоригдлыг цөмийн ректорын гагнуурчин болон аливаа үйлдвэрийн автомат шугам дээр ажиллах роботын тохиргооны мэргэжлээр сургаж байна. Энэ нь тухайн хоригдолд нарийн мэргэжил олгож байгаа нь цаашид шоронгоос суллагдсаны дараа ажил олох, амжилттай хөдөлмөрлөхөд тус дөхөм үзүүлж байна.

Мөн шоронд телевизийн буюу алсын зайн сургалтыг олноор нь зохион байгуулж хоригдолд шаардлагатай мэдээ мэдээлэл, мэдлэгийг олгох ажлыг зохион байгуулж, Европын бусад улсын хэд хэдэн телевизийн төвийн сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлсэн байна.

Англи улсад: Хорих ангийг нээлттэй ба хаалттай гэж ангилдаг. Нээлттэй хорих анги нь зэвсэглэсэн хамгаалалт байхгүй, цонх нь төмөр хаалтгүй бөгөөд хоригдлууд нь бусад байгууллагад очиж гэрээгээр, харуул хамгаалалтгүй сайн дурын үндсэн дээр

⁸ <https://www.reuters.com/article/idUSKBN2FA0ON/> АНУ-ын шоронгууд хоригдлуудын утасны дуудлагад дүн шинжилгээ хийхийн тулд хиймэл оюун ухааныг авч үздэг

очиж хөдөлмөрлөж болдог байна. Хаалттай хорих анги нь зэвсэглэсэн харуултай, өндөр бөх бат хана зэргээр нийгмээс тусгаарлагдсан байдаг.

Тус хорих байгууллагын үзэж байгаагаар ял эдэлнэ гэдэг нь шийтгэл бус, тухайн хүнийг муу зуршлаас салгах, нөхөн сэргээх ажил арга хэмжээ гэж үздэг байна.

Франц улсад: Төв болон орон нутгийн насанд хүрсэн, насанд хүрээгүйчүүдийг хүмүүжүүлэх тусгай байгууллагаас бүрдэх ба эдгээр нь өөрсдийн онцлог дэглэмтэй байна. Засрах найдлагатай хоригдлуудыг өдрийн цагаар нийтээр нь ажиллуулж, орой нь тэднийг тусгаарладаг. Ийм хоригдол нь гадуур ажил эрхлэх хөнгөлөлт эдэлдэг байна. Засрахад эргэлзээтэй, засрахгүй хоригдлын хувьд хязгаарлагдмал эрхийг эдлэх бөгөөд ял эдлүүлэх асуудлыг тусгай шүүгч хариуцаж хугацаанаас нь өмнө суллах, хорих ялын хугацааг багасгах асуудлыг шийдвэрлэдэг. Нийгмийн аюулаар бага, жижиг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд давтан гэмт хэрэг үйлдэх явдлаас зайлсхийх боломж олгох, гэмт хэрэгт холбогдсон этгээдийн зан төлөвийг ойлгох, засах, тэднийг хүмүүжих, нийгэмших явдалд туслах зорилготой.⁹

Финлянд улсад: Хорих байгууллага нь онцгой, жирийн, нээлттэй гэсэн гурван төрлийн дэглэмд хуваагддаг. Жирийн дэглэмд хорих ял эдэлж буй хоригдлууд хянагчийн хамт гадуур явж болох бөгөөд нээлттэй хорих байгууллага нь хоригдлыг оргон зугтахаас сэргийлсэн хашаа байхгүй, хоригдол өрөөнийхөө түлхүүрийг өөрөө эзэмшиж дотор чөлөөтэй явж, энгийн хувцас өмсдөг байна. Харин аль ч дэглэмд хоригдож байгаа хоригдол ганцаараа нэг өрөөнд ял эдэлдэг онцлогтой.

Зарим хорих ялыг 8 хүртэл сарын хугацаагаар албадан ажил хийлгэх ялд дүйцүүлэн 20 - 200 цагийн ажлыг 7 хоногт 2 удаа, 3 - 4 цаг ажилладаг. Энэ шийтгэлийг эдэлж байх хугацаанд хоригдлын үндсэн ажил, сургуулиас нь чөлөө авахгүй, гэр орондоо байх боломжийг хангаж гүйцэтгэдэг байна.

Тус улсын хуулиар хорих ял нь хүнд шийтгэл тул тухайн төрлийн гэмт хэргийг хүндрүүлэн аливаа шинжийг ял дээр нь нэмдэггүй, мөн хорих ангиас суллагдаад гарахад ямар нэгэн анкет, баримт бичигт ял эдэлж байсныг дурдахгүй байхаар тусгагдсан байна.

Швейцар улсад: Хорих байгууллагын нийгмийн ажил нь дотроосоо болон гаднаас гэсэн хоёр хэлбэртэй бөгөөд тэдний үйл ажиллагааны үндсэн зорилго нь ял эдэлж байгаа хүмүүсийг дахин хорих ангид эргэж ирэхгүй байхаар хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх чиглэлээр ажилладаг байна.

Япон улсад: Ял нь бага хэмжээний торгууль, торгууль, эрүүгийн баривчилгаа, албадан хөдөлмөрлүүлэх болон албадан хөдөлмөрлүүлэхгүйгээр хорих, цаазаар авах гэсэн төрөлтэй. Тус улсын ял эдлүүлэх байгууллагын бүтцэд урьдчилан хорих, баривчлах байр, насанд хүрэгчдийн болон насанд хүрээгүйчүүдийг хорих байгууллага орж байна. Хорих ялын нэг онцлог нь хөдөлмөр эрхэлж хорих эсвэл ажил хийлгэхгүй хорих ял оногдуулдаг. Хоригдлыг засрах хамгийн боломжтой нөлөөллийн арга бол биеийн хүчний хөдөлмөр гэж үздэг. Хоригдол өдөрт 8 цаг, долоо хоногт 44 цаг ажилладаг бөгөөд хоригдлуудын дунд нөлөөллийн ажил зохиохдоо аль болох олныг

⁹ Гадаад орны прокурорын байгууллагын бүтэц, чиг үүргийн талаар харьцуулсан судалгаа 38,56 –р тал

хамруулахгүй байхыг хичээдэг байна. Хоригдлыг хөдөлмөр эрхэлж хорих, хөдөлмөр эрхлэхгүй хорих нь тухайн хэргийн нөхцөл байдлаас шалтгаалж байна.

Дээрх улсуудын хорих ангийн үйл ажиллагаанд тухайн улсын прокурорын байгууллагуудаас хиймэл оюун ухаан ашиглан төдийлөн сайн хяналт тавьдаггүй байна. Учир нь хиймэл оюун ухаан нь шүүх, прокурорын байгууллага, олон нийтийн аюулгүй байдлын тогтолцоонд зарим хэрэглээг хэрэгжүүлсэн боловч эдгээр хэрэглээ нь жигдрээгүй гэж үздэг байна. Энэ нь хиймэл оюун ухаан нь оптик тэмдэгт таних технологи, байгалийн хэл боловсруулах технологи, ухаалаг яриа таних технологи, элемент олборлох технологи, робот сурах чадварыг сайжруулснаар дээд түвшний хиймэл оюун ухааныг ашигласнаар зорилт хангагдах юм байна.¹⁰

Энэ талаар АНУ-ын хуульч, судлаач Бесики Лука Кутателадзе 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр Bloomberg law-д хэвлүүлсэн нийтлэлд “Амжилт ихэвчлэн инновац, технологийг нэвтрүүлэхээс хамаардаг гэтэл прокурорын салбар шинэлэг зүйлд үргэлж эргэлзсээр ирсэн. Прокурорын аливаа шийдвэр гаргах процесс нь хиймэл оюун ухааныг хэрхэн ашиглах талаар судалгаа хийгдэж байна” гэжээ.¹¹

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хэнд ч эрүү шүүлт тулгах, эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй, хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй, хүн бүр сурч боловсрох эрхтэй, наад зах нь анхан шатны болон ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байвал зохино, анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстой, техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол нийтэд хүртээлтэй байх ёстой, хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй зэрэг заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олсон байдаг.

Иймд бид Монгол улсын шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу шүүхээс оногдуулсан хугацаагаар тухайн хоригдол ялыг хорих ангийн дэглэм, нөхцөлд эдэлж буй эсэхийг хянаж Эрүүгийн хуулийн энэрэнгүй ёсны зарчмыг үндэслэн бус хуулийн ерөнхий ангийн 6.12 дугаар зүйлд заасан үндэслэлээр хоригдлыг хугацааны өмнө суллах¹² эсэх асуудлыг шийдвэрлүүлэхээр харьяа дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд прокурорын дүгнэлт үйлдэн шийдвэрлүүлж байна.

Гэтэл Ази болон Европын хөгжиж байгаа болон хөгжингүй орны хорих ангиудад тухайн хоригдлыг ямар нөхцөлд ял эдлүүлж, хэрхэн нийгэмшүүлэх ажлыг яаж зохион байгуулж байгаа болохыг олдсон материалын хүрээнд судалж үзэхэд цаашид бид дараах ажлыг хиймэл оюун ухааны тусламжтайгаар хянах боломжтой гэж харсныг дүгнэлт хэсэгт оруулав.

¹⁰ <https://www.scirp.org/journal/paperinformation?paperid=120103> Хятад дахь хиймэл оюун ухааны шүүхийн ололт амжилт ба хэтийн төлөв

¹¹ <https://gordoninstitute.fiu.edu/news-events/the-policy-spotlight/2024/ai-is-here-to-stay-prosecutors-should-adopt-its-metrics-prowess.html> AI энд үлдэх болно. Прокурорууд түүний хэмжүүрийн ур чадварыг батлах ёстой нийтлэл

¹² Монгол Улсын Эрүүгийн хууль, 2017 он

Дүгнэлт

Хиймэл оюун ухаан нь машин жолоодохоос эхлээд зүрхний нээлттэй хагалгаа хийх хүртэл бидний амьдралын ихэнх хэсгийг эзлэхээр төлөвлөж байна. Унших тэвчээр багасаж, бичих чадвар буурч байгаа нийгэмд хиймэл оюун ухаан энэ ажлыг гүйцэтгэх боломж бүрдэж байна.

Прокурорын байгууллага хүний гаргасан шийдвэрийг хиймэл оюун ухаанаас гаргасан шийдвэртэй харьцуулж, асуудал үүсгэж болзошгүй хэргийг илрүүлэх боломжтой. Энэ нь хиймэл оюун ухааныг ашиглан тогтмол статистик мэдээ гаргах замаар энэхүү аналитик цоорхойг үр дүнтэйгээр нөхөж чадна.

Цаашид хиймэл оюун ухааныг чадварыг хурдан тодорхойлж, автомат орчуулга хийх, нүүр царайг таних, дүрсийг баяжуулах, медиа файлуудыг орчуулах, хуулбарлах, эх материал, видео, зургийн аналитик хийх зэрэг бусад хэрэглээнд өдөр тутам ашиглах боломжтой байна.

Хорих ангийн нийгэм, сэтгэл зүйн албанаас зохион байгуулдаг сургалтуудыг хоригдлуудын үйлдсэн гэмт хэргийн хууль зүйн үр дагаварт тохирсон, сэдвээр хоригдлуудад сургалтыг үе шаттай зохион байгуулж байгаа эсэхийг прокуророос шууд хянах боломжийг бүрдүүлэх нь туйлын ач холбогдолтой. Учир нь тухайн хоригдол гэмт хэргийг ямар сэдлээр үйлдсэн болохыг нийгмийн ажилтан судалж мэдсэний үндсэн дээр сургалтын сэдвийг тохируулан сургалт орж байгаа эсэхийг прокуророос хянаж, тухайн хоригдол хэрхэн нийгэмшиж, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх боломжийг хэрхэн бүрдүүлж байгааг дүгнэх боломжтой. Тухайлбал: Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хоригдлууд нь хохирогчтой гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай, удаан хугацаанд гэр бүлийн хүчирхийлэлд байлган, тарчлаасны эцэст хөнөөсөн байдаг бол бага насны хүүхдийг хүчиндэж алсан хоригдлууд үйлдсэн гэмт хэргээ нуун далдлах, гэмт хэргийн ул мөрөө арилгах зорилгоор бага насны хохирогчийг алсан байдагт анхаарч сургалтыг зохион байгуулах нь үр дүнтэй.¹³

Прокурорын шийдвэр хууль зүйн үндэслэлтэй гаргах зорилгоор тухайн хоригдлын талаарх мөрдөн шалгах ажиллагаанд өгч байсан мэдүүлэг, шүүх хурлын бичлэг, хорих ял эдлэх хугацаанд нийгэмшүүлэх сургалтад хэрхэн сууж, оролцож байсан болон зан төрхийн өөрчлөлт, засрал хүмүүжлийн ямар нөлөө үзүүлж байсан зэрэг шаардлагатай бүх мэдээллийг видео хэлбэрээр үзэж дүгнэлт хийхийн тулд хиймэл оюун ухааныг ашиглаж мэдээллийг багцлах боломжтой.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Прокурорын байгууллагын цахим системийг ашиглан хиймэл оюун ухааныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх: Прокурорын байгууллагад хяналт тус бүрийн чиглэлээр цахим сүлжээнд бүрэн үйлчилгээтэй ухаалаг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээллийн сан бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын чиглэлээр тухайн хоригдлыг хэрэгт холбогдсон үеэс хуулийн сахиулах байгууллагаас түүнд чиглэсэн бүх төрлийн ажил, арга хэмжээний талаарх мэдээлэл,

¹³ “Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн сэтгүүл. 2021 он №01. 7 дахь тал

шаардлагатай бичлэгийг хяналтын прокурор хянаж шийдвэр гаргахдаа ашиглах боломжийг бүрдүүлэх.

Хорих ангиас хиймэл оюун ухааныг ашиглан хоригдолд чиглэсэн ажил арга хэмжээний талаарх мэдээлэл: Хорих ангид ашиглаж буй царай таних, алхаа таних зэрэг хиймэл оюун ухааны технологиудыг ашиглан зөрчил илрүүлсэн, нийгэмшүүлэх сургалтын үйл явц зэргийг харуулсан бүх төрлийн бичлэгийг прокуророос шууд хянах боломжийг бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл гэмт хэргийн хандлагын шинжилгээ, хэргийн шинж чанарын шинжилгээг нэгтгэсэн хиймэл оюун ухааны систем нь бүх төрлийн мэдээлэл, өгөгдлийг автоматаар цуглуулж, холбогдох элементүүдэд ухаалгаар дүн шинжилгээ хийж, эрүүгийн хэрэг, зөрчлийг илрүүлэхэд үр ашгаа өгөх боломжтой.

Шүүхэд төрийг төлөөлөх чиглэлээр: Хиймэл оюун ухааныг ашиглан шүүхийн шийдвэрийн талаарх мэдээллийг нэгтгэн дүгнэх, дүн шинжилгээ хийх, ухаалаг шийдвэр гаргах, шүүх хуралдаанд хяналт тавих боломж бүрдүүлэх.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Хиймэл оюун ухааныг ашиглан прокурорын байгууллагаас санаачлан хийсэн видео бичлэг, шторк, контент, баннерууд нэгтгэн сайтаар дамжуулан олон нийтэд байнга хүргэж байх. Холбогдох төрөл бүрийн видео зураг, бичлэгийн сан бүрдүүлэн видео дүрсний мэдээллийг олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, хянахад ашиглах боломжтой.

Зөвлөмж

Судлаач А.Гиндденс “Нийгэмшил гэдэг нь тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд өөрийн ухамсар бүхий ухаант амьтан болон хувирч, төрж өссөн соёлынхоо мөн чанарыг ойлгох явц, зарим нөхцөлд насанд хүрсэн хүмүүс дахин нийгэмшилд орж болно. Өөрөөр хэлбэл урьд өмнө тогтсон үнэт зүйлс, бие хүний зан үйлийн загвараа өөрчилж өмнөхөөс эрс ялгаатай үнэт зүйлсийг эзэмших нь буй. Хүмүүсийн үнэт зүйлс, ертөнцийг үзэх үзэл нь яг хэвээндээ байдаггүй, амьдралын бүхий л мөчлөгийн туршид хуримтлуулсан туршлагатайгаа хамт хувиран өөрчлөгдөнө¹⁴ гэж хэлсэн. Иймд хорих ангид нэн түрүүнд хоригдлыг нийгэмшүүлэх сургалтыг маш оновчтой, үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай юм. Үүнд:

- Хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зорилго нь хоригдлыг нийгэмшүүлэхийн тулд чанартай сургалтыг зохион байгуулах.

- Хорих ангиас суллагдсан хүнийг нийгэмшүүлэх ажлыг хэн, хэрхэн зохион байгуулах талаар хуульчлах.

- Хоригдолд албан болон албан бус сургалтаар боловсрол заавал эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах.

- Хорих ангийн нийгмийн ажилтан нарт болон хорих ангиас суллагдсан хүнийг дахин нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүсийг мэргэшүүлэх, мэргэшсэн нийгмийн ажилтны нөөцийг бүрдүүлэх шаардлагатай.

- Хоригдлын ял эдлэх орчин нөхцөл, дэглэмийг олон улсын хууль тогтоомж, хүний эрхийн байгууллагаас гаргасан зөвлөмжид нийцүүлэн дотоодын хууль, тогтоомж

¹⁴ Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ /2015-2020 он /
/https://cd.gov.mn/uploads/643623500229a.pdf/ 16 тал

холбогдох журам, зааврыг өөрчлөн орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглах, мөн хэрэглэж чаддаг боловсон хүчнийг бэлтгэх нь ирээдүйд тохиох үсрэнгүй хөгжлөөс бид хоцрохгүй, зэрэгцэн ажиллаж амьдрах нөхцөл бүрдэх боломжтой байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Эрүүгийн хууль, 2017
2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
3. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн сэтгүүл. 2020 он №03, 2021 он №01
4. Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
5. <http://www.baabar.mn/article/3986> Амьдралын хулгай нийтлэл
6. <https://rm.coe.int/ai-in-prisons-2030-acjournal/1680a40b83> Artificial Intelligence in prisons in 2030: An exploration on the future of AI in prisons
7. <https://le.fbi.gov/science-and-lab/biometrics-and-fingerprints/biometrics/next-generation-identification-ngi>
8. <https://www.ozgunlaw.com/en/it-technology-law/china-has-created-the-worlds-first-ai-prosecutor-935> Хятад дэлхийн анхны AI-ийн прокурорыг бүтээлээ.
9. <https://www.reuters.com/article/idUSKBN2FA0ON/>. АНУ-ын шоронгууд хоригдлуудын утасны дуудлагад дүн шинжилгээ хийхийн тулд хиймэл оюун ухааныг авч үздэг
10. УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн. Гадаад орны прокурорын байгууллагын бүтэц, чиг үүргийн талаар харьцуулсан судалгаа
11. <https://www.scirp.org/journal/paperinformation?paperid=120103> Хятад дахь хиймэл оюун ухааны шүүхийн ололт амжилт ба хэтийн төлөв
12. <https://gordoninstitute.fiu.edu/news-events/the-policy-spotlight/2024/ai-is-here-to-stay-prosecutors-should-adopt-its-metrics-prowess.html> AI энд үлдэх болно. Прокурорууд түүний хэмжүүрийн ур чадварыг батлах ёстой нийтлэл
13. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ /2015-2020 он/. Судалгааны тайлан. <https://cd.gov.mn/uploads/643623500229a.pdf/>

ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЗАРИМ АСУУДАЛ

Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Ц.Мөнхбат

Хураангуй:

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эрх зүйн орчин, хууль хэрэглээ, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх явц дахь зарим хүндрэлтэй асуудлыг хөндөж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох талаар энэхүү илтгэлээр авч үзсэн болно.

Түлхүүр үгс:

Эрүүгийн хариуцлага, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ, албадлагын арга хэмжээ, эмнэлгийн чанартай албадлага.

Удиртгал

Манай улсад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг “эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ”, “албадлагын арга хэмжээ” зэрэг нэршлээр эрүүгийн хариуцлагад хамааруулан Эрүүгийн хуульд хуульчлан ирсэн уламжлалтай.

Гэмт хэргийн бүрэлдэхүүн, гэмт үйлдэл, эс үйлдэл түүнд хандсан сэтгэхүйн харьцааны үүднээс өөрийн үйлдэл, эс үйлдлийн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлан ойлгох чадваргүй, гэм буруугүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт, томьёолол нь гэм буруу, шударга ёсны зарчмын үүднээс учир дутагдалтай билээ. Энэ талаар бусад улс оронд эрүүгийн хариуцлагад хамааруулахгүйгээр нийгмийн хамгааллын чиглэлийн хууль тогтоомжоор зохицуулдаг туршлага байна. Тухайлбал, Бельги улсад тухайн харилцааг эрүүгийн бус Нийгмийн хамгааллын хуулиар зохицуулж байна¹.

Гэм буруугаас хамааран цээрлүүлэх, нийгэмшүүлэх гэсэн эрүүгийн хариуцлагын зорилго ч эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хувьд үгүйсгэгдэнэ.

Процессын хууль², УДШ-ийн тогтоол³ оор ч гэм буруугийн асуудал хэлэлцэхгүйгээр шийдвэрлэхээр заасан нь эрүүгийн хариуцлагад хамааруулах нь тохиромжгүй болохын нэг илрэл гэж хэлж болох юм.

Гэсэн ч хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2015 оны Эрүүгийн хуулиар тус арга хэмжээг албадлагын арга хэмжээний нэг төрөл болгон Эрүүгийн хариуцлагад хамааруулан хэрэглэж байгаа тул холбогдох хууль зүйн зохицуулалт, хэрэглээний практик, хүний эрхийн холбогдолтой зарим асуудлыг хөндөхийг зорьлоо.

¹ Н.Одонтуул. “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний онол, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2023. 122 дахь тал

² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017.

³ Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2019.12.16. №658

Албадлагын арга хэмжээний төрөл

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно” гэж заасан.

Тус зүйлд амбулаторийн албадан хяналтад, сэтгэцийн эмгэг судлаачаар эмчлүүлэх, сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх гэсэн албадлагын арга хэмжээний төрлийг заасан боловч хууль тогтоомжоор тухайн төрлүүдийн ялгааг тодорхойлоогүй байх бөгөөд тухайн албадан эмчилгээний төрлийн онцлог, албадан эмчлүүлэгчид тавигдсан өвчний онош, тэдгээрийн уялдаа зэрэг шинжлэх ухааны тусгай мэдлэгийг зайлшгүй харгалзахаар буюу шинжээчийн дүгнэлт, шүүх хуралдааны явцад шинжээчээс гаргасан дүгнэлтийг тайлбарлуулж, тодруулах замаар шүүхээс тогтоохоор хуульчилсан.

Шинжлэх ухааны өөр салбарын тусгай мэдлэгийг шийдвэр гаргахад зайлшгүй харгалзахаар зохицуулсан хэдий ч практикт шинжээч томилох тогтоолд албадлагын арга хэмжээний төрөлтэй холбогдох асуултыг тавьж өгдөггүй, шүүхээс ч энэ талаар тодорхой төрөл зааж өгөөгүй тохиолдол цөөнгүй байна.

Тухайлбал; 2018-2021 онд шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн 77 шийдвэрийн 16-д албадлагын арга хэмжээний төрлийг зааж өгөөгүй талаарх судалгааны дүн харуулна⁴.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Сэтгэцийн шинжилгээ хийх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг дараах тохиолдолд” авна гэж заасан нь анхаарал татах ба нэгдүгээрт, албадлагын арга хэмжээний төрөл буюу материаллаг хэм хэмжээг процессын хуулиар тогтоохгүй, хоёрдугаарт эмчлэх бус, яллагдагчийн сэтгэцийн байдлыг тогтоох зорилгоор явуулж буй ажиллагаа тул албадан эмчилгээний төрөлд хамааралгүй, хуулийн найруулгын алдаа гэсэн агуулгаар ойлгож байна.

Албадан эмчилгээ явуулах дэглэм

2015 оны Эрүүгийн хуулиар албадлагын арга хэмжээний дэглэмийг шүүхээс тогтоохоор зааснаас бусад зохицуулалт тодорхойгүй, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан журмаар⁵ ч албадан эмчилгээ явуулах дэглэмийн ялгааны асуудлыг огт зохицуулаагүй байна.

Дээр дурдсанаар тусгай мэдлэг бүхий шинжээчийн дүгнэлтийг үндэслэн албадан эмчлүүлэгчийн өвчний онош, үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, хор аюул зэргийг тооцсоны үндсэнд эмчилгээ явуулах дэглэмийн асуудлыг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай байна.

2002 оны Эрүүгийн хуульд дэглэмийг “ердийн” болон “тусгай эмнэлэг” гэж ангилан, дэглэм тогтооход “сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын

⁴ Н.Одонтуул “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний онол, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2023. 169 дэх тал

⁵ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А-240/А369 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”

шинж чанар, хэр хэмжээг харгалзах”, тусгай эмнэлгийн дэглэмийг “онц аюултай этгээдэд хэрэглэх”, “тусгай эмнэлэгт байлгаж байгаа этгээдийг нийгэмд аюултай гэмт хэрэг шинээр үйлдэх боломжгүй, хүч нэмэгдүүлсэн хяналтын нөхцөлд байлгах”-аар тусгасан чухал зохицуулалтуудыг⁶ 2015 оны Эрүүгийн хуульд тусгаагүй орхигдуулжээ.

Дэглэм тогтоох зохицуулалтын дагуу 2018-2021 онд 2002 оны Эрүүгийн хуулийн жишгээр 77 шүүхийн шийдвэрийн 18-д ердийн, 21-д тусгай эмнэлэг гэж тогтоосон тоон судалгаа байна⁷.

Тухайн дэглэмд мөрдөгдөх хориглосон, зөвшөөрсөн хэм хэмжээний асуудал, тухайлбал, дэглэмээс хамаарсан хязгаарлалт, албадан эмчлүүлэгчийн эрх, харуул хамгаалалтын үйл ажиллагаа, өрөө тасалгаа, цонх, орны стандарт, ганцаарчлан эмчлэх, тусгаарлах зэрэг асуудлыг зайлшгүй журамлах шаардлагатай байна.

2023 онд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сүрьеэгийн тасат тусгаарлагдан эмчлүүлж байсан албадан эмчлүүлэгч нь энгийн тасгийн буюу хяналтын камергүй өрөөнд орж боомилон нас барсан тохиолдол гарсан нь дэглэм, түүний хүрээнд хориглох зохицуулалтуудыг тодорхой болгох шаардлагатай байгааг харуулж байна.

Процессын хуулиудад албадан эмчилгээний дэглэмийн асуудлыг орхигдуулсан зохицуулалт ч харагдана⁸.

Албадан эмчилгээний хугацаа

Шинэ Эрүүгийн хуулийн албадан эмчилгээний хугацааг тогтоох шаардлагын дагуу шүүхээс хугацааг тогтоож байгаа боловч хугацааг тогтоогоогүй цөөнгүй тохиолдол гарсан байх ба 2024 оны байдлаар Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт 2022 оны Эрүүгийн хууль хэрэгжих үед хугацаагүйгээр албадан эмчилгээ авагдсан 14, 2015 оны хуулиар хугацаа тогтоогоогүй 1 албадан эмчлүүлэгч холбогдох эмчилгээг хийлгэж байна⁹.

ЭХХШТХ-ийн 19.3-6-д “эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, хугацааг шинжээчийн дүгнэлт, прокурорын саналыг үндэслэн шүүх тогтооно” гэж заасны дагуу прокуророос хугацааны талаар санал гаргаагүй, шүүхийн шийдвэрийг зөвтгүүлэх арга хэмжээг аваагүй байна.

Шинжээч томилж, дүгнэлт гаргуулах тогтоолд хугацааны талаар асуулт тусгадаггүй, шинжээчийг шүүх хуралдаанд оролцуулаагүйн улмаас хугацааг харилцан адилгүй, эмчилгээний бодит үр дүн гарах, тооцох боломжгүйгээр тогтоох тохиолдлууд гарсаар байна. Албадан эмчлүүлэгчийг 30 хоногийн хугацаагаар албадан эмчлэхээр шүүхээс шийдвэрлэсэн тохиолдлыг нэрлэж болно¹⁰.

⁶ Эрүүгийн хуулийн 66 дугаар зүйл, 2002. Төрийн мэдээлэл 2002. №5

⁷ Н.Одонтуул. “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний онол, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2023. 168 дахь тал

⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, хугацааг шинжээчийн дүгнэлт, прокурорын саналыг үндэслэн шүүх тогтооно” гэж заасан боловч “дэглэм”-ийг тусгаагүй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлд мөн дэглэмийн талаар зохицуулаагүй байна.

⁹ Прокурорын байгууллагын цахим бүртгэл

¹⁰ Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 287 дугаартай шийтгэх тогтоол

Нэг талаас албадан эмчлүүлэгчийг хүлээн авч, оношийг бататгах, цаашид эмчилгээ хийх явц нь богино бус хугацаа шаарддаг, нөгөө талаас өвчтөний сэтгэцийн байдал, өвчний онош зэргээс хамааран эдгэрэх, сэтгэцийн байдал тогтворжих хугацаа харилцан адилгүй, тодорхой хугацаа тогтоох боломжгүй байдаг тул хугацааны асуудалд шинжээчийн тусгай мэдлэгийг зайлшгүй ашиглах, харгалзах шаардлагатай байна.

ХБНГУ, Грек улсад согтуурах, мансуурах бодист донтсон хүмүүст 2 жилээс дээшгүй, Их Британид 3 жилээс, Испанид үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах шийтгэлийн хэмжээнээс хэтрэхгүй байхаар, Эстонид 18 сараас 3 жил хүртэл хугацаагаар албадлагын арга хэмжээ хэрэглэхээр тус тус зохицуулсан байна¹¹.

Албадан эмчилгээг зогсоох

Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний “хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан” бол гэсэн тодорхой үндэслэлээр шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоох тухай шийдвэр гаргахаар заасан, өөрөөр хэлбэл анагаах ухааны талаас албадан эмчлүүлэгчийн сэтгэцийн өвчин эдгэрсэн тохиолдолд зогсоож шийдвэрлэнэ.

Журмаар¹² дээрх үндэслэлээс гадна “эмчлүүлэгчийн сэтгэцийн байдал засарсан” гэсэн үндэслэлийг тусгаж, практикт “сэтгэцийн байдал засрал сайжралын байдалд орсон”, “тогтвортой байгаа” гэсэн 2 нөхцөлөөр албадлагын арга хэмжээг зогсоох тухай санал гаргаж, түүний дагуу шийдвэрлэж байгаа нь хуулиар тогтоосон үндэслэлтэй нийцэхгүй байна.

2002 оны Эрүүгийн хуульд зогсоох үндэслэлийг “эдгэрсэн буюу өвчний шинж байдал өөрчлөгдсөн”¹³ гэж тогтоож байсан нь оновчтой зохицуулалт байжээ.

Албадан эмчилгээг сунгах

2015 оны Эрүүгийн хуулиар албадан эмчилгээний хугацааг шүүхээс тогтооходой холбогдуулан сунгах ойлголт гарч ирсэн ба сүүлийн 5 жилийн байдлаар давхардсан тоогоор 5 удаа албадлагын арга хэмжээг сунгасан байна¹⁴.

Албадлагын арга хэмжээг сунгах талаар тодорхой хугацааны хязгаарлалт тогтоогоогүй ба үүний улмаас сэтгэцийн байдал засрал сайжралд ороогүй байгаа тохиолдолд хүнийг бүх насаар нь албадан эмчилж болох нөхцөл байдал үүсэхээр байна. Оюуны хомсдол, шизофрени зэрэг сэтгэцийн өвчин одоогоор эмчлэгдэхгүй буюу эдгэрсэн практик тохиолдол байхгүй, тус шалтгаанаар шинжилгээ хийхэд тухайн өвчин эдгэрэхгүй гэсэн хариулт өгдөг талаар тухайн салбарын мэргэжилтнүүд тайлбарладаг бөгөөд Эрүүгийн хуульд бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээдийг суллаж болох зохицуулалтыг тусгасан атал албадан эмчлүүлэгчийн хувьд хугацааны

¹¹ Н.Одонтуул. “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний онол, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2023. 181 дэх тал

¹² Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А-240/А369 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”

¹³ Эрүүгийн хуулийн 66 дугаар зүйлийн 66.5 дахь хэсэг, 2002. Төрийн мэдээлэл 2002. №5

¹⁴ Прокурорын байгууллагын цахим бүртгэл

дээд хязгааргүйгээр албадан эмчлэх, тусгаарлах нь шударга ёсны зарчимд нийцэхгүй, хүний эрхийг дордуулсан асуудал үүсгэх юм.

Албадан эмчлүүлэгчийн эрхийн асуудал

Албадан эмчилгээтэй холбогдох харилцааг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А-240/А369 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-аар зохицуулж байгаа ба албадан эмчлүүлэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчийн эрхтэй холбогдох цөөнгүй асуудал тодорхойгүй буюу нарийвчлан зохицуулаагүй байна.

Албадан эмчилгээ явуулах журам, эрхийн талаар мэдээлэл өгөх, усанд оруулах, эргэлт, уулзалт, илгээмж, утсаар ярих хугацаа, илгээмжээр зөвшөөрөх, хориглох зүйл, хоногоор эргэлт хүлээн авах, хувцасны хангалт зэрэг асуудлыг зохицуулаагүй, зохицуулалтгүйн улмаас холбогдох арга хэмжээ авах, ахуй нөхцөлийг бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ байхгүй байна.

Нэгэнт эрүүгийн хариуцлагын хүрээнд нийгмээс тусгаарлаж, албадан эмчилж байгаа нөхцөлд тухайн этгээдийн захидал, харилцаа, ахуйн буюу зайлшгүй шаардлагатай эд зүйлсээр хангах болон бусад асуудлыг албадан эмчилгээний дэглэмийг харгалзан нарийвчлан зохицуулах буюу холбогдох байгууллага, албан тушаалтан, түүнчлэн асран хамгаалагчийг үүрэгжүүлэх нь зүйтэй байна.

Харуул хамгаалалт.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А-240/А369 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-аар өдөр тутмын хамгаалалтын үйл ажиллагааг хариуцаж, хамгаалалтын ээлжинд 2-оос доошгүй хамгаалалтын ажиллахаар тогтоосон ба Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникийн хэвтүүлэн эмчлэх орны тоог 40 байна.

Харуул хамгаалалтын ажилтнаас өдөр тутам журамд заасан бие, өрөөнд хийх үзлэг явуулах, гадна эмчилгээнд хамгаалж авч явах, бусад үед аюулгүй байдлыг хангах зэрэг үйл ажиллагааг тогтмол явуулж байгаа ба албадлагын арга хэмжээний дэглэмээс хамааран гүйцэтгэх үүргийг нарийвчлах шаардлагатай. Тухайлбал, эмчээс холбогдох үзлэг, эмчилгээ хийх явцад хамгаалалтын ажилтан байлцах эсэх, хаана байрлах, албадан эмчлүүлэгчид тусгай хэрэгсэл хэрэглэсэн байх зэргийг журамлах нь хамгаалалтын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдал болон хариуцлага тооцох үүднээс шаардлагатай байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх явцад эмчлүүлж буй этгээдээс халдан довтлох 5¹⁵, эмчийн биед халдсан 1 тохиолдол гарсныг дурдах хэрэгтэй.

Түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн ажлын ачааллын жишиг нормативт Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт ажиллах албан

¹⁵ “Гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй хүнд оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилт” судалгаа, 2023. <https://sudalgaa.gov.mn/pdf/gemt-khereg-yldsen-setgetsyn-emgegtey-khnd-onogduulsan-ennelgiyn-chan-gu8>

хаагчдын тоо, ачааллын хэмжээг тусгаагүй¹⁶, биечилсэн хяналт тавих хамгаалалтын ажилтанд ногдох эмчлүүлэгчийн тоог тогтоож өгөх шаардлагатай байна.

Албадан эмчлүүлэгчээс өөрт болон бусдад аюул учруулсан тохиолдолд таслан зогсоох үүргийн хүрээнд хүчний харьцаанаас цахилгаан бороохой хэрэглэх ч шаардлага харагдаж байх ба тусгай хэрэгслийн жагсаалтад хамааруулаагүй байна.

Бусад асуудал

Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болох”-оор зохицуулсан байх ба шүүхийн практикт тус хэсгийг баримтлан шийдвэрлэсэн тохиолдол байхгүй байна¹⁷.

Тус хэсэгт шүүх тухайн зохицуулалтыг хэрэглэхээр заасан бол процессын хуульд¹⁸ прокуророос хэрэгсэхгүй болгохоор зохицуулсан нь тодорхойгүй байдал үүсгэж байна. Шүүх, прокуророос “аюул учруулахааргүй” гэсэн үндэслэлийг баримтлан тус тусын шатанд хэрэгсэхгүй болгож болох боловч эмнэлгийн чанартай албадлагатай холбогдох шийдвэрийг шүүхээс гаргахаар зохицуулсан Эрүүгийн хуулийн зохицуулалтын хүрээнд тухайн эрхийг шүүхэд хамааруулах нь зохимжтой гэж үзэж байна.

Аюул учруулахгүй гэсэн дүгнэлтийг ямар баримтад үндэслэн гаргах нь тодорхойгүй, практикт сэтгэцийн шинжээчийн дүгнэлтэд өвчин хэзээ сэдрэх буюу бусдад аюул учруулах эсэхийг тогтоох боломжгүй гэсэн хариултыг байнга өгдөг. Албадан эмчлүүлэгчийн хувьд ч хэрэг хариуцах чадваргүй буюу тухайн гэмт үйлдэл, эс үйлдэл хийсэн мөчид өөрийн үйл ажиллагааг ухамсарлах, жолоодох чадваргүй байсан нь тогтоогдсон нөхцөлд албадан эмчилгээ хэрэглэхээр шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл хэрэг хариуцах чадваргүй нөхцөлд “аюул” гэсэн ойлголт байнга дагалдах бөгөөд хэзээ бий болох нь тусдаа асуудал юм.

Нэгэнт гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй тохиолдолд албадан эмчилгээг тогтоож өгөх зайлшгүй шаардлагатай бөгөөд нэг талаас хууль тогтоогч “аюул учруулахгүй” гэсэн ойлголтыг “дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхгүй”, “шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх үеийн байдлаар хэрэг хариуцах чадваргүй хүний сэтгэцийн байдал эдгэрсэн, засарч байгаа” гэсэн агуулгаар хуульчилсан гэж үзэж байна.

Өөртөө, бусдад аюул учруулахгүй байна гэдэг нь дахин хуулиар хамгаалагдсан объектод халдаж, гэмт хэрэг, зөрчил үйлдэхгүй байх гэсний нэг илэрхийлэл гэж ойлгож болох ба энэ тохиолдолд тухайн зохицуулалтыг өөрчлөн найруулах шаардлагатай байна. Норвегийн Эрүүгийн хуулийн 62 дугаар зүйлд¹⁹ хэрэг хариуцах чадваргүй хүн дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй байдлыг хувийн байдал, сэтгэцийн өвчний түүх,

¹⁶ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Жишиг норматив шинэчлэн батлах тухай” А247/А167/303 дугаартай хамтарсан тушаал

¹⁷ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан

¹⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

¹⁹ Norway_Penal Code.pdf (legislationline.org)

сэтгэцийн одоогийн байдал, согтууруулах, мансууруулах бодисын хамаарал зэргийг харгалзан шүүхээс үнэлэхээр зохицуулсан байна.

Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүн шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх үед хэрэг хариуцах чадвартай болсон тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар шууд зохицуулалт байхгүй байх ба энэ үүднээс сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан хүн эдгэрсэн, сэтгэцийн эмгэг нь засралын байдалд байгаа зэрэг тохиолдолд албадан эмчлэхгүйгээр шийдвэрлэж болох юм.

Нөгөө талаас “эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр” холбогдох байгууллагад шилжүүлэх гэж томьёолсон нь ял, албадлагын арга хэмжээнд үл хамаарах бие даасан зохицуулалт гэсэн ойлголтыг төрүүлэх тул тухайн хэсгийг өөрчлөн найруулах шаардлагатай гэж харж байна. Мөн хэсэгт эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхэд хугацаа тогтоох, эмчлүүлэгчид эсхүл хууль ёсны төлөөлөгчид холбогдох үүрэг хүлээлгэх эсэх нь тодорхой бус харагдана.

Асран хамгаалагчийн хувьд

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоож шийдвэрлэхэд хууль ёсны төлөөлөгч /асран хамгаалагч/-тэй холбоотойгоор хүндрэлтэй асуудлууд үүсч байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэтгэцийн, эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэл сонирхлоо илэрхийлж чадахгүй тохиолдолд түүний төрсөн, үрчилж авсан эцэг, эх, эхнэр, нөхөр, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож, шүүх хуралдаанд оролцуулахаар заасан ²⁰ боловч эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн 101 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн судалгаагаар 50.5 хувьд нь хууль ёсны төлөөлөгч оролцуулаагүй²¹ шийдвэрлэжээ.

Албадлагын арга хэмжээг зогсооход асран хамгаалагчид хүлээлгэн өгөх шаардлага гардаг, түүний хүрээнд асран хамгаалах хүнээр холбогдох хүсэлт гаргуулах, сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр асран хамгаалагчаар тогтоолгох, тухайн этгээдээс идэвхгүй хандах, зайлсхийх зэргээр хүндрэлтэй байдал үүсдэг тул мөрдөн шалгах ажиллагааны явцад хууль ёсны төлөөлөгчийг тогтоон, шүүх хуралдаанд оролцуулж байх шаардлагатай байна.

Хууль ёсны төлөөлөгчөөс асрамжиндаа авахаас татгалзсан тохиолдолд журамд ²² зааснаар холбогдох байгууллагад хүсэлт гарган шийдвэрлүүлэхээр зохицуулсны дагуу Сэтгэцийн асрамжийн газарт шилжүүлэх шаардлага үүсэж байна.

²⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйл

²¹ Н.Одонтуул “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний онол, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2023. 168 дахь тал

²² Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А-240/А369 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын 4.8-д “Асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь холбогдох байгууллагад хүсэлтээ гарган асуудлыг шийдвэрлэж ажиллана” гэж заасан.

Асрамжийн газар

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд²³ зааснаар төрийн байгууллагууд сэтгэцийн эмгэгтэй хүний тусгайлсан асрамжийн газрыг аймаг, дүүрэгт байгуулах үүрэгтэй.

Тус чиглэлийн асрамжийн газар улсын хэмжээнд байхгүйн улмаас асран хамгаалах хүнгүй албадан эмчлүүлэгчийн эмчилгээг зогсоосон нөхцөлд хүлээн авах байгууллага байхгүй, шүүхээс 2023 онд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 6-р клиникт 4, 4 дүгээр клиникт 1, асрамжийн клиникт 1 эмчлүүлэгчийг шилжүүлж шийдвэрлэсэн байна²⁴.

Одоогоор Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт асран хамгаалах хүнгүй 10 эмчлүүлэгч байгаа ба цаашид тухайн тасгуудад шилжүүлсэн тохиолдолд орны хүрэлцээгүй нөхцөл байдалтай байна.

Дүгнэлт

Ял эдлүүлэх ажиллагаа, тухайлбал хорих ял эдлүүлэх эрх зүйн орчинтой харьцуулахад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт харьцангуй сул байх тул Эрүүгийн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох журам зэрэг эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хууль тогтоомжийг боловсронгуй болгосноор албадан эмчлүүлэгчийн эрх хангагдах хууль зүйн болон бусад орчин бүрдэнэ.

Хууль хэрэглээний алдаа буюу хуулийг нэг мөр хэрэгжүүлэх явдал чухал байна. Сэтгэцийн байдал засрал, сайжралд орсон, тогтвортой гэсэн үндэслэлээр албадлагын арга хэмжээг зогсоож буй нь хуульд заасан үндэслэлээс ангид байна.

Хууль тогтоомжийн хэрэглээ харилцан адилгүй байх тул хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар прокуроруудад холбогдох чиглэл хүргүүлэх, энэ талаар сургалт зохион байгуулах хэрэгцээ, шаардлага байна. Хууль ёсны төлөөлөгчийг тогтоож, шүүх хуралдаанд оролцуулах, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг тогтоох талаар шинжилгээ хийлгэхэд холбогдох асуулт тусгаж, хариултыг авах, шүүх хуралдаанд тодорхой санал гаргаж, шүүхээр шийдвэрлүүлэх зэргээр хуулийн хэрэгжилтийг хангуулах нь зүйтэй байна. Судалгаагаар албадлагын арга хэмжээ хэрэглэх асуудлыг хэлэлцсэн шүүх хуралдааны 11.8 хувьд шинжээч оролцсон²⁵ нь хангалтгүй үр дүнг үзүүлж байна.

Төрийн бусад байгууллагаас хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх талаар холбогдох арга хэмжээ аваагүйн улмаас албадлагын арга хэмжээг зогсоож шийдвэрлэхэд хүндрэлтэй байдал үүссэн, цаашид нөхцөл байдал дордох хандлага харагдаж байна. Сэтгэцийн тусгайлсан асрамжийн газар байгуулах талаар төрийн

²³ Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, Төрийн мэдээлэл, 2013.№3

²⁴ “Гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй хүнд оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилт” судалгаа, 2023. <https://sudalgaa.gov.mn/pdf/gemt-khereg-yldsen-setgetsyn-emgegtey-khnd-onogduulsan-emnelgiyn-chan-gu8>

²⁵ Н.Одонтуул “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний онол, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2023. 185 дахь тал

байгууллагуудаас хуульд заасан үүргээ биелүүлснээр албадан эмчилгээтэй холбогдох тодорхой нөхцөл байдлыг бүрэн шийдвэрлэх боломжтой юм.

Санал

А.Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээнд:

Эрүүгийн хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний дэглэмийн төрөл, дэглэм заах үндэслэлийн талаар нэмэлт оруулах;

Албадлагын арга хэмжээ хэрэглэх хугацааны эсхүл хугацааны дээд хязгаарыг тогтоох;

Хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоох гэсэн үндэслэлийг өөрчлөн ,сэтгэцийн эмгэг эдгэрсэн, дэглэмээс хамааран тодорхой хугацаанд албадан эмчлэгдсэн тохиолдолд зогсоох байдлаар зохицуулах;

Дээрх тохиолдолд цагдан хоригдсон хугацааг албадан эмчлүүлсэн хугацаанд оруулан тооцдог болох;

7.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр гэснийг хасах, гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүний сэтгэцийн байдал нь хэрэг хянан шийдвэрлэх үеийн байдлаар эдгэрсэн, сайжирсан, дахин гэмт хэрэг үйлдэхгүй гэсэн үндэслэлтэй бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр шийдвэрлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болох агуулгаар өөрчлөн найруулах;

Албадан эмчилгээний хугацаа дууссаны дараа албадан эмчлүүлэгчийг асран хамгаалагч эсхүл сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн байгууллагад шилжүүлэх;

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт дэглэм гэж нэмэх, 19.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулах;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний дэглэм, дэглэмд мөрдөгдөх хязгаарлалтын талаарх зохицуулалтыг тусгах.

Б.Журам шинээр боловсруулах хүрээнд:

Дээрх хэм хэмжээнд нийцүүлэн, албадан эмчлүүлэгчийн эрх, харуул хамгаалалт, дэглэм, стандарттай холбогдох зохицуулалтыг тусган журам дахин боловсруулж гаргах;

ШШГБ-ын норм тогтоосон, харуул хамгаалалтын үйл ажиллагаатай холбогдох журамд өөрчлөлт оруулах.

В. Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох арга хэмжээ авах хүрээнд:

Прокуроруудад албадан эмчилгээтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэглээ, дэглэм, төрөл, хугацааны талаар санал гаргах, шинжээч оролцуулах, шинжилгээ хийлгэхэд тус асуудлаар асуулт тавьж хэвших, шүүх хуралдаанд шинжээч, хууль ёсны төлөөлөгчийг оролцуулах талаар чиглэл хүргүүлэх;

Тус албадлагын арга хэмжээний зохицуулалт, хэрэглээтэй холбогдох сургалт зохион байгуулах.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Эрүүгийн хууль, /2002, 2015 он/
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017 он /
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017 он/
4. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль /2013 он/
5. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А-240/А369 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”;
6. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Жишиг норматив шинэчлэн батлах тухай” А247/А167/303 дугаартай хамтарсан тушаал;
7. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2019.12.16 №658
8. Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 287 дугаартай шийтгэх тогтоол;
Хүний эрхийн үндэсний комисс. “Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл”;
9. Н.Одонтуул. “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний онол, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2023
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны захилгаар Дотоод хэргийн их сургуулийн судалгааны багийн “Гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй хүнд оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилт” судалгаа, 2023 <https://sudalgaa.gov.mn/pdf/gemt-khereg-yldsen-setgetsiyn-emgegtey-khnd-onogduulsan-emnelgiyn-chan-gu8>
11. Прокурорын байгууллагын цахим бүртгэл
12. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны Албадлагын арга хэмжээ, хяналтын хэлтсээс ирүүлсэн тоон мэдээ
13. [Norway Penal Code.pdf \(legislationline.org\)](https://legislationline.org/)

ХОРИГДЛЫН ХУГАЦААНААС ӨМНӨ СУЛЛАГДАХ БОЛОМЖ, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД

Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын
Прокурорын газрын хяналтын прокурор Б.Амартүвшин

Хураангуй:

Эрүүгийн хуульд зааснаар хоригдлыг хугацаанаас өмнө суллах процесс ажиллагааны эрх зүйн онолын үндэслэл, мөн чанар, хууль зүйн агуулга, практик ач холбогдлын талаарх ойлголт, түүхэн уламжлал, хөгжил, цаашдын хандлагыг тодорхойлж, эрүүгийн эрх зүйн шударга ёсны болон хүмүүнлэг энэрэнгүй ёсны зарчмуудын харилцан хамаарлын хүрээнд авч үзэж эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулахад энэ илтгэлийн зорилго оршино.

Энэхүү илтгэлийг бичихдээ хоригдлыг хугацаанаас өмнө суллах асуудлыг үндэсний хууль тогтоомжид хэдий үеэс тусгаж хэрхэн ямар хэмжээ хүрээнд хэрэглэж ирсэн талаарх түүхэн эх сурвалжуудаас судлан дүгнэх, прокурор, шүүхийн өнөөгийн практик, хугацаанаас өмнө суллах үндэслэл, хэлбэрийг хөрш улсууд болон Франц, Герман, Япон зэрэг улсуудын эрүүгийн хуулийн зохицуулалттай харьцуулан дүгнэх, ангилан төрөлжүүлэх зэрэг арга зүйг сонгосон юм.

Түлхүүр үгс:

Эрүүгийн хариуцлага, хорих ял, ял шийтгэлийн зорилго, ял оногдуулах, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хоригдлын эрх, хорихтой холбоогүй арга хэмжээ, нөхөн сэргээх эрх зүй, хохирогчийн эрх, энэрэнгүй ёс, шударга ёс.

Удиртгал

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн зарим гэмт хэрэг болон албан тушаалын зарим хүндрүүлэх нөхцөлтэй гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол хугацаанаас өмнө суллахгүй байх заалтыг¹ нэмэлтээр оруулсан нь энэхүү илтгэлийг бичих сэдэл, сонирхлыг төрүүлэв.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн эх сурвалж болсон 1926, 1929, 1934, 1942 оны эрүүгийн хуулиудад² хорих болон албадан ажил хийлгэх³ ялаас, 1961 оны Эрүүгийн хуульд⁴ дээрх хоёр төрлийн ялаас гадна “уг нутгаас зайлуулах” ялаас хугацааны өмнө суллах зохицуулалт хэрэглэж байсан. 1986 онд баталсан Эрүүгийн хуулиар “хорих, нутаг заах, уг нутгаас зайлуулах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, сахилгажуулах

¹ Манай улсын орчин цагийн Эрүүгийн хуулийн анхдагч болох 1926 онд баталсан “БНМАУ-ын Шүүх цаазын бичиг”-ийн 36 дугаар зүйлд анх удаа /хорих ял болон албадан ажил хийлгэх ялаас тэн хагасыг эдэлсэн бол/ хугацаанаас өмнө суллах зохицуулалт орсноос хойш 1929, 1934, 1942, 1986, 2022, 2015 оны хуулиудад уламлагдан хадгалагдаж иржээ.

² 1926, 1929, 1934 оны эрүүгийн хуулийг “БНМАУ-ын Шүүх цаазны бичиг” хэмээн нэрлэж байсан бол 1942 оноос эхлэн Эрүүгийн хууль гэж нэрлэсэн байна.

³ 1926, 1929 оны хуульд “албадан үйлдвэр хийлгэх”, 1934 оны хуульд “албадан ажил хийлгэх”, 1942 оны хуульд “засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх”, 1961 оны хуульд “засан хүмүүжүүлэх ажил хийлгэх”

⁴ 1961 оны Эрүүгийн хуулийн 41 дүгээр зүйлийг үзэх.

ангид явуулах” зэрэг 5 төрлийн ялаас хугацааны өмнө суллах журмыг хэрэглэж ирсэн онцлогтой байна⁵.

Харин хугацаанаас өмнө суллахгүй байх буюу уг журмыг хэрэглэхгүй гэмт хэргүүдийн талаар анх 1961 оны Эрүүгийн хуулиар зохицуулсан байдаг. Энэхүү хуулийн 41 дүгээр зүйлийн “г” заалтад зарим төрлийн хэрэгт урьд ял шийтгэгдсэн хүн дахин тэдгээр хэргийн аль нэгийг үйлдэж хорих ял шийтгүүлсэн бол, “д” хэсэгт улс, олон нийтийн хөрөнгийг ашиглан шамшигдуулсан, хулгай, дээрэм хийсэн, хүчиндэх, хүндрүүлэх шалтгаантайгаар танхайрсан хэрэгт урьд хоёроос доошгүй удаа шийтгэгдсэн хүн дараа нь эдгээр хэргийн аль нэгэнд дахин шийтгэгдсэн бол хугацаанаас өмнө суллах, өөр хөнгөн ялаар солих журмыг хэрэглэхгүй гэж заасан байна. Мөн өмнөх дөрвөн удаагийн эрүүгийн хуулиар тухайн ялаас хугацаанаас нь өмнө суллах журмыг тогтоож байсан бол үүнээс гадна эдлээгүй үлдсэн ялыг “өөр хөнгөн ялаар солих” журмыг нэмж тусгасан онцлогтой байна.

1986 онд баталсан Эрүүгийн хуульд хугацаанаас өмнө суллах, өөр хөнгөн ялаар солих журмыг өмнөх эрүүгийн хуулийн уламжлалын дагуу хэрэглэхээр зохицуулсан ба энэхүү журмыг хэрэглэхгүй байх эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн хэргүүдээс гадна зарим тодорхой ялтны талаар нэмж тусгажээ. Тухайлбал, онц аюултай гэмт хэрэгтэн, цаазаар авах ял нь өршөөл уучлалын журмаар хорих ялаар солигдсон этгээд, урьдах гэмт хэрэгт ял шийтгэлгүйд тооцоогүй буюу ял шийтгэлгүй болоогүй байхад гэмт хэрэг санаатай үйлдэж хоёр, түүнээс дээш удаа хорих ял шийтгүүлсэн этгээд, хугацаанаас өмнө суллагдсан, хөдөлмөрт татан оролцуулахаар тэнсэн суллагдсаны дараа эдлээгүй үлдсэн ялын , эсхүл заавал хөдөлмөрлөх хугацаанд дахин санаатай гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэглэхгүйгээр заажээ.

2002 онд баталсан эрүүгийн хуулиар зарим тодорхой төрлийн гэмт хэргийн зүйл ангиар ялгаж хугацаанаас өмнө суллах, эсхүл уг журмыг хэрэглэхгүй байхаар зохицуулж байсныг халж гэмт хэргийн ангилал бүрд оногдуулсан ялын тодорхой хувийг эдэлсэн бол хугацаанаас өмнө суллах ба харин цаазаар авах ял шийтгүүлж уучлагдсан, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй этгээдэд хугацаанаас өмнө суллах журмыг хэрэглэхгүй байхаар шинээр зохицуулсан байна. 2015 оны Эрүүгийн хуульд оногдуулсан ялын тодорхой хувийг эдэлсэн бөгөөд хохирлоо бүрэн төлсөн хоригдолд хугацаанаас өмнө суллах журмыг хэрэглэхээр заажээ. Энэ нь хохирогчийн эрхийг хамгаалах, бодитоор сэргээхэд чиглэсэн⁶ эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх олон улсын эрх зүйн зохицуулалтын орчин цагийн чиг хандлагад нийцүүлсэн хууль тогтоогчийн үзэл баримтлал болсон.

Дээрхээс үзэхэд хугацаанаас өмнө суллах журмыг хорих ялаас гадна бусад үндсэн ялаар шийтгүүлсэн ялтанд нэгэн адил хэрэглэж байсан төдийгүй 1961, 1986 оны Эрүүгийн хуулиар хорих ялыг хугацаанаас өмнө суллах, эсхүл эдлээгүй үлдсэн ялыг өөр хөнгөн ялаар солих асуудлыг давхар зохицуулж байсан нь онцлогтой юм.

⁵ 1986 онд баталсан Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийг үзэх.

⁶ Эрүүгийн хуулийн 6.5, 6.7, 7.1 дүгээр зүйлд гэм буруугаа хүлээн зөвшөөрч, учруулсан хохирлоо нөхөн төлж гэм хорыг арилгасан, эсхүл учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн шүүгдэгчид хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх журмыг тусгаснаар илэрхийлэгдэнэ.

1926-1961 оныг хүртэлх хугацаанд мөрдөж байсан эрүүгийн хуулиар хорих болон албадан ажил хийлгэх ялын тэн хагас буюу хоёрны нэгийг эдэлсэн бол хугацаанаас өмнө суллах журмыг хэрэглэж байсан бол 1961 оноос хойш энэхүү журмыг тодорхой төрлийн зарим гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдүүдэд хамааруулан хэрэглэхээр бодлого баримталж байсан байна. Түүнчлэн хугацаанаас өмнө суллах, өөр хөнгөн ялаар солих журмыг **хэрэглэхгүй байх** тохиолдол, нөхцөлийг 1961, 1986, 2002 оны хуулиар нарийвчлан зохицуулж ирсэн. Харин 2015 онд баталсан Эрүүгийн хуулиар хугацаанаас өмнө **суллахгүй байх** тохиолдлыг тусгайлан заагаагүй боловч “хохирлоо бүрэн нөхөн төлсөн” байх шалгуур, болзлыг тусгасан нь хохирол төлөөгүй бол **хэрэглэхгүй** гэсэн логик агуулгаар хэрэгжүүлж байсан бол 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар⁷ оруулсан нэмэлтээр бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн 4 төрлийн хэрэг, албан тушаалын эсрэг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн зарим гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоохгүй байхаар заасан. Энэ нь бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн зарим төрлийн гэмт хэрэг болон авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах эрүүгийн хариуцлагыг чангатгах талаарх олон нийтийн санаа бодол, ашиг сонирхолд нийцүүлсэн төрийн бодлогын илрэл⁸ юм.

Хугацаанаас өмнө суллахын хууль зүйн үндэслэл, агуулга, ач холбогдол

Орчин цагийн⁹ эрүүгийн эрх зүйн эх сурвалж болох дээрх хуулиудаас үзэхэд эрүүгийн эрх зүйн ерөнхий ангийн эрүүгийн ял, хариуцлагаас чөлөөлөх судлагдахууны нэг хэсэг болох “хугацаанаас өмнө хяналт тогтоож суллах” асуудал нь хугацаанаас өмнө суллах, үлдсэн хугацааны ялыг өөр хөнгөн ялаар солих гэсэн **хоёр хэлбэрээр** тодорхой хугацаанд хэрэгжиж иржээ.

Хугацаанаас өмнө тэнсэж суллах нь зөвхөн хорих ялын хүрээнд биш хорихоос өөр төрлийн ялыг ч хамруулан хэрэглэж байсан нь сонирхолтой бөгөөд бас эргэж харахад илүүдэхгүй асуудал гэж үзэхээр байна. Тухайлбал, 1986 оны Эрүүгийн хуулиар нутаг заах, уг нутгаас зайлуулах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, сахилгажуулах ангид явуулах ялыг үндсэн болон нэмэгдэл ялаар хэрэглэж байсан ба эдгээр ялаас хугацааны өмнө тэнсэж суллах журмыг хэрэглэдэг байсан. Ингэхдээ хугацаанаас өмнө суллах **үндсэн шалгуур** нь оногдуулсан ялын талаас доошгүйг эдэлсэн ялтанд хэрэглэж байсан байна. Түүнчлэн зарим **болзолт шалгуур** тавьж суллах асуудлыг хэрэглэж ирсэн байна. Жишээ нь санаатай гэмт хэрэг үйлдэж 3-с дээш жилийн хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн болон ял шийтгэлгүй болоогүй байхад дахин санаатай гэмт хэрэг үйлдэж хорих ялаас шийтгүүлсэн бол оногдуулсан ялын гуравны хоёроос доошгүйг эдэлсний дараа, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн зарим гэмт хэргийг тусгайлан нэр заан дурдаж тухайн хэрэгт ял шийтгүүлсэн хүнийг оногдуулсан ялын дөрөвний гурваас доошгүйг эдэлсний дараа хэрэглэж болохоор зохицуулж байв.

⁷ Энэхүү нэмэлтээр Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд 6 дахь хэсэг нэмсэн. Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2024 оны №02 /1298/ 144 дэх тал

⁸ Энэ нь эрүүгийн эрх зүйн хүнлэг, энэрэнгүй ёсны зарчимд харшлах эсэх, шүүх, хуулийн болон хууль, шүүхийн өмнө тэгш байх зарчимд нийцэж байгаа эсэх нь өөрөө асуудалтай бөгөөд эрүүгийн эрх зүйн ерөнхий ангийн судлагдхууны хүрээнд авч үзэх чухал сэдэв байж болно.

⁹ Монгол улсад Ардын хувьсгал ялж ардын эрхт төр байгуулсан 1921 оноос хойшхи хугацааг шинжлэх ухааны салбар бүрт ийнхүү тодотгон хэрэглэдэг жишгийг дагав.

Хугацаанаас өмнө тэнсэж суллах, эсхүл суллахгүй байх үндсэн болон болзолт шалгуураар нь нэгдүгээрт гэмт хэрэг үйлдсэн хувь хүнээр нь, хоёрт үйлдсэн гэмт хэргийн шинжээр, гуравт гэмт хэргийн ангиллаар нь, дөрөвт хорих ялын хэмжээгээр нь хамааруулах **аргыг** ашиглан энэхүү журмыг хэрэглэж ирсэн гэж үзэхээр байна.

Гэмт хэрэг үйлдсэн хувь хүн /хоригдол/-ээр нь гэдэгт: онц аюултай гэмт хэрэгтэн, санаатай гэмт хэрэг үйлдэж 3-с дээш жилийн хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн болон ял шийтгэлгүй болоогүй байхад дахин санаатай гэмт хэрэг үйлдэж хорих ялаас шийтгүүлсэн хүн, цаазаар авах ял шийтгүүлж уучлагдсан, хугацаанаас өмнө суллагдсан, хөдөлмөрт татан оролцуулахаар тэнсэн суллагдсаны дараа эдлээгүй үлдсэн ялын, эсхүл заавал хөдөлмөрлөх хугацаанд дахин санаатай гэмт хэрэг үйлдсэн хүнд хэрэглэхгүй байх гэх мэт,

Үйлдсэн гэмт хэргийн шинжээр нь гэдэгт: төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэг, зандалчлах, бусдыг санаатай алах, онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх, онц их хэмжээтэй хулгайлах, хүндрүүлэх нөхцөл байдалтай хээл хахууль авах, онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах гэх мэт тухайн үед мөрдөж байсан эрүүгийн хуульд заасан зарим төрлийн гэмт хэргийн шинжээс хамааруулан уг журмыг хэрэглэж байсан. Энэхүү уламжлалыг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр сэргээн бага насны хүүхдийг алах, хүчиндэх, бэлгийн мөлжлөг хийх, худалдах гэмт хэрэг болон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт хэрэглэхгүй байхаар зохицуулсан гэх мэт,

Үйлдсэн гэмт хэргийн ангиллаар нь гэдэгт: 2002 оны Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйл буюу хүндэвтэр гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг, хүнд гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг, онц хүнд гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын тавны дөрвөөс доошгүй хувийг эдэлсэн тохиолдолд уг журмыг хэрэглэж болно гэж заасан.

Хорих ялын хэмжээгээр нь гэдэгт: 2015 оны Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд таван жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг, таван жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг, арван хоёр жилээс дээш хорин жил хүртэл оногдуулсан хорих ялын дөрөвний гурваас доошгүй хувийг эдэлсэн тохиолдолд хэрэглэж болохоор заасан байгааг ойлгож болно.

Хугацаанаас өмнө суллаж тэнсэх журмын хууль зүйн **үндэслэл** нь төрөөс оногдуулсан ялыг эдлэх хугацаандаа засарч хүмүүжсэнээ илтгэн харуулсан ялтан байх явдал юм. Энэ нь 1926, 1929 оны Шүүх цаазын бичигт “зан авир, үйлдвэрт хичээлтэйн¹⁰ аваас” гэж¹¹, 1934 оны Шүүх цаазын бичиг, 1942 оны Эрүүгийн хуульд “засрах төлөвийг илрүүлсэн”¹² гэж, 1961 оны Эрүүгийн хуульд “үлгэр жишээч шударга байдал, хөдөлмөрт үнэнч хандсанаараа өөрийн засарч хүмүүжсэнээ харуулж чадвал”¹³ гэж, 1986 оны Эрүүгийн хуульд “зөвхөн өөрийн засарч хүмүүжсэнээ үлгэр жишээ зан

¹⁰ Үнэнч шударга хөдөлмөрлөх чанар гэж ойлгохоор байна.

¹¹ Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) УБ 2011 он 287,317 дах тал

¹² Мөн тэнд 354,371 дэх тал

¹³ Мөн тэнд 432 дахь тал

төлөв, үнэнч шударга хөдөлмөрөөрөө харуулсан¹⁴ гэж, 2002 оны Эрүүгийн хуульд “засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан бол¹⁵” гэж, 2015 оны Эрүүгийн хуульд “гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлж, зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй” гэж тус тус тусган хэрэгжүүлж ирсэн байна.

Эндээс үзэхэд хугацаанаас өмнө суллах гол үндэслэл нь ял эдлэх хугацаандаа хорих ялын цээрлүүлэн хүмүүжүүлэх зорилгыг хангасан буюу хүмүүжиж зан төлөвийн хувьд үлгэр жишээ байх явдал байх бөгөөд түүнийг ялын тодорхой хувийг эдэлсэн байх шалгуурын хамт хэрэглэх нөхцөл бүрдэхээр зохицуулж ирсэн гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Үүнтэй холбоотойгоор “хугацаанаас өмнө суллаж тэнсэх” нь урамшуулал шагналын нэг хэлбэр юм уу, эсхүл төрийн энэрэнгүй ёсны бодлогын нэг илрэл юм уу гэдэг асуултад хариулах хэрэгтэй болно. Нөгөө талаас энэ нь хоригдлын эрх мөн эсэх нь сонирхолтой асуудал. Хугацаанаас өмнө суллах журмыг улс орнууд хэдий үеэс хэрхэн хэрэглэж ирсэн болох, анх ийм журмыг хэрэглэх болсон үндэслэл, шалтгаан юу байсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрүүгийн эрх зүйн сонгодог суурь болон тусгай зарчмуудад /шударга ёсны зарчим, ял гарцаагүй байх зарчим/ нийцэж байгаа эсэх, тэдгээрийн харилцан хамааралд хэрхэн зохицож байгаа зэргийг цаашид гүнзгийрүүлэн судалж, эрүүгийн эрх зүйн онолын эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх институтын¹⁶ түвшинд нарийвчлан үзэж судалгааны хүрээг тэлэх шаардлагатай юм.

Хугацаанаас өмнө эдлээгүй үлдсэн ялаас суллах журмыг¹⁷ эрүүгийн эрх зүйн ном, сурах бичгүүдэд “урамшууллын шинжтэй үйл ажиллагаа”¹⁸, “хорих ялаас тодорхой болзолтой суллаж, хяналт тогтоох арга хэмжээ”¹⁹, “ялын хугацааг дуустал эдлүүлэхгүйгээр суллах нь хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах нэг хэлбэр”²⁰, “ял эдлүүлэхээс бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөх үндэслэл, журам, нөхцөлийг заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, ял эдлүүлэх эрх зүйн институт”²¹ хэмээн өөр өөрөөр томъёолон авч үзсэн байна.

Манай улсын эрүүгийн эрх зүйн эх сурвалжуудад томъёолсон гол үндэслэл, үзэл санаа нь “засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулсан” байх явдал бөгөөд эндээс үзэхэд хорих ялаас хугацаанаас өмнө суллах нь ялтанд оногдуулсан хорих ялын зорилтыг богино хугацаанд хангасан, өөрөөр хэлбэл ялтныг нийгэмшүүлэх, хохирлыг нөхөн төлүүлэх зорилт тухайн ялын хугацаанаас өмнө биелэгдсэн²² гэж үзэж төрийн

¹⁴ Мөн тэнд 530 дахь тал

¹⁵ Мөн тэнд 716 дахь тал

¹⁶ Г. Гантөмөр нар. Эрүүгийн эрх зүй ерөнхий анги (сурах бичиг) УБ. 2020 он. 440 дэх тал

¹⁷ Эрүүгийн хуулийн Зургаадугаар бүлэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх, чөлөөлөх үндэслэл, журамыг зохицуулж, 6.12 дугаар зүйлд “Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоох” асуудлыг журамласан байна.

¹⁸ Монгол улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сангаас эрхлэн хэвлүүлсэн Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2010 он. 216 дах тал

¹⁹ О. Батсүх. Эрүүгийн эрх зүй ерөнхий анги. УБ. 2021 он. 274 дэх тал

²⁰ Г. Гантөмөр нар. Эрүүгийн эрх зүй ерөнхий анги (сурах бичиг) УБ. 2020 он. 442 дах тал

²¹ С. Нарангэрэл. Монгол улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. УБ. 2021 он. 637 дах тал

²² Г. Гантөмөр нар. Эрүүгийн эрх зүй ерөнхий анги (сурах бичиг) УБ. 2020 он. 442 дах тал

нэрийн өмнөөс шүүхийн шийтгэх тогтоолоор өгсөн буруутгалыг зогсоож²³ буй эрүүгийн эрх зүйн ялаас чөлөөлөх институтын нэг төрөл²⁴ юм.

Хорих ялаас хугацааны өмнө суллах журмыг хэрэглэхийн **хууль зүйн ач холбогдол** нь хоригдол хүнийг богино хугацаанд засарч хүмүүжин тухайн ялын цээрлүүлэх, хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, нийгэмшүүлэх²⁵ зорилгыг хугацаанаас нь өмнө биелүүлэхэд оршино. Өөрөөр хэлбэл ялын дээрх зорилгыг өөрийн зан төлөв, хөдөлмөрт хандах хандлага, хохирлыг нөхөн төлсөн байдлаараа тодорхой богино хугацаанд хангасан болохоо харуулж нийгэмших сэдлийг дэмждэг арга хэрэгсэл болдгоороо чухал ач холбогдолтой.

Энэ нь дэлхийн бусад улс оронд хорих ялаас хугацаанаас өмнө суллах журмыг хэрэглэж байгаа зорилго, үндэслэлээс тодорхой харагдаж байна. Тухайлбал, **Япон улсын** хоригдлыг засрал олох үндсэн хэрэгсэл нь хөдөлмөр гэж үзэж хоригдлын хөдөлмөрийг зохион байгуулах эрх зүйн үндэслэл нь Хөдөлмөрийн тухай хууль байдаг байна. Ялыг хугацаанаас өмнө суллах нэг гол үндэслэл нь “Чин сэтгэлийн ухаарал” олсон байх явдал²⁶ гэж үздэг нь манай улсын эрүүгийн хуулийн эх сурвалжуудад “хөдөлмөрт үнэнч хандсанаараа өөрийн засарч хүмүүжсэнээ харуулж чадвал” гэсэн үндсэн үзэл баримтлалтай адил байна.

Оросын Холбооны улсын Эрүүгийн хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар “... өөрийн засрал хүмүүжлээрээ шүүхээс оногдуулсан ялыг цаашид эдлэх шаардлагагүй болсон” гэж үзвэл хугацаанаас өмнө суллана гэж заасан байна²⁷.

Хятад улсын эрүүгийн хуулийн 81 дүгээр зүйлд “...сурган хүмүүжүүлэн өөрчлөхийг хүлээж, үнэхээр гэмшин засрах илрэлтэй бөгөөд тэнсэж сулласны дараа нийгэмд дахиж хор хөнөөл учруулахад хүрэхгүй бол” тэнсэн суллаж болно²⁸ гэж заасан нь бидний нэгэн адил “засарч хүмүүжсэн байх нь” гол үндэслэл гэж үзжээ.

Харин **Герман улсын** эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлд “... олон нийтийн аюулгүй байдалтай нийцсэн бөгөөд ялтан өөрөө хүлээн зөвшөөрсөн” бол түүний хувийн зан байдал, үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, хорих ялын үлдсэн хугацаанаас түдгэлзүүлснээр²⁹ ялтанд үзүүлэх нөлөө зэргийг шүүх онцгой анхаарч үзэх ёстой гэсэн нь өвөрмөц бөгөөд ял эдлэх хугацаандаа хүмүүжсэн байдлыг ерөнхийд нь авч үздэг онцлогтой байна.

Хорих ялаас хугацааны өмнө суллах журмын практик хэрэглээ ба боловсронгуй болгох нь /хэрэгжилт, алдаа оноо/

Орчин үеийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд хүнлэг, энэрэнгүй ёсны зарчим, чиг хандлагуудыг түлхүү хэрэгжүүлэх болсонтой холбоотой эрүүгийн хуулийн ерөнхий

²³ С. Нарангэрэл. Монгол улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ.1999 он. 336 дах тал

²⁴ Ялаас чөлөөлөх институтын төрлүүдийг Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14 дүгээр зүйлд зааснаар /хугацаанаас өмнө суллах, өвчний учир ялаас чөлөөлөх, өршөөл, уучлал үзүүлж чөлөөлөх / хэрэгжүүлдэг.

²⁵ Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

²⁶ М. Алтан-Очир. Хорих ял эдлүүлэх дэглэм. УБ. 2020 он. 95-96 дах тал

²⁷ Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль. УБ. 2021 он. 125 дах тал

²⁸ Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль. УБ. 2021 он. 274 дэх тал

²⁹ Мөн тэнд. 368 дах тал. Энд үлдсэн хугацаанаас суллах биш харин түдгэлзүүлэх гэж хэрэглэдэг байна.

ангид олон шинэлэг³⁰ зохицуулалтууд орсоор байна. Эрүүгийн хариуцлагын гол зорилго нь гэмт этгээдийг залхаан цээрлүүлэх, аль болох хатуу ял оногдуулахад чиглэж байсан бол өдгөө нийгмийн сэргэлдөөнийг шийдвэрлэх буюу хохирогчийн байр суурийг түлхүү харгалзаж хохирол барагдуулсан байх нь нэн тэргүүний зорилт болон хувирч байна. Үүнтэй холбогдуулан хорих ялаас хугацаанаас өмнө суллах журмыг ч илүү боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага урган гарч байна. Ялангуяа эрүүгийн ялын зайлшгүй байх зарчим, шударга ёсыг тууштай хангах зарчмыг улс орон бүрт эрүүгийн эрх зүйн чухал зарчмуудад тооцон хэрэгжүүлсээр³¹ байгаа бөгөөд үүнийг хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг зөрчихгүйгээр хэрхэн тэнцвэрт байдлыг хадгалах вэ гэдэгт анхаарах ёстой.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах нь шүүхийн шийтгэх тогтоолын заавал биелүүлэх хууль зүйн шаардлага, шүүхийн хараат бус байдалд ч сэргөөр нөлөөлдөг.³²

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах журмыг хэрэгжүүлж байгаа шүүх, прокурорын практик хэрэглээнээс үзэхэд “зан байдлаараа нийгэмд аюулгүй болсноо нотлон харуулсан” байх гол үндэслэлийг Улсын Дээд шүүхийн 1995 оны 390 дүгээр тогтоолоор³³ тайлбарласан хэмжээ хязгаараас хэтрэхгүй байна. Үүнийг дараах хоёр жишээнээс харж болно. Говь-Сүмбэр аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хоригдол С-г “ялтан засарч хүмүүжсэнээ нотолж чадаагүй” гэсэн үндэслэлээр прокурорын дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож шийдсэн. Үүнийг эс зөвшөөрч бичсэн прокурорын эсэргүүцлээр давж заалдах шатны шүүх хянан хэлэлцээд “зан байдлаараа аюулгүй болсноо нотлон харуулсан” нь тогтоогдсон гэж үзээд ялтан С-н эдлээгүй үлдсэн 11 сар 6 хоногийн хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, анхан шатны шүүхийн захирамжийг хүчингүй болгосон³⁴ байна.

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хоригдол Ц.П нь “засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулсан нь хангалттай тогтоогдоогүй, түүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал нь болзол хангаагүй” гэсэн³⁵ үндэслэлээр прокурорын дүгнэлтийг хэрэгсэхгүй болгожээ. Ямар байдлаар яагаад тогтоогдоогүй гэж үзсэнээ шүүх захирамждаа тодорхой дурдаагүй гэсэн үндэслэлээр прокурор эсэргүүцэл бичсэнээр Нийслэлийн давж заалдах шатны шүүх хянан хэлэлцээд “... “засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулсан...” гэдгийг ялтан ял эдлэх хугацаандаа хорих ангийн дотоод

³⁰ Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, ялаас чөлөөлөх, ялыг хөнгөрүүлэх, цаазаар авах ялыг халах, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх, хорихоос өөр төрлийн ял оногдуулах журмыг өргөн хэрэглэх болсон.

³¹ МУИС. Эрх зүй сэтгүүл. 2013 он. №01 69 дэх тал

³² Шүүх нь гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, үйлдсэн хэргийн нийгмийн хор аюулын шинж, хэр хэмжээ гэмт хэрэг үйлдэгдсэн байдал зэргийг харгалзан үзэж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ялын төрөл, хэмжээг тодорхойлон шударга ёсны зарчимд нийцүүлэн ял оногдуулдаг. Өөрөөр хэлбэл 10 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол заавал биелэгдэх ёстой байтал 6 жил орчмыг эдэлсэн бол хугацаанаас өмнө суллаж байгаа нь шийтгэх тогтоолын заавал биелэх шинжийг үгүйсгэхэд хүргэнэ. Нөгөө талаар Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.12 дугаар зүйлд заасан үндэслэл, нөхцөл болзлыг хангасан гэж үзэж шүүхэд прокурор дүгнэлт хүргүүлснээр шүүх хугацаанаас өмнө суллаж шийддэг нь шүүхийн хараат бус байдалд нөлөөлсөн гэж үзэж болно.

³³ Монгол улсын дээд шүүхийн тогтоолын эмхтгэл УБ. 1999 он. 165 дах тал

³⁴ Говьсүмбэр аймгийн Давж заалдах шатны шүүхийн магадлал. 2023 он. [Zoggii.mn/post/7581964](https://zoggii.mn/post/7581964) хамгийн сүүлд үзсэн 2024-03-15

³⁵ Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 42 дугаар шүүгчийн захирамж.

журам, дэглэмийн шаардлагыг хэрхэн сахин биелүүлж байсны дотор /авсан шагнал урамшуулал, гаргасан зөрчил дутагдал, эзэмшсэн мэдлэг, боловсрол, бусадтай харьцах харьцаа, хүмүүжлийн нөлөө/ зэрэг асуудлуудыг нэг бүрчлэн авч үзэж, түүний хувийн байдал, зан төлөв, үйлдсэн гэмт хэргийн ангилал, нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээтэй харьцуулан дүгнэх учиртай. Хэрэгт авагдсан нотлох баримтуудаас үзэхэд Ц.П нь эдэлбэл зохих ялаас тодорхой хугацааны ялыг эдэлсэн боловч засарч хүмүүжин дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх итгэл үнэмшил төрүүлэхүйц нөхцөл байдал тогтоогдохгүй байна.” гэж дүгнэж прокурорын эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож шийджээ.³⁶

Эндээс үзэхэд хорих ялаас хугацаанаас өмнө суллах гол үндэслэл болох “зан байдлаараа аюулгүй болсноо нийтэд харуулсан” гэх ойлголтыг шүүх тухайн хоригдлын хувьд хэрхэн ойлгож хэрэглэснээс³⁷ хамаарч шийдвэрлэдэг нь харагдаж байна.

Тус Хархорин сум дахь Сум дундын прокурорын газраас сүүлийн 5 жилд хорих ангиас ирүүлсэн хоригдлыг хугацаанаас өмнө суллах 1223 саналыг хүлээн авч хянаад 307 хоригдлын хувийн хэргийг хорих ангид буцаан хүргүүлсэн байна. Буцаасан үндэслэлүүд нь:

а/ шагналын хоног орохгүйгээр биечлэн эдэлсэн хугацаа бага байгаа нь ялын цээрлүүлэх зорилгыг хангаагүй,

б/ үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж, хэр хэмжээ их, гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал хүнд,

в/ хоригдлын хувийн байдал буюу удаа дараа нэг төрлийн гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, өмнө нь өршөөл үзүүлэх хуульд хамрагдаж байсан, мөн хугацаанаас өмнө суллагдаж дахин гэмт хэрэг үйлдсэн гэх зэрэг шалтгааныг үндэслэжээ.

Бидний хийсэн судалгаагаар 2019-2023 он, 2024 оны эхний улиралд тус Хархорин сум дахь Сум дундын прокурорын газрын хяналтын харьяа Нээлттэй, хаалттай 423 дугаар хорих ангиас хорих ялаас хугацааны өмнө суллагдсан нийт 916 хоригдлоос 480 хоригдол нь дахин гэмт хэрэг үйлдсэн, үүнээс 3 удаа ял шийтгүүлсэн 112, 4 ба түүнээс дээш удаа ял шийтгүүлсэн 158 байгаа бөгөөд тэдний 76 буюу 48,1% нь өмнө нь хорих ялаас хугацааны өмнө суллагдаж байжээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

³⁶ Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал. 2016-08-25. №549
https://shuukh.mn/single_case/2034?start_date=&end_date=&id=2&court_cat=2&bb=1 сүүлд үзсэн 2024-03-15

³⁷ Тухайн шүүгч тухайн хоригдлын хувьд хэрхэн үнэлсэнээс хамаарч түүний үзэмжээр шийдэгдэж байгаа бөгөөд Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд заасан хугацаанаас өмнө суллах журам нь шүүхэд эрх олгосон хэм хэмжээ учраас хуулийг буруу хэрэглэсэн гэж үзэж шүүгчийн захирамжийг хүчингүй болгох боломжгүй байдалд хүргэнэ.

Хүснэгт №01. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нээлттэй, хаалттай 423 дугаар хорих ангиас хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан болон дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлын тоо

№	Он	Бүгд	Хоёроос дээш удаа ял шийтгүүлсэн хоригдол					
			2 түүнээс дээш удаа	Хувь	Үүнээс	Үүнээс		
					4 түүнээс дээш удаа	4 удаа	5 удаа	6 түүнээс дээш удаа
1	2019	207	80	38.6%	36 буюу 45%	19 буюу 52.8%	8 буюу 22.2%	9 буюу 25%
2	2020	222	129	58.1%	40 буюу 31%	18 буюу 48%	8 буюу 20%	14 буюу 35%
3	2021	171	101	59%	33 буюу 32.6%	13 буюу 40.3%	10 буюу 30%	10 буюу 30%
4	2022	81	42	52%	12 буюу 28.5%	5 буюу 41.6%	3 буюу 25%	4 буюу 33.4%
5	2023	172	91	53%	30 буюу 33%	6 буюу 20%	6 буюу 20%	18 буюу 60%
6	2024 оны эхний 3 сард	63	37	58.7%	7 буюу 19%	6 буюу 85.7%	-	1 буюу 14.2%
7	Нийт	916	480	52.4	158 буюу 33%	67 буюу 42.4%	35 буюу 22.2%	56 буюу 35.4%

Нийт суллагдсан 916 хоригдлоос 3 удаа ял шийтгүүлсэн 112 хоригдол байгаа бөгөөд энэ нь 2-с дээш удаа ял шийтгүүлсэн 480 хоригдлын 23,3%-ийг, нийт хугацаанаас нь өмнө суллагдсан 916 хоригдлын 12,2%-ийг эзэлж байна. Давтан гэмт хэрэг үйлдсэн бөгөөд хугацаанаас өмнө суллагдсан нийт 480 хоригдлын 136 буюу 28,3% нь өмнө нь 1-с доошгүй удаа хугацаанаас өмнө суллагдаж байжээ. Эндээс үзэхэд ял гарцаагүй байх зарчим хэрхэн алдагдаж, нийгэмд уг зарчмын үнэлэмжийг бууруулж, ялангуяа хохирогчийн хүсэн хүлээсэн үр дүнг сулруулж нийгмийн сөргөлдөөнийг бууруулахгүйд хүргэж байгаад дүгнэлт хийх шаардлагатайг харуулж байна.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүн дахин санаатай гэмт хэрэг үйлдэж байгаа нь тухайн ялын цээрлүүлэх зорилтыг үгүйсгэхээс гадна хугацаанаас өмнө суллах үндэслэл, нөхцөл болзлыг хэрхэн хангасан болохыг тодорхойлох бодит үзүүлэлт, нотлох аргачлал нь тодорхойгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

Тодруулбал, зан байдлаараа аюулгүй болсноо нотлон харуулсан гэх үндэслэлийг хэрхэн ямар бодит шалгуураар тодорхойлох вэ гэдэг нь хуулиар зохицуулагдаагүй байна. Засарч хүмүүжсэн буюу нийгэмд аюулгүй болсныг нотлох асуудал тодорхойгүй байгаагаас хугацаанаас өмнө суллагдсан олон хүн удаа дараа гэмт хэрэг үйлдэж /ихэнх тохиолдолд өмнө нь үйлдэж байсан гэмт хэрэгтэй ижил төрлийн хэргийг дахин үйлддэг/ дахин хорих ялаар шийтгүүлсээр байна. Тухайлбал, дээрх хугацаанаас өмнө суллагдсан 916 хоригдлоос 3 ба түүнээс дээш удаа гэмт хэрэг үйлдсэн 270 хоригдлын 151 буюу 56% нь хулгайлах гэмт хэрэг, 35 буюу 16% нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах, дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн байна. Хатуухан хэлбэл тэднийг хугацаанаас өмнө суллаж дахин гэмт хэрэг үйлдэх нөхцөлийг бүрдүүлсэн гэж

үзэхээр байна. Тэд дахин гэмт хэрэг үйлдэхдээ хэдэн жилийн ял авах, түүний хэдэн хувийг эдлээд хэзээ хугацаанаас өмнө суллагдахаа тооцсон байдаг нь нууц биш юм.

Дүгнэлт

Дээрх нөхцөл байдлуудыг нэгтгэн үзвэл дараах дүгнэлтэд хүрч болохоор байна. Үүнд:

1. Хорих ялаас хугацаанаас өмнө суллах Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн журмыг эрүүгийн эрх зүйн харилцаа олон улсын шинжтэй болж, хувийн эрх зүйн диспозитив хэм хэмжээний агууламж өсөж, ял оногдуулахад хохирогчийн нөлөө нэмэгдэх хандлагатай болсон³⁸ өнөө цагт цаашид улам боловсронгуй болгож хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Тухайлбал, ялаас чөлөөлөхдөө шударга ёсны болон ял гарцаагүй байх үзэл баримтлалуудыг зөрчихгүйгээр зохицуулах хэм хэмжээг Эрүүгийн хуульд бий болгож салбарын хуулиудын зохицуулалтыг эргэн харж хугацаанаас өмнө суллах асуудлыг илүү нарийвчлан тодорхой болгох шаардлагатай³⁹ болжээ.

2. Ялын цээрлүүлэх, хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх зорилтыг хангах үүднээс хорих ялаас хугацаанаас өмнө суллах журмыг хэрхэн хэрэгжүүлэх талаар Эрүүгийн хуулийн хэм хэмжээг тодорхой болгож дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх хэрэгцээ ч бий болсон байна. Тодруулбал, хорих ялаас хугацаанаас өмнө суллах журмыг хэрэглэхгүй байх хэргийн /хаалттай/ талаар уг заалтад нэг нөхцөл, болзол болгож заах, зан байдлаараа нийгэмд аюулгүй болсноо нотлон харуулсан байх гол үндэслэлийг хэрхэн ойлгох талаар аутентик тайлбар ч шаардлагатай болсон байна.

3. Эрүүгийн хуулиар хязгаарласан хаалттай⁴⁰ гэмт хэрэг үйлдээгүй бол хугацаанаас өмнө суллагдах эрх бүх хоригдолд нээлттэй байна. Өөрөөр хэлбэл хугацаанаас өмнө суллах нь хоригдлын засрал хүмүүжилтэйгээр ялаа эдэлдэг байх хүсэл эрмэлзлийг бий болгосон хамгийн чухал хүчин зүйл, хөшүүрэг болж чадсан байна. Үүгээр уг журмын мөн чанар, хууль зүйн ач холбогдол тодорхойлогдож байгааг дээр дурдсан. Хүний эрхийн үндэсний комиссоос 2022 онд хийсэн Монгол улс дахь хоригдлын ажил хөдөлмөрийн нөхцөл байдал тодорхойлох судалгаагаар 90 гаруй хувь нь “эдлэх ялаас хасдаг учраас хөдөлмөр эрхэлдэг” гэсэн⁴¹ нь шагналын хоног авч хугацаанаас өмнө суллагдахад “ялын тодорхой хувийг эдэлсэн байх” нөхцөл болзлыг хангадаг учир ажил эрхлэх хүсэл эрмэлзэлтэй болдог байна.

4. Хугацаанаас өмнө суллах үндсэн үндэслэл болох “зан байдлаараа аюулгүй болсноо нотолсон” гэх үндэслэлийг хэрхэн тодорхойлж тогтоох, ямар нотлох баримтууд заавал авагдсан байх, ямар шалгуур үзүүлэлтийг яаж хангасан байх зэрэг нь практикт төдий л тодорхой болж нэг мөр төлөвшөөгүй байна гэж үзэж болохоор байна.

³⁸ Монголын төр, эрх зүй сэтгүүл. 2022 он. №2 (100) 106 дах тал

³⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 225 дугаар зүйлийн зохицуулалт олон улсын эрүүгийн эрх зүйн орчин цагийн чиг хандлагаас хоцорсон гэж үзэхээр байна.

⁴⁰ Хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоохгүй гэмт хэргүүдийг 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуулиар тогтоож ирсэн бөгөөд тухайн үеийн хууль зүйн албан ёсны баримт бичгүүдэд “хаалттай зүйл, анги” гэж нэрлэн хэрэглэж байжээ.

⁴¹ <https://ikon.mn/n/2rzo> хамгийн сүүлд үзсэн 2024-03-15

Санал

Энэхүү илтгэлийн сэдвийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

Холбогдох хуулиудад тусгуулах санал:

1. Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд заасан хууль зүйн үндэслэл болох “зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулсан” гэх нөхцөлийг хуульд аутентик тайлбар хийх байдлаар нарийвчлан тодорхой болгох нь практикт ойлгож хэрэглэхэд хялбар байх болно. Одоогийн байдлаар Улсын дээд шүүхийн 1995 оны тогтоолоор тайлбарласан хэмжээ хязгаарын дотор ойлгон хэрэгжүүлж байгаа нь орчин цагийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцэж байгаа эсэх нь эргэлзээтэй юм. Шагналын хоногийг эдлэх ялд нь оруулан тооцох эсэх нь хуулиар зохицуулагдаагүй хэр нь “ялын зохих хувийг эдэлсэн” гэх шалгуурт оруулж ирсэн, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, хоригдлын хувийн байдлыг хэрхэн ямар шалгуураар үнэлж үзэх нь тодорхойгүй байгааг арилгах хэрэгтэй. Ингэснээр “**Nulla poeng sine Lege**” зарчмын нэг хэсэг болох “**lex certa**” буюу тодорхой байдлын зарчмыг⁴² Эрүүгийн хуулийн үзэл баримтлалд /хууль ёсны зарчмын агуулгад байдаг хэдий ч/ оруулан⁴³ цаашид хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Энэ хүрээнд ялын тодорхой хувийг эдэлсэн байх нь нөхцөл⁴⁴, болзол, шалгуур, эсхүл шаардлагын аль нь болохыг ч нэр томъёоны хувьд тодорхой болгох нь эрх зүйн шинжлэх ухааны ойлголтыг нэг мөр болгох ач холбогдолтой.

2. Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлийн 1.2 дах заалтын “бүлэглэж үйлдсэн,” гэсний дараа “эсхүл өмнө нь санаатай гэмт хэрэг үйлдэж хорих ялаас хугацаанаас өмнө суллагдаж байсан” гэдэг нөхцөлийг нэмж оруулах. Хэрэв энэ нь эрүүгийн эрх зүйн “**Ne bis in idem**” буюу “нэг гэмт хэрэгт нэг л удаа ял шийтгүүлэх” зарчимтай зөрчилдөнө гэж үзвэл Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “үйлдсэн” гэсний дараа “өмнө нь санаатай гэмт хэргийг 3 түүнээс дээш удаа үйлдэж хугацаанаас өмнө суллагдаж байсан” гэсэн нөхцөл /гипотези/ нэмэх шаардлагатай. Энэ нь хугацаанаас өмнө суллах журмын хууль зүйн ач холбогдол, үр нөлөөг дээшлүүлэх чухал хөшүүрэг болно гэж үзэж байна. Нөгөө талаар гэмт хэрэг үйлдсэн тухайн хоригдлын хувьд эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх шударга ёсны зарчимд нийцсэн бодлого болно.

3. Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлийн 2, 3, 4, 5 дахь хэсгийн нөхцөл журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.6 дугаар зүйлийн 2,3,4,5 дахь хэсэгт дахин хуулбарлан зааж материаллаг суурь хууль болон процессын хуулийн хэм хэмжээг давхардуулан ялгаагүй болгосон байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээ нь гэмт хэрэг болон эрүүгийн хариуцлагын асуудлыг журамласан нийтлэг хэм хэмжээ буюу урьдчилсан нөхцөлүүд /гипотези/ байдаг бол процессын хуулийн хэм хэмжээ нь эрүүгийн хуулийн хэрэгжилтийг хангуулахад чиглэдэг. Ийм учраас Эрүүгийн

⁴² Тодорхой байдлын зарчим нь эрүүгийн эрх зүйн гол зарчмуудын нэг бөгөөд хуулийн зүйл, заалтын үг, агуулга нь тодорхой байж өөр утга, хоёрдмол эргэлзээтэй утга санаа агуулахгүй байхыг илэрхийлнэ.

⁴³ МУИС. Эрх зүй сэтгүүл. 2014 он. №1 (27) 94 дэх тал

⁴⁴ Эрх зүйн сурах бичиг, нэг сэдэвт бүтээлүүдэд хугацаанаас өмнө суллах үндсэн үндэслэл болон нөхцөл шалгуурыг хольж нийлүүлэн “4 шаардлагыг хангасан байх” гэх мэтээр бичиж байна. Judcouncil.mn/news_full/13359 сүүлд үзсэн 2024-03-15

хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.6 дугаар зүйлээс Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн давхардсан хэм хэмжээг хасаж, хорих ялаас хугацаанаас өмнө суллах журмыг хэрхэн хэрэглэх талаарх заалт шинээр оруулах ёстой. Тухайлбал, цагдан хоригдсон хоног, шагналын хоног⁴⁵, ял эдлэх хугацаандаа өвчтэй, чөлөөтэй байсан хугацааг хэрхэн ял эдэлсэн хугацаанд оруулан тооцох ажиллагаа, мөн өршөөлийн хуулиар ялаас хасагдсан тохиолдолд үлдсэн ялаас хугацаанаас өмнө суллах асуудлыг ч тодорхойлон уг 37.6 дугаар зүйлд заах хэрэгтэй.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 225 дугаар зүйлийн 225.2 дахь хэсэгт “прокурор үндэслэлтэй гэж үзвэл 5 хоногийн дотор дүгнэлт үйлдэн шүүхэд хүргүүлэх ба шүүх 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэсэн нь салбарын хуулиар зохицуулах биш харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулах процесс ажиллагаа байх тул үүнийг дээрх 37.6 дугаар зүйлд оруулж журамлах ёстой гэж үзэж байна. Мөн уг зүйлийн 225.3 дахь хэсгийн “прокурорын дүгнэлтийг шүүх хангаагүй бол уг асуудлыг 6 сарын дотор дахин авч хэлэлцэхгүй.” гэсэн нь мөн адил процессын хуулийн хэм хэмжээнд хамаарах юм. Үүнтэй холбоотойгоор дээрх 225 дугаар зүйлийн 225.2 дахь хэсгийн заалтыг “Энэ хуулийн 225.1-д заасан хурлаар хоригдол хуульд заасан шаардлагыг хангасан гэж шийдвэрлэсэн тохиолдолд хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга хорих ялаас хугацаанаас өмнө суллуулах, хяналт тогтоох саналаа хурлын тэмдэглэл, шаардлагатай бусад мэдээлэл, баримт бичгийн хамт ажлын 3 өдрийн дотор прокурорт хүргүүлнэ.” гэж өөрчлөн найруулах, 225.3 дахь хэсгийг “Хоригдлыг хорих ялаас хугацаанаас өмнө суллуулах тухай хорих ангийн саналыг прокурор хүлээн авахаас татгалзаж хоригдлын хувийн хэргийг хорих ангид буцаасан бол тухайн хоригдлын хувьд 3 сарын дотор дахин хэлэлцэхгүй.” гэж өөрчлөн найруулах саналтай байна. Учир нь хугацаанаас өмнө суллах саналаар ирсэн хоригдлын үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж, хэр хэмжээ, хувийн байдал, биечлэн эдэлсэн ялын хэмжээг харгалзан “зан байдлаараа нотлон харуулсан” гэх үндсэн шалгуурыг хангаагүй гэж үзсэн прокурорын шийдвэр үнэгүйдэж сарын дараа дахин саналаар оруулж ирдэг буруу практикийг таслан зогсооно

5. Зорчих эрхийг хязгаарлах ялаас хугацаанаас өмнө суллах журам хэрэглэх боломжтой бөгөөд энэ нь хэмнэлттэй байх эрх зүйн тогтолцооны суурь шаардлага, бодлогод нийцнэ гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл зорчих эрх хязгаарлах ялаар 4-с дээш жилээр шийтгүүлсэн тохиолдолд ялын гуравны хоёрыг эдэлсэн бол ялтны хувийн байдал, зан төлөвийг харгалзан хугацаанаас өмнө чөлөөлөх асуудлыг шүүх шийддэг байвал ял эдлүүлэхтэй холбоотой дэлхий нийтийн сэтгэлгээний чиг хандлагад ойртсон арга хэмжээ болохоос гадна шийтгэл оногдуулах асуудлаарх Олон улсын эрх зүйн хязгаарлалтын нэг болох “хорихтой холбоогүй арга хэмээ”-г хэрэгжүүлэх буюу 1990 оны Ерөнхий Ассамблейн Хорихтой холбоогүй арга хэмжээний тухай Нэгдсэн Үндэсний байгууллагын дүрмийг⁴⁶ хэрэгжүүлэх нэг алхам болно.

6. Хорих ялаас хугацаанаас өмнө суллах журам нь 1926 оноос өнөөг хүртэл эрүүгийн эрх зүйн онолын ялаас чөлөөлөх институт болон хөгжиж ирсэн ба хоригдлын засрал хүмүүжилтэй байх хүсэл сонирхлын гол хөшүүрэг, зан байдалд нөлөөлөх хууль

⁴⁵ Шагналын хоногийг эдэлсэн ялд оруулан “ялын зохих хувийг эдэлсэн” гэх болзлыг хангуулж байгаа ба үүнийг хуулиар биш УДШ-ийн тогтоолоор журамлаж ирснийг халах цаг болсон.

⁴⁶ Энэхүү Токиогийн дүрэмд хорихоос тэнсэн суллах болон шүүхийн хяналт гэж хорихтой холбоогүй арга хэмжээнд оруулсан.

зүйн чухал арга хэрэгсэл болсон байна. Энэ утгаараа хоригдол бүрд нээлттэй байдаг боломж учраас хоригдлын эдлэх нэг эрх болгож хуульд тусгах цаг болсон байна. Ийм учраас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 210 дугаар зүйлд “Эрүүгийн хуулиар хязгаарласан, эсхүл хаалттай зүйл, ангид заасан гэмт хэрэг үйлдээгүй бол хугацаанаас өмнө суллагдах” гэсэн 210.1.16 дахь хэсэг нэмж 100 орчим жилийн хугацаанд хоригдолд эдлүүлж ирсэн **боломж** буюу **эрхийг** хуульчлан хэлбэржүүлэх саналтай байна.

7. Өсвөр насны ялтанд хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас хугацаанаас өмнө суллах, өөр хөнгөн ялаар солих асуудлыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангиар журамлах хэрэгцээ бий гэж үзэж байна. Учир нь насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал нь тэдний нийгмийн юмс үзэгдэлд хандах сэтгэлгээ, ухамсрын түвшин бүрэн төлөвшөөгүйтэй холбоотойгоор үйлдэгдэх нь түгээмэл. Насанд хүрээгүй хоригдлыг шашин, буяны болон олон нийтийн хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагад ажиллаж ялаа эдлэхийг зөвшөөрдөг Францын туршлагыг ч хэрэгжүүлэхэд болохгүй гэх газаргүй юм. Франц улсын шүүх ялтныг хугацаанаас өмнө суллахад өргөн эрх эдэлдэг онцлогийг ч энэ хүрээнд судлан хэрэгжүүлэх боломжтой.

Хуулийн хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн бусад арга хэмжээ авах хүрээнд тавих санал:

1. Хоригдлын ялын түүхийг судлан нийгэмшүүлэх ажлыг 3 ба түүнээс дээш удаа гэмт хэрэг үйлдсэн хоригдолд тусгайлсан хөтөлбөрөөр зохион байгуулж дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлэх боломжтой байна. Япон улсад ялтныг ялын хугацаанаас өмнө суллахдаа олон нийтийн байгууллагатай хамтарсан нийгэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулсны дараа сулладаг байна. Энэ нь тухайн ялтан дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд тухайн ялтан “Чин сэтгэлийн ухаарал” олсон байх нь ялын хугацаанаас өмнө суллах үндэслэл болдог. Уг ажиллагааг ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүмүүст зөвлөгөө өгч тэдэнтэй хамтран ажиллахад чиглүүлдэг тул “Чин сэтгэлийн ухаарал” олсон ялтан дахин гэмт хэрэг үйлдэх магадлал нь буурч ялаас хугацаанаас өмнө суллагдсаны дараа ял эдлүүлэх байгууллагаас явуулдаг аливаа хөтөлбөрт идэвхтэй оролцож хариуцлагатай ханддаг байна.⁴⁷ Ийм туршлагыг манай нөхцөлд ч хэрэгжүүлж болно гэж үзэж байна.

2. Хугацаанаас өмнө суллагдсан хүнийг цагдаагийн байгууллагын хараа хяналтад шилжүүлээд орхиж байгаа нь түүний цаашдын зан үйлийн бүрэн төлөвшилд огт нөлөөлөхгүй байна. Орон гэргүй, тогтсон амьдралгүй, гэр бүлгүй, өндөр настай зэрэг зарим бүлгийн хоригдлуудын хувьд нийгэмд гараад амьдралын зөв хэв маягт орох хүртэл хөл алдах явдал түгээмэл байна. Тэдэнд цагдаагийн хяналт огтхон ч үр нөлөө өгөхгүй, харин ч өмнөх ялтан байсан үеийнх нь байр сууринаас хандаж харьцдаг нь сэтгэлийн тэвчээр хатгүй хүнийг дахин гэмт хэрэг зөрчил үйлдэх сэдэл төрүүлэхүйц хэмжээнд байгаа гэж үзэхээр байна. Ийм учраас хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүмүүсийн ялын түүхийг судлан ангилж дахин нийгэмшүүлэх хөтөлбөр, төслийг өргөн хэрэглэх тогтолцоог бий болгох ёстой. Үүнд нутгийн захиргааны байгууллага буюу сум, хороодын Засаг даргын тамгын газрын эсхүл гэр бүл, хүүхэд

⁴⁷ М. Алтан-Очир. Хорих ял эдлүүлэх дэглэм. УБ. 2020 он. 96 дах тал.

залуучуудын хөгжлийн газрын нэг чиг үүрэгт хамааруулан хэрэгжүүлэх боломжтой бөгөөд холбогдох хуулиудад тусган эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай.

Эцэст нь тэмдэглэхэд эрх зүйн систем нь улс орны эдийн засагт үр нөлөөтэй, хэмнэлттэй байх суурь бодлогод нийцсэн байх тул ялаас хугацаанаас өмнө суллах журмыг дэлхий нийтийн ял эдлүүлэх ажиллагааны чиг хандлагатай нягт уялдуулан боловсронгуй болгож хэрэгжүүлэх нь эрх зүйн хүмүүнлэг энэрэнгүй ёсны зарчмын агуулгыг төгөлдөржүүлсэн арга хэмжээ болно.

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын 1926, 1929, 1934 оны Шүүх цаазын бичиг хууль, 1942, 1961, 1986, 2002, 2015 оны Эрүүгийн хуулиуд
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он
4. Франц, ХБНГУ, БНХАУ, ОХУ-ын эрүүгийн хуулиуд

Ном, сурах бичиг:

1. С. Нарангэрэл. Монгол улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ.1999 он.
2. Г. Гантөмөр нар. Эрүүгийн эрх зүй ерөнхий анги (сурах бичиг) УБ. 2020 он
3. О. Батсүх. Эрүүгийн эрх зүй ерөнхий анги. УБ. 2021 он.
4. С. Нарангэрэл. Монгол улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. УБ. 2021 он
5. М. Алтан-Очир. Хорих ял эдлүүлэх дэглэм. УБ. 2020 он
6. Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл УБ. 1999 он.
7. Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль. УБ. 2021 он.
8. Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) УБ 2011 он
9. Улсын Дээд шүүх, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангаас эрхлэн хэвлүүлсэн Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2010 он

Сэтгүүл:

1. МУИС. Эрх зүй сэтгүүл. 2013 он. №01, 2014 он. №1
2. Монголын төр, эрх зүй сэтгүүл. 2022 он. №2 (100)
3. Хууль дээдлэх ёс сэтгүүл 2023 он №2

Шүүхийн шийдвэр:

1. Говь-Сүмбэр аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 67 дугаар шүүгчийн захирамж
2. Говь-Сүмбэр аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 17 дугаар магадлал
3. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 42 дугаар шүүгчийн захирамж.
4. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 549 дүгээр магадлал

Цахим эх сурвалж:

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://Legalinfo.mn>
2. Шүүхийн шийдвэрийн цахим сан. <https://shuukh.mn>
3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн албан ёсны сайт, Judcouncil.mn/news_full/13359
4. <https://ikon.mn/n/2rzo>
5. www.zogii.mn/post/7581964

ХОРИХ ЯЛЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ БА ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Нийслэлийн Прокурорын газрын хяналтын прокурор Н.Ихбаяр

Хураангуй:

Дэлхийн улс орнуудын хорих ял эдлүүлэх ажиллагаанд баримталж буй бодлого, чиглэл нь хүний заяагдмал эрх, эрх чөлөөг дээдэлж, энэрэнгүй, шударга ёсыг бий болгох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэж байгаа билээ.

Энэ ч утгаараа Монгол Улсад эрүүгийн ялын бодлого, ял шийтгэлийн төрөл, хорих ял эдлүүлэх ажиллагааг олон улсын жишигт хүргэхийг зорьж байгаа бөгөөд энэ асуудлыг эрх зүйн хүрээнд түүхчлэн судалж хорих ялын хэрэгжилтэд гарч буй хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудлыг практик судалгаанд үндэслэн тодорхойлж, дүгнэлт санал дэвшүүлсэн.

Түлхүүр үгс:

Ял, хорих ял, ял эдлүүлэх дэглэм, хүний эрх, эрх чөлөө.

Удиртгал

Манай улс Үндсэн хуульдаа *“хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон байгуулах, эрх зүйт төрийг төлөвшүүлэх”* гэж тодорхойлж эрх зүйн шинэчлэлийг үе шаттай хийж байгаа билээ.

Энэхүү шинэчлэлийн хүрээнд эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаанд зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүдийг оруулсан гэж болно. Тухайлбал: Хорих ял эдлүүлэх эрх зүйн орчин бүрэн шинэчлэгдэж, хорих ялыг нээлттэй, хаалттай дэглэмд эдлүүлэх болж ял эдлүүлэх ажиллагаанд дахь хүний эрхийн асуудал ихээр яригдах боллоо. Энэ ч утгаараа хорих ял эдлүүлэх явцад хүний эрхийг хангах ажил хэрхэн хангагдаж байгаад судлаачийн зүгээс үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон.

Үндсэн хэсэг

“Ял” гэсэн үг нь Латины “reina”, “punitas” буюу залхаалт, цээрлэл, төлөөс гэсэн үгнээс гаралтай.¹

Ялын тухай эртний гол үзэл, тодорхойлолт бол “Талионы”² буюу “нүдийг нүдээр, шүдийг шүдээр, амийг амиар” гэсэн зарчимд үндэслэж байсан. Нийгмийн хөгжлийн явцад хууль бус буруу үйлдлийн төлөө амь, шүд, нүдний оронд эд хөрөнгө, мал төлөх болон өөрчлөгдсөн ба энэхүү төлөөс төлөх зарчмыг “композиц”-ийн зарчим гэж нэрлэдэг байсан.

Дундад зууны үеийн сэтгэгчдийн ялын талаарх сургаалд “Төр шийтгэх эрхтэй”, “Ялын агуулга, зорилго нь юунд орших”, “Ял нь хүний оюун ухаан, ёс суртахуунд нөлөөлж чадах эсэх” гэсэн гурван асуудалд төвлөрч байсан төдийгүй ялын зорилгыг шашинтай холбож үзэх “инквизац”-ийн зарчим мөн ноёлж байсан. Уг зарчим нь “Ял нь

¹ Бадам.Д, Насанд хүрээгүй хүнд оногдуулах хорих ялын эрх зүйн зохицуулалт, 6 дахь тал, Уб. 2017

² Баярсайхан.Д, Ромын эрх зүй. Уб 2000

бурхнаас үзүүлж буй цээрлэл, ял нөхөн төлөх, гэмт хэрэгтнийг хүмүүжүүлэх, айлгах зорилгыг агуулна” хэмээжээ.³

Иймээс хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн эхэн үед ялын гол төрөл нь эрхтэн хагаслах болон цаазаар авах, цусан өшөө авах байдлаар хэрэгждэг байсан бол дундад зууны үед ял нь бага ч болов хууль үйлчилж, төрийн хяналт тавигдах болсноор торгох, эд хөрөнгийг хураах зэрэг ял шийтгэлээр шинэчлэгдэж, цус асгаралтыг багасгахад ихээхэн дөхөм үзүүлсэн⁴ гэж судлаач, эрдэмтэд үзсэн байдаг.

Дундад зууны үед Чингис хааны Их засах хуульд нийт 51 гэмт хэргийн 41-д цаазаар авах ял, XV-XVIII зуунд Германд 44 гэмт хэрэгт, Францад 115 гэмт хэрэгт, Испанид 81 гэмт хэрэгт, Англид 140 гэмт хэрэгт цаазаар авах хэрэглэж байсан талаар эрдэмтэн, судлаачид бүтээлдээ дурдсан байна.

Үүнээс үзвэл ял, шийтгэл нь төр бий болсон цагаас үүсэн хөгжиж түүний хэлбэр, үндсэн ял нь цаазаар авах ял байсан гэдэгт эрдэмтэд санал нэгдсэн байна.

Харин Эртний болон дундад зууны үед хорих ялын тухайд төдийлөн ялын нэг төрөлд авч үзээгүй, энэ талаарх түүхэн эх сурвалжуудад тэмдэглэгдэн үлдээгүй, хэргийг шалгаж тогтоох, ялыг хэрэгжүүлэх хүртэл хугацаанд хорьж таслан сэргийлэх арга хэмжээ хэлбэрээр хэрэглэж байжээ.

XVIII зуунаас эхлэн хүний эрхийг хүндэтгэх, шударга ёсны энэрэнгүй зарчимд тулгуурласан ялын зарчмууд үйлчилж, өмнөх зууны ял шийтгэлийн тулгуур ойлголтууд хуучирч улс орон бүрд ялын зорилгыг илүү энэрэнгүй зарчмын хүрээнд шинээр авч үзсэн үзэл, сургаалууд дэлгэрч, ялын цоо шинэ төрлүүдийг хэрэглэх болсон. Энэхүү үзэл, сургаалыг дэмжигчид ялтныг нийгэмшүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэхэд “Шорон” үр ашигтай хэрэгсэл болно гэж үзэж байжээ.

Тэгвэл **хорих ялыг** судлаач, эрдэмтийн судалж тогтоосноор

1-рт: “Хэрэг зөрчилд буруутгагдан сэжиглэгдэж байгаа этгээдийг өндөр цайз, цамхгийн доод хэсэгт эсхүл ухсан нүхэнд хорьж гэм бурууг нь хүлээлгэж байсан хэрэг хянан шийдвэрлэх аргаас гэм буруутай этгээдийг тодорхой хугацаанд нийтээс тусгаарлан тусгай байгууллагын хяналт дор эрх чөлөөг нь хасаж, хязгаарласан ялын бие даасан төрөл болж өөрчлөгдсөн явцын үр дүн” гэж;

2-рт: “Цаазын ялыг хязгаарлах, халсан явдал зарим орны хувьд ялын төрөл болох хорих ялыг шинээр бий болгосон, эсхүл өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна” гэсэн хоёр замаар дэлхий дахинаа үүсэн хөгжсөн гэж үздэг⁵.

Монгол Улсын хувьд ял шийтгэл, тэр дундаа хорих ял эдлүүлэх ажиллагаа нь түүхэн хөгжлийнхөө явцад тодорхой үе шатыг дамжин хөгжиж ирсэн байна. Тухайлбал: Хүннү, Их Монгол Улс, Юань гүрний үеийн хорих ял, Дөчин, дөрвөн хоёрын Монголын Улсын үеийн хорих ял, Манжийн ноёрхлын үеийн хорих ял, Олноо өргөгдсөн Монгол Улсын үеийн хорих ял, Хэмжээт эрхт Хаант Монгол Улсын үеийн буюу Ардын

³ Оюунбадам.Д., Бадам.Д., Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалт. 5 дахь тал. УБ, 2005

⁴ Б.Амарбаясгалан. Цаазаар авах ял: Эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал. 10 дахь тал. УБ. 2015, Оюунбадам.Д., Бадам.Д., Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалт. 5-6 дахь тал. УБ, 2005

⁵ М.Алтан-Очир. Хорих ял эдлүүлэх дэглэм. 18 дахь тал, УБ, 2020

хувьсгалын дараах үеийн хорих ял, Ардчилсан хувьсгалын дараах үеийн хорих ял⁶ гэсэн хөгжлийн үе шатуудад ангилан авч үзсэн байдаг.

Энэ талаар товч авч үзье.

-Хүннү улсын үед цаазаар авах, хорих, бэрээдэх, хөрөнгө хураах, хүнд ажилд зүтгүүлэх зэрэг ялын төрлүүд байсан бол Их Монгол Улсын үед Их засаг хуульд цаазаар авах ялыг түлхүү хэрэглэж байсан ба ташуураар занчих, цөлөх, гянданд хорих онцгой ял, торгох ялуудыг тогтоож мөрдүүлдэг байсан байна.

-Юань гүрний үед /Их Юань Улсын цаазын бичиг/ гэмт хэргийг “Их муу” хэмээн томёолж нийт 14 төрлийн гэмт хэргийг их мууд хамааруулж тувандах /*богино банзаар 57 удаа хүртэл банздах*/, чавчиргадах /*урт банзаар 67-107 удаа суналзуулан банздах*/, дөнгөлөх, үйлтгүүлэх, торгох, зэрэг, цол, тушаал буруулах, хураах, пүнлүү хасах, газар, эд хөрөнгийг хураах, нугалж төлүүлэх, хорих, биед үсэг, тэмдэг шивэх, эрхтэн хагаслах, цаазаар авах ялыг хэрэглэж байсан.⁷ Эдгээр ялын төрлүүдээс хамгийн хүнд нь хорих, цөлөх, цаазаар авах ял үйлчилж байжээ.

Хорих ялын хугацаа нь 1-3 жил байсан бөгөөд улсаас байгуулсан гяндан /шорон/-д хорих ялыг эдлүүлж байсан байна. Мөн “Их Юань Улсын цаазын бичиг”-т хүний амийг бусниулсан амин хэргээс бусад ял халдсан жинхэнэ Монгол хүнийг барьж гянданд хоривоос сайнаар хамгаалж явах хэрэгтэй гэж зааж байжээ.

-Дөчин, Дөрвөн хоёрын Монголын Улсын үед /XIV-XVII зуун/ Монгол-Ойрадын цаазын бичиг, “Халх журам” зэрэг хууль үйлчилж байсан болох нь түүхэн эх сурвалжид үлдсэн байдаг.

Монгол-Ойрадын цаазын бичигт эхнэр хүүхдийг нь хоосруулан хөөж, цаазаар авах ял, гар хуруу, чих мэтийн зарим эрхтнийг огтлох, ташуур занчих, газар нүхэнд хорих, хэрэгтнийг хоосруулах /хэрэг үйлдсэн этгээдийн бүх эд хөрөнгийг хураах, мал, үнэт зүйлээр торгох, албан тушаалаас огцруулах,

Халх журам хуульд цаазаар авах, цөлөх, жанчих, хөрөнгө хураах, боол болгох, албан тушаалаас огцруулах, гянданд хорих, дөнгөлөх, торгох ялыг тус тус тогтоосноос ялын ихэнх нь малаар тооцоолон гаргадаг торгууль байсан. Мөн уг хуульд хулгайлах, нэн ялангуяа мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялыг тодорхой болгож нийтэд жигшүүлэх шинжтэй ял оноохоос гадна ямар ч тохиолдолд хүндрүүлэн үзэж байхаар заажээ. Жишээ нь: Саалийн үнээ, унааны морь, тэмээ зэрэг ядуу хүний амьжиргааны үндэс болсон цөөн малаас хулгайлсныг гэгээний сан, цагаан сүргээс хулгай хийсэнтэй адил үзэж бүх хөрөнгийг нь хураан, 80 ташуурдаад, 3000 мөргүүлж, 300 эргүүлэн шийтгэхээр заасан байна.

-Манжийн ноёрхлын үед буюу XVII зууны сүүлчээр үйлчилж байсан “Гадаад Монголын цаазын бичиг” /1815 он/ цаазаар авах /*огтчиж алах, цавчин алах, хөвчдөн алах*/, цөлөх, эд хөрөнгийг хураах, 3 сар хүртэл хугацаагаар дөнгөлөх, жанчих, гянданд хорих, торгох, боол болгох, пүнлүү хасах, хэргэм зэрэг буулгах, албан тушаалаас

⁶ Б.Алтангэрэл, Хорих ял эдлүүлэх ажиллагаа, УБ, 2018, М.Алтан-Очир. Хорих ял эдлүүлэх дэглэм. УБ 2020, А.Лхагва, Гяндан салаанаас Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болж өргөжсөн түүхэн замнал, УБ. 2001

⁷ Дашням.И, Монголын юань гүрний төр, эрх зүйн түүх. 124-125 дахь тал. УБ.2016

огцруулах, албад нарыг хурааж бусдад өгөх, бичиг шивэх зэрэг ялыг хэрэглэдэг байжээ.

Түүнчлэн Манж улс нь Монголд урьд ер байгаагүй хүний сүр, сүлд, хийморь, бие бялдарт асар хортой харгис эрүү шүүлт буюу есөн эрүү, дур зоргын эрүү гэх шүүлтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж байсан.⁸ Тухайлбал: төөнүүр эрүү, хавчуур буюу савслага эрүү, туйван, шаахай эрүү, хүлэх эрүү, сараалж эрүү, дүүжин эрүү, чавчирга эрүү, хөшүүрэг зэрэг 9 эрүү үүнээс гадна “Дур зоргын эрүү шүүлт” гэж байсан ба үүнд, хулсан хадаас, элэг наах, ширлэх, мүглэн, ташуур, шахаа зэрэг 6 төрлийн эрүү хэрэглэж байжээ.

Мөн хэрэгт холбогдсон этгээдийг хорьж цагдаж байх зорилгоор цагдах газрыг байгуулж байсны зэрэгцээ ихэвчлэн “Хар гэр”-т хорьж байсан ба шоронгийн анхны хэлбэр нь эсгий гэр, хар гэр, /хойд захын хар овоохой/ майхан, газар нүхэн зоорь, өндөр хашаа бүхий хэлбэр, зохион байгуулалттай байсан бөгөөд түүхийн цаг хугацааны уртад өөрчлөгдөн, хөгжсөөр ирсэн байна. Зарим судлаачдын үздэгээр Монгол оронд Манжийн ноёрхол үүссэн цагаас тухайлбал, 1723 онд Шанздубадмын яам байгуулагдсанаар шорон жинхэнэ утгаараа үүссэн гэж үздэг.⁹

Ардын хувьсгалын дараах үеэс хорих ялыг Зөвлөлт Орос Улсын хууль тогтоомжийн жишгээр “Түр хорих байшин”, “Засан сайжруулах газар”, “Хөдөөний аж үйлдвэрийн колони”-д эдлүүлж байсан ба БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1966 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар зарлигаар “Засан хүмүүжүүлэх хууль” батлагдан уг хуульд ЗХУ-ын жишгээр “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн жирийн, чанга, онцгой дэглэм бүхий колони”, “Жирийн, чанга дэглэмтэй гяндан”, “Хүмүүжил-хөдөлмөрийн жирийн, чанга, дэглэмтэй колони”, 1993 оноос “Жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих байгууллага”, “Гянданд”-д тус тус эдлүүлж ирсэн байна.

Ийнхүү Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа нь түүхэн хөгжлийнхөө явцад тодорхой үе шатуудыг дамжин хөгжиж ирсэн бөгөөд 1990 онд ардчилсан өөрчлөлт, шинэчлэлт гарч улмаар ардчилал, хүний эрхийн дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг тусгасан 1992 оны Үндсэн хууль, нийгмийн шинэтгэлийн хүрээнд хорих ял эдлэгсдийн эрхийг дээдлэх, нөхцөл, журмыг сайжруулах чиглэлээр эрх зүйн болон аж ахуйн олон үйл ажиллагааг авч хэрэгжүүлж ирсэн ба 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “нээлттэй, хаалттай дэглэм бүхий хорих байгууллагад” тус тус эдлүүлэх болсон.

Хорих ялын нээлттэй болон хаалттай дэглэмийн талаар:

Хорих ял эдлүүлэх дэглэмийн талаар манай орны эрдэмтэн, судлаачид болон дэлхийн улс орнуудын эрдэмтэд цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн тогтолцоо, хүний эрх, эрх чөлөө, эрх зүйн зохицуулалт, шинэчлэл зэргийг хамруулан, өөр өөрийн өнцгөөс тодорхойлж, томъёолсоор ирсэн байна.

Хорих ял эдлүүлэх дэглэм гэдгийг нийтлэг агуулгаар нь хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үүсэж бий болсон эрхийн хязгаарлалт, ял эдлүүлэх нөхцөл, журам,

⁸ Болдбаатар.Ж, Лүндээжанцан.Д, Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. 154-156 дахь тал. УБ 1997

⁹ Сүлд инфо сэтгүүл. 3-4 дэх тал, УБ 2014

хоригдлыг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон өөр хоорондоо ялгаа, өвөрмөц байдал бүхий үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээний нийлбэр юм гэсэн томъёоллыг доктор, профессор Б.Алтангэрэл “Хорих ял эдлүүлэх ажиллагаа” гэсэн бүтээлдээ дурджээ.¹⁰

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалд нээлттэй болон хаалттай дэглэм, хорих байгууллагын агуулга, онцлогийн талаар дараах байдлаар туссан байна. Үүнд:

Хорих ангийн нээлттэй болон хаалттай дэглэмийн гол агуулга нь ялтныг сургах, байнгын тасралтгүй ажлын байраар хангах, ял эдлүүлэх орчин нөхцөлийг хүний эрхийг хангасан стандартын дагуу бүрдүүлэх, хоригдлыг ангилан ялгамжтай байдлаар ялыг тусад нь эдлүүлэх зэрэг асуудлыг цогц хэлбэрээр шийдвэрлэж, хорих ял эдэлж байгаа хүмүүсийг нийгэмшүүлэхэд чиглэгддэг.

Нээлттэй дэглэмийн онцлог нь хоригдлын хувийн зан төлөв, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюул, шинж чанар, хувь хүний нөөц боломжийг харгалзан нийгмээс бүрэн тусгаарлалгүйгээр, тухайн хүнийг гэр бүл, хамт олон зэрэг эерэг орчны нөлөөлөл дор, хяналт, хязгаарлалт багатай орчинд хөдөлмөрлүүлэх, ял эдлүүлэх явдал юм.

Хаалттай дэглэмийн онцлог нь хорих ангийн хамгаалалтын бүсэд хатуу хяналт дор ялтныг хөдөлмөрлүүлэх, ял эдлүүлэхийн зэрэгцээ амьдрах байр нь ялтны зорчих хөдөлгөөнийг хязгаарласан байдлаар зохион байгуулагдсан байдаг.

Түүнчлэн хоригдол зөвхөн хорих ангийн үйлдвэрлэлийн бүсэд ажиллах, бусадтай харилцах боломж нь хязгаарлагдмал, өндөр ачаалал бүхий нийгэм, сэтгэл зүйн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагддаг зэрэг онцлогтой байдаг гэжээ.

Тэгвэл гадаадын зарим орны хорих ял эдлэх дэглэм, хорих байгууллагын онцлогийн талаар¹¹ товч дурдвал

-Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын хувьд ял длүүлэх байгууллага нь төвийн ба орон нутгийн шоронгийн байгууллагаас бүрдэх бөгөөд 1969 оноос эхлэн хорих ял эдлүүлэх төвлөрсөн байгууллагад хорих ялын хугацаа, гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан ялгавартай ялыг эдлүүлдэг байна. Төвлөрсөн хорих байгууллага нь нээлттэй болон хаалттай хорих байгууллага бүтэц, зохион байгуулалттай. Нээлттэй байгууллагад зэвсэглэсэн хамгаалалт байхгүй, цонх нь төмөр торгүй бөгөөд нээлттэй дэглэм бүхий хоригдол нь өөр байгууллагад очиж хөдөлмөрлөж болдог бол хаалттай шорон нь зэвсэглэсэн харуул, өндөр, бөх бат хана, хэрэм зэргээр нийгмээс хатуу тусгаарлагдсан байдаг онцлогтой.

-Холбооны Бүгд найрамдах Герман улсын хувьд хорих ялын дэглэмийн хувьд нээлттэй ба хаалттай гэсэн төрөлтэй, дэглэмүүд нь дотроо хэд хэдэн зэрэглэлд хуваагдах ба хаалттай хорих ангиуд нь харуул хамгаалалт, хяналтын төхөөрөмжөөр маш сайн тоноглогдсон барилга, байгууламж, төрөл бүрийн зэвсэг хэрэгслээр хангагдсан алба хаагчид үүрэг гүйцэтгэдэг, 2 хоригдолд 1 алба хаагч байхаар тооцсон байдаг байна. Хаалттай дэглэм нь дотроо дээд, дунд, доод гэсэн 3 зэрэглэлтэй байх

¹⁰ Алтангэрэл.Б, Хорих ял эдлүүлэх ажиллагаа. 62 дахь тал, УБ 2018

¹¹ М.Алтан-Очир. Хорих ял эдлүүлэх дэглэм. 76-93 дахь тал, УБ, 2020

бөгөөд нөхцөлөөсөө хамаараад хоригдлын эрх, ахуй хангалт, дэглэм нь тодорхойлогддог байна. Нээлттэй хорих байгууллагад 6 хүртэл сарын богино хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн этгээдүүд, эсхүл үйлдсэн гэмт хэргийн хор аюул нь бага хоригдлын ялыг эдлүүлдэг.

-Бүгд найрамдах Франц улсын хувьд ял эдлүүлэх байгууллага нь мөрдөн тусгаарлах газар, ял эдлүүлэх байгууллага гэсэн 2 төрөлд хуваагдах ба ял эдлүүлэх байгууллага нь насанд хүрэгчдийн төвлөрсөн болон орон нутгийн хорих байгууллага, насанд хүрээгүйчүүдийн тусгайлсан сургалт, хүмүүжлийн байгууллагаас бүрддэг байна.

-Польш улсын тухайд хорих байгууллагууд нь хаалттай, хагас хаалттай, нээлттэй гэсэн 3 дэглэмтэй байх ба үйлдсэн гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан ялгамжтай байдлаар дэглэмд хуваарилдаг байна. Нээлттэй дэглэмийн хоригдлууд нь тусгай хамгаалалттайгаар тухайн шоронгийнхоо аж ахуйн үйлчилгээний болон гадуур аж ахуйн нэгжид гэрээгээр ажилладаг бол хагас хаалттай дэглэмийн хоригдлууд нь тухайн хорих ангийнхаа үйлдвэрүүдэд ажилладаг. Хаалттай дэглэмийн хорих ангид ихэвчлэн онц аюултай гэмт хэрэгтэн ял эдэлдэг ба тэдгээр хоригдлууд нь ажил хийдэггүй байна.

Европын Холбооны Улсууд дахь хорих ял эдлүүлэх дэглэмийн онцлог нь хорих ял шийтгүүлсэн этгээдийг ихэвчлэн нээлттэй болон хаалттай дэглэмд эдлүүлэх ба зарим улсад хагас хаалттай, завсрын, дунд шатны гэх мэтээр нэрлэгдсэн нээлттэйгээс хаалттай руу, хаалттайгаас нээлттэй рүү шилжүүлэхэд ашигладаг дундын дэглэм бүхий хорих анги, байгууллага ажилладаг байна.

Америкийн нэгдсэн улсын тухайд Холбооны болон Мужийн хорих ял эдлүүлэх байгууллагын бүтэц нь нээлттэй, хаалттай гэсэн үндсэн хоёр төрөлтэй, тэдгээрийн дунд завсрын /medium security/, мөн онц аюултай гэмт хэрэгтнийг хорьж ялыг нь эдлүүлэх онцгой /хаалтай, maximum security/ шоронгоос тус тус бүрдэнэ. Хаалттай хорих ангийн хоригдол өдрийн ихэнх цагийг хатуу хяналтад өнгөрөөдөг бол нээлттэй хорихын хоригдлууд өдрийн турш гадуур ажиллаж, ямар нэг хяналт хязгаарлалтыг мэдэрдэггүй байна. Нээлттэй хорих анги нь зэвсэглэсэн хамгаалалтгүй, хөнгөн дэглэмтэй, гадна байгууллагад хөдөлмөр эрхлэх боломжтой байдаг байна. Хаалттай шоронгууд нь зэвсэглэсэн хамгаалалттай, дээгүүрээ өргөст торон хамгаалалт бүхий хоёр давхар хашаагаар хүрээлэгдсэн байдаг байна.

Нэгтгэн харвал дэлхийн ихэнх хөгжингүй орнуудын ял эдлүүлэх нөхцөл нь нээлттэй болон хаалттай дэглэм бүхий 2-оос 3 төрөлтэй, дэглэмүүд нь ял эдлүүлэх нөхцөл, журам, хоригдлыг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон өөр хоорондоо ялгаатай, өвөрмөц байдал бүхий үйл ажиллагаа, харуул хамгаалалтын хувьд харилцан адилгүй байхаар зохион байгуулагдсан байдаг байна.

Монгол Улсын эрүүгийн бодлого, ялын төрөл, ял эдлүүлэх ажиллагааны түүхэн хөгжил, үе шат, өнөөгийн байдал, дэлхий нийтийн чиг хандлага, жишиг ямар байгааг судалж үзсэний эцэст хорих ял эдлүүлэх тогтолцоо бүрэн шинэчлэгдэж чадсан уу аль эсхүл өмнөх үеийн уламжлал, хэв маяг хадгалагдсаар байгаа юу, шинэчлэл нэг мөр хэрэгжиж байгаа эсэх, хорих ял эдлүүлэх ажиллагаа дахь хүний эрхийн байдал Олон Улсын жишигт хүрч чадсан уу? шинэчилсэн хуулийн хүрээнд хүний эрхийн зөрчилтэй

зүйл заалтууд байсаар байна уу? гэдэг талаар одоо хэрэгжиж байгаа хууль болон практикт тулгуурлан товч авч үзэе.

1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 204 дугаартай “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолоор “Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэм”-ийг шинэчлэн баталж, хорих байгууллагын тогтолцоог нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлсэн.

Уг тогтоолоор 407, 413, 423, 457 дугаар хорих ангиудын дэглэмийг “нээлттэй, хаалттай” байхаар тогтоосон. Мөн Монгол Улсыг Засгийн газрын 2020 оны 82 дугаартай тогтоолоор 415 болон 427 дугаар хаалттай хорих ангиудыг нээлттэй-хаалттай хорих анги болгон нэгтгэж, өөрчлөн зохион байгуулсан. Энэ үйл явц цаашид ч үргэлжлэх хандлагатай байна.

Энэ нь 2017 онд шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан нээлттэй болон хаалттай хорих ангийг “нээлттэй-хаалттай” хорих анги болгон нэгтгэж бүтэц, зохион байгуулалтын хувьд нэг хорих байгууллага байхаар өөрчлөн зохион байгуулсан явдал нь мөн хуулийн 195 дугаар зүйлийн 195.1 “Хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг /цаашид “хорих анги” гэх/, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ.”, 198 дугаар зүйл “Нээлттэй хорих анги”, 199 дүгээр зүйл “Хаалттай хорих анги” гэж заасныг тус тус ноцтой зөрчсөн гэж үзэхээр байна.

Түүнчлэн нээлттэй болон хаалттай дэглэм бүхий хоригдлыг нэг дор ял эдлүүлж байгаа нь нээлттэй болон хаалттай хорих ангид хорих ял эдлүүлэх нөхцөл, журам, хорих ялын дэглэм, зэрэглэлийн онцлог, нээлттэй болон хаалттай тогтолцооны агуулга, зарчмыг алдагдуулсан, шинэ тогтолцоонд шилжих үйл явцаас ухарсан, өмнөх ял эдлүүлэх тогтолцооноос бүрэн салаагүй, холилдсон байдалтай хэрэгжих нөхцөлийг бүрдүүлсэн шийдвэр болсон гэж үзэж болохоор байна.

Мөн зарим хорих ангийн барилга, байгууламжийн ашиглалт, бүтэц, зохион байгуулалт зэрэг нөхцөл байдлаас хамаарч өөр өөр зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол бие биетэйгээ харилцах боломжгүй байдлаар хорих ангийн үйл ажиллагааг зохион байгуулах боломжгүй байгааг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал: 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын барилга, байгууламжийн зохион байгуулалт, ашиглалтын үйл ажиллагаа алдагдаж, үйл ажиллагаа явуулах боломжгүй тухай мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт гараад цөөнгүй хугацаа өнгөрч байгаа боловч уг байрандаа одоог хүртэл ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулж байна. Орон нутагт ч үүнтэй ижил нөхцөлд хорих ял эдлүүлж байгаа хорих байгууллагууд ч цөөнгүй байгаа билээ.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2023 оны жилийн эцсийн мэдээ, тайланд дурдсанаар улсын хэмжээнд нээлттэй дэглэм бүхий 7, хаалттай дэглэм бүхий 7, нээлттэй-хаалттай дэглэм бүхий /нэгтгэсэн/ 6 хорих анги болон Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага зэрэг нийт 21 хорих байгууллагад 2023 оны байдлаар 6942 хоригдол ял эдэлснээс 5520 буюу 80 хувь нь нээлттэй дэглэмд, 1300 буюу 19 хувь нь хаалттай дэглэмд ял эдэлсэн бол тусгай нэгжид 43 хоригдол, Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад өсвөр насны 79 хоригдол тус тус хорих ял эдэлсэн байна.

Тэгвэл ямар хоригдлыг нээлттэй дэглэмд ял эдлүүлэх, ямар хоригдлыг хаалттай дэглэмд ял эдлүүлэх талаар хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан байгааг судлахад.

Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хугацаатай хорих ялыг нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр тогтооно.” гэж заасан бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198 дугаар зүйл /Нээлттэй хорих анги/-ийн 198.2 дахь хэсэгт “Нээлттэй хорих ангийн...тусгай зэрэглэлд 2 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн ...хоригдлыг ял эдлүүлнэ” гэж, 199 дүгээр зүйл /Хаалттай хорих анги/-ийн 199.2 дахь хэсэг “Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд санаатай гэмт хэрэг анх удаа үйлдэж 4-6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, ...тусгай зэрэглэлд 6 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн... хоригдлыг ял эдлүүлнэ” гэж хуульчилсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн заалтаас харахад хүнд гэмт хэрэг үйлдэж, 6 жил түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг мөн хуулийн 198.2-т зааснаар “...2 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн” заалтад хамааруулан авч үзэж тухайн хоригдлын ял эдлэх дэглэмийг нээлттэй дэглэмд эдлүүлэхээр тогтоох боломжтой байна.

Тодруулбал, хоригдлын үйлдсэн гэмт хэргийн шинж, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, учруулсан хохирол, хор уршиг, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээ, үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөн байдал, оногдуулсан ялын хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал зэргийг харгалзан нээлттэй болон хаалттай дэглэмд ял эдлүүлэх талаар хуульд нарийвчлан заагаагүйгээс шалтгаалж анх удаа хүнд гэмт хэрэг үйлдэж 6 жил түүнээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн бүх л хүнд шүүхээс нээлттэй дэглэмд хорих ялыг эдлүүлэхээр тогтоох боломжтой байна.

Практикт удаа дараа ял шийтгүүлсэн, хүнийг алах, залилах гэх мэт хүнд гэмт хэрэгт 6, түүнээс дээш жилийн хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн, хаалттай дэглэмд ял эдэлбэл зохих хоригдлын хорих ял эдлэх дэглэмийг нээлттэй дэглэмд эдлүүлэхээр шүүхээс шийдвэрлэсэн тохиолдол цөөнгүй гарч байгааг зарим хорих ангийн хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, оногдуулсан ял шийтгэлийн хэмжээнээс харж болохоор байна. Жишээ нь:

407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид нийт нээлттэй дэглэмд 267 хоригдол ял эдэлж байгаагаас 6 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн 113 хоригдол, урьд ял шийтгүүлсэн 111 хоригдол байна. Урьд ял шийтгүүлсэн 111 хоригдлоос 6 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн 40 хоригдол байна. Мөн үйлдсэн гэмт хэргийн байдлаар авч үзвэл нийт нээлттэй дэглэмд ял эдэлж байгаа хоригдлын 24 хувь нь буюу 65 хоригдол хүнийг алах гэмт хэрэгт, 37 хувь буюу 98 хоригдол залилах гэмт хэрэгт тус тус ял шийтгүүлж, хорих ял эдэлж байна.

Мөн 421 дүгээр нээлттэй хорих ангид нийт 218 хоригдол ял эдэлж байгаагаас хүнийг алах гэмт хэрэгт 6 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн 62 буюу 28.4 хувь, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт 6 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн 17 хоригдол буюу 8 хувь нь тус тус нээлттэй дэглэмд ял эдлүүлэхээр шүүх шийдвэрлэсэн байна.

Судалгаанд авагдсан дээрх хоригдлуудын ял эдлэх дэглэмийг хаалттай дэглэмд бус нээлттэй дэглэмд ялыг эдлүүлэхээр шүүхээс тогтоож байгаа нь шударга ёсны зарчимд нийцээгүй, Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлд заасныг харгалзан үзсэн гэхэд эргэлзээ төрүүлэхээр байна гэж үзэхээр байна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ял шийтгүүлсэн арван найман насанд хүрсэн эмэгтэй хоригдлын ялыг эмэгтэйчүүдийн нээлттэй, хаалттай хорих ангид эдлүүлнэ. Эмэгтэйчүүдийн хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна.

Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа эмэгтэй хоригдол 7 хоногт нэг удаа түр, 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 7 хоногт нэг удаа илгээмж явуулж, утсаар ярьж болно гэж заасан бол нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа эрэгтэй хоригдол 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болох бөгөөд түр хугацааны уулзалт хийх, захидал илгээх, илгээмж авах, утсаар ярих тоог хязгаарлахгүй гэж;

Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа эмэгтэй хоригдол 30 хоногт нэг удаа түр, 60 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа утсаар ярьж, 15 хоногт нэг удаа илгээмж авахаар заасан бол мөн зэрэглэлд ял эдэлж байгаа эрэгтэй хоригдол 60 хоногт нэг удаа түр, 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно гэж;

Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа эмэгтэй хоригдол 45 хоногт нэг удаа түр, 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа илгээмж авч, 60 хоногт нэг удаа утсаар ярьж болно гэж заасан бол мөн зэрэглэлд ял эдэлж байгаа эрэгтэй хоригдол 90 хоногт нэг удаа түр, 120 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 60 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно гэж тус тус заасан.

Дээрх заалтууд нь эрэгтэй, эмэгтэй хоригдлын хүйсийн байдлаар нь ялгаварлан төрөл, садан, үр, хүүхэдтэйгээ уулзах хүний заяагдмал эрхээ эдлэх боломжийг ялгамжтай байдлаар томъёолсон байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хүнийг хүйсийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглосон хэм хэмжээг зөрчсөн хүний эрхийн ноцтой зөрчилд хамаарах боломжтой гэж судлаачийн зүгээс үзэж байна.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, /цаашид "хорих анги" гэх/-аас бүрдэнэ гээд хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ гэж заасан. Мөн хуульд "Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдолд хуульд заасан үндэслэлээр хорих ангийн дарга зам хоногийг оролцуулан 7 хүртэл хоногийн чөлөө олгохоор зохицуулсан ба Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хоригдолд мөн хуульд заасан үндэслэлээр чөлөө авах зайлшгүй шаардлага үүссэн тохиолдолд чөлөөг олгох эсэх асуудлыг зохицуулалгүй орхигдуулсан.

Энэ нь өсвөр насны хоригдлын хуулиар олгогдсон эрхийг хангах боломжгүй болгож байгаа төдийгүй эрх зүйн зохицуулалтын хувьд хүний эрхийн ноцтой зөрчилд хамаарахаар байна гэж судлаачийн зүгээс тус тус үзэж байна.

Дүгнэлт

Нээлттэй болон хаалттай дэглэмийн хорих ял эдлүүлэх нөхцөл, журам, хорих байгууллагын бүтэц, зохион байгуулалт, барилга, байгууламж, харуул хамгаалалт, хүний нөөц, хоригдлын эрхийг хангах үйл ажиллагаа, нийгэмшүүлэх ажил, хөдөлмөрт хамруулах зэрэг хорих ангийн бүхий л үйл ажиллагаа нь хорих ангийн дэглэмээс хамаарч өөр өөр, тусдаа бие даасан байдлаар зохион байгуулагдахаар эрх зүйн орчинд тусгагдсан байгаа нь олон улсын жишигт хүрэхүйц зохицуулалт болсон гэж үзэж болохоор байна.

Гэвч хуулийг хэрэгжүүлэх шатанд нээлттэй болон хаалттай хорих ангийг “нээлттэй-хаалттай” хорих анги болгон нэгтгэж бүтэц, зохион байгуулалт, харуул хамгаалалт, дэглэмийн хувьд нэг хорих байгууллага мэт байхаар зохион байгуулж, нээлттэй болон хаалттай дэглэмийн хоригдлын ялыг нэг дор эдлүүлэх, холилдох нөхцөлийг бүрдүүлж байгаа нь хорих ялын үндсэн зорилго хангагдаж байгаа юу гэдэгт эргэлзээ төрөхөд хүргэж байна гэж үзэхээр байна.

Түүнчлэн хорих ял эдлүүлэх ажиллагааг Олон Улсын жишигт хүргэх энэхүү шинэчлэлийн хүрээнд хууль, эрх зүйн орчныг боловсруулж батлахдаа хүний эрхийн зөрчилд тооцогдох хэд хэдэн ноцтой алдааг хуульд тусгаж, практикт бий болгосон байна. Үүнд:

-Хоригдлын үйлдсэн гэмт хэргийн шинж, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, учруулсан хохирол, хор уршиг, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээ, үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөн байдал, оногдуулсан ялын хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал зэргийг харгалзан нээлттэй болон хаалттай дэглэмд ял эдлүүлэх талаар хуульд нарийвчлан заагаагүй, зөвхөн хорих ялын хэмжээгээр ял эдлүүлэхээр заасан нь давхацсан шинжтэй болсон.

Үүнээс шалтгаалж гэмт хэрэг үйлдсэн хүний ял эдлэх дэглэмийг шүүх бодитоор тогтоох боломжгүй, үзэмжээр тогтоох байдал түгээмэл байгаагаас нээлттэй дэглэмд ял эдлэх хоригдлын тоо эрс ихэссэн, шударга ёсны зарчмыг алдагдуулсан үр дагаврыг бий болгосон.

-Хоригдлын чөлөө авах, эргэлт, уулзалт авах, захидал, илгээмж авах, утсаар ярих эрхийг хоригдлын нас, хүйсийн байдлаар ялгамжтай эдлүүлэхээр хуульчлан зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хууль болон Олон Улсын гэрээ, конвенцэд заасан хүний салшгүй, заяагдмал эрхийг хязгаарласан гэж болохоор байна.

Дээрх байдлаас дүгнэж үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь түүхэн хөгжлийнхөө явцад тодорхой үе шатыг дамжин хөгжиж байгаа боловч хорих байгууллагын орчин нөхцөл, дэглэм, журам өмнөх үеийн уламжлал, хэв шинжээ хадгалсан хэвээрээ, хууль эрх зүйн зохицуулалт, нийгэм, эдийн засгийн хүрээнд дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, жишигт хараахан хүрээгүй, хууль тогтоомжийн хүрээнд хүний эрхийн зөрчилтэй зүйл, заалтууд үйлчилсэн хэвээрээ байсаар байна гэж судлаачийн зүгээс дүгнэж дараах **САНАЛЫГ** дэвшүүлж байна.

1. Хорих ангийг “Нээлттэй-хаалттай” хэлбэрээр нэгтгэн байгуулах бус зөвхөн “нээлттэй хорих анги” болон “хаалттай хорих анги”-ийн бүтэц, зохион байгуулалтад шилжүүлэх.

Энэ хүрээнд хаалттай хорих анги болон нээлттэй хорих ангийг улсын хэмжээнд төвлөрсөн хорих ангийн бүтэц, зохион байгуулалтаар тус тусад нь шинээр байгуулах, ялангуяа өсвөр насны болон эмэгтэй хоригдлыг ял эдлүүлэх хорих ангийн барилга, байгууламжийг шинэчлэх асуудлыг нэн яаралтай шийдвэрлэх асуудлыг эрх бүхий байгууллагад уламжилж, шийдвэрлүүлэх.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198 дугаар зүйлийн 198.2, 199.2, 202.3, 202.4 дэх хэсэгт заасан хоригдлын хорих ял эдлэх дэглэмийг тогтоосон зохицуулалтыг Эрүүгийн хуульд нарийвчлан зааж оруулах.

Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт өөрчлөлт оруулах замаар хоригдлын үйлдсэн гэмт хэргийн шинж, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн нийгмийн аюулын хир хэмжээ, учруулсан хохирол, хор уршиг, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээ, үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөн байдал, оногдуулсан ялын хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал зэргийг харгалзан нээлттэй болон хаалттай дэглэмд ял эдлүүлэх асуудлыг ялгамжтай байдлаар тогтоох эрх зүйн үндэслэлийг хуульд нарийвчлан тусгах.

Энэ хүрээнд шүүхээс хоригдлын ял эдлэх дэглэмийг тогтоосон байдлыг үйлдсэн гэмт хэргийн шинж, хоригдлын хувийн байдал зэрэг дээрх агуулгаар улсын хэмжээнд нарийвчилсан нэгдсэн судалгаа явуулж холбогдох санал, зөвлөмжийг эрх бүхий байгууллагад уламжлуулах.

Мөн удаа дараа ял шийтгүүлсэн болон хүнийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх, залилах зэрэг хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн хүний хорих ял эдлэх дэглэмийг илтэд үндэслэлгүйгээр нээлттэй дэглэмд ял эдлүүлэхээр тогтоосон шүүхийн шийдвэрт улсын яллагчийн зүгээс онцгойлон анхаарал хандуулж тухай бүр прокурорын эсэргүүцэл бичиж, зөвтгүүлэх. Энэ талаар нийт прокуроруудад сургалт, мэдээлэл өгөх арга замаар дадлагажуулж, хэвшүүлэх.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан өсвөр насны хоригдлын чөлөө авах, эрэгтэй, эмэгтэй хоригдлын эргэлт, уулзалт авах, захидал, илгээмж авах, утсаар ярих эрхийн талаарх зохицуулалтыг эргэн харж, өөрчлөлт оруулах замаар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ, конвенцид заасан хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хүнийг нас, хүйсийн байдлаар ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг эрхийг хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.

Ашигласан эх сурвалж

Нэг. Монгол Улсын хуулиуд

- 1.БНМАУ-ын Эрүүгийн хууль. УБ. 1942, 1961
- 2.БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн тухай хууль. УБ. 1966, 1981
3. Монгол Улсын Үндсэн хууль. ТМ. №1. УБ1992
- 4.Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль. ТМ. №01. УБ. 1994
- 5.Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль. ТМ. №01. УБ, 1997
- 6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. ТМ. №08.УБ. 2002.

- 7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. ТМ. №24. УБ. 2017
8. Эрүүгийн хууль. ТМ. №07. УБ. 2016
- 9.Эрүүгийн хууль. ТМ. №05. УБ 2002

Хоёр. Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ, конвенц

1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон Улсын пакт. 1966
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. Парис. 1948.
3. Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд. Женев. 1955

Гурав. Ном, сурах бичиг

1. М.Алтан-Очир. Хорих ял эдлүүлэх дэглэм, УБ, 2020
2. Б.Алтангэрэл, Хорих ял эдлүүлэх ажиллагаа, УБ, 2018,
3. Б.Амарбаясгалан. Цаазаар авах ял: Эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал. 2015
4. Ж.Болдбаатар. Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ 1997
5. Б.Баярсайхан. Монголын төр эрх зүйн түүх дээж бичиг. V дугаар дэвтэр. УБ 2010
6. И.Дашням. Монгол Улсын төр эрх зүйн түүх. УБ. 2012
- И.Дашням. Монголын юань гүрний төр, эрх зүйн түүх. УБ.2016
7. А.Лхагва, Гяндан салаанаас Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болж өргөжсөн түүхэн замнал, УБ. 2001
8. Д.Оюунбадам. Д.Бадам. Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалт. УБ. 2005
9. О.Энхбат “Хорих ял эдлүүлэх дэглэм, түүнийг хангах хэрэгсэл” УБ., 1989.

Дөрөв. Эрдэм, шинжилгээний өгүүлэл, илтгэл

- 1.Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал. Илтгэл. Сүлд инфо. 2014, 2017
- 2.С.Жанцан. Хорих дэглэм. Эрдэм шинжилгээний өгүүлэл. Сонор сэрэмж сэтгүүл. №4. 1982

Тав. Бусад эх сурвалж.

- 1.<http://www.legalinfo.mn/>- Монгол Улсын Их хурлын 2008 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 35 дугаартай “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоол
2. <http://www.legalinfo.mn/>- Монгол Улсын Их хурлын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоол
3. <http://www.legalinfo.mn/>- Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 193 дугаартай “Хөтөлбөр батлах тухай” тогтоол
4. <http://www.legalinfo.mn/>- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 204 дугаартай “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол
5. cd.gov.mn /ШШГЕГ-ын веб сайт/
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 02/536 дугаартай албан бичгийн хавсралт. /Хоригдлын тоон судалгаа/
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2023 оны жилийн эцсийн мэдээ, тайлан./Хоригдлын хөдөлгөөний мэдээ/
8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 407 дугаар нээлттэй-хаалттай хорих анги, 421 дүгээр нээлттэй хорих ангийн хоригдлын тоо, мэдээ.

ХҮМҮҮЖЛИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ҮЗЭЛ БАРИМТАЛ БА ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ АСУУДАЛ

Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газрын хяналтын прокурор П.Бямбасүрэн

Хураангуй:

Эрүүгийн хуульд зааснаар өсвөр насны хүнд оногдуулах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалтыг тодорхой авч үзэх, эрүүгийн эрх зүйн уламжлал шинэчлэл, нийтлэг жишгийг харьцуулан судлах мөн хууль тогтоомжийн хэрэгжилт, практикт тулгамдаж буй асуудлыг эрх зүйн зохицуулалт болон үйл ажиллагааны хүрээнд тодорхойлж гаргахыг зорилгоо болголоо.

Энэхүү илтгэлийг бичихдээ өсвөр насны хүнд оногдуулах эрүүгийн хариуцлага, уг албадлагын арга хэмжээний хэрэгжилт, тэр дундаа хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх буюу практик, хэрэгжилтийн хувьд учир дутагдалтай, үр дүнгүй, түүнчлэн хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр¹ заасан ч хууль, журам бүрэн хэрэгжихгүй, хэлбэр төдий хэрэгжиж байгаа нь анхаарал татах асуудлын нэг болж байх тул албадлагын арга хэмжээний хяналтын талаар зайлшгүй судлан, дүн шинжилгээ хийх хэрэгцээ шаардлагыг үндэслэн энэхүү сэдвийг сонгон авч эрх зүйн зохицуулалт болон үйл ажиллагааны хүрээнд практикт тулгамдаж буй асуудлын шалтгаан холбоог тодруулах, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилт, хэлбэрийг хөрш улсууд болон Америкийн Нэгдсэн Улс, Холбооны Бүгд Найрамдаг Герман Улс, Англи зэрэг улсуудын эрүүгийн хуулийн зохицуулалттай харьцуулан дүгнэх, албадлагын арга хэмжээ авагдсан тоо мэдээнд дүгнэлт хийх зэрэг арга зүйг сонгов.

Түлхүүр үгс:

Эрүүгийн хариуцлага, ял, албадлагын арга хэмжээ, албадлагын арга хэмжээний зорилго, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, сургалт, хүмүүжил, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, эрх зүй зохицуулалт, судалгаа, хууль тогтоомжийн хэрэгжилт, энэрэнгүй ёс, шударга ёс, нийгэмшүүлэх.

Удиртгал

Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дүгээр хэсэгт “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, мөн зүйлийн 13 дугаар хэсэгт “Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэж НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А тоот тогтоолоор баталж, 1976 оны 03 дугаар 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 10 дугаар зүйл 1 дэх хэсэгт “Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэнэ”, 2 дахь хэсгийн (b) “буруутнаар татагдсан насанд хүрээгүй этгээдийг насанд хүрсэн этгээдээс тусгаарлаж хэргийг нь аль болох богино хугацаанд шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлнэ”, 3 дахь хэсэгт “гэмт хэрэг үйлдсэн насанд

¹ Монгол улсын Эрүүгийн хууль. УБ., 2017 он

хүрээгүйчүүдийг насанд хүрэгсдээс тусгаарлаж, тэдний нас, эрх зүйн байдалд нийцсэн дэглэмд байлгана” гэж гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ажиллагааны олон улсын эрх зүйн зохицуулалт байдаг бол НҮБ-ын 1985 онд баталсан Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрмийн 17.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хорихоос өөр төрлийн ял хэрэглэх боломжийг ямагт харгалзах. Насанд хүрээгүй хүний сайн сайхан байдал, ирээдүйг хангах сонирхол ямагт тодорхойлогч хүчин зүйл, харгалзах баримт болно” гэж заажээ².

Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын эрүүгийн ялын хууль, шүүхийн практик өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хүмүүжлийн шинжтэй, ялын бус аргаар чөлөөлөх, хөнгөрүүлсэн агуулга бүхий тогтолцоог бүрдүүлэх, шүүн таслах ажиллагаа явуулахгүйгээр хууль зөрчсөн хүүхдийн асуудлыг зохицуулах арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх, ял оногдуулж эрхийг нь хязгаарлах арга хэмжээг гагцхүү эцсийн, гарцаагүй байдалд хэрэглэхийг гол үзэл баримтлалаа болгож байна.

Иймд өсвөр насны хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн бол тэдэнд ял оногдуулж, цээрлүүлэх бус нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх, цаашдын чиг хандлагаа өөрчлөхөд нь дэмжлэг үзүүлэх эрүүгийн хариуцлагын оновчтой төрөл, хэлбэрийг сонгон, түүнийгээ үр дүнтэй хэрэгжүүлэх нь нэн чухал юм.

1. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, түүхэн уламжлал, улс орнуудын харьцуулалт.

Нэгдсэн үндэсний байгууллагаас баталсан “Токиогийн дүрэм” зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд гэмт хэрэг үйлдсэн хүнийг учруулсан хохирол, эрх зүйн үр дагаврын байдлыг харгалзан ялыг аль болох хамгийн зохистой нөхцөлөөр зөв ногдуулж хэрэглэх нь эрүүгийн эрх зүйн салшгүй нэг чиг үүрэг болсныг онцлон тэмдэглэсэн бөгөөд цээрлүүлэх буюу зовоох ялыг аль болох хэрэглэхгүй байх, хамгийн үр нөлөөтэй, хорихоос өөр төрлийн ялын төрлийг сонгож, нийгэмд учруулсан хохирлыг нөхөн сэргээх агуулгаар уян хатан, нөхцөл боломжтойгоор хэрэглэх тухай өгүүлсэн байна³.

“Хүмүүжил” гэдэг нь хүнийг төрсөн цагаас эхлэн тасралтгүй явагдаж байдаг нийгмийн шинж, ухамсарт үйлийн илэрхийлэл юм.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ нь хэн нэгний хүсэлтээр бус шүүх өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон хэрэглэдэг учир албадлагын шинж агуулсан өвөрмөц арга хэмжээ юм.

Монгол Улс 1926 оны “Шүүх цаазын бичиг⁴”-ээс өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулиудын эрх зүйн зохицуулалтаас үзэхэд “Монгол улс нь эрт үеэсээ хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг баримт бичиг, хуульдаа тусгаж ирсэн ба хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ нь гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахаас зайлсхийлгэх, тэднийг хамт олон, гэр бүлдээ

² Алтангэрэл, Б, Хүрэлбат. М нар Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. -Уб., 2020. 11 дэх тал

³ Мөнхбат, Ц. Нийтэд тустай ажил хийлгэх ял. -Уб., 2020. 6 дахь тал

⁴ Монгол Улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил I дэвтэр., Эмхэтгэсэн, Адьяабазар, Уб 1998, 78 дахь тал.

хүмүүжих боломжийг олгосон, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх талаарх ялын бодлогын нэг тусгал байжээ” гэж дүгнэж болохоор байна.

Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага мэргэжил арга зүйн удирдлагаар хангахаас гадна Прокурорын байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллахаар хуульчилж өгсөн байна.

1.1. Гадаадын зарим орны өсвөр насны хүнд оногдуулах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ:

А. Америкийн Нэгдсэн Улс:

Америкийн Нэгдсэн Улсын хувьд насанд хүрээгүйчүүдийн хорих ялыг тэдэнд зориулж тусгайлан байгуулсан газарт буюу хүмүүжлийн сургуульд эдлүүлдэг.

Насанд хүрээгүй хоригдлуудад өдөрт нь шоронгийн байрлалд ажиллаж, сурах бөгөөд шөнө нь гэртээ очиж, хонож болдог байна. Энэ байдал нь хоригдлуудын хүмүүжилд нааштай нөлөө үзүүлдэг болох нь практикаар батлагджээ.

Б. Холбооны Бүгд Найрамдах Герман улс:

Тус улсад насанд хүрээгүйчүүдийг засан хүмүүжүүлэхэд нийгмийн ажилтны онцлон анхаарах зүйл бол өсвөр үеийнхэнтэй явуулах хүмүүжлийн ажлыг ирээдүйд амьдралын хууль сахих хэв маягийг амьдралдаа шингээж, нийгмийн өмнө хариуцлагаа ухамсарлаж сургахад оршдог.

Герман болон баруун европын улсуудад туршилтын гэгдэх аргыг өргөн хэрэглэдэг. Энэ нь шүүхээс тогтоох нэг төрлийн дэглэм бөгөөд тухайн насанд хүрээгүй ялтны ял эдлэх хугацаанд биелүүлэх “ажлын төлөвлөгөө” гаргаж биелэлтийг нь нийгмийн ажилтан хянаж ажиллана гэсэн үг юм.

В. Франц улс:

Франц Улсын ял эдлүүлэх ажиллагааны нэг онцлог бол насанд хүрээгүй хоригдлын шашин, буяны болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагад ялаа эдлэхийг зөвшөөрч, насанд хүрээгүй гэмт этгээдийг нийгэмшүүлдэг хувийн болон төрийн тусгай байгууллагыг бий болгосон.

2000 оны эхэн үеэс эхлэн хуулийн дагуу насанд хүрээгүй этгээдэд оногдуулдаг байсан албадлагын арга хэмжээнээс илүү боловсрол, хүмүүжлийн аргад суурилсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах нь их болсон байна.

Г. Оросын Холбооны Улс:

Тус улсын Эрүүгийн хуульд хөнгөн болон хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх нь тохиромжтой гэж үзвэл ялаас чөлөөлөгдөхөөр заажээ.

Тус улсын хувьд сурган хүмүүжүүлэх тусгай хөтөлбөр сургалттай байдаг.

Тухайлбал, сануулга болон эцэг эхийн хараа хяналтад шилжүүлэх, учруулсан хор уршгийг арилгах үүрэг болон чөлөөг хязгаарлах нь нэгэн зэрэг оногдуулах боломжтой.⁵

Д. Англи улс:

Тус улсын хууль тогтоомж дахь насанд хүрээгүй этгээдэд ял оногдуулахдаа

⁵ ГТод ред А.Наумова., Комментарий к уголовному кодексу российской федерации. М., 1997. Стр 2

эрүүгийн хариуцлага ногдуулах доод нас 10 байдаг бөгөөд 10-14 насны хүүхэд хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага нь насанд хүрсэн этгээдээс өөр, ял шийтгэлийн ялгамжтай өөрөөр хэлбэл насанд хүрээгүй этгээд нь ноцтой гэмт хэрэг үйлдсэнээс бусад тохиолдолд насанд хүрсэн этгээдэд оногдуулснаас хөнгөн буюу ялгамжтай ялыг оногдуулдаг.

Мөн 10-17 насны буюу насанд хүрээгүй гэмт хэрэгтний хувьд зөвхөн онц ноцтой гэмт хэрэг (хүн алах зэрэг) үйлдсэнээс бусад тохиолдолд залуучуудын шүүх тухайн хэргийг шийддэг байна.

Шүүх хүмүүжлийн арга хэмжээ авахыг даалгах даалгавар гаргах ба энэ нь эцэг эх болон хүүхэд нь юу хийх ёстой, юу хийх ёсгүйг даалгасан даалгавар байдаг байна. Хэрэв үүнийг зөрчвөл шүүхэд дахин дуудагдаж цаашлаад ялыг нь хүндрүүлдэг.

Дээрх орнуудын өсвөр насны хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын эрх зүйн зохицуулалтаас харахад Монгол улсын эрүүгийн хуульд заасантай утга агуулгын хувьд төстэй ч зарим талаараа насанд хүрээгүй этгээдийн боловсрол, суурь хүмүүжил, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, хүмүүжүүлэх ажлыг аливаа байгууллага, ажилтанд үүрэг болгохоос илүү эцэг, эхэд нь даалгаж байна.

Мөн гадаадын зарим орны туршлагаас үзэхэд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ бүлэгт дурдсанчлан олон төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэж болохоор сонголттой байхад манай улсын өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага л гэхэд цөөн хэдэн төрлөөр хэрэгжиж байна.

Дээрхээс үзвэл гадаад орнуудын соёл, хөгжил дэвшил Монгол улс шууд нэвтрүүлэн хэрэглэх нь боломжгүй, хэдий тийм ч хүний эрх, эрх чөлөөг хамгаалах болоод олон улсын жишигт нийцүүлэн харьцангуй үр дүнтэй эрүүгийн хариуцлагын төрлийг сонгон, үр дүнтэй хэрэглэх нь зүйтэй юм.

2. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний талаарх практик, судалгаа, одоогийн практикийн хэрэгжилт.

Хүснэгт. Монгол Улсын хэмжээнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн тоон судалгааг 2022 он, 2023 он, 2024 оны эхний 2 сарын байдлаар судлахад:

2023 он										
Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	409	196	156	1	1	6	1		31	213
2024.02 сар										
Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	284	65	55	2		1				219
Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	249	89	66			3	3	1	16	160

Дээрх судалгааг дүгнэж үзэхэд өсвөр насны шүүгдэгч нарт шүүхээс сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдлүүлэхээс илүүтэйгээр гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр, нийгэмд нь хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, гэмт хэрэг үйлдэх шалтгаан нөхцөл, үүсэх үр дүнг таниулах, өөрийгөө өөрчлөх, засах боломжийг олгож, нийгэмд эргэн ороход нь туслах зорилгоор хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авч байна гэж дүгнэхээр байна.

Гэвч дахин гэмт хэрэг үйлдсэн тохиолдол 2022 онд 3, 2023 онд 6, 2024 он гарсаар 1 бүртгэгдсэн байгаа нь тухайн албадлагын арга хэмжээнд хяналт тавих үүргээ төрийн болон төрийн бус байгууллага, нийгмийн ажилтан гэмт хэрэг үйлдсэн тухайн этгээдийг хүмүүжүүлэхээр байдаг, тухайн үүргийг эцэг эх, сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалагч харгалзан дэмжигч нарт давхар үүрэг болгож өгөөгүйгээс тэдгээр хүмүүсийн зүгээс хүүхдэдээ тавих хараа хяналт сул байгаагаас нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх ажил үр дүнгүй байна гэж дүгнэхээр байна.

Мөн өсвөр насны хүүхэд тавих хараа хяналтыг зөвхөн “Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн төв” буюу төрийн байгууллага болон бусад төрийн бус байгууллагад даатгаад орхилгүй, эцэг, эх, сурган хүмүүжүүлэгч нараас тавих хяналтыг сайжруулж, тухайн хүмүүсийг явуулж буй сургалт хөтөлбөр төлөвлөгөөнд хүүхдүүдийн хамт хамруулж, зохих нийгэмших, зөв хүн болж төлөвшүүлэх, эцэг, эх, сурган хүмүүжүүлэгч нараас тавих хяналтыг сайжруулах, зохих хэмжээнд хүүхдүүдийн санхүүгийн боломжоор хангаж амьдрах, хүүхдэдээ тавих анхаарал халамжийг сайжруулж байж, зөв хүн төлөвшин хөгжих боломжтой байна.

Мөн шүүхээс хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авахдаа голцуу зан үйлээ засах, хөдөлмөрлөх сургалтад хармагдах үүргийг хүлээлгэж шийдэж байна. Өсвөр насны хүүхдэд дан сургалтад хамруулахаас гадна нас бие, онцлогт нь тохирсон давхар нийгэмд тустай хөдөлмөр эрхлүүлэх, мэргэжил эзэмшүүлэх, сайн дурын сайн үйлсийн аянд тодорхой хугацаагаар оролцуулахаар тогтоож өгч шийдвэрлэдэг боломжийг эргэн нэг хармаар санагдаж байна.

Өсвөр насны хүүхэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хугацаандаа насанд хүрсэн тохиолдолд албадлагын арга хэмжээг хэрхэн явуулах, сургалт, хөтөлбөр төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах боломж нөхцөлийг судлах шаардлагатай байна.

3. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалтын тулгамдсан байдал ба хүний эрхийн асуудал.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хяналт тавихад Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн 3, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 192 дугаар зүйлийн 192.3 дахь хэсэгт заасны дагуу, бусад хууль тогтоомж болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын хамтарсан 2020 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн А/138, А/191 дугаар тушаалаар баталсан “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журам”-ын дагуу хэрэгжүүлдэг.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “... гэмт хэргийн хор уршгийг арилгах, гэмт зан

үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, тодорхой ажил үүрэг гүйцэтгэх, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх” үүрэг болгосон албадлагын арга хэмжээг хэсэгчлэн болон бүгдийг биелүүлэхийг шүүхээс даалгасныг үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан.

Гэтэл практикт хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ тухайн хүүхдийн гэмт хэрэг үйлдэх болсон учир шалтгааныг төдийлөн тодорхойлохгүйн улмаас тодорхой хэдэн сургалтын хөтөлбөрийг хүүхэд бүрд төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь албадлагын арга хэмжээ авагдсан хүний нас, эрүүл мэнд, сэтгэл зүйн онцлогт тохирсон сургалт, хүмүүжлийн ажлын хөтөлбөр, төлөвлөгөөг батална⁶ гэсэн цогц үйл ажиллагааг хангаж чадахгүй байна.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн этгээд болон сум, дүүргийн Засаг даргаас хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх харилцан мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлж, хамтран ажилладаг хэдий боловч энэ талаар нарийн зохицуулсан журам байхгүй байна.

Одоогоор сургалтын төлөвлөгөө нь хууль эрх зүйн боловсрол олгох сургалт- 8 цаг, амьдрах ухааны боловсрол олгох сургалт- 12 цаг, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт- 4 цаг, нийгэм, сэтгэл зүй, зан үйлийн сургалт- 10 цаг, эцэг, эхийн боловсролд- 10 цаг байхаар боловсруулж албадлагын арга хэмжээ авч, хяналт тогтоосон хугацаанд сард 2 удаа сургалт зохион байгуулдаг ба ихэнх тохиолдолд лекц, харилцан яриа хэлбэрээр явагддаг, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага нь уг албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн үйлдсэн гэмт хэргийн төрөл, гэмт хэрэг үйлдсэн гол шалтгаан нөхцөлд тулгуурлан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг тусгайлан хүүхэд нэг бүрд зориулж боловсруулахгүй байгаагаас практикт хэрэгжилт үр дүнгүй байна.

Иймд хувь хүний хүмүүжил, үзэл баримтлал, амьдрах ухаан, сурч боловсрох, нийгэмтэй харилцах, бие хүн болж төлөвших мэдлэг, боловсрол олж авах ажилд сургалтыг чиглүүлж явуулах нь зүйтэй байна.

Дүгнэлт

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, хяналтын ажлын явц, холбогдох судалгаа хийсэн дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний мөн чанар биеллээ олох нэг түлхүүр нь үр дүнтэй сургалт байхад ихэнх тохиолдолд лекц, харилцан яриа хэлбэрээр явагддаг, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага нь уг албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн үйлдсэн гэмт хэргийн төрөл, гэмт хэрэг үйлдсэн гол шалтгаан нөхцөлд тулгуурлан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг тусгайлан хүүхэд нэг бүрд зориулж боловсруулахгүй байгаагаас практикт

⁶ Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журам. Уб., 2020 он

хэрэгжилт үр дүнгүй байна.

Мөн албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд өсвөр насны хүүхэд насанд хүрсэн тохиолдолд түүнд авах арга хэмжээ нь урд баталсан төлөвлөгөөний дагуу сургалт нь явагдах уу, дахин сургалтын хөтөлбөр батлуулж ажиллах уу гэдэг нь тодорхойгүй, тодорхой хэдэн сургалтын хөтөлбөрийг хүүхэд бүрд төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь албадлагын арга хэмжээ авагдсан хүний нас, эрүүл мэнд, сэтгэл зүйн онцлогт тохирсон сургалт, хүмүүжлийн ажлын хөтөлбөр, төлөвлөгөөг батална⁷ гэснийг хангаж чадахгүй байна

2. Олон улсын хэмжээнд Нэгдсэн Үндэсний Байгууллагаас гаргасан “Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан гаргасан стандартын наад захын журам”-д насанд хүрээгүй хүнд үзүүлэх нөлөөллийн олон төрлийн арга хэмжээ болох асран хамгаалах, удирдан чиглүүлэх, хяналтад өгөх, ял тэнсэх, мөнгөн шийтгэл, нөхөн төлбөр, хохирлыг барагдуулах, завсрын болон бусад арга хэмжээ авахаар тогтоох, нийгэмд тустай хөдөлмөр эрхлүүлэх, бүлэг хэсэгт нь сэтгэцийн эмчийн зөвлөгөө өгүүлэх болон түүнтэй төстэй үйл ажиллагаанд оролцох, зохих бусад арга хэмжээ тогтоох⁸ зэрэг хорихоос өөр төрлийн арга хэмжээнээс боломжит байдлаар хэрэгжүүлэх хууль эрх зүйн нөхцөлийг судлан шийдвэрлэх шаардлага үүсэж байна.

Ингэснээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний зорилго нь гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдралын зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

3. Монгол Улсын хэмжээнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүдээс дахин гэмт хэрэг үйлдэх тохиолдол жил ирэх тусам өсөх хандлагатай байна.

Өсвөр насны хүүхэд тавих хараа хяналтыг зөвхөн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн төв буюу төрийн байгууллага болон бусад төрийн бус байгууллагад даатгаад орхилгүй, эцэг, эх, сурган хүмүүжүүлэгч нараас тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Эцэг эхийн зүгээс насанд хүрээгүй хүүхдүүдийг хүмүүжүүлэх үйл явцад сэтгэл зүйн болон эд материалын хэрэгцээ шаардлагыг зохих төвшинд үзүүлдэггүй, хараа хяналт сулаас өсвөр насны хүүхдүүд дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдсоор байна.

Иймд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээнд тавих хяналтыг зөвхөн төрийн болон төрийн бус байгууллагад даатгаад орхилгүй, эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч нарт давхар үүрэг болгож өгөх нь зүйтэй юм.

4. Манай улсын хувьд хүүхдийн тусгайлсан шүүх, хүүхдүүдийг байршуулсан хүмүүжүүлэх тусгай төв ажилладаггүй, хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газар өсвөр насны хүнд оногдуулсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахдаа хуульд заасан үүргийг хангуулахаас гадна арга хэмжээ авагдсан хүүхдүүдийг тодорхой хугацаагаар бие, эрүүл мэндэд нь тохирсон нийгэмд тустай олон нийтийн сайн дурын ажилд хамруулах, сурч боловсрох, сургалтад

⁷ Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журам. УБ., 2020

⁸ Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам. /Бээжингийн журам/. 1985

хамруулах, тодорхой мэргэжил эзэмшүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө, уулзалт зохион байгуулах, гэмт хэрэг зөрчил гаргахгүй байх талаас нь урьдчилан сэргийлэх ажлын шат дараалаалтай авч хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна.

Санал

Энэхүү илтгэлийн сэдвийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

- Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулах хорихоос өөр төрлийн арга хэмжээг олон улс болон гадаадын зарим орнуудын жишигт нийцүүлэн эрх зүйн зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулах буюу Монгол улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт “Хорихоос өөр төрлийн арга хэмжээний төрөл” гэж нэмж, үүнд нь сануулах, засарч хүмүүжихийг өөрт нь даалгах, эцэг эхэд нь хүмүүжүүлэх үүрэг хүлээлгэх, тодорхой эрх чөлөөг хасах, нийгэмд тустай хөдөлмөр эрхлүүлэх, зэрэг хүний эрх, эрх чөлөөг хангасан эрүүгийн хариуцлагын төрөл хэрэглэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.

- Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээнд тавих хяналтыг зөвхөн төрийн болон төрийн бус байгууллагад даатгаад орхилгүй, эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч нарт давхар үүрэг болгож өгөхийг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан тусгах нь зүйтэй байна.

Зохион байгуулалтын хүрээнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон хүүхэд залуучуудын төвөөс явуулж байгаа сургалт, хөтөлбөр төлөвлөгөө нь албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн үйлдсэн гэмт хэргийн төрөл, гэмт хэрэг үйлдсэн гол шалтгаан нөхцөлд тулгуурлан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг тусгайлан хүүхэд нэг бүрд зориулж боловсруулах, насанд хүрээгүй этгээдийн сэтгэл зүйн онцлог, нас аливаад хандах хадлага зэргийг нь харгалзан тусгай мэргэшсэн сэтгэцийн эмч хүүхдэд зөвлөгөө өгөх, зөвлөгөө нь хүүхдийн төлөвшил, зан араншинд тодорхой үр дүн нөлөө үзүүлэхээр байх, сэтгэл засал, сэтгэл зүйн сургалтыг тогтмол явуулах, сургалт боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх, нийгэмшүүлэх, хүмүүжлийн аргад суурилах.

- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ тэдний эцэг, эх, харгалзан дэмжигчидтэй илүү ойр ажиллаж, хүүхэдтэйгээ цагийг өнгөрөөх, харилцан ярилцах, хүмүүжил төлөвшилд сайнаар нөлөөлөх, зөв хүн болж төлөвшүүлэх үр дүнтэй арга барилын талаар мэдээлэл, зөвлөмж өгөх болон хүүхдийнхээ наад захын санхүүгийн хэрэгцээ шаардлагыг хангах, боловсрол эзэмшүүлэхтэй холбоотойгоор хамтран ажиллах.

Үйл ажиллагааны хүрээнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон хүүхэд залуучуудын төвөөс явуулж байгаа сургалт, хөтөлбөр төлөвлөгөө нь албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн үйлдсэн гэмт хэргийн төрөл, гэмт хэрэг үйлдсэн гол шалтгаан нөхцөлд тулгуурлан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг тусгайлан хүүхэд нэг бүрд зориулж боловсруулах.

- Сургалтыг уламжлал болон тогтсон хэлбэрээр бус өсвөр насны хүн өөрийн

биеэр оролцох байдлаар зохион байгуулах буюу сайн үйлсийн аян зохион байгуулахыг даалгах, эсхүл оролцуулах, хэд хэдэн этгээдүүдийг өөрсдийн хүсэл, сонирхлын дагуу 1 бүлэг, баг хамт олон болгон клуб, зөвлөл хэлбэрээр бүлгийн үйл ажиллагаа зохион байгуулахыг даалгах гэх мэт орчин үеийн боловсронгуй аргыг ашиглах.

- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн засрал, хүмүүжил, зан үйлийн илэрхий өөрчлөлтөд анхаарч, сургалтын үйл явцын тайлангаас илүү зан үйлд хэрхэн нөлөөлсөн өөрчлөлтийн талаар бодит үр дүнд хүрч ажиллах.

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн Хууль 1992 он
2. Монгол Улсын 1926, 1929, 1934 оны Шүүх цаазын бичиг хууль, 1942, 1961, 1986, 2002, 2015 оны Эрүүгийн хуулиуд
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он
5. Эрүүгийн хууль 2017 он
6. Прокурорын тухай хууль 2017 он
7. Америкийн Нэгдсэн Улс. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Оросын Холбооны Улс, Англи улсын хуулиуд

Олон Улсын гэрээ, конвенци, гадаад эх сурвалж

8. Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам. /Бээжингийн журам/ 1985 он
9. Нэгдсэн Үндэсний байгууллагын “Хорихоос бусад төрлийн арга хэмжээний наад захын жишиг дүрэм (Токиогийн дүрэм) 1990 он,
10. Хорихоос бусад төрлийн арга хэмжээний наад захын жишиг дүрэм (Токиогийн дүрэм) 1990 он,
11. Дэлхийн эрүүгийн загвар хууль ба орчин үе. УБ., 2013 он
12. Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам. /Бээжингийн журам/, 1985
13. UNICEF. Хууль зөрчсөн хүүхдийн асуудал Монголд., 2002 он
14. ГТод ред А.Наумова., Комментарий к уголовному кодексу российскоф федерации. М., 1997
15. Model Codes for Post-conflict. Criminal Justice Model Criminal Code. Vivienne O Connor and Colette Raush editors, Peasbuilding and the Rule of Law. W. 2007

Журам, заавар

16. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журам 2020 он
17. Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар 2021 он

Ном, сурх бичиг

18. Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль. УБ. 2021 он.
19. Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) УБ 2011 он
20. Улсын Дээд шүүх, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангаас эрхлэн хэвлүүлсэн Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2010 он
21. хэрэгжилт. 2020 он
22. Мөнхбат, Ц. Нийтэд тустай ажил хийлгэх ял. -УБ., 2020. 6 дахь тал
23. Б.Содовсүрэн “БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” 1971 он
24. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил I дэвтэр., Эмхэтгэсэн, Адьяабазар, УБ., 1998 он
25. Монгол хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл,
26. Баярсайхан, Б. Жанцан, С. Сумъяацэрэн, Д. Энхнасан, Ж. Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009).
27. Жанцан, С. Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол
28. Гантөмөр, Г. Энхболд, Б. Гантулга, С. Бат-Очир, Л. Төгс-Очир, Ж. нар Эрүүгийн эрх зүй ерөнхий анги,
29. Гантулга, С. Энхболд, Б. Монгол улсын ялын бодлогын өөрчлөлт 2012-2017 /Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл. 2017.
30. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба., Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл 2018 он
31. Дотоод хэргийн их сургууль Цэрэнхандын Түвшинжаргал “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилт эрх зүйн зохицуулалт” судалгааны материал,

Цахим эх сурвалж:

32. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://Legalinfo.mn>
33. Шүүхийн шийдвэрийн цахим сан. <https://shuukh.mn>
34. https://www.ncs.cd.gov.mn/?page_id=648

ХААЛТТАЙ ДЭГЛЭМИЙН ТУСГАЙ НЭГЖИД ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ХОРИГДЛЫН ЭРХ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нийслэлийн Прокурорын газрын хяналтын прокурор Л.Цогтхүү

Хураангуй:

Энэ эрдэм шинжилгээний илтгэлд хаалттай дэглэмийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлын эрх, эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, тэдгээрийг боловсронгуй болгох, бүх насаар хорих ял шийтгэгдсэн хүний эрхийн талаар хууль тогтоомжид хэрхэн тодорхойлсон, өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

Түлхүүр үгс:

Хүний эрх, ял эдлүүлэх ажиллагаа, бүх насаар хорих ял, хаалттай дэглэм, тусгай нэгж, хоригдлын эрх.

Удиртгал

Хүний эрх нь хүнд төрөхөөс заяагдсан эрх бөгөөд хүний эрхэм чанар, хүний үндсэн эрх, эрх чөлөөнд харшлах үйлдлээс хувь хүн болон аливаа бүлгийг, үндэсний, олон улсын хуульчилсан хэм хэмжээгээр хамгаалах явдал юм. Өөрөөр хэлбэл хүний эрх бол таныг хүний зэрэгтэй, нэр төртэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа гэж хэлж болно. Хүний эрх нь хүнээс төр, нийгэм, хүмүүстэй харьцах түүний эдийн засаг, нийгэмшил, улс төр, соёлын хүрээн дэх зан үйлийн боломжоос гадна өөрийн мөн чанараа илэрхийлж нийгэм дэх эрх зүйн байдалтай зохицон эрх чөлөөний хэмжээ хязгаарыг тодорхойлно, өөрөөр хэлбэл, хүний эрх нь эрх чөлөөгүйгээр байх боломжгүй юм. Хүний эрх нь нийгмийн бүхий л харилцаанд хамааралтай ба хуулиар тодорхой эрхийг нь хязгаарласан хүнд ч мөн адил хамаарна.

Үндсэн хэсэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 405 дугаар хаалттай /тусгай нэгж/ хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлын эрхийн хэрэгжилтийг судлахын урьд шүүхээс оногдуулж буй бүх насаар хорих ялын онцлог, түүнийг Монгол улсад болон гадаад орнуудад хэрхэн хэрэгжүүлж буй байдлыг товч авч үзлээ.

Дэлхийн ихэнх улсуудын Эрүүгийн хуульд бүх насаар хорих ялыг хуульчилсан ба цээрлэлээрээ цаазаар авах ялын дараа ордог, цаазаар авах ялыг халсан орнуудын хувьд хамгийн хүнд, бас онцлог ялын төрөл юм.

НҮБ-ын “Хүний иргэний болон улс төрийн эрхийн факт”-ын нэмэлт II протокол буюу “Цаазаар авах ялыг халах” тухай конвенц-ийг баталснаас хойших 20-иод жилийн хугацаанд олон улсын хэмжээнд цаазаар авах ялыг халах, татгалзах үйл явц хүчтэй өрнөж байна. Түүнчлэн 2022 онд дэлхийн 193 улсаас 169 улсад цаазаар авах ялыг хэрэглээгүй /оногдуулаагүй, гүйцэтгээгүй/ болохыг олон улсын “Amnesty International” байгууллагын мэдээнд дурджээ¹.

¹ Хуторская Н.Б. Пожизненное лишение свободы в мире // ж. Уголовно-исполнительное право. 2018. № 13. С. 67

Сүүлийн жилүүдэд цаазаар авах ялыг халах, татгалзах үйл явцыг дагалдан дэлхийн улсууд бүх насаар хорих ялыг хуульчлах болсноор уг ялаар шийтгүүлэгсдийн тоо өсөх хандлага ажиглагдаж байна. Олон улсын Ялын шинэчлэл /Penal reform international/ байгууллага болон Английн Ноттенгэймийн их сургуулийн эрдэмтдийн 2020 онд хийсэн хамтарсан судалгаагаар 2000 онд дэлхийн хэмжээнд 261.000 ялтан уг ялаар шийтгүүлж, ялаа эдэлж байсан бол энэ тоо, 2014 онд 305.323, 2017 онд 479.002 болж өссөн нь үүнийг батална².

Бүх насаар хорих ялын тухай асуудал нь хүний эрх, сэтгэл зүй, хууль зүйн салбар шинжлэх ухааны судлагдахууны өнцгөөс тодорхойлон тайлбарлаж болох өргөн хүрээтэй асуудал юм.

Ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн онол, практикийн асуудлыг авч үзэхдээ тухайлбал, хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн асуудал, түүний дотор хаалттай дэглэмийн тусгай нэгжид хорих ял эдэлж буй хоригдлын эрхийн хэрэгжилт, түүний эрх зүйн зохицуулалтыг авч үзсэн бөгөөд хоригдлын эрх нь мөн хоригдлын эрх чөлөөтэй шууд хамааралтай юм..

Хоригдлын эрх гэдэг ойлголтод Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудад хорих ял эдэлж буй хоригдлын хуулиар олгогдсон нөхцөл боломж, хуулиар хориглосноос бусад зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, бусад этгээдүүдээс тухайн хоригдолд эдэлж хэрэгжүүлэх эрх чөлөөний цогц гэж томьёолж болохоор байна..

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой төрлийн хүнд гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх насаар хорих ял оногдуулж хаалттай хорих байгууллагад эдлүүлж байгаа бөгөөд хоригдлын эрхийн хэрэгжилт нь хууль тогтоогч болон хэрэгжүүлэгч байгууллагуудын хувьд тухайн хоригдлын эргэлт уулзалт, хөдөлмөр эрхлэлт, сурч боловсрох зэрэг эрхүүдийг хэрхэн хангах, жам ёсны эрхийг нь хэрхэн эдлүүлэх асуудал маргаан дагуулсаар байна.

Бүх насаар хорих ялын онцлогийн талаар судлаач Г.Оюунболд: “ Хэрэв бүх насаар нь хоривол тэр хүн шоронгоос үхээд л гарна. Хугацаагүйгээр хорих ялтай бол тухайн хоригдлыг хүмүүжсэн гэж үзвэл суллаж болно гэсэн үг” гэж³ үзсэн бол доктор (Ph.D) Д.Баярсайхан " Нилээд оронд бүх насаар нь хорих ял нь цаазаар авах ялыг орлон хэрэглэгдэж байгаа боловч сүүлийн 30 жилийн хандлагаас үзэхэд энэ ялын хэрэглээнд хүнлэг ёсны шаардлагыг хангах, хүмүүнлэгийн /өршөөн нигүүлсэх/ зарчмыг хангахад чиглэгдсэн зарим алхам хийгдэж буй нь бүх насаар нь гэдгээр биш, харин уртасгасан хугацаагаар буюу хугацаагүй хорих гэсэн агуулгаар солигдон хөгжих төлөв илрэх болсныг анхаарч хандах ёстой” гэж⁴, доктор (Ph.D) Л.Бат-Очир: “Бүх насаар хорих ялын агуулга нь хүний амьд явах итгэл, үнэмшлийг үгүйсгэх, устгах зэргээр илрэх ба нэр томьёо, хэллэг, эрүүгийн эрх зүйн үр дагаврыг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлж олон улсын жишиг, хүний эрхийн суурь зарчмуудад нийцүүлэх шаардлага байна” гэж тэмдэглэжээ⁵.

² <https://cdn.penalreform.org/wpcontent/uploads/2018/04pdf>

³ Д.Баярсайхан. Харьцуулсан судлал. Уб., 2005.

⁴ Д.Баярсайхан. Харьцуулсан судлал. Уб., 2005. 78 дахь тал.

⁵ Л.Бат-Очир. Бүх насаар хорих ялын хэрэгжилт, эрх зүйн зохицуулалт. Уб., 2019. Цагдаа судлал Дугаар № 01

НҮБ-ын “Хүний иргэний болон улс төрийн эрхийн пакт”-ын нэмэлт II протокол буюу Цаазаар авах ялыг халах тухай конвенцыг баталснаас хойших 20-иод жилийн хугацаанд олон улсын хэмжээнд цаазаар авах ялыг халах, татгалзах үйл явц хүчтэй өрнөж байна. НҮБ-ын “Хүний иргэний болон улс төрийн эрхийн пакт”-ын нэмэлт II протокол буюу Цаазаар авах ялыг халах тухай конвенцыг НҮБ-ын Ерөнхий ассамблей 1989 оны 12 дугаар сарын 05-ны өдөр баталж, 1991 оны 07 дугаар сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд 2023 оны 04 дүгээр сарын байдлаар уг конвенцид 89 улс нэгдэн ороод байна. Мөн бүс нутгуудын хэмжээний хүний эрхийн бичиг баримтад зарим өөрчлөлтүүдийг оруулжээ. Тухайлбал, Европын Зөвлөлийн Хүний эрх ба үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенцын нэмэлт VI протокол буюу Цаазаар авах ялыг халах тухай протокол нь 1983 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Страсбург хотод батлагджээ. Европын Зөвлөлд 46 улс, Европын Холбоонд 27 улс багтах ба 1997 оноос хойш Европ тивд цаазаар авах ялыг гүйцэтгээгүй, 2013 оноос Европ тив цаазаар авах ялгүй бүс нутаг болоод байгаа юм. Европын зөвлөлийн гишүүн орнуудаас гагцхүү Беларусь улс уг конвенцид нэгдэн ороогүй байна. Мөн Америкийн улсуудын байгууллагын Ерөнхий ассамблей 1978 онд баталсан Америкийн Хүний эрхийн тухай конвенцын 1990 оны нэмэлт протоколд “... гишүүн орууд цаазаар авах ял хэрэглэхгүй байх, хэрэв хэрэглэх бол онцгой нөхцөлд буюу дайны цагт цэргийн гэмт хэрэг үйлдсэнээс бусад тохиолдолд цаазаар авах ялыг хэрэглэхгүй байх...”-ыг үүрэг болгосон байдаг. 2022 оны байдлаар 108 улс цаазаар авах ялыг бүрмөсөн халсан, 6 орон цаазаар авах ялыг ердийн эрүүгийн хэрэгт хэрэглэхгүй, зөвхөн дайны цагт эсвэл дайн бүхий байдлын үед онц хүнд гэмт хэрэг үйлдсэн онцгой тохиолдолд хэрэглэхээр байгаа бол 60 гаруй оронд цаазаар авах ялыг Эрүүгийн хуульд ялын төрөл болгон хуульчилсан хэвээр байна. Түүнчлэн 2018 онд дэлхийн 193 улсаас 169 улсад цаазаар авах ялыг хэрэглээгүй / оногдуулаагүй, гүйцэтгээгүй/ болохыг олон улсын Эмнести Интернешнл байгууллагын мэдээнд дурьджээ.

Монгол Улс ч уг үйл явцаас ангид байсангүй, ийм сонголтыг 2012 онд хийж, Улсын Их Хурал “Цаазаар авах ялыг халах тухай” конвенцыг соёрхон баталж, 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулахдаа цаазаар авах ялыг ялын төрлөөс хасаж, хугацаагүй хорих ялыг хорих ялын төрөл болгон хуульчилсан билээ.

Монгол улсад бүх насаар хорих ялыг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 14 төрлийн гэмт хэрэгт оногдуулахаар хуульчилсан байна.

Монгол Улсын хувьд бүх насаар хорих ялыг Эрүүгийн хуульд тусгаж, ял эдлүүлэх ажиллагааны нөхцөл журмыг бусад хууль, журмуудаар зохицуулж, ял шийтгүүлсэн хоригдол 30 жил хорих ялыг биечлэн эдэлсний дараа шүүхээс тухайн хоригдлыг суллах эсэх асуудлыг шийдвэрлэхээр хуульчлагдсан нь төрөөс Үндсэн хуульд⁶ заасан хүний амьд явах язгуур эрхийг баталгаажуулж өгсөн явдал юм.

Тухайлбал: Монгол Улсын Эрүүгийн хуульд⁷ дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

5.6.5. Энэ хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүнийг хаалттай хорих байгууллагад тусгаарлаж бүх насаар хорих ял эдлүүлнэ,

⁶ Монгол Улсын Үндсэн Хууль. УБ., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл № . дүгээр зүйл

⁷ Эрүүгийн хууль. УБ., 2015. Төрийн мэдээлэл эмхэтгэл №. 5.6 дугаар зүйл.

5.5.6. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн гучин жил хоригдсоны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэнэ,

5.6.7. Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан журмаар ялтныг суллаагүй бол хоёр жил тутам энэ талаар дахин хэлэлцэнэ гэж тус тус хуульчилсан байна.

2015 онд Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдаж 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 405 дугаар хаалттай /тусгай нэгж/ хорих анги нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлуудыг 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч эхэлснээс хойш өнөөдрийн байдлаар бүх насаар хорих ял шийтгүүлсэн 24 хоригдол, зэрэглэл хүндэрч тусгай нэгжид шилжин ирсэн 14 хоригдол тус тус хорих ял эдэлж байна. Үүнээс бүх насаар хорих ял шийтгүүлсэн 7 хоригдлын ял шийтгэлд Улсын Дээд Шүүхээс өөрчлөлт оруулж хугацаатай хорих ял болгосон ба тусгай нэгжид зэрэглэл хүндэрч ирсэн 16 хоригдол нь хуульд заасан хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, засрал хүмүүжлээ олсон гэсэн үндэслэлээр хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд зэрэглэл хөнгөрүүлж шилжүүлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 200 дугаар зүйлд хаалттай хорих ангийн тусгай нэгжид хоригдлыг ял эдлүүлэх нөхцөл журам, эрхийг нь хуульчилж өгсөн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд⁸ зааснаар тусгай нэгжид хорих ял эдэлж буй хоригдол нь ганцаарчилсан тасалгаанд хоригдож байгаа бөгөөд шаардлагатай гэж үзвэл хорих ангийн дарга, прокурортой зөвшилцөн хоригдлыг хоёроор нь хорьж болох боловч ийм тохиолдол одоогоор практикт гараагүй.

Харин дээрх зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хоригдлыг тусгай тоноглогдсон газарт, зохих хяналт хамгаалалтад өдөрт 1 цагаас доошгүй хугацаагаар гадаалуулахаар заасан ба энэ нь хууль, журмын дагуу бүрэн хэрэгжиж байна.

Тэгвэл мөн зүйлийн 3 дахь хэсэгт хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно гэсэн заасан нь практикт огт хэрэгжихгүй байна. Учир нь тухайн хоригдлыг хэрхэн ажил хөдөлмөрөөр хангах талаар тодорхой зохицуулсан журам заавар байхгүй бөгөөд ганцаарчлан хорьж буй тохиолдолд ямар хөдөлмөр эрхлүүлж болох талаар тодорхойгүй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн⁹ 200 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар хоригдол 180 хоногт 2 удаа түр уулзалт хийж, 30 хоногт 1 удаа захидал явуулж, 90 хоногт 1 удаа илгээмж авч болно гэсэн заасан заалтыг хэрхэн хэрэгжиж буйг судлахад, 405 дугаар хаалттай /тусгай нэгж/ хорих ангийн хэмжээнд 2022-2024 оны эхний 2 сарын байдлаар түр хугацааны эргэлт уулзалт:

- 1 удаа авсан хоригдол 2,
- 2 удаа авсан хоригдол 3,

⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2015. Төрийн мэдээлэл эмхэтгэл № .. 200 дугаар зүйл.

⁹ Мөн хуулийн 200 дугаар зүйлийн 4 дэх хэсэг.

- 3 удаа авсан хоригдол 4,
- 4 удаа авсан хоригдол 3,
- 5 удаа авсан хоригдол 2,
- 6 удаа авсан хоригдол 3,
- 7 удаа авсан хоригдол 2,
- 8 удаа авсан хоригдол 1 байх ба энэ хугацаанд огт эргэлт уулзалт аваагүй 15 хоригдол байна.

Дээрх хугацаанд илгээмж

- 1 удаа авсан хоригдол 5,
- 2 удаа авсан хоригдол 6,
- 3 удаа авсан хоригдол 2,
- илгээмж огт аваагүй 22,
- ар гэрээс нь захидал ирсэн 15,
- захидал ирээгүй 24,
- ар гэртээ захидал явуулсан 18 хоригдол, захидал явуулаагүй 11 хоригдол байна.

Гэхдээ эдгээр эрхийн хэрэгжих нөхцөл нь тухайн хоригдол болон хорих ангиас шууд хамааралгүй боловч тус 405 дугаар хаалттай /тусгай нэгж/ хорих ангийн нийгэм, сэтгэл зүйн албанаас, ар гэрээс нь харилцаа холбоо байхгүй нэр бүхий 11 хоригдлын ар гэртэй холбоо тогтоож, тэдэнд хоригдлын хуулиар олгосон нөхцөл боломжийн дагуу түр уулзалт авах, захидал, илгээмж ирүүлэх талаар тодорхой тайлбарлаж, ойлгуулж өгсний үндсэн дээр хуульд заасан хугацаанд түр уулзалт зохион байгуулж, захидал, илгээмж хүлээн авсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан тусгай нэгж зэрэглэлд хорих ял эдэлж буй хоригдол нь утсаар ярих эрхгүй байгаа нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл хоригдол нь хорих байгууллагын харуул хамгаалалтын ажилтны хяналтын дор утсаар ярих бөгөөд үүнд ямар нэг хүндрэл бэрхшээлтэй ноцтой асуудал үүсэхгүй байх гэж үзэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тусгай нэгжид зөвхөн бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг хорих ял эдлүүлэхээр хуульчилсан боловч хаалттай дэглэмийн тусгай зэрэглэлд хорих ял шийтгүүлсэн хоригдол дахин сахилгын зөрчил гаргавал хаалттай дэглэмийн тусгай нэгжид хорих ял эдлүүлэхээр хуульчилсан нь буруу гэж үзэх үндэстэй. Өөрөөр хэлбэл бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын эрхийн хязгаарлалттай зэрэглэл хүндэрсэн хоригдлын эрхийг адил хэмжээнд тавьж өгсөн нь буруу юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар¹⁰ батлагдсан “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-ын 11 дүгээр бүлэгт “Хаалттай хорих ангийн тусгай нэгжийн харуул хамгаалалт”-ыг зохицуулж өгсөн бөгөөд тухайн заалтаар тусгай нэгжид

¹⁰ Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. Хорих ангийн харуул хамгаалалтын журам”. УБ., 2017. Дугаар А/197.

хорих ял эдэлж буй хоригдлыг ямар нэг хөдөлгөөн хийж хорих өрөөнөөс гаргах тохиолдол бүрд гар хөлд нь гав зүүж байхаар заасан бөгөөд иймд тусгай нэгжид хорих ял эдэлж буй хоригдлуудад сургалт, нийгэмшүүлэх ажил зохион байгуулахад хоригдлуудад бүлгээр, нийтээр сургалт, нийгэмшүүлэх ажил зохион байгуулах ямар ч хууль, эрх зүйн зохицуулалт, боломж байхгүй бөгөөд хоригдол бүртэй ганцаарчлан уулзаж эсвэл тухайн хоригдлуудын байрлах өрөөнүүдийн урд талд нь коридорт байрлуулсан дэлгэцээр хоригдлуудад мэдээлэл өгөхөөс өөр ямар ч боломж байхгүй зэрэг асуудлууд тулгамдаж байна. Энэ нь хоригдлын хуулиар олгогдсон зарим эрхүүд нь бүрэн хэрэгжих боломжийг хязгаарлаж байгаа явдал юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 405 дугаар хаалттай /тусгай нэгж/ хорих анги нь бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлэх Монгол Улсын хэмжээнд байгаа цорын ганц тусгай объект бөгөөд ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын харьяаллыг тогтоосон Монгол Улсын Ерөнхий Прокурорын ¹¹ тушаалаар Нийслэлийн прокурорын газарт харьяалуулсан бөгөөд одоогоор Нийслэлийн прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсээс прокурорын хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар ¹² хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачлалыг зааж өгсөн.

Дүгнэлт

Хаалттай хорих ангийн тусгай нэгжид хорих ял эдэлж буй хоригдлын эрхийн асуудлыг авч үзэхэд хууль тогтоомжийн боловсронгуй бус байдал нь хоригдлын зарим эрхийг зөрчсөн гэж дүгнэж байна.

Тухайлбал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 199 дүгээр зүйлийн 199.1 дэх хэсэгт “Хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна. Тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна”, мөн хуулийн 199.3 дахь хэсэгт “Хаалттай хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлнэ” гэж тус тус хуульчлан заасан бөгөөд энэ хуульд тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна гэж заасан заалтуудаас үзэхэд тусгай нэгж нь зэрэглэлд хамаарахгүй мэт боловч мөн хуулийн 206 дугаар зүйлд заасан “хорих ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх заалтад, тухайлбал, 206 дугаар зүйлийн 206.8. дахь хэсэгт “хоригдол 1 жилийн хугацаанд хоёр, түүнээс дээш удаа сахилгын зөрчил гаргасан, эсхүл сахилгын ноцтой зөрчил гаргасан тохиолдолд... хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлээс тусгай нэгжид зэрэглэл хүндрүүлэх саналаа прокурорт гаргаж прокурор 10 хоногийн дотор шийдвэрлэнэ” гэж заажээ.

Энэ зохицуулалтаас үзэхэд хуулиар тусгай нэгжид зөвхөн бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг хорих ял эдлүүлэхээр хуульчилсан боловч хаалттай дэглэмийн

¹¹ Монгол улсын Ерөнхий прокурорын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/96 дугаар тушаал. УБ., 2021.

¹² Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/71 дүгээр тушаал. “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”. УБ., 2021.

тусгай зэрэглэлд хорих ял шийтгүүлсэн хоригдол дахин сахилгын зөрчил гаргавал хаалттай дэглэмийн тусгай нэгжид хорих ял эдлүүлэхээр хуульчилсан нь тодорхой бус байдлыг бий болгосон.

Өөрөөр хэлбэл бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын эрхийн хязгаарлалттай зэрэглэл хүндэрсэн хоригдлын эрхийг адил хэмжээнд тавьж өгсөн нь буруу зохицуулалт болсон байна гэж үзэж байна.

Тусгай нэгжид хорих ял эдэлж буй хоригдлыг ганцаарчлан хорихоор хуульчилсан нь хамгийн хатуу заалт байх бөгөөд энэ нь бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн хоригдолд л зөвхөн хамаарах заалт байхаар хуульчилсан боловч зэрэглэл хүндрүүлж тусгай нэгжид хорих ял эдлүүлэхээр шийдвэрлэсэн хоригдолд мөн хамааралтай болж байгаа нь хоригдлын эрх зөрчигдсөн, хуулийн буруу зохицуулалт болсныг харуулж байна.

Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 90 хоногт нэг удаа түр, 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 60 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно гэж заасан байхад тусгай нэгжид хорих ял эдэлж буй хоригдол 180 хоногт хоёр удаа түр уулзалт хийж, 30 хоногт нэг удаа захидал явуулж, 90 хоногт нэг удаа илгээмж авч болно гэж зааснаас үзэхэд хаалттай хорих ангийн тусгай нэгжид хорих ял эдэлж буй хоригдлын эрх хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлийн хоригдлын эрхээс хязгаарлалт нь харьцангуй илүү байгааг харж болно. Үүнээс үзэхэд хуулийн буруу зохицуулалтаас хоригдлын эрх зөрчигдөх үндэслэл гарч ирж байна гэж үзэж болохоор байна.

Тусгай нэгж нь хоригдлын ял эдлэх хамгийн хүнд гэхээр газар, тухайлбал ганцаарчлан хорих ял эдлэх, мөн эрхийн хязгаарлалт нь бусад хоригдлоос хамгийн хатуу байхаар хуульчилсан тул энэхүү заалтад зөвхөн бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдолд л хамааралтай байх нь хуульд нийцнэ гэж үзэж байна.

Ийм учраас хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлээс зэрэглэл хүндрүүлж тусгай нэгжид хорих ял эдлүүлэх нь хууль зөрчсөн үйлдэл гэж үзэж болохоор байна. Энэ асуудлыг эргэж авч үзэх нь зүйтэй гэж дүгнэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206 дугаар зүйлийн 206.5 дах хэсэгт “Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болно” гэж заасан заалт нь ойлгомжгүй байна.

Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг зөвхөн тусгай нэгжид хорих ял эдлүүлэхээр хуульчлан заасан бөгөөд тусгай нэгжид 30 жил хорих ял эдэлсний дараа суллах эсэх асуудлыг шийдвэрлэж болохоор заасан ба өөрөөр тусгай нэгжид хорих ял эдэлж буй хоригдлыг дэглэм, зэрэглэлийг хөнгөрүүлэх, бууруулах талаар тусгайлан зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Гэтэл хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол 10 жил ял эдэлбэл гэж заасан нь туйлын ойлгомжгүй заалт болсон нь харагдаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206 дугаар зүйлийн 206.5 дахь хэсэгт заасан энэхүү заалт нь хоригдлын ял эдлэх зэрэглэлийг хөнгөрүүлж, эрхийг хангаж байгаа мэт зүйл заалт боловч энэ нь хуулиар огт зохицуулагдаагүй, хэрэгжүүлж болохгүй асуудал болох нь тодорхой байна.

Дээр дурдсан хууль тогтоомжийн боловсронгуй бус байдал нь хоригдлын эрхийг зөрчиж байна гэж үзэхээр байна.

Мөн тусгай нэгжид хорих ял эдэлж буй хоригдлуудад явуулах, нийгэмшүүлэх ажлыг тусгайлан авч үзэх, нийгэмшүүлэх ажлыг явуулах нөхцөл, арга хэлбэр, шаардлагад тохирсон тусгайлсан зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд цаазаар авах ялаас татгалзах, уг ялыг халах үйл явц хүчтэй өрнөж, дэлхийн улсууд бүх насаар бүх насаар хорих ялыг хэрэглэх болсонтойгоор уг ялыг оногдуулах, эдлүүлэхтэй холбоотой асуудлыг үндэсний хууль тогтоомжийн хүрээнд олон улсын жишиг, стандартад нийцүүлэн хуульчлах, уг ялаар шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангах асуудал чухлаар тавигдаж байна. Энэ асуудалд НҮБ, түүний салбар байгууллагууд анхаарал хандуулан бүх насаар хорих ялыг хэрэглэх, оногдуулах, эдлүүлэхтэй холбоотой асуудлыг хүний эрхийн олон улсын үндсэн баримт бичгүүд болон шүүх эрх мэдлийн салбарт хүний эрхийг хангахтай холбоотой жишиг дүрэм, журмуудад тодорхойлсон нь бүх насаар хорих ялын олон улсын эрх зүйн зохицуулалтын үндэс болжээ. Европ тивийн улсууд /Беларусь улсаас бусад/ цаазаар авах ялаас татгалзаж бүх насаар хорих ялыг хэрэглэдэг, иймээс уг ялыг хэрэглэх оногдуулах үндэслэл, хэмжээ хязгаар, бүх насаар хорих ял эдлүүлэх зарчим, тавигдах нөхцөл шаардлага, бүх насаар хорих ял эдэлж байгаа ялтантай харьцах эрхийг хангах, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн болон бусад туслалцаа үйлчилгээ зэрэг асуудлыг нарийвчлан тусгасан бүс нутгийн хэмжээний механизм, эрх зүйн зохицуулалтыг бий болгосон нь туйлын ач холбогдолтой, бусад тив улсуудад үлгэр жишээ болж байгааг зориуд тэмдэглэх нь зүйтэй. Энэ чиглэлээр сүүлийн жилүүдэд Хүний эрхийн болон бүс нутгийн олон улсын байгууллагууд, их дээд сургуулиуд холбогдох судалгааг явуулж, түүнд үндэслэн бүх насаар хорих ялыг эдлүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох зөвлөмжүүдийг гарган гишүүн орнууд хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай байна. Иймээс манай улс бүх насаар хорих ялтай холбоотой дэлхийн болон бүс нутгийн олон улсын эрх зүйн баримт бичгүүд, зөвлөмжүүдийг сайтар судлан хэрэгжүүлэх, тухайлбал, Эрүүгийн хуульд бүх насаар нь хорих ялыг ялын тогтолцоонд бие даасан ялын төрөл болгон хуульчлах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд уг ялыг эдлүүлэх асуудлыг тусгайлан бүлэг болгон хуульчлах, бүх насаар хорих ял эдлүүлэх тусгай салбарын /байрны/ нөхцөл журам, уг ялыг эдэлж буй хоригдлын эрхийг хангах, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн болон бусад үйлчилгээ, дэмжлэг зэргийг олон улсын жишиг, стандартад ойртуулах, олон улсын байгууллагын зөвлөмж, гадаад орнуудын сайн туршлагыг тусган хэрэгжүүлэх шаардлага чухлаар тавигдаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206 дугаар зүйлийн 206.9 дэх хэсэгт заасан "... ял эдэлж байгаа хоригдол хувиарлагдсан зэрэглэлд 1 жилийн хугацаанд зөрчил гаргаагүй бол зэрэглэл хүндрүүлэн шилжүүлсэн дарааллын дагуу анх хувиарласан зэрэглэлд зэрэглэл хөнгөрүүлэн шилжүүлнэ" гэж заажээ. Иймд хаалттай дэглэмийн тусгай нэгжид зэрэглэл хүндэрч шилжүүлсэн хоригдлыг тусгай нэгжид 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй бол зэрэглэл хөнгөрүүлж хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд хорих ялыг эдлүүлж болох ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/165 дугаар тушаалаар батлагдсан "Хоригдол, зорчих эрхийг хязгаарлах ял

шийтгүүлсэн ялтанд шагналын хоног олгох, хоригдлыг ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх болон хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоох тухай санал гаргах чиг үүрэг бүхий зөвлөлийн дүрэм, зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар бүлгийн 3.2 дахь хэсэгт “ Хоригдол, зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд шагналын хоног олгох, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох санал гаргах асуудлыг сар бүрийн эхний 7 хоногт багтааж, хоригдлын ял эдлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх болон хорих анги солих тухай санал гаргах асуудлыг тухайн нөхцөл байдал бий болсон үед хугацаа харгалзахгүйгээр хэлэлцэнэ” гэж зааснаас үзэхэд тусгай нэгжид хувиарлагдан 1 жил хорих ял эдлэхдээ сахилгын зөрчил гаргаагүй бол тухайн 1 жил дууссан үед хоригдлын хорих ял эдлэх зэрэглэлийг хөнгөрүүлж болно гэсэн ойлголт гарч ирж байгаа бөгөөд энэ нь хоригдлын эрхэд эерэг нөлөө үзүүлэх заалт гэж үзэж байна.

Санал

1. Хэрэв хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлийн хоригдол нь энэхүү хуульд заасан сахилгын зөрчлийг гаргасан тохиолдолд хаалттай хорих ангийн тусгай нэгжид зэрэглэл хүндрүүлж ял эдлүүлэх нь зүйтэй гэж үзвэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “хаалттай хорих ангийн тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол болон зэрэглэл хүндрүүлж шилжүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна” гэсэн томьёоллоор өөрчлөн найруулах,

2.Тусгай нэгжид хорих ял эдэлж буй хоригдлуудад явуулах сургалт, нийгэмшүүлэх ажлыг тусгайлан журам, заавраар зохицуулж өгөх нь зүйтэй. Учир нь тусгай нэгжид харуул хамгаалалтын тусгайлсан журам заавар хэрэгждэг тул тухайн хоригдлуудын харуул хамгаалалт болон эрх зүйн нөхцөл байдалтай холбоотойгоор тусгайлан авч үзэх шаардлагатай асуудал болно.Өөрөөр хэлбэл тусгай нэгжид хорих ял эдэлж буй хоригдлуудад явуулах нийгэмшүүлэх ажил нь хаалттай, нээлттэй дэглэмийн бүх зэрэглэлд ял эдэлж буй хоригдлуудад явуулах нийгэмшүүлэх ажлаас ихээхэн ялгаатай болох нь харагдаж байна..

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206 дугаар зүйлийн 206.5 дахь хэсэгт заасан “Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болно” гэсэн заалтыг хэрхэн ямар журмаар хэрэгжүүлэх талаар тодорхой болгох

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 200 дугаар зүйлд заасан хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдлүүлэх тухай заалтад “ хоригдол 90 хоногт нэг удаа утсаар ярьж болно” гэсэн заалтыг нэмж оруулж найруулах. Хоригдол утсаар ярих нь хорих байгууллагын харуул хамгаалалтын ажилтны хяналтын дор явагддаг учраас ямар нэг хүндрэл, бэрхшээл, ноцтой асуудал үүсэхгүй бөгөөд энэ нь хоригдлын зан төлөв, засрал хүмүүжил, сэтгэхүйн нөхцөл байдалд маш их эерэг нөлөө үзүүлдэг заалт болох нь хорих байгууллагын алба хаагчдын судалгааны үр дүнгээс харж болно.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 200 дугаар зүйлийн 200.3 дахь хэсэгт “ хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно” гэсэн заасан нь практикт огт хэрэгжихгүй байна. Учир нь тухайн хоригдлыг хэрхэн ажил хөдөлмөрөөр хангах талаар тодорхой зохицуулсан журам заавар байхгүй бөгөөд

ганцаарчлан хорьж буй тохиолдолд ямар хөдөлмөр эрхлүүлж болох талаар тодорхойгүй. Иймд энэ талаар тодорхой заалт, эсвэл тусгайлсан зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна.

Зөвлөмж

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний Эрхийн Үндэсний Комиссын гишүүний тайланг Улсын Их Хурлаар авч хэлэлцээд авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолын 1.е-д “Бүх насаар хорих ялыг хорих ялаас тусдаа ялын төрөл болгон хуульчлах асуудлыг судлан үзэж, ял эдлүүлэх дэглэм, зохион байгуулалт, сургалт, хөдөлмөрийн стандартыг шинээр тогтоох, түүнчлэн хорих ял эдлүүлэх дэглэмийн зэрэглэл хүндрүүлэн ганцаарчлан хорьж байгаа тохиолдлыг таслан зогсоох” гэж заасан бөгөөд энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иймд прокурорын байгууллагаас санаачлан холбогдох хууль тогтоомжуудын төсөл саналуудыг нэн даруй гаргаж хууль тогтоох дээд байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Ашигласан эх сурвалж

Нэг. Монгол Улсын хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.
2. Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2015.
3. Монгол Улсын Прокурорын тухай хууль. УБ., 2017.
4. Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2015.

Хоёр. Олон улсын гэрээ, конвенц, тогтоол:

1. Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм. УБ., 1955.
2. Хоригдлуудтай харилцах үндсэн зарчмууд. УБ., 1990.
3. Бүх этгээдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай тунхаглал. УБ., 1975.
4. Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын фактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт 2 дугаар протокол. УБ., 1989.
5. Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын фактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт 2 дугаар протокол. УБ., 1989.

Гурав. Эрдэм, шинжилгээний өгүүлэл, илтгэл:

1. С.Жанцан. Монгол Улсын ялын бодлого ба цаазаар авах ял. Гэмт явдалтай тэмцэх асуудал. УБ., 2010. Дугаар 04.
2. Ц.Очгэрэл. Хугацаагүй хорих ял ба түүнийг эдлүүлэхэд анхаарах зарим асуудал. Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ., 2010. Дугаар 03
3. Л.Бат-Очир, Бүх насаар хорих ялын өнөөгийн байдал, харьцуулсан судалгаа. Цагдаа судлал. УБ., 2019. Дугаар № 01
4. Ц.Мөнхбат. Бүх насаар хорих ялын мөн чанар, эрх зүйн зохицуулалтын зарим анхаарах асуудал. Сүлд инфо. УБ., 2019. Дугаар 03
5. Г.Оюунболд. Бүх насаар хорих ялын онцлог. Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ., 2021.

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫН ҮР НӨЛӨӨГ НЭМЭГДҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

Өвөрхангай аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Г.Цолмонгэрэл

Хураангуй:

Ялын онолд үндэслэн дэлхийн ялын бодлогын чиг хандлага, нийтэд тустай ажил хийлгэх ялын тухай ойлголт, эрх зүйн зохицуулалтыг судалж, Монгол Улсад нийтэд тустай ажил хийлгэх ялыг гүйцэтгэхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлж, ялын үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарах асуудлыг тодорхойлно.

Түлхүүр үгс: Эрүүгийн хариуцлага, ял, ялын онол, нийтэд тустай ажил хийлгэх ял, ял эдлүүлэх ажиллагаа.

Оршил

Ял нь гэмт хэрэгтэй тэмцэх, эрүүгийн эрх зүйн харилцааг зохицуулах чухал арга хэрэгсэл бөгөөд эрүүгийн эрх зүйн үр дагавар, цээрлэлийн шинжээрээ хамгийн хүнд хэлбэрийн хууль зүйн хариуцлага болох эрүүгийн хариуцлагын бие даасан нэгэн төрөл юм¹.

Германы нэрт сэтгэгч И.Кант² ялыг хариу авах гэсэн зорилготой гээд ял нь угтаа нөхөн төлөх эрх гэж тодорхойлсон бол Г.Гегель³ ял бол гэмт этгээдийн эдлэх эрх, иймд айлган сүрдүүлэх, засан хүмүүжүүлэх зорилготой бол үр дүнд хүрэхгүй, гагцхүү зөрчигдсөн эрхийг сэргээх, шударга ёсыг тогтооход оршино⁴. Харин Францын нэрт сэтгэгч Ш.Л.Монтескье⁵ “ял шийтгэлийн шинж чанар нь засаглалын мөн чанараас хамаардаг”, Италийн соён гэгээрүүлэгч Ч.Бекарриа⁶ “ял нь хатуу чангадаа бус түүний гарцаагүйд оршино” гэж үзсэн байдаг⁷.

Энэ мэтчилэн ял шийтгэл түүнд хандах хандлага цаг үетэй холбоотойгоор өөрчлөгдөн шинэчлэгдсээр байна.

¹ Б.Ганболд. Эрүүгийн эрх зүйн мэдлэг. УБ., 2009., 170 дахь тал

² Иммануэл Кант (1724-1804) бол барууны гүн ухааны хамгийн нөлөө бүхий хүмүүсийн нэг гэж тооцогддог Германы гүн ухаантан юм. Кантын бүтээл нь метафизик, эпистемологи, ёс зүй, гоо зүй зэрэг философийн янз бүрийн салбарт гүн гүнзгий нөлөө үзүүлсэн.

³ Георг Вильгельм Фридрих Хегель (1770-1831) бол метафизик, улс төрийн философи, ёс зүй, түүхийн гүн ухаан зэрэг төрөл бүрийн салбарт томоохон хувь нэмэр оруулсан Германы гүн ухаантан юм. Гегелийг барууны гүн ухааны түүхэн дэх хамгийн нөлөө бүхий хүмүүсийн нэг гэж үздэг.

⁴ А.Сьез. Ялын ойлголт, зорилт, үр нөлөө. Эрх зүй. УБ 2001 /6-7/, 146 дахь тал

⁵ Шарль-Луи де Секондат, Барон де Ла Бреде ба де Монтескье, олны дунд Монтескье хэмээн алдаршсан бөгөөд тэрээр 18-р зууны Францын улс төрийн философич, зохиолч юм. 1689 оны 1-р сарын 18-нд Францын Бордо хотод төрсөн Монтескью улс төрийн онол, засаглалын философийн талаар нөлөө бүхий бүтээлүүдээрээ алдартай. Түүний хамгийн алдартай бүтээл бол 1748 онд хэвлэгдсэн "Хуулийн амин сүнс" ("De l'esprit des lois") юм. Монтескью энэхүү гайхамшигт бүтээлдээ төрийн эрх мэдлийг хуваах тогтолцооны талаар шинэ үзэл санааг дэвшүүлсэн.

⁶ Чезаре Беккариа (1738–1794) нь Италийн хуульч, гүн ухаантан, шинэчлэгч байсан бөгөөд криминологи, эрүүгийн эрх зүйн салбарт нөлөө бүхий бүтээлүүдээрээ алдартай. Беккариа нь хууль эрх зүйн тогтолцоо, эрүүгийн хуулийн зарчмуудыг шинэчлэхэд чухал нөлөө үзүүлсэн сэтгэгчдийн нэг гэж тооцогддог. Беккариагийн хамгийн алдартай бүтээл бол 1764 онд хэвлэгдсэн "Гэмт хэрэг ба шийтгэлийн тухай" ("Dei delitti e delle pene") юм.

⁷ Ч.Беккариа. О преступлениях и наказаниях. М., 1939., стр-373

Үндсэн хэсэг

Ял шийтгэлийг онолын талаас авч үзвэл зонхилох 2 онол байх бөгөөд эдгээр онолууд нь нэг нь нөгөөгөө үгүйсгэх замаар хөгжиж ирсэн байдаг. Үүнд:

1. Ялын абсолют онол буюу тэнцвэржүүлэх хандлага /Кант, Гегель/

Энэхүү онол, хандлага нь XIX зууны II хагасаас 1950-аад он хүртэл хүчтэй нөлөөтэй хэвээр байсан бөгөөд гол агуулга нь “Хохирлыг хохирлоор”, “Гэмтнийг гэсгээлээр” гэсэн үндэслэгээ, зарчимд тулгуурлан, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг төрөөс “Хашраах” яллан цээрлүүлэх, үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон ялыг оноох, шаардлагыг хангахад чиглэгдэж байв⁸.

2. Харьцангуйн онол буюу нийгэмшүүлэх хандлага /Ж.Руссо, М.Вебер/

XX зууны II хагасаас эхлэн абсолют онолыг шүүмжлэх хандлага баруун Европт хүчтэй дэлгэрч, ялын зорилго нь ялтныг нийгмээс тусгаарлаж, залхаан цээрлүүлэхэд гол нь биш, харин эргээд нийгмийн амьдралд хөлөө олоход нь туслах, засаж төлөвшүүлэх замаар нийгэмшүүлэхэд чиглэгдэх ёстой гэсэн үзэл баримтлал үүссэн юм. Энэ концепц 1960 оноос эхэлсэн ялын бодлогын шинэчлэлд тусгалаа олж, дэлхийн олон орны эрүүгийн хуулиудад илэрч, хэрэгжсэн байдаг.

Үүнээс үүдэн дэлхийн улс орнуудын ялын бодлогын чиг хандлага нь аливаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг харьцангуй онолын үзэл баримтлалыг баримтлах чиг хандлагатай байна. Энэхүү хандлагын гол үзэл баримтлал нь хүний оюун ухаан, ухамсар, мэдрэмж хөгжихийн хэрээр ял нь зөөлөн, хүний эрхийг хүндэтгэсэн шинж чанартай байх ёстой бөгөөд тухайн этгээдийг нийгмээс тусгаарлаж, тусгай газар хорихоос илүүтэйгээр хорихоос өөр төрлийн ял оногдуулах замаар нийгэмд нь засан хүмүүжүүлэх, төлөвшүүлэх шаардлагатай хэмээн үздэг.

Европын Эрүүгийн эрх зүйн үндэс суурийг тавигч Чезаре Беккариагийн тодорхойлсноор “Ялын зорилго нь тэгэхлээр гэмт этгээдийг дахин бусдад хор уршиг учруулахад саад хийх, бусдыг мөн тийм хэрэг үйлдэхээс сэргийлэхээс өөр юу ч биш. Иймд гэмт хэрэгтний бие махбодод аль болох бага зовлон зүдүүр учруулахын хамтаар сэтгэл санаанд нь аль болох гүн хоногшиж, хүчтэй сэтгэгдэл төрүүлэх ялыг хэрэглэх нь зүйтэй”⁹ гэсэн нь ялын харьцангуй онолын үзэл баримтлалыг дэмжиж буйн илрэл юм. Тиймээс ял нь гэмт хэрэг үйлсэн этгээдийн бие махбод болон сэтгэл зүйг нь залхаан зовоох бус харин тухайн этгээдэд гэм бурууг нь ухамсарлуулж ойлгуулах дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх төлөвшлийг суулгах зорилготой юм.

Дээрх 2 ерөнхий онолоос үүдэлтэйгээр дэлхийн улс гүрнүүд өөрийн орны өвөрмөц шинж чанарыг тусгасан ялын бодлогыг тодорхойлон хэрэгжүүлдэг. Ялын бодлого гэдэг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хүрээнд ялын оновчтой төрөл, хэлбэрийг хуульчлан тогтоон, сонгон хэрэглэх тухай үзэл баримтлал юм.

⁸ Д.Баярсайхан, Ц.Мэргэн. МУ-ын Эрүүгийн эрх зүй дэх эрүүгийн ял ба эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ. Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ., 2016., №4 72 дахь тал

⁹ Ч.Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. 2021 он.47 дахь тал

2007 оны Дэлхийн эрүүгийн загвар хуулийн ерөнхий ангийн 12 дугаар бүлгийг “Ял шийтгэл” гэж нэрлээд ялын зорилгыг ялын зарчим, төрөлтэй нягт уялдуулж, тодорхойлохыг зорьсон байдаг. Тус загварын 34 дүгээр зүйлд ялын үндсэн зорилгыг “...нийгмийн амар тайван, аюулгүй байдлыг хангах, гэмт этгээдийг засан төлөвшүүлэх, гэмт хэргийн хор аюулыг нийгмээс зайлуулах, гэмт хэргийг таслан зогсоох, сэргийлэхэд оршино” гэж тодорхойлжээ¹⁰.

Сүүлийн жилүүдэд дэлхий даяар хорих ялын сөрөг үр дагаврыг улам бүр ойлгож, гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих байгууллагад хорихоос илүүтэйгээр хорихоос өөр төрлийн ялаар цээрлүүлэх, засан хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх арга хэлбэрийг эрэлхийлэх болсны үр дүнд хорихоос өөр төрлийн ялын нэр төрөл улам нэмэгдэх чиг хандлагатай байна.

Хорихоос өөр төрлийн буюу олон улсад “алтернатив ял” гэж нэрлэгддэг ял /alternative penalty/ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, тогтоосон хугацаанд хорихгүйгээр тодорхой эрхийн хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгждэг¹¹.

Энэ төрлийн ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, хамт олон, нийгэмд нь байлгаж, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулан ойлгуулах, өөрийн хөдөлмөрөөр нь учруулсан хохирлыг барагдуулах зорилготой. Хорихоос өөр төрлийн ялын төрөл дундаас нийтэд тустай ажил хийлгэх ялыг эрүүгийн хариуцлагын үр нөлөөтэй арга хэрэгсэлд тооцон, дийлэнх улс орнууд эрүүгийн хууль тогтоомждоо тусган ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлсээр байна.

Энэ нь ялын залхаан цээрлүүлэх шинжээс татгалзаж, гэмт этгээдийг нийгэмшүүлэх, засаж хүмүүжүүлэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх, хорих ялын хэрэглээг хязгаарлаж, хорихоос өөр төрлийн ялыг өргөн хүрээнд хуульчлах шаардлагыг бий болгож байна¹².

Энэхүү үзэл баримтлалаас ял эдлүүлэх ажиллагааны бодлогыг тодорхойлох хэрэгцээ, шаардлага үүсэн бий болно. Ял эдлүүлэх ажиллагааны бодлого нь төрийн эрүүгийн бодлого, ялын ойлголт, шинж чанартай шууд хамааралтай асуудал юм. Ялын бодлого зөв тодорхойлогдсон боловч ял эдлүүлэх ажиллагааны бодлого сайн тодорхойлогдоогүй тохиолдолд ялын зорилго биелэгдэх боломжгүй болж ял үр нөлөөгүй болно. Иймд ялын бодлого, ял эдлүүлэх ажиллагааны бодлого хооронд салшгүй харьяа хамааралтай бөгөөд нэг нь нөгөөгүйгээр оршин тогтнох боломжгүй юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1990 онд Токиогийн дүрэм Non-custodial Measures (the Tokyo Rules)¹³ буюу Хорихоос өөр төрлийн ял хэрэглэхэд баримтлах

¹⁰ Дэлхийн эрүүгийн загвар хууль ба орчин үе эмхэтгэл. УБ., 2013., 13-14 дэх тал

¹¹ Ц.Очгэрэл. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал” Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017., 411 дэх тал

¹² Д.Бадам, С.Батгэрэл. Зорчих эрхийг хязгаарлах ялын эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал. Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ., 2021., №2., 121 дэх тал

¹³ <https://www.ohchr.org/sites/default/files/Documents/ProfessionalInterest/tokyorules.pdf>

The Non-custodial Measures, as articulated in the United Nations Standard Minimum Rules for Non-custodial Measures, known as the Tokyo Rules, embody a paradigm shift within criminal justice systems. Established in 1990, these rules advocate for a nuanced approach to offender management, delineating a spectrum of alternatives to imprisonment. Non-custodial measures enumerated in the Tokyo Rules encompass probation,

наад захын жишиг дүрэм"-ийг баталсан бөгөөд энэ дүрэмд энэ төрлийн ялыг “нийгэмд үйлчлэх ял” гэж нэрлэдэг. Дэлхий дахинд өргөнөөр тархаж буй онцлог ялын нэг болох нийгэмд үйлчлэх ялыг 60 гаруй улс орон эрүүгийн хууль тогтоомждоо бие даасан заалт, бүлэг болгон оруулан хэрэглэж байна. Тухайлбал: Их Британи, АНУ, Франц, Нидерланд, Португали, Норвег, Финлянд, Орос, Швед, Швейцар, Эстони, Испани, Бразил, Литва, Украин, Чех, Унгар, Беларусь, Армени, Мексик, Казахстан, Монгол, Гүрж, Перу, Кени, Люксембург, Киргиз, Тажикстан, Тунис, Уганда, Замби, Зимбабве зэрэг улсууд байна.

Нийгэмд үйлчлэх ялын талаар Францын эрдэмтэн Ж.Парадел “ХХ зууны сүүлийн 10-аад жилд хууль тогтоогчдын бодож боловсруулсан ялын хамгийн шинэлэг хэлбэр гэж үзэж болно” гэж тодорхойлсон байдаг.

Олон улсад нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүмүүсийн гүйцэтгэх ажлын төрөл нь харьяалал, гэмт хэргийн шинж чанар, олон нийтэд тустай үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр зэргээс хамаарч өөр өөр байдлаар тодорхойлогддог.

Энэхүү ял нь ихэвчлэн нийгэмд ашиг тустай байхын зэрэгцээ гэмт хэрэгтнүүдэд хийсэн үйлдлээ засах боломжийг олгох зорилготой байдаг. Дэлхийн ихэнх орнууд энэ төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулахдаа дараах зонхилох 8 төрлийн ажлыг гүйцэтгүүлж байна. Үүнд:

I. Байгаль орчны цэвэрлэгээ

Гэмт этгээдүүд олон нийтийн газар, цэцэрлэгт хүрээлэн, наран шарлагын газар болон бусад байгаль орчинд ээлтэй газрыг цэвэрлэх ажилд оролцох болдог. Үүнд хог хаях, граффити арилгах, мод тарих ажилд оролцох зэрэг хамаарна.

II. Нийтийн байгууламжийн засвар үйлчилгээ

Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээд олон нийтийн барилга байгууламжийг будах, тоглоомын талбайг засах, олон нийтийн төвүүдийн засвар үйлчилгээ зэрэг олон нийтийн газрыг тохижуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэх

III. Ашгийн бус байгууллагын тусламж:

Шийтгэгдсэн этгээдүүдэд өөрсдийн цаг зав, ур чадвараараа ашгийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх боломжийг олгох. Үүнд хүнсний агуулах, хамгаалах байр, буяны байгууллагад ажиллах, захиргааны ажилд туслах, хөрөнгө босгох арга хэмжээг дэмжих зэрэг багтаж болно.

IV. Барилга, засварын төслүүд:

suspended sentences, fines, restitution, community service, and rehabilitative programs. Central to this framework is an emphasis on an individualized sentencing approach, wherein contextual factors such as the nature of the offense and offender characteristics are considered. In alignment with human rights principles, the Tokyo Rules prioritize fair treatment, dignity, and non-discrimination. Moreover, they underscore the pivotal role of community involvement in fostering successful social reintegration and reducing recidivism, thus positioning non-custodial measures as essential components of contemporary criminal justice reform efforts on a global

Зарим тохиолдолд энэ төрлийн ял шийтгүүлсэн ялтнууд хямд үнэтэй орон сууц барих, олон нийтийн дэд бүтцийг засах гэх мэт олон нийтэд ашигтай барилга, засварын төслүүдэд оролцож болно.

V. Ахмад болон залуучуудын хөтөлбөрүүд:

Гэмт этгээдүүд олон нийтийн төв, асрамжийн газарт ахмад настан, залуучуудтай хамтран ажиллаж болно. Үүнд тэдэнтэй ярилцах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, нөхөрлөх, тухайн байгууллагын олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулах, боловсролын хөтөлбөрт туслах зэрэг орно.

VI. Олон нийтийн арга хэмжээ, баяр наадам:

Мөн зарим тохиолдолд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүмүүс олон нийтийн арга хэмжээ, наадам, яармаг зохион байгуулахад хувь нэмрээ оруулах боломжтой байдаг.

VII. Боловсролын хөтөлбөрүүд:

Нийтэд тустай ажил хийлгэх ялын зарим хөтөлбөрүүд нь сурган хүмүүжүүлэх, сургах зэрэг боловсролын үйл ажиллагааг дэмжихэд зориулагдсан байдаг. Гэмт этгээдүүд боловсролын санаачилгыг дэмжих зорилгоор тэдэнд сургууль, номын сан, залуучуудын төвтэй хамтран ажиллах боломжийг олгодог.

VIII. Шударга ёсыг сэргээх хөтөлбөрүүд:

Шударга ёсыг сэргээх хөтөлбөрийн хувьд гэмт хэрэгтэн өөрийн үйлдлээс үүдэлтэй хохирлыг шууд арилгах үйл ажиллагаа явуулж болно. Үүнд хохирогчидтой уулзах, эвлэрүүлэн зуучлах хуралдаанд оролцох, олон нийтийн харилцааг сэргээхэд чиглэсэн хөтөлбөрүүдэд оролцох зэрэг орно. Олон нийтийн үйлчилгээний төрөл нь тухайн хүний ур чадвар, олон нийтийн онцлог хэрэгцээнд нийцсэн байх нь хамгийн чухал байдаг. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь гэмт хэрэгтнийг шийтгэх үр дагаврыг өгөхөөс гадна нийгэмд эергээр нөлөөлөх ач холбогдолтой.

Дээрхээс харахад нийтэд тустай ажил хийлгэх ялыг маш өргөн хүрээнд нийгмийн сайн сайхныг дэмжих зорилгоор зохион байгуулах боломжуудыг илэрхийлж байна. Нэг талаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд түүний учруулсан гэм хорын талаар ойлголтыг дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх ухамсрыг өгөхөөс гадна тэдгээр шийтгэгдсэн этгээдийн мэдлэг, ур чадварыг үнэ төлбөргүйгээр ашиглаж, нийгэмд сайн нөлөөллийг бий болгох замаар гэмт хэрэгтнийг нийгэмшүүлж байгаа нь орчин цагийн хамгийн боловсронгуй эрүүгийн хариуцлагын төрөл байж болох боломжийг харуулж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ” хэмээн тодорхойлсон.¹⁴

Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил

¹⁴ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. УБ. 2016., Төрийн мэдээлэл эмхэтгэл.№07.

хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт 240-720 цагаар тогтооно. Хэрэв ялтан нийтэд тустай ажил хийлгэх ялаас зайлсхийсэн тохиолдолд ялын 8 цагийг ажлын нэг өдөрт тооцож хорих ялаар сольдог.

Эрүүгийн хуульд энэ төрлийн ялыг өсвөр насны хүнд оногдуулж болохоор хуульчилсан бөгөөд “гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх, уг ялыг өдөрт гурваас дээшгүй цагаар нийт 120-360 цагаар гүйцэтгүүлэхээр тогтоосон байна.

Дан ганц нийтэд тустай ажил хийлгэх ялтай гэмт хэрэг Эрүүгийн хуулийн тусгай ангид байхгүй байна. Зөвхөн хорих ба зорчих эрхийг хязгаарлах торгох ялуудтай хамт буюу сонгох санкцын хэлбэрээр тогтоожээ.

Орчин цагт ял нь “хорих болон хорихоос өөр төрлийн ял” гэж зааглагдаж буй хандлага түгээмэл болсон учир нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорихоос өөр төрлийн буюу нийгмээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тусгаарлахгүй шинжтэй ялын тогтолцооны хүрээнд “алтернатив” шинжийг нь харгалзаж, ялын бодлогын хувьд “хүний эрх, энэрэнгүй ёсны зарчимд тулгуурласан, хорих ялаас хөнгөн шинж чанартай” байдалд нь үндэслэж, сонгох санкцын нөхцөлд өргөн хэрэглэх болсон байна¹⁵.

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг зарим эрдэмтэн, судлаачид тодорхойлохдоо: Хуульч Д.Дэмбэрэлцэрэн “гудамж талбай цэвэрлэх, тохижуулах, хог цэвэрлэх, булах, мод сөөг суулгах, арчлах зэрэг ажил багтана”, доктор, профессор Б.Уранцэцэг “нийгэмд ашигтай ажил буюу ялтны хөдөлмөрийн үр дүн нь нийтэд эсхүл, тодорхой нутаг дэвсгэрийн тодорхой бүлгийн хүн ам хүртэж байх ажлыг хэлнэ” гэж тус тус тодорхойлжээ.

Эдгээр тодорхойлолтоос харахад нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгэгдсэн ялтныг нийтийн эрүүл, аюулгүй болон орчны таатай нөхцөл байдлыг бий болгоход чиглэсэн тохижилт бүтээн байгуулалтын шинжтэй ажлыг хийлгэх хэлбэрээр ойлгох ойлголт түгээмэл ажиглагдаж байна.

Уг ялаар шийтгүүлсэн хүнийг нийтийн эрүүл, аюулгүй болон орчны таатай нөхцөл байдлыг бий болгоход чиглэсэн, өөрийнх нь нас, бие, эрүүл мэнд мэргэжилд тохирсон хүмүүнлэгийн чанартай, гамшигт байдал буюу байгалийн давагдашгүй хүчний улмаас бий болсон нөхцөл байдлын хор уршгийг арилгах, бүтээн байгуулалтын шинжтэй ажлыг хийлгэн ялыг эдлүүлж болох юм¹⁶.

Гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд нийцсэн, мөн хуулийн тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор багтсан байх хууль ёсны зарчмыг хангахын зэрэгцээ тухайлан сонгон оногдуулж буй ялын төрөл, түүний хэмжээ нь гэмт хэргийн шинж чанар, хэрэг үйлдэгдсэн тодорхой нөхцөл байдал болон гэмт хэрэгтний хувийн байдалд хамгийн зүй зохистой харьцаагаар нийцсэн байх Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмыг хангасан байх шаардлага давхар тавигддаг болно. Хуулиар тогтоосон эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг чанд баримтлан хэрэгжүүлэхдээ, үүнд

¹⁵ Э.Батбаяр, Б.Ганболд. Хорихоос өөр төрлийн ял. 2023., 98-99 дэх тал

¹⁶ Мөн тэнд 103 дахь тал

хамаарах нийтлэг зарчим нэг бүрийн шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийн цогц нэгдлийг илэрхийлж чадахуйц дүгнэлт хийсний үндсэн дээр оногдуулж буй ял нь шударга ёсны зарчмын агуулга, эрүүгийн хуулийн зорилгод нийцнэ¹⁷.

Ял эдлүүлэх ажиллагаанд ШШГЕГ-ын даргын баталсан “Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгэгдсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалт”-ыг үндэслэн ахлах шийдвэр гүйцэтгэгч нь тухайн ялтны эзэмшсэн мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд зэргийг харгалзан үзэж ажиллах байгууллагыг хуваарилан, тогтоол үйлддэг. Энэхүү жагсаалтад:

1. Авто замын хөгжлийн газар
2. Нийслэлийн газрын алба
3. Боловсролын газар
4. Статистикийн газар
5. Өмчийн харилцааны газар
6. Байгаль орчны газар
7. Соёл урлагийн газар
8. Татварын газар гэх мэт 51 төрлийн төрийн байгууллагуудыг ерөнхийлөн тодорхойлж өгчээ.

Харин тус жагсаалтад байгаа нийт 51 байгууллагуудыг харахад энэ төрлийн ял шийтгэгдсэн хүнийг төрийн өмчийн байгууллагуудад ажиллуулах боломжтой байна.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтныг нийтэд тустай ажил хийлгэх байгууллагыг тогтоох бөгөөд шийдвэр гүйцэтгэгч ажиллуулах байгууллагатай ялтныг нэг өдөрт ажиллах цаг, гүйцэтгэх үүрэг, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын хувцсаар хангах, ажиллах нөхцөлийг урьдчилан тохиролцож, гэрээ байгуулж шүүхийн шийдвэр, ажил хийлгүүлэх тухай мэдэгдлийн хамт нийтэд тустай ажил хийлгэхээр тогтоосон байгууллагад биечлэн хүлээлгэн өгдөг.


Шүүх болон ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс яг ямар төрлийн ажил хийж гүйцэтгэхийг нь тодорхойлж өгөхгүй байгаа нь тухайн ялтныг тохижилт, үйлчилгээний ажлыг хийлгэх үндсэн шалтгаан болж энэхүү ялын “нийтэд тустай байх” мөн чанарыг алдагдуулж байж болзошгүй байна.

¹⁷ Улсын дээд шүүхийн тогтоол. 2019.02.20., №83., Н.А, Д.Б нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай. Танилцуулсан шүүгч Д.Эрдэнэбалсүрэн.

Хүснэгт 1. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт



График 1. Нийтэд тустай ажил хийлгэх ялын 2023 оны хэрэгжилт



Шүүхээс нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн нийт ялтнуудын хүйсийн хувьд 10,8%-ийг эмэгтэйчүүд, 89,2 хувийг эрэгтэйчүүд, насны хувьд өсвөрийн насны хүн 2,3%, 18-39 насны хүн 76,4%, 40-55 насны хүн 21,3% хувийг тус тус эзэлж тэдгээрийн 10-20 хувь нь эзэмшсэн тодорхой мэргэжилтэй, 80-90 хувь нь мэргэжилгүй гэсэн тоо баримт байна¹⁸.

¹⁸ ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба. 2023 оны жилийн эцсийн мэдээ

Зураг 1. Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн этгээдийн нас, хүйсийн байдалд хийсэн харьцуулалт



Дээрх судалгаатай холбогдуулан шийдвэр гүйцэтгэгч нараас зарим асуудлын талаар тодруулахад нийтэд тустай ажил хийлгэх ялыг ихэвчлэн 18-39 насны эрэгтэйчүүдэд оногдуулсан байх бөгөөд эдгээр ялтнуудын 80-90% нь эзэмшсэн мэргэжилгүй байгаа нь тэдгээрийг хотын тохижилт үйлчилгээг хангах ажилд дайчлахад хүргэдэг талаар ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулж буй шийдвэр гүйцэтгэгч нар уулзалт, ярилцлагын үеэр дурдсан байдаг.

Зарим тохиолдолд мэргэжилтэй залуучууд өөрийн эзэмшсэн мэргэжлийн талаар мэдүүлэхээс татгалзах, олон нийтийн газар бохирдсон цаас, хог ачих ажлыг гүйцэтгэх нь тэднийг гутаан доромжилж байгаа мэдрэмжийг төрүүлж байгаа учир энэ төрлийн ажлыг хийж гүйцэтгэхгүй, ял солиулах саналыг албан бусаар ахлах шийдвэр гүйцэтгэгчид илэрхийлж байсан тохиолдлууд цөөнгүй байдаг талаар мөн мэдээлсэн юм. Энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч нар тэдгээрийн ирцийн мэдээллийг үндэслэн хорих ялаар солих саналыг прокурорт хандан гаргаж, шүүхээр шийдвэрлүүлэх зарчмаар шийдэж ирсэн байна.

График 2. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорих ялаар сольсон 3 жилийн дундаж үзүүлэлт



Энэ мэтчилэн нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтнууд ийнхүү ял эдлүүлэх ажиллагааг хүний ялгандас бүхий бохирдсон цаас цэвэрлүүлэх, ачих хэлбэрээр зохион байгуулж байгааг эсэргүүцэн хуваарилагдсан ажилдаа гарахгүй байх, ял эдлэхээс зайлсхийж, уг ялыг хорих ялаар солих тохиолдол жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Үүний шалтгаан нөхцөл нь энэ ялаар шийтгэгдсэн этгээд нь өөрийгөө ялтан хэмээн дуудуулахаас ичдэг, мөн өөрийн ур чадвар, эзэмшсэн мэргэжилдээ тохирсон ажил хийдэггүй, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын уялдаа холбоо, ял эдлүүлэх ажиллагааны зохион байгуулалт муу мөн нөгөө талаас тухайн ялаар шийтгэгдсэн этгээдэд энэ ялын тухай ойлголт дутуу дулимаг байгаатай холбоотой байна.

Эрүүгийн хариуцлага нь өөрөө гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх зорилготой атлаа энэ мэтчилэн гутаан доромжилсон агуулгатай байж хэрхэвч болохгүй юм.

Мөн нөгөө талаас нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгэгдсэн этгээдийг олон нийтийн дунд оруулан сургуулийн цагдаа, сувилагч, тогооч, үйлчлэгч, мужаан гэх мэт олон төрлийн ажлыг хийлгэх боломжтой байдлаар эрүүгийн хуульд хуульчилсан боловч нийгэм тэр дундаа олон нийтийн ялтанд хандах хандлага муу байгаатай холбогдуулан энэ төрлийн ажил гүйцэтгэхэд хамгийн том хүндрэлийг бий болгож байна.

Учир нь тухайн этгээдийг нийгэм гэмт хэрэгтэн тэр дундаа онц ноцтой гэмт хэрэгтний түвшинд үзэж хүлээн авдаг тул тэдний мэргэжлээрээ ажиллаж, үйлдсэн гэмт хэрэгтээ гэмших, ухаарах боломжийг тэр бүр олгохгүй байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь нийгмийн бүтээн байгуулалт, нийгмийн сайн сайхан, хөгжил дэвшилтэд ихээхэн хувь нэмэр оруулах боломжтой ялын томьёолол билээ. Тиймээс нэг талаас ялтнууд өөрсдийгөө ялаар шийтгэгдэж байна гэж ойлгохоос илүүтэйгээр нийгмийн сайн сайхны төлөө өөрийн хувь нэмрээ оруулж байна хэмээх ухамсрыг төлөвшүүлэх, нөгөө талаас ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих эрх бүхий албан тушаалтан болон ажил олгогч байгууллага олон нийтэд энэ төрлийн ялын үр нөлөө, энэ ялаар шийтгэгдсэн этгээдийн онцлогийг таниулах, нөлөөлөх ажлыг цогцоор нь зохион байгуулах нэн шаардлагатай байна.

Дүгнэлт

Дэлхий нийтээр нийтэд тустай ажил хийлгэх ялыг маш өргөн хүрээнд нийгмийн сайн сайхныг дэмжих зорилгоор зохион байгуулах боломжуудыг эрэлхийлэн ажиллаж байна.

Энэхүү ял нь нэг талаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд түүний учруулсан гэм хорын талаар ойлголтыг дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх ухамсрын хамт өгөхөөс гадна тэдгээр шийтгэгдсэн этгээдийн мэдлэг, ур чадварыг үнэ төлбөргүйгээр ашиглах замаар нийгэмд сайн нөлөөллийг бий болгож байгаа нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлж байгаа орчин цагийн хамгийн боловсронгуй эрүүгийн хариуцлагын төрөл байж болох боломжийг харуулж байна

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь эрүүгийн хариуцлагын бусад төрөлтэй харьцуулахад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулж болох хамгийн хөнгөн, өөрийн үндсэн ажлаа хийж, гэр бүлээ тэжээн тэтгэх үүргээ гүйцэтгэхийн хамт биелүүлж болох хүмүүнлэг зарчим, хүнлэг ёсны хандлагад тулгуурласан нийгэмд сайн нөлөөллийг бий болгох замаар хэрэгждэг зэрэг ашигтай шинжээрээ ялгардаг үндсэн ял юм.

Гэвч ял эдлүүлэх ажиллагааны дүн мэдээнээс харахад уг ял нь зорилгоо хангаж чадахгүй байгаа нь нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөөг бууруулж байгаа нь анхаарах ёстой асуудал болж байна.

Тиймээс энэхүү ялын үр нөлөөг дээшлүүлэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс энэхүү ялын тухай ойлголтыг нийгэмд зөвөөр таниулах нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлж, хууль хяналтын байгууллага, олон нийтийг энэ төрлийн ялыг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллах боломжуудыг нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулан ажиллах шаардлагатай байгаа юм.

Үүнтэй холбоотойгоор дараах цөөн хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ажил олгогч байгууллагад болон олон нийтэд нийтэд тустай ажил хийлгэх ялын ач холбогдлыг таниулах ажлыг бодлого боловсруулан үе шаттайгаар зохион байгуулах;

2. “Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгэгдсэн ялтныг ажиллуулахдаа түүний мэргэжил, ур чадварыг харгалзан тохирох ажлын байранд хуваарилна” гэсэн зүйл заалтыг практикт бодитойгоор хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хамтран ажиллах байгууллагын цар хүрээг нэмэгдүүлэх;

3. Монгол Улсын хөгжил цэцэглэлтэд ихээхэн хувь нэмэр болохуйц байгалийн тэнцэл алдагдаж, цөлжилт нэмэгдэж байгаа энэ цаг үед мод тарих ажлыг шүүхээс шууд оногдуулах эсвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага энэ төрлийн ажлыг

гүйцэтгүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх нь ялтны эрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой.

Ашигласан эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992., №01
2. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2016 №07
3. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2002., №05
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №26
5. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги., 2002 он
6. Ч.Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. УБ., 2021 он
7. Д.Баярсайхан.,Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012 он
8. Б.Ганболд. Эрүүгийн эрх зүйн мэдлэг. УБ., 2009 он.
9. Ч.Беккариа. О преступлениях и наказаниях. М., 1939 года
- 10.Э.Батбаяр, Б.Ганболд. Хорихоос өөр төрлийн ял. УБ., 2023 он
- 11.А.Съез. Ялын ойлголт, зорилт, үр нөлөө. Эрх зүй. УБ., 2001 он
- 12.Д.Баярсайхан, Ц.Мэргэн. МУ-ын Эрүүгийн эрх зүй дэх эрүүгийн ял ба эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ. Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ., 2016. №4
- 13.Д.Бадам, С.Батгэрэл. Зорчих эрхийг хязгаарлах ялын эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал. Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ., 2021. №2.
- 14.Дэлхийн эрүүгийн загвар хууль ба орчин үе эмхэтгэл. УБ., 2013 он
- 15.Ц.Очгэрэл. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал” Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017 он
- 16.ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба. 2023 оны жилийн эцсийн мэдээ
- 17.Улсын дээд шүүхийн тогтоол. Н.А, Д.Б нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай. УБ., 2019.02.20. №83

ХОРИХ ЯЛ ЭДЛЭХ ХУГАЦАА ДУУСАЖ СУЛЛАГДАХ ДӨХСӨН, ЭСХҮЛ ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНААС ӨМНӨ СУЛЛАЖ, ХЯНАЛТ ТОГТООХ ХУУЛИЙН ШААРДЛАГА ХАНГАСАН ХОРИГДЛЫГ НИЙГЭМШҮҮЛЭХ ТУСГАЙ БАЙРЫГ ХОРИХ АНГИД БИЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Ховд аймгийн Прокурорын газрын ахлах прокурор М.Берикбол

Хураангуй:

Монгол Улсын өнөөгийн эрүүгийн ялын бодлого, үзэл баримтлалыг хэрэгжүүлж буй нэг үндсэн асуудал нь хорих ял шийтгэгдсэн этгээдийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажиллагаа юм.

Монгол Улсад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 219 дүгээр зүйлд заасан “хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан зүйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр” гэсэн заалтын хүрээнд Хорих байгууллага нь хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг хэрэгжүүлж байна.

Хорих анги нь нийгэмшүүлэх ажлыг хөдөлмөрийн дадал олгох, мэдлэг боловсрол олгох, дээшлүүлэх чиглэлийн сургалттай хослуулах хэлбэрээр зохион байгуулж ирсэн боловч хорих ялын хугацаа нь дөхсөн, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдах хуулийн шаардлага хангасан хоригдлуудад чиглэсэн нийгэмшүүлэх ажил нь нийгмийн хөгжлийн хурд, ажлын байрны шалгуур, хувь хүний төлөвшил, нийгэмд эзлэх байр суурь, нийгэмшсэн байдал зэрэг шаардлагуудыг бүрэн хангахааргүй байна.

Иймд хорих ангид 2 жилээс дээш хугацаанд ял эдлээд суллагдах дөхсөн, эсхүл хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах хуулийн шаардлагыг хангасан хоригдлуудыг нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн бэлтгэл, дадал, нийгмийн хөгжлийн талаарх мэдээлэл өгөх зорилгоор тусгай байрыг хорих ангийн дэргэд шинээр бий болгохтой холбоотой хууль, журамд өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага гарч байна гэж үзлээ.

Энэхүү илтгэлээр тусгай байрыг хэрхэн шийдвэрлэх арга зам, ололт болон гарах үр дүн, цаашид хэрэгжүүлэх санал боловсруулах талаар танилцуулах болно.

Түлхүүр үгс:

Хоригдлуудыг нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн бэлтгэл, дадал, нийгмийн хөгжлийн талаарх мэдээлэл өгөх зорилгоор тусгай байрыг хорих ангийн дэргэд шинээр бий болгох.

Удиртгал

Хүн бүр нийгмийн амьдралд оролцон, мэдлэг боловсролоо дээшлүүлж, өөрийгөө хөгжүүлэн төлөвшиж, зохицон амьдрах чадвар эзэмших нь нийгэмшлийн гол суурь нь болж явдаг.

Нийгэмшлийн тухай ойлголтын талаар хуульчид, судлаачид харилцан адилгүй байдлаар тодорхойлсон ба нийгэмшил буюу нийгэмшихүй гэсэн ухагдахуун нь орос

хэлний социализация, англи хэлний socialization гэсэн үгний орчуулга бөгөөд тайлбар толь болон эрдэмтэн, судлаачид дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал:

Хууль зүйн толь бичиг, мэргэжлийн судалгааны бусад бүтээлд¹: -“социализация” буюу “нийгэмших”, “нийгэмшүүлэх” гэсэн нэр томьёо нь хүмүүний нийтлэг үнэт зүйлс, ёс суртахуун, аж байдал, эрх зүйн дэг журмыг хүндэтгэн сахиж, зохицож амьдрах, түүнд хэвшүүлэх ухамсарт үйл явц, зорилго чиглэл бүхий үйл ажиллагаа, түүний үр дүн;

-харин эдгээр үнэт зүйлс, журмыг үл ойшоон, санаатайгаар зөрчсөн гэм буруутай хүмүүнийг ухааруулан ойлгуулах (ухамсарлуулах), сөрөг зан байдал, харьцаа, амьдралын хэв маяг, сэтгэхүй, сэтгэлгээг нь өөрчлөн засан төлөвшүүлэх үйл ажиллагааг “ресоциализация”,¹

-зан байдал, сэтгэхүй, үг хэллэг, амьдралын гажуудал-эвдрэл, хэв маягийг нь засан өөрчлөх үйл ажиллагааг “коррекция”, “исправление”²

-иргэний, чөлөөт нийгэмд дасан зохицож, хариуцлагаа хүлээн, ухамсарлах, бие даан амьдрах дадал хэвшил, чадварт сургахыг “адаптация” (адаптирование)² гэж томьёолон тодорхойлсон байна.

Мөн эрдэмтэн А.Гиндденс “Нийгэмшил гэдэг нь тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд өөрийн ухамсар бүхий ухаант амьтан болон хувирч, төрж өссөн соёлынхоо мөн чанарыг ойлгох явц, зарим нөхцөл байдалд насанд хүрсэн хүмүүс дахин нийгэмшилд орж болно, өөрөөр хэлбэл урьд өмнө тогтсон үнэт зүйлс, бие хүний зан үйлийн загвараа өөрчилж өмнөхөөс эрс ялгаатай үнэт зүйлсийг эзэмших нь буй. Хүмүүсийн үнэт зүйлс, ертөнцийг үзэх үзэл нь яг нэг хивэндээ байдаггүй, амьдралын бүхийн л мөчлөгийн туршид хуримтлуулсан туршлагатайгаа хамт хувиран өөрчлөгдөнө”³ гэж тодорхойлсон байна.

Насанд хүрсэн хүнд төрж өссөн соёлоос гадна нийгмийн шинэ харилцаанд орж нийгэм, орчны нөлөөлөл, хүчин зүйлийн улмаас эерэг болон сөрөг ухамсар төлөвшиж, амьдралын хэв маяг болж хувиран, улмаар гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлэхэд хүргэдэг.

Хорих ангиас нийгэмшүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж байгаа хэдий ч нийгмийн харилцаанд ороогүй хоригдлыг зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулсан гэж дүгнэх нь учир дутагдалтай.

Тусгай байранд нийгэмшсэнээр хоригдлын сэтгэхүйд эрх зүйн буюу эерэг зан зүйлд зохицож амьдрахад нь туслах, дэмжих, төлөвшүүлэх, хоригдлын эрх, эрх чөлөөг хангаж, чадавхжуулахад чиглэсэн, практикт суурилсан цогц ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм. Энэхүү ажиллагааг хэрэгжүүлэхэд нийгмийн шударга ёс, хүний эрх, хамтын хариуцлага, хоригдлын ялгаатай байдлыг хүндэтгэн үзэх нь чухал.

Энэ нь тухайн аймаг, хот, орон нутгийн уугуул соёлын мэдлэгт суурилах замаар хүмүүсийн амьдралд тулгарч буй сорилт бэрхшээлүүдийг даван туулах, эрх зүйн байдлыг дээшлүүлэхэд туслах зорилготой юм.

¹ С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” нэмж засварласан 2 дахь хэвлэл, УБ. 2008;

² Н.Гантулга. Ялсны өөрчлөн нийгэмшүүлэх ажиллагаан дахь хамтын оролцоо. УБ. 2015,

³ А.Гиндденс. Социологи.УБ.2006 он.

Монгол Улсын хорих байгууллагын хоригдлыг нийгэмшүүлэх түүхэн замналыг судалж үзвэл:

1921 оны долоодугаар сард Ардын Намын Төв Хороо, Түр Засгийн газрын хамтарсан хуралдаанаар Шүүх Яамны ерөнхий хэлтсийн дэргэдэх “Гяндан хороо” нэртэй хороог байгуулснаар Хорих байгууллага байгуулагдах суурь тавигдсан байна.

1924 оны 11 дүгээр сард Улсын анхдугаар их хуралдаанаар тус улсыг “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” гэж тунхаглан анхдугаар Үндсэн хуулийг батлан, 1925 оны 11 дүгээр сард хуралдсан хоёрдугаар их хуралдаанаар шүүн таслах эрхийг шинэтгэн явуулах тухай тогтоол гаргаж, “Хэрэгтэн хүнийг шийтгэх ял, улс төрийн бодлого бол хэрэгтнийг сурган хүмүүжүүлэхийг гол болгох, оногдуулах ял нь хууль зүйд нийцсэн, хэрэгтэн этгээдийг засрах бололцоо олгосон хөдөлмөр хийлгэх, цаг хугацаа дуусахын өмнө тэнсэн суллах зэргийг оролцуулсан байвал зохино”⁴ гэж заасан нь хоригдлыг нийгэмшүүлэх ажлын эхлэл нь тавигдаж улмаар хоригдлыг нийгэмшүүлэхдээ улсынхаа бодлогод тулгуурлан сурган хүмүүжилдэг, засрах бололцоо олгосон хөдөлмөр эрхлүүлж, хүнийг хөдөлмөр хүмүүжилдэг гэсэн үзэл санаагаар ял шийтгэлд нь тохирсон хөдөлмөр хийлгэдэг байсан нь хоригдлыг сурган хүмүүжилдэг хэлбэрийн нэг болжээ.

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар хуралдаанаар “Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн, ялтныг засан сайжруулах ажлын тухай” хууль батлагдаж “...хоригдогсдыг эрхбиш аливаа боловсролын ажилд оролцуулан сургаж, тэдгээрээс алсдаа ажлын дадлагыг олж, суллагдан дараа гарсны хойно ард олонд тустай ажил үйлдвэр хийж, гэмт явдлыг үйлдэх хэв заншлаа устгахад дөхөм болгохыг хичээнэ”⁵ гэж заасан нь хоригдол суллагдсаны дараа одоогийн 2015 оны эрүүгийн хуульд заасан хорихоос өөр төрлийн ял болох нийтэд тустай ажил хийлгэх ялыг засран хүмүүжилдэг арга хэрэгслээр ашиглаж иржээ. Нөгөө талаас *ажиллах* хүчний эрэлтийн хэмжээг тодорхойлох, хүний нөөц бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.

Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1966 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар зарлигаар Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд “...Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийн зорилт нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ялыг хууль ёсоор эдлүүлж, тэднийг хууль ёсыг хүндэтгэн сахиж, социалист нийгмийн амьдрал, хөдөлмөрт хэвшүүлэн дахин хүмүүжүүлэх, тэднээс шинээр гэмт хэрэг үйлдэх буюу нийгэмд хортойгоор нөлөөлөх явдлаас урьдчилан сэргийлэхэд оршино”⁶ гэж зорилгыг тодорхойлсон нь социалист нийгмийн амьдралын үзэл санаанд тулгуурлаж, тэднийг нийгмийн тустай хөдөлмөрт заавал оролцуулдаг, бага болон суурь боловсролд нийтээрээ суралцаагүй, соён гэгээрүүлэх ажлын суурь нь тавигдаж байсан үе гэж ойлгож болно.

1993 оны 12 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хуулийг баталж, “Хүмүүжлийн ажил нь хоригдлыг үйлдсэн гэмт хэрэгт нь гэмшүүлж, түүний нийгмийн хор аюулыг ойлгуулах, хорих ялын зорилгыг

⁴ Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагаа.УБ.,2018

⁵ Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ.УБ.,2020 он,

⁶ А.Лхагва, Д.Даваа-Очир. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ., 2011

хангахад чиглэгдэнэ. Хүмүүжлийн ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон хувийн байдал, нас хүйс, ял эдлүүлэх дэглэмийг харгалзан ялгамжтай явуулна”⁷ тодорхойлж, үйлдсэн гэмт хэрэг, нийгмийн хор аюулын шинжид тохирсон ажил арга хэмжээг тодорхойлсон байна. Энэ нь ардчилсан нийгэмд суурилагдсан хууль тогтоомж болсон гэх утгаар бусад хуулиудаас онцлогтой болсон.

1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Шүүхийн шийдвэр биелүүлэх хуулийг батлан гаргасан, нийгмийн ажлын тодорхойлолт нь өмнөх хуультай адилхан байдлаар тодорхойлогдсон байна.

Харин 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт, эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах”-аар заасан бол 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад “хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан зүйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр” нийгэмшүүлэх ажлыг тодорхойлон оруулж өгчээ.

Энэ удаагийн хуулийнд “...ур чадвар, ...хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан зүйлд төлөвшүүлэх” гэсэн тодорхойлолтыг нэмж тусгасан нь хүний эрхийг хангах, хоригдлын үзэл бодол, хүсэл сонирхлыг хүндэтгэж, эрхийг хангаж байгаа нэг хэлбэр болсон гэж үзэхээр байна.

Урьд урьдын хуулиудад зөвхөн хөдөлмөрлөх, сурган хүмүүжүүлэх гэсэн хэлбэрээр нийгэмшүүлж, хоригдлын санаа бодол, хүсэл эрмэлзлээс үл хамаардаг байсан бол шинэ хуульд хоригдлын ур чадварыг үнэлэх, хүсэл сонирхлыг хүндэтгэж, түүнд тохирсон нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахаар хуульчилсан нь дэвшилттэй тал болсон.

Нэгдсэн Үндэсний байгууллагаас хоригдлыг нийгэмшүүлэх талаар баримталж буй бодлого болон зарим гадаад улсын сайн туршлагыг судалж үзвэл:

Нэгдсэн Үндэсний байгууллагын Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/111 дүгээр тогтоолын 10 дахь заалтад: Хорих ял эдэлсэн хүмүүс олон нийтийн болон нийгмийн байгууллагуудын оролцоо, тусламжтайгаар, хохирогчийн ашиг сонирхлыг хохироохгүйгээр аль болох зохистой байдлаар **нийгмийн амьдралд эргэн орох таатай нөхцөлийг бий болговол зохино**”⁷ гэж заасан нь хоригдлыг хорих ял эдэлж дуусахад нийгмийн амьдралд эргэн орох бэлтгэл ажил хангагдсан, сургалт хүмүүжил, сэтгэл зүй, харилцаа хандлага, хууль эрх зүйн хувьд төлөвшсөн байх шаардлагыг тавьж байна.

Оросын Холбооны Улсын хорих байгууллагын сайн туршлагаас: -Ялтны суллагдсаны дараах нийгэмд дасан зохицох явдлыг хангаж, давтан гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр удаан хугацааны хорих ял эдлээд дуусаж

⁷ Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ.УБ.,2020 он,

байгаа этгээдэд нийгмийн өөрчлөлтийн тухай бүхий л мэдээллийг багтаасан тусгай дасгалжилт, хөтөлбөр боловсруулан хамруулах, амьдрах орчинтойгоо танилцах боломж олгосон **суурин хэлбэрийн хорих газарт шилжүүлэх**, ялтныг нийгмийн амьдралд дасгах албаар /probation/ дамжуулан зохих нөхцөлийг бүрдүүлэх зэрэг эерэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг байна.

Герман Улсын сайн туршлагаас: Хаалттай хорих ангид ялынхаа 2/3-ыг эдэлсэн, зөрчил гаргаагүй хоригдлыг хорих ангийн холбогдох албан хаагчдын тодорхойлолтыг үндэслэн суллагдахад нь бэлтгэх зорилгоор нээлттэй хорих анги руу шилжүүлж, хоригдлыг нийгэмшүүлэх, чөлөөт амьдралд дасгах, бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулдаг ба хорих байгууллагын захиргаа, нийгмийн ажилтнууд хөдөлмөрийн биржтэй нягт хамтран ажилладаг байна.⁸

Энэ нь манай улсын хоригдлын дэглэм, зэрэглэл өөрчлөх, хугацаанаас өмнө тэнсэн суллах эрх зүйн зохицуулалттай төстэй байна.

Америк Улсын сайн туршлагаас:” 1.Дээд зэргийн харуул хамгаалалтай шорон, Дунд зэргийн харуул хамгаалалтай шорон.

Сул харуул хамгаалалттай шорон. Энэ зэрэглэлийн шорон нь хашаагаар хүрээлэгдсэн, зэвсэглэсэн харуулын постгүй, дохиолол, камерын тусламжтайгаар хашаан доторх орчноо хянаж байдаг. Шоронгийн бас нэг төрөл байдаг нь /open prison/буюу задгай шорон юм. Задгай шоронгууд нь хүрээлэн байгаа орчноо аюулгүй байдлаа хангах хэрэгсэл болгон ашигладаг байна.

Франц Улсын хувьд: Засрах найдлагатай, засрахад эргэлзээтэй, засрахгүй гэсэн ангилалд хуваан ялыг эдлүүлдэг. Засрах найдлагатай ялтнуудыг өдрийн цагаар нийтээр нь ажиллуулж, орой нь тэднийг тусгаарладаг. Ийм ялтан нь гадуур ажил эрхлэх зэрэг нэлээд хөнгөлөлтийг эдэлдэг. Түүнчлэн хагас чөлөөтэй дэглэмд хөдөлмөрлүүлэхээр шилжүүлж, үлгэр жишээч сахилга батын төлөө гэсэн нөхцөлөөр суллах дэвшилтэт систем үйлчилдэг бөгөөд итгэл дааж буй ялтныг хугацаанаас нь өмнө суллах асуудлыг хорих анги өөрөө бие дааж шийддэг байна. Засрахад эргэлзээтэй, засрахгүй ялтны хувьд хязгаарлагдмал эрхийг эдлэх бөгөөд ял эдлүүлэх асуудлыг тусгай шүүгч хариуцаж хугацаанаас нь өмнө суллах, ялын хугацааг богиносгох хүртэл эрхийг эдэлдэг. Уг дэглэмийн ялтнууд хүмүүжилтэй, ял эдлэх явцдаа ямар нэг зөрчил гаргаагүй бол засрах найдлагатай буюу дээд, илүү нээлттэй дэглэмд шилжүүлж болдог онцлогтой байна.⁹

Үндсэн хэсэг

“Нийгмийн амьдралд эргэн орох байр” гэж юу вэ?

Удаан хугацааны турш хорих ял эдлээд дуусаж байгаа хоригдолд нийгмийн хөгжлийн хурд, ажлын байрны шалгуур, хувь хүний төлөвшил, нийгэмд эзлэх байр суурь, нийгэмшсэн байдал зэргийг багтаасан тусгай хөтөлбөр бүхий амьдрах орчинтойгоо танилцах буюу “Нийгмийн амьдралд эргэн орох” байрт шилжүүлэн дахин

⁸ О.Пүрэвсүрэн. Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2014

⁹ Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ.УБ.2020 он,

алдаа дутагдал гаргаж, гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилготой сэтгэл зүй, нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан тусгай байр юм.

Энэ нь гадаад улсын сайн туршлагад суурилагдсан ба Америкийн нэгдсэн улсад өнөө цагт “Halfway house” нэртэйгээр хоригдлыг нийгэмшүүлж байгаа бол Франц улсад “илүү нээлттэй” харуул хамгаалалтгүй хорих анги гэсэн нэршлээр хэрэгжиж байна.

Харин Холбооны Герман улсад “чөлөөт амьдралд дасгах, бэлтгэх үйл ажиллагаа” гэсэн нэршлээр хэрэгжиж, ажилчдын хүний нөөцийн зарим хэсгийг хорих ангиас бэлтгэн гаргадаг онцлогтой байна.

Манай улсын хувьд нээлттэй, хаалттай хорих ангийн дэглэм, зэрэглэлээр ангилж, хоорондоо зөвхөн түр удаан хугацааны уулзалт, утсаар ярих эрх, эргэлт илгээмжийн тоогоор ялгаатай, нийгэмшүүлэх чиглэлээр хийж буй ажил, арга хэмжээ нь хоорондоо ижил түвшинд байгаа нь учир дутагдалтай байна.

Энэхүү байрыг Хорих ангийн дэргэд байгуулж, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлснээр хорих ял эдлүүлэх ажиллагаа, хоригдлыг нийгэмшүүлэх ажиллагаанд шинэ хөгжил дэвшил авчирна гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна.

Иймд хоригдлын нийгэмшүүлэх ажлыг тогтсон арга барил, хэвшмэл зан заншлаас салж, хөгжлийн шинэ шатанд гаргах цаг нь болсон гэж үзэж байна.

Хэрэгцээ шаардлага:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2017 онд гаргасан “Рецидив” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх судалгаагаар нийт хорих ял эдэлж байгаа хүмүүсийн 50.4 хувь нь хоёр буюу түүнээс дээш удаа хорих ялаар шийтгүүлсэн, түүнчлэн суллагдсан хүмүүсийн 47 орчим хувь нь дахин гэмт хэрэгт холбогддог гэсэн судалгаа гарсан байна. Олон улсын байгууллагаас гаргасан статистик судалгаагаар манай улсыг 100,000 хүн тутамд дунджаар 110-120 хүн хорих ял шийтгүүлж байгаа гэсэн судалгаа байдаг.¹⁰

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээллээр өнөөдрийн байдлаар 4526 хоригдол хорих ял эдэлж байна. Үүнээс 4211 эрэгтэй, 279 эмэгтэй, насанд хүрээгүй 36 хүүхэд хорих ял эдэлж байгаа бол анх удаа ял шийтгүүлсэн 2040, дахин гэмт хэрэг үйлдсэн 2486 ялтан байна. Үүний өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн 1594, эдийн засгийн гэмт хэрэг 32, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 79, Олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 137, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 441, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 1053 хоригдол ял эдэлж байна¹¹. Үүнээс үзэхэд 2017 оны дахин гэмт хэрэг үйлдсэн нийт хоригдлын 50.4 хувь байсан бол 2023 оны байдлаар 54.9 хувь болж 4.5 хувиар өссөн үзүүлэлттэй ба өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлж байна.

Дэлхийн нийтээр хурдтай хөгжиж буй өнөө цагт хүн болгон дор бүрнээ хичээж, бусадтай хөл нийлүүлэн хамт алхахгүй бол хөгжлийн хоцрогдолд орж нийгэм, соёл, эрүүл мэнд, эдийн засаг, технологийн дэвшил зэргээс хоцрон үлдэх, эдийн засгийн

¹⁰ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2017 оны рецидив судалгаа.

¹¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик судалгаа 2024 он

хямралд өртөх, улмаар идэвхтэй амьдралын хэв маяг алдагдах, амьдрах хүсэл эрмэлзэлгүй болох эрсдэлт нөхцөл байдал өдөр тутам тохиолдож байна.

Хорих ял эдэлж байгаа хэдий ч улсын төсвөөс хоол идэж, улсын хангамжаар хэдэн жил амьдарсан, бэлэнчлэх сэтгэлгээтэй болсон хүмүүсийг шууд нийгмийн амьдралд гаргахад эдийн засгийн хувьд хүндрэлтэй, ажил олгогч байгууллагын шалгуур, шаардлагад нийцэхгүй, хэсэг хугацааны дараа нөгөө амар хялбар аргаар мөнгө олох замд эргэн орох магадлал өндөр байдаг.

Эрхээ хязгаарлуулж, хорих ангийн дотоод журам, захирагдах ёсны хэв маягт дассан хүмүүсийг өөртөө итгэх илтгэлийг олж авах, өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх, ухамсарлах, аливаа шийдвэрийг зөв оновчтой бие даан гаргахад суралцуулах хэрэгцээ шаардлага гарч байна.

Хорих байгууллагаас хөдөлмөрлөх, дадал олгох сургалтуудад хамрагдаж, ангийн үйлдвэрлэлд ажиллаж мэргэжил эзэмшиж, ур чадвартай болж гарсан хэдий ч түүнийг амьдралд хэрхэн хэрэгжүүлж, өөрийгөө болон гэр бүлээ тэжээн тэтгэх менежментийг олоогүйн улмаас амьдралд хэрэгжүүлж чаддаггүй байна.

Энэхүү байранд байрлаж байх хугацаанд гадуур ажил эрхлэх зэрэг тодорхой хөнгөлөлтийг эдлүүлж, хорих ангийн үйлдвэрлэлээс сурсан, мэдсэн зүйлийг амьдралд хэрэгжүүлж, хийсэн эд зүйлийг зах зээлд нийлүүлэх, зарж борлуулахад нь туслах дэмжих зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой.

Нөгөө талаас “Нийгмийн амьдралд эргэн орох байр”-нд байрлуулснаар тухайн хоригдлын хэрхэн нийгэмшиж засран хүмүүжсэн, эерэг зан үйлд төлөвшсөн байдал зэрэгт дүн шинжилгээ хийж, хугацаанаас өмнө тэнсэн суллах асуудлыг тодорхойлох нөхцөл боломж бүрдэнэ.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 2.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан болгоомжгүй хэлбэрээр гэмт хэрэгт үйлдсэн хүмүүсийг зарим тохиолдолд тусад нь хорих ял эдлүүлэх нь зүйтэй гэж үздэг мэргэжилтэн, судлаачид байдаг. Учир нь удаа дараа санаатай гэмт хэрэг үйлдэж шийтгэгдсэн хүмүүстэй хамт байлгах нь нөлөөллийн хувьд сөрөг нөлөө үзүүлж, орчны буруу үлгэр дуурайлалд автаж, сөрөг зан байдал, харьцаа, амьдралын хэв маяг, сэтгэхүй, сэтгэлгээ төлөвших эрсдэлтэй. Болгоомжгүй гэмт хэрэг үйлдэж, хорих ялаар шийтгүүлсэн хоригдлыг санаатай, дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудтай хамт хорих нь хэр оновчтой гэдгийг давхар судлах шаардлагатай болохыг дурдах нь зүйтэй.

“Хоригдлыг нийгмийн харилцаанд дасгах” байр нь хоригдлын эрхийг хамгаалахад ямар шалтгаант холбоотой вэ?

1. Хорих ангиас суллагдсан хүмүүст ажлын байрын хаалга, үүд хаалттай байдаг. Төрийн албаны тухай хуульд төрийн жинхэнэ албан тушаалтанд тавигдах ерөнхий шаардлагад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй” гэж тодорхойлсон ба үүнийг ихэнх байгууллагуудын дотоод журамд оруулах хэлбэрээр төрийн үйлчилгээний албан тушаалтны ажилд ороход харгалзах шалгуур болгож, хууль, журмаас давсан шалгуур тавьж, хорих ял шийтгүүлсэн хүмүүст ажил олгохоос татгалздаг байна.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.7-т "ажил олоход хүндрэлтэй иргэн" гэж ...хорих ангиас суллагдсан ...иргэнийг,

-15.1.2-т "...хорих ангиас суллагдсан иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн ажиллуулж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг ажилтан, ажил олгогч тус бүрд нь нэг удаа олгох,

-15.1.5-т "...хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулах"

-Мөн хуулийн 31.4-т "...хорих ангиас суллагдсан иргэний талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас тухай бүр харьяалах аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэж, уг байгууллага иргэний хүсэлтийн дагуу бүртгэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамруулна",

-Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5-т "Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно", 13.5.3. "хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн" гэсэн хоригдлыг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн хуулиудын хэрэгжилт төдийлөн хангагдахгүй байгаа бөгөөд энэ талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаарх мэдээ, мэдээлэл хомс байна.

3. Харилцаа, хандлага, өөртөө итгэх итгэлийг бий болгох, бусдад өөрийгөө илэрхийлэх чадвар сул байгаа байдал хорих ангиас суллагдсаны дараа ажилд ороход том саад бэрхшээл болдог.

4. Ажил олоход хүндрэлтэй иргэний статустай тул дахин гэмт хэрэг үйлдэх санаа зорилго, сэдэлт дахин төрөх эрсдэл бий болдог.

5. Хөдөлмөрийг дэмжих үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 01 дугаартай хөтөлбөрт "хорих ангиас суллагдсан иргэний хөтөлбөрт хамруулахаар заасан боловч хэдэн хүн хамрагдаж тогтвортой ажлын байртай болсон талаар мэдээлэл тодорхойгүй байна.

6. Нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдлуудыг суллахад бэлтгэх хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа хэдий ч нийгмийн амьдралд оролцуулаад байдаггүй.

Дүгнэлт

Монгол Улсад хоригдлыг 1921 оноос 1990 он хүртэлх хугацаанд улсын бодлого, социалист үзэл баримтлалыг үндэслэн хүмүүжүүлэх хэлбэрийг ашиглаж ирсэн.

Харин Монгол Улсад өрнөсөн ардчилсан өөрчлөлтийн үр дүнгээр 1990 оноос эхлэн хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлд анхаарч үүнтэй уялдуулан хууль тогтоомжид өөрчлөлт оруулж ирсэн байна.

Хууль, түүнд нийцүүлэн гарсан журмын хүрээнд хорих ангийн зүгээс нийгэмшүүлэх ажлыг хэрэгжүүлж байгаа боловч хорих ял эдлээд дуусаж байгаа хоригдолд нийгмийн өөрчлөлтийн тухай бүхий л мэдээллийг багтаасан нийгэмд дасгах

тусгай хөтөлбөр боловсруулан хамруулах, амьдрах орчинтойгоо танилцах боломжоор хангах байдал хангалтгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд нээлттэй, хаалттай хорих ангийг дэглэм, зэрэглэлээр ангилахаар заасан ба энэ нь хоорондоо зөвхөн түр, удаан хугацааны уулзалт, утсаар ярих эрх, эргэлт илгээмжийн тоогоор ялгаатай байна.

Мөн нээлттэй, хаалттай хорих анги нь дээр дурдсан нөхцөл байдлын хувьд ялгаатай боловч нийгэмшүүлэх чиглэлээр хийж буй ажил, арга хэмжээ нь хоорондоо ижил түвшинд байгаа нь учир дутагдалтай байна.

Хорих ангид 2014 онд 6500 хоригдлын 3070 буюу 47.2 хувь, 2018 онд 3500 хоригдлын 1614 буюу 46.1 хувь, 2023 онд 4526 хоригдлын 2485 буюу 54.9 хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж ял эдэлсэн байна.

Энэ нь хорих ангиас суллагдсан этгээд нийгэмд шилжин орох үед материаллаг байдлын хомсдол, сэтгэл зүйн бэлтгэл хангалтгүй, төрийн зүгээс авч хэрэгжүүлэх нийгэмшүүлэх үйл ажиллагаа дутмаг, ар гэрийн зүгээс тэдэнд үзүүлэх дэмжлэг сул байгаа нь хорих ангиас суллагдахаас зайлсхийх, эсхүл ажлын байрны олдоц хангалтгүй, зарим хуулийн хэрэгжилт нэг мөр хэрэгждэггүй, хялбар аргаар мөнгө олох зэрэг шалтгааны улмаас дахин гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр гэж үзэхээр байна.

Иймд хоригдол “Нийгмийн амьдралд эргэн орох байр”-нд байх хугацаандаа хууль эрх зүйн шинэчлэл, нийгмийн хөгжлийн чиг хандлага, өдөр тутмын ашиглаж буй аппликейшн, Е-Монголиа цахим үйлчилгээний нэгдсэн портал, иргэний тоон гарын үсэг, АТМ, киоск цахим машинтай ажиллах зэрэг технологийн дэвшил, хөгжлийн талаарх мэдээ мэдээллээр хангагдаж, нийгмийн амьдралд өөрийгөө бэлдэх, дасгах, сургах хэрэгцээ шаардлагыг нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болж байна.

Өөрөөр хэлбэл илүү нээлттэй, сул харуул хамгаалалттай байранд байрласнаар ажлын зар унших, анкет бөглөх, ажилд орох өргөдөл гаргах зэрэг ажлуудыг судалж, урьдчилан нийгмийн харилцааг хэрэгжүүлэх боломжтой.

Энэ нь нөгөө талдаа Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “...ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах...” заасан эрхээр, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...хөдөлмөрлөх” заасан журамт үүргээ биелүүлэх нөхцөл боломжоор хангагдах боломжтой болно.

Үүний үр дүнд Хорих ангид дахин гэмт хэрэг үйлдэж ял эдэлж байгаа хоригдлын тоо буурах, нөгөө талдаа гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хангах том ажил арга хэмжээ болно гэж дүгнэж байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

1. Хорих ангийн дэргэд “Нийгмийн амьдралд эргэн орох байр” эсхүл “Нийгмийн амьдралд дасгах байр” бий болгох ач холбогдлыг улсын хэмжээнд судлах, хорих ял эдлэх хугацаа дуусаж суллагдах дөхсөн хоригдлыг нийгмийн амьдралд гаргахад бэлтгэх гадаадын сайн туршлагаас нэвтрүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлэх,

2. Хорих ангиас суллагдахаас өмнө ажлын байрыг судлах, ажилчны нөөц бүрдүүлэх, суллагдахаас өмнө ажилд орох өргөдөл бичих, анкет бөглөх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих судалгаанд хамрагдах ажлуудыг хорих ангиудад ажил хэрэг болгох,

3. Эрүүгийн хуулийн 2.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан болгоомжгүй хэлбэрээр гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг удаа дараа санаатай гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгэгдсэн хүмүүстэй хамт байлгах нь нөлөөллийн хувьд сөрөг нөлөө үзүүлж, орчны буруу үлгэр дуурайлалд автаж, сөрөг зан байдал, харьцаа, амьдралын хэв маяг, сэтгэхүй, сэтгэлгээ төлөвших магадлалтай тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг судлах,

4.Нээлттэй, хаалттай хорих ангийн дэглэм, зэрэглэлд хэрэгжүүлэх нийгэмшүүлэх ажлыг ялгаатай байдлаар явуулах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах нөхцөл боломжийг судлах,

Зөвлөмж

1. Төрийн үйлчилгээний байгууллагууд нь иргэдийг ажилд авахдаа хууль, журмаар хязгаарлалт тогтоогоогүй, тухайн албан тушаалын ангилалд ял шийтгүүлсэн байдал нь хамааралгүй байхад “гэмт хэрэгт холбогдож байгаагүй” гэсэн хуулиас давсан шалгуур тавьж, ял шийтгүүлсэн хүмүүст ажил олгохоос татгалздаг. Энэ талаар Төрийн албаны зөвлөлд хандаж, хуулиар хязгаарлалт тогтоосноос бусад тохиолдолд байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд хязгаарлалт тогтоосон асуудлыг таслан зогсоох, хүний эрхийг сэргээх арга хэмжээ авах,

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.7-т "ажил олоход хүндрэлтэй иргэн" гэж ...хорих ангиас суллагдсан ...иргэнийг тодорхойлсон ба мөн хуулийн 15.1.2, 15.1.5, 31.4-т заасан хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд судалж, Хөдөлмөрийг дэмжих үндэсний зөвлөлөөс хорих ангиас суллагдсан хүмүүсээс ажлын байраар хангагдсан хүмүүсийн судалгааг авч, холбогдох арга хэмжээг авах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих,

3.Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5-т Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно: 13.5.3.хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн" гэж заасан хуулийн хэрэгжилтийг судалж, хорих ангиас суллагдсан иргэнд хэдэн төгрөгийн мөнгөн тусламж үзүүлснийг ил тод, нээлттэй болгох, хорих ангиас суллагдсан орон гэргүй иргэнээс хамрагдаагүй хүмүүсийн судалгааг гаргуулан холбогдох арга хэмжээ авах,

4.Дээрх ажил арга хэмжээг хорих ангиас суллагдахаас өмнө судалгаанд хамруулах байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас зохион байгуулах, Хорих ял эдэлж суллагдсан, орон гэргүй этгээдийг түр хугацаанд байр, хоолоор хангаж үйлчлэх чиг үүрэг бүхий нийгэмшүүлэх байр байгуулах туршлага Япон, Герман зэрэг улсад хэрэгжиж байна. Монгол Улсад төвийн хорих байруудад энэ төрлийн үйлчилгээ үзүүлэх байрыг ажиллуулж турших, судлах;

Ашигласан эх сурвалж

- 1.Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагаа.УБ.2018 он;
- 2.Б.Алтангэрэл. Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ.УБ.2020 он;
- 3.М.Алтан-Очир.Хорих ял эдлүүлэх дэглэм.УБ.2020 он;
- 4.А.Лхагва, Д.Даваа-Очир. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ.2011 он;
- 5.С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” нэмж засварласан 2 дахь хэвлэл, УБ. 2008 он;
- 6.О.Пүрэвсүрэн. Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа. УБ.2014 он;
- 7.С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” нэмж засварласан 2 дахь хэвлэл, УБ. 2008 он;
- 8.Н.Гантулга. Ялтныг өөрчлөн нийгэмшүүлэх ажиллагаа дахь хамтын оролцоо. УБ.2015 он;
- 9.Хууль сахиулахуй сэтгүүл /тусгай дэвтэр/. УБ.2015 он;
- 10.А.Гидденс. Социологи.УБ.2006 он;
- 11.НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/111 дугаартай тогтоол;
- 13.Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2017 оны рецидив судалгаа;
- 14.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээ 2024 он;

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

Баянгол дүүргийн Прокурорын газрын ахлах прокурор С.Цэрэндорж

Хураангуй:

Монгол Улсын Эрүүгийн хуульд зааснаар хорихоос өөр төрлийн ялын төрөлд торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ял, эрх хасах ял гэх мэт ялууд хамаардаг¹. Энэ нь тухайн улсынхаа мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийг зөрчин улмаар шүүхийн шийтгэх тогтоолоор хорихоос өөр төрлийн ял эдлэхдээ иргэнийхээ үндсэн эрхээ эдэлж, журамт үүргээ хүлээдэг бөгөөд ингэхдээ зохих хязгаарлалттай байх гэсэн суурь зарчим юм. Энэ ч утгаараа манай улсад хэрэгжүүлж буй хорихоос өөр төрлийн ялын нэг төрөл болох “нийтэд тустай ажил хийлгэх” ялыг илүү үр нөлөөтэй хэрэглэх, прокурорын хяналтын явцад зөрчил илрэхгүй байх нөхцөл бололцоог бий болгох, хүний эрхийг зөрчихгүй байхад энэхүү илтгэлийн ач холбогдол оршино.

Түлхүүр үгс : Нийтэд тустай ажил хийлгэх ял, ялын хэрэгжилт, үзэл санаа, хүний эрх.

Удиртгал

Эрдэм шинжилгээний өгүүлэлд хорих ял эдэлж байгаа 1 хоригдол өдөрт 13 мянга орчим төгрөгийг² хоол хүнс, орон байр, хувцас, бусад хэрэгцээнд зарцуулж байгаагаас үзэхэд хорихоос өөр төрлийн ялын бодлого нь улс орны эдийн засагт хэмнэлттэйн зэрэгцээ, орчин үеийн эрүүгийн эрх зүйн ялын бодлогын залхаан цээрлүүлэх чиг үүрэг улам бүр хязгаарлагдмал болж харин засан төлөвшүүлэх, нийгэмшүүлэх болон урьдчилан сэргийлэх чиг хандлагыг илүү тусган хөгжиж байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх үзэл санаа нь уян, аль болох иргэдээ хорихоос татгалзсан, гэмт зан үйлээ засах, ухаарах боломж олгодгоороо хүний эрхийн үнэт зүйлсийг эрүүгийн эрх зүйгээр хамгаалах нэг чухал бололцоо болж өгч байгаа юм.

Монгол Улс 2015 онд Эрүүгийн хуулиа шинэчлэн баталсан бөгөөд өмнө нь “албадан ажил хийлгэх ял” гэж нэрлэгдэж байсан ялын төрлийг “Нийтэд тустай ажил хийлгэх ял” гэж өөрчилж хуульчилсан. Ийнхүү 2017 оноос дагаж мөрдөх болсон Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйлд “гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ”³ гэж тодорхойлсон.

Эрүүгийн хуульд нийгэмд учруулах хор аюул багатай зарим төрлийн гэмт хэргүүдэд хорих ял оногдуулахгүй байх, үүнтэй холбогдуулан хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт нийтэд тустай ажил хийлгэх ялыг өргөн хэрэглэх бололцоог

¹ Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016. № 7.

² М.Хүрэлбат., Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, чиг хандлага. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 2020

³ Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйл

бүрдүүлэх, уг ялыг оногдуулах боломж нөхцөлийг нэмэгдүүлсэн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байна.

Энэхүү ял нь нийгэм эдийн засгийн хувьд ихээхэн ач холбогдолтой ба эрүүгийн ял шийтгэлийн тогтолцоонд хамт олны оролцоог бий болгох тэдний дэмжлэг нөлөөгөөр ялтан гэм буруугаа ойлгож, зөв амьдрал руу орох боломжийг олгох шинэ хандлагыг бий болгож буйгаараа онцлогтой бөгөөд цаашид тогтвортой тогтолцоог бий болгон хөгжүүлэх шаардлагатай. Нийтэд тустай ажил хийлгэх ялын давуу тал нь гэмт хэрэгтнийг олон нийтийн ойр орчинд ял эдлүүлэх, тодорхой хяналтын дор нийгэмд ашигтай хөдөлмөр эрхлэх боломжоор хангаж, хуульд заасан цагаар ажиллуулах замаар “шоронжих” сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлдэг, хүмүүнлэг ял юм.

Иймээс нийтэд тустай ажил хийлгэх ялыг илүү үр нөлөөтэй болгох, ялын хэрэгжилтийг оновчтой, боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж дэвшүүлэх үүднээс уг сэдвийг сонгосон болно.

Тус чиглэлээр 2019 оноос хойш нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөөг судлах, сайжруулах санал зөвлөмж бүхий эрдэм шинжилгээний хурал, судалгаа ихээхэн хийгдэж эхэлсэн байна. Үүнд:

Улсын Ерөнхий прокурорын газрын сургалт судалгааны хүрээлэнгийн сургалтын албаны судлаач хяналтын прокурор Ц.Мөнхбат “Нийтэд тустай ажил хийлгэх, ялын хэрэгжилт” сэдвийн хүрээнд судалгаа хийж өнөөгийн шүүхийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх практикт дээрх ялын хэрэглээнд олон тулгамдсан асуудал хуримтлагдаж, шийдлээ хүлээсэн хэвээр байгааг дурдаад цаашид хэрэгжүүлж болох санал зөвлөмжийг дэвшүүлсэн байна.⁴

2020 онд Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газраас нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтийг хангах ажиллаж буй боловч тус ялын зорилго, үр нөлөө, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт нь онолын болон практикийн хувьд хүндрэлтэй, үр дүн муутай байдал байсаар байгаа учир уг шаардлагаас үүдэн эрдэм шинжилгээний хурлыг шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах салбарын алба хаагчид, эрдэмтэн, судлаачдын дунд зохион байгуулсан байна. Уг эрдэм шинжилгээний хурлаар нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтийг албадан ажил хийлгэх ялын хэрэгжилттэй харьцуулан томьёолж үр нөлөө, онцлогийг гаргаж ирсний зэрэгцээ цаашид боловсронгуй болгох арга, зөвлөмж саналыг дэвшүүлсэн байна.⁵

Хүний Эрхийн Үндэсний Комиссоос эрхлэн гаргадаг Хүний эрхийн сэтгүүлийн 2023 оны дугаарт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга, хууль зүйн магистр З.Өнөржаргал “Нийтэд тустай ажил хийлгэх ял ба хүний эрхийн зарим асуудал” сэдвээр нийтлэл бичжээ.⁶ Уг нийтлэлд Хүний эрхийг хязгаарладаг Эрүүгийн хууль тогтоомж нь хүний эрхийн суурь зарчим, хэм хэмжээнд нийцсэн байх нь хүний эрхийг зөрчихгүй байх, ял завшуулахгүй байх боломжийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзээд нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөө, хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн анхаарах шаардлагатай зарим

⁴Ц.Мөнхбат., Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, бодлогын судалгааны тайлан. УБ 2019

⁵ Тус судалгааны эмхэтгэлийг <https://fliphtml5.com/dwwfp/ergo/basic/101-150>

⁶ Нийтлэлийг бүрэн эхээр нь <https://nhrcm.gov.mn/assets/img/da281ee308ea3af654b58325ee32a397.pdf>

асуудлыг хөндсөн байх бөгөөд мөн л цаашид боловсронгуй болгох зөвлөмж саналыг тусгасан байна.

Түүнчлэн Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан, түүний дотор эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд нийтэд тустай ажил хийлгэхтэй төсөөтэй ялын асуудлыг хэсэгчлэн авч үзэж судалсан бүтээлүүд цөөнгүй бий. Тухайлбал, С.Нарангэрэл “Монгол Улсын эрүүгийн эрх зүй. ерөнхий анги” УБ., 1999, С.Жанцан “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол” I, II боть. 2009-2013, Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал” УБ., 2004, Д.Баярсайхан “Харьцуулсан эрүүгийн эрх зүй” УБ., 2011 зэрэг бүтээлүүдэд тухайн ялын онол, практикийн үндэслэлийг тоймлон дурдсан нь бий.

Ялын бодлогын чиг хандлагад үндсэн өөрчлөлт орсон нь нэг талаас хүний эрхийн үнэт зүйлс, зарчмыг хамгаалах шаардлага өсөн нэмэгдсэнтэй холбоотойн дээр сүүлийн хориод жилд НҮБ-аас баталсан гэрээ, конвенцод ялын залхаан цээрлүүлэх чиг үүргийг нийгэмшүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгод нийцүүлж, өөрчлөн шинэчлэх хандлага гүнзгий тусгагдах болсноор хорихоос өөр төрлийн ялын хэм хэмжээ эрүүгийн эрх зүйд ихээхэн байр суурийг эзлэх болсон. Энэ ч утгаараа манай улсад хэрэгжүүлж буй хорихоос өөр төрлийн ялын нэг төрөл болох “нийтэд тустай ажил хийлгэх” ялыг илүү үр нөлөөтэй хэрэглэх, прокурорын хяналтын явцад зөрчил илрэхгүй байх нөхцөл бололцоог бий болгох, хүний эрхийг зөрчихгүй байхад энэхүү илтгэлийн ач холбогдол оршино.

Үндсэн хэсэг

Орчин үед цаазаар авах ялыг халж, хорих ялыг илт хязгаарлах, шүүхээс хорих ялыг аль болох бага оногдуулж, хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэж, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх нь зүйтэй гэсэн байр суурийг эрдэмтэн судлаачид бүтээлдээ дурдсан байдаг. Академич С.Нарангэрэл: “Хорих ялыг ихээр хавтгайруулан ногдуулснаас хорихоос өөр төрлийн ялын нэр хүнд буурч, улмаар уг ял нь гэмт явдалтай тэмцэх үр нөлөөтэй хэрэглүүр болж чадахгүй байдалд хүрнэ”⁷ гээд “хорих ялыг хавтгайруулан хэрэглэх нь түүний хамгийн хатуу хүнд ял гэсэн нэр хүндийг бууруулахаас гадна энэ ялын сөрөг нөлөөллийг даван туулахад ихээхэн төвөгтэй байдал үүсдэг”⁸ гэжээ. Үүнээс үзвэл хорих ял нь гэмт хэрэгтнүүдэд хамгийн хүнд ял гэж тооцогдохоо больж, үр нөлөө нь харьцангуй багасаж ялын зарчим алдагдах нөхцөл байдал бий болохыг дурдсан байдаг. Тиймээс түүхэн цаг үеийн явцад хорихоос өөр төрлийн ялын хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдсээр байх болно.

Ялын бодлогын чиг хандлагад үндсэн өөрчлөлт орсон нь нэг талаас хүний эрхийн үнэт зүйлс, зарчмыг эрүүгийн эрх зүйгээр хамгаалах шаардлага өсөн нэмэгдсэнтэй холбоотойн дээр ялын үр нөлөөг нэмэгдүүлэх, гэмт хэрэгтнийг илүү зан суртахууны хувьд нийгэмшүүлэн төлөвшүүлэх чухал түлхэц болж өгсөн. Үүний нэгэн жишээ бол нийтэд тустай ажил хийлгэх ял юм. Уг ялын нэг чухал онцлог нь нийтэд тустай ажлыг цалингүй хийхээс гадна, биеэр эдлэх ял хэмээн тооцогддог. Гэхдээ хорих ял биш учраас харьцангуй хүмүүнлэг, ялтныг нийгэмшүүлэх агуулга бүхий ял бөгөөд

⁷С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги., УБ 1999

⁸С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж., УБ 2019

биеэр эдлэх ялынхаа хувьд ялтныг залхаан цээрлүүлэх ялын үндсэн зарчим хамт хадгалагдаж байдаг.

Ялын үзэл баримтлал нь орчин үеийн эрүүгийн эрх зүйн зарчмыг алдагдуулаагүйн дээр ялын төрлүүдэд иргэний болон төрийн бус байгууллагуудад хүмүүнлэгийн шинжтэй ажил үүрэг гүйцэтгэх, нийтийн зориулалтын үйлчилгээний болон нийгмийн ажил үүрэг гүйцэтгэх байгууллагуудад ажиллуулах, сургалтын болон мэргэжлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцох, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газарт ажиллуулах, гал түймэртэй тэмцэх, нийтийг хамарсан гамшгийг арилгах үйлсэд оролцуулах, иргэний болон хүний эрхийн байгууллагатай ажил үүргийн гэрээ хийсний үндсэн дээр тодорхой даалгавар биелүүлж ажиллах, орон нутгийн өөрөө удирдах байгууллагад нийтэд тустай ажил үүрэг гүйцэтгэх гэх мэт олон талт үйл ажиллагаа явуулахад оролцох байдлаар хэрэгждэг. Мөн цагийн зохицуулалт том байр суурийг эзэлдэг.

Тиймээс энэ ялын зорилго, үзэл баримтлалын үүднээс цаашид улам бүр боловсронгуй болгож, олон нөхцөлт шалгуур бүхий санал санаачилгыг хэрэгжүүлэх хэрэгтэй гэдгийг дурдах нь зүйтэй.

Зарим улсад авч хэрэгжүүлж буй байдлыг дэлгэрүүлэн судалж үзэхэд:

Францын эрүүгийн эрх зүйн “Неоклассицизм”-ын онолын төлөөлөгчдийн үзэж буйгаар ялын зорилго нь **“Залхаах, гэсгээх, нөхөн төлүүлэх”** гэж үздэг бол “Нийгмийн хамгаалал”-ын шинэ онолын төлөөлөгчдийн хувьд **“Засрал төлөвшил олгох, дахин нийгэмшүүлэх”** нь ялын гол зорилго гэх мэтээр тус бүрийн үзлээр өөр өнцгөөс тайлбарласан байдаг.

Дээр дурдсанчлан хуучнаар социалист системийн орнуудад ялын үндсэн зорилгод “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хоригдож буй хүнийг засан хүмүүжүүлэх, нийгмийн шударга ёсыг хамгаалах” явдлыг хамааруулан үзсэн байдаг бол Англи саксоны эрх зүйн бүл /Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, АНУ-ын системийн улс орнууд/ ялын гол зорилгыг “Гэмт хэрэгтэнг нийгмээс тусгаарлах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээлгэх, цээрлүүлэх, засрал төлөвшил олгох, ухаарч ойлгоход түлхэц үзүүлж, гэмт хэргийг дахин үйлдэхгүй байх нөхцөлийг бий болгох, хувь хүн, өрх гэр, улс нийгмийг гэмт хэргийн халдлагаас хамгаалах”⁹ гэх мэтээр тодорхойлсон байдаг¹⁰.

“Их газрын систем”-ийн орнууд ялын зорилгод “Гэмт этгээдэд үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон шийтгэлийг шударгаар оногдуулах, учирсан хохирол, үр дагаврыг нөхөн төлүүлэх, гэмт этгээдийг засан төлөвшүүлэх, нийгэмшүүлэх, урьдчилан сэргийлэх” зэргийг хамааруулан үзсэн байна.

Францын нэрт хуульч эрдэмтэн Ж.Парадель “Нийтэд тустай ажил хийлгэх ял нь хорьдугаар зууны сүүлийн арваад жилд хууль тогтоогчдын бодож боловсруулсан хамгийн шинэлэг ялын төрөл” гэж тодорхойлсон бөгөөд дэлхийн 60 гаруй улс оронд

⁹ШШГЕГ-ын “Сүлд инфо” сэтгүүл. 2017 он №2, 117 дахь тал,

¹⁰«Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: хэрэгжилт, чиг хандлага»сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. «Гадаадын зарим улс орны хорих өөр төрлийн ялын ойлголт, төрөл, эрх зүйн зохицуулалт». УБ хот. 2018. 32дахь тал.

ялын бодлогодоо уг ялыг хэрэглэж буй гэсэн судалгаа байдаг. Хятад, Энэтхэг, Япон, Австри зэрэг зарим улсууд ялын шийтгэлийн бодлогодоо огт хэрэглэдэггүй.

Нийтийн өмнө албадан хөдөлмөр хийлгэх ял шийтгэлийн арга хэмжээ нь дээр дурдсан бүхий л эрх зүйн системүүдийн улс орнуудын ялын зорилгод тодорхойлсон **“Засан хүмүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, цээрлүүлэх, ухаарч ойлгоход түлхэц үзүүлэх** гэх мэт ялын олон цогц шинжийг багтаасан, шүүхээс гэмт этгээдийг тус ялаар шийтгэсэн тохиолдолд харьцангуй эерэг үр нөлөөтэй, нийгэм эдийн засагтай үр өгөөж өгөхүйц ашиг тустай, ял зорилго, биелэлт бүрэн хангагдахуйц ялын төрөл” гэж судлаачдын зүгээс үздэг.

Дэлхийн улс орнуудад нийтэд тустай ажил хийлгэх ял нь хорихоос өөр төрлийн арга хэмжээнүүд дундаас хамгийн түгээмэл тархсан ял шийтгэлийн төрөл бөгөөд улс орон бүрийн хууль тогтоомжид олон төрлийн нэршилтэйгээр, хэрэгжүүлэх арга хэлбэрийн тухайд ч мөн янз бүрээр ашиглагддаг. Тухайлбал,

Голланд, Норвеги, Шведэд - Нийгмийн ажил буюу /общественные работы/;

Гүржид - нийгмийн ашигтай ажил /общественно полезный труд/;

Голланд улсад - албадлагын ажлууд /принудительные работы/;

Латвид - нийтийн өмнө ажил хийлгэх /публичные работы/;

Литва улсад - нийгмийн ашиг тусын ажил /работа в пользу общества/;

Мексик улсад - нийгмийн ашиг тусад чиглэсэн ажил /работы на пользу общества/;

Испанид нийгмийн ашиг тусад чиглэсэн эргэн төлөгдөхгүй хөдөлмөр эргэн төлөгдөхгүй /неоплачиваемый труд в пользу общества/;

Молдав улсад - заавал хийлгэх ажил /обязательные работы/;

Орос, Тажигстан улсуудад нийгмийн ашиг сонирхолд нийцсэн ажил буюу /работы в общественных интересах/;

Францид - нийгэмд ашигтай ажил буюу /общественно-полезные работы/;

Финланд, Израил улсуудад-Нийгмийн ажил үйлчилгээ үзүүлэх буюу /предоставление услуг обществу/;

Их Британи, Ану, Польшид – Нийгмийн ашигтай ажлууд /общественные полезные работы/.¹¹

Нэршил, хэрэгжүүлэх арга хэлбэрийн хувьд харилцан адилгүй боловч дээрх улс орнууд нь тус ялыг ихэвчлэн цагаар тогтоосон байдаг. Тухайлбал, АНУ, Их Британи, Франц, Швед, Польшид 40-240, ОХУ, Казакстан, Тажигстан 60-240, Чехэд 50-400, Арменд 360-1500 цагаар тус тус тогтоож, өдрийн 4 цагаас дээшгүй байхаар хуульчилсан байна.

Ихэнх улс орнуудын хууль тогтоомжид нийтэд тустай ажил хийлгэх бие даасан ялаар хэрэглэгддэг боловч АНУ, Польш, Герман, Молдав зэрэг зарим улс орнуудын

¹¹Ковалев А.Ф. Сравнительно-правовой анализ системы уголовных наказаний романо-германской и англосаксонской правовых семей // Юридическая наука и практика : Вестник Нижегородской академии МВД России. 2019. №2 (46). С. 251-259.

ялын бодлогод тус ял нь **ял эрүүгийн ялаас чөлөөлөх, ялыг эдэлж дуусгах** арга хэмжээгээр байна. Тухайлбал,

- АНУ, Польшид нийтийн тустай ажил хийлгэх ял нь хорих ялаас **суллагдахын өмнөх арга хэмжээ** байдлаар хэрэглэгдэх бөгөөд пробацийн албаны тавьсан нөхцөлөөр ялтныг хөдөлмөрлүүлж, хяналт тавих арга хэлбэрийн хувьд эрх чөлөө хязгаарлах болон заавал хөдөлмөр хийлгэх ялтай адил замаар хэрэгжүүлдэг байна. Нэг үгээр хэлбэл ялтанд хөдөлмөр хийлгүүлэх чиг баримжаа олгох, нийгмийн амьдралд дасгах арга хэлбэрээр;

- Швед, Герман улсуудад нийтэд тустай ажил хийлгэх ял нь хорих ял оногдуулалгүйгээр хянан харгалзах буюу пробацийн албанд шилжүүлэх, хорих ялаас хугацааны өмнө суллах эрүүгийн шийтгэл хэлбэрээр;

- Молдав улсад эрүүгийн шийтгэл оногдуулсан тохиолдолд тухайн этгээдэд шүүхээс шалган сорилтын хугацаа тогтоон, мөн хугацаанд хөдөлмөр эрхлүүлж, тухайн ялтан цаашид засран төлөвшиж боломжтой тохиолдолд албадан хөдөлмөрийг үргэлжлүүлэн эдлүүлэх, тухайн сорилтын хугацаанд засран төлөвших боломжгүй тохиолдолд хорих ял эдлүүлэх арга хэмжээг авахаар;

- Албани, Болгарь, Данид эрүүгийн шийтгэл оногдуулсан үед эрүүгийн хариуцлагын бусад хэмжээгээр;

- Грек, Лексэнбург, Нидерланд, Португаль, Эстонид зэрэг улсуудад хамгийн хүнд төрлийн ялаар солих боломжтой байдлаар хэлбэрээр тус тус эрүүгийн ялын бодлогодоо дээрх ялыг хэрэглэдэг байна¹². Харьцуулс

ан эрх зүй судлалын хүрээнд судалгааны хэсэгтээ гадаад орнуудад уг ялын санкц, нийтлэг жишгийг судлан тодорхойлж таньж мэдэх нь зүйтэй гэж үзлээ.

¹² Лопотенко Ю. Ю. Проблемы законодательной регламентации, возникающие при применении уголовного наказания в виде исправительных работ // Общество: политика, экономика, право. 2018. №2. С. 57-59.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын статистик тоо баримт

Хүснэгт 1. Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн сүүлийн 3 жилийн судалгаа

д/д		Бүгд	Ял эдэлж дууссан					
			Ялын хугацаа дууссан	Өршөөл, уучлал үзүүлсэн	Хэрэгсэхгүй буюу хүчингүй болсон	Өвчний улмаас ялаас чөлөөлсөн	Ял сольсон	Нас барсан
2021	Насанд хүрсэн	751	403	213	2	4	108	4
		268591	14928	62928	560	1582	37815	2038
	Өсвөр нас	13	15				4	
		2105	325				615	
2022	Насанд хүрсэн	674	451	82			124	2
		255443	15889	29869			42233	680
	Өсвөр нас	14	11				1	
		1940	463				200	
2023	Насанд хүрсэн	752	553	6	5		163	4
		276003	32950	2297	1794		55410	1146
	Өсвөр нас	19	15				1	
		2805	274				174	

Энэхүү судалгаанаас харахад сүүлийн 3 жилийн байдлаар нийтэд тустай ажил хийлгэх ял шүүхээс оногдуулсан байдал тооны хувьд өөрчлөгдөөгүй ч жилээс жилд нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорих ялаар сольсон тохиолдол нэмэгдсэн байна. 2021 онд 751 ялтнаас 108 ялтны 14,3 хувь, 2022 онд 674 ялтнаас 124 ялтны 22,8 хувь, 2023 онд 752 ялтнаас 163 ялтны 21,6 хувийг тус тус хорих ялаар сольж шийдвэрлэсэн болон хууль тогтоомжийн дутмаг зүйлээс болж хүний эрх зөрчигдөж байгаа эсэхэд хууль зүйн дүгнэлт хийх ёстой.

Гэтэл шүүхээс гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага оногдуулахдаа хорихоос өөр төрлийн ялыг оногдуулж шийдвэрлэсэн ч эцэстээ хорих ялаар сольж шийдвэрлэгдэж байгаа нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх буюу эрүүгийн хариуцлагын зорилготой нийцэхгүй байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэхэд гарч буй бэрхшээл, тулгамдаж буй асуудал

Ялыг хэрэгжүүлж эхэлснээс хойших ажиглагдсан нэг зүйл нь ялтнуудыг гол төлөв хот тохижилтын ажилд ажиллуулсан байх бөгөөд энэ нь нийтлэг зохицуулалтын хүрээнд л болохоос тухайлсан зохицуулалт дутмаг байгаагаас үүдэж байна. Үүнийг дагаад ялын үр нөлөө багасаж, явцууруулах хандлага ажиглагдсаар байна. Нийтэд тустай ажил хийлгэх ялын нэг онцлог нь нийгэм, олон нийт нь ял шийтгэлийг эдлүүлдэг институт болдог. Ийм учраас нийтэд тустай ажил хийлгэх ялыг аль салбарт эдлүүлэх вэ гэдэг асуудал бүрэн төгс шийдэгдээгүй хэвээр байна. Өнөөгийн байдлаар нийтэд тустай ажил хийлгэх ялыг төрийн болон төрийн бус байгууллагад эдлүүлж болох боломжтой.

Гэтэл зарим төрийн бус байгууллага тухайн ялтныг ял эдэлж байна гэж хүлээж авч буй учир тэр бүр ажиллуулах хандлага цөөн байна. Гагцхүү ялтны хийж буй ажлын үр шим, ашиг тус нийгэм, иргэдэд чиглэж байх ёстой юм.

Нийтэд тустай ажил хийлгэх хугацааг хуульд 720 цаг хүртэл байхаар тогтоосныг багасгах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг энэхүү судалгааны явцад хийлээ. Шүүхээс ногдуулсан нийтэд тустай ажил хийлгэх ялыг цалин хөлс олгохгүйгээр өдөрт бага багаар удаан хугацааны турш биелүүлэх нь үр нөлөөтэй, нийгэмд засрал хүмүүжил олгох сайн талтай, гэмт хэрэгтэнд үзүүлж буй ялын цээрлэл юм гэж ойлгогдож байгаа ч практик хэрэгжилт өөр байдлыг илэрхийлж байна. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хугацаа бусад оронд тухайлбал, Украин, Казахстанд 60-240 цаг, Англи, Франц, Дани, Шведэд 40-240 цаг, Норвегид 360 цаг хүртэл, Орос, Латвид 480 цаг хүртэл, Финляндад 20-200 цаг¹³ тогтоосонтой харьцуулахад манай улсад 240-720 цаг байгаа нь “хэт өндөр” гэж үзэж болохоор байна. Учир нь тухайн ял шийтгүүлсэн этгээд эрхэлсэн ажил төрөлтэй байх тохиолдолд өдөрт хоёроос дээшгүй цагаар ажиллуулах бөгөөд 720 цаг ажиллах хугацаа нь 360 хоног болж байна.

Ял эдлүүлэх цагийн зохицуулалтыг анхаарах асуудал эн тэргүүнд тавигдаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 164.1-д зааснаар “Нийтэд тустай ажил хийлгэх хугацаа нь амралтын өдөр болон үндсэн ажил, хичээлээс чөлөөтэй өдөр 4 цагаас ихгүй, ажлын өдөр ажил болон хичээлээс чөлөөтэй үед 2 цаг, эсхүл ялтан өөрөө зөвшөөрсөн тохиолдолд 8 цагаас ихгүй, 7 хоногт 10 цагаас багагүй байна”¹⁴ гэж хуульчилсан. Энэ цагийн зохицуулалт нэг талаараа дэлхий нийтийн жишигт нийцэж буй боловч манай улсын онцлог ялгаатай холбоотойгоор тэр бүр тохиромжтой биш байдаг. Жишээ нь 7 хоногт 10 цаг ажилласан байхад болох юм байна гэж ялтан ойлгож, хувьдаа ажил хийдэг ч бай, хийдэггүй ч бай энэ цагаа л гүйцээхэд зөрчилд тооцогдохгүй байна гэж өрөөсгөл байдлаар ойлгох талтай. Гэтэл ямар ч ялтан тодорхой шалтаг, шалтгаан гаргаж өдөрт хэдэн цагийг ч нийтэд тустай ажил хийлгэх ялын эдлэх хугацаа болгож болохоор нөхцөл байдал үүсэж байгаа төдийгүй ялын залхаан цээрлүүлэх зарчим алдагдахад хүрээд байна. Иймээс нийтэд тустай ажил хийлгэх ялыг цалин хөлсгүйгээр харьцангуй уян хатан буюу сонгох боломжтойгоор тухайн хүний хүсэлт, санал, зөвшөөрлийг харгалзах замаар оногдуулж эдлүүлэх нь зүйтэй ба энэ нь ялын үр нөлөөг дээшлүүлэх ач холбогдолтой. Хуульд ялыг ямар хугацаанд эдлүүлж дуусгахыг заагаагүй нь ял шийтгүүлсэн этгээд ял завших, улмаар ялын үр нөлөөг бууруулахад хүргэсэн байна.

Мөн түүнчлэн эрүүгийн хуулийн 8.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт 3-аас дээшгүй цагаар 120-360 цагаар тогтооно” гэж хуульчилсан.

Эрүүгийн эрх зүйн судлаач, доктор Т.Золбоо дурдахдаа: “...Ял нь залхаан цээрлүүлэх шинж чанар бүхий гэмт үйлдлийн хариу арга хэмжээ мөн ч гэсэн үзэл баримтлал өнөөгийн оршин буй бидний нийгэмд нийцэхгүй болж байна.”, “...Ял нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг нийгэмшүүлэх зорилготой албадлагын арга хэмжээ гэсэн харьцангуйн онолын үзэл баримтлалд давхар суурилдаг.”, “... Ялын

¹³Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй., УБ 2011 он

¹⁴Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 164.1 дүгээр зүйл

нийгэмшүүлэх зорилго нь зөвхөн насанд хүрсэн этгээдэд л үр нөлөөтэй байдаг”¹⁵ гэж тэмдэглэсэн байна. Үүнээс үзвэл өсвөр насныхан болон насанд хүрэгчдийн нийтэд тустай ажил хийлгэх ял эдлэх хугацаа харьцангуй өөр боловч өсвөр насныханд уг ялыг эдлүүлэх нь эргээд ялын нийгэмшүүлэх зорилго алдагдах урьдач нөхцөл болж байна.

Шүүхийн шийтгэх тогтоолд нийтэд тустай ажил хийлгэх байгууллагыг заадаггүй, төрийн эрх бүхий байгууллагаас ялтан ажиллуулах санал ирдэггүй, ялтанд итгэж ажил хөдөлмөр эрхлүүлэх үүргээ биелүүлдэггүй, тайлан, мэдээгээ цаг тухай бүр нь гаргаж өгөхөөс төвөгшөөдөг зэрэг олон хүндрэлүүд тулгардаг.

Шинэчлэн батлагдаж хэрэгжиж буй одоогийн хуульд “Нийтэд тустай ажил хийлгэх ял”-ыг өдөрт 4 цагаар эдлүүлдэг байсныг 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр өдөрт 8 цаг болгон өөрчилсөн нь ялтныг залхаах, сул чөлөөтэй байдал үүсэх улмаар дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлснээрээ онцлогтой болсон төдийгүй шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалал тодорхой хэмжээгээр буурсан ач холбогдолтой зохицуулалт болсон гэж үзэж байгаа ба ялтныг хориhoос илүүтэйгээр ажил, мэргэжлийн дагуу гадуур төрийн байгууллагад нийтэд тустай ажил хийж ялаа эдлэх, нийгэмшүүлэх, ухамсарлуулах нөхцөл боломжоор хангаж хуульд тусгайлан тухайн төрлийн ялыг тусгаж өгсөн нь ялын бодлогын үүднээс харвал том дэвшил гэж үзэж болохоор байна.

Гэвч Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйлд зааснаар “Нийтэд тустай ажил хийлгэх ялыг Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй” гэж хуульчилсан байгаа нь нэг талаараа нарийвчилсан заалт мэт боловч нөгөө талаас үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг илүү тусгаж өгсөн зохицуулалт шаардлагатай байна. Тухайлбал, дээр дурдсанчлан ажил хийдэг хүнийг уг ялаар шийтгэснээр ялын бодлого алдагдаад байгаа учраас цагийн зохицуулалт, хувийн байдлын шинж чанарыг илүү нарийвчлан тусгаж өгөөгүйгээс үүдэн уг ялыг хорих ялаар солих нөхцөл цөөнгүй гарсаар байна.

Дүгнэлт

Өнөөдрийн байдлаар нийтэд тустай ажил хийлгэх ялын эрх зүйн зохицуулалтыг Эрүүгийн хууль (5.1, 5.4), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (162-166) болон бусад эрх зүйн актууд бүрдүүлж байна. Хууль тогтоогч нь Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт нийтэд тустай ажил хийлгэх ялын ойлголтыг өгсөн бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ гэж тодорхойлсон байна. Гэсэн хэдий ч логикийн аргыг ашиглан бидний судалж байгаа ялын төрлийг шинжээс нь хамаарч бусад ялаас ялган тодорхойлж болох юм.

Зарим ном, сурах бичгүүдэд нийтэд тустай ажил хийлгэх ялын талаар судалж байгаа зохиогчид тухайн ялын агуулгад нийцсэн онцлог, элементүүдийг судлан авч үзсэн байдаг. Б.В. Здравомыслов тухайн ялын онцлог нь нэгдүгээрт заавал хийх ажил буюу албадан биелэгдэх; хоёрдугаарт эдгээр ажлуудыг цалин хөлсгүйгээр хийдэг,

¹⁵Т.Золбоо. Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, Гэмт хэргийн бүтэц., УБ 2018

өөрөөр хэлбэл ялтан нь хийж гүйцэтгэсэн ажлынхаа төлөө цалин, мөнгөн урамшуулал авахгүй; гуравдугаарт ажил, хичээлээс чөлөөтэй өдөр болон амралтын өдөр хийдэг зэрэг юм гэж тэмдэглэсэн¹⁶. П.Г. Пономарев тухайн ялын онцлог нь: 1) заавал хийх ажил; 2) ажил, хичээлээс чөлөөтэй цагт хийдэг; 3) цалингүй, хөлсгүй ажил; 4) нутгийн захиргааны байгууллагатай харилцан тохиролцож хийх ажлын төрөл, байршлыг тогтоож өгдөг зэргийг онцолсон байна¹⁷. Бидний үзэж байгаагаар эдгээр нь нийтэд тустай ажил хийлгэх ялын онцлогийг бүрэн илэрхийлж чадахгүй байна гэж үзэж байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь эрүүгийн ялын нэг төрөл болохын хувьд түүний орчныг тодорхойлж болох *дотоод* гэж нэрлэж болох шинжтэй: нийтэд тустай ажил хийлгэх ял нь өөрийн гэсэн мөн чанартай, агуулгатай эрүүгийн ялын төрөл; нийтэд тустай ажил хийлгэх ял нь ялын төрөл болохын хувьд өөрийн гэсэн хэлбэртэй бөгөөд нийтэд тустай байх зорилгоор хэрэглэгддэг.

Улс орны эрх зүйн эрүүгийн эрх зүйн хөгжил нь дэлхийн бусад улс орнуудын хууль дахь шинэлэг давуу талыг тусгахын хамт өөрийн орны өвөрмөц онцлогийг илэрхийлж, ялын бодлогын бие даасан үзэл баримтлал, хандлагыг бий болгон хөгждөг онцлогтой.

Төр эрх зүйн түүхэн уламжлалын асар баялаг түүхтэй манай улсын хувьд гадаадын өндөр хөгжилтэй, нийгэм эдийн засгийн байдал, эрүүгийн эрх зүйн орчин, хууль сахиулагч чиг үүрэг бүхийн байгууллагуудын бүтэц тогтолцоо нь адил төсөөтэй улс орны туршлагаас суралцахын хамт өөрийн улс орны онцлог байдал, цаашдын чиг хандлагыг зайлшгүй тусган баяжуулах нь зүйтэй юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.3 дэх “Шүүх ялтны мэргэжил, ур чадварыг харгалзан ялтанд тодорхой нийтэд тустай ажлыг хийхээр даалгасан тохиолдолд ялыг шүүхийн шийдвэрт заасан журмын дагуу гүйцэтгэнэ” гэсэн боловч өнөөдрийн байдлаар шүүхээс нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах нийтийн ашиг сонирхолд нийцсэн ажлыг шүүхийн шийдвэрт тогтоон ирүүлэхгүй байна.

Практикт нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах нийтийн ашиг сонирхолд тустай ажил гэдэгт юуг ойлгох, ямар ажил байх талаар тодорхой зохицуулалт байхгүй байгаа нь уг ялыг хэрэгжүүлэхэд мөн л хүндрэлтэй асуудлын нэг байсаар байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж

1. Гэмт этгээдийг хорилгүйгээр засран төлөвших хугацаа тогтоон өгч хууль сахиулах байгууллагын хяналтад нийтэд тустай хөдөлмөр эрхлүүлж, иргэн, нийгэмд учруулсан хохирлыг барагдуулах, засран төлөвших боломжтой гэж үзсэн тохиолдолд үргэлжлүүлэн тухай ялыг бүрэн эдэлсэнд тооцдог,
2. Гэмт этгээд нь шүүхээс тогтоосон хугацаанд албадан хөдөлмөр эрхлэх,

¹⁶Б.В. Здравомыслов. Уголовное право Российской Федерации. Общая часть: учебник. М., 1999. 345 тал.

¹⁷Уголовное право Российской Федерации. Общая часть. Под ред. Л.В. Иногамовой-Хегай, А.И. Радога, А.И. Чучаева. М., 2011. 382 тал.

засран төлөвших боломжгүй тохиолдолд хорих ялаар солих боломжтой;

3. Хорих ялыг эдэлж дуусахаас өмнө хөдөлмөр хийлгүүлэх чиг баримжаа олгох, нийгмийн амьдралд дасгах хэлбэрээр ялын бодлогодоо ашиглаж байгаа зэрэг нь манай орны нөхцөлд тохирч болохуйц оновчтой жишиг байж болох юм.

4. Судалгааны ажлын явцад нийтэд тустай ажлын төрлийг зөв хуульчлан тогтоож, ял эдлүүлэх үр нөлөөг сайжруулсан тохиолдолд Эрүүгийн хуульд энэ төрлийн ялыг нэмэгдүүлэх бодит боломж нээгдэх бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг олон нийтээс тусгаарлахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх орчин үеийн чиг хандлагатай бүрэн нийцэх юм.

5. Төрийн бус байгууллагуудыг гэрээний үндсэн дээр нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаанд оролцуулж, тэдгээрийг мэргэжлийн арга зүй, удирдлагаар хангаж, урамшуулах тогтолцоог бий болгох,

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.1 дэх хэсэгт “нийтэд тустай ажил хийлгэх хугацаа нь амралтын өдөр болон үндсэн ажил, хичээлийн чөлөөтэй өдөр 4 цагаас ихгүй, ажлын өдөр ажил болон хичээлээс чөлөөтэй үед 2 цаг, эсхүл ялтан өөрөө зөвшөөрсөн тохиолдолд 8 цагаас ихгүй, 7 хоногт 10 цагаас багагүй байна” гэж заасан зохицуулалтыг илүү нарийвчлан боловсронгуй болгох шаардлагатай байна.

Ялтан 7 хоногийн 2 өдөрт 10 доошгүй цагийг биелүүлж бусад цагт ажил, хичээлтэй тохиолдолд тус ялыг биелүүлээгүй зайлсхийсэн гэж үзэх хууль зүйн боломжгүй байна. Дээрх хуулийн заалтад өдөрт 2 цаг биелүүлэхээр тусгагдахдаа ажил болон хичээлээс чөлөөтэй үед гэж тусгайлан зохицуулжээ. Гэтэл ялтан ажил, хичээл нь 8 цаг 30 минутаас 17 цаг 30 минут хүртэл байгаа тохиолдолд “чөлөөтэй” гэдгийг хэрхэн яаж ойлгох талаар нарийвчлан хэрэглэх зохицуулалт байхгүй байна.

Нөгөө талаас ажил болон хичээлд явж байгаа үед шийдвэр гүйцэтгэгч өдөрт 2 доошгүй цагийг биелүүлбэл Үндсэн хуулийн 16 дүгээр зүйлд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, сурч боловсрох эрхэнд халдах нөхцөл байдал үүсэж байх тул шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.

Мөн нийтэд тустай ажил хийлгэх ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, ажил олгогч байгууллагатай нийтэд тустай ажил хийлгэх гэрээг байгуулахад тухайн байгууллагын дотоод журмыг ялтан дагаж мөрдөх үүргийг хүлээдэг.

Гэтэл байгууллагын дотоод журам нь тухайн байгууллагын ажил олгогч, нөгөө талаас иргэн хоёрын харилцааг зохицуулдаг. Ялтан тус байгууллагын дотоод журмыг зөрчсөн тохиолдолд ялыг солих үндэслэл үүсэж байгаа нь нөгөө талдаа хүний эрхийн томоохон зөрчил гэж үзэхээр байна.

Ашигласан эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Монгол улсын Эрүүгийн хууль 2015 он
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он

5. Прокурорын тухай хууль 2017 он
6. М.Хүрэлбат., Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, чиг хандлага. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 2020 он
7. С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги., УБ 1999
8. С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж., УБ 2019
9. Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй., УБ 2011
10. Т.Золбоо. Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, Гэмт хэргийн бүтээц., УБ 2018
11. Ц.Мөнхбат., Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, бодлогын судалгааны тайлан. УБ 2019
12. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 2020 он
<https://fliphtml5.com/dwwfp/ergo/basic/101-150>
13. З.Өнөржаргал “Нийтэд тустай ажил хийлгэх ял ба хүний эрхийн зарим асуудал нийтлэл.2023 он
<https://nhrcm.gov.mn/assets/img/da281ee308ea3af654b58325ee32a397.pdf>
14. ШШГЕГ-ын “Сүлд инфо” сэтгүүл. 2017 он
15. «Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: хэрэгжилт, чиг хандлага» сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. «Гадаадын зарим улс орны хорих өөр төрлийн ялын ойлголт, төрөл, эрх зүйн зохицуулалт». 2018 он
16. Ковалев А.Ф. Сравнительно-правовой анализ системы уголовных наказаний романо- германской и англосаксонской правовых семей //Юридическая наука и практика : Вестник Нижегородской академии МВД России. 2019 он

ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

Баян-Өлгий аймгийн Прокурорын газрын ахлах прокурор А.Еркегүл

Хураангуй:

Монгол Улсын Эрүүгийн хуульд “Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийг этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино”¹ гэж тодорхойлон шүүхээс ихэвчлэн хорих ял оногдуулж, дийлэнхийг нь биечлэн эдлүүлдэг байдлыг өөрчлөх зорилгоор торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ялыг үндсэн ялаар сонгож хэрэглэхээр хуульчилсан.²

Эдгээр ял нь хоорондоо агуулга, ялтанд нөлөөлөх арга, ял эдлүүлэх нөхцөл, журам, хэмжээгээрээ ялгаатай³ хэдий ч ялын хэрэгжилт, хэрэглээ нь хүний эрхтэй салшгүй холбоотой тул хүний суурь эрхүүд ял эдлүүлэх ажиллагааны явцад зөрчигдөх учиргүй.

Иймд энэхүү илтгэлээр төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэхэд ял чухал үүрэг гүйцэтгэдэг тул торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг эдлүүлэх явцад хүний эрхийг зөрчихгүй байх, үр нөлөөг дээшлүүлэх, ялын зорилгод нийцүүлэхэд учирч буй хүндрэл бэрхшээлтэй зарим асуудлыг авч үзэж, санал, зөвлөмж боловсрууллаа.

Түлхүүр үгс:

Хорихоос өөр төрлийн ял, хүний эрх, торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял.

Удиртгал

1. Сэдвийг сонгох болсон үндэслэл

Дэлхийн олон улс эрүүгийн ялын бодлогоо хүний эрхийг хангах, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлэх, ялын чанга шийтгэлээс татгалзах, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох хүрээнд хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг хэрэглэх чиг хандлагатай байна.

Манай улсын хувьд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих ял оногдуулахаас аль болох татгалзаж, хорихоос өөр төрлийн ял сонгож хэрэглэхийг зорьж, багагүй хугацаа өнгөрчээ.

Энэхүү үзэл баримтлал нь олон улсад “Токиогийн дүрэм” хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн “хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм”-ийн зорилгод⁴ нийцсэн, дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг багасгах, архаг гэмт хэрэгтэн болохоос сэргийлэх, түүнийг нийгмийн амьдралд түргэн оруулахад туслах замаар дахин хэрэгт орооцолдох магадлалыг бууруулах, гэм бурууд нь тохирсон ял

¹ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

² Э.Батцэрэн Б.Амарбат нар. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ сургагч багшийн гарын авлага. УБ, 2017. 52 дахь тал

³ О.Батсүх. Эрүүгийн эрх зүй ерөнхий анги. УБ, 2021. 233 дахь тал

⁴⁴ НҮБ-ээс баталсан Токиогийн дүрмийн 1.2 дахь заалт, 1990

оногдуулахад чиглэгдсэн Эрүүгийн хуулийг хэрэглэхэд хандлагын томоохон өөрчлөлт хийгдсэн.

Хорихоос өөр төрлийн ялыг нэмэгдүүлэх нь нэг талаас Монгол Улс олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцсэн хууль батлах хэрэгцээ, шаардлага, нөгөө талаас нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд нийцэж байна.

Үүнтэй холбоотой хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтны тоо жил тутам өсөн нэмэгдэж байх бөгөөд Монгол Улсын хэмжээнд хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн хүн, хуулийн этгээд 2022 онд 15480 байсан бол 2023 оны байдлаар 16832 хүн, хуулийн этгээд шийтгүүлсэн нь 1,352 буюу 8.7 хувиар өсчээ.⁵

Прокурорын байгууллагаас дунд хугацааны бодлого, чиглэлийг тодорхойлох зорилгоор Төрийн албаны тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон бусад бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн “Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-г боловсруулж, 2023 оноос эхлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улмаар Улсын ерөнхий прокурорын газраас стратеги төлөвлөгөөг оновчтой бодитой боловсруулахын тулд салбарын өмнө тулгамдсан асуудлыг шинжлэн судалж, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, олон улсын гэрээ конвенцоор олгосон чиг үүрэгт үндэслэн мандатын шинжилгээ хийхэд “...ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэхэд хяналт тавих...” дэд чиг үүргийг тусгайлан зааж өгсөн нь хүний эрх зөрчигдөх явдал гаргахгүй байхад онцгойлон анхаарч буйг илтгэж байна⁶.

Гэвч хууль, журамд зарим асуудлыг нарийвчлан зохицуулаагүй, хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүйн улмаас ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөх тохиолдол таслан зогсоогдохгүй байна.

Энэхүү шаардлагаас үүдэн Улсын ерөнхий прокурорын газраас санаачлан “Ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийг хангах, хамгаалахтай холбоотой онол, арга зүй, практик” сэдвийн дор эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг зарлаж байгаад таатай байна.

2. Зорилго, зорилт

Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг эдлүүлэх явцад ялтны эрх ашигт хохирол учруулахуйц зарим нэгэн асуудлыг боловсронгуй болгох, ялын үр нөлөө, хэрэгжилтийг дээшлүүлэх талаар дүгнэлт хийж, санал, зөвлөмж боловсруулахад илтгэлийн зорилго оршино.

Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлсэн:

1.Хорихоос өөр төрлийн ялын ач холбогдол, үр нөлөө

2.Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, тулгамдсан асуудлыг тодорхойлох

3.Хорихоос өөр төрлийн ялын талаар хууль, журмын зохицуулалтыг боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэх дүгнэлт, санал, зөвлөмж уламжлах зэрэг болно.

⁵ Прокурорын байгууллагын үйл ажиллагааны тайлан, УБ, 2023, 73 дахь тал,

⁶ Монгол Улсын Прокурорын байгууллагын стратеги төлөвлөгөө 2023-2026

3. Сонгон авсан сэдвийн хамрах хүрээ, хязгаарлалт

Үндсэн ялын чанартай хэрэглэдэг торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг эдлүүлэх явцад хүний эрхийг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, ялын үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга замын талаар та бүхэнтэй өөрийн санаа бодлыг хуваалцахыг зорьлоо.

4. Илтгэл бичихэд ашигласан судалгааны арга зүй

Хууль зүйн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгддэг судалгааны аргуудыг сэдвийн онцлогт тохируулан хэрэглэхдээ анализ, синтез, харьцуулах, системчлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, статистик, дүн шинжилгээ, ярилцлагын аргыг хэрэглэсэн.

Нэг. Хорихоос өөр төрлийн ялын ач холбогдол, үр нөлөө

Хорихоос өөр төрлийн ялыг нэмэгдүүлэх нь хорих ялыг бууруулах, нийгмээс тусгаарлахгүйгээр ялтны зарим эрхийг хязгаарлах, ажил хөдөлмөр эрхлэн орлого олох, сурч боловсрох боломжийг олгох, гэр бүл, олон нийтийн дунд засарч хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, цээрлүүлэх ач холбогдолтой.

Ялын эцсийн зорилго бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд зориулагдана, энэ зорилгод нийцээгүй бол аливаа ял нь өөрийн уг чанараараа шударга ёсонд нийцэхгүй тул ял биш гэж үзсэн байдаг.⁷ Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг үр нөлөөтэй хэрэгжүүлснээр дараах үр дүн гарах боломжтой. Үүнд:

1. Дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх
2. Хохирогч хохирсон дээрээ хохироод үлдэхгүй байх, хохирол, хор уршгийг арилгах, хохирогчийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх
3. Ялтан ял эдлэх явцад давхар ажил хөдөлмөр эрхэлснээр гэр бүл, нийгэм, эдийн засаг, улс орны амьдралд оруулах хувь нэмэр, хөдөлмөрийн бүтээмж дээшлэх
4. Гэр бүл салалт багасах, хүүхэд өнчрөх явдал буурах
5. Хариуцлагатай, ухамсарт иргэн болж төлөвших
6. Нийгэм, хамт олны дунд хариуцлага хүлээх чадвар нэмэгдэх зэрэг болно.

Хоёр. Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, тулгамдаж буй асуудал

Улсын хэмжээнд 2023 оны байдлаар шүүхээс хорихоос өөр төрлийн ял оногдуулсан тохиолдлыг төрлөөр нь авч үзвэл торгох 9878, нийтэд тустай ажил хийлгэх 1480, зорчих эрхийг хязгаарлах 2934 байна.⁸

Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилттэй холбоотой тулгамдсан асуудлыг ялын төрөл тус бүрээр хөндөж үзвэл,

2.1. Торгох ялын хэрэгжилттэй холбоотой зарим асуудал:

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг эхлүүлэх үндэслэл нь хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр байдаг. Шүүхийн тогтоол, магадлал хэзээ хүчин төгөлдөр болсон нь хорихоос өөр төрлийн ял эдлүүлэхэд чухал ач холбогдолтой.

⁷ Чезаре.Беккариа."Гэмт хэрэг ба ялын тухай" /сонгодогууд цуврал/ Орч Г.Эрдэнэбат. УБ., 2009. 9 дахь тал

⁸ Прокурорын байгууллагын үйл ажиллагааны тайлан, УБ, 2023, 74 дэх тал,

Гэтэл шүүхээс ирүүлж буй зарим гүйцэтгэх хуудаст шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон хугацааг тусгаагүй, тодорхойгүй байдаг ба энэ тохиолдолд торгох ялыг биелүүлэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй, ял эдлүүлэх ажиллагаанд саад учруулж, ялтны эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шаардлага хангаагүй гүйцэтгэх баримт бичгийг шүүхэд буцаах хуулийн заалттай⁹ хэдий ч энэ нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах гүйцэтгэх баримт бичигт хамааралтай болно.

Харин эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувьд ахлах шийдвэр гүйцэтгэгч хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг шууд хүлээж авч, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоол гаргаж, ажлын 3 өдрийн дотор тойрог хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид хуваарилж, прокурорт мэдэгдэх үүрэгтэй.

Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон байхад шийдвэр гүйцэтгэх байгууллагад ялтны хамт хүргүүлэхгүйгээр дарагдуулдаг, прокурор уг зөрчлийг хяналтаараа илрүүлж, зөрчлийг арилгуулахаар шүүхэд албан бичгээр хандаж байгаа боловч төдийлөн үр дүн гарахгүй байгаа нь ял эдлүүлэх ажиллагааг **“даруй эхлүүлэх”** үндсэн зарчим алдагдахад хүргэж байна.

Торгох ялаар шийтгүүлсэн ялтны хувьд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн ял эдлэх хугацааг тоолохоор хуульчлан зохицуулсан. Гэвч шүүх, прокурорын буруутай үйл ажиллагаанаас болж, хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг хугацаа алдаж харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлдэг тохиолдол нилээдгүй гардаг байна. Жишээлбэл, шийтгэх тогтоолд торгох ялыг биелүүлэх хугацааг 3 сараар тогтоосон, шүүхийн шийдвэр 2023.05.20-нд хүчин төгөлдөр болсон, харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шийтгэх тогтоолыг 2023.08.23-ны өдөр хүргүүлсэн байна. Торгох ялыг биелүүлэх 3 сарын хугацааг хэзээнээс, хэрхэн тооцох нь тодорхойгүй,

Дээрх тохиолдолд практикт хугацааг хэрхэн тооцож, ялыг биелүүлж байгааг тогтоох зорилгоор бүсчлэн авч үзэж, зарим аймаг, дүүргийн прокурорын газар буюу баруун бүсээс Ховд аймгийн прокурорын газар, хангайн бүсээс Хөвсгөл аймгийн прокурорын газар, төв бүсээс Сүхбаатар дүүргийн прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорууд ахлах прокуроруудтай утсаар холбогдсон.

Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш хэсэгчлэн төлөхөөр тогтоосон хугацаа болон ахлах шийдвэр гүйцэтгэгчийн 30 хоногийн хугацаа өнгөрсний дараа шүүхээс гүйцэтгэх хуудас ирүүлсэн тохиолдолд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн өдрөөс **ялтны ял эдлэх хугацааг тоолдог**, эсхүл **ялтнаар хүсэлт гаргуулж, 30 хоногоор сунгуулан торгох ялыг төлүүлдэг**, мөн шүүхийн шийдвэрт хэсэгчлэн төлөх хугацаа дууссан боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 160 дугаар зүйлийн 160.2 дахь хэсэгт зааснаар ахлах шийдвэр гүйцэтгэгчийн **30 хоногоор сунгах хугацаа нь өнгөрөөгүй бол уг 30 хоногт багтаан ялтанд торгуулийн ялыг төлүүлдэг** гэж хариулсан¹⁰.

2.2. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилттэй холбоотой зарим асуудал:

⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг

¹⁰ Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж буй зарим прокуроруудтай утсаар холбогдож хийсэн ярилцлагаас 2024 оны 3 дугаар сар “Ярилцлагын үеэр харьцангуй бага үнийн дүнтэй буюу 450,000-1,000,000 төгрөгийн хооронд торгох ялаар шийтгүүлсэн ялтнуудад дээрх тохиолдол гарч байгаа нь тогтоогдлоо ”

Эрүүгийн хуульд уг ялын үндсэн шинжийг “...шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажил...” хэмээн хуульчилсан нь энэ ялын үр нөлөөг бууруулахад нөлөөлсөн гэж үзэхээр байна. Учир нь шүүх ажил олгогч байгууллага биш. Тиймээс энэ ялын ажлын төрлийг тогтооход нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага шүүх, шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран ажиллах асуудлыг зайлшгүй хуульчлах шаардлагатай. Нийтэд тустай ажил хийлгэх ял ногдуулж ирсэн **өнгөрсөн 4 жилийн хугацаанд ялын биелэлтийг хангахад**, төрийн бус байгууллагууд нэг ч удаа оролцоогүй байна. Судалгааны хүрээнд нийт 272 этгээдэд холбогдох шүүхийн шийтгэх тогтоолд шинжилгээ хийж үзэхэд зөвхөн 1.1 хувьд ямар төрлийн ажил хийхийг тодорхой заасан бол үлдсэн 98.9 хувьд огт заагаагүй. Энэ нь эцсийн дүндээ тус ялын үр нөлөөг бууруулж, ял шийтгүүлэгч зөвхөн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд бүртгүүлдэг, эсхүл аар саархан ажил төрөлд зарах байдлаар ялыг эдлүүлж байгаа нь тодорхой болсон юм¹¹. Судалгааны ажлын явцад нийтэд тустай ажлын төрөл зүйлийг маш нарийн зөв хуульчлан тогтоож, ял эдлүүлэлтийн үр нөлөөг сайжруулсан тохиолдолд Эрүүгийн хуульд энэ төрлийн ялыг нэмэгдүүлэх бодит боломж нээгдэх бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олон нийтээс тусгаарлахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх орчин үеийн чиг хандлагатай бүрэн нийцнэ гэж дүгнэжээ¹².

Дээрх судалгааны дүнгээс харахад нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөөг дээшлүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг зөрчихгүй байхад анхаарах зайлшгүй шаардлагатай болох нь харагдаж байна.

Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ¹³ гэж заасан байдаг. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас чухамхүү ямар шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн тухайн байгууллагуудыг сонгосон нь тодорхойгүй, ямар төрлийн нийтэд тустай ажил байгааг үндэслэн байгууллагыг жагсаалтад оруулсан нь ойлгомжгүй байгаа болно.

Дэлхийн бусад улс орнуудад ял шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагыг бус, эсрэгээрээ хийх ажлын жагсаалтыг баталж, ялыг эдлүүлж байна. Тодруулбал,

Швед Улсад ялтны хийх ажлын жагсаалтыг Нийгмийн халамжийн сайд нь гаргадаг бөгөөд нийгмийн халамж, үйлчилгээний ажлын жагсаалтад 80 гаруй төрлийн ажил байдаг байна.

Грек Улсад ажлын жагсаалтыг Хууль зүйн сайд баталдаг бөгөөд уг ялыг бүтээн байгуулалт, боловсролын чиглэлээр эдлүүлдэг.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, журамд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр ажилд гарахаас өмнө өгсөн эсэхэд хяналт тавих субъект тодорхойгүй байна. Судалгааны явцад манай улсад энэ төрлийн ялыг гол төлөв хот тохижилтын ажилд хэрэглэдэг болох нь тогтоогджээ¹⁴. Үүнээс үзэхэд гудамж, зам

¹¹ Нээлттэй нийгэм форум ТББ “Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт”-д дүн шинжилгээ хийсэн судалгааны тайлан. УБ.,2021.

¹² Нээлттэй нийгэм форум ТББ “Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт”-д дүн шинжилгээ хийсэн судалгааны тайлан. УБ.,2021.

¹³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.1 дэх хэсэг

¹⁴ Нээлттэй нийгэм форум ТББ “Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт”-д дүн шинжилгээ хийсэн судалгааны тайлан. УБ.,2021.

талбай цэвэрлэх ажил гүйцэтгэх явцад ялтан унаж бэртэх, цаашлаад эрүүл мэнд, амь насаараа хохирсон тохиолдолд ялтанд зааварчилгаа өгсөн эсэх, эрхийг нь хангасан эсэх асуудал гарцаагүй хөндөгдөнө.

Түүнчлэн нийтэд тустай ажил хийлгэж байгаа байгууллагын ажилтан чөлөөтэй байх, өөрөө ажил таслах, хоцорч ирэх зэрэгт ялтны цагийг хэн бүртгэх нь тодорхойгүйн улмаас ялтан тухайн өдөр ажилд гарахгүй байх, ялыг хэвийн эдлэх нөхцөл алдагдсанаар эрх нь зөрчигдөх үр дагавар үүсэж байна. Энэ талаар хууль, журамд тодорхой зохицуулаагүй.

2.3. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилттэй холбоотой зарим асуудал:

Уг ялыг цахим бугуйвч, техникийн тусламжтайгаар 2021 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, 3 жил гаруй хугацаанд ялын зорилгод нийцүүлэхээр хууль, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, ялын үр нөлөөг дээшлүүлэхэд чиглүүлэх шат дараалсан арга хэмжээг авч ажилласнаар хууль хэрэгжүүлэгч байгууллагуудад тодорхой хэмжээгээр жишиг тогтоод байна.

Гэвч бусад төрлийн ялтай харьцуулахад харьцангуй шинэ төрлийн ял учир практикт хэрэгжүүлэх явцад гарч буй ялтны эрхийг хөндсөн зарим асуудлыг авч үзэхэд,

Ялтанд шүүхээс тогтоосон бүс, цахим хяналтын системд зурсан хэмжээ, хязгаарын зураглалыг танилцуулахгүй байна. Мөн ахлах шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн прокурорын тогтоолоор зорчих бүсийг өөрчилсөн тохиолдолд ялтанд танилцуулах талаар Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох журамд тусгаагүй.

Үүнээс шалтгаалж ялтан цахим хяналтын системд шүүхээс тогтоосон бүсийг үнэн зөв бүртгэсэн эсэхийг мэдэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Энэ нь шүүхийн шийдвэрт тодорхой баг, хорооноос гарахыг хориглож шийдвэрлэсэн ялтнуудад хамааралтай. Учир нь баг, хорооноос гарч болохгүй байдлаар зорчих бүсийг шүүхээс тогтоосон ялтнуудын хувьд аль зам, гудамж, талбай, үйлчилгээний төв, сургууль, цэцэрлэг, эмнэлэг эмийн сан тухайн баг, хорооны нутаг дэвсгэрт орохгүй гэдгийг нарийн мэдэх боломжгүй, мэдээ, мэдээлэлгүйгээс болж зорчих бүсээс гардаг, энэ нь хуульд зааснаар зөрчилд тооцогдож, ялтны эрх зүйн байдлыг дордуулж байна.

Өөрөөр хэлбэл баг, хорооны нутаг дэвсгэрийн ялгах тэмдэг, тэмдэглэл байхгүй тул ялтанд тухайн баг, хорооны нутаг дэвсгэрийн хүрээ, хязгаарыг мэдсэн байх ёстой гэсэн шаардлагыг тавих нь ялтны хуулиар хүлээсэн үүрэг гэж үзэхэд эргэлзээтэй юм.

“Шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг техникийн хяналтын санд үнэн зөв бүртгэсэн байдал”-ыг улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар шалгахад шүүхээс тогтоосон зорчих бүсийг багасгасан, буруу тогтоосноос 188 ялтны эрхийг зөрчсөн¹⁵ болох нь тогтоогдсон байна. Энэ нь прокурор хяналтаараа ял эдлүүлэх ажиллагааны явцад зөрчигдсөн эрхийг сэргээж буй эерэг үзүүлэлт хэдий ч зөрчил гарсан шалтгаан нөхцөлийг ялтны эрхийг хууль, журамд тусгаж, баталгаажуулаагүйтэй холбоотой гэж үзэж болохоор байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “... эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах...” эрхтэй¹⁶ гэж заасан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүхээс

¹⁵ Прокурорын байгууллагын үйл ажиллагааны тайлан, УБ, 2023, 79 дахь тал,

¹⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг

тогтоосон бүсэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжгүй бол зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр өөрчлөхөөр зохицуулжээ.

Гэтэл хууль, журамд ялтны хүсэлтийг шийдвэр гүйцэтгэгч ямар хугацаанд шийдвэрлэж, прокурорт санал гаргах нь тодорхойгүй. Тухайлбал, аймгийн төвийн тодорхой багуудаас гарахгүй байх, эсхүл аймгийн төвөөс алслагдмал сумын нутаг дэвсгэрээс гарахыг хориглосон ялтнуудын хувьд амралт, баярын өдрүүдэд яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ авах, ялтны бие гэнэт муудах өвдөх, эсхүл хүүхэд болон гэр бүлийн гишүүд нь өвдөхөд аймагт хүргэх зэрэг нөхцөл байдал үүсэхэд тухайн ялтан шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэх, шийдвэр гүйцэтгэгчээс прокурорт утсаар урьдчилан танилцуулах, зорчих бүсийг түр өөрчлөх **эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хойшлуулшгүйгээр, прокурорын зөвшөөрөлгүй явуулж болох эсэх** нь ойлгомжгүй,

Түүнчлэн хуулиар хүндэтгэн үзэх бусад үндэслэлээр ялтны зорчих бүсийг түр өөрчилж болохоор тусгасан. Монгол Улсын Үндсэн хуульд "...шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй...сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ..."¹⁷ гэж заасан бөгөөд зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтан сонгуульд санал өгөх эсэх, сонгох эрхийг хангах үүднээс зорчих бүсийг түр өөрчлөн шийдвэрлэх эсэх, хүндэтгэн үзэх бусад үндэслэл гэдэгт юуг ойлгох нь тодорхойгүй байна.

Гурав. Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялын зохицуулалтыг боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэх талаар дүгнэлт, санал, зөвлөмж

Дүгнэлт

Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг эдлүүлэх явцад үүсэх зарим асуудлыг хууль, журамд нарийвчлан зохицуулаагүй нь хүний эрхийг зөрчиж, ялын үр нөлөөг бууруулж байгааг харуулж байна. Иймд ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрхийг зөрчихгүй байх, хорихоос өөр төрлийн ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулах, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгайлсан журам, аргачлал боловсруулах,

Улсын хэмжээнд торгох ялыг биелүүлэх хугацааг өөр байдлаар, янз бүрээр тооцож буй нь Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нарийвчилсан зохицуулалтгүй, ялтан уг ялыг эдлэх явцад хуулиар олгосон эрхээ эдэлж чадахгүй сөрөг үр дагаврыг бий болгосон. Бодит байдалд **"ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого болох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөх"** хуулийн заалт, **"хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх"** зарчмыг алдагдуулсан,

Хууль сахиулах салбарын хөгжлийн хүрээнд "...технологийн дэвшилд суурилсан, хүний оролцоог багасгасан, ухаалаг системүүдийг нэвтрүүлэх..." талаар дурдсан байдаг.¹⁸ Тиймээс зөвхөн зорчих эрхийг хязгаарлах ялаар хязгаарлахгүйгээр нийтэд

¹⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх хэсэг

¹⁸ Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого

тустай ажил хийлгэх ялын үр нөлөөг дээшлүүлэх, боловсронгуй болгох, ялтны эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зарим ажиллагааг техникийн тусламжтайгаар гүйцэтгэх арга барилыг нэвтрүүлэх нь зохистой. Учир нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт сум хариуцсан хэсгийн төлөөлөгч нараар дамжуулан нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны ялын биелэлтийг хангуулдаг. Ялтан ажилд ирсэн, явсан хугацааг техникийн тусламжтайгаар бүртгэх нь ялтны эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой,

Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтан хүндэтгэн үзэх шалтгаанаар зорчих бүсээс шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэхгүйгээр гарсан тохиолдолд ял эдлүүлэх нөхцөл, журмыг зөрчсөн гэж эрхийг нь хөндөж болзошгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Санал, зөвлөмж

Дээрх дүгнэлтэд тулгуурлан 2015 оны Эрүүгийн хуульд шинээр тусгагдсан зорчих эрхийг хязгаарлах ял болон торгох, нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэх явцад хүний эрхийг хамгаалах, зөрчилдөхөөс урьдчилан сэргийлэх, ялын үр нөлөөг дээшлүүлэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан тушаалаар баталсан “Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-д заасан ял эдлүүлэх ажиллагааны тухай зохицуулалтыг боловсронгуй болгох талаар:

1. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч нь тогтоол, магадлал хэзээ хүчин төгөлдөр болсон нь тодорхойгүй бол эрүүгийн гүйцэтгэх баримт бичгийг олгосон шүүхэд буцаах заалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэх;

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас торгох ялыг биелүүлэх шүүхээс тогтоосон хугацаа дууссан” бол ялтанд ашигтайгаар ял эдлүүлэх ажиллагааг явуулах зохицуулалтыг тусгах;

3. Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга баталсан нь олон улсын гэрээ конвенц, эрүүгийн хууль тогтоомжийн үзэл баримтлал, агуулгад нийцэж байгаа эсэхийг анхаарч, нийтэд тустай ажлын жагсаалтыг Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар батлах хэрэгцээ шаардлага бий эсэхийг тодорхойлох;

4. Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны цагийн бүртгэлийг “цаг бүртгэлийн төхөөрөмж”-өөр бүртгэх, ялтанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, хяналт тавих албан тушаалтны эрх, үүргийг “Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-д нэмэлтээр оруулах;

5. “Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-д ял эдлүүлэх ажиллагааг эхэлмэгц шүүхээс тогтоосон бүс, цахим хяналтын системд зурсан зураглалыг ялтанд танилцуулдаг байхаар тусгах;

6. Ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Улсын дээд шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар,

Цагдаагийн ерөнхий газраас хамтарсан ажлын хэсэг байгуулж, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах санал, зөвлөмжийг та бүхэнд уламжилж байна.

Ашигласан эх сурвалж

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (Шинэчилсэн найруулга). 2017.
3. Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга). 2017.
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017.
5. Прокурорын тухай хууль. 2017.

ХОЁР. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

6. Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм. 1990.

ГУРАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛ, НОМ

7. Батсүх О. "Эрүүгийн эрх зүй ерөнхий анги". УБ., 2021.
8. Беккариа Ч. "Гэмт хэрэг ба ялын тухай" /сонгодогууд цуврал/ Орч Г.Эрдэнэбат. УБ., 2009.
9. ШШГЕГ, ДХИС. "Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, чиг хандлага" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2020.
10. Нээлттэй нийгэм форум ТББ. "Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт" судалгааны тайлан. УБ., 2021.
11. Нээлттэй нийгэм форум ТББ. "Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт" судалгааны тайлан. УБ., 2022.
12. Э.Батцэрэн Б.Амарбат нар. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ сургагч багшийн гарын авлага. УБ., 2017.
13. Прокурорын байгууллагын үйл ажиллагааны тайлан, УБ., 2023.
14. Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
15. Монгол Улсын Прокурорын байгууллагын стратеги төлөвлөгөө 2023-2026.

ДӨРӨВ. ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ

16. www.legalinfo.mn
17. www.prokuror.mn
18. www.forum.mn

ЦАГДАН ХОРИХ, БАРИВЧЛАХ, СААТУУЛАХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Дорноговь аймгийн Прокурорын газрын хяналтын прокурор Б.Мөнгөнтуяа

Хураангуй:

Хүнийг цагдан хорих, баривчлах, саатуулах шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллагааны явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон “бэлгийн цөөнх” гэж нэрлэгдэх лесбиян, гей, бисексуал, трансжендэр болон интерсекс хүмүүсийн эрх чөлөөтэй байх, хувийн халдашгүй эрхээ эдлэх эрхэд хуульд заасан үндэслэл, журмын дагуу халдаж, тодорхой хугацаанд нийгмээс тусгаарлах тохиолдолд тэдгээрийн жам ёсны эрх, эрх чөлөөг хэрхэн хангах, эрхийг зөрчихгүй байхад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах, улмаар шийдвэрлэх арга замыг тодорхойлох талаар энэхүү илтгэлээр авч үзсэн болно.

Түлхүүр үгс:

Цагдан хорих, баривчлах, саатуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон “бэлгийн цөөнх” гэж нэрлэгдэх лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс хүмүүсийн халдашгүй эрх, эрх чөлөө.

Удиртгал

Хүний эрх бол хүнээс салшгүй, заяамал бөгөөд хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил тэгш эрх чөлөөтэй, үнэ цэнэтэй амьдрах ёстой.

Өөрөөр хэлбэл хүний эрх гэдэг ойлголт нь хүн болж төрснийхөө хувьд заяагдсан, өөр хоорондоо ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран эдэлвэл зохих эрх, эрх чөлөөг хэлдэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “...халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. ...” гэж заасан нь хүний өөрийнх нь жам ёсны эрхээс үүдэлтэй олон улсын хэм хэмжээгээр баталгаажсан хүний халдашгүй байх эрхтэй холбоотой хуулийн зохицуулалт юм.

Тэгвэл Үндсэн хуулиар баталгаажсан хүний жам ёсны эрх болох “Хүний халдашгүй байх” эрхэнд гагцхүү хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад халдах шаардлага зайлшгүй гардаг бөгөөд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд сэжигтнийг шүүхийн шүүхийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй баривчлах, цагдан хорих, зөрчилд холбогдсон хүнийг саатуулах, баривчлах шийтгэл оногдуулах зэргээр тодорхой хугацаанд нийгэм, иргэдээс тусгаарлан, зориулалтын байранд хорих шаардлагатай болдог.

Энэ тохиолдолд хүний жам ёсны эрхийг тодорхой хугацаанд хязгаарласан тохиолдолд уг шийдвэрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, тухайлбал, холбогдох хууль тогтоомжийн зохицуулалт нь олон улсын хүний эрхийн зарчимд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийн, улмаар хүний эрхийг хангахад чиглэгдсэн хууль, журам, зааврыг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудлыг дурдах, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход энэ илтгэлийг агуулга, зорилго оршино.

Өөрөөр хэлбэл 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, зааврын хэрэгжилт практик ямар түвшинд байгаад дүгнэлт хийхийн зэрэгцээ хүний эрхийн тулгамдсан асуудлыг тодорхойлоход ач холбогдолтой болох юм.

Үндсэн хэсэг

Монгол Улсын өнөөгийн байдлаар Нэгдсэн Үндэстний байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагаас батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 70 гаруй гэрээ, конвенцод нэгдсэн орсон байдаг.

Аливаа улс олон улсын гэрээ конвенцод нэгдэн орсноор тухайн гэрээ конвенцын заалтыг дотоодын хууль тогтоомжид тусгах үүрэг хүлээсэн бөгөөд энэ үүргийнхээ хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар холбогдох хороодод жил бүр тайлангаа хүргүүлсээр ирсэн байна.

Илтгэлээр хөндөх асуудлын нэг бол “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” түүнд нийцүүлэн гаргасан “Хорих байрны дотоод журам”-ын эрх зүйн үндэслэл, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, түүнд нийцүүлэн гаргасан “Баривчлах байрны дотоод журам”, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан “Саатуулах байрны дэглэм, журам” зэрэг хүний эрхийг хязгаарлахтай холбоотой дээрх хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон “бэлгийн цөөнх” гэж нэрлэгдэх лесбиян, гей, бисексуал, трансжендэр болон интерсекс хүмүүсийн эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудалтай уялдуулан тусгах талаар санал дэвшүүлж байна.

Монгол Улс нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протоколыг 2009 онд соёрхон баталсан юм.

Энэхүү конвенцын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхүүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ гэж тусгасан байдаг.

Түүнчлэн дээрх конвенцод хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх чөлөөтэй байх, хувийн халдашгүй эрхээ эдлэх эрхэд хуульд заасан үндэслэл, журмын дагуу халдаж, түүний эрх чөлөөг аливаа хууль журмын дагуу хассан бол уг тохиолдолд оролцогч улсууд нь бусадтай адил тэгш нөхцөлийн үндсэн дээр боломжит хэрэглэгдэхүүнээр

хангахыг оролцуулан энэхүү конвенцын зорилго, зарчим болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн байдлаар тэдэнд хангах талаар тусгасан байдаг.

Энэ ч утгаараа Монгол Улс нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нийцүүлэн УИХ-аас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталж, одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд энэхүү хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршдог.

Түүнчлэн уг хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан “хууль зүйн туслалцаа авах эрх”-ийн хүрээнд “Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.” гэх, “Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүнд түүний эрх, үүрэг болон холбогдох мэдээллийг хөгжлийн бэрхшээлийн онцлогт нь нийцүүлэн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр тайлбарлаж өгнө.” гэх, “Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд тэдгээрийг текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах ба үйлчилгээний зардлыг улсын төсөвт тусгана.” гэх зохицуулалтуудыг хуульд тусгаж өгсөн байх боловч өнөөдрийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэмт хэрэгт холбогдож, түүнийг зайлшгүй цагдан хорих үндэслэл тогтоогдсон, зөрчилд холбогдсон бол зайлшгүй саатуулах, баривчлах шийтгэлийг эдлүүлэх тохиолдолд цагдан хорих, саатуулах, баривчлах шийдвэрийг хэрэгжүүлэхэд тэдгээрт бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг хэрхэн үзүүлэх, түүнчлэн “дохионы хэлний хэлмэрч, орчуулагч” гэж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилдэг хүнийг оролцуулах талаарх эрх зүйн зохицуулалтыг “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” түүнд нийцүүлэн гаргасан “Хорих байрны дотоод журам”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, түүнд нийцүүлэн гаргасан “Баривчлах байрны дотоод журам”, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан “Саатуулах байрны дэглэм, журам”-д тус тус тусгаж, эрх зүйн үндэслэлийг тодорхойлоогүй байна.

Орчин үед “бэлгийн цөөнх” гэж нэрлэгдэх лесбиян, гей, бисексуал, трансжендер болон интерсекс (цаашид ЛГБТ хүн гэх) хүмүүс аль ч улс оронд амьдардаг. Тухайн улсын нийт хүн амын 10 гаруй хувийг лесбиян, гей, бисексуал, трансжендер хүмүүс эзэлдэг гэсэн судалгааны дүн байдаг боловч, улс тус бүрээр нь авч үзвэл энэ тоо харилцан адилгүй байдаг ажээ¹.

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл нь төрөлхийн бөгөөд өөрчлөгддөггүй гэдгийг дэлхийн олон эрдэмтэн судлаачид тогтоосон байна².

¹Эмэгтэй хүн эмэгтэй хүндээ сэтгэл, хайр дурлал, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй дотно ба бэлгийн харилцаа үүсгэх гүн гүнзгий мөн чанар, чадвар юм..

² Аль аль хүйсийн хүмүүст сэтгэл, хайр дурлал, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй дотно ба бэлгийн харилцаа үүсгэх гүн гүнзгий мөн чанар, чадвар юм. Өөрийнхөө хүйсийг төрсөн хүйсээсээ өөрөөр

Улмаар 1973 онд АНУ-ын Сэтгэл судлаачдын холбоо бэлгийн чиг баримжааг сэтгэцийн өвчний жагсаалтаас, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 1990 онд тус тус хасжээ. Ингэснээр “сэтгэцийн өвчин, гаж үзэгдэл биш” гэдгийг нотолж, эдгээр хүмүүсийн эрх, эрх чөлөөг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч байна³.

Өнөөдөр ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн төлөв байдал, тэдний улс төрийн оролцоо, ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа бүхий хосуудын гэрлэлт, трансжэндэр иргэдийн хүйсийн шилжилт, эрүүл мэндтэй холбоотой асуудлууд нь НҮБ-ын хүний эрхийн механизмд бүс нутгийн түвшинд ч анхаарлын төвд байсаар байна.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заасан байх бөгөөд энэхүү заалтын эх суурь нь “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэхүү Пактад оролцогч улсууд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр энэхүү пактад тунхагласан эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгох үүрэгтэй” гэж, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй” гэж, 26 дугаар зүйлд “Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчлах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчлахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой” гэж тус тус заасныг үндэслэн дотоодын хуульд тусгасан байна.

Монголчуудын уламжлал, зан заншил болон нийгмийн сэтгэлгээнд тохирохгүй гэсэн хандлагыг өөрчилж, эдгээр хүмүүсийг ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлж, эрх, эрх чөлөөг нь бодитойгоор эдлүүлэхэд чиглэсэн төрийн бодлого, үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай боллоо.

Учир нь ЛГБТ хүмүүс бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээсээ болж үзэн ядагдах, гэмт халдлагад өртөх, гэмт хэргийн хохирогч, холбогдогч болох тохиолдол өндөр байх магадлал харагдаж байна⁴.

буюу эсрэгээр гүн гүнзгий мэдэрч, тодорхойлж, тэр тодорхойлсноороо амьдардаг хүн. Бэлгийн чиг баримжааны хувьд трансжэндэр хүмүүс стрэйт, лесбиян, гей, бисексуал байж болдог.

³Лесбиян, гей, бисексуал, трансжэндэр, интерсекс зэрэг бэлгийн цөөнхийг нэрлэсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр томъёо, товчлол. Энэ нь ижил хүйсийн бэлгийн зан үйл, харилцаа, хүйсийн онцлог шинжийг илэрхийлнэ. ХЭҮК, “ЛГБТ Төв” ТББ, “Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа. 2012.

⁴Лесбиян, гей, бисексуал, трансжэндэр, интерсекс зэрэг бэлгийн цөөнхийг нэрлэсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр томъёо, товчлол. Энэ нь ижил хүйсийн бэлгийн зан үйл, харилцаа, хүйсийн онцлог шинжийг илэрхийлнэ. ХЭҮК, “ЛГБТ Төв” ТББ, “Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа., 2012.

Энэ нь монголчуудын уламжлал, зан заншил болон нийгмийн уламжлалт сэтгэлгээнд тохирохгүй гэсэн хандлагыг өөрчилж эдгээр хүмүүсийг ялгаварлан гадуурхалтад өртөх, улмаар тэдгээр хүмүүсийг гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тохиолдолд хууль, эрх зүйн орчин дахь эрх, эрх чөлөөг нь бодитойгоор эдлүүлэх шаардлага тулгарч байна.

Монгол Улсад Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хэрэгжиж байгаа “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” нь Монгол Улс анх удаа 1999 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталж, 1999 оны 08 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд энэ хугацаанд дээрх хуульд 2000 онд 2, 2002 онд 15, 2003 онд 1, 2013 онд 1, 2017 онд 23, 2020 онд 2, 2024 онд 2 заалтад тус тус нэмэлт өөрчлөлт орсон байх бөгөөд энэхүү хууль батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр цагдан хорих байрны стандарт, шаардлагыг тогтоож өгсөн юм.

Энэ хуулийг хэрэгжиж байх хугацаанд эрүүгийн процессын хууль 2002, 2015 онд тус тус шинэчлэгдэн өөрчлөгдсөн, түүнчлэн цагдан хорих байрны харьяалал нь 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар цагдаагийн байгууллагын хяналтаас гарч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжихийн зэрэгцээ баривчлах, цагдан хорих шийдвэрийг буюу зөвшөөрлийг Монгол Улсын нэгдэн орсон хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой олон улсын гэрээ конвенцын хэм хэмжээнд нийцүүлэн шүүх шийдвэрлэхээр тогтоосон юм.

Түүнчлэн “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Хорих байранд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан “Хорих байрны дотоод журам”-ыг дагаж мөрдөнө.” гэж заасны дагуу Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дугаар тушаалаар батлагдсан “Хорих байрны дотоод журам”-ыг батлан одоог хүртэл баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд дагаж мөрдөж байгаа билээ.

Уг журамд зааснаар хоригдох этгээдийг хүлээн авах, хорих өрөөнд байрлуулах; хоригдсон этгээдэд хориглох зүйл; хоригдсон этгээдэд өгөх цай, хоолны хэмжээ, хоригдол тус бүр хоолоо идэж байгаа эсэхэд хяналт тавих; хоригдсон этгээдийн бие, эд зүйлд үзлэг хийх; хоригдсон этгээдийг эргэх, түүнтэй уулзах; хоригдсон этгээд захидал, цахилгаанаар харилцах; хоригдсон этгээд ном, сонин, сэтгүүл ашиглах; хоригдсон этгээд шашны зан үйл үйлдэх; хоригдсон этгээдийн эмнэлэг, ариун цэврийн үйлчилгээ; хоригдсон этгээдийг салхилуулах; хоригдсон этгээдийг мөрдөн байцаах ажиллагаа, шүүх хуралдаанд оруулах, буцаан авчрах; хорих өрөөнд гаднаас хүн ороход түүний аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлыг журамлан зохицуулсан юм.

Мөн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад зөрчлийн холбогдогчийг саатуулах, улмаар зөрчил үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд 7-30 хүртэл хоногоор баривчлах шийтгэл оногдуулах зэргээр зөрчлийн хэргийн холбогдогчийг тодорхой, богино хугацаанд нийгмээс тусгаарлах эрх зүйн зохицуулалт бүрджээ.

Үүнтэй холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/192 дугаартай тушаалаар батлагдсан “Саатуулах байрны дэглэм, журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/246 дугаар тушаалаар батлагдсан “Баривчлах байрны дотоод журам” зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг зөрчлийн холбогдогчийг саатуулах, баривчлах шийдвэрийг хэрэгжүүлж байна.

Гэтэл гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон “бэлгийн цөөнх” гэж нэрлэгдэх лесбиян, гей, бисексуал, трансжендэр болон интерсекс хүмүүсийг тодорхой хугацаанд нийгмээс зайлшгүй тусгаарлах тохиолдолд тэдгээрийг цагдан хорих, баривчлах, саатуулах байранд хүлээн авч, шийдвэрийг хэрэгжүүлэх тохиолдолд жам ёсны эрх, эрх чөлөөг хэрхэн хангах, эрхийг зөрчихгүй байхад чиглэгдсэн зохицуулалтыг дээрх хууль тогтоомжид тусгаж өгөөгүй байна.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй болон бэлгийн цөөнх хүмүүсийн эрх, эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны зарчимд үндэслэсэн хүний жам ёсны эрхүүд болох амьд явах, халдашгүй дархан байх, эрүү шүүлтээс ангид байх зэрэг эрхүүдийг хангахад чиглэгдсэн эрх зүйн шинэчлэлийг хийх шаардлага тулгарч байна.

Олон улсын түвшин дэх ЛГБТЕ хүмүүсийн эрх зүйн зохицуулалт:

ЛГБТЕ хүмүүсийн хүний эрхийг ханган хамгаалах олон улсын үйл явц 1994 оноос эрчимжиж, олон улсын эх зүйн хэм хэмжээд тусгалаа олж эхэлсэн нь НҮБ-ын Иргэний болон улс төрийн олон улсын пактын хэрэгжилтийг хянах Хүний эрхийн хорооноос гаргасан зөвлөмжтэй холбоотой ажээ.

1992 онд Австрали Улсын иргэн Николас Түүнэн НҮБ-ын Хүний эрхийн хороонд насанд хүрсэн ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүмүүс хувийн орон зайдаа бэлгийн хавьталд орохыг “ёс бус бэлгийн хавьтал” хэмээн холбооны тогтолцоотой Австрали Улсын Тасмани мужийн Эрүүгийн хуулиар шийтгэдэг байсныг лесбиян, гей хүмүүсийг бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан шийтгэх нь ялгаварлан гадуурхалт мөн, бэлгийн чиг баримжаа нь хүйс хэмээх зүйлтэй салшгүй холбоотой тул ийм төрлийн ялгаварлан гадуурхалт нь Австрали Улсын Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын дагуу хүлээсэн үүрэгт үл нийцсэн эрүүгийн зохицуулалт тул хүчингүй болгох асуудлыг дэвшүүлж байсан байна.

Хүний эрхийн хороо нь 1994 оны 03 дугаар сарын 31-нд хуралдан, энэхүү гомдлыг авч хэлэлцэн, бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхах, шийтгэх нь хүйст үндэслэсэн ялгаварлан гадуурхалт мөн тул Тасмани мужийнхаа Эрүүгийн хуулийн зохих заалтыг хүчингүй болгох, Австрали Улс даяар бэлгийн чиг баримжаанд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг дуусгавар болох ёстой гэсэн шийдвэрийг Австрали Улсад зөвлөж байсан байна.

Харин 2011 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл нь ЛГБТЕ хүмүүсийн эсрэг хаана ч гарсаар байгаа үзэн ядалт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг зогсоох зорилгоор Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа ба хүний эрх, 2014 онд мөн зөвлөлөөс Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа ба хүний эрх, 2016 онд мөн зөвлөлөөс Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаанд үндэслэсэн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас хамгаалах нь гэсэн тогтоолуудыг тус тус гаргасан нь олон улсын түвшинд ЛГБТЕ хүмүүсийн эрхийг хамгаалах эрх зүйн үндэслэл нь болсон байна.

ЛГБТЕ хүмүүсийн эрхэд хамаарах Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээ:

Монгол Улс нь 2012 оны 11-р сард засгийн газар хоорондын Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ)-д жинхэнэ гишүүнээр элссэнээр Европын хүний эрхийн хэм хэмжээ Монгол Улсад мөн хамааралтай болсон юм.

ЕАБХАБ нь одоогоор дэлхий дахинаа хамгийн хөгжингүй үзэн ядалтын эсрэг эрх зүйн хэм хэмжээг тодорхойлж чадсанаараа алдартай ба үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэгт ялангуяа ЛГБТЕ хүмүүс бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээрээ өртдөгийг цохон, ЛГБТЕ хүмүүс болон бусад цөөнхийг тэгш хамгаалах бүх арга хэмжээг авахыг гишүүн орнууддаа үүрэг болгодог байна.

Иймд Монгол Улсын нэгдэн орсон бүх гэрээ конвенцод ЛГБТЕ хүмүүсийн хүний эрхэд хамааралтай заалтууд байдаг нь бүх гэрээ конвенцод хүн бүр тэгш ба ямар байдлаар, тэр дундаа хүйсээр ялгаварлахгүй хэмээх зарчим багтсантай уялдаатай.

Түүнчлэн ЛГБТЕ хүмүүсийн хүний эрхийг ханган хамгаалах асуудлыг 2011 оны 05 дугаар сарын 18-нд батлагдсан Засгийн газрын 159-р тогтоол, 2013 оны 07 дугаар сарын 03-нд батлагдсан УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 13-р тогтоол, 2015 оны 12 дугаар сарын 03-нд батлагдсан шинэчилсэн Эрүүгийн хууль, 2013, 2014, 2017 онуудад батлагдсан эрүүл мэндийн салбарын мэргэжилтний ёс зүй, салбарын хөгжил болон эрүүл мэндээр баримтлах засгийн газрын бодлогод “бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаар үл ялгаварлах” гэсэн заалтууд орж ирсэн талаар “ЛГБТИ - Хүний эрх” гарын авлагад дурдсан байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад ЛГБТЕ хүмүүсийн эрхийн асуудлыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрсөн байх тул эдгээр хүмүүсийн хууль эрх зүйн орчин дахь эрх, эрх чөлөөний асуудал зайлшгүй тавигдаж байна.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон “бэлгийн цөөнх” нь өдөр тутмын амьдралдаа ялгаварлан гадуурхалтад байнга өртдөг бөгөөд гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан цагдан хорих, саатуулах, баривчлах шийтгэл эдлүүлэх тохиолдолд бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс илүүтэй эрх зөрчигдөх магадлал өндөр байх бөгөөд цагдан, хорих, баривчлах, саатуулах байранд байрлуулахдаа бусад хүмүүсээс тусад нь байрлуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний эдлэх эрх, хүлээх үүргийг хууль тогтоомжид хөнгөлөлттэй байдлаар тогтоож өгөх шаардлагатай байна.

Хэдийгээр гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгуулж байгаа ч цагдан хорих, баривчлах, саатуулах байрны стандарт шаардлага нь эдгээр хүмүүст хэрэгцээ шаардлагыг хангасан зориулалтын тоног, төхөөрөмж байдаггүй талаар хүний эрхийн чиглэлийн байгууллагуудын хяналт шалгалтаар тогтоогдсон байдаг.

ХБНГУ-ын нэгэн мужийн хорих ангид хөгжлийн бэрхшээлтэй хүний зорчих зам, ариун цэврийн зориулалтын тоноглол бүхий суултуур, хоолны газрын тусгай зориулалтын суудлыг шийдсэн байна. Нөгөө талаас хамт хоригдож буй хүмүүсээс гадна хууль сахиулагчдын хандлага тэднийг ялгаварлан гадуурхах, тусгай хэрэгцээтэй гэдгийг нь ойлгохгүйгээр шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах нь нэг талын эрүүдэн шүүлт гэж үзэхээр болно.

Түүнчлэн Монгол Улсад өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болон ЛГБТ хүмүүст хөдөлмөр, эрхлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, боловсрол, гэр бүл, хэвлэл мэдээллийн чиглэлээр тулгарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудлыг хөндөж яригдаж байгаа хэдий ч тэдгээр хүмүүс гэмт хэрэг зөрчилд холбогдон цагдан хоригдох, саатуулагдах, баривчлагдах тохиолдолд эрх, эрх чөлөөг нь зөрчихгүйгээр эрх хязгаарлах шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх төрийн бодлого шаардлагатай байна.

Иймд одоогийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” түүнд нийцүүлэн гаргасан “Хорих байрны дотоод журам”-ын эрх зүйн үндэслэл, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, түүнд нийцүүлэн гаргасан “Баривчлах байрны дотоод журам”, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан “Саатуулах байрны дэглэм, журам” зэрэг хүний эрхийг хязгаарлахтай холбоотой хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон “бэлгийн цөөнх” гэж нэрлэгдэх лесбиян, гей, бисексуал, трансжэндэр болон интерсекс хүмүүсийн эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудалтай уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулах, шаардлагатай бол хуулийг шинэчлэн батлуулах арга хэмжээ авах зэргээр хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон “бэлгийн цөөнх” гэх хүмүүсийн хууль эрх зүйн орчин дахь эрх, эрх чөлөөг хангахад чиглэгдсэн эрх зүйн шинэтгэл хийх нь зүйтэй байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж

Хөгжлийн бэрхшээлтэй болон бэлгийн цөөнх гэх хүмүүсийн суурь буюу жам ёсны эрхийг хангах ор, шат, нийтийн зам, ариун цэврийн болон хоол, байрлах өрөөний стандартуудыг хүний эрхийг хязгаарлахтай холбоотой хууль тогтоомжид тодорхой тусгаж өгөх, өөрөөр хэлбэл Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” түүнд нийцүүлэн гаргасан “Хорих байрны дотоод журам”-ын эрх зүйн үндэслэл, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, түүнд нийцүүлэн гаргасан “Баривчлах байрны дотоод журам”, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан “Саатуулах байрны дэглэм, журам” зэрэг хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах талаар үе шаттайгаар арга хэмжээ авах.

Тэдний хувьд хийсэн гэмт үйлдэлдээ буруутгагдан зорчих эрхээ хязгаарлуулж байгаа ч бусад цагдан хоригдсон хүмүүсээс илүү хөгжлийн бэрхшээл нь өөрт нь дарамт болж байгааг харгалзан тусгай өрөө гаргаж /бид эр, эм, хүүхэд гэж ангилдаг/ шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг хэрхэн үзүүлэх, түүнчлэн "дохионы хэлний хэлмэрч, орчуулагч" гэж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилдэг хүнийг оролцуулах зэрэг ажиллагаанд гарах зардлыг төсөвт нэмж тусгах шаардлагатай.

Улмаар “бэлгийн цөөнх” гэж нэрлэгдэх лесбиян, гей, бисексуал, трансжэндэр болон интерсекс хүмүүсийн талаарх хууль сахиулах байгууллагын алба хаагч нарын бэлгийн чиг баримжаа болон хүйсийн илэрхийлэлтэй холбоотой онолын ойлголтыг

нэмэгдүүлэх, мөн тэдгээртэй хэрхэн харилцах чиглэлээрх сургалт зохион байгуулах саналыг дэвшүүлж байна.

Ашигласан эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Прокурорын тухай хууль
3. Сэжигтэн, яллагдагчийг, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль / 1999 он /
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль / 2015 он /
5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль / 2015 он /
6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай / 2016 он /
7. Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын факт / 1979 он /
8. Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын факт / 1966 он/
9. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц / 2019 он /
10. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц / 2006 он /
11. Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ийн холбогдох хороодоос Монгол Улсад өгсөн зөвлөмжийн эмхэтгэл / 2014 он /
12. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэл / 2013 он /
13. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл / 2023 он /
14. Эрүү шүүлтээс ангид байх эрх / 2020 он /
15. Хүний эрхийн баримт, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл / 2014 он /
16. Азид ЛГБТ байх нь: Монгол Улсын тайлан лесбиян, гей, бисексуал, трансжендэр, хүмүүс, иргэний нийгмийн хууль эрх зүй, нийгмийн орчны оролцоонд суурилсан үнэлгээ шинжилгээ /2014 он/
17. ЛГБТИ - Хүний эрх /Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарт зориулсан гарын авлага – 2018 он/

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ, ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Налайх, Багахангай дүүргийн прокурорын газрын
ахлах прокурор М.Батхишиг

Хураангуй:

Аль ч улс орон иргэнийхээ эрх, эрх чөлөөг Үндсэн хуулиар хамгаалж баталгаажуулдгийн нэгэн адил манай улс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц баталгааг бүрдүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцахаар Монгол Улс Үндсэн хуульдаа¹ хуульчилсан байна.

Иргэний Үндсэн хуулиар хамгаалж баталгаажсан эрх, гэмт хэрэг үйлдэж, шүүхийн шийдвэрээр ял, шийтгэл хүлээсэн хүний хувьд Эрүүгийн хууль тогтоомжоор хязгаарлагддаг боловч, энэхүү хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн суурь зарчим, хэм хэмжээнд нийцсэн байх нь хүний эрхийг зөрчихгүй байх боломжийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Иймд энэхүү илтгэлээр Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.4 дүгээр зүйлд заасан “Нийтэд тустай ажил хийлгэх” ялаар шийтгүүлсэн ялтны хуулиар хязгаарлагдсан “цалин хөлс олгохгүйгээр” нийтэд тустай ажил хийхээс бусад эрхийн хамгаалалт нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн суурь зарчим, хэм хэмжээнд нийцсэн эсэх, ялын үр нөлөө, хэрэгжилтийг сайжруулахад анхаарах шаардлагатай зарим асуудлыг хөндөхийг хичээлээ.

Түлхүүр үгс:

Эрүүгийн хууль, нийтэд тустай ажил хийлгэх ял, ялтны эрх, хүний эрх, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрсдэл.

Удиртгал

НҮБ-ийн Хүний эрхийн хорооноос Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын хэрэгжилтийн талаар Монгол Улсын ээлжит 6 дахь тайланг² 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдөр 3404 дэх чуулганаар хэлэлцээд дүгнэлт, зөвлөмж гаргасны 23-т “Хорихоос өөр төрлийн ял шийтгэлийг бий болгоход оролцогч улс хүчин чармайлт гаргасныг онцлон тэмдэглэж байна” гээд 24-д “Хорихоос өөр төрлийн ял шийтгэлийг хэрэглэх, ийнхүү хэрэглэхийг дэмжихэд гаргаж буй хүчин чармайлтыг нэмэгдүүлж, сайжруулах нь зүйтэй” гэсэн үүргийг өгчээ.

Монгол улс эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хорих ял нь нийгэм эдийн засгийн үр ашиг багатай, зардал ихтэй тул хорихоос өөр төрлийн ялыг оновчтой өргөн сонголттойгоор хэрэглэх нь эдийн засгийн төдийгүй хүмүүжлийн чухал ач холбогдолтой гэж үзэн 2015 оны Эрүүгийн хуулийн өөрчлөлт шинэчлэлтээр нийгмийн хор аюул бага гэмт хэрэгт хорих ял оногдуулахгүй байх, хорих ял оногдуулахаар заагаагүй хэрэгт

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

² Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол улс 2021 он 226 тал

нийтэд тустай ажил хийлгэх ялыг өргөн хэрэглэх бололцоо нөхцөлийг бүрдүүлж, 57 төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэхүү ялыг оногдуулахаар хуульчилсан байна.³

Эрүүгийн хуулийн шинэчлэлт өөрчлөлтийн үр дүнд өмнөх хуулиар жилд дунджаар 420 этгээд албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлж байсан бол шинэчлэн батлагдсан хуулиар жилд дунджаар 1400-1700 хүн шийтгүүлж,⁴ энэ төрлийн ялын хэрэглээ 3-4 дахин нэмэгдэж, эдийн засгийн ач холбогдлыг харуулж чадсан гэж үзэж болохоор байна.

Гэвч хэрэгжүүлэх арга хэлбэрт онцын өөрчлөлт ороогүй, ялтны хөдөлмөрлөх эрх “хүний эрх”-ийн суурь зарчим, хэм хэмжээтэй уялдаагүй, ялын үр нөлөөг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйлсийг нийгмийн өөрчлөлт шинэчлэлттэй уялдуулж сайжруулах арга хэмжээ аваагүйгээс ял эдлүүлэх ажиллагаанд олон хүндрэл бэрхшээлүүд тулгарч, үүнээс нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтан ялыг нийтийн эрх ашгийн төлөө сайн дураар эдлэхээс илүүтэй зайлсхийж, хорих ялаар солиулах тохиолдол жил ирэх тусам 1-1,5 хувиар⁵ өссөн үзүүлэлттэй байна.

Иймээс энэхүү илтгэлээр нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтнуудын хөдөлмөр эрхлэхтэй холбоотой харилцаанд холбогдох хууль тогтоомж, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, стандарт шаардлагад нийцсэн эсэхэд дүгнэлт хийж, цаашид энэ төрлийн ялын үр нөлөө хэрэгжилтийг сайжруулахад анхаарах шаардлагатай дараах 2 асуудлыг хэлэлцүүлэхийг зорилоо. Үүнд:

-Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны хуулиар хамгаалагдсан эрх, түүнийг ял эдлүүлэх ажиллагаанд хэрэгжүүлэх нь.

-Ял эдлүүлэх ажиллагаанд нийтэд тустай ажил хийлгүүлэх байгууллагын оролцоо, цаашдын хэрэгцээ шаардлага.

Үндсэн хэсэг

Нэг. Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны хуулиар хамгаалагдсан эрх, түүнийг ял эдлүүлэх ажиллагаанд хэрэгжүүлэх нь.

1.1. Монгол Улс Үндсэн хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд Монгол Улсын иргэн бүрийг “хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэхгүй байх”⁶-аар хувь хүний хөдөлмөр эрхлэхтэй холбоотой үндсэн эрх, суурь зарчмыг тодорхойлж, тэдний ажлын байранд тавигдах стандарт шаардлага, хөдөлмөрийн нөхцөл, ажлын байрны эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар тус тус хуульчилж хамгаалсан байна.

Энэхүү хүний эрхийн суурь хамгаалалт нь нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны хувьд цалин хөлс авах эрхээс бусдаар хязгаарлагдаагүй байх

³ Ц.Мөнхбат “Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт” Бодлогын судалгааны тайлан 2019 он.

⁴ \10.33.0.213 мэдээ. Мэдээ. 2013-2023 оны мэдээнүүд

⁵ \10.33.0.213 мэдээ. Мэдээ. 2013-2023 оны мэдээнүүд

⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэг
Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэг

боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд⁷ ялтны эрхийг тэднийг ажиллуулах байгууллагын “ялтанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, ажлын тусгай хувцас, хөдөлмөрийн багаж, хэрэгслээр хангах” үүргээр хязгаарлаж, ажлын байранд тавигдах стандарт шаардлага, хөдөлмөрийн нөхцөл, ажлын байрны эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх хамгаалалтыг хуульчлаагүй байна.

Өнөөдөр хорих ял эдэлж байгаа хоригдлын хөдөлмөр эрхлэхтэй холбоотой харилцааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.7-д “ял эдэлж байгаа хоригдол” гэсэн субъектийн хувьд хуулиар зохицуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийг нь хамгаалж хуульчилсан.

Харин мөн адил шүүхээр тодорхой эрхээ буюу цалин хөлс авахгүй байх эрхээ хязгаарлуулсан нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны хийж гүйцэтгэх ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн харилцааг тус хуулиар зохицуулаагүй, ялтны Эрүүгийн хуулиар хязгаарлаагүй эрх зөрчигдөх нөхцөл бүрдэж, цаашлаад ялтны амь нас эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд ажил олгогч байгууллага болон төрөөс хүлээх үүрэг хариуцлага тодорхойгүй байна.

Хэдийгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд ялтны хөдөлмөр эрхлэхтэй холбоотой харилцааг ялтны хувьд хоригдлын нэгэн адил хуульчлаагүй боловч, Монгол Улсын иргэнийхээ хувьд тус хуулийн 4.1.9-д зааснаар “хамтран ажиллах, ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр болон бусад хэлбэрээр ажил хөдөлмөр эрхэлж байгаа” хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлөө хангуулах эрхтэй этгээд юм.

Манай улсад нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны 70-аас дээш хувийг орон нутгийн “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т ялыг эдлүүлдэг жишиг хандлага, газар бүрд тогтоод удаж байна.

Тус байгууллагад ялтныг ажиллуулахад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасан⁸ “хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн аюултай, хортой, хүчин зүйлсийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байх, хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлсээс шалтгаалан хүний бие махбод, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж, өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдах эрсдэлгүй байх” шаардлагууд бүрэн хангагдсан эсэх нь тодорхойгүй, түүнд тавих хяналтыг холбогдох хууль тогтоомж, тушаал журмаар зохицуулаагүй байна.

Прокуророос хяналтын явцад нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтнуудын “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т ажиллаж байгаа байдалд судалгаа хийхэд⁹ ял эдэлсэн 20 ялтнаас 5 буюу 75 хувийг айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийн хог ачих ачигчийн ажлыг, 4 буюу 20 хувийг гудамж талбайн хог цэвэрлэх ажлыг, 1 буюу 2 хувийг бусад ажил буюу тухайн байгууллагын дотор гадна цэвэрлэгээ үйлчилгээ, дотоод ажилд туслах ажлыг тус тус хийж гүйцэтгүүлсэн байна.

⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.1 дэх хэсгийн 166.1.2

⁸ Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 18, 28 дугаар зүйл

⁹ 2023-2024 онд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны ял эдлэлтийн байдлыг танилцаж, шалгасан материалд үндэслэж тус газарт ял эдэлсэн 20 ялтны хүрээнд судалгааг хийсэн.

Тус байгууллагаас ялтныг ажилд гарахад нь хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа өгч, энэ талаарх тэмдэглэлд гарын үсэг зуруулж, тухайн байгууллагын 1 ажилтан жолоочийн хамт өдөрт дунджаар 20-30 айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийн 5-10 тонн хогийг өргөж, ачих ажлыг хийж гүйцэтгүүлсэн байна.

Ялтны хийж гүйцэтгэж байгаа энэхүү ажлын байр нь жагсаалтад орсон бусад байгууллагуудад хийж гүйцэтгэх ажлуудаас хамгийн хүнд, өвөл, зуны цаг уурын эрс тэс уур амьсгалд улирал харгалзахгүй хийгддэг онцлогтой байх ба ялтнууд хэт даарах, хэт халууцах, шороо тоосны харшилд өртөх зэрэг эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлүүд үүсэх боломжтой ажлын байр тул дээрх эрсдэлүүдээс мэргэжлийн байгууллагын тусламжгүйгээр тооцоолол хийх боломжтой 2 төрлийн эрсдэлийн түвшнийг Монгол улсын стандарт хэмжил зүйн газраас баталсан MNS4970:2023, MNS5080:2023 стандартаар¹⁰ тооцоход тус ажлын байр нь ялтны хувьд эрүүл мэнд “**эрсдэлгүй**” стандартад хүрэхгүй үзүүлэлттэй байв. Тухайлбал:

-Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газраас ажилтны эрүүл мэндийн аюулгүй байдал буюу гараар гүйцэтгэх ажлын үед ажилтан эд зүйлсийг өргөснөөс шалтгаалан яс булчин холбогч эдийн эмгэгтэй болох эрсдэлтэй гэж үзэн 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр “Гараар гүйцэтгэх ажлын үеийн өргөх ачааны жингийн зөвшөөрөх дээд хэмжээ” MNS4970:2023 стандартыг¹¹ баталсан байна.

Тус стандартад зааснаар ялтны гүйцэтгэж байгаа ажлын буюу айл өрхийн ачиж байгаа хогны зөвшөөрөгдөх дээд хэмжээг /ЗДХ/ газар дээр нь хийсэн хэмжээсээр тооцоход нэг удаагийн өргөх ачааны дээд хэмжээ 11.4 кг-аас хэтрэхгүй байхаар тооцоо гарч байна. /ЗДХ=лавламж жин*давталтын коэффициент*мурийлтын коэффициент/

Ялтнуудын хог ачиж байгаа байдалтай танилцаж, тэдний өргөж ачиж байгаа хог хаягдлын хэмжээг тооцоход нэг удаагийн ачих хогны хүндийн жин 10-дээш кг байх ба ялтнуудаас энэ талаар тодруулахад “айлуудын хог янз бүр байдгаас нэг удаагийн өргөлтөөр 11.4 кг-аас илүү ачаа өргөж ачих тохиолдол их гардаг” гэсэн судалгаа гарав.¹²

Энэ тоон үзүүлэлтээр гараар гүйцэтгэх ажлын үед өргөх ачааны жингээс хамаарсан эрүүл мэндийн эрсдэлийн түвшнийг “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал үнэлгээнд тавигдах ерөнхий шаардлага” MNS5080:2023 стандартын 8.6.9-д заасан шалгуураар тооцоход хэтэрсэн ачаа өргөх нь эрүүл мэндийн буюу яс булчин холбогч эдийн эмгэгт өртөх эрсдэл “Өндөр” гэж тодорхойлогдож байв.

-Мөн дээрх стандартын хавсралт шалгуураар ялтны ажилтай холбоотой ядралтын зэргийг тогтоох асуумжийн судалгааг танилцах явцад ажил хийж байсан 10 ялтнаас авахад ажлын байран дахь ядралтаас хамаарсан эрүүл мэндийн эрсдэлийн түвшин тус стандартын 8.6.10-д зааснаар 8 буюу “Дунд зэргийн” гэж үнэлэгдэж байна.

¹⁰ <mailto:standardinform@masm.gov.mn>

¹¹ <mailto:standardinform@masm.gov.mn>

¹² Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтнуудын ял эдлэлтийн байдлыг 2024 оны 02 дугаар сард танилцах явцад судалгаа хийв.

Иймд ялтныг ял эдлэх хугацаанд ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалж, өвчлөл, осол гэмтэлд өртүүлэхгүй байх боломжоор хангахын тулд ажлын байр бүрд Хөдөлмөрийн нөхцөлийн болон, эрсдэлийн үнэлгээ хийлгэх шаардлагатай юм.

1.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтны хөдөлмөрийн харилцааг хамгаалсан “хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх” заалт нь ажлын байр бүрт ямар байх талаар тогтсон стандарт байхгүй, хэт ерөнхий байдлаар өгдөг жишиг практик нэгэнт тогтсон байна.

Тухайлбал “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т ял эдэлж байгаа ялтанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн нэгдсэн зааварчилгаа дүрэм журмыг даган мөрдөн ажиллах, ажлаа гүйцэтгэж эхлэхийн өмнө ажлын бээлий хантааз багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгасны дараа тогтмол өмсөж хэвших, ажлын багаж хэрэгслийг зориулалтын дагуу удирдлагаас өгсөн зааврын дагуу ашиглах, багаж хэрэгсэлд гар хөлөө гэмтээхээс болгоомжлох, нүдээ хамгаалахад сайтар анхаарч ажиллах, аливаа зүйлээс унаж гэмтэхээс болгоомжлох, зөвшөөрөлгүйгээр ажлын байрыг дүр мэдэн хаяж явахгүй байх, ажлын байранд архи согтууруулах ундаа, сэтгэгцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэхгүй байх...” гэсэн байдлаар өгөгдөж, тэдний хийж гүйцэтгэж байгаа ажлын онцлогт нь тохирохгүй байна.

Түүнчлэн ажил олгогчоос ажилтанд ажлын тусгай хувцас, хөдөлмөрийн багаж, хэрэгслээр хангах үүрэг нь нэг удаагийн бээлий маск, хүрз мэтээр хязгаарлагдаж, төсөвт энэ талаарх зардал тусгагдаагүй гэх шалтгаанаар ялтан амьдралын хувцастайгаа ажилд гарах асуудал нь тэдгээрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалсан “хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, ажлын тусгай хувцас, хөдөлмөрийн багаж, хэрэгслээр хангагдах” хуулийн хамгаалалт ялтанд үйлчлэхгүй байгаа мэт харагдаж байна.

Иймд ялтанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тухайн байгууллагын ажлын байрны тодорхойлолт, дотоод журам, холбогдох хууль тогтоомж, Монгол улсын стандарт хэмжил зүйн газраас баталсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал үнэлгээнд тавигдах ерөнхий шаардлага”¹³ MNS5080:2023 стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны чиглэл, ажлын онцлогийг харгалзан ажлын байрны төрөл тус бүрээр стандарт тогтоох нь зүйтэй юм.

Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсгийн 26.5.4-д зааснаар ажилтан нь “ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах зардлыг өөрөө хариуцахгүй” тул цаашид тухайн байгууллагын төсвөөс ялтныг ажлын тусгай хувцас, хөдөлмөрийн багаж хэрэгслээр хангах, түүний эдлэх норм, хугацааг тооцож, хангасан эсэхэд санхүүгийн баримтыг үндэслэн хяналт тавих, ялтан ял эдэлж дууссаны дараа хувцас, багаж хэрэгслээр хангагдсан байдлын тоо ширхэг үнийн дүнгийн талаарх мэдээллийг шийдвэр гүйцэтгэх байгууллагад өгдөг зохицуулалтыг хийх нь зүйтэй юм.

¹³ mailto:standardinform@masm.gov.mn

3.Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 18 дугаар зүйлд ажилтан нь “хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдаж, ажлын байрны нөхцөл, эрүүл мэндэд учирч болох эрсдэл, түүнчлэн үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн талаар мэдээлэл авч, амь нас эрүүл мэндэд нь сөрөг аюултай нөхцөл бий болсон тохиолдолд ажлаа зогсоох, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хэлэлцэхэд өөрөө болон төлөөлөгчөөр дамжуулан оролцох” эрхийг эдлэхээр хуульчилсан байна.

Мөн тус хуулиар ажилтан нь “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, тусгайлан заасан бол шалгалт өгөх, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх, болзошгүй аюул ослын үед анхан шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх” үүргийг хүлээхээр хуульчилсан.

Харин практикт ялтан хийж байгаа ажлынхаа талаар тодорхой мэдээ мэдээлэл байхгүй, хуулиар хамгаалагдсан эрхээ эдлэх боломжгүй нөхцөл байдалтай байх ба ажил олгогчоос “ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийх, хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэх, ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтад хамруулах, сургалтад хамрагдаагүй, зааварчилга аваагүй, шалгалт өгч тэнцээгүй ажилтнаар ажил гүйцэтгүүлэхгүй байх, хэт халуун, хэт хүйтэн нөхцөлд ажиллуулж байгаа ажилтныг түр завсарлах, амрах, дулаацах, хоргодох байраар хангах, эрсдэлтэй ажлын байранд ажилтан ажиллуулахаар бол үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамруулах, болзошгүй аюул ослын үед анхан шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлэх” үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих зохицуулалтгүйгээс ялтны хуулиар хамгаалагдсан эрхийг эдлүүлэхэд учир дутагдалтай байна.

Ялтныг сургалтад хамруулж, хийж гүйцэтгэх ажлын онцлог, ажлын байрны орчин нөхцөл, өөрийгөө болон бусдыг аюул эрсдэлээс хамгаалах талаар мэдлэгтэй болсноор ял эдлэх явцад эрсдэл үүсэхгүй байх, ялтны эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

Иймд ажил олгогчоос ажилтанд аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалтыг ажил эхлэхээс өмнө тодорхой цагийн хугацаагаар олгодог байх, тэдний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгийг шалгасны дараа ажилд гаргах асуудлыг шийдвэрлэх үүргийг биелүүлдэг байх зохицуулалтыг хийх нь зүйтэй юм.

Хоёр: Ял эдлүүлэх ажиллагаанд нийтэд тустай ажил хийлгүүлэх байгууллагын оролцоо, цаашдын хэрэгцээ шаардлага

1.Эрүүгийн хуульд “гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ”¹⁴ гэж тодорхойлсон боловч, практикт гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг хийлгэхээр шүүхээс тогтоодог тохиолдол бараг байхгүй, ихэвчлэн ялтнуудын мэргэжилгүй, ажилгүй байдлаас тэднийг эзэмшсэн мэргэжил, ур чадварын дагуу ажиллуулах байгууллагыг тогтоох боломжгүйд хүргээд байна.

¹⁴ Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйл.

Энэхүү тогтсон жишгийг өөрчлөх, шинэчлэх асуудлаар хууль хэрэгжүүлэгч болон судлаачдаас Эрүүгийн хуулийг хэрэгжүүлж эхэлсэн цагаас хойш асуудлыг хөндөж байгаа боловч, өнөөдрийг хүртэл дорвитой өөрчлөлт хийгдээгүй, ялын хэрэгжилт, үр нөлөө хэлбэрийн төдий байна.

Прокуророос хяналтын явцад дээрх хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, шүүхээс ялтныг ажиллуулж болох байгууллагыг тогтооход шүүгч улсын яллагч нарыг ажлын байрны мэдээллээр хангах зорилгоор Сум, дүүргийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд жагсаалтад орсон¹⁵ 19 байгууллагын удирдах албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулж,¹⁶ хийж болох нийтэд тустай ажлын санал бүхий судалгааг авсан.

Судалгаанд жагсаалтад орсон дүүргийн 19 байгууллагаас гадна, жагсаалтад ороогүй боловч нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулдаг 8 байгууллагыг хамруулахад, жагсаалтад орсон байгууллагын 15.7 хувь буюу “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ, Гэрэлтүүлэг чимэглэлийн алба, Боловсролын байгууллага зэрэг 3 байгууллагаас тогтмол хугацаанд, нийтийн ашиг сонирхолд тустай тодорхой ажлуудын саналыг ирүүлсэн байна.¹⁷

Онцгой байдлын хэлтэс, Гэр бүл хүүхэд залуучууд хөгжлийн хэлтэс, Цэцэрлэгжүүлэлтийн алба, Спортын хороо, Чандмань Налайх ОНӨААТҮГ Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Газар зохион байгуулалтын алба зэрэг 7 байгууллагаас тогтмол хугацаанд хийх ажлын санал байхгүй, харин улирлын чанартай тогтмол хийх боломжгүй ажлын саналыг, Нийгмийн даатгалын хэлтэс, Статистикийн хэлтэс, Соёлын ордон, Эрүүл мэндийн нэгдэл, Цагдаагийн хэлтэс зэрэг 5 байгууллагаас байгууллагын гадна, болон дотор талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийлгэх, архивын ажилд туслуулах зэрэг тухайн байгууллагын ашиг сонирхолд тустай ажлын саналуудыг тус тус ирүүлсэн байна.

Харин Худалдан авах ажиллагааны алба, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Дотоод аудитын алба зэрэг 4 байгууллагаас үйл ажиллагаа нь бүрэн цахимжсан, мөн хувь хүн, хуулийн этгээдийн хувийн мэдээлэлтэй холбоотой ажлыг гаднын хүнээр хийлгэх боломжгүй тул ажлын санал байхгүй гэсэн байна.

Жагсаалтад ороогүй дүүргийн 8 хороодоос авсан саналаар¹⁸ хороодод “нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог хаягдал цас мөсийг цэвэрлэх, хүүхдийн тоглоомын талбайн цэвэрлэгээ, засвар, үйлчилгээг хийлгэх, халиа, шар усны үерийн үед далан цэвэрлэх, шуудуу татах, албан байгууллага, аж ахуйн нэгж иргэдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх гарын авлага тараах, иргэдийг угтаж чиглүүлэх үйлчилгээ үзүүлэх, хороодын өндөр настай иргэд болон халамж шаардлагатай хүмүүст туслуулах” зэрэг нийтийн ашиг сонирхолд тустай ажлын саналуудыг ирүүлсэн байна.

Нийтэд тустай ажлын үр нөлөөг гадаад улсын туршлага, чиг хандлагаас судлахад¹⁹ АНУ-д нийтэд тустай ажлыг төрлөөр нь ангилж, үүнээс гар ажиллагааны хөдөлмөрт барилгын ажил, зам цэвэрлэх, цэцэрлэгжүүлэлт, цэвэрлэгээний ажлуудыг

¹⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он 163 дугаар зүйл.

¹⁶ Дүүргийн прокурорын газраас 2023 оны эхний хагас жилд хийсэн хамтарсан зөвлөгөөний материал.

¹⁷ Дүүргийн прокурорын газраас 2023 онд хийсэн судалгааны ажлын материал.

¹⁸ Дүүргийн прокурорын газраас 2023 онд хийсэн судалгааны ажлын материал.

¹⁹ <https://cd.gov.mn/> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар “Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт чиг хандлага 2020 он 41-42 тал.

хамааруулж ялтны сонголтоор хийлгэдэг бол, БНХАУ-д ялтнуудыг “Олон нийтийн үйлчилгээний ажилчид” гэж нэрлэн олон нийтийн байгууллага, төрийн алба болон халамжийн байгууллагуудад ажиллуулах нь үр дүнтэй гэж үздэг байна.

Иймд ялтныг ажиллуулах ажлын байрны сонголтыг нэмэгдүүлж, хийх ажлыг /түр болон удаан хугацаагаар хийх, эмэгтэй болон өсвөр насны этгээд хийх, гар ажиллагаатай, хүч шаардагдах эсэх зэргээр/ ангилан төрөлжүүлснээр ялтныг эрүүл мэндийн байдал, эзэмшсэн мэргэжил, ур чадварт нь тохирсон ажлыг хийлгэх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

2.Ялтны хийж гүйцэтгэх ажил болон ажиллуулах байгууллагыг зөв оновчтой сонгож тогтоосноор ялтны эрүүл мэндийг хохироохгүй, хэвийн байдалд хадгалж, хамгаалахаас гадна эдлэх **ялын хугацаанд** чухал ач холбогдолтой юм.

Эрүүгийн хуульд зааснаар шүүхээс нийтэд тустай ажил хийлгэх ялын хамгийн их хэмжээ буюу 700 цагийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг ялтны өөрийнх нь хүсэлтийн дагуу өдрийн 8 цагаар тооцож ажиллуулахад /амралтын өдөр орохгүй/ түүний ял эдлэх хугацаа 4-5 сар, 4 цагаар тооцоход 8-9 сар үргэлжлэхээр байна.

Гадаадын улс орны туршлагаас удаан хугацаагаар ажиллах ялтны ажлын байрны нөхцөлийг судлахад²⁰ Их Британи, Умард Ирландын нэгдсэн хаант улсад ялтныг үйлдсэн гэмт хэргийн хэмжээнээс хамаарч, удаан хугацаагаар эдлэх ялыг түүний оршин суудаг орчноо сайжруулахад чиглүүлдэг нь ялтанд чирэгдэлгүй, нийтийн ашиг сонирхолд бүрэн нийцсэн гэж үздэг байна.

Иймд ялтны хийж гүйцэтгэх ажлын сонголтыг түүний “эрүүл мэндийн байдал, эзэмшсэн мэргэжил, ур чадвар”-ыг нь харгалзахаас гадна үйлдсэн гэмт хэрэг, оногдуулсан ял шийтгэлийн хугацааг нь харгалзан зөв оновчтой тогтоосноор Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчимд бүрэн нийцэхээр байна.

Түүнчлэн урт хугацаанд ял эдлэх ялтныг ажиллуулах байгууллагад үндсэн ажилтны нэгэн адил сургалтад хамруулж, ажлын тусгай хувцсаар хангаж, эрсдэлийн даатгалд даатгуулж, хөдөлмөрийн таатай нөхцөлд ажиллуулах ажлын байрыг бий болгох шаардлагыг тавих нь зүйтэй юм.

Дүгнэлт

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай 1981 оны 155 дугаар конвенцын 11 дүгээр зүйлд “ажил олгогч нь хориглосон, хязгаарласан, эсхүл эрх бүхий байгууллага, байгууллагуудын зөвшөөрөл, хяналттайгаар явуулах ажлын үйл ажиллагааны явц ...эрүүл мэндэд учрах аюулыг анхааралдаа авах”, “ажилчдын эрүүл мэндэд эрсдэл бүхий хүчин зүйлийг шинжлэх тогтолцоог нэвтрүүлэх буюу өргөтгөх” “ажилчид, байгууллага дахь тэдний төлөөлөгчид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар зохих ёсоор бэлтгэгдэнэ”, “ажил олгогч даатгалын байгууллага болон шууд холбогдох бусад этгээдэд үйлдвэрлэлд гарсан осол, мэргэжлийн өвчний тухай мэдэгдэх журам тогтоон мөрдөх, үйлдвэрлэлд гарсан осол, мэргэжлийн өвчний тухай жил тутмын мэдээ гаргах”²¹ зэргээр ажлын

²⁰ <https://cd.gov.mn/> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар “Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт чиг хандлага 2020 он 41-42 тал.

²¹ <mailto:info@mlsp.gov.mn>

байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах, эрсдэл бүхий хүчин зүйлийг шинжлэх тогтолцоог өргөжүүлэх талаар тусгасан байна.

Харин илтгэлд дурдсанаар манай улсад нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны хийж гүйцэтгэх ажлын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн нөхцөлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох тушаал, журмаар бүрэн зохицуулаагүй, ялтны эрхийг эдлүүлэх нөхцөлийг бүрдүүлээгүй, одоо хэрэгжүүлж байгаа эрх зүйн зохицуулалт нь хүний эрхийг хамгаалсан хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенц, өнөөгийн нийгмийн өөрчлөлт шинэчлэлт, хэрэгцээ шаардлагатай уялдуулж, шинэчилж өөрчлөгдөөгүй, ялтны эрхийг бүрэн хамгаалаагүй гэж дүгнэхээр байна.

Энэ төрлийн ял шийтгүүлсэн хүмүүс нь гэмт хэрэг үйлдэж, шүүхийн шийдвэрээр ял шийтгэл хүлээж, ялтан болсон хэдий ч тэдний Эрүүгийн хуулиар хязгаарлаагүй эрхэд хүндэтгэлтэй хандаж, эдлэх ёстой эрхийг эдлүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх, түүнд тавих хяналт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь хууль хэрэгжүүлэгч хүн бүрийн үүрэг юм.

Иймд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах ажлын байранд тавигдах стандарт шаардлага, хөдөлмөрийн нөхцөл, ажлын байрны эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх хамгаалалтыг оновчтой тодорхойлж, ялтан үйлдсэн гэмт хэрэг, оногдуулсан ял шийтгэл, эрүүл мэнд, эзэмшсэн мэргэжил ур чадвартаа тохирсон ажлыг хийж гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн боловсронгуй болгох нь нэн тэргүүний асуудал болоод байна.

Санал

Илтгэлийн сэдвийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах санал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлд шийдвэр гүйцэтгэх байгууллагаас:

- Ялтны хийж гүйцэтгэх ажлын нөхцөл зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй, ялтны ажиллах чадвар, эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлгүй эсэхэд “ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ”-г хийлгэх;

- Эрсдэлтэй гэж үзсэн ажлын байранд эрсдэлийн үнэлгээг хийлгэж, учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох үнэлэх, бууруулах, арилгах эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

- Ялтанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажлын байрны тодорхойлолт, дотоод журам, холбогдох хууль тогтоомж болон стандарт шаардлагад нийцүүлэн, үйл ажиллагааны чиглэл, ажлын онцлогийг харгалзан тогтоох;

- Ялтныг ажлын тусгай хувцас, хөдөлмөрийн багаж хэрэгслийг эдлэх норм, хугацааны дотор хангасан эсэхэд санхүүгийн баримтыг үндэслэн хяналт тавих;

- Ялтныг ажиллуулах байгууллагыг “эрүүл мэндийн байдал, эзэмшсэн мэргэжил, ур чадвар”-г нь харгалзан тогтоохоос гадна үйлдсэн гэмт хэрэг оногдуулсан ял шийтгэлийн хугацаа, зэргийг харгалзан тогтоох;

- Ялтныг ажиллуулах байгууллагаас жилд 1-ээс доошгүй удаа ялтнаар хийлгэх ажлын саналыг тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хийх ажлын онцлог,

ажлын байрны орчин, нөхцөл, ажиллуулах боломжтой субъектийн төрлөөр нь төрөлжүүлэн гаргуулж авах;

- Шүүхээс удаан хугацаагаар ял эдлэх шийтгэл оногдуулсан ялтны эдлэх ялыг тогтмол хугацаанд хийх боломжтой ажлын сонголтоос хийх.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 166 дугаар зүйлд ажил хийлгэж байгаа байгууллагаас:

- Ялтан ял эдэлж дууссаны дараа хувцас, багаж хэрэгслээр хангагдсан байдлын тоо ширхэг үнийн дүнгийн талаарх мэдээллийг шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлэх;

- Ажилтанд аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалтыг ажил эхлэхээс өмнө тодорхой цагийн хугацаагаар олгох, тэдний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгийг шалгасны дараа ажилд гаргах;

- Ялтанд хийж гүйцэтгэх ажлын онцлог, ажлын байрны орчин нөхцөл, өөрийгөө болон бусдыг аюул эрсдэлээс хамгаалах талаар мэдлэгтэй болгох;

- Удаан хугацаанд ажиллах ялтныг үндсэн ажилтны нэгэн адил сургалтад хамруулж, ажлын тусгай хувцсаар хангаж, эрсдэлийн даатгалд даатгуулж, хөдөлмөрийн таатай нөхцөлд ажиллуулах ажлын байрыг бий болгох үүргийг тус тус хуульчилж нэмэлт оруулах.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт оруулах санал:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.7-д “ял эдэлж байгаа хоригдол, ялтан” гэсэн субъектийн ард “ялтан” гэж нэмэх.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/168 дугаартай тушаалыг өөрчлөх санал:

- Ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалтыг гаргахдаа тус байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хийх ажлын онцлог, ажлын байрны орчин, нөхцөл, ажиллуулах боломжтой субъектийн төрлөөр нь төрөлжүүлэн гаргаж батлуулах.

4. 2017 оны А/234, А/103 дугаартай тушаалаар батлагдсан ”Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ыг шинэчлэх санал:

- Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжоор хамгаалсан эрх, үүрэг, ял эдлүүлэх байгууллага болон ялтныг ажиллуулах байгууллагын үүрэг хариуцлага, ажлын стандарттай холбоотой зохицуулалтыг тусгасан журмыг дахин боловсруулж батлах.

Ашигласан эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
2. Хөдөлмөрийн тухай хууль. 2021 он

3.Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015 он

4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он

5. Хүний эрхийн олон улсын гэрээ бэ Монгол Улс. 2021 он

6.Ц.Мөнхбат. “Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт” бодлогын судалгааны тайлан. 2019 он

7.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенц

8.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц

9.Монгол Улсын Стандарт хэмжил зүйн газрын цахим хуудас <mailto:info@mlsp.gov.mn>

10.Прокурорын байгууллагын мэдээллийн сан [\10.33.0.213](#) 2013-2023 оны мэдээ

11.Дүүргийн прокурорын газраас 2023 онд хийсэн судалгааны ажлын материал.

12.Дүүргийн прокурорын газраас 2023 оны эхний хагас жилд хийсэн хамтарсан зөвлөгөөний материал.

13.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. <https://cd.gov.mn/>. “Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт чиг хандлага. 2020 он

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газрын ахлах прокурор Ц.Амгаланбаатар

Хураангуй:

Зорчих эрхийг хязгаарлах ялыг 2015 оны Эрүүгийн хуульд шинээр тусгаж, 2021 оны 01 сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд даруй 3 жилийн нүүрийг үзэж байна.

Шүүхээс 2021 онд 949 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж байсан бол 2023 онд 1585¹ болж 59.8 хувиар өссөн байгаа нь энэ төрлийн ялыг өргөн хэрэглэж, шүүхээс зорчих эрхийг хязгаалах ял шийтгүүлсэн хүний тоо жил ирэх тусам өсөж байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр практикт гарч буй хүндрэл бэрхшээлд тулгуурлан санал дэвшүүлсэн болно.

Түлхүүр үгс:

Зорчих эрхийг хязгаарлах ял, эрүүгийн хариуцлага, ял шийтгэлийн зорилго, албадлагын арга хэмжээ.

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуульд эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг Монголын ард түмний эрхэм зорилго болгон тунхагласан билээ.

Нэгдсэн Үндэсний байгууллагын Ерөнхий ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний 45/110 дугаар тогтоолоор хэлэлцэн баталсан “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм)-ийн 1.5-д “Гишүүн орнууд нь хорих ялыг хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжийг хангах, эрх зүйн зөрчил гаргагчийг хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, нийгмийн шударга ёсны болон хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн байцаан шийтгэх салбар дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор өөрийн эрх зүйн системийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулна” гэж заасан.

Ийм ч учраас эрүүгийн ял шийтгэлийн бодлогыг илүү хүнлэг, энэрэнгүй, ардчилсан хэлбэрт шилжүүлэх арга замыг тууштай эрэлхийлж эхэлсэн.

Дэлхийн олон улс эрүүгийн ялын бодлогоо хүний эрхийг хангах, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлэх, ялын чанга шийтгэлээс үндсэндээ татгалзах, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох хүрээнд хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг хэрэглэх чиг хандлагатай байна.²

¹ Прокурорын байгууллагын цахим бүртгэл

² Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018, 29 дэх тал.

“Хорихоос өөр төрлийн ял” нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгмийн орчинд нь байлгаж, гэр бүл, үр хүүхдээ тэжээн тэтгэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн төдийгүй эдийн засгийн хувьд ч үр өгөөжтэй ялын төрөл юм.

Хорихоос өөр төрлийн ялын нэг хэлбэр болох “Зорчих эрхийг хязгаарлах ял”-ыг дэлхийн улс орнууд дотоодын хууль тогтоомждоо тусгаж техник, технологийн дэвшлийг ашиглан амжилттай хэрэгжүүлж буй сайн туршлагуудыг хуваалцсан эрдэмтдийн бүтээл цөөнгүй байна.

Тиймээс зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллах явцад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, техник, технологийн дэвшлийг ашиглаж ялтанд тавих хяналтыг улам боловсронгуй болгох, тэдний эрхийг зөрчихгүй байхад анхаарч, хуулийг нэг мөр хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Үндсэн хэсэг

А. Зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт

Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад

- өөрийн оршин суугаа газраас явахыг хориглох,
- тодорхой газар очихыг хориглох,
- шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих,

- эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх зорчих үүргийг 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорих эрхийг хязгаарлах ял” хэмээн хуульчилсан бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 20 бүлгийн 139 гэмт хэрэгт зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар хуульчилжээ.

Мөн хуулийн 2 дахь хэсэгт Шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялыг бусад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно гэж заасан.

Шүүхийн практикт зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулахдаа ялтны оршин суух газраас явахыг хориглож өөрөөр хэлбэл аймаг, сум, баг, нийслэг, дүүрэг, хорооны нутаг дэвсгэрээс бусад газарт зорчихыг хориглож, чөлөөтэй зорчих эрхэд хязгаарлалт тогтоох байдлаар хэрэгжүүлж байна.

Хуулийн дээрх зохицуулалтаас харахад зорчих эрхийг хязгаарлах ялыг томъёолсон тодорхойлолт нь Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-д заасан “тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах” албадлагын арга хэмжээний төрөлтэй давхцаж хуулийн нэг мөр хэрэгжүүлэхэд эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл байдал үүсэж байна.

Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь энэ хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ” гэж заасан.

Эрүүгийн хуульд зааснаар хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ялаас хугацаанаас өмнө тэнсэн сулласан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэхээр зохицуулсан.

Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн этгээдийн ялын биелэлтэд хяналт тавьж шүүхийн шийтгэх тогтолтой танилцахад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахдаа хуульд заасан хугацаагаар “өөрийн оршин суугаа газраас явахыг хориглож” хязгаарлалт тогтоон шийдвэрлэдэг практик тогтсон бөгөөд “тодорхой газар очихыг хязгаарлаж” шийдвэрлэсэн тохиолдол гараагүй байна.

Харин зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж нэмж Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэсэн тохиолдол цөөнгүй байна.

Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголтыг хэт ерөнхий байдлаар тодорхойлсноос Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс ³ ял оногдуулахдаа зорчих эрхийг хязгаарлах ялын агуулга, үзэл баримтлалаас гажуудуулан “эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх зорчих” үүргийг хүлээлгэх байдлаар оногдуулсан тохиолдол шүүхийн практикт гарсан бөгөөд үүнийг прокуророос зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн үндэслэлээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.12 дугаар зүйлд зааснаар прокурорын дүгнэлт, мөн эсэргүүцэж бичиж анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулан тухайн ялтныг өөрийн оршин суух газраас явахыг хориглох хязгаарлалтыг тогтоож хуулийн нэг мөр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлж буй гадаад орны туршлагаас судалсан эрдэмтдийн бүтээлтэй танилцахад “Бүгд Найрамдах Хятад Ард улсын 2012 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “үйлдсэн гэмт хэргийн шинж нөхцөл байдалд үндэслэн гэмт этгээдэд тэнсэн харгалзах ял оногдуулах бөгөөд ялтны сурч боловсрох, ажиллах эрхийг хөндөлгүйгээр тодорхой газарт нэвтрэх, зарим хүмүүстэй холбоо барих, уулзахын хориглох заалт тусгасан”⁴ бөгөөд техник, технологийн ололт дэвшлийг ашиглан уг ялыг улам боловсронгуй болгон практикт хэрэглэж иржээ.

Тиймээс манай улсын хувьд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд гадаад орны сайн туршлагыг судлах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Б. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээл

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.1 дэх хэсэгт “Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг

³ Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 2022/ШЦТ/950 дугаартай шийтгэх тогтоол

⁴ Нээлттэй нийгэм форум. “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт” сэдэвт судалгааны тайлан. УБ., 2022, 42 дахь тал

хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа хаяг болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавина” хэмээн хуульчилсан.

Манай улсад SW12 маркийн цахим бугуйвчийг 2021 оны 01 сарын 01-ний өдрөөс DDX04 маркийн цахим бугуйвчийг 2023 оны 09 дүгээр сараас эхлэн хэрэглэж техник, технологийн дэвшлийг ашиглан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

“Цахим хяналт, удирдлагын төв”-өөс зорчих эрхийг хязгаарлах ялын биелэлтэд техникийн хяналтыг тасралтгүй тавин ажиллаж байгаа ба техник хяналтын ажилтан нь ялтны гаргасан зөрчлийн мэдээллийг ялтанд болон хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид тухай бүр мэдэгдэж байна.

Хариуцсан шийдвэр гүйцэтгэгчээс ялтны гаргасан зөрчлийн шалгаан нөхцөл, ял эдлэх нөхцөл журмыг зөрчсөн эсэхийг шалгахад шүүхээс тогтоосон бүсээс гарч явсан маршрут тогтоогдохгүй байхад Цахим хяналт удирдлагын төвөөс бүсээс гарсан гэх зөрчлийн анхааруулгыг ялтнуудад мэдэгдэж тэдний эрхийг зөрчсөн, хууль бус үйлдэл гарч байна.

Ялтны шүүхээс тогтоосон бүсээс гаргасан гэх зөрчил нэг бүртэй танилцахад 2023 оны 09 дүгээр сараас хэрэглэж буй DDX04 маркийн цахим бугуйвчийг зүүж буй ялтнуудад шүүхээс тогтоосон бүсэд байхад:

- Монгол Улсын хилийн гадна гарсан,
- Орон нутагт буюу аймаг, сумын нутаг дэвсгэрт зорчсон,
- Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт зорчсон
- Шүүхээс тогтоосон бүсэд байхад бүсээс гарсан гэх мэдээлэл бүртгэгдэж ялтан, шийдвэр гүйцэтгэгчид анхааруулах дохиог мессежээр илгээж байна.

Хуучин төрлийн цахим бугуйвч өөрөөр хэлбэл SW12 маркийн цахим бугуйвчийг ашиглаж буй ялтнууд цахим гавыг өндөр ампертай цэнэглэгчээр цэнэглэх тохиолдолд хий цэнэгээр дүүрч цэнэгээ барихгүй хурдан унтрах, улмаар цахим бугуйвчийн батерей нурж цэнэглэгдэхгүй болж цэнэг дуусаж цахим бугуйвч унтраасан гэх анхааруулах дохио олон удаагийн давтамжтай ирж ялтны гаргасан зөрчлийн мэдээлэлд бүртгэгдэж байна.

Мөн хяналтад байгаа зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтнууд шүүхээс тогтоосон бүс /Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр/-ээс гарч Сүхбаатар дүүргийн 5 дугаар хорооны нутагт байрлах Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт очиж гомдол хүсэлт гаргах, цахим гав ашиглалтын зардлыг төлөх зорилгоор биечлэн очих тохиолдолд ялтанд “бүсээс гарсан” гэх анхааруулах дохио илгээгддэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.3 дахь хэсэгт “шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг зөрсөн ялтанд дахин зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг сануулж, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх ярилцлага хийж тэмдэглэл үйлдэнэ” гэж заасан ба хариуцсан шийдвэр гүйцэтгэгчээс ялтныг зөрчил гаргаагүй байхад техник хяналтын

системээс ирүүлсэн зөрчлийн мэдээллийг үндэслэн тухай бүр дуудан ирүүлж тайлбар тэмдэглэл авах боломжгүй нөхцөл байдал үүсэж байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж буй SW12, DDX04 маркийн цахим бугуйвч цэнэггүй болж унтарсан тохиолдолд тухайн ялтны байршил тодорхойгүй болж, техникийн тасралтгүй хяналтаас алдах, улмаар шүүхээс тогтоосон бүсээс гарсан зөрчлийг илрүүлэхэд хүндрэл учирдаг тул түүнд тавих техникийг хяналтыг улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

Дүгнэлт

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтыг боловсронгуй болгох чиглэлээр хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хуулийн хийдлийг арилгах, техник технологийг ололт, дэвшлийг ашиглах зэргээр цогц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдөхөөс сэргийлж, ялтныг өөрийн оршин суух газраас явахыг хориглож, чөлөөтэй зорчих эрхэд хязгаарлалт тогтоох эрх зүйн орчин бүрдэж, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, хувийн байдлыг харгалзан албадлагын арга хэмжээний төрлөөс чөлөөтэй сонгож хэрэглэх нөхцөл бүрдэнэ.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж

Зорчих эрхийг хязгаарлах ялыг Эрүүгийн хуульд товч, ойлгомжтой байдлаар тодорхойлох, техник технологийн дэвшлийг ашиглан зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтнуудад тавих хяналтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага урган гарч байгааг харгалзан дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглож, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ” гэж товч бөгөөд ойлгомжтой байдлаар томъёолох;

2. Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хэд хэдэн үүрэг хүлээлгэж хязгаарлалт тогтоож болно” гэж өөрчлөх;

3. Шинээр “Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх зорчих үүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар зохицуулна” гэсэн заалт нэмж оруулах;

4. Цахим бугуйвчийг ашиглах, техникийн зааварчилгаа өгөх ажлыг боловсронгуй болгох, ялтныг шинэ төрлийн цахим бугуйвчаар хангах, техник хяналтын ажилтны орон тоог нэмэгдүүлэх санал хүргүүлэх;

5. Цахим бугуйвчийг унтраасан тохиолдолд тухайн ялтны байршлыг заагч GPS төхөөрөмж цахим гавд суурилуулж техник, технологийн дэвшлийг ашигласнаар ялтныг техникийн тасралтгүй хяналт тавих боломж бүрдэнэ;

6. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт төвлөрч буй эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавьж буй нэгжийг харьяа дүүргийн нутаг

дэвсгэрт байршуулснаар зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд учирч буй хүндрэл бэрхшээл арилж ялтны эрхийг хангах, улмаар ял эрүүгийн хариуцлагын зорилго бүрэн хангагдана.

Ашигласан эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он.
2. Эрүүгийн хууль 2017 он.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он.
4. НҮБ-ийн Ерөнхий ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45/110-р тогтоолоор баталсан Нэгдсэн Үндэсний Байгууллагын хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм /Токиогийн дүрэм/.
5. Улсын Ерөнхий прокурорын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/71 тоот тушаалаар баталсан “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”.
6. ХЗДХС, УЕП-ын хамтарсан 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/158, А/76 тоот тушаал Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам/
7. Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ, 2018 он.
8. Нээлттэй нийгэм форум. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт /судалгааны тайлан/. УБ. 2022 он.
9. Б.Алтангэрэл, М.Хүрэлбат. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ. УБ. 2021 он.

ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНААС ӨМНӨ СУЛЛАЖ ХЯНАЛТ ТОГТООХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Нийслэлийн Прокурорын газрын хяналтын прокурор Ц.Отгонсүх

Хураангуй:

Шинэчлэн батлагдсан 2015 оны Эрүүгийн хуульд хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллах явдлыг эдлээгүй үлдсэн хугацаанд ялтанд тодорхой үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр хуульчилсан нь уламжлалт ойлголтуудаас өвөрмөц зохицуулалт болж чадсан юм.

Хорих ялаас хугацааны өмнө суллагдсан ялтныг эдлээгүй үлдсэн хугацаанд үүрэгжүүлж, эрхийн тодорхой хязгаарлалтыг тогтоосноор хэдийгээр шүүхээс оногдуулсан ялынхаа тодорхой хувийг эдлээд суллагдаж байгаа ч дахин эрх бүхий субъектийн хяналтад орж буй нь эрүүгийн хариуцлагын цээрлүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх зорилгыг хангаж байгаагийн илрэл мөн билээ.

Түлхүүр үгс:

Ял, ялын төрөл, хорих ялаас хугацааны өмнө суллах, тэнсэх, хүний эрх, эрх чөлөө, хяналт тогтоох.

Удиртгал

Хорих ялаас хугацааны өмнө суллаж хяналт тогтоохтой холбоотой асуудлын тоон баримтыг судалж үзэхэд 2019 онд 1382, 2020 онд 1386, 2021 онд 1115, 2022 онд 834, 2023 оны нэгдүгээр улиралд 560¹ ялтныг тус тус хорих ялаас хугацаанаас өмнө чөлөөлж хяналт тавьж байгаагаас үзэхэд шүүхийн практикт хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга хэмжээ болох нь харагдаж байна.

Энэ үүднээс хорих ялаас хугацааны өмнө суллах ойлголт, хууль зүйн үндэслэл, шалгуур шинжүүд, суллагдсаны дараах эрхийн хязгаарлалт, хэрхэн үүрэгжүүлж хяналт тавих нь эрүүгийн эрх зүйд төдийгүй, ял эдлүүлэх эрх зүйн тулгамдсан асуудлын нэг бөгөөд илтгэгчийн зүгээс хорих ялаас хугацааны өмнө суллахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын хийдэл, зөрчилдөөнийг илрүүлэх, үүнээс үүдэн ялтны эрх хэрхэн зөрчигдөж буйг энэхүү илтгэлээр тусгайлан авч үзэж байгаа болно.

Үндсэн хэсэг

Нэг. Хорих ялаас хугацаанаас нь өмнө суллаж, хяналт тогтоох ойлголтын онолын үндэслэл

Эл асуудал юуны өмнө хорих ялын үүсэл хөгжилтэй салшгүй уялдаатай бөгөөд хорих ялын цаашдын хөгжилтэй уялдан хорих ялаас хэзээ, хэдийд хэрхэн чөлөөлөх явдал Эрүүгийн эрх зүйд зайлшгүй шаардлагатай болсноос улбаалан бусад ялын төрлүүдийн нэг адил ялаас бүрэн, хэсэгчлэн суллах асуудалтай зэрэгцэн хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох асуудал XIX зууны эхэн үеэс Баруун

¹ Шүүхийн тайлан, 2019, 2020, 2021, 2022, 2023 оны нэгдүгээр улирал

Европын орнуудын эрүүгийн болон эрүүгийн ял эдлүүлэхтэй холбоотой хууль тогтоомжуудад хуульчлагдан хэрэглэгдэх болжээ².

Орчин үед эрүүгийн эрх зүйн хөгжилд тэргүүлэх чиглэл болон хөгжиж буй **хүмүүнлэгийн тогтолцоонд** хорих ялаас аль болох татгалзах, хорихоос бусад төрлийн ялд илүү ач холбогдол өгөх, ялаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх асуудалд илүү анхаарлаа хандуулах болсон өнөөгийн нөхцөлд хорих ялаас хугацааны өмнө суллах нь ялын нийгэмшүүлэх зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Ялын агуулга, зорилгыг хэрэгжүүлэх гол механизм нь нэг талаас шүүхээс оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх, нөгөө талаас ялаас чөлөөлөх, өөр төрлийн ялаар хөнгөрүүлэн солих, тэнсэх явдлаар илэрдэг. Эдгээр нь нэгдэж нийлж ялын зорилгыг хангана гэж үзэж байна.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах асуудлыг **нэг талаас** эрүүгийн эрх зүйн шударга ёсны зарчимтай сөргүүлэн тавих, ял бол цээрлэл, шүүхээс үйлдсэн хэрэгт нь тохирсон ял шийтгэлийг оногдуулсан тохиолдолд түүнийг дуустал эдлүүлэх, ингэснээр ялын зорилго бүрэн хангагдах буюу ялын **“абсолют”** онолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авч үзэж негатив байр сууринаас **үгүйсгэх хандлага**, **нөгөө талаас** ял нь ялтныг нийгмээс бүрэн тусгаарлах, залхаан цээрлүүлэхэд бус харин ялтныг засаж хүмүүжүүлэх, нийгэмд эргэж ороход туслах, нийгэмшүүлэх зорилгыг хангах ялын **“харьцангуй”** онолын үүднээс позитив байр сууринаас **дэмжих хандлага** өрсөлдөн хөгжиж³ байгаа талаар судлаачид тодорхойлжээ.

Дээрхээс гадна ялаас чөлөөлөх ойлголтын хүрээнд

1.Сэргээн засах шударга ёсны онол: Гэмт хэргийн улмаас эвдэрсэн нийгмийг засах нь шударга ёсыг сэргээн засах үзэл баримтлалаар илрэх ба үүний тулд хоригдлуудын хандлага, үзлийг шинэчлэх шаардлагатай, нэг үгээр гэмт хэрэгтнүүдийг нийгмийн амьдралд эргэн ороход нь туслах, нийгмийн харилцааг сэргээх ажлыг түргэтгэх нөхцөл хэмээн үздэг.⁴

Уг онолоор авч үзвэл, ялаас чөлөөлөх эрүүгийн эрх зүйн зохицуулалт бол сэргээн засах шударга ёсны онолын илрэн гарах хэлбэр мөн, гэмт хэрэгтнүүдийн сэтгэл зүйд нөлөөлж, нийгэмшүүлэх шаардлагыг хэрэгжүүлэхэд ялаас хугацааны өмнө чөлөөлөх явдал ач холбогдолтойг авч үздэг ажээ.

2.Ялын зорилгын нэгтгэх онол: Ялын талаарх шударга ёсны болон урьдчилан сэргийлэх зорилгыг нэгтгэж өөр хооронд нь уялдуулах асуудлыг голлон авч үздэг онол сургаал юм. Гэмт хэрэг үйлдсэний төлөө ялыг заавал оногдуулах, ял оногдуулснаар гэмт хэрэг дахин үйлдэх, хэн нэгэн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чадах ёстой. Шоронгийн талбай хаалттай тул гэмт хэрэгтнүүд ял эдэлж байх хугацаандаа бусад хоригдлуудтай холбоо тогтоож "хөндлөнгийн халдвар"-ыг авдаг. Хэт удаан хугацаагаар ял эдлэх нь эргээд нийгэмтэйгээ зөрчилддөг учраас гэмт

² Д.Бадам, Б.Одонтулгал. Хорих ялаас хугацаанаас нь өмнө суллаж хяналт тогтоох ойлголтыг шинэ хандлагаар авч үзэх нь. Эрх зүйн сэтгүүл.2021.№1.193 дахь тал

³ Дурьдсан өгүүлэл.193 дахь тал

⁴ 恢复性司法：法理及其实践展开 / Шударга ёсыг сэргээн засах: хууль зүй болон практик хөгжил/ Шандун их сургуулийн хэвлэлийн газар. 2008 он

хэрэгтнийг урамшуулж, өөрсдийгөө шинэчлэхэд илүү сайн түлхэц болох үүднээс ялаас хугацааны өмнө суллах ёстойг сургадаг онол мөн.⁵

3. Утилитари онол: Утилитари үзэл бодлын сонгодог илэрхийлэл бол гэрээ юм. Энэ онол нь үр ашгийн зарчимд суурилдаг бөгөөд гэрээний шинжийг талуудад ашигтай байхаар тайлбарладаг. Өөрөөр хэлбэл талууд сэтгэл ханамжтай байх ёстой. Дан ганц эдийн засгаар тодорхойлогдохгүй хэмээсэн байдаг.

Эрүүгийн хууль тогтоомжийн ялаас чөлөөлөх зохицуулалтыг 2 талын гэрээ гэж үзвэл гэрээний 2 талд адилхан ашиг, сэтгэл ханамжийг өгөх боломжтой. Төрийн зүгээс гэрээ байгуулан гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлж, ялаас чөлөөлөгдөж буй ялтангийн хувьд сэтгэл ханамж, нийгэмдээ ирж нийгэмшихэд нь дэмжлэг үзүүлж байна. Нөгөө талаасаа хууль ёсны, хүчин төгөлдөр байх ёстой.⁶

Дээрх онол сургаал, үзэл баримтлалыг нэгтгэн дүгнэвэл ялаас чөлөөлөх нэн ялангуяа хорих ялаас хугацааны өмнө чөлөөлөх ойлголт нь эрүүгийн ялын зорилгыг хангах, нийгэмдээ төдийгүй хувь хүндээ ач холбогдолтой ойлголт бөгөөд эрүүгийн эрх зүй түүний дотор ялын эрх зүйд бие даасан судлагдахуун болох нь харагдаж байна.

Хоёр. Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоох арга хэмжээний хэрэгжилт

Дурдсан арга хэмжээний хэрэгжилтийн тоон судалгаанаас үзэхэд:

2022 онд улсын хэмжээнд хорих байгууллагын арга зүйн зөвлөлөөс хугацааны өмнө суллаж, хяналт тогтоолгох саналтай 1121 / давхардсан тоогоор/ хоригдлын хувийн хэрэг, материал прокурорын байгууллагад хянагджээ. Үүнээс 908 хоригдлын хувийн хэргийг хугацааны өмнө суллуулах болзол шаардлага хангасан хэмээн үзэж шүүхэд шилжүүлсэн бөгөөд 834 хоригдлыг, 2023 онд 1235 хувийн хэрэг, материал хянагдан 947 хоригдлын материалыг шүүхэд шилжүүлснээс 902 хоригдлыг хугацааны өмнө суллаж хяналт тогтоосон шүүгчийн захирамж тус тус гарчээ. Эдгээрээс 2022 онд 74, 2023 онд 45 хоригдлуудыг шүүх “**зан ба байдлын хувьд засарч хүмүүжсэн, нийтэд аюулгүй болсон нь нотлогдохгүй байх тул**” гэсэн хуульд байхгүй үндэслэл зааж өөрийн үзэмжээр хугацааны өмнө суллуулахаар шилжүүлсэн прокурорын дүгнэлтийг хэрэгсэхгүй болгох, улмаар хэлэлцэхгүй орхин хоригдлын хууль ёсны эрх ашгийг хохироосон байна. Хоригдлын засрал, хүмүүжлийн талаарх ял эдэлж буй хорих ангийн тодорхойлолт, түүнд хяналт тавьж байгаа прокурорын дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож шүүх чухамхүү ямар үндэслэлээр, юунд тулгуурлаж ийнхүү дүгнээд байгаа нь ойлгомжгүй байдлыг бий болгож байгаа юм.

Түүнчлэн хорих байгууллагын арга зүйн зөвлөлөөс ирүүлсэн материалуудын 10-20 орчим хувийг хяналтын прокурорууд хугацааны өмнө суллаж, хяналт тогтоолгох хуулийн шаардлага хангаагүй гэж үзэж дүгнэлт гаргалгүй буцаах тохиолдол байсаар байгаа нь ч нууц биш. Энэ нь нэг талаас эрүүгийн хуулийн тодорхой бус зохицуулалт, нөгөө талаас ихэвчлэн хоригдлын үйлдсэн хэргийн шинж байдалд хөтлөгдөж “хийсвэрээр” дүгнэдэгтэй холбоотой гэж үзэж байна.

⁵ <https://www.cnki.net/>

⁶ Л.Банзрагч. Гэрээний эрх зүйн онол, арга зүйн асуудал.2017

Дээрхээс гадна прокурорын зүгээс хорих ангид тавьсан хяналтын явцад хугацаанаас өмнө суллагдах боломжтой, эрүүгийн хуульд заасан шаардлагыг хангасан хоригдол байсаар байхад ангийн зөвлөлийн хурлаар оруулахгүй орхих дутагдал байсаар байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Гурав. Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоох арга хэмжээний эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал

Шүүхээс оногдуулсан хорих ялын хугацааг дуустал эдлүүлэхгүйгээр суллах нь хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах нэг хэлбэр бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан ялын зорилгыг богино хугацаанд биелүүлэхэд ач холбогдолтой. Энэхүү ойлголт нь нэг талаас эрүүгийн эрх зүйн нөгөө талаас ял эдлүүлэх эрх зүйн зохицуулалтын хүрээнд хэрэгждэг салбар хоорондын шинжтэй харилцаа мөн. Өөрөөр хэлбэл материаллаг эрх зүйн хэм хэмжээ нь процессын буюу эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйн хэм хэмжээгээр дамжин хэрэгжиж биеллээ олдог.

Тэгэхээр хорих ялаас хугацааны өмнө суллаж хяналт тогтоохтой холбоотой асуудлыг зохицуулах эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын болон шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн хэм хэмжээ хийдэлгүй, зөрчилдөөнгүй баймааж сая ялтны эрхийг хангах цаашлаад тухайн зохицуулагдаж буй харилцаа хуулийн дагуу явагдах боломж бүрдэх юм. Энэ үүднээс дурьдсан хэм хэмжээнд судалгаа хийж үзвэл:

Эрүүгийн хууль:

1. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.12 дахь хэсэгт хорих ялаас хугацааны өмнө суллаж хяналт тогтоох асуудлыг “ Ялтан хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахад хохирлоо нөхөн төлсөн, нийтэд аюулгүй болсноо зан байдлаараа харуулсан, ноцтой зөрчил гаргаагүй, ялын тодорхой хувийг биеэр эдэлсэн байх ёстой” талаар хуульчилжээ.

Хуулийн дээрх заалт нь хорих ялаас хугацааны өмнө суллагдах ялтанд тавих шалгуур шинжүүд бөгөөд эдгээрийг тус бүрд нь авч үзвэл:

а/. “**нийтэд аюулгүй болсноо зан байдлаараа харуулсан**”-ыг хамруулах ба энэхүү харьцангуй ойлголтыг практикт үнэлэхэд хүндрэлтэй байдаг, ихэнх тохиолдолд ялтан ял эдлэх явцад хэрэг, зөрчил гаргаж байгаагүй, бие дааж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн, хөдөлмөр эрхэлж ажлын хоног авсан, хорих ангиас хүлээлгэсэн үүргийг тухай бүр биелүүлж байсан, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн гэх бодит шалгуураар бүхэлд нь үнэлж иржээ.

Өмнөх эрүүгийн хуулиудад ялтны хувийн байдал, засарч хүмүүжсэн эсэх гэх ойлголтоор тодорхойлогдож байсан уламжлалт ойлголтуудын нэг ба мэргэжлийн сэтгэл зүйчийн үнэлэлт дүгнэлтээр тодорхойлогдох эл ойлголтыг хорих ангийн удирдлага, прокурор, шүүх өөрсдийн үзэмжээр үнэлж тогтоох боломжгүй юм. Ялтан үнэхээр нийтэд аюулгүй болсноо зан байдлаараа харуулсан гэж үзэж хорих ялаас хугацааны өмнө сулласан бол эдлээгүй үлдсэн хугацаанд “**хяналт**” тогтоох шаардлагатай юу гэх асуулт аяндаа урган гаргана.

Үе үеийн эрүүгийн хуульд хорих ялаас хугацааны өмнө суллахтай холбоотой зохицуулалтад төдийлөн хэрэгждэггүй дээрх заалтыг эрүүгийн хуулиас хасах эсхүл

холбогдох хуулиудад мэргэжлийн байгууллага, шинжээчийн дүгнэлтээр тогтоолгохтой холбоотой заалтыг нэмж тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Хорих ялаас хугацааны өмнө суллагдсан ялтны 30-33 хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж ял эдэлж буй практик дээрхийн тод нотолгоо мөн.

б/."Ноцтой зөрчил гаргаагүй" гэх заалтыг мөн л ялаас чөлөөлөх явцад хэрхэн үнэлэх асуудал бэрхшээл учруулдаг. Чухамхүү ямар зөрчлийг ноцтойд тооцох хууль зүйн ойлголт байхгүй бөгөөд бидний ойлгож байгаагаар ялтнаас гаргаж буй зөрчлийн шинж, үр дагавраар тодорхойлогдох авч Зөрчлийн хуульд ийм ойлголтыг хуульчлан тодорхойлоогүйг тэмдэглэх хэрэгтэй. Ял эдлэх явцад гаргасан зөрчилд ялтан хорих ангийн даргын шийдвэрээр шийтгэл хүлээдэг, ноцтой зөрчил гэдгийг тогтоох шалгуур шинжийг хэрхэн үнэлж тогтоох нь ялаас чөлөөлөх төдийгүй ял эдлүүлэх явцад гаргасан зөрчилд шийтгэл хүлээлгэх асуудлын хүрээнд ч тулгамдаж буйг онцолж байна. Тиймээс энэхүү ойлголтыг Эрүүгийн хуулийн зохих хэм хэмжээнээс хасах хэрэгтэй гэж үзэж байгаа юм.

в/."Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлсөн байх" нь бодитоор үнэлж, тогтоож болох ойлголт бөгөөд ялтан ял эдлэх хугацаанд хөдөлмөр эрхэлж, улмаар ажлын хөлсөөр хохирлыг нөхөн төлж байгаа практик цөөн байна. Ихэнхдээ ар гэрийнхний дэмжлэг туслалцаатайгаар хохирлыг барагдуулж байгаа ба энэ үндэслэлээр хорих ялаас хугацааны өмнө суллагдаж чадаагүй ялтан нэлээдгүй байдаг. Хуулийн энэ заалтыг гол шалгуур болгохгүйгээр хяналтын хугацаанд хохирлыг нөхөн төлүүлэх үүрэг хүлээлгэж, шийдвэр гүйцэтгэгчийн хяналтын дор хохирлыг барагдуулахаар хуульчлах боломжтой гэж үзнэ.

Дээрхээс дүгнэвэл хорих ялаас хугацааны өмнө суллаж хяналт тогтооход гол үндэслэл болгож буй Эрүүгийн хуулийн 6.12 .1 дэх хэсгийн заалтыг өөрчилж, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

г/."Хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахдаа эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтоох"

Хорих ялаас хугацааны өмнө суллагдсан ялтны эдлээгүй үлдсэн хорих ялын хугацаатай тэнцүү хяналт тогтоох явцад шүүхээс чухамхүү ямар үүргийг хэрхэн хүлээлгэх талаар тодорхой заалт байдаггүй. Практикаас үзэхэд шүүх эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3.2 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж байгаа ба харин 7.3.3 дахь хэсэгт заасан эрхийн хязгаарлалтыг хэрэглэх боломжгүй болгосон нь "хяналт тогтоох"-ын хууль зүйн агуулгыг бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүйд хүргэжээ. Өөрөөр хэлбэл хууль тогтоогч эрүүгийн хуулийн 6.12 дахь хэсэгт "үүрэг хүлээлгэх" талаар дурдсан ч ялтны зарим эрхэд хязгаарлалт хийхийг орхигдуулсан байна. Угаас үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах нь ялгаатай, хууль зүйн өөр өөр үр дагавар агуулсан тусдаа ойлголт мөн. Иймээс эрүүгийн хуулийн 6.12.2 дахь хэсэгт хяналтын хугацаанд эрүүгийн хуулийн 7.3.2 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэх, 7.3.3 дахь хэсэгт заасан эрхийн хязгаарлалт тогтоохыг нэмж хуульчлах нь зүйтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль:

-Уг хуулийн 210.1 дэх хэсэгт Хоригдлын эрхийн талаар заасан ба энд хорих ялаас хугацааны өмнө суллагдах талаар хорих ангийн удирдлагад хүсэлт гаргахтай холбоотой заалт байхгүй, гэхдээ 210.1.2.хорих ангийн захиргаагаар дамжуулан өөрт

аюулыг дурдсан, ингэснээр ялтны хуулиар олгогдсон эрхийг бүдүүлгээр зөрчиж байна гэсэн дүгнэлтэд яахын аргагүй хүргэдэг.

Хоригдлын үйлдсэн гэмт хэрэгтээ шүүхээр тодорхой ял шийтгүүлсэн, тэрхүү гэмт хэргийг ялаас чөлөөлөхөд харгалзан үзэх ямар ч хуулийн үндэслэл байхгүй гэдгийг хэлэх нь зүйтэй.

Эцэст нь дүгнэхэд:

Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тавихтай холбоотой Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудын холбогдох зохицуулалтыг Олон улсын стандарт дэлхий нийтийн жишигт нийцүүлж өөрчилж, боловсронгуй болгох, ялтны эрхийг хангах нь тулгамдсан асуудлын нэг болох нь дээрх судалгаанаас тодорхой харагдаж байна.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нэг хэлбэр төдийгөөр авч үзэх бус энэ нь ялтны хуулиар олгогдсон эрх, ялтанд урамшуулал, итгэл хүлээлгэснээр эрүүгийн хариуцлага, ялын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх зорилгыг хангах, нөгөө талаас эдийн засгийн хувьд хэмнэлт гаргах, гэмт хэргийн хохирлыг нөхөн төлөх, хохирогчийн эрхийг хангахад чухал ач холбогдолтой талаас шинэ хандлага, үзэл баримтлалаар тодорхойлох зайлшгүй шаардлагатай гэж дүгнэж дараах САНАЛ-ыг дэвшүүллээ.

- **эрүүгийн хуульд** хуульчилсан хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоох шалгуур шинжүүдийн уламжлалт зохицуулалтыг өөрчлөх, хяналтын агуулга, ач холбогдлыг зөв тодорхойлох, бүх насаар хорих ялаас чөлөөлөгдөж буй хүнд хяналтын хугацааг нэг адил тогтоох,

- **шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн** доторх хийдэл зөрчилдөөнийг арилгах, хяналт тавих ажиллагаанд оролцогч субъектүүдийн чиг үүргийг тодорхой хуульчлах, хяналтын хугацаа дуусч суллагдаж буй этгээдийг нийгэм нь хүлээж авдаг уламжлалт зохицуулалтыг сэргээх, ингэснээр ялтны эрхийг хангах, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоохын учир холбогдол, цаашлаад эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах боломж бүрдэх юм.

Ашигласан эх сурвалж

Нэг. Монгол Улсын хуулиуд

1. Монгол Улсын Үндсэн хууль. ТМ. №1. УБ1992
2. БНМАУ-ын Эрүүгийн хууль. УБ. 1942, 1961
4. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль. ТМ. №01. УБ, 1997
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. ТМ. №08. УБ. 2002.
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. ТМ. №24. УБ. 2017
8. Эрүүгийн хууль. ТМ. №07. УБ. 2016
9. Эрүүгийн хууль. ТМ. №05. УБ 2002

Хоёр. Монгол Улсын нэгдэн орсон

Олон Улсын гэрээ, конвенц

1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон Улсын пакт. 1966
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. Парис. 1948.
3. Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд. Женев. 1955

Гурав. Ном, сурах бичиг

1. Л.Банзрагч. Гэрээний эрх зүйн онол, арга зүйн асуудал.2017

1. Ж.Болдбаатар. Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ 1997

2. О.Энхбат “Хорих ял эдлүүлэх дэглэм, түүнийг хангах хэрэгсэл” УБ., 1989.

Дөрөв. Эрдэм, шинжилгээний өгүүлэл, илтгэл

1. Д.Бадам, Б.Одонтунгалаг. Хорих ялаас хугацаанаас нь өмнө суллаж хяналт тогтоох ойлголтыг шинэ хандлагаар авч үзэх нь. Эрх зүйн сэтгүүл.2021.№1.193 дахь тал

2.С.Жанцан. Хорих дэглэм. Эрдэм шинжилгээний өгүүлэл. Сонор сэрэмж сэтгүүл. №4. 1982

3. 恢复性司法：法理及其实践展开 / Шударга ёсыг сэргээн засах: хууль зүй болон практик хөгжил/ Шандун их сургуулийн хэвлэлийн газар. 2008 он

Тав. Бусад эх сурвалж.

1.cd.gov.mn /ШШГЕГ-ын веб сайт/

2.<https://www.cnki.net/>

3. Прокурорын байгууллагын тайлан, мэдээ, 2018, 2019 он

4. Шүүхийн тайлан,2019,2020,2021,2022, 2023 оны нэгдүгээр улирал

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2023 оны жилийн эцсийн мэдээ, тайлан./Хоригдлын хөдөлгөөний мэдээ/

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа зарим хорих ангийн хоригдлын хөдөлгөөний мэдээ зэрэг эх сурвалжуудыг ашиглав.

ЯЛЫН ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ (ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ЖИШЭЭН ДЭЭР)

Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх
Сургалт, судалгааны хүрээлэнгийн Судалгааны албаны
хяналтын прокурор Н.Нандин-Эрдэнэ

Хураангуй:

Орчин цагт ялыг хорих болон хорихоос өөр төрлийн ял гэж ангилах хандлага түгээмэл болжээ. Ялын бодлогын хувьд “хүний эрх, энэрэнгүй байх зарчимд үндэслэж, хорих ялаас татгалзах” явдлыг гол үзэл санаа, баримтлал болгож, сонгох боломж бүхий ялаар зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэх болсон байна. Энэхүү илтгэлээр зорчих эрхийг хязгаарлах ялын онол, үзэл баримтлалыг авч үзэж, улмаар үүнд хүний эрхийн тулгамдсан ямар асуудлууд байгааг тодорхойлж, түүнд үндэслэн авч хэрэгжүүлж болох саналыг дэвшүүлсэн юм.

Түлхүүр үгс:

Ялын онол, үзэл баримтлал, хүний эрх, эрх чөлөө, нийгэмшүүлэх, хорихоос өөр төрлийн ял, зорчих эрхийг хязгаарлах ял.

Удиртгал

Хүний эрх гэдэг нь хүний чөлөөтэй амьдрах, аж төрөх байгалийн /жам ёсны/ ба нийгэм, эдийн засаг, соёлын болон бусад боломж мөн.¹

Монгол Улс нь олон улсын хүний эрхийн салбар дахь эрх зүйн баримт бичгүүдийн зарчим, үзэл санаанд бүрэн нийцсэн хэм хэмжээнүүдийг хүний эрх, эрх чөлөө гэсэн хоёрдугаар бүлэгт баталгаажуулсан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд “Монгол улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна” гэж заасан. Түүнчлэн төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах үүргийг хүлээсэн байдаг.

Хүний эрх зүйн байдал нь үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор хуульчлан баталгаажуулсан бие хүний эрх, үүргийн тогтолцоо мөн.²

Сонгодог үзэл баримтлалд ял шийтгэл нь хүнийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх, хохирогчийн гомдлыг барагдуулах, тохирсон шийтгэл эдлүүлэх зэрэг зорилготой байдаг. Үүнээс гадна гэмт этгээдийг хорьж, нийгмээс тусгаарласнаар нийгмийг хамгаалах зорилгыг бас агуулдаг.³ Эндээс харахад Беккариагийн шийтгэлтэй холбоотой шинж тэмдэг нь нийтэд нээлттэй, хурдан хэрэгцээтэй, байж болох хамгийн хөнгөн байх, гэмт үйлдэлд тохирсон хэмжээтэй, хуульд тусгасан байх зэрэг юм.

¹ Эрх зүйн ерөнхий онол. Ч.Нямсүрэн, Улаанбаатар хот, 2021 он, 380 дахь тал

² Теория права и государства. Под ред. Г.Н.Манова, М., 1996, С 233.

³ Pickford, R.W. 1947. "Psychological Aspects of Punishment." Ethics, Vol.58, No 1, pp.1-17

Беккариа нь шийтгэлийн зорилго бол шийтгэхдээ биш гэмт явдлаас урьдчилан сэргийлж, нийгмийг хор уршгаас хамгаалах гэж үзсэн. Иймээс шийтгэл гэдэг хүнийг ухамсарлуулахын тулд хүнлэг шинжтэй байх нь чухал юм. Энэ ч утгаараа Беккариа бусад сэргэн мандалтын үеийн эрдэмтэн, судлаачдын адил цаазаар авах ялыг халж, түүний оронд илүү хүмүүнлэг шийтгэл оногдуулах нь зүйтэй гэж үзжээ.⁴

Үндсэн хэсэг

Орчин үед хууль зүйн шинжлэх ухаанд, үүний дотор эрүүгийн эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн ялын гурван сонгодог онолын хандлагыг авч үзье.

Нэгдүгээрт, ялын туйлын онол буюу ялын бодлогын үнэмлэхүй хандлага гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд түүний учруулсан хохирол, гэмт хэргийн шинж, хэр хэмжээг харгалзан тэдгээрт яг тохирсон ялыг онооход чиглэгдсэн үзэл баримтлал юм. Энэхүү онолын үндэслэлийг И.Кант, Г.Гегель нар гаргасан байдаг. Уг онолын анхны танин мэдэхүйн үндэслэл нь Ромын эрх зүйгээс эхлэлтэй “Талеоны системийн аксиом”⁵-оос эх үндэстэй ба энэ нь эртний Вавилон, Монсейн хуулиудад тусгагдан хэрэгжиж байсан⁶ гэж үздэг.

Абсолют онолын нэг агуулга нь ялын зорилгыг зөвхөн залхаан цээрлүүлэх гэсэн агуулгаар тодорхойлдог бөгөөд энэ нь ихэвчлэн цаазлах, эрхтнээс нь салгах, тарчлаах буюу шоронд хорих ялыг харьцангуй түгээмэл хэрэглэх шаардлагыг өөртөө агуулдаг. Энэхүү хандлага 1810 оны Францын анхны төрөлжсөн Эрүүгийн хуульд тусгагдаж ирснээс хойш 1950-аад оны дунд үе хүртэл нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн түгээмэл ялын гол онол нь болж хэрэглэгдэж байв. Гэхдээ дээрх онолын агуулга орчин үед талеоны системийн мөн чанарыг эвдэж, шударга ёсны зарчимд нийцэхүйц байдлаар өөрчлөгдөн хөгжиж ирснийг үгүйсгэх аргагүй юм. Энэхүү онол нь баруун Европ, Пост-социалист орнуудад өргөн тархсан байна. Энэхүү онолын гол үзэл санаа болох гэмт хэрэгт хариуцлага заавал байх, гэм буруутай бол тохирсон ял оноох гэсэн үзэл санаа өнөөдөр ч эрүүгийн эрх зүйд баттай оршсоор байна.⁷

Хоёрдугаарт, ялын харьцангуйн онолоор ял нь дан ганц залхаан цээрлүүлэх бус, харин ялтныг нийгэмшүүлэх, улмаар урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байдаг. Энэ онолыг үндэслэгчид нь Германы эрдэмтэн П.А.Файербах, Ф.Ф.Лист нар юм. Харьцангуйн онолын танин мэдэхүйн үндэслэл нь аливаа ял нь эцсийн эцэст нийгмийн зорилго, агуулгад нийцсэн байх шаардлагаар тодорхойлогдсон байна.⁸ Ялын харьцангуйн онолын төлөөлөгчдийн нэг Марк Ансель бичихдээ: “...Ял нь зөвхөн төрийн бодлогын илэрхийлэл бус харин нийгмийн агуулга бүхий нөлөөллийн систем мөн тул энэ нь хэзээ ч залхаан цээрлүүлэх зорилго агуулах ёсгүй. Харин ямар ч ял тухайн гэмт

⁴ Осман Долу. Криминологийн онолууд. Улаанбаатар хот, 2022 он, 32 дахь тал

⁵ Талеоны системийн аксиом-(лат. Talio-цусан өшөө авах, хонзонг тайлах гэсэн утгатай). Энэ нь цусыг цусаар, амийг амиар гэсэн утгыг илэрхийлж, эрүүгийн цаазад гэмт хэргийг ялгаж ангилахаас өмнө үүссэн бөгөөд гэмт этгээдийн хийсэн хэрэгт нь адилхан шийтгэх, өшөө авах нь тухайн үед Ромын эрх зүйн ялын бодлогын үндсэн зарчим болж үйлчилж байв. Ц.Мөнхбат. Нийтэд тустай ажил хийлгэх ял. УБ., 2020 он.16 дахь тал

⁶ А.Съез. Ялын ойлголт, зорилго, үр нөлөө. Эрх зүйн шинэтгэл: Эрүүгийн эрх зүйн асуудал. 2001/6-7.143 дахь тал

⁷ Т.Золбоо. Эрүүгийн эрх зүй, ерөнхий анги: Гэмт хэргийн бүтээц. УБ., 2018. 21 дэх тал

⁸ Ц.Мөнхбат. Нийтэд тустай ажил хийлгэх ял. УБ., 2020 он.17 дахь тал

хэрэг үйлдсэн хүнийг засаж төлөвшүүлэх, нийгэмшүүлэх болон нийгмийн зорилгод нийцүүлж урьдчилан сэргийлэх агуулгатай байх ёстой”⁹ гэж тэмдэглэжээ.

Гуравдугаарт, ялын дундын буюу либерал онол нь ял бол залхаан цээрлүүлэх шинж бүхий албадлагын арга хэмжээ болохыг хүлээн зөвшөөрдөггүй хэдий ч туйлын онолын “Гэмт хэрэгтний үйлдсэн хэрэгт нь оноох ял тэнцүү байх”, харьцангуй онолын “Ял нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх зорилготой албадлагын арга хэмжээ” гэсэн үзэл санааг өөртөө багтаасан байдаг. Ийм ч учраас дундын онол гэж нэрлэдэг ба өнөөдөр эх газрын эрх зүйд зонхилж буй ялын үзэл баримтлал, онол юм.¹⁰

Дээрх дурдсан холимог онолын зорилгыг тодорхойлоход Оросын эрдэмтэн И.Я.Фоницкий, Н.Д.Сергиев нар “Хорихоос өөр төрлийн ялыг ногдуулах гол үндэслэл, зорилго нь ялын сүрдүүлгийн залхаах чиг үүргийг хангахад чиглэгддэггүй, харин гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд, ялтныг нийгэмшүүлэх үүднээс нийгэмд ач тустай засан төлөвшүүлэх, зохистойгоор нөлөөлөх агуулгыг хангах тухай”¹¹ тайлбарласан байдаг.

Дээрх ялын онолуудын хандлагаас үзэхэд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлд “эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.” гэж заасан нь либерал онолын тусгал болжээ.

Дэлхийн олон улс, үндэстэн эрүүгийн эрх зүйн ялын бодлого, түүнийг даган гарах хууль эрх зүйдээ хүний эрхийг хангаж, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлж, ялын чанга шийтгэлээс үндсэндээ татгалзаж, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох, хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг өргөн дэлгэр хэрэглэх чиг хандлагатай байна.¹²

Ийм ч учраас гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр зүй зохистой, зөв амьдралд ороход туслалцаа үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэх зан үйлээс нь татгалзуулах, урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хохирогч, бусад хүнийг хамгаалах зорилгоор зорчих эрхийг хязгаарлах ялын төрлийг 2015 оны Монгол Улсын Эрүүгийн хуульд шинээр нэмж тусгасан байдаг.

Зорчих эрхийг хязгаарлах ял эрүүгийн хариуцлагын “нийгэмшүүлэх, эрх сэргээх, хохирол төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” зэрэг зорилгыг хангахад чиглэсэн, эрүүгийн эрх зүйн “шударга, энэрэнгүй, тэгш, хууль ёсны, ял гарцаагүй байх” зарчмуудад үндэслэсэн байна.

1983 онд АНУ-ын Нью-Мексико мужид анх энэ ялыг хэрэглэсэн бол үүний дараа Флорида муж хэрэгжүүлэх хөтөлбөрийг эхлүүлж, улмаар 1980-аад оны сүүл гэхэд АНУ-

⁹ Ансель М. Новая социальная защита (гуманистическое движение в уголовной политике). М., 1970. с 267-268

¹⁰ Т.Золбоо. Эрүүгийн эрх зүй, ерөнхий анги: Гэмт хэргийн бүтээц. УБ., 2018. 23-24 дэх тал


¹¹ Михлин А.С. Уголовно-исполнительное право. М., 2000, Пономарев П.Г. . Уголовно-исполнительное право. М., 1999

¹² Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018. 29 дэх тал

ын олон муж зорчих эрхийг хязгаарлах цахим гав, электрон хяналт хэрэглэх олон янзын хөтөлбөрийг эхлүүлжээ.¹³

Зорчих эрхийг хязгаарлах ял нь ялтан цахим гав буюу цахим хяналтын төхөөрөмж бүхий дохио дамжуулах, гадны нөлөөнд тэсвэртэй, зориулалтын бусаар тайлах, суллах боломжгүй төхөөрөмж зүүх үүргийг хүлээн, урьдчилан тогтоосон зам, цагийн хүрээнд ажил, гэр, сургууль руу явах боломжийг олгож байгаа юм.¹⁴

График 1. Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн ялтны тоо¹⁵



Гэвч дээр дурдсан ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрхийг хөндсөн асуудлууд мөн тулгарч байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны явцад шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоосон хязгаарыг багасгасан зөрчлүүд нэлээдгүй гарч байна. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн прокурорын газраас зөрчигдсөн эрхийг сэргээхээр шалгах ажиллагаа явуулахад, 2023 оны 9 дүгээр сарын байдлаар зөвшөөрөгдсөн бүсийг багасгаж тогтоосон 70 тохиолдол гарсан байна. Тодруулбал, зорчих эрхийг Улаанбаатар хотын нутаг дэвсгэрээр хязгаарласан байхад шийдвэр гүйцэтгэгч нь техникийн хяналтын системд Багануур дүүргийг хасаж оруулах, эсвэл зорчих эрхийг дүүргийн хэмжээнд хязгаарласан байхад 1 хороог нь хасах зэрэг зөрчлүүд гардаг байна. Зөвхөн нэг дүүргийн хэмжээнд дээрх тооны зөрчил гарч байгаа нь улсын хэмжээнд ихээхэн тоо гарахыг үгүйсгэхгүй юм.

Энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 13 дугаар зүйлд “...Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суугаа газраа чөлөөтэй сонгох эрхтэй”, 19 дүгээр зүйлд “...ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв

¹³ Jolin/Rogers, Journal of Contemporary Criminal Justice 1989, p. 141; Schmidt, Journal of Contemporary Criminal Justice 1989, p. 138

¹⁴ Нээлттэй нийгэм форум. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт /судалгааны тайлан/. УБ., 2022. 17 дахь тал

¹⁵ Прокурорын байгууллагын цахим бүртгэлийн нэгдсэн системийн тоон мэдээлэл

журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй” гэж заасан байдаг бөгөөд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны явцад шийдвэр гүйцэтгэгч нь дээрх хүний эрхийг хөндөж байна.

Сүүлийн жилүүдэд өсвөр насны хүүхэд, оюутан залуус гэмт хэрэгт холбогдох нь ихэссэн байна. Эдгээр гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг нийгмээс тусгаарлахгүйгээр зүй зохистой, зөв амьдралд ороход туслалцаа үзүүлэх зорилгоор зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 169 дүгээр зүйлийн 169.1 дэх хэсэгт “Ялтан гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг хариуцан төлөх үүрэгтэй.” гэж заасан тул энэхүү зардлыг өсвөр насны хүүхэд, оюутан залуус өөрсдийн гэсэн орлогогүй учраас гэр бүлийн гишүүд төлж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “...Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно.” гэсэнтэй зөрчилдөж байна. Ял халдаах онол зүйн гол үндэслэл нь үйлдсэн гэмт хэрэгтээ бус, харин хэрэгтээ гэм буруутай байх, тэр нь нотлогдох, энэ нь хууль зүйд яв цав нийцсэн /хууль ёсны зарчим хэрэгжсэн/ байхад оршино.¹⁶ Иймд гэр бүлийн гишүүдэд ял халдааж байгаа нь мөн л хүний эрхийг хөндөж байна. Энэ тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ялаас өөр төрлийн ял оногдуулах асуудалд мөн анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Үүнээс гадна ялтан нь хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг хариуцан төлөх үүрэг хүлээж байгаа нь давхар торгуулийн ял эдэлж байгаа мэт байна.

Нээлттэй нийгэм форумаас хийсэн судалгаагаар зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны явцад цахим бугуйвчаар хяналт тавихад дараах хүндрэл үүсэж байна гэж тогтоожээ. Үүнд:

- Цахим бугуйвчийн цэнэг дууссан тохиолдолд дахин цэнэглэхэд төвөгтэй, суурин цахилгааны эх үүсвэрээр зориулалтын (толин) цэнэглэгчээр бүрэн цэнэглэсэн үедээ цэнэгээ барих хугацаа нь хагас өдөр буюу 10-12 цагаас хэтрэхгүй;

- Зориулалтын (толин) цэнэглэгчээр суурин цахилгаан эх үүсвэрт холбож бүрэн цэнэглэхэд дунджаар 1 цаг 30 минутын хугацаа зарцуулдаг бөгөөд цэнэглэх хугацаанд ялтан нэг цэгт хөдөлгөөнгүй удаан байрлах шаардлагатай, цахим бугуйвчийн зориулалтын (толин) цэнэглэгч нь хэтэрхий богино тул цэнэглэхэд хүндрэлтэй (толин цэнэглэгчийн урт 40 см);

- Зөөврийн цэнэглэгчээр цахим бугуйвчийг зөвхөн нэг удаа бүрэн цэнэглэх боломжтой ба бүрэн цэнэглэхэд 30-40 минут зарцуулж 4-5 цагийн хугацаанд цэнэгээ барьдаг;

- Цахим бугуйвчийн байршил тогтоогч (GPS) нь орон байр (объект)-наас гарах хөдөлгөөн хийгээгүй үед хиймэл дагуулаас ирсэн мэдээллийн сүүлчийн байршилд тухайн цагт гацаж, явсан маршрутыг заадаггүй;

¹⁶ Э.Батбаяр, Б.Ганболд. Хорихоос өөр төрлийн ял. УБ., 2023. 19 дэх тал

- Үүрэн холбооны тархцын антеннаас хамаарсан сүлжээний тасалдал, доголдол болон дата дугаар ашиглахтай холбогдон гарсан зардал, төлбөрийн асуудал зэрэг болно.¹⁷

Дээрх байдлаас үзэхэд, цахим бугуйвчны цэнэг барилт, сүлжээний тасалдал, доголдол зэргээс шалтгаалсан нөхцөл байдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1.2-т заасан “техникийн хяналтын тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл тэдгээрийн хэвийн ажиллагааг сарниулсан; мөн зүйлийн 170.1.4-т заасан “техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүүгүй хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн” зэрэг үндэслэлд тооцож зорчих хязгаарлах ял эдлэх журмыг зөрчих, зорчих хязгаарлах хязгаарлах ялыг хорих ялаар солих үр дагаварт хүрснээр ялтны эрх хөндөгдөж болзошгүй байна.

Дүгнэлт, санал

Манай улс олон улсын жишгийн дагуу эрүүгийн эрх зүйн ялын бодлого, түүнийг даган гарах хууль эрх зүйдээ хүний эрхийг хангаж, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлж, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох, хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг өргөн дэлгэр хэрэглэх чиг хандлагатай байгаа нь сайшаалтай.

Хэдий тийм боловч шинээр ялын төрөлд нэмэгдсэн зорчих эрхийг хязгаарлах ял, түүний ял эдлүүлэх ажиллагааны явцад ялтны эрх зөрчигдөж буй нөхцөл байдлууд гарч байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд заасан “...ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй” гэх заалтыг зөрчин түүний эрхэд халдах тохиолдлууд цөөнгүй байна.

Мөн түүнчлэн ялтан нь хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг хариуцан төлөх үүрэг хүлээж байгаа нь давхар торгуулийн ял эдэлж байгаа мэт, өсвөр насны ялтан, өөрийн гэсэн орлогогүй ялтнуудын эцэг, эх, асран хүмүүжүүлэгч нар хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг хариуцан төлж байгаа явдал нь гэм буруутны ял зэмлэлийг халдаан хэрэглэх нөхцөл үүсч байна.

Цахим бугуйвчны цэнэг барилт, сүлжээний тасалдал, доголдол зэргээс шалтгаалсан нөхцөл байдлыг зорчих хязгаарлах ял эдлэх журмыг зөрчих, зорчих хязгаарлах хязгаарлах ялыг хорих ялаар солих үр дагаварт хүргэж болзошгүй нөхцөлүүд ч гарч байна.

Иймд ялын онол, үзэл баримтлал, хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, конвенци, дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөхиүлэн дэмжих, сургалтуудыг зохион байгуулах, үүнд эрдэмтэн, судлаач, хуульч, хууль сахиулагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь ял эдлүүлэх ажиллагааны институцийн цогц хөгжилд зайлшгүй түлхэц болно гэж бодож байна.

Түүнчлэн, зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулах санал гаргах, оногдуулах, эдлүүлэх, түүнд тавих хяналтын ажиллагааны үр дүнтэй, үр нөлөөтэй байдлыг

¹⁷ Нээлттэй нийгэм форум. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт /судалгааны тайлан/. УБ., 2022. 71 дэх тал

сайжруулах, үүнд хүний эрх, эрх чөлөөг хөндөхгүй, зөрчихгүй байх талын хууль эрх зүйн болон бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал хэмээн үзэж байна.

Ашигласан эх сурвалж

Нэг. Ном, сурах бичиг, гарын авлага, сэтгүүл

1. Pickford, R.W. 1947. "Psychological Aspects of Punishment." Ethics, Vol.58, No 1
2. Ансель М. Новая социальная защита (гуманистическое движение в уголовной политике). М., 1970
3. Jolin/Rogers, Journal of Contemporary Criminal Justice 1989, p. 141; Schmidt, Journal of Contemporary Criminal Justice 1989
4. Теория права и государства. Под ред. Г.Н.Манова, М., 1996
5. Михлин А.С. Уголовно-исполнительное право. М., 2000, Пономарев П.Г. . Уголовно-исполнительное право. М., 1999
6. А.Съез. Ялын ойлголт, зорилго, үр нөлөө. Эрх зүйн шинэтгэл: Эрүүгийн эрх зүйн асуудал. 2001
7. Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018
8. Т.Золбоо. Эрүүгийн эрх зүй, ерөнхий анги: Гэмт хэргийн бүтээц. УБ., 2018
9. Осман Долу. Криминологийн онолууд. Улаанбаатар хот, 2022
10. Ц.Мөнхбат. Нийтэд тустай ажил хийлгэх ял. УБ., 2020
11. Эрх зүйн ерөнхий онол. Ч.Нямсүрэн, Улаанбаатар хот, 2021
12. Нээлттэй нийгэм форум. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт /судалгааны тайлан/. УБ., 2022
13. Э.Батбаяр, Б.Ганболд. Хорихоос өөр төрлийн ял. УБ., 2023

Хоёр. Олон улсын конвенц, дотоодын хууль тогтоомж

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 он.
2. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
3. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015 он
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017 он
5. Засгийн газрын 2021 оны 94 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам”

Гурав. Цахим эх сурвалж

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем [/www.legalinfo.mn/](http://www.legalinfo.mn/)
2. Монгол Улсын Ерөнхий прокурорын газар [/www.prosecutor.mn/](http://www.prosecutor.mn/)

ХОРИГДЛЫН ТҮР БОЛОН УДААН ХУГАЦААНЫ УУЛЗАЛТ АВАХ ЭРХ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Төв аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Д.Сүрэнхор

Хураангуй:

Хорих ял эдэлж буй ялтны зарим эрх болох түр ба удаан хугацааны уулзалт авах эрхийг нэмэгдүүлж гэр бүлтэйгээ илүү ойр байх нөхцөл боломжийг бүрдүүлснээр хоригдлын гэр бүлдээ эзлэх байр суурийн ач холбогдлыг таниулах, гэр бүлийн харилцаагаар дамжуулан төлөвшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хохирол, хор уршгийг ойлгон ухамсарлуулах, нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэхэд уг илтгэлийн зорилго оршино.

Илтгэлд хууль зүйн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгддэг судалгааны аргуудыг сэдвийн онцлогт тохируулан хэрэглэхдээ харьцуулах, системчлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, түүхчлэх, нэгжээс ерөнхийд шилжин дүгнэлт гаргах зэрэг аргуудад тулгуурлан, сэдэвтэй шууд болон шууд бус холбоотой бүтээл, онол арга зүйн шинжтэй төрөл бүрийн мэдээлэл, материал, эх сурвалжид тулгуурлан түүнд анализ хийх аргыг өргөнөөр ашигласан.

Түлхүүр үгс:

Эрүүгийн хариуцлага, хорих ял, ял шийтгэлийн зорилго, хорих байгууллага, хорих байгууллагын чиг үүрэг, хоригдлын эрх, эргэлт, уулзалт авах эрх.

Удиртгал

Хуулиар олгогдсон чиг үүргийнхээ хүрээнд хорих ангийн үйл ажиллагаатай биечлэн танилцах, шалгах явцдаа хоригдлуудаас санал хүсэлтийг тодруулахад хуульд заасны дагуу гэр бүлийн гишүүдтэй удаан, бусад хүнтэй түр хугацаагаар уулзах эргэлт, уулзалтын хугацаа хол байгаагаас зарим тохиолдолд гэр бүл салдаг, харилцаа холбоо мууддаг, сэтгэл санаа тогтворгүй болдог талаар илэрхийлж байсан.

Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршдог.

Хоригдлыг нийгэмшүүлэхэд хорих анги дахь сургалт, нийгэмшүүлэх, соёл хүмүүжлийн ажлаас гадна ар гэрийн харилцаа холбоо, анхаарал халамж, дэмжлэг туслалцаа ихээхэн үр нөлөөтэй байдаг.

Гэтэл хуулиар олгогдсон эргэлт, уулзалт авах эрх хэтэрхий хязгаарлагдмал байгаагаас шалтгаалан ар гэрийн харилцаа хөндийрөх, хоригдлын сэтгэл зүйн байдал тогтворгүй болох, цаашлаад түүнээс шалтгаалан аливаа орголт, гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй байдаг бөгөөд дээрх эрсдэлүүд гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой зохицуулалт шаардлагатай байгаа тул уг сэдвийг сонгох болсон.

Үндсэн хэсэг

Хорих ял эдлүүлэх ажиллагаа болон хоригдлын эрхийн тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт:

Нэгдүгээрт хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн бүрэлдэхүүн болох хорих ял, хорих байгууллага болон хоригдлын талаарх ойлголтыг тодорхойлох нь зүйтэй.

Монгол улсын холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг судалж үзэхэд дээрх нэр томъёонуудыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг **хорих ял** гэнэ.”¹
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 195 дугаар зүйлийн 195.5 дахь хэсэгт “Хорих ял эдэлж байгаа ялтанг **хоригдол** гэнэ.”²
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 267 дугаар зүйлийн 267.1 дэх хэсэгт “**Хорих анги** нь цагдан хорих шүүхийн шийдвэрийг биелүүлж гэм буруутай этгээдийг нийгмээс тусгаарлаж, эрх, эрх чөлөөнд нь хуульд заасан хязгаарлалт тогтоож, шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага...” гэж тус тус тодорхойлсон байдаг.

Хорих ангийн үндсэн чиг үүрэг, зорилго нь гэмт хэрэг үйлдэж шүүхээс хорих ял шийтгүүлсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар хязгаарлаж, нээлттэй эсхүл хаалттай хорих байгууллагад ял эдлүүлэх явцад хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэгдсэн байдаг.

Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршдог³.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан ялын төрөлд багтах хорих ялыг эдлүүлэх нөхцөл, журам нь бусад төрлийн ялтай харьцуулахад хамгийн хүндэд тооцогддог.

Өөрөөр хэлбэл хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүн иргэнийхээ эрхийг үндсэндээ бүрэн эдэлдэг байдлыг хорих ял шийтгүүлсэн хүнтэй харьцуулах аргагүй юм.

Иймд хорих ял шийтгүүлсэн ялтны эрхийн байдлыг тусгайлан авч үзэх шаардлагатай болдог.

Түр болон удаан хугацааны уулзалт авах эрхийн эрхийн тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт:

Энэхүү илтгэлийн гол сэдэв болсон хоригдлын эрхүүдээс эргэлт, уулзалт авах эрхийг тусгайлан авч үзэж байна.

Аль ч улсын иргэн тухайн улсад мөрдөгдөж байгаа хуулийн заалтыг зөрчин шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ял эдэлж байгаа ч тэр л улсынхаа иргэний үндсэн

¹ Монгол улсын Эрүүгийн хууль 5.6.1 дүгээр зүйл 2015 он

² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 195 дугаар зүйл 195.5, 2017 он

³ Монгол улсын Эрүүгийн хууль 5.6.1 дүгээр зүйл 2015 он

эрхийг эдэлж, үүрэг хүлээх, ингэхдээ зохих хязгаарлалттай байх түгээмэл зарчим байдаг.

Хоригдлын эрх хэдийгээр хязгаарлагдмал ч хууль тогтоомжоор баталгаажсан⁴ байдгаас эргэлт уулзалт авах эрхийг дараах эрх зүйн баримт бичгүүдэд баталгаажуулж өгчээ. Үүнд:

- ✚ Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмүүдийн 37 дугаар зүйл “Хоригдлуудад тогтмол цаг хугацаанд, зохих хяналтын дор гэр бүлийнхэнтэйгээ болон нэр төрдөө сэв суулгаагүй найз нөхөдтэйгээ захидлаар харилцаж буюу биечлэн уулзаж харилцах боломж олгож байвал зохино.”⁵
- ✚ Хоригдлуудтай харьцах наад захын үндсэн зарчмууд 1990 он 10 дугаар зүйл “Хорих ял эдэлсэн хүмүүс олон нийтийн болон нийгмийн байгууллагуудын оролцоо, тусламжтайгаар, хохирогчийн ашиг сонирхлыг хохироохгүйгээр аль болох зохистой байдлаар нийгмийн амьдралд эргэн орох таатай нөхцөлийг, бий болговол зохино”⁶
- ✚ Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогцын 19 дүгээр зарчим “Саатуулагдсан болон хоригдсон этгээд тухайлбал гэр бүлийн гишүүдтэйгээ уулзах, тэдэнтэй захидлаар харьцах түүнчлэн хуулиар буюу хуульд нийцүүлж тогтоосон гадаад орчинтой харилцах эрхтэй”⁷
- ✚ Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 210 дугаар зүйлийн 210.1.6 дахь хэсэгт “Хоригдол хуульд заасны дагуу гэр бүлийн гишүүнтэй удаан, бусад хүнтэй түр хугацаагаар уулзах, суурин утас, захидлаар харилцах, илгээмж авах, өөрийн нэрийн дансаар дамжуулж мөнгөн гуйвуулга авах, явуулах” эрхтэй⁸ гэж тус тус заасан байдаг.

Хоригдол зохих хяналтад эхнэр, нөхөр, хүүхэд, төрсөн болон хадам эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, өвөг эцэг, эмэг эх, нэг ам бүлд хамт амьдардаг ач, зээтэй **удаан**, бусад хүнтэй **түр** хугацааны уулзалт хийж болно.⁹

Эргэлт, уулзалт гэдэг нь хоригдож байгаа хүнтэй биеэр уулзахыг хэлнэ.¹⁰

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хоригдлын эргэлт уулзалтын хугацааг дараах байдлаар зохицуулсан байдаг. Үүнд:

Удаан хугацааны уулзалтыг нээлттэй дэглэмийн энгийн зэрэглэлд ял эдэлж буй хоригдол 30 хоногт 1 удаа, нээлттэй дэглэмийн тусгай зэрэглэлд ял эдэлж буй хоригдол 45 хоногт 1 удаа, хаалттай дэглэмийн энгийн зэрэглэлд ял эдэлж буй хоригдолд 90 хоногт 1 удаа, хаалттай дэглэмийн тусгай зэрэглэлд ял эдэлж буй хоригдол 120 хоногт 1 удаа удаан хугацааны эргэлт уулзалт авч байна. Харин хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлын хувьд удаан хугацааны эргэлт, уулзалтын бүр мөсөн хязгаарласан байдаг.

⁴ А.Лхагва “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй”, УБ хот, 2012 он, 151 дэх тал

⁵ Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмүүд 37 дугаар зүйл, 1955 он

⁶ Хоригдлуудтай харьцах наад захын үндсэн зарчмууд 10 дугаар зүйл, 1990 он

⁷ Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц 19 дүгээр зарчим, 1988 он

⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 210 дугаар зүйл 210.1.6 дахь хэсэг, 2017 он

⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 213 дугаар зүйл 213.1, 2017 он

¹⁰ Монгол хэлний тайлбар толь

Түр хугацааны уулзалтыг нээлттэй дэглэмийн энгийн зэрэглэлд ял эдэлж буй хоригдол тоо хязгаарлахгүй, нээлттэй дэглэмийн тусгай зэрэглэлд ял эдэлж буй хоригдол 7 хоногт 1 удаа, хаалттай дэглэмийн энгийн зэрэглэлд ял эдэлж буй хоригдолд 60 хоногт 1 удаа, хаалттай дэглэмийн тусгай зэрэглэлд ял эдэлж буй хоригдол 90 хоногт 1 удаа, хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдол авч байна.

Дээрх байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Эргэлт, уулзалт

	Нээлттэй энгийн	Нээлттэй тусгай	Хаалттай энгийн	Хаалттай тусгай	Хаалттай тусгай нэгж
Түр	Тоо хязгаарлахгүй	7 хоногт 1 удаа	60 хоногт 1 удаа	90 хоногт 1 удаа	180 хоногт 2 удаа
Удаан	30 хоногт 1 удаа	45 хоногт 1 удаа	90 хоногт 1 удаа	120 хоногт 1 удаа	-

Мөн түр хугацааны уулзалтын үргэлжлэх хугацаа 3 цаг хүртэл, удаан хугацааны уулзалтын үргэлжлэх хугацаа 72 цаг хүртэл байдаг.

Сэдвийн хүрээнд бодит нөхцөл байдлыг судалсан судалгааны дүнгийн талаар

Хоригдлын түр болон удаан хугацааны эргэлт, уулзалт авах эрхийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, түүний шалтгаан нөхцөлийг тогтоох зорилгоор хяналтын харьяа хорих ангиудад ял эдэлж буй нийт 560 гаруй хоригдлуудаас “Хуульд заасны дагуу түр болон удаан хугацааны эргэлт, уулзалтын тоо, Эргэлт, уулзалтын хугацаа хангалттай байдаг” эсэх талаар санал, асуулгын хуудсаар судалгааг авч дүгнэлт хийсэн бөгөөд судалгааны үр дүнг ял эдэлж буй дэглэм, зэрэглэл тус бүрээр харьцуулахад дараах үр дүн гарч байна.

1. Нээлттэй дэглэмийн энгийн зэрэглэлд ял эдэлж буй хоригдлуудын хувьд түр хугацааны эргэлт, уулзалтын тоо 100 хувь хангалттай байдаг гэх үр дүн гарсан. Учир нь дээрх зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдлуудын эргэлт уулзалтын тоог хязгаарладаггүй. Харин судалгаанд оролцогчдын 91 хувь нь удаан хугацааны эргэлт, уулзалтын тоо “хангалттай” 9 хувь нь эргэлт, уулзалтын тоо “хангалтгүй” байдаг гэх хариултыг өгсөн.

График 1. Нээлттэй дэглэмийн энгийн зэрэглэлд ял эдэлж буй хоригдлуудын эргэлт уулзалтын тоо хангалттай байдаг эсэх судалгааны үр дүн




2. Нээлттэй дэглэмийн тусгай зэрэглэлд ял эдэлж буй хоригдлуудаас авсан судалгааг дүгнэхэд 92,7 хувь нь түр хугацааны эргэлт, уулзалтын тоо хангалттай, 7,3 хувь нь хангалтгүй гэх хариултыг өгсөн байна. Харин судалгаанд оролцогчдын 77,3 хувь нь удаан хугацааны эргэлт, уулзалтын тоо "хангалттай" 22,7 хувь нь эргэлт, уулзалтын тоо "хангалтгүй" байдаг гэх хариултыг өгсөн.

График 2. Нээлттэй дэглэмийн тусгай зэрэглэлд ял эдэлж буй хоригдлуудын эргэлт уулзалтын тоо хангалттай байдаг эсэх судалгааны үр дүн




3. Хаалттай дэглэмийн энгийн зэрэглэлд ял эдэлж буй хоригдлуудаас авсан судалгааг дүгнэхэд 83,2 хувь нь түр хугацааны эргэлт, уулзалтын тоо "хангалтгүй", 16,8 хувь нь "хангалттай" гэх хариултыг өгсөн байна. Харин судалгаанд оролцогчдын 88,1 хувь нь удаан хугацааны эргэлт, уулзалтын тоо "хангалтгүй" 11,9 хувь нь эргэлт, уулзалтын тоо "хангалттай" байдаг гэх хариултыг өгсөн.

График 3. Хаалттай дэглэмийн энгийн зэрэглэлд ял эдэлж буй хоригдлуудын эргэлт уулзалтын тоо хангалттай байдаг эсэх судалгааны үр дүн



4. Хаалттай дэглэмийн тусгай зэрэглэлд ял эдэлж буй хоригдлуудаас авсан судалгааг дүгнэхэд 91,4 хувь нь түр хугацааны эргэлт, уулзалтын тоо “хангалтгүй”, 8,6 хувь нь “хангалттай” гэх хариултыг өгсөн байна. Харин судалгаанд оролцогчдын 97,3 хувь нь удаан хугацааны эргэлт, уулзалтын тоо “хангалтгүй” 2,7 хувь нь эргэлт, уулзалтын тоо “хангалттай” байдаг гэх хариултыг өгсөн.

График 4. Хаалттай дэглэмийн тусгай зэрэглэлд ял эдэлж буй хоригдлуудын эргэлт уулзалтын тоо хангалттай байдаг эсэх судалгааны үр дүн



5. Хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлуудаас авсан судалгааг дүгнэхэд 95 хувь нь түр хугацааны эргэлт, уулзалтын тоо “хангалтгүй”, 5 хувь нь “хангалттай” гэх хариултыг өгсөн байна. Судалгаанд оролцсон нийт хоригдлууд 100 хувь нь эргэлт, уулзалтын тоо “хангалтгүй” байдаг гэх хариултыг өгсөн. Учир нь тус зэрэглэлд удаан хугацааны эргэлт, уулзалт хийх эрхийг бүрэн хязгаарласан байдагтай шууд холбоотой.

График 5. Хаалттай дэглэмийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлуудын эргэлт, уулзалтын тоо хангалттай байдаг эсэх судалгааны үр дүн



6. Түр /3 цаг хүртэл/ болон удаан /72 цаг хүртэл/ хугацааны эргэлт уулзалтын хугацаа хангалттай байдаг уу? гэх асуултанд судалгаанд оролцогчдын 91,6 хувь нь “хангалттай”, 8,4 хувь нь “Хангалтгүй” гэх хариултуудыг өгсөн байна.

График 6. Хаалттай дэглэмийн тусгай зэрэглэлд ял эдэлж буй хоригдлуудын эргэлт уулзалтын тоо хангалттай байдаг эсэх судалгааны үр дүн



Дээрх судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэхэд нээлттэй дэглэмд ял эдэлж буй ялтнуудын зүгээс түр болон удаан хугацааны уулзалт хангалттай гэх хариултыг 90-ээс дээш хувь нь өгсөн бол хаалттай дэглэмд ял эдэлж хоригдлуудын 90-ээс дээш хувь нь хангалтгүй гэх хариултыг өгсөн байна.

Түр болон удаан хугацааны уулзалт авах эрхийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал

Эргэлт, уулзалт бол нэг талаасаа **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хөндлөнгийн хяналт** гэж үздэг бөгөөд хоригдлуудын хувьд түр болон удаан хугацааны эргэлт, уулзалт авах эрх нь тэдэнд эхнэр, нөхөр, хүүхдэд гэр бүлийн бусад гишүүд төрөл садангийн хүмүүстэйгээ уулзах боломжийг бүрдүүлж байдгаараа онцлог. Энэ эрхийг хэтэрхий их хязгаарлах нь тухайн этгээдтэй хүн ёсноос гадуур хүнлэг бус харьцаж буйн илрэл юм. Монгол улсад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тогтоосон эргэлт, уулзалтын хязгаарлалт нь зарим дэглэмд хэт хатуу байдаг бөгөөд хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлуудын удаан хугацааны эргэлтийг бүр мөсөн хязгаарласан нь олон улсын хэмжээнд хүний эрхийн зөрчилд

тооцогдож байна. Манай улсын хувьд хоригдлууд ял эдэлж буй дэглэм, зэрэглэлээсээ шалтгаалан эргэлт, уулзалт авах эрхээ ялгамжтай байдлаар эдэлж байна.¹¹

Энэ талаар Монгол улсын хүний эрхийн Үндэсний комисс 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдөр илтгэлийг хэлэлцэн Монгол улсын их хуралд өргөн барьсан байна. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр шинэчлэн батлахдаа дээрх асуудлыг шийдвэрлээгүй байгаа нь харамсалтай.

Олон улсын гэрээ конвенц, эрх зүйн баримт бичгүүдэд гэр бүлийн гишүүдтэйгээ биечлэн уулзах эрхийг тусгайлан баталгаажуулж өгсөн байтал ялангуяа хаалттай дэглэмд ял эдэлж буй хоригдлуудын түр болон удаан хугацааны эргэлт, уулзалт авах тоо хэтэрхий хязгаарлагдмал түүнээс шалтгаалан хорих ял эдлэгсдийн ар гэрийн харилцаа холбоо хөндийрөх, цаашлаад гэр бүл салах, хоригдлын нэн тэргүүний хэрэгцээ болох сэтгэл санаа, бие физиологийн хэрэгцээнүүд хангагдахгүй байгаагаас шалтгаалан хоригдолд оргох, гэмт хэрэг, зөрчил үйлдэх сэдлүүд төрж байгаа нь тулгамдаж буй асуудал болж байгаа нь судалгааны үр дүнгээс тодорхой харагдаж байна.

Хорих байгууллагын дэглэмийн нэн чухал зорилго нь хоригдлыг засан хүмүүжүүлж, нийгмийн хэвийн гишүүн болгох явдал байна.¹²

Дүгнэлт

Хорих байгууллага нь гэмт хэрэг үйлдэж шүүхээс хорих ял шийтгүүлсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар хязгаарлаж, нээлттэй эсхүл хаалттай хорих байгууллагад ял эдлүүлэх явцад хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгох зорилгоор ажилладаг.

Уг байгууллага нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Их хурлаас баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг баримтлан хоригдолд хориглоогүй эрхүүдийг хуулийн хүрээнд эдлүүлдэг.

Хоригдол гэр бүлийн гишүүдтэйгээ уулзах харилцах эрхийг хэтэрхий хязгаарласнаас хорих ял эдлэгсдийн ар гэрийн харилцаа холбоо хөндийрөх, цаашлаад гэр бүл салах, хоригдлын нэн тэргүүний хэрэгцээ болох сэтгэл санаа, бие физиологийн хэрэгцээнүүд хангагдахгүй байгаагаас шалтгаалан хоригдолд оргох, гэмт хэрэг, зөрчил үйлдэх сэдлүүд төрж байдаг.

Иймд хорих ялаар шийтгүүлсэн ялтан, ялангуяа хаалттай дэглэмийн энгийн болон тусгай зэрэглэл, тусгай нэгжид ял эдэлж байгаа хоригдлын эргэлт, уулзалт авах эрхийг үе шаттайгаар, судалгаанд үндэслэн нэмэгдүүлж гэр бүлтэйгээ илүү ойр байх нөхцөл боломжийг бүрдүүлснээр хоригдлын гэр бүлдээ эзлэх байр суурийн ач холбогдлыг таниулах, гэр бүлийн харилцаагаар дамжуулан төлөвшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хохирол, хор уршгийг ойлгон ухамсарлуулах, нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэхэд чухал ач холбогдолтой гэсэн дүгнэлтэд хүрсэн болно.

¹¹ Монгол улс дах хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл, 43 дахь тал, 2016 он

¹² Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 1966 он

Санал

Хоригдлыг гэр бүлтэйгээ илүү ойр байх нөхцөл боломжийг бүрдүүлэх, гэр бүлийн харилцаагаар дамжуулан төлөвшүүлэх боломжийг нэмэгдүүлэх нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлуудыг удаан хугацааны эргэлт, уулзалт авах эрхийн хязгаарлалтыг сэргээх;

2. Хаалттай дэглэмд ял эдэлж буй хоригдлуудын түр болон удаан хугацааны эргэлт уулзалт хийх тоог нэмэгдүүлэх. Жишээлбэл: Хаалттай дэглэмийн энгийн зэрэглэлд ял эдэлж буй хоригдлын түр хугацааны уулзалт хийх тоог 30 хоногт 1 удаа, удаан хугацааны уулзалт хийх тоог 60 хоногт 1 удаа тусгай зэрэглэлд ял эдэлж буй хоригдлын түр хугацааны уулзалт хийх тоог 60 хоногт 1 удаа, удаан хугацааны уулзалт хийх тоог 90 хоногт 1 удаа болгох;

3. Хоригдлын өдөр тутмын нэн тэргүүний хэрэгцээт ариун цэвэр, хүнсний болон ахуйн барааг ар гэрээсээ авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор эргэлт уулзалт авах эрхээс гадна илгээмж авах, утсаар ярих тоог нэмэгдүүлэх;

4. Түр болон удаан хугацааны уулзалтын байрны ахуй нөхцөлийг сайжруулах, уулзаж буй этгээдийн аюулгүй байдлыг хангах;

Эцэст нь тэмдэглэхэд эргэлт, уулзалт бол нэг талаасаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хөндлөнгийн хяналт гэж үздэг бөгөөд хоригдлыг гэр бүлтэйгээ илүү ойр байлгах, гэр бүлийн харилцаагаар дамжуулан төлөвшүүлж, нийгэмшүүлснээр эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад чухал үр нөлөөтэй юм.

Ашигласан эх сурвалж

Хууль, эрх зүйн акт:

1. Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмүүд 1955 он
2. Хоригдлуудтай харьцах наад захын үндсэн зарчмууд 1990 он
3. Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц 1988 он
4. Эрүүгийн хууль 2015 он
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

Монгол хэл дээрх ном, зохиол:

6. А.Лхагва “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй”, УБ хот, 2012 он
7. Монгол улс дах хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл, 43 дахь тал, 2016 он
8. Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол, шийдвэрийн эмхэтгэл, УБ хот, 2014 он

Ашигласан вэб сайт:

9. <https://legalinfo.mn/mn/detail/12701>
10. <https://mongoltoli.mn/>

ЦАГДАН ХОРИХ БАЙРАНД ГАРЧ БУЙ ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Нийслэлийн Прокурорын газрын хяналтын прокурор Б.Энхбат

Хураангуй:

Энэхүү илтгэлээрээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа, Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид цагдан хоригдсон хүмүүсийн зүгээс гаргаж буй зөрчил, гаргасан зөрчлийн шалтгаан нөхцөл, алба хаагчдаас гарч буй зөрчлийн эсрэг авсан арга хэмжээ, тэдгээрт хэрхэн нөлөөлөх талаарх сүүлийн хоёр жилийн тоон судалгаанд үндэслэн дүн шинжилгээ хийж санал, дүгнэлтийг дэвшүүлэн гаргасан болно.

Түлхүүр үгс:

Цагдан хорих байр, хоригдогч, албан хаагчийн аюулгүй байдал, зөрчил, дүн шинжилгээ.

Удиртгал

“Хууль” бол нийгмийн харилцааг зохицуулж буй төрийн бодлого. Хуулиар дамжуулан тухайн улсын явуулж буй бодлогыг харж, нийгмийг таньж мэдэрч болдог бөгөөд хүн хуулийн дор төрж, хуулийн дор амьдардаг нь жам билээ.

Нийгэм болон нийгмийн үнэт зүйл, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэхийн тулд төр зарим тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн, үйлдсэн байж болзошгүй хэмээн сэжиглэгдэж буй хүмүүсийн тодорхой төрлийн зарим эрхүүдийг эрх бүхий албан тушаалтнаас хуульд заасан үндэслэлээр гаргасан шийдвэрийн дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хязгаарладаг буюу таслан сэргийлэх арга хэмжээг авч хэрэглэдэг, үүнээс хамгийн хүнд хэлбэрийн нэг бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ юм.

Шүүхийн шийдвэрээр цагдан хорих байранд хоригдож буй хоригдогч хүмүүс нь эрүүгийн хэрэгт ял шийтгүүлээгүй, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт сэжиглэгдэн түр хугацаагаар саатуулагдан шалгагдаж байгаа иргэд тул “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”-д заасан зарим хязгаарлалтаас бусад жам ёсны эрхүүдийг бүрэн эдэлж байдгаараа онцлогтой.

Цагдан хоригдсон хүмүүсийн эрх зүйн байдал, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх нөхцөл, журмыг тодорхойлох, Цагдан хорих байрны өдөр тутмын үйл ажиллагаа, харуул хамгаалалт, аюулгүй байдал, тэдгээртэй холбогдсон харилцааг “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” (1999 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд 2002 оны 01 дүгээр сарын 10-ны хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан), Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дүгээр тушаалаар батлагдсан “Хорих байрны дотоод журам” болон Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, бусад эрх зүйн актуудад тулгуурлан зохицуулсан байдаг.

Энэхүү илтгэлээрээ дээрх хууль, журмын хэрэгжилт нь практикт хэрхэн хэрэгжиж байгаа, цагдан хоригдсон хүмүүсийн зүгээс гаргаж буй зөрчлийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж зөрчлийг бууруулахад эрх зүйн болоод үйл ажиллагаанд анхаарах асуудлын талаар санал бодлоо илэрхийлэхийг зорилоо.

Үндсэн хэсэг

Гэмт явдал нь эрх зүйт төрийн тогтсон дэг журам, хэлбэр агуулгад харшилсан хэвээр байгаа энэ үед гэмт этгээд болон сэжиглэгдэж буй иргэдийн эрх, эрх чөлөөг хуулийн дагуу хязгаарлах үйл ажиллагаа нь эрх зүйт төрийн үндсэн зарчимд хэрхэн нийцэж байгааг судлах нь гэмт хэргийг хуулийн хүрээнд илрүүлэх, баримтжуулахад чухал ач холбогдолтой.

Өнөөдрийн байдлаар гэмт хэрэг дахин үйлдэх хүмүүсийн тоо эрс нэмэгдсэн нь хорих ял эдлэгсдийн тавиас дээш хувийг эзэлж байна, түүнчлэн хорих ял эдлэгсдийн 70 орчим хувь нь гэмт хэргийг бүлэглэн үйлдэгсэд, мөн гэмт хэргийн 70 орчим хувийг 18-35 насны залуучууд үйлдэж буй харамсалтай тоо баримт судалгаагаар батлагдсан байна¹. Энэ судалгаа тоо баримтаас үзэхэд хорих ялаар шийтгүүлсэн тохиолдол улам залуужиж **Хорих байгууллага** хоригдлыг хуульд² зааснаар хүмүүжлийн нөлөө үзүүлэх биш харин гэмт хэрэг дахин үйлдэх хань хамсаатантай болгох, гэмт хэрэг үйлдэх талаар харилцан мэдээлэл, туршлага судлах, гэмт үйлдэлдээ мэргэшэх байдалд хүргэж гэмт хэрэгтнүүдийг бэлтгэдэг **Уурхай**, хоригдлууд хэд хэдэн төрлийн гэмт хэрэг үйлдээд аль хөнгөн гэмт хэрэгт ял шийтгүүлэн хорих байгууллагыг гэмт **Хэргээ нуун далдлах газар** болгон ашиглаж байж болзошгүй байгаа талаар судлаачдын³ гаргасан саналтай илтгэгч санал нэг байгааг дурдах нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улс харилцаа холбоо, технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан цахим шилжилтэд шилжиж буй энэ цаг үед шинэ төрлийн гэмт хэргийн тоо нэмэгдэж, гэмт этгээдүүдийн үйлдлийн арга, сэдэл нарийсаж, улам зохион байгуулалттай болж, нийгэмд учруулж буй гэм хор, хохирол хор уршгийн хэмжээ өсөж, хорих ял эдлэгсдийн дотор урьд төдийлөн үйлдэгддэггүй байсан хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодис, хүн худалдаалах, мөнгө угаах, авлига хээл хахуул, цахим залилангийн гэмт хэрэгт ял шийтгүүлэх явдал улам өсөх хандлагатай болж байна. Гэмт хэргийг илрүүлэхэд санаатай саад учруулах, дахин гэмт хэрэг үйлдэх, мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шатнаас оргон зайлсан, зайлж болзошгүй тохиолдолд тухайн этгээдэд эрх бүхий албан тушаалтнаас хуульд заасан үндэслэлээр гаргасан шийдвэрийн дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсаар байна.

Цагдан хорих байранд хоригдож буй хоригдсон хүмүүс шалгагдаж буй эрүүгийн хэргээс шалтгаалан сэтгэл зүйн байдлын хувьд тогтворгүй байдаг тул харуул, хамгаалалтын хяналтыг тасралтгүй тавих шаардлага бий болдог, одоогийн байдлаар цагдан хорих төвд нэг хамгаалалтын ажилтанд 70-100 хоригдогч ноогдож байгаа нь батлагдсан нормативаас 6-10 дахин их ачаалалтай байгаа нь харуул хамгаалалтын хүч суларч гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй байдал бий болсон гэж үзэхээр байна. Тухайлбал, Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид 2022 онд зөвхөн утаат тамхитай холбоотой зөрчил 442 гарсан байна.

¹ ШШГЕГ-ийн Ялтны сургалт хүмүүжлийн хэлтсийн нэгдсэн судалгаа. УБ. 2023. 10 сар.

² ШШГТХ-ийн 267.2.3 хорих байгууллага нь “Хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх” чиг үүрэгтэйг заасан байна.

³ Б.Нямгомбо “Терроризм ба хорих байгууллага” илтгэл 2011 он.

Зөрчил гэдгийг ⁴ “Аливаа нэг талын тодорхой үйл ажиллагаагаар нөгөө талын эрх ашиг, байр суурь хөндөгдсөний улмаас харилцаанд зөрчил үүсэхийг хэлнэ. Харилцан хоёр талуудын харилцаан дээр асуудал үүсэхийг зөрчил гэнэ” гэж тодорхойлсон. Зөрчил үүсэх шалтгаан⁵:

- Үзэл бодлын зөрөө,
- Үл ойлголцол, Үл итгэлцэл,
- Хүсэл сонирхол, тэмүүлэл,
- Зорилго, Байр суурь,
- Дарамт, Атаархал зэрэг болно.

Зөрчлийн тухай хууль⁶ 2.1-д “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ” гэж тодорхойлжээ.

Шүүхийн шийдвэрээр цагдан хоригдож буй хүмүүст архины болон сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий, сэтгэцийн хувьд тулгамдсан асуудалтай, архаг хууч өвчтэй, олон удаагийн ял шийтгэлтэй, зан чанарын хувьд янз бүрийн ааш араншинтай хүмүүс хоригддог.

Эдгээр хоригдсон хүмүүсийн зүгээс шалгагдаж буй эрүүгийн хэргийн нөхцөл байдал, орчин нөхцөлийн өөрчлөлтөөс үүдсэн цагдан хорих байранд ажиллаж буй алба хаагч нарт өөрөө болон бусдаар нөлөөлүүлэхийг оролдох, өөртөө ашигтай шийдвэр гаргуулахыг эрмэлзэх, албан хаагчдад мөнгө төгрөг амлах, өгөх, өгөхийг завдах янз бүрийн аргаар эрхшээлдээ оруулахыг хичээх зэрэг алба хаагчдыг үүрэг гүйцэтгэхэд хүндрэл үүсгэдэг. Мөн хоригдсон хүмүүс нь сэтгэл зүйн тулгамдсан асуудлаас шалтгаалан бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулах, амиа хорлох, алба хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх, хэл амаар доромжлох, биед нь халдахыг завдах зэрэг зүй бус үйлдлүүд гаргасаар байгаа нь албан үүргээ гүйцэтгэж буй алба хаагчдад сэтгэл зүйн дарамт, айдас түгшүүрийг бий болгож байдаг талаар тус ангийн албан хаагч нартай уулзаж, ярилцахад дурдаж байсныг хэлэх нь зүйтэй байх.

Тухайлбал, Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид зөвхөн 2023 онд⁷ нийт 22 хоригдогч өөрийн амиа хорлох үйлдэл буюу дүүжлэгдсэн, судсаа ханасан зэрэг үйлдлийг харуул хамгаалалтын биечилсэн болон дүрс бичлэг, хяналтын ажилтнууд шуурхай илрүүлэн, таслан зогсоосон байна. Мөн тус ангийн хоригдогч, аж ахуй үйлчилгээний хоригдлуудын дундаас 2023 онд гарсан 44 зөрчилд⁸ дүн шинжилгээ хийж үзвэл:

1.Хорих ангийн аж ахуй үйлчилгээнд ажиллаж буй хоригдлуудаас нийт 6 зөрчил гаргасан, зөрчил гаргасан тухай бүрд албаны шалгалтыг явуулж, хуульд заасны дагуу хорих ангийн даргын тушаалаар сахилгын арга хэмжээ авсан, гаргасан зөрчлийн

⁴ Монголын Хүний нөөцийн институт. Mhri.mn Зөрчил ба зөрөлдөөн гэж юу вэ?

⁵ Монголын Хүний нөөцийн институт. Mhri.mn Зөрчил ба зөрөлдөөн гэж юу вэ?

⁶ Зөрчлийн тухай хууль 2017 он.

⁷ Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих ангийн тайлан. УБ, 2023 он.

⁸ Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн 2023 оны зөрчлийн судалгаа, тайлан. УБ

дийлэнх буюу 80 хувь нь хоригдлууд өөр хоорондын харилцаанаас үүдэлтэй үл ойлголцлын улмаас маргалдаж жижгээр танхайрсан үйлдлүүд гарсан байна.

2.Цагдан хоригдсон хүмүүсээс нийт 38 зөрчил гаргасан, зөрчлийг тохиолдол тус бүрээр задалж авч үзвэл:

-Албан хаагчийн биед халдахаар заналхийлсэн 3;

-Жижгээр танхайрсан, харилцан зодолдсон 20;

-Хоригдсон бусад хүмүүсийг дарамталсан, доромжилсон 2;

-Албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэж хэл амаар доромжилсон, биед халдсан 16 тохиолдол тус тус гарсан байна.

Дээрх зөрчлүүдийн дийлэнх хувийг танхайрч, харилцсан зодолдсон зөрчил 52,6 хувь, алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн болон биед халдсан зөрчил нийт зөрчлийн 42.1 хувийг эзэлж байна.

Хоригдогчийн гаргасан зөрчлийг шалгасан албаны шалгалтын материалд дүн шинжилгээ хийхэд хоригдсон хүмүүс өөрийн шалгагдаж байгаа эрүүгийн хэргийн нөхцөл байдал, хязгаарлагдмал орчин нөхцөлд дасан зохицож чадахгүй, уур бухимдлаа барьж чадахгүй байх, ар гэрт тохиолдсон хүндрэл, гачигдал, үзэл бодлын зөрүүнээс үүдэлтэй бие биеэ дарамтлах, өш хонзон, атаархлаас үүдсэн харилцаа хандлага нь зөрчил үүсэх шалтгаан болж байгаагаас гадна удаа дараа ял шийтгэл эдэлж байсан хүмүүс ихэнх зөрчлийг гаргаж байгаа ба тэдгээр нь хамт хоригдож буй бусад хоригдогчдын дунд өөрийн байр сууриа олох зорилго агуулсан байх хандлагатай байж болзошгүй гэж дүгнэж болохоор байна.

Цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангахын тулд албан хаагчдын хоорондын ажлын уялдаа холбоог уялдуулж, харилцан мэдээлэл байнга солилцож байх, удирдлагын түвшний албан хаагчид дотоод нөхцөл байдлыг зөв мэдэрч, цаг үеэ олсон шийдвэрийг гаргаж биелэлтэд байнгын хяналт тавьж ажилласнаар цагдан хорих байрны аюулгүй байдал хангагдах, зөрчлийг бууруулах гол үндсэн нөхцөл бүрдэнэ. Энэ талаар тус анги хоригдогч нараас тулгамдаж буй асуудлын талаар 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр нийт хоригдогч нараас санал асуулга авч дүн шинжилгээ хийн гарч болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хоригдогсдын хоолны асуудал, дэлгүүрийн үйлчилгээний асуудал, тамхины асуудал, эмнэлгийн үйлчилгээний асуудал, өргөдөл гомдлын асуудал, хууль эрх зүй, сэтгэл зүйн үйлчилгээний асуудлыг шийдвэрлэснээр хоригдогчийн дундаас гарч байсан зөрчил 90-92 хувь, үйл ажиллагаатай холбоотой гомдол, санал 90-ээс дээш хувь буурсан нь алба нэгжийн ажлын уялдаа холбоо сайжирсан мөн дарга, харуул хамгаалалт болон нийгэм сэтгэл зүйн алба нь хорих байрны аюул, эрсдэлт нөхцөл байдлыг урьдчилан судлах, үнэлэх, хор аюулыг бууруулах, таслан зогсоох, арилгах, урьдчилан сэргийлэх зорилт бүхий цогц арга хэмжээ үр дүнтэй төлөвлөн, алба хаагчдыг мэргэжлийн удирдлагаар цаг тухайд нь ханган ажилласнаар зөрчлийн тоо буурах үндэс суурь болжээ.

Эрх зүйн хувьд хүндрэлтэй, хийдэлтэй асуудлууд их байгаагаас зөвхөн хоригдогчийн гаргасан зөрчилтэй холбоотой асуудалд дүн шинжилгээ хийхэд:

1. Цагдан хорих байранд зөрчил гаргасан хүмүүст “Сэжигтэн яллагдагчийг

баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлд заасны дагуу ангийн даргын тушаалаар сахилгын байранд хорих сахилгын шийтгэл ноогдуулдаг боловч тухайн шийтгэл нь зөрчил гаргагчдын хувьд шийтгэл бус байдаг л зүйл, тэдгээрээс зөрчил дахин гаргуулахгүй байх, хоригдогч хууль, дүрэм журам биелүүлэх хөшүүрэг, механизм болдоггүй, хуулийн шаардлагыг хангахгүй байсаар байна.

Учир нь сахилгын өрөөнд тавигдах шаардлага, цагдан хорих байрны хорих энгийн өрөөнд тавигдах шаардлага, түүнчлэн сахилгын шийтгэл хүлээсэн хоригдогчийн эрх, үүрэг нь дүрэм журмыг сахиж буй бусад хоригдогчийн эрх, үүрэгтэй ижил түвшинд ялгагдахгүй байгаа нь тухайн зөрчил гаргагч хоригдогч цагдан хорих байранд зөрчлийг удаа дараа гаргасан байхад оногдуулсан шийтгэл ямар ч үр нөлөө үзүүлдэггүйд гол шалтгаан нөхцөл оршсоор байна, үүнээс үүдэлтэй хоригдогч нарийн дунд цагдан хорих байранд зөрчил гаргахад хуулийн хариуцлага тооцогдохгүй, алба хаагчдын зүгээс яаж ч чадахгүй, мөн хорих ангид хуваарилагдахад дээрх шийтгэл хамаарахгүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 227 дугаар зүйлд зааснаар “Хорих ангид үйлдээгүй тул сахилгын шийтгэлгүй”-д тооцогдог гэсэн яриа өгүүлэмжтэй, ойлголттой болсон, мөн бусад хоригдогчийг өдөөн турхирах хандлага их байгаа нь цагдан хорих байрны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг алдагдуулж байна.

2. Шүүхийн шийдвэрээр согтууруулах ундаа болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий, сэтгэцийн хувьд тулгамдсан асуудалтай, архаг хууч өвчтэй хүмүүс нэлээдгүй цагдан хоригдож байгаа ба тэдгээр хоригдогчид өөртөө болон бусдын биед халдах, амиа хорлох үйлдлийг ихээр гаргадаг, тодруулбал, 2023 онд 22 тохиолдол, 2024 оны эхний I улирлын байдлаар 3 тохиолдол гарсныг тус тус хяналтаар илрүүлж таслан зогсоосон. Согтууруулах ундаа болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай, сэтгэл зүйн хувьд тулгамдсан асуудалтай, амиа хорлох, бие эрхтэндээ гэмтэл учруулахаар завдсан хоригдсон хүмүүст “Сэжигтэн яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 заасны дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж байгаа боловч энэ талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй. Өөртөө болон бусдын биед гэмтэл учруулахаар завдсан хоригдогчдод тусгай хэрэгсэл хэрэглэж байгаа тохиолдолд сэтгэл зүйч хэрхэн ажиллах, ямар хугацаанд хэрэглэх, түүнийг хэний шийдвэрийг үндэслэж үргэлжлүүлэх эсхүл зогсоох зэрэг олон асуудлууд өөрөө эрх зүйн хувьд асуудал дагуулсаар байна.

3. Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дүгээр тушаалаар батлагдсан “Хорих байрны дотоод журам”-ны 2.7.-д “Согтууруулах ундааны зүйл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бодис хэрэглэсэн хоригдох этгээдийг хорих байранд саадгүй хүлээн авч тусгай өрөөнд байршуулна. Хэрэв хоригдох этгээдэд хорих байрны эмнэлгийн шатлалаас дээш шатлалын нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай бол хүлээн авахгүй” гэж заасны дагуу тус цагдан хорих байрны алба хаагчид согтууруулах ундааны зүйл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хоригдогчийг хүлээн авч байна.

Дээрх хоригдогч нар нь удаан хугацаанд дээрх хорт зуршлаа хэрэглэсэн байдаг тул гэнэт зуршил болсон хэрэглээгээг зогсооход эрүүл мэндэд маш их өөрчлөлт өгч өөрийн бие эрхтэндээ гэмтэл учруулах, амиа хорлох үйлдлийг гаргадаг. Мөн “Согтууруулах ундааны зүйл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бодис хэрэглэсэн

хоригдох этгээдийг” тусгай өрөөнд байлгана гэж хуульд заасан боловч тус өрөө нь ямар стандарт шаардлагыг хангасан байх нь тодорхойгүй, ийм хүмүүст тус ангийн эмнэлгийн шатлалаас дээгүүр шатлалын эмнэлэг эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг тул шууд дур мэдэн эмчилгээ үйлчилгээ хийх боломжгүй зэрэг эрх зүйн хувьд зөрчилтэй асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Дүгнэлт

Цагдан хорих байрны аюулгүй байдалд болон хоригдогчийн сэтгэл зүйн байдалд зөв үнэлэлт дүгнэлт өгч, нөлөөлж буй гадаад болон дотоод хүчин зүйлийг зөв тодорхойлж, гарч болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд мэргэжлийн сэтгэл зүйч болон нийгмийн ажилтны үүрэг, оролцоо их тул “Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” болон “Хорих байрны дотоод журам”-д энэ талаар зайлшгүй нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага бий болсон гэж үзээд дараах саналыг дэвшүүлж байна.

Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дүгээр тушаалаар батлагдсан “Хорих байрны дотоод журам”-ын 2.7.-д “Согтууруулах ундааны зүйл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бодис хэрэглэсэн хоригдох этгээдийг хорих байранд саадгүй хүлээн авч тусгай өрөөнд байршуулна. Хэрэв хоригдох этгээдэд хорих байрны эмнэлгийн шатлалаас дээш шатлалын нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай бол хүлээн авахгүй” гэж заасныг хэрэгжүүлэхэд журмын заалтад заасан хоёр салаа утга нь цагдан хорих байрны аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл учруулах нэг шалтгаан болж байна.

Согтууруулах ундаа болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бодис хэрэглэсэн хоригдсон хүмүүсээс гаргаж болзошгүй үйлдлээс шалтгаалж шаардлагатай тохиолдолд тухайн хоригдогчийг хамгаалалтын нэг ажилтанд дангаар нь хариуцуулж ажиллуулснаас үүдэлтэй бусад хоригдогч нарт тавигдах хяналт суларч болзошгүй юм.

Санал

Эрх зүйн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. “Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлд заасны дагуу ангийн даргын тушаалаар сахилгын байранд хорих сахилгын шийтгэл хүлээсэн хоригдогч нь шүүхээр хорих ялаар шийтгүүлж, хорих ангид хуваарилагдсан тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 227 дугаар зүйлд заасны дагуу сахилгын шийтгэлтэйд тооцож, мөн хуулийн 206, 225, 226 дугаар зүйлд заасан хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх эсэх асуудлыг нэг мөр болгох;

2. “Сэжигтэн яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4-д заасны дагуу хоригдогчид тусгай хэрэгсэл хэрэглэсэн тохиолдолд үргэлжлэх цаг хугацааны хувьд ямар байх, сэтгэл зүйч хэрхэн ажиллах, хэний шийдвэрээр зогсоох, эсхүл үргэлжлүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх зэрэг нарийвчилсан тодорхой зохицуулалтыг “Хорих байрны дотоод журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах;

3. Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 24 өдрийн А/209 дугаар тушаалаар батлагдсан “Хорих байрны дотоод журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7 дахь заалт болон 2.8 дахь заалтуудыг илүү дэлгэрэнгүй, нарийвчилсан тодорхой зохицуулалттай болгож өөрчлөлт оруулах;

Ашигласан эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль,
2. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,
3. Зөрчлийн тухай хууль.
4. Прокурорын тухай хууль,
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль,
6. “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”,
7. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах шийтгэхийн эсрэг конвенц, НҮБ-аас баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”,
8. Улсын ерөнхий прокурорын 2021 оны А/71 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”
9. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2017 оны А/260, А/112 дугаар тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам”,
10. Хууль зүйн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дугаар тушаалаар баталсан “Хорих байрны дотоод журам”
11. Улсын ерөнхий прокурор, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны А/236, А/104 тоот тушаалаар батлагдсан “Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл журам”,
12. Монголын Хүний нөөцийн институт. “Mhri.mn Зөрчил ба зөрөлдөөн гэж юу вэ?” Улаанбаатар хот 2017 он,
13. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа, Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн тайлан. Улаанбаатар хот 2023 он,
14. “Хорих байгууллагын аюулгүй байдлын мөн чанар, ойлголт” Лекц: Дотоод хэргийн их сургуулийн багш, хурандаа Ч.Нэргүй.
15. “Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэлийн асуудал” Лекц: Дотоод хэргийн их сургуулийн багш, хурандаа Ч.Нэргүй.

ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНЫ ӨМНӨ СУЛЛАХ АСУУДАЛ БА ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Хан-Уул дүүргийн Прокурорын газрын хяналтын прокурор Б.Сүрмандах

Хураангуй:

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдох зарим асуудлыг шийдвэрлэхэд гарч буй хүний эрхийн зөрчил, тэдгээрийг арилгах арга замын талаар үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээ, конвенцийг харьцуулан судалж, бодит тохиолдолд шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж гаргахад илтгэлийн зорилго оршино.

Түлхүүр үгс:

Үндсэн хууль, хууль тогтоомж, хүний эрх, шинжилгээ, зөрчил, хугацаанаас өмнө суллах, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам.

Удиртгал

1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд¹ “...эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” хэмээн тунхагласан ба хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна² гэж заажээ. Прокурорын тухай хуулийн³ 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт “Хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах” нь прокурорын үйл ажиллагааны нэг зарчим болох, 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь хэсэгт “Ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэх”-д хяналт тавих тухай хуульчилжээ. Түүнчлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалд⁴ “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү тунхаглалд харшлах аливаа алагчлалаас болон тийнхүү алагчлахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй.”, 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 26 дугаар зүйлд⁵ “Бүх хүн хуулийн өмнө тэгш бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчлах явдлыг хуулиар хориглох бөгөөд ... бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой”-г дурдсан байна.

Эдгээр үндэсний болон олон улсын эрх зүйн баримт бичигт заасан хууль зүйн үндэслэл нь ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлох, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбоотой асуудалд дараах зүйлийг хууль тогтоомжийн хүрээнд хамааруулж ойлгож болно. Тухайлбал, Хорих өөр төрлийн ялыг хорих ялаар солих, Ялтны зорчих эрхэд тогтоосон хориглолт, хязгаарлалтыг өөрчлөх, Нийтэд тустай ажил хийлгэх ялыг өөр тойрогт шилжүүлэн эдлүүлэх, Тэнссэн,

¹ Үндсэн хууль. Төрийн мэдээлэл, эмхэтгэл. УБ. 1992. №01. Оршил хэсэг

² Мөн тэнд. 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

³ Прокурорын тухай хууль. Төрийн мэдээлэл, эмхэтгэл. 2017. №24

⁴ Нэгдсэн Үндэстний байгууллагын 217 /A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ. Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. УБ. 2014. 5 дахь тал

⁵ Мөн тэнд. 19 дэх тал

тогтоолын шийдвэрийг хүчингүй болгож ялаас чөлөөлүүлэх, ял оногдуулах, Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх, зогсоох, Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, сунгах, Хоригдлын ял эдлэх дэглэмийг өөрчлөх, Хоригдлыг өвчний учир ялаас чөлөөлүүлэх, Өсвөр насны хоригдлыг хорих ангид шилжүүлэх, Хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох, Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг суллах, Хоригдлын хорих ял эдлэх зэрэглэл өөрчлөн шилжүүлэх, Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээх, Ялтныг ялаас чөлөөлүүлэх, ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэх⁶ г.м байна.

Үүнээс хорих ялаас хугацааны өмнө суллах ажиллагаан дахь хүний эрхийн зөрчил, түүнийг шийдвэрлэх арга замыг харьцуулах аргаар тусгайлан судалж, дүн шинжилгээ хийж, үр дүнг илтгэлд тусгасан болно.

Хорих ялаас хугацааны өмнө суллах ажиллагаан дахь тулгамдсан асуудал

Материаллаг хуульд ялтан гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлж, зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж, ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй, оногдуулсан ялын хувийг эдэлсэн бол прокурорын саналыг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шийдвэрлэж болно⁷ гэжээ. Энд хоригдол “...ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй” гэсэн томъёолол нь анхаарал татаж байна.

1. Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүхийн шүүгчийн 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн №149/ХМШЗ/68 захирамжаар⁸ хоригдол Г.П -г 2011 онд 2, 2014 онд 1 нийт 3 удаа сахилгын шийтгэл хүлээсэн, мөн шүүхийн 2022 оны шүүгчийн 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 67 дугаар захирамжаар⁹ хоригдол Б.Д-г 2014 онд 2 удаа, 2018 онд 1 нийт 3 удаа, мөн шүүхийн 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 418 дугаар захирамжаар¹⁰ хоригдол Л.А-г 2014 онд 2 удаа, 2019 онд 1 нийт 3 удаа сахилгын шийтгэл хүлээсэн үндэслэлээр тус тус “хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай прокурорын дүгнэлт”-ийг хэрэгсэхгүй болгосон байна. Прокурор дээрх шийдвэрээс 1-д нь эсэргүүцэл бичсэн ч биелэгдээгүй байна. Шинжилгээ хийж үзэхэд шүүгчийн шийдвэр нь үндэслэл муутай бөгөөд хоригдлын эрхийг зөрчсөн нөхцөл байдал тогтоогдож байна. Жишээ нь, Шүүх хуралдаан хийсэн хугацааг хоригдол зөрчил гаргасан он, цаг, өдөртэй харьцуулахад 2-11 жилийн зайтай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Сүүлийн нэг жилд сахилгын зөрчил гаргаагүй” гэсэн заалт нэлээд зүйл, хэсэгт бичигдсэн байгааг тэмдэглэж байна. Зөрчил гаргаж, сахилгын шийтгэл хүлээсэн бол хугацаа харгалзахгүй, түүнийг хугацаанаас өмнө суллахгүй, хоригдлын эрхийг зөрчиж байгаа шүүхийн буруу практикийг засах цаг болсон байна. Гэхдээ бүх шүүх биш, зарим шүүх дээр ийм зүйл байгаа нь судалгаагаар тогтоогдсоныг илтгэж байна.

⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл. эмхэтгэл. УБ. 2017. №03, 24 -г үзнэ үү. Б.С

⁷ Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл. эмхэтгэл. УБ. 2015. 6.12 зүйл

⁸ Архивын материалаас авав. Б.С

⁹ Мөн тэнд.

¹⁰ Мөн тэнд

Улсын Дээд шүүхийн 1995 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 390 дугаар “Ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах ...талаарх эрүүгийн хуулийн зарим зүйл, хэсэг заалтыг тайлбарлах тухай”¹¹ тогтоолын 3 дахь хэсэгт “Ял эдлэх тухайн дэглэмийн хорих ангид тогтоосон журмыг сахин биелүүлэхийн хамт гэм буруугаа ухамсарлаж, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх итгэл үнэмшилтэй болсон, ял эдэлж байх хугацаандаа сахилгын зөрчил гаргаагүй, хэрэв гаргаж арга хэмжээ авагдсан бол түүнийг арилгуулсан” гэж заасан байна. Хоригдол ял эдлэх хугацаанд тодорхой шалтгаанаар зөрчил гаргаж, сахилгын шийтгэл хүлээх нь нийтлэг боловч, 1 жил өнгөрсний дараа сахилгын шийтгэл “автомат”-аар сахилгын шийтгэлгүйд тооцдог дэлхий нийтийн жишиг байгааг шүүх анхаарах ёстой гэж судлаачийн хувьд үзэж байна.

Нөгөө талаар хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дэргэд хоригдолд шагналын хоног олгох энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай санал гаргах чиг үүрэг бүхий арга зүйн зөвлөл¹² нь хоригдол хорих ял эдлэх хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, хуваарилсан ажил, үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэсэн, сургалт хүмүүжлийн ажил болон нийгэмшүүлэх хөтөлбөрт идэвхтэй хамрагдсан хууль тогтоомж, хорих ангийн дотоод журмыг мөрдөж байгаа байдал, өөрийн зан үйл, хувийн байдлаараа хорих ангийн дарга алба хаагчаас эерэг үнэлгээ авсан тохиолдолд түүнд шагналын хоног олгож,¹³ хоригдол хуульд заасан шаардлагыг хангасан гэж үзсэн тохиолдолд хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга хорих ялаас хугацаанаас өмнө суллуулах, хяналт тогтоох саналаа хурлын тэмдэглэл, шаардлагатай бусад мэдээлэл баримт бичгийн прокурорт хүргүүлж, прокурор үндэслэлтэй дүгнэлт үйлдэн, шүүхэд шилжүүлж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, прокурор тус тусын чиг үүргийн дагуу хоригдлыг хорих ялаас хугацааны өмнө суллах асуудлаар тодорхой шийдвэр гаргаж шүүхэд хүргүүлэхэд, шүүгч өөр байр сууринаас хандаж эргэлзээтэй шийдвэр гаргаж байгаа нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулж байна.

2. “Ноцтой зөрчил”-ийн тухайд хоригдол дотоод журмыг зөрчиж, хорих ангийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий байгууллагын болон хорих ангийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, доромжилсон, эсхүл хорих ангийн алба хаагч, түүний гэр бүлийн гишүүнд хүч хэрэглэхээр заналхийлсэн, айлган сүрдүүлсэн, хоригдол санаатайгаар өөртөө гэмтэл учруулсан, бусад хоригдолд хүч хэрэглэсэн, нэр төрийг нь гутаан доромжилсон, заналхийлсэн, согтууруулах ундаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис олж авсан ашигласан, хадгалсан, сарын хугацаанд хоёр, эсхүл түүнээс дээш удаа сахилгын зөрчил гаргасан зэргийг тооцож, түүнд сахилгын байранд хорих шийтгэл оногдуулж болох талаар хуульд¹⁴ тодорхой заасан байна. Тэгэхээр дээрхээс бусад зөрчлийг “ноцтой биш” гэж үзэх боломжтой. Хоригдлын гаргасан зөрчлийг судлахад гар утас хэрэглэсэн, талхны шуудайнд цайны идээ хийсэн г.м зөрчлийг “ноцтой” зөрчилд тооцсон нь үндэслэлгүй байна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн 225 дугаар зүйлийн 225.3 дахь хэсгийн “Хоригдлыг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоолгох тухай

¹¹ Эрх зүйн мэдээллийн системээс үзнэ үү Б.С

¹² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл, эмхэтгэл. УБ. 2017. 224. 2 зүйл

¹³ Мөн тэнд

¹⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл, эмхэтгэл. УБ. 2017.228 дугаар зүйл

прокурорын дүгнэлтийг шүүх хангаагүй бол уг асуудлыг 6 сарын дотор дахин авч хэлэлцэхгүй”¹⁵ гэж заасан байна.

Дээр дурдсан тухайн шүүхийн шүүгчийн 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 419 дүгээр захирамжаар¹⁶ хоригдол М.М-ын ялын хугацаанаас 2 жил хорих ялыг орхигдуулсан үндэслэлээр прокурорын дүгнэлтийг хэрэгсэхгүй болгосон.

Уг захирамжид шинжилгээ хийхэд эдлэх ялын хугацааг буруу бодсон нь тухайн хоригдолтой ямар ч хамааралгүй бөгөөд эрх бүхий албан тушаалтны ажлын хариуцлагатай холбоотой байхад хуульд зааснаар энэ асуудлыг шүүх 6 сарын дотор дахин авч хэлэлцэхгүй байгаа нь хоригдлын эрхийг зөрчиж буй нэг илрэл юм. Хуулийн энэхүү заалтыг тодорхой болгох, эсхүл хуулиас хасаж, хоригдлын зөрчигдсөн эрхийг сэргээх боломжтой.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 256.1 дүгээр зүйлд¹⁷ “Хоригдол хорих ялаас хугацаанаас өмнө суллагдах хуульд заасан шаардлагыг хангаснаас хойш 5 хоногийн дотор энэ тухай мэдэгдэнэ” гэжээ. Хоригдол хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн арга зүйн зөвлөлийн хурлаас гаргасан хорих ялаа хугацааны өмнө суллагдах шаардлагыг хангасан мэдэгдлийг хүлээн авч “баярласан” хоригдлын тухайд уг асуудал нь прокурор, эсхүл шүүхээс “буцсан” тохиолдолд сэтгэл санааны хувьд “хохирол” учирсан гэж үзэж болох талтай.

5. Хоригдлын эрхийг хангах, зөрчигдсөн тохиолдолд сэргээхэд прокурорын хяналт чиглэгдэх учиртай. Иймд ял эдлүүлэх ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуулийн болон бусад хуулийн заалтыг нэг мөр хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, прокурорын шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцсэн байх, хяналт хариуцсан прокурорт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх¹⁸, харилцагч байгууллагатай хамтарсан зөвлөгөөнийг тухай бүр хийж, ял эдлүүлэх ажиллагаанд хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа байдал, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл, бэрхшээл түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, гадаад орнуудын ажлын сайн туршлагыг судалж нэвтрүүлэх, шинэлэг инновацийг эрэлхийлэх зэргээр удирдлага, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авах нь үр нөлөөтэй болохыг тэмдэглэж байна.

Дүгнэлт

Судалгааны дүнгээс үзэхэд ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн зөрчилд нөлөөлж буй нэг шалтгаан нөхцөл нь хууль хэрэглээний нэгдмэл тогтолцоо бүрдээгүйгээс хууль хэрэгжүүлэгч нар өөр өөрийн байр сууринаас асуудалд хандах хандлага нь бодитой оршиж байна. Иймд эрх зүйн зохицуулалтыг ойлгомжтой байдлаар боловсруулах, хүний эрхийн зөрчлийг арилгах, хуульч болон хууль сахиулагчдын хүний эрхийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар системтэй удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэсэн дүгнэлтийг хийсэн болно.

¹⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл, эмхэтгэл. УБ. 2017

¹⁶ Архивын материалаас авав. Б.С

¹⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл, эмхэтгэл. УБ. 2017. 256.1 дугаар зүйл

¹⁸ Улсын ерөнхий прокурорын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар баталсан “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”-г үзнэ үү. Б.С

Санал, зөвлөмж

Энэхүү илтгэлийг боловсруулах явцад дараах санал, зөвлөмжийг дэвшүүлсэн болно.

1. Хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулах. Үүнд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 227 дугаар зүйлд¹⁹ /Хоригдолд хүлээлгэх сахилгын шийтгэл/ “227.5 Сахилгын шийтгэл оногдуулснаас хойш 1 жил өнгөрсөн тохиолдолд сахилгын зөрчил гаргаагүйд тооцно” гэсэн нэмэлт оруулах, 225 дугаар зүйлийн 225.3 дахь хэсгийн “Хоригдлыг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоолгох тухай прокурорын дүгнэлтийг шүүх хангаагүй бол уг асуудлыг 6 сарын дотор дахин авч хэлэлцэхгүй” гэсэн заалтыг хасах;

2. Ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар томоохон судалгаа хийж, тэдгээрийн дүнг үндэслэн холбогдох эрх бүхий байгууллагад санал гаргаж, шийдвэрлэлтэд нь анхаарч ажиллах;

3. Дээд шатны прокуророос ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт хариуцсан прокурорыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах ур чадварыг байнга дээшлүүлж, холбогдох мэдээллээр хангаж байх, хяналтын ажлын чиглэлээр бусад байгууллагатай зохион байгуулах ажил хэргийн уулзалт, зөвлөгөөнд ач холбогдол өгч хууль хэрэглээний нэгдмэл ойлголтыг бий болгоход анхаарч ажиллах;

4. Шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хийх ажил хэргийн уулзалт, зөвлөгөөний чанар, үр нөлөөнд анхаарах;

5. Прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, шүүгч нарыг хүний эрхийн сургалтад тогтмол хамруулж байх;

6. Сүүлийн нэг жилд сахилгын зөрчил гаргаагүй бол сахилгүй зөрчилгүйд тооцох практик тогтоох.

Ашигласан эх сурвалж

1. Хүний эрхийн түгээмэл тунхаг. 1946 он
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966 он
3. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
4. Прокурорын тухай хууль. 2017 он
5. Эрүүгийн хууль. 2017 он
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он
8. Улсын ерөнхий прокурорын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар баталсан “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”
9. Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл
10. Архивын материал. Сэлэнгэ аймаг. 2024 он.

¹⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2017. №24

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫГ ОРОН НУТАГТ ЭДЛҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БУЙ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

Хөвсгөл аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Б.Болд

Хураангуй

Шүүхээс “Нийтэд тустай ажил хийлгэх” ял оногдуулсан этгээдийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа нэгжгүй байгууллагад нийтэд тустай ажил хийлгэх ял эдэлж буй этгээдүүдийн эрхийг хэрхэн хангаж буй талаар сэдвийг энэхүү бэсрэг судалгаагаар хөндөж байна.

Учир нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгж бүхий нутаг дэвсгэрт ял эдлүүлэх ажиллагаатай тодорхой хугацааны давтамжтай танилцах боломжтой бол тийм нэгжгүй нутаг дэвсгэрт ял эдлэх ажиллагаатай хэсгийн төлөөлөгч танилцаж байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зохих хууль журмын дагуу явагдаж буй эсэх, нийтэд тустай ажил хийлгэх ялыг сумдад хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, цаашид авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг үндэслэл бүхий дэвшүүлэхийг зорьсон болно.

Түлхүүр үгс:

Нийтэд тустай ажил хийлгэх ял, ял шийтгэлийн зорилго, хүнлэг ёсны зарчим, ялтны эрх, сум, Засаг даргын Тамгын газар, хүний эрхэм чанар.

Удиртгал

Монгол Улс “Нийтэд тустай ажил хийлгэх ял” гэж тодорхойлсон ялыг 2015 оны Эрүүгийн хуульдаа тусгаж, “гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ. Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно” гэж хуульчилсан.

Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийг хуулиар зөвшөөрсөн ажлыг хуульд заасан хугацаа, нөхцөлийн дагуу хүнлэг ёсны зарчимд нийцүүлэн, цалин хөлсгүй хийлгэж, түүний хорих ангид байлгах бус нийгэмд учруулсан хор уршгаа нийтэд тустай ажил хийж, засарч хүмүүжих боломжийг олгодог ял юм.¹

Ялын бодлогын чиг хандлагад үндсэн өөрчлөлт орсон нь нэг талаар хүний эрхийн үнэт зүйлс, зарчмыг хамгаалах шаардлага өсөн нэмэгдсэнтэй холбоотойн дээр сүүлийн хориод жилд НҮБ-аас баталсан гэрээ, конвенцод ялын залхаан цээрлүүлэх чиг үүргийг нийгэмшүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгод нийцүүлж, өөрчлөн шинэчлэх хандлага гүнзгий тусгагдах болсноор тайлбарлаж болно.²

¹ Ц.Мөнхбат. Албадан ажил хийлгэх ял ба нийтэд тустай ажил хийлгэх ялыг харьцуулан судлах нь., Хүний эрх сэтгүүл. 2016/01 дугаар. 49 дүгээр тал

² Ц.Мөнхбат. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт. Нээлттэй нийгэм форум, <https://forum.mn/product/152582>

Өөрөөр хэлбэл нийтэд тустай ажил хийлгэх ял нь хүнлэг ёсны зарчимд нийцсэн нийгэмшүүлэх чиг үүрэг бүхий ял мөн гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Мөн ялыг эдлүүлэхдээ мөн хүний эрх цаашлаад “хүний эрхэм чанар”³-ыг дээдлэх явдал нь дээрх хүнлэг ёсны зарчмын агуулгад нийцнэ.

Иймд Хөвсгөл аймгийн хэмжээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт оршин суух ялтны нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаанд ялтны эрхийг хэрхэн хангаж буй талаар судлан энэхүү илтгэлийг танилцуулж байна.

Үндсэн хэсэг

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хяналтад нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлж, ял эдэлж буй 10 этгээд байгаа бөгөөд эдгээрийн 5 нь аймгийн төв буюу Мөрөн суманд, 1 хүн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгонд, 1 хүн Төмөрбулаг суманд, 2 хүн Цагааннуур суманд, 1 хүн Тосонцэнгэл суманд тус тус ял эдэлж байна.

Мөрөн сумаас бусад сумдад ял эдэлж буй этгээдүүдтэй утсаар холбогдон ял эдлүүлэх ажиллагаанд эрх нь зөрчигдсөн эсэхийг тодруулах зорилгоор 1.Өдрийн хэдэн цагаар ажиллаж байгаа, 2.Нийтэд тустай ажил хийлгэж буй байгууллагаас хамгаалах хувцас хэрэгслээр хангаж буй эсэх, 3.Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар танилцуулж байгаа эсэх, 4.Цагдаагийн алба хаагч ялтны гүйцэтгэж буй ажилтай танилцаж, заавар, зөвлөгөө өгч буй эсэх, 5.Эрүүл мэндэд хортой, хүнд нөхцөлд ажиллуулсан эсэх, 6.Ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой гомдол санал байгаа эсэх зэрэг 6 асуулгын хүрээнд ярилцлага хийлээ.

Ял эдэлж буй байгууллагын талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.1-д “Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөр А/168 дугаар тушаалаар баталсан. Дээрх тушаалд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулж болох байгууллагуудыг тоочин жагсаасан бөгөөд сумын Засаг даргын Тамгын газар тус жагсаалтад ороогүй байна.

Харин сумдад нийтэд тустай ажил хийлгэх ялыг эдэлж буй ялтнууд бүгд харьяа сумынхаа Засаг даргын Тамгын газарт нийтэд тустай ажил хийлгэх ял эдэлж байна.

Практикт сумдын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд төрийн байгууллагын хэлтэс, нэгж байхгүй бөгөөд сумын Засаг даргын Тамгын газраас өөр нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэхээр байгууллага байхгүй байдаг.

³ Хүний эрхэм чанар (Human dignity)- Хүн бүрд адилхан байдаг (нийгмийн гарал үүсэл, хөрөнгө чинээ, ял эдэлж буй эсэхээс үл хамааран), хүнээс үл салгаж болох, үл хэмжигдэх норматив зарчим.

Энэ нь нэг талаар ялтан этгээдийг өөрийн оршин суух хаягтаа гэр бүлтэйгээ ойр ял эдлэх боломжийг олгож, хүний эрхийг хангаж байгаа боловч нөгөө талаар жагсаалтад заагаагүй байгууллагад ял эдлүүлж буй нь холбогдох хууль, журмыг зөрчиж байж болзошгүй байна.

Энэ талаар зарим эрдэмтдийн “...Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ажил олгогч биш учраас нийгэмд ашигтай ажлын (Жишээлбэл, хот суурин гарын ногоон цэцэрлэгт хүрээлэнг тодон арчлах, хог, цас мөс арилгуулах, шарилж зэрлэг өвс зулгаалгуулах зэрэг) байр байхгүй тул шүүхээс ногдуулсан энэ төрлийн ял бодитой биелэгдээгүй, энэ ялаар шийтгүүлэгчид шийдвэр гүйцэтгэгчийн ир гэсэн цагт бүртгүүлчихээд явдаг байсан нь судалгаагаар тогтоогдсон юм ... Шүүх ажил олгогч биш тул түүнд нийгэмд тустай ажлын байр байхгүй, үүнээс үүдэн энэ ял үр нөлөөтэй байж чадалгүй, нэр төдий ял болон хувирсан. Яагаад ийм болсон бэ гэвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нийгэмд ашигтай ажлыг ялтнаар хийлгэх ямар ч бодит боломжгүй байгаад оршино. Угтаа үр нөлөө сайтай эл ялыг жинхэнэ ёсоор нь байлгая гэвэл нутгийн өөрөө удирдах ёсны болон Засаг захиргааны байгууллагаар хийлгэх ажлын төрлийг тодорхойлуулах заалтыг Эрүүгийн хуульд оруулах шаардлагатай. Бидний үзэж байгаагаар уг нь Эрүүгийн хуульд нийгэмд тустай ажлын төрөл болон объектыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагатай тохиролцон буй болгож, энэ ялыг эдлүүлбэл үр нөлөө нь дээшлэх нь гарцаагүй. Энэ ялыг үр нөлөөтэй эдлүүлж чадвал ялтны хувьд ч, тухайн нутаг орны хувьд ч ашиг тусаа өгөхүйц үр өгөөжтэй ялд тооцоход ташаарал болохгүй”⁴ гэж тэмдэглэсэн.

Мөн Оросын Холбооны улсад нутгийн төр, захиргааны байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай зөвшилцөж ажлын байрыг тодорхойлж, ялыг үр нөлөөтэй эдлүүлдэг туршлагыг судалж үзэх нь зүйтэй байна.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 162 дугаар зүйлийн 162.6-д “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт оршин суух ялтны ял эдлүүлэх ажиллагаанд харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хяналт тавих бөгөөд ял эдлүүлэх ажиллагааны талаар 30 хоног тутам шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бичгээр, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр мэдэгдэнэ.” гэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/260 А/242 дугаартай “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам”-д шүүхийн шийдвэрийн харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт ял эдэлж буй ялтнуудад цагдаагийн алба хаагч хяналт тавих асуудлыг хэт ерөнхий зохицуулсан, ялтны эрхийг хангах талаар зохицуулалт огт тусгагдаагүй байна.

Ялтныг ажиллуулж буй байгууллага ажлын хувцас хэрэгслээр хангаж буй эсэх талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.4-д “Шийдвэр гүйцэтгэгч ялтныг ажиллуулах байгууллагатай ялтны нэг өдөрт ажиллах цаг,

⁴ Нарангэрэл.С. Эрдэнэбулган.Ж, Монгол Улсын эрүүгийн эрх зүй. “Үзэл баримтлал уламжлал, сургамж.2019. 256-257 дахь тал.

гүйцэтгэх үүрэг /хөдөлмөрийн норм/, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын хувцсаар хангах, ажиллах нөхцөлийг урьдчилан тохиролцож, гэрээ байгуулна” гэж заасан.

Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн этгээдүүдтэй ярилцлага хийх явцад ажиллуулж буй байгууллага буюу Тосонцэнгэл, Төмөрбулаг, Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газар, Хатгал тосгоны захирагчийн ажлын алба нь ялтнуудыг ажлын хувцсаар хангадаггүй, ялтнууд өөрсдөө бээлий, маск болон бусад хувцас, хамгаалах хэрэгслийг авдаг гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Дээрх нөхцөл нь ялтныг ажиллуулж буй байгууллага хүний эрхийг хангах арга хэмжээг аваагүй гэж дүгнэж болох юм.

Гэвч нөгөө талаас Сумдын Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээнүүдийг судалж үзэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.4-д заасан “...ажлын хувцсаар хангах...” асуудлыг гэрээнд огт тусгаагүй, хуулийн заалтыг ерөнхий байдлаар тусгасан гэрээ байгуулсан нь ялтныг ажиллах нөхцөлөөр хангаагүй, эрхийг нь зөрчсөн гэж дүгнэж болохуйц байна.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааны өгч буй талаар

Ялтнуудтай ярилцлага хийх явцад 1 ялтан “хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын талаар өглөө бүр зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулдаг” гэсэн бол 1 ялтан “огт танилцуулдаггүй”, 3 ялтан “өглөө ажил хийхээр ирэхдээ шууд гарын үсгээ зурчихаад ажилдаа гардаг” хэмээн хариулсан ажиллуулж буй байгууллагын эрх бүхий албан хаагч нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг уншиж танилцуулж, нэг бүрчлэн зааварчилдаггүй, шууд гарын үсэг зуруулах байдлаар ажиллаж буй нөхцөл байдал тогтоогдож байна.

Нийтэд тустай ажил нь мэргэжил боловсрол шаардахгүй, гол төлөв биеийн хүчний хөдөлмөр зонхилсон хэлбэртэй⁵ тул хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын зааварчилгааг зохих журмын дагуу тогтмол өгөх нь нэг талаас ялтныг эрсдэлээс хамгаалах, нөгөө талаас түүний эрхийг хангах ач холбогдолтой.

Ялтаар хийлгэж буй ажлын талаар

Ялтнуудтай ярилцлага хийх явцад өвс, тэжээл ачих буулгах, мод түлээ бэлтгэх, цас мөс арилгах, төрийн байгууллагад шаардлагатай засварын ажил хийх зэрэг ажлыг гүйцэтгэсэн байх бөгөөд зарим ажил нь нийтийн ашиг сонирхол, нийгэмд тустай байх ялын үндсэн шинжийг⁶ агуулаагүй бөгөөд үр дүн нь тодорхой этгээдэд биш нийгмийн сайн сайхны төлөө нийгэмд бүхэлд нь ашиг өгөхүйц байх⁷ шаардлагыг хангахгүй байна.

Тухайлбал, Тосонцэнгэл суманд нийтэд тустай ажил хийлгэх ял эдэлж буй ялтан Б нь сумын Засаг даргын Тамгын газрын барилгад будгийн ажлыг 3 өдөр буюу 24 цагийн хугацаагаар гүйцэтгэсэн байна.

⁵ Ц.Мөнхбат. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт-Бодлогын судалгааны тайлан. 36 дугаар тал.

⁶ Нийтэд тустай ажил хийлгэх ял нь 1.Нийтийн ашиг сонирхол нийгэмд тустай, цалин хөлсгүй, шүүхээс тогтоож өгсөн, албадлагын шинжтэй.

⁷ Ц.Мөнхбат. “Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт-Бодлогын судалгааны тайлан”. 31 дэх тал.

Дээрх нь ялтныг ажиллуулж буй байгууллагын орон тоо, хүний нөөцийн чадамжаас хамааран зарим тохиолдолд төрийн албан хаагчийн чиг үүрэг бүхий ажил хийлгэсэн гэж үзэхээр байна.

Дүгнэлт

Энэхүү илтгэлийн хүрээнд хийсэн судалгааг үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлж, тус ялыг сумдад эдэлж буй ялтнуудыг судлахад бүгд сумын Засаг даргын Тамгын газарт нийтэд тустай ажил хийлгэх ял эдэлж байх бөгөөд тус байгууллага нь “Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх байгууллагын жагсаалт”-д тусгаагүй байна.

2. Тус ялыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт эдлүүлж буй нь ялтны эрхийг илүү хангах боловч эдгээр ялтнуудад тавих хяналт болон тэдний эрхийг хэрхэн хангаж буй талаар тавих хяналтыг сайжруулах шаардлагатай.

3. Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтнуудын хувийн хэрэгтэй танилцахад хувцас, хамгаалах хэрэгслээр хангасан талаар тэмдэглэл үйлдсэн байх боловч ялтантай ярилцлага хийх явцад ажил хийлгэж буй байгууллагаас хувцас, хамгаалах хэрэгслээр тогтмол хангадаггүй.

4. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг бүрэн дүүрэн өгч, ялтныг эрсдэлээс хамгаалдаггүй хэлбэрийн төдий буюу зөвхөн гарын үсэг зуруулах байдлаар танилцуулдаг зэрэг хүний эрхийг зөрчсөн байж болохуйц нөхцөл байдлууд тогтоогдож байна.

Санал

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөр А/168 дугаар тушаалаар баталсан “Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалт”-ыг боловсронгуй болгож сум, орон нутагт тус ялыг эдлэх байгууллагыг тодорхой болгох замаар ялтны эрх болон ялын үр нөлөөг дээшлүүлэх,

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг суманд ажиллуулахаар гэрээ байгуулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, хувцас хэрэгслээр хангах талаар гэрээнд нэг бүрчлэн нарийвчлан тусгах асуудлаар зөвлөмж, зааварчилгаа хүргүүлэх,

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/260 А/242 дугаартай “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам”-д шүүхийн шийдвэрийн харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт ял эдэлж буй ялтнуудад цагдаагийн алба хаагч хяналт тавих асуудлыг хэт ерөнхий зохицуулсан, ялтны эрхийг хангах талаар зохицуулалт огт тусгаадаггүй байгааг анхаарч журмыг шинэчлэн батлах шаардлагатай гэж үзэж байна.

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж

1. Эрүүгийн хууль. 2015 он
2. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он
3. Прокурорын тухай хууль. 2017 он
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он
5. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-234/А/103 дугаартай “Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”
6. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар баталсан “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/168 дугаар тушаалаар баталсан “Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалт”

Ном, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Нарангэрэл.С. Эрдэнэбулган.Ж, Монгол Улсын эрүүгийн эрх зүй. “Үзэл баримтлал уламжлал, сургамж. УБ. 2019 он
2. Албадан ажил хийлгэх ял ба нийтэд тустай ажил хийлгэх ялыг харьцуулан судлах нь., Ц.Мөнхбат, Хүний эрх сэтгүүл, 2016/01 дугаар,
3. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт-Бодлогын судалгааны тайлан., Ц.Мөнхбат.

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ АСУУДАЛ

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын хяналтын прокурор Д.Сүрэнхорлоо

Хураангуй:

Хүний эрхийг дээдлэх нь дэлхийн улс орнуудын нэн тэргүүний зорилт болсон байна. Хүний эрхийн баталгаа болсон олон улсын эрх зүйн баримт бичиг дотроос хамгийн түгээмэл нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал юм. Монгол Улс НҮБ-аас гаргасан дүрмийн бүхий л заалтыг дагаж мөрдөхөө илэрхийлж 1961 онд НҮБ-д элсэн орсон.

Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд “прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж заасан. Энэ ч утгаараа ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурор нь ял эдлүүлэх ажиллагаа хууль, журмын дагуу явагдаж байгаа эсэх, ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх зөрчигдөж байгаа эсэхэд нэн тэргүүнд хяналт тавьж, ялтан этгээдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, зөрчигдсөн эрхийг сэргээж ажилладаг.

Түлхүүр үгс:

Хүний эрх, зөрчигдсөн эрхийг сэргээх, ял, зорчих эрхийг хязгаарлах ял.

Удиртгал

Дэлхийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн түүхэнд “цөлөх”, “нутаг заах” ял хэрэглэж байсан уламжлал нь ялын агуулга, шинжийн хувьд одоогийн Зорчих эрх хязгаарлах ялын суурь ойлголт гэж эрдэмтэд үзэж байна.¹

Монгол Улсад зорчих эрх хязгаарлах ялыг хамгийн анх 2015 оны Эрүүгийн хуульд ялын төрөл болгон шинээр тусгаж улмаар 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Зорчих эрх хязгаарлах ял нь хорих ангийн төвлөрлийг бууруулах, гэмт этгээд ажиллаж хөдөлмөрлөх, улмаар учруулсан хохирлыг нөхөн төлөх, гэр бүл, үр хүүхдээ тэжээн тэтгэх, нийгэм олон нийтээс тусгаарлагдахгүй байх, хөгжих гэх мэт олон давуу талтай ялын төрөл юм.

Монгол Улсын Үндсэн хууль нь “...хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлнэ” гэж эрхэм зорилгоо болгосон, мөн Эрүүгийн хуульд заасан “...гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд ялын зорилго оршино” гэж заасан байх тул дээрх хуулийн зорилго зорилттой зорчих эрх хязгаарлах ялын бодлого нийцэх үү?

¹ Б.Алтангэрэл, М.Хүрэлбат нарын “Зорчих эрх хязгаарлах ялын хэрэгжилт” судалгааны ажлын тайлан. 26-р хуудас тал.

Тэгвэл практик дээр хэрэгжээд 3 жил гаруй хугацаа өнгөрч байгаа энэхүү шинэ төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд хууль хэрэгжүүлэгч байгууллага болон ял эдэлж байгаа ялтанд ямар хүндрэл гарч байгаа болох, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар гарц гаргалгааг олж, санал санаачилга дэвшүүлэхэд илтгэлийн зорилго оршино.

Үндсэн хэсэг

Дэлхийн улс орнуудад зорчих эрх хязгаарлах ялыг Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улс зэрэг томоохон өндөр хөгжилтэй дэлхийн 40 гаруй оронд хэрэглэдэг. Цахим бугуйвчийг анх Америкийн Нэгдсэн Улсад 1983 оноос хэрэглэж эхэлсэн байдаг. Европ тивд Англи улс 1989 онд анх нэвтрүүлж, түүнээс хойш Швед, Голланд, Франц, Бельги, Канад, Австри, Швейцар, Герман, Португали, Итали, Израйль, Эстон, Оросын Холбооны Улс 2009 онд, Ази тивд Бүгд Найрамдах Солонгос, Турк, Сингапур зэрэг улсууд 2007 оноос хэрэглэсэн байна².

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ гэж хуульд заасан байдаг. Үүнийг энгийн үгээр хэлбэл ялтны чөлөөтэй зорчих хөдөлгөөнийг хязгаарлах гэсэн утга харагдаж байна.

Монгол Улсын хэмжээнд 2023 онд нийт 2934 ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг эдэлсэн нь нийт хорихоос өөр төрлийн ялын 17.4 хувийг дангаараа эзэлж байна. Харин торгох ял 58.6 хувь, нийтэд тустай ажил хийлгэх ял 8.8 хувийг тус тус эзэлж байна.³

Үүнээс дүгнэхэд шүүх хорихоос өөр төрлийн ял оногдуулахдаа нэгдүгээрт торгох ял, дараагийн дугаарт зорчих эрхийг хязгаарлах ялыг сонгон оногдуулж байна гэж үзэхээр байна. Энэхүү ялыг оногдуулах бас нэг шалтгаан нь хууль тогтоогчоос Эрүүгийн хуулийг батлахдаа тус хуулийн тусгай ангийн 219 зүйлд заасан гэмт хэргийн 144 зүйлд буюу 65.7 хувьд нь зорчих эрх хязгаарлах ялыг сонголтыг оруулсантай холбоотой байж болох юм. Иймээс хэрэгжээд удаагүй ч цаашид энэхүү төрлийн ялаар шийтгүүлэх ялтны тоо өсөн нэмэгдэх хандлагатай гэж судлаачийн хувьд үзэж байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялын практик хэрэглээ ба боловсронгуй болгох нь /хэрэгжилт, алдаа оноо/

Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлж, уг ялаа эдэлж байгаа ялтнуудын байдлыг харьяа орон нутгийн хэмжээнд судаллаа. 2024 оны эхний улирлын байдлаар Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хяналтад зорчих эрх хязгаарлах ялтай 23 ялтан ял эдэлж байна. Энэ нь хорихоос өөр төрлийн ял эдэлж буй нийт ялтнуудын 33.8 хувийг эзэлж байна. Дээрх ялтнуудын 2 буюу 8.7 хувь нь эмэгтэй, 21 буюу 91.3 хувь нь эрэгтэй, насны хувьд 20-29 насны 9 буюу 39.2 хувь, 30-40 насны 8 буюу 34.8 хувь, 40-өөс дээш насны 6 буюу 26 хувь байна.

² ШШГЕГ-ын <https://www.ncs.cd.gov.mn/?p=26165> веб сайтад тавигдсан мэдээллээс

³ УЕПГ-ын \10.33.0.213 серверт байрлуулсан ЯЗАХТХ-ээс нэгтгэсэн мэдээний тоон үзүүлэлтээс

Зорчих эрх хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтнуудын үйлдсэн гэмт хэргийг Эрүүгийн хуульд заасан бүлгээр авч үзвэл өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 15 буюу 65.2 хувь, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3 буюу 13.4 хувь, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг, авлигын гэмт хэрэг, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг тус бүр 1 буюу тус бүр 4.3 хувийг эзэлж байна.

Дээрх ял эдэлж байгаа ялтнуудын боловсролыг авч үзвэл боловсролгүй 3 буюу 13 хувь, бага боловсролтой 3 буюу 13 хувь, бүрэн бус дунд боловсролтой 8 буюу 34.7 хувь, бүрэн дунд боловсролтой 7 буюу 30.4 хувь, дээд боловсролтой 2 буюу 8.6 хувийг тус тус эзэлж байна. 14 буюу 60 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй ялтан зорчих эрх хязгаарлах ял эдэлж байгаа бол 9 буюу 39 хувь нь урьд өмнө ял шийтгэл эдэлж байсан, 14 буюу 61 хувь нь урьд эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй судалгаа гарсан.

Дээрх ялтнуудад шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлд заасан хориглолт хязгаарлалтуудаас эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг сонгож оногдуулсан байх ба ингэхдээ зорчих бүсийг аймгийн нутаг дэвсгэрээр тогтоосон 5 ялтан буюу 22 хувь, сумын нутаг дэвсгэрээр тогтоосон 18 ялтан буюу 78 хувь байна.

1. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ... өөрийн оршин суух газраас явахыг хориглох... гэж заасан ба оршин суух газар гэх ойлголтыг Иргэний хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно” гэж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1,1-д “Нэгж” гэж аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороог” ойлгоно гэж хуульчилсан байна.

Гэтэл дээр дурдсан 5 ялтны зорчих бүсийг тэдгээрийн оршин суугаа аймгийн нутаг дэвсгэрээр тогтоосон нь Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журам, зорчих эрхийг хязгаарлах ялын гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг богино хугацаанд сэргээх нөхцөлийг бүрдүүлэх буюу нийгмээс тусгаарлахгүйгээр зарим эрхийг хязгаарлан, ажил эрхлэх, сурч боловсрох боломжийг олгож, гэр бүл, олон нийтийн дунд засарч хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх болон цээрлүүлэх зорилгод нийцээгүй гэж үзэхээр байна.

Тодруулбал, оршин суух газраас явахыг хориглох хүрээг шүүгдэгчийн оршин суух сум, дүүргийн нутаг дэвсгэрээр хязгаарлаж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.1-д заасан “Нэгж” гэж аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороог” ойлгоно гэсэн тодорхойлолтын дагуу шүүгдэгчийн оршин суух баг, хорооны нутаг дэвсгэр, эсхүл байнга оршин суух орон сууц, гэрээс зорчих, явахыг хориглож, хязгаарлалт тогтоох нь Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журам, зорчих эрхийг хязгаарлах ялын зорилгод нийцэхээр байна.

Иймд цаашид зорчих эрхийг хориглох хүрээ хязгаар, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүрэг хүлээлгэх талаар улсын хэмжээнд прокурор, шүүх нэгдсэн ойлголтод хүрэх хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

2. Судалгаанаас дүгнэхэд зорчих эрх хязгаарлах ялыг ихэвчлэн 25-40 насны эрэгтэй, бүрэн бус дунд боловсролтой, эрхэлсэн тодорхой ажилгүй, орлогогүй ялтнууд дийлэнх хувийг эзэлж байна.

Судалгааны дүнгээр тогтогдсоноор ял эдэлж байгаа ялтнуудын дийлэнх хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, тогтсон орлогогүй байна. Гэтэл зорчих эрх хязгаарлах ял эдэлж байгаа ялтнууд нь гарт зүүж байгаа бугуйн цаг хэрэглэсний төлбөрт өдөрт 1305 төгрөгөөр тооцож 30 хоногтой сард 39150 төгрөгийг сар бүр улсад төлдөг. Жишээ нь: Шүүхээс тухайн шүүгдэгчийн сарын орлого, амьжиргааны түвшин, хувийн байдал зэргийг харгалзаж торгох ял оногдуулахгүйгээр 1 жилийн хугацаагаар зорчих эрх хязгаарлах ял оногдуулсан гэж тооцоход ял эдэлж байх хугацаанд ойролцоогоор 476,325 төгрөгийг төлж байгаа нь ялтан зорчих эрхээ хязгаарлуулснаас гадна торгох ялаар шийтгүүлсэнтэй дүйцэхүйц санхүү, хөрөнгө мөнгө, эдийн засгаараа хохирч тэдний гэр бүл, амьдралд нөлөөлж байгаа нь агуулгаараа Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэх шударга ёсны зарчимд нийцэхгүй байна.

Гэтэл Монгол Улсад хорих ял эдэлж байгаа ялтны ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой бүх зардлыг төрөөс хариуцаж байна. 2022 онд хийгдсэн судалгааны ажлын тайлантай танилцахад 2022 оны байдлаар хоригдолд ногдох өдрийн дундаж зардал 7231 төгрөг буюу жилд 2.639.619 төгрөг, харин зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд ногдох өдрийн нийт дундаж зардал 3313 төгрөг буюу жилд 1.209.173 төгрөг байгаа нь хорих ял эдлүүлэх зардлаас даруй 54.1 хувиар бага байна⁴ гэх судалгаа байна. Хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй гэх зарчмыг мөрдлөг болгож энэ талаар хууль эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулах талаар эргэн нэг харах цаг нь болжээ.

3. Дараагийн хөндөв сэдэв бол Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж байгаа ялтан ял эдэлж байх хугацаанд дахин гэмт хэрэгт холбогдон шалгагдсан тохиолдолд ялыг нэмж нэгтгэх, хорих ялаар солих зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага практикт үүсэж байна.

Тодруулбал: Ялтан ял эдэлж байх хугацаандаа гэмт хэрэг үйлдэж, тухайн гэмт хэрэгт шалгагдаж байх хугацаанд ялыг биеэр эдэлж дуусгавар болох, улмаар хэргийг шүүхээр шийдвэрлэх үед шүүх зорчих эрх хязгаарлах ял эдэлж байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн ялыг биелүүлээгүй гэж үзэн, зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацаа, хоногийг хорих ялаар сольж нэмж нэгтгэн шийдвэрлэж байгаа нь ялтны эрхийг зөрчиж байна.

Энэхүү төрлийн ялыг түдгэлзүүлэх зохицуулалт хуульд тусгагдаагүй, мөн Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 3-д “Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны

⁴ Б.Алтангэрэл нарын “Зорчих эрх хязгаарлах ялын хэрэгжилт” судалгааны ажлын тайлан. 12 дугаар хуудас тал. 2022 он.

нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино” гэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 170.4-д “Ялтан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солино.”, 170.2.Дараах тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчсөнд тооцно: 170.2.2.гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн гэж тус тус зохицуулсан ба ялтны сүүлийн үйлдсэн гэмт хэрэгт шүүхээс ял оногдуулахаас өмнө тухайн хэрэг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын болон шүүхийн шатанд байх үед ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж буй прокурорын зүгээс ялтан ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчсөн үндэслэлээр зорчих эрх хязгаарлах ялыг хорих ялаар солиулах боломжгүй байна.

Иймд хэрэг шалгагдаж байх хугацаанд ялтан цагдан хорих болон бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авагдах, гэмт хэрэгт шалгагдах явцдаа цахим бугуйвч зүүж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтад байж, ялаа эдэлсэн байтал, гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн ялыг биелүүлээгүй гэж үзэн, зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацаа, хоногийг тооцож хорих ялаар сольж нэмж нэгтгэн ялтны эрхийг зөрчих, мөн эрүүгийн эрх зүйн *“Ne bis in idem”* буюу “нэг гэмт хэрэгт нэг л удаа ял шийтгүүлэх” зарчимтай зөрчилдөж байна.

Жишээ: “А нь 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр 1 жил 2 сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ба уг ялыг эдэлж байх хугацаандаа буюу 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэрэг үйлдэж, уг хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээн мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна. А нь дээрх хугацаанд цахим бугуйвчаа зүүж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтад байж, ялаа эдэлж 2023 оны 02 дугаар сард дуусгавар болсон. Улмаар түүний үйлдсэн хүчиндэх гэмт хэрэгт прокуророос 2023 оны 07 дугаар сард яллах дүгнэлт үйлдэж, 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр анхан шатны шүүх хурал болсон ба Сүхбаатар аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс түүнийг зорчих эрх хязгаарлах ялыг биелүүлээгүй гэж үзэн, гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш, ял дуусгавар болсон өдрийг хүртэлх 4 сар 18 хоногийн зорчих эрх хязгаарлах ялыг хорих ялаар сольж Эрүүгийн хуулийн 6.8, 6.9-д заасан журмаар нэмж нэгтгэсэн байна.”⁵

А болон түүний өмгөөлөгчөөс давж заалдах гомдол гаргасан ба Сүхбаатар аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хэргийг хянан хэлэлцээд “А нь зорчих эрх хязгаарлах ялаа 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр эдэлж дууссан байхад анхан шатны шүүхээс түүний нэгэнт эдэлсэн ялыг хорих ялаар сольж нэмж нэгтгэсэн нь үндэслэлгүй гэж дүгнэн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын “.. 6.8, 6.9-д заасан журмаар нэмж нэгтгэсэн” хэсгийг хүчингүй болгож, шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна.”⁶

⁵ Сүхбаатар аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 31 дугаартай шийтгэх тогтоол

⁶ Сүхбаатар аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 05 дугаартай магадлал

Иймд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай хуулийн зохицуулалтыг тусгаж өгөх, эсхүл уг ялыг хорих ялаар солих зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага зайлшгүй үүсэж байна.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 175.1-д “ялтан ял эдлүүлэх журмыг зөрчөөгүй, өөрийн зан үйл, хувийн байдлаараа ял эдлүүлэх ажиллагаанд саад учруулаагүй бол түүнд 1 сард 5 хүртэл хоногийн шагналын хоног олгож болно” гэж зохицуулсан. Гэтэл мөн хуулийн 224.3-д Хоригдол энэ хуулийн 224.1-д заасан шаардлагыг хангасан, хөдөлмөрт хамрагдсан хугацаа нь ял эдэлж байгаа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст тухайн сард ажилласан хугацаа нь дангаар, эсхүл шилжин ирэхээс өмнө ял эдэлж байсан хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ажилласан хугацааны нийлбэр нь 160 цагаас доошгүй тохиолдолд ажлын бүтээмж, чанарыг үндэслэн 1 сард 10 хүртэл хоногийн шагналын хоног олгоно гэжээ.

Дээрх заалтуудыг харахад “...олгоно”, “...олгож болно” гэж томъёолсноос хорих ял эдэлж байгаа ялтнуудын хувьд хуульд заасан дээрх шаардлагаа хангасан тохиолдолд шагналын хоног зайлшгүй олгогдохоор зохицуулагдсан бол зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж байгаа ялтнуудын хувьд хуулийн шаардлагаа хангасан, сард төлөх төлбөрийг цаг тухай бүр төлж, гэмт хэрэг зөрчилд холбогдоогүй, хориглосон хязгаарлалтаас гараагүй, ямар нэг зөрчил гаргаагүй байхад шагналын хоногийг олгохгүй байх боломжтой байна. Цаашлаад шагналын хоног олгох нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нарын үзэмжийн асуудал болж, ялтны эрх зөрчигдөж, ялгаварлан гадуурхалт, “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчим алдагдах эрсдэлийг үүсгэхээр байна.

Иймд цаашид ялтанд шагналын хоног олгохтой холбоотой хуулийн дээрх зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар ял эдлүүлэх ажиллагаанд ялтны эрх зөрчигдөхөөс сэргийлэх нь зүйтэй байна.

Дүгнэлт

Зорчих эрхийг хязгаарлах ял нь хорих ялыг бууруулж, хорихоос өөр төрлийн ялыг нэмэгдүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг богино хугацаанд сэргээх нөхцөлийг бүрдүүлэх буюу нийгмээс тусгаарлахгүйгээр зарим эрхийг хязгаарлан, ажил эрхлэх, сурч боловсрох боломжийг олгож, гэр бүл, олон нийтийн дунд засарч хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх болон цээрлүүлэх зорилготой бөгөөд Монгол улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 18 дахь хэсэгт заасан “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах...” хүний суурь эрхэд хориг, хязгаарлалт тогтоосон эрүүгийн хариуцлагын төрөл юм.

Уг ял нь Монгол Улсад хэрэгжиж эхлээд дөнгөж 3 жил гаруй хугацаа өнгөрч байгаа боловч шүүхээс гэмт хэрэг үйлдсэн хүнд зорчих эрх хязгаарлах ялыг оногдуулах байдал цаашид нэмэгдэх хандлагатай байна.

Иймд дээрх шинэ төрлийн ялыг хэрэгжүүлэхэд ял эдлүүлэх ажиллагаанд ялтны эрх зөрчигдөхөөс сэргийлж ажиллах талаар зарим шаардлагатай хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, санал санаачилга гаргаж ажиллах нь прокурорууд бидний үүрэг юм.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж:

- Зорчих эрхийг хязгаарлах ялын зорилгод нийцүүлэн зорчих бүс, хориглох хүрээ хязгаар, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүрэг хүлээлгэх талаар улсын хэмжээнд нэгдсэн ойлголтод хүрэх;

- Зорчих эрх хязгаарлах ял эдэлж байгаа ялтнууд чөлөөтэй зорчих эрхээ хязгаарлуулсан атал дахин бугуйн цагны мөнгө төлж, торгох ял давхар эдэлж буй мэт хөрөнгө мөнгө, санхүү эдийн засгийн хүндрэлд орж байх тул бугуйн цагны зардлыг төрөөс хариуцах талаар судалж, тухайн зардлыг төр хариуцдаг байхаар хуульд өөрчлөлт оруулах;

- Зорчих эрх хязгаарлах ял эдэлж байх хугацаандаа гэмт хэрэгт холбогдон шалгагдсан тухай цагдаагийн байгууллагаас мэдээлэл ирсэн даруйд ял эдлүүлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай хуулийн зохицуулалтыг тусгаж ялтны эрх зөрчигдөхөөс сэргийлэх;

- Хуульд заасан шаардлага хангасан ялтан шагналын хоног зайлшгүй авдаг байхаар хууль эрх зүйн нарийвчилсан зохицуулалт хийх шаардлагатай гэж үзэж байна.

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Монгол Улсын 2002, 2015 оны Эрүүгийн хуулиуд
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2015 он
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

Ном, сурах бичиг

5. С. Нарангэрэл. Монгол улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ.1999 он.
6. С. Нарангэрэл. Монгол улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. УБ. 2021 он

Шүүхийн шийдвэр

7. Сүхбаатар аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 31 дугаартай шийтгэх тогтоол
8. Сүхбаатар аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 05 дугаартай магадлал

Цахим эх сурвалж

9. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://Legalinfo.mn>
10. Шүүхийн шийдвэрийн цахим сан. <https://shuukh.mn>
11. Википедия веб сайт,
12. ШШГЕГ-ын <https://cd.gov.mn/index> веб сайт.
13. УЕПГ-ын серверт байрлуулсан ЯЭАХТХ-ээс нэгтгэсэн мэдээний тоон үзүүлэлтүүд

Судалгааны ажил:

14. Б.Алтангэрэл, М.Хүрэлбат нарын Зорчих эрх хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ. 2022 он.
15. Зорчих эрх хязгаарлах ялын хэрэгжилт судалгааны ажлын тайлан. 2022 он.

ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Говь-Алтай аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Х.Гүнжидмаа

Хураангуй:

Дэлхийн зарим улс орны эрх зүйн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд хорих ялыг зөвхөн хохирогчийн аюулгүй байдалд заналхийлсэн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зэрэг цөөн тооны тохиолдолд хэрэглэх учиртай гэсэн үзэл, зарчим давамгайлж байна. Ял эдлүүлэх ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийж үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь өндөр хэмжээний зардлыг үүсгэж байгаагийн зэрэгцээ хорих ял эдлээд суллагдсан хүмүүс нийгмийн орчинд буцаж очих, дахин гэмт хэрэг үйлдэхээс үл эмээх хандлагатай байгаагаас үүдэн хорих ял хамгийн үр дүн багатай ялын төрөл хэмээн тооцогдож байна. Энэхүү илтгэлээрээ ял эдлүүлэх үйл ажиллагаан дахь хүний эрхийн онол, практикийн асуудлын талаар судлахыг зорьлоо.

Түлхүүр үгс:

Ял эдлүүлэх үйл ажиллагаа, хорих ял, хүний эрх.

Удиртгал

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийг шүүхийн шийтгэх тогтоолд заасан хугацаа, төрөл дэглэм, нөхцөл журмын хүрээнд ял эдлүүлж буй төрийн албадлагын онцгой арга хэмжээ бөгөөд өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжоор энэхүү ажиллагаа нь ялтанд үзүүлэх цээрлүүлэх, хүмүүжүүлэх болон ард иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл, Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний зарим эрхийг хязгаарлан, хуулиар тогтоосон хязгаарлагдмал эрх, үүргийн нэгдлийг бий болгож, тодорхой дэглэм, түүний биелэлтийг хангаж буй арга хэрэгслийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ гэж үзэж болох юм.

Аливаа эрх эдлэх нь ямагт үүргийг өөртөө дагуулдаг ойлголт юм. Түүнээс гадна эрх гэдэг нь хязгааргүй боломж биш бөгөөд тодорхой хэм хэмжээгээр хязгаарлагдаж болох зүйл аж. Хүний эрхийг хязгаарлаж болно.

Зайлшгүй нөхцөл байдал үүссэн, бусад хүний эрх эрх чөлөөг хамгаалах зорилгын үүднээс гагцхүү хуулиар хүний эрхийг хязгаарлах нь ардчилсан нийгэмд төрөөс хүний эрхийг хангах чухал зарчим болдог.¹

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгаа нь хөндөгдсөн эрхийг сэргээх хууль зүйн боломжийг бүрдүүлэх, бусдын эрх эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэх, зөрчигчдөд хууль зүйн хариуцлага оногдуулах зэргээр илрэлээ олдог. Өөрөөр хэлбэл хүний эрхийг хуульд заасан үндэслэл журмын дагуу хязгаарлах нь бусдын эрх эрх чөлөөг хөндөгдөхөөс урьдчилан сэргийлэх зорилготой байдаг тул зарим

¹ Гэмт явдалтай тэмцэх асуудал онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. УБ.2021.№1 (75). 59 дэхь тал. Сүүлд үзсэн 2024.03.31. Дараах холбоосоор үзэх боломжтой: <https://uia.gov.mn/uploads/trans/attach/1.2021-1.pdf>

тохиолдолд хүний эрхийн баталгаа болдог байна. Тодруулбал гоц халдварт өвчин дэгдлээ гэхэд тухайн орон нутагт байгаа хүмүүсийн дунд хөл хорио тогтоож, өөр зүг зорчихыг тодорхой хугацаанд хязгаарладаг. Энэ нь олон нийтийн дунд өвчин тарж хүмүүсийн эрүүл мэнд доройтох, ноцтой байдалд орохоос урьдчилан сэргийлж байгаа арга хэмжээ юм. Ардчилсан нийгэмд хүний эрхийн хязгаарлалтыг хоёр тохиолдолд хийдэг. Эхнийх нь бусдын эрх эрх чөлөөг зөрчсөн этгээдийн тодорхой эрхийг хууль тогтоомжид заасан үндэслэлээр шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр хязгаарладаг бол удаах нь:

1. Үндэсний аюулгүй байдал
2. Нийгмийн хэв журам
3. Нийтийн эрүүл мэнд
4. Ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор хязгаарлаж болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд прокурорын байгууллагын чиг үүргийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж тодорхойлсон. Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлд прокурор ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихдаа:

- Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ биелүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;
- Ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн эсэх;
- Ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэх;
- Баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэхийг хянана гэж заасан²

Хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн явцад нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг, түүнийг төрүүлдэг шалтгаан, нөхцөл, тэдгээрийн үйлчлэлийг хэрхэн саармагжуулах талаар гүн ухаантан, хуульч, нийгэм судлаач, хүн судлаач, криминологчдын олон жилийн турш боловсруулан хөгжүүлсэн эрүүгийн эрх зүй, криминологийн шинжлэх ухааны онолын сэтгэлгээ, сургаал, номлол нь гэмт хэрэг, ялын мөн чанар, тэдгээрийн нийгмийн учир холбогдол, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг түүхийн үүднээс танин мэдэхэд онол, практикийн гүн гүнзгий ач холбогдолтой¹ хэмээн тодорхойлсон. Аливаа улс орон амгалан тайван нийгмийг бүрдүүлэх явдлыг төрийн эрүүгийн бодлогын нэн тэргүүнд тавьж, түүнд хүрэхийг байнга эрмэлздэг хэдий ч бэрхшээлтэй тулгарсаар байдаг нь үнэн билээ. Гэмт хэрэг, зөрчлөөс ангид амар амгалан нийгэмд хөтлөх нэг үндэс бол гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх, нийгэмдээ аюулгүй этгээд болгон хүмүүжүүлэх явдал байдаг. Монгол Улсын Эрүүгийн хуульд “Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх,

² М.Хүрэлбат. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ. 7 дахь тал. Сүүлд үзсэн 2024.03.31. Дараах холбоосоор үзэх боломжтой: [file:///C:/Users/Admin/Downloads/zorchikh-erkhiyg-khyazgaarlakh-yal-onogduulsan-shkhiyn-shiydver-gytsetgekzh-azh-gyv%20\(1\).pdf](file:///C:/Users/Admin/Downloads/zorchikh-erkhiyg-khyazgaarlakh-yal-onogduulsan-shkhiyn-shiydver-gytsetgekzh-azh-gyv%20(1).pdf)

хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.” 2 гэж хуульчилсан.

2015 оны Эрүүгийн хуульд заасан “Хууль ёсны зарчим”, “Шударга ёсны зарчим”, “Гэм буруугийн зарчим”-уудад “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно”, “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна”, “Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан нь Ч.Беккариагийн үзэл санаатай бүрэн нийцэж, хууль тогтоогчийн баталсан хуулийн дагуу шүүхээс ял оногдуулж, хуульд заасан хэмжээ хязгаараас хэтрэхгүй, тухайн ял, хариуцлагын асуудал нь гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруу, бусад байдалд тохирсон байх гэсэн үзэл санааг хуульчилжээ.

Эрүүгийн хууль нь гэм буруутай этгээдэд ял оногдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үнэт зүйлсийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг давхар агуулдаг. Германы эрүүгийн эрх зүйг үндэслэгч, гүн ухаантан Иоганн Ансельм Фейербах (1775-1883)⁸¹ “Сэтгэл зүйн дарамт үзүүлэх” онолыг боловсруулсан. Түүний үзэж байснаар, хуулиар тогтоосон ял шийтгэл нь хүмүүст сэтгэл зүйн нөлөөлөл буюу дарамт үзүүлж, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлдэг байна. Өөрөөр хэлбэл, хүч чадал, эрх мэдлээ буруугаар, дур зоргоор ашиглах гэсэн хүчний эсрэг яг ийм хууль, эрх зүйн тогтолцоо үйлчилж байж нийгэмд тэнцвэртэй, тогтвортой байдал үүснэ. Ял шийтгэл нь гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруу, хувийн байдалд тохирсон, өөрөөр хэлбэл Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчимд нийцсэн байна. Ял шийтгэлийн тухай асуудал гэмт хэргийн тухай ойлголттой салшгүй холбоотой. Шүүх гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж, ял оногдуулахад харгалзах хүндрүүлэх болон хөнгөрүүлэх бүхий л нөхцөл байдлыг бүрэн тогтоосны үндсэн дээр гэм буруутай этгээдэд хуульд заасан, тохирсон ялыг сонгон оногдуулна.

Эрүүгийн хариуцлага нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, нийгэмшүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой төрийн албадлагын арга хэмжээний хамгийн хатуу төрөл болохын хувьд эрх зүйн бусад албадлагаас ялгагдана. Эрүүгийн хариуцлагыг гэмт

хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулж, хүний эрх, эрх чөлөөнд Эрүүгийн хуульд заасан хязгаарлалт тогтоодог. Эрүүгийн хариуцлага нь өөрөө зорилго биш, харин Эрүүгийн эрх зүйн зорилтод хүрэх хэрэгсэл юм. Ийм учраас эрүүгийн хариуцлагын зорилго нь Эрүүгийн хуулийн зорилтоос үүдэн гарна. 2002 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын зорилгыг “Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх” гэж тодорхойлж байсан бол 2017 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль дээрх зорилгууд дээр хохирол нөхөн төлүүлэх зорилгыг нэмж хуульчилсан. Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг шийтгэж цээрлүүлэхээс гадна нийгэмшүүлэх зорилгыг давхар агуулдаг.

2015 оны Эрүүгийн хуульд ялын эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлэн гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан

сэргийлэх зорилгоор хорих ял тэнссэн, эсхүл хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүнд шүүх үндсэн ялаас гадна тодорхой үүрэг хүлээлгэх, эрхийн хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заасан. Тухайлбал, гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох зэрэг болно.

Хоригдлыг суллагдсаны дараах хяналт-нийгэмшүүлэх ажилд хийсэн дүн шинжилгээ Нэг. Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох үндэслэл, журам: Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллах институт нь анх 1885 онд Францад үүссэн гэж үздэг. Энэ цагаас хойш Европын бусад орноор дэлгэрч улмаар одоог хүртэл хорих ялаас өмнө тэнсэн суллах институт нь дэлхийн бараг бүх оронд хэрэглэгдэж ирсэн байна⁸³. Харин манай улсын хувьд 1921 онд хувьсгалт засаг ялж Монгол улс тусгаар тогтнолоо олж, анхны Үндсэн хуулиа баталсны дараа 1926 онд Бүгд Найрамдах Монгол Ардын Улсын Шүүх цаазын бичиг нь 31 бүлэг 227 зүйтэйгээр батлагдсан. Шүүх цаазын бичгийн 7 дугаар бүлэгт урьд хоригдсоныг ялд тооцох, хугацаа дуусахын урьд ялтныг гаргах ба ялыг нэгмөсөн өршөөн хэлтрүүлэх тухай заасан байдаг. Хугацаа дуусахын урьд гаргах тухай дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд: Аливаа хоригдсон ба албадын үйлдвэр хийлгэж бүхий ялтны дотроос зарим нэгэн зан авир сайн, үйлдвэр дор хичээлтэй нь буй аваас түүнийг хугацаа дуусахаас өмнө тавьж гаргаваас зохино⁸⁴ гэж зааж өгсөн байна.

Түүнээс хойш өөрчлөгдөн батлагдсан 1929, 1934, 1942, 1961, 2002, 2015 оны Эрүүгийн хуулиудад хорих ялаас тэнсэн суллах тухай оруулж өгсөн байна. А.Эрүүгийн хуульд туссан байдал: а. Ялтан гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн б. Зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй в. Оногдуулсан ялын дараах хувийг эдэлсэн бол прокурорын саналыг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шийдвэрлэж болно: 1.таван жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг; 2.таван жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг; 3.арван хоёр жилээс дээш хорин жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын дөрөвний гурваас доошгүй хувийг эдэлсэн бол. Хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахдаа эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтооно.

Дэлхийн улсуудын эрүүгийн эрх зүйн системийн шинж, ангилал:

Харьцуулсан эрх зүйн судлалыг үндэслэгчдийн нэг Францын судлаач А.Леви-Ульманы ангиллаар эх газрын, англо- саксоны, мусульманы гэсэн 3 тогтолцоо болгон авч үздэг хандлага эдүгээ ихээхэн өргөн дэмжлэг авсаар байна. Түүнчлэн сүүлийн үед К.Осакве (АНУ), Жон Бриэрли (Англи), П.Круз (Англи), Х.Эберт (Герман), Г.Кётце (Герман), П.Флетчер (АНУ), Г.Есаков (Орос), Г.Созерхолл (Швейцарь) нарын зэрэг олон эрдэмтэд хосолсон, холимог, нийлмэл, заримдаг зэрэг онцлог шинж бүхий зарим системийн тухай үзэл санааг дэвшүүлжээ.³ Дээрх байдал, хандлагаас үзэхэд дэлхийн

³ Intetnational Encycloedia of Comparativ Law. 1999 он

улс орнуудын эрүүгийн эрх зүйн системийг дараах байдлаар ангилан үзэж болно. Үүнд: Англи- Америкийн эрүүгийн эрх зүйн систем;

1. Эх газрын эрүүгийн эрх зүйн систем;
2. Мусульманы эрүүгийн эрх зүйн систем;
3. Хосолсон ба холимог эрүүгийн эрх зүйн систем; Дээрх ангиллын гол чиг хандлага нь харьцангуй хүлээн зөвшөөрөгдсөн баримтлал мөн бөгөөд дараах шалгуур шинж, арга зүйн үндэслэлд тулгуурласан байдаг.⁴

Үүнд: а) эрүүгийн эрх зүйн эх сурвалж б) эрүүгийн эрх зүйн зарчим, зорилго в) эрүүгийн эрх зүйн түүхэн уламжлал г) хүн амын соёл, ёс заншил д) шүүхийн практик, төрийн бодлого гэх мэт.

Хэдийгээр систем, хүрээлэл бүхэнд өөрийн гэсэн ялгагдах шинж, онцгойрох байдал илэрч туссан байдаг ч бүхэлд нь авч үзвэл дэлхийн улсуудын эрүүгийн эрх зүйн систем нь аль ч улсад дараах шинжүүд нийтлэг байдгийг харж болно. Үүнд:

- Гэмт хэрэг, ялын асуудлыг эрүүгийн хууль, тогтоомжоор тусгайлан зохицуулж тогтоосон;
- Хүний амь хохироох, хүчирхийлсэн буюу хүч хэрэглэсэн, бусдын өмчийг хулгайлах, дээрэмдэх, завших, танхайрах болон албан тушаалаа хууль бусаар урвуулах, хээл хахууль авах өгөх, бусдын биед гэмтэл учруулах, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, үймээн самуун дэгдээх, зам тээврийн болон үйлдвэрлэлийн аюул, осол гаргах, цэргийн болон төрийн эсрэг гэмт хэрэг гэх мэт наад захын гэмт хэргийн төрлүүдийг жагсаан хуульчилж, тус бүрд нь оногдуулах ялын төрөл, сонгох санкцыг тогтоосон;
- Ялын үндсэн ба нэмэгдэл төрөл, зүйлийг ялган хуульчилсан;
- Торгох, хорих, баривчлах, нийтэд тустай ажил хийлгэх, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах зэрэг ялыг сонгох боломжтойгоор тогтоосон;
- Ялыг зөвхөн гэмт хэрэг үйлдсэн нь хуулийн дагуу тогтоогдсон этгээдэд гагцхүү шүүхээс оногдуулах журмыг тогтоосон;
- Гэмт хэргийг хор аюул, сэдэл санаа, үйлдлийн шинж байдлаар нь хөнгөн, хүнд, хүндэвтэр гэж ангилсан ба гэмт буруугийн санаатай ба санамсаргүй хэлбэр, хүсэл зоригийн илрэл, онцлогийг шалгуур шинж болгон тогтоосон;
- Хөнгөн хэрэгт хөнгөн ял, хүнд хэрэгт хүнд ял оноох зарчим, бодлогыг ихэнх орны эрүүгийн хуулиудад тусгасан;
- Ял хөнгөрүүлэх, хүндрүүлэх болон ялаас чөлөөлөх, ял хойшлуулах, ял тэнсэх зэрэг эрх зүйн дэглэмийн зохицуулалтыг нийтлэг байдлаар хуульчилсан;
- Гэмт хэргийн субъектын насны болон хэрэг хариуцах чадварын шалгуурыг жишгийн дагуу адил төстэйгээр тогтоосон зэрэг түгээмэл шинжүүд илэрсэн байдгийг дурьдаж болно.

Эрүүгийн эрх зүйн системийн хооронд интеграцчилал явагдаж, зарим хүрээнд интервенц, рецепци хийгдэж хосолсон хэв маягийн бүлүүд нэмэгдэж байгаа хэдий ч Эх газрын ба Англи-Америкийн гэсэн үндсэн хоёр системийн онцлог (давтагдашгүй) дүр төрх улам бүр тодорч, эрх зүйн дефференциациллын үйл явц явагдаж, хоорондын зааглагдсан харилцааны хамааралт бус хэлбэрүүд бий болж эхэлснийг анхаарах ёстой.

Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн системийн онцлог:

⁴ Г.А.Есаков, Н.Е.Крылова, АВ.Серебренникова Уголовное право зарубежных стран. 2009 ., 22 дахь тал

Англи нь нийтийн эрх зүйн системийн /common law/ анхны үр хөврөл нь болсон газар бөгөөд 1066 оноос хойш сүм хийдийн шүүхийн (canon law) жишгийн практик хөгжлөөр дамжин 1485 оноос эхлэн албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн шүүхүүдийн өрсөлдөөн, тэмцлийн үр дагавар болж “Common law” буюу жишгийн эрх зүйн тогтолцоо бүрэлдсэн⁵ гэж үздэг. Харин XIX зууны эцэс XX зууны эхэн үеэс парламентын статут (statute)-ын актууд олноор гарч (Statute Law) шүүхийн жишгийн эрх зүйг тайлбарлан зохицуулах болсноор “precedent” буюу шүүхийн жишгийн эрх зүй жинхэнэ утгаараа үйлчлэх болсон⁶.

Эх газрын эрх зүйн системтэй харьцуулахад Нийтийн эрх зүйн систем өөрийн гэсэн ялгагдах шинж, өвөрмөц онцлогтой бөгөөд энэ нь эрүүгийн эрх зүйн системээс тодорхой харагдах хэдий ч “бүхэлд нь авч үзвэл дэлхийн улсуудын эрүүгийн эрх зүйн систем нь аль ч улсад байдаг нийтлэг шинжүүдийг олж харж”⁷ болно. Тухайлбал, гэмт хэрэг, ялын асуудлыг эрүүгийн хууль, тогтоомжоор тусгайлан зохицуулж тогтоосон, ялын үндсэн ба нэмэгдэл төрөл зүйлийг ялган хуульчилсан, торгох, хорих, баривчлах, нийтэд тустай ажил хийлгэх, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах зэрэг ялыг сонгох боломжтойгоор тогтоосон, хөнгөн хэрэгт хөнгөн, хүнд хэрэгт хүнд ял оногдуулах зарчим, бодлогыг эрүүгийн хуулиудад тусгасан, ял хөнгөрүүлэх, хүндрүүлэх болон ялаас чөлөөлөх, ял хойшлуулах ял тэнсэх зэрэг зохицуулалтыг нийтлэг байдлаар хуульчилсан байна.

Английн ялын тогтолцоо нь харьцангуй уян хатан шүүхээс ял шийтгэлийг сонгон хэрэглэх нөхцөлөөр хангагдсан байдаг. Өөрөөр хэлбэл эрүүгийн төрөлжсөн хуульгүй байдгаас үүдэн олон хууль, хуульчилсан актуудад ял оноох бүрэн эрхийг шүүхэд олгодог.⁸ Ялын зорилго, зарчим, ойлголтыг 2003 онд батлагдсан Эрүүгийн шүүх цаазын тухай хуульд томъёолсон байдаг. Тухайлбал уг хуулийн 142-р зүйлд⁹ ял оногдуулах, эдлүүлэх нь дараах зорилгыг хангана:

- а/ гэмт хэрэг үйлдсэн этгээдэд залхаалт, цээрлүүлэлт үзүүлэх,
- б/ гэмт хэргийг багасгах тогтоон барих,
- в/ гэмт хэрэгтнийг өөрчлөн нийгэмшүүлэх, төлөвшүүлэх
- г/ нийгмийг гэмт халдлагаас хамгаалах
- д/ гэмт хэрэгтний бусдад учруулсан хохирлыг арилгах, нөхөн төлүүлэх.

Английн ялын тогтолцоо нь дараах гурван төрөл хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Хорих ял (custodial sentence);
2. Эрх, эрх чөлөөг хасах, хязгаарлах (community sentence);
3. Топрох (Fine sentence).

Эрх, эрх чөлөөг хасах, хязгаарлахад чиглэсэн хорихоос өөр төрлийн ял нь нийгмийн ашиг сонирхол эрх ашгийн дагуу нийгмийн нөлөөлөл үзүүлэх зорилгыг агуулдаг. Үүнийг “Нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэх ял буюу “community sentence” гэж нэрлэдэг. Энэхүү ялын төрлүүдийг 2003 оны хуулийн 199-211-р зүйлд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

⁵ Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2010. 108 дахь тал

⁶ Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2017. 222 дахь тал

⁷ Дурдсан бүтээлийн 41 дэх тал

⁸ Гэмт хэргийн тухай 1967, 1977 оны хууль, Гэмт хэрэгт завдсан үйлдлийн тухай 1981 оны хууль, Ялын тухай 1997 оны хууль, Эрүүгийн болон хэв журмын зөрчлийн тухай 1998 оны хууль, Гэмт хэрэгт шийтгэгдсэн этгээдийг засан төлөвшүүлэх тухай 1974 оны хууль, Ял хэрэглэх болон шүүхийн эрх хэмжээний тухай 1973 оны хуулийг дурдаж болно.

1. Үнэ төлбөргүй ажиллуулах: Энэ 40-300 цаг хүртэлх хугацаатай цалин хөлсгүй ажиллуулахад чиглэгдэнэ. Ялын хэрэгжилтэд пробацийн алба болон ажилтан хяналт тавьж зохих үйлчилгээ үзүүлэхээр заасан.
2. Болзолтойгоор хянан харгалзах. Шүүхээс тогтоосны дагуу тусгайлсан газар байлгаж (нийгэмшүүлэх болон халамжийн үйлчилгээ үзүүлэх төв¹⁰) тодорхой хугацаанд, тодорхой үйл ажиллагаа явуулах (хохирогчийн нөхцөл байдлыг ойлгуулах, уулзуулах, үйлдсэн гэмт хэрэгтээ гэмшиж ойлгож байгаа эсэх) талаар үүрэг гүйцэтгүүлж ажиллуулахад чиглэгдэнэ. Үүнийг хэрэгжүүлэхэд орон нутгийн пробацийн албаны ажилтан эсхүл энэ төрлийн үйлчилгээ үзүүлж буй ажилтан оролцдог. Хугацааны хувьд 60 хоногоос дээшгүй байна.

Английн туршлагаас харахад нийгмийн хор аюул бага, болгоомжгүй байдлаар болон хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихоос өөр төрлийн ялаар шийтгэж, тэднийг нийгэмшүүлэх, нийгэм, сэтгэл зүй, гэр бүлийн харилцааны тусгайлсан сургалтад хамруулах, нийтэд тустай ажил хөдөлмөр эрхлүүлэх, шаардлагатай тохиолдолд улс төрийн болон нийгэм, эдийн засгийн эрхэнд хязгаарлалт хийх, чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж хянан харгалзах зэргээр эдийн засгийн хувьд чирэгдэл багатай (Cost-effective) ялыг шийтгэлийг оногдуулах, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, хорих ял эдлээд суллагдсан хүнийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлд ихээхэн анхаарч ял шийтгэлийг үр нөлөөтэй эдлүүлэх тогтолцоог бий болгожээ. Английн эрүүгийн ялын бодлого, хэрэгжилт нь өөрийн орны онцлог, уламжлалаа хадгалсан, уян хатан шинжтэй бөгөөд эрүүгийн ялын санкцыг сонгон хэрэглэх талаар шүүхэд бүрэн итгэл хүлээлгэсэн болох нь харагдана.

Дээрхээс үзэхэд Английн эрүүгийн эрх зүйн тогтолцоо ял шийтгэлийн бодлого, ял эдлүүлэх ажиллагаа нь бусад улсуудтай харьцуулахад эртний арвин баялаг туршлагатай бөгөөд эдүгээ өөрийн баялаг туршлага, уламжлал үнэт зүйлсээ хадгалан өвлүүлж ирснийг зүй ёсоор үнэлэн авч үзэх ёстой. Ялангуяа пробацийн тогтолцоог бүрдүүлэхэд тэдний туршлагаас суралцан, харьцуулан судалж өөрийн орны онцлог, уламжлалд нийцүүлэн нутагшуулах нь ихээхэн ач холбогдолтой юм.

2002 оны Эрүүгийн хуульд:

2002-2017 оныг хүртэл хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах тухай хуулийн зохицуулалт нь Эрүүгийн хууль /74-р зүйл/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /1261 1-р зүйл/ болон холбогдох дүрэм, журмаар зохицуулагдаж байжээ. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих үндэслэл нь ялтан засарч хүмүүжсэн байх өөрөөр хэлбэл ялтан дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зан суртахууны хэмжээнд хүрсэн байх явдал мөн.

Үүнийг 2002 оны “Эрүүгийн хууль”-ийн 74 дүгээр зүйлд хорих ял 150 шийтгүүлсэн ялтан засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг шүүх ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж болно хэмээн тусгажээ. Ялтан засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулах гэдэг нь ял эдлүүлэх дэглэмийн нөхцөл, журмын хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлэхийн зэрэгцээ гэм буруугаа ухамсарлаж, гэмт хэрэг шинээр үйлдэхгүй байх итгэл үнэмшилтэй болсон түүнчлэн ял эдлэх хугацаандаа

сахилгын шийтгэлийн арга хэмжээний хөөн хэлэлцэх хугацаа дууссан буюу арилгуулсан, хорих ангийн захиргаа, ялтны сайн дурын байгууллагаас зохиож байгаа хүмүүжлийн ажилд идэвхтэй оролцдог, боловсрол, мэдлэгээ дээшлүүлэхэд биеэ дайчлан ажилладаг, бусад ялтны хүмүүжилд сайн нөлөө үзүүлдэг байхаас гадна хуулиар тогтоосон хөдөлмөрлөх журмыг биелүүлсэн байх шаардлагатай.

Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо төлсөн байх гэдэг нь хохирогчид учруулсан хохирлоо барагдуулж дуусахыг хэлнэ. Шүүх ялтныг хугацаанаас нь өмнө тэнсэн суллахдаа эдлээгүй үлдэж байгаа ялын хугацаатай тэнцүү хянан харгалзах хугацаа тогтоож, түүнд тодорхой хугацаанд ажил, сургуульд орох, учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хорыг арилгах, ажлын газар сургуулиа өөрчилсөн тухайгаа оршин суугаа газрынхаа цагдаагийн газарт мэдэгдэж байх зэрэг түүний засрал хүмүүжилд дөхөм үзүүлэх үүргийг даалгаж, түүнийг хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон буюу төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл садангийн хүн, тодорхой иргэнд тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр хариуцуулах нөхцөл тавьдаг байна.

Хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхэд заавал баримтлах урьдчилсан нөхцөл нь, ялтан оногдуулсан ялын Эрүүгийн хуульд заасан хэсгийг эдэлсэн, засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулсан, гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн байх зэрэг юм. Хорих ял шийтгэгдсэн ялтан шүүхээс оногдуулсан ялын зохих хувийг биечлэн эдэлсэн тохиолдолд хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэнэ. Үүнд: -

- хүндэвтэр гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг;
- хүнд гэмт хэрэг оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг;
- онц хүнд гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын тавны дөрвөөс доошгүй хувийг зэрэг болно.

Цаазаар авах ял шийтгүүлж уучлагдсан, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон, түүнчлэн гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй этгээдэд ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхгүй. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах явдал нь зөвхөн хорих ялаас чөлөөлж байгаа бөгөөд ялтныг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Мөн ялтан шүүхээс оногдуулсан ялын хуулиар оногдуулсан хэсгийг эдэлсэн байлаа ч засарч хүмүүжээгүй, хохирлоо төлөөгүй байвал хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллагдах үндэслэл болохгүй. Харин шүүхээс оногдуулсан ялын тодорхой хэсгийг эдэлсэн байх нь ялын ерөнхий урьдчилан сэргийлэх зорилгыг хэрэгжүүлэхэд нэн чухал нөлөө үзүүлнэ.

Ялтныг хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гаргасан прокурорын дүгнэлтийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оршин байгаа газрын шүүхийн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.¹¹ Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд цагдаагийн байгууллага, цэргийн алба хаагчид, цэргийн анги, нэгтгэлийн дарга нар захиргааны хяналт тавихаар хуульчилсан бөгөөд ялтан хянан харгалзах хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлэхээс зайлсхийсэн, захиргааны зөрчил гаргаж шийтгэгдсэн бол шүүгч Цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан шийдвэрийг хүчингүй болгож,

¹¹ МУ-ын Эрүүгийн хууль. УБ., 2002. 74-р зүйл 5 дэхь хэсэг, ЭБШТХ-ийн 334-р зүйл

үлдсэн ялыг эдлүүлэхээр захирамж гаргаж болно. Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээд хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдсэн бол шүүхийн сүүлчийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ял дээр өмнөх шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулснаас эдлээгүй үлдсэн ялыг бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэн уг этгээдийн биечлэн эдлэх ялыг тогтооно хэмээн хуульчилсан байна.

2015 оны Эрүүгийн хуульд:

Нийгмийн хэрэгцээний шалгуур болж эрүүгийн эрх зүйн салбарт хийгдсэн томоохон өөрчлөлтийн илрэл нь Улсын их хурлаас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр шинээр баталсан Эрүүгийн хуулиар ял шийтгэлийн тогтолцоонд өөрчлөлт оруулж, шинэ төрлийн хэд хэдэн ял бий болгосон явдал юм. 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн онцлог нь хорих ял биечлэн эдлүүлэх явдлыг багасгах, хохирол нөхөн төлүүлэх чиглэлд анхаарч, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ялыг тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах ялыг хөнгөрүүлэх, чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх, өсвөр насны хүнд болон хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх институтыг тусгасан. Аливаа хариуцлага тэр тусмаа эрүүгийн хариуцлагын мөн чанар нь бие хүн, нийгэм ба төр хэмээх хоорондоо харилцан шүтэлцээ бүхий хүн төрөлхтний бодит ахуйгаар нөхцөлдсөн байдаг.

Хариуцлага гэдэг¹² нь өргөн утгаараа өөрийнхөө хийсэн үйлдэл, хэрэг явдал, тэдгээрээс үүсэх үр дагаврыг өөрийн биеэр хариуцах хүн бүрийн бэлэн байдал, үүрэг юм. Хариуцлага бол хувийн ухамсрын түгээмэл үзэгдэл юм. Хариуцлагын үндэс нь нийгмийн өргөн хүрээтэй харилцаа. Энэ харилцааны хүрээнд өрнөж буй үйл явцын гол шинж бол харилцан холбогдож буй субъектүүд нэг нэгнийхээ өмнө зан үйлийн тодорхой үүрэг хүлээх явдлаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл аливаа харилцаа, тэр тусмаа эрх зүйн харилцаанд орж буй субъектүүд тухайн нийгэмд тогтсон зан үйлийн заавал биелүүлэх шинжтэй журмыг дагаж, үүрэг хүлээж, хариуцлага хүлээнэ гэж үг юм. Субъектийн зан үйлд нөлөөлсөн гадна нөхцөл байдал үгүйсгэгдэж байгаа нөхцөлд түүний бодит байдал дээр нийгэмд харш үйл ажиллагаа явуулсан шалтгаан нөхцөл, хүчин зүйлүүдийг нэг бүрчлэн тогтоох шаардлагатай болдог.

Хууль зүйн хариуцлага нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйн төлөө үүсэх эрх зүйн үр дагавар байдаг. Мөн хууль зүйн хариуцлага нь эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн этгээдийн хүлээх үүргийг тодорхойлж эд хөрөнгийн болон хувийн эрхэд хязгаарлалт тогтоох замаар буруутай этгээдийн үйл ажиллагаанд төрийн зүгээс үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг олгодог ба эрүүгийн хариуцлага нь хамгаалах, цээрлүүлэх, урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох чиг үүргийн хэрэгжүүлдэг. Эрүүгийн хариуцлага нь эрүүгийн эрх зүйн бие даасан ойлголт бөгөөд гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд

¹² Я.Цэвэл, “Хариуцлага гэдгийг а) хариуцах үйлийн нэр, хариуцсан үүрэг, хариуцаж биедээ хүлээсэн үүрэг, хариуцлага, б) хууль зөрчсөн хүнд хүлээлгэх хариуцлага” гэж тайлбарласан. “Монгол хэлний товч тайлбар толь”, УБ хот, 1966 он, 666 дахь тал
Г.Галиндэв, Г.Батжаргал нар, “Хариуцлага гэдэг нь өөрийнхөө хийсэн үйлдэл, хэрэг явдал, тэдгээрийн үр дагаврыг хариуцах субъектийн бэлэн байдал юм” гэж тодорхойлсон. “Орчин үе, онол”. УБ хот, 328 дахь тал

хуульд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ мөн¹³.

Түүнчлэн эрүүгийн хариуцлага нь хууль зүйн хариуцлагын онцгой төрөл учраас эхлээд хууль зүйн хариуцлагын асуудлыг хөндөх шаардлагатай. Хууль зүйн хариуцлага нь:

- хариуцлагыг үзэл бодолд бус зөвхөн хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх;
- хариуцлагыг гэм буруутай эрх зүйн зөрчилд хүлээлгэх;
- хариуцлагыг шударга ёсонд нийцүүлж оногдуулах;
- хариуцлага зүй зохистой, гэмт хэрэг, зөрчлийн шинжид нийцсэн байх;
- хариуцлага маргаангүй байх;
- хууль зөрчсөн нэг үйлдэл, эс үйлдэхүйд зөвхөн нэг удаа хариуцлага хүлээлгэх зэрэг зарчимд үндэслэгдэх ёстой.

Эрүүгийн хариуцлагыг нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө хүлээлгэдэг учир түүний хууль зүйн үр дагавар нь ял оногдуулах байдлаар хэрэгждэг. Эрүүгийн хариуцлага нь Эрүүгийн хуулиар хүлээлгэсэн үүрэг, хэрэгжүүлэх бодит боломжтой, чөлөөт хүсэл зориг зайлшгүй шаардлагатай хэрхэн харьцаж байгаад нийгэм-эрх зүйн хяналтыг ямар нэгэн хэмжээгээр хэрэгжүүлж байдгаараа эрүүгийн эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд чухал байр суурь эзлэн оршдог.

Эрүүгийн хуульд заасан заавал биелүүлэх бодит шаардлага нь нийгмийн амьдралын объект хуулиудаар ямагт нөхцөлдсөн байдаг эрүүгийн хариуцлагын объектив тал юм. Тийм учраас эрүүгийн эрх зүй нь нийгмийн харилцааны субъектүүдийн хариуцлагатай, зүй зохист зан үйлийг урамшуулан хамгаалж байдаг. Эрүүгийн хариуцлага нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан үйлдэл, эс үйлдэхүй хийсэн гэм буруутай этгээдийн эрх зүйн байдалд хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын онцгой арга хэмжээ болох ойлгомжтой байна. Эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг зөвхөн Эрүүгийн хуулиар тогтоох бөгөөд ял ба эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ гэсэн хоёр үндсэн хэлбэртэй байна. Эрүүгийн хариуцлагын хэлбэр нь гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон шүүгдэгчийн эрхийг хязгаарласан агуулгатай ялын төрлүүдийг хэрэглэх замаар хэрэгждэг. Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь шүүгдэгчид гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайг тогтоож үнэлэлт өгсөн боловч биеэрээ болон эд хөрөнгийн хувьд ямар нэгэн хязгаарлалт шууд хүлээдэггүй онцлогтой эмнэлгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээгээр хэрэгждэг онцлогтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "...гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл, саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно" гэсэн заасан байдаг. Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах нь эрүүгийн хариуцлагын анхдагч зорилго юм. Энэ зорилго нь Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлд нэрлэж заасан нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн амин чухал эрх ашгийг эрүүгийн хуулийн хамгаалалтад авах нь нэг талаас энэрэнгүй ёсны зарчмын тод илрэл байдаг бөгөөд нөгөө талаас хүн, түүний аюулгүй байдал, эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалж байгаагаар тухайн зорилго бодит байдлаар хэрэгжиж байдаг.

¹³ Д.Мөрөн, Г.Ганбаатар нар, "Эрүүгийн эрх зүй (Ерөнхий ба тусгай анги), УБ хот. 2016 он, 15 дахь тал

Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх нь эрүүгийн хариуцлагын хоёр дахь зорилго юм. Энэ зорилго нь нийгмийн шударга ёсны илэрхийлэл бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулах болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэглэхийн зэрэгцээ гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан эд материалын болон сэтгэл санааны гэм хорыг арилгуулах, төлүүлэхэд чиглэгдсэн олон хэм хэмжээ Эрүүгийн хуульд тусгагдан хэрэгжиж байгаагаар хангагдаж байдаг. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хүмүүжүүлэх нь эрүүгийн хариуцлагын дөрөв дэх бие даасан зорилго юм.

Ялтныг цээрлүүлж, өөрөөр хэлбэл эрхийг нь хязгаарлах замаар үйлдсэн гэмт хэрэгт гэмшүүлж байгаа явдал нь агуулгаараа хүмүүжүүлэх зорилгыг хангахад чиглэгдэнэ. Ялтан үйлдсэн гэмт хэргийн хортой үр дагаврыг бүрэн ухамсарлан ойлгож, нийгэмд тогтсон хууль ёс, дэг журмыг чанд сахидаг, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэдэг, иргэнийхээ үүрэгт хүндэтгэлтэй ханддаг, шударга, зарчимч нийгмийн идэвхтэй гишүүн болон хүмүүжсэнээр эрүүгийн хариуцлагын энэ зорилго хангагдах юм.

Гэмт хэрэг үйлдэхээс хоригдлыг болон бусад этгээдийг урьдчилан сэргийлэх нь эрүүгийн хариуцлагын тав дахь зорилго юм. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг түргэн шуурхай илрүүлж, түүнд шударга ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг цаг алдалгүй хэрэглэж чадвал сая эрүүгийн хариуцлага гарцаагүй байх эрүүгийн эрх зүйн зарчим хангагдана. Гэмт хэрэг үйлдсэн хүн бүрт хариуцлага тооцох нь гэмт хэрэг үйлдвэл эрт орой хэзээ нэгэн цагт төрийн цээрлэл амсдаг юм байна гэсэн итгэл үнэмшил, болгоомжлолыг ялтанд болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй бусад тогтворгүй хүмүүст төрүүлэх нь эрүүгийн хариуцлагын энэ зорилго хангагдаж байгаагийн илрэл болно.

Иймд гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг хуулиар хүлээсэн төрийн тусгай байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хэвлэл, мэдээллээр өргөн сурталчлах зайлшгүй шаардлагатай юм. Ялын үүслийн талаар баруун Европт “Итали Руссо” хэмээн алдаршсан, криминологийн сонгодог сургаалыг үндэслэгч Чезаре Беккариа (1738- 1794): “...хуулийг үл хэрэгсэж хүй нэгдлийн эмх замбараагүй байдалдаа эргэж очих гэсэн хүмүүсийн дур зоргоороо байх хүсэл эрмэлзлийг хазаарлах мэдрэхүйг цочроогч бол хууль зөрчигчид хүлээлгэдэг ял болой, гэмт хэрэгт оногдуулах ялыг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд тэрхүү хуулийг бүтээх эрх мэдэл зөвхөн гэрээний үндсэн дээр байгуулагдсан нийгмийг төлөөлөгч болох хууль тогтоогчид хадгалагдах учиртай. Шударга ёсны зарчмын дагуу ямар ч шүүх өөрөө нийгмийн нэг хэсэг атлаа нийгмийн бусад гишүүдэд зориулан ял тогтоож болохгүй. Хуульд зааснаас хатуу болон хуулиар тогтоогоогүй ял оногдуулсан нь шударга байвч түүнийг ял гэж лав болохгүй...”¹⁴ “ хэмээн тодорхойлжээ.

2015 оны Эрүүгийн хуульд заасан “Хууль ёсны зарчим”, “Шударга ёсны зарчим”, “Гэм буруугийн зарчим”-уудад “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно”, “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна”, “Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан нь Ч.Беккариагийн үзэл санаатай бүрэн нийцэж, хууль тогтоогчийн баталсан хуулийн дагуу шүүхээс ял оногдуулж, хуульд заасан хэмжээ хязгаараас хэтрэхгүй, тухайн ял, хариуцлагын асуудал нь гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруу, бусад байдалд тохирсон

¹⁴ Чезаре Беккариа. “Гэмт хэрэг ба ялын тухай”. /Орчуулсан Г.Эрдэнэбат/

байх гэсэн үзэл санааг хуульчилжээ. Эрүүгийн хууль нь гэм буруутай этгээдэд ял оногдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үнэт зүйлсийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг давхар агуулдаг.

Германы эрүүгийн эрх зүйг үндэслэгч, гүн ухаантан Иоганн Ансельм Фейербах (1775-1883)¹⁵ “Сэтгэл зүйн дарамт үзүүлэх” онолыг боловсруулсан. Түүний үзэж байснаар, хуулиар тогтоосон ял шийтгэл нь хүмүүст сэтгэл зүйн нөлөөлөл буюу дарамт үзүүлж, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлдэг байна. Өөрөөр хэлбэл, хүч чадал, эрх мэдлээ буруугаар, дур зоргоор ашиглах гэсэн хүчний эсрэг яг ийм хууль, эрх зүйн тогтолцоо үйлчилж байж нийгэмд тэнцвэртэй, тогтвортой байдал үүснэ. Ял шийтгэл нь гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруу, хувийн байдалд тохирсон, өөрөөр хэлбэл Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчимд нийцсэн байна. Ял шийтгэлийн тухай асуудал гэмт хэргийн тухай ойлголттой салшгүй холбоотой. Шүүх гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж ял оногдуулахад харгалзах хүндрүүлэх болон хөнгөрүүлэх бүхий л нөхцөл байдлыг бүрэн тогтоосны үндсэн дээр гэм буруутай этгээдэд хуульд заасан, тохирсон ялыг сонгон оногдуулна. Эрүүгийн хариуцлага нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, нийгэмшүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой төрийн албадлагын арга хэмжээний хамгийн хатуу төрөл болохын хувьд эрх зүйн бусад албадлагаас ялгагдана. Эрүүгийн хариуцлагыг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулж, хүний эрх, эрх чөлөөнд Эрүүгийн хуульд заасан хязгаарлалт тогтоодог. Эрүүгийн хариуцлага нь өөрөө зорилго биш, харин Эрүүгийн эрх зүйн зорилтод хүрэх хэрэгсэл юм. Ийм учраас эрүүгийн хариуцлагын зорилго нь Эрүүгийн хуулийн зорилтоос үүдэн гарна.⁸² 2002 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын зорилгыг “Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх” гэж тодорхойлж байсан бол 2017 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль дээрх зорилгууд дээр хохирол нөхөн төлүүлэх зорилгыг нэмж хуульчилсан. Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг шийтгэж цээрлүүлэхээс гадна нийгэмшүүлэх зорилгыг давхар агуулдаг.

2015 оны Эрүүгийн хуульд ялын эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлэн гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ял тэнссэн, эсхүл хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүнд шүүх үндсэн ялаас гадна тодорхой үүрэг хүлээлгэх, эрхийн хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заасан. Тухайлбал, гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох зэрэг болно.¹⁶

¹⁶ С.Нарангэрэл, Г.Эрдэнэбат. Эрүүгийн эрх зүй гарын авлага. УБ., 2007.65 дахь тал

Дүгнэлт

Дээрх нөхцөл байдлуудыг нэгтгэн үзвэл дараах дүгнэлтэд хүрч болохоор байна. Үүнд:

Улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарууд, тэр дундаа хууль сахиулах салбарт хийгдэж буй тогтолцооны болон эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтүүд нь хүний хөгжлийг, улмаар нийгмийн зөв тогтолцоог дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстойг салбарын эрдэмтэд хүлээн зөвшөөрч байна. Пробаци (probation) гэсэн нэр томъёо нь “probation” гэсэн латин үгнээс гаралтай, туршилт, ажиглалт явуулах гэсэн утга бүхий гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүхийн шийдвэрийн үндсэн дээр тодорхой хөтөлбөрөөр нийгэмшүүлэх үйл ажиллагаа юм.

Анх 18 дугаар зууны дунд үеэс Английн эрүүгийн хуульд анх тусгагдсан Пробацийн үйл ажиллагаа нь дэлхийн олон орны шүүхийн болон хууль сахиулах үйл ажиллагаанд хэдийнээ өргөнөөр ашиглагдах болжээ. Дэлхийн улс орнуудын шүүх, хууль сахиулах үйл ажиллагааны практикт пробацийн үйл ажиллагааг хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны явцад гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн харилцаанаас тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх үйл явц гэж нийтлэг байдлаар тодорхойлсон байна.

Иймээс ч олон улсад пробацийг туршилтийн хугацаа, тэнсэн харгалзах, батлан даалт гэсэн нэршлээр тодорхойлж иржээ. Пробацийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь: - Гэмт хэрэг үйлдсэн хүнд аль болох хорих ял оногдуулахгүйгээр тэнсэн харгалзах ялаар шийтгэн, шийтгэл эдлэх үйл явцад хяналт тавих;

- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хор уршгийг ойлгуулах, ажил хөдөлмөр эрхлүүлэн, учирсан хохирлыг бүрэн төлүүлэх;
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих ангиас суллагдахын өмнө болон суллагдсаны дараа нийгмийн амьдралд дасан зохицоход тусламж үзүүлэх зэрэг байна. Пробацийн үйл ажиллагааны ач холбогдлыг тодорхойлохдоо гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих ял оногдуулахгүйгээр хүмүүнлэг нийгмийг бүтээх, гэмт хэрэгтнийг албадан хөдөлмөрлүүлж нийгмийн хөгжилд хувь нэмрийг оруулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорихоос өөр төрлийн ял оногдуулж эдийн засгийн хувьд харьцангуй бага зардал гарган гэж үздэг байна.

Дэлхийн улс орнууд өөрийн эрх зүйн тогтолцоо, нийгмийн хөгжлийн онцлогт нийцүүлэн пробацийн албыг нэршил, чиг үүрэг, харьяаллын хувьд 189 өөр өөр хэлбэрээр байгуулан ажиллуулж байна. Тухайлбал, АНУ, Англи, Швед, Латви, Гүржид бие даасан алба, Норвеги, Финлянд, Дани, Япон, Чех, Эстонид Хууль зүйн яамны харьяаны алба, Герман, Унгарт Шүүх байгууллагын харьяаны алба, Голландад Прокурорын байгууллагын харьяа алба, Казакстанд Хорих байгууллагын харьяа алба, Сингапурт Спорт, нийгмийн хөгжлийн яаманд тус тус харьяалагдан үйл ажиллагаагаа явуулдаг байна. Гадаад орнуудын пробацийн үйл ажиллагааг судлан үзэхэд дараах 3 хэлбэрээр зохион байгуулж байна. Үүнд:

1. Гэмт хэрэг сэжиглэгдэж эхлэх үеэс тусламж үзүүлэх хэлбэр: /гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг тодорхойлох, хууль зүйн туслалцаа үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдох хүртэл ар гэр, хамт олны батлан даалтад авах/

2. Нийгмийн хяналтын хэлбэр: /гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихгүйгээр нийгэмд засах, хүмүүжүүлэх, ар гэр, хамт олны хяналтад авах, чөлөөтэй зорчин явах эрхийг хязгаарлах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах/

3. Хорих эдэлсэн этгээдийг нийгмийн хэвийн амьдрал ороход тусалцаа үзүүлэх хэлбэр: /нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан ажилд зуучлах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран түр амьдрах орон байраар хангах/ зэрэг байна.

Санал:

Энэхүү илтгэлийн сэдвийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд ял эдлээд суллагдсан болон ял хойшлогдсон, тэнссэн этгээдэд үзүүлэх нийгэмшүүлэх ажлын чиглэлээрх төрийн байгууллагуудын хүлээх үүргийг тодорхой тусгах;
2. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын хүрээнд “Суллагдахад бэлтгэх хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлэх;
3. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх хүрээнд орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагч, олон нийтийн цагдааг хяналтын үйл ажиллагаанд ашигладаг тогтолцоонд шилжих;
4. Хувийн хэвшлийн байгууллага, ажил олгогчид хорих байгууллагаас суллагдсан иргэний ажилд олгосон тохиолдолд бизнесийн үйл ажиллагаанд нь бодитой дэмжлэг үзүүлдэг эрх зүйн зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлэх;
5. Гадаадын зарим орны Пробацийн албаны сайн туршлага, тухайлбал төрийн бус байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг бий болгох зэрэг болно.

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. 2017.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017.
4. Цагдаагийн албаны тухай хууль. 1999; 2017.
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. 1997 оны хууль болон түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд 2012.01.19-ны; 2013.07.05-ны; 2015.12.04-ны; 2016.12.22-ны; 2017.02.09-ны; 2017.05.18-ны.

Ном, сурах бичиг, гарын авлага

1. Ж.Амарсанаа. Англи-Орос-Герман-Монгол олон улсын эрх зүйн толь. УБ. 2004 он
2. Б.Алтангэрэл. Хорих ял эдлүүлэх ажиллагаа.УБ.,2018 он
3. Б.Алтангэрэл.Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ.УБ.,2019 он
4. Б.Алтангэрэл Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны харьцуулсан судлал. УБ., 2018 он
5. М.Алтан-Очир. Хорих ял эдлүүлэх дэглэм.УБ., 2020 он
6. А.Лхагва. МУ-ын Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүй. УБ., 2012.
7. С.Жанцан. “МУ-ын Эрүүгийн эрх зүйн онол” ялын тухай сургаал. УБ., 2014.
8. С.Жанцан. Хорих ял эдлүүлэх газраас суллагдсан хүмүүсийг рецидив гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал. УБ., 1989.

9. Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012.
10. С.Жанцан. Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009.
11. С.Нарангэрэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. УБ., 1999.
12. Г.Совд. Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002.
13. А.Думбарай, А.Лхагва, Л.Чүлтэмсүрэн. БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар гарсан хууль, эрхийн баримт бичгийн эмхэтгэл. УБ., 1991
14. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон Улсын эрх зүй. УБ., 1999
15. А.Лхагва, Д.Даваа-Очир. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ., 2011
16. А.Лхагва. Монгол Улсын Эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэрийг биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт /1931-2005/. УБ., 2005 он
17. А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ., 2012
18. С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” нэмж засварласан 2 дахь хэвлэл, УБ. 2008
19. О.Пүрэвсүрэн. Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2014
20. Каратис Чех ТББ. Хорих байгууллага дахь нийгмийн ажил. УБ., 2015
21. ХЭҮК, Каратис Чех. Хорих байгууллагын ажилтнуудад зориулсан Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. УБ., 2014

Гадаад хэл дээрх материал

1. Обзор законодательства скандинавских и балтийских стран по службе пробации (уголовному надзору). Санкт-Петербург., 2010.
2. Probation and Probation service: A European Perspective (ed by A Van Kalmthout & J Derks). Wolf legal publishers.
3. 2000. Обзор законодательства скандинавских и балтийских стран по службе пробации (уголовному надзору). Санкт-Петербург., 2010.
4. Probation and Probation service: A European Perspective (ed by A Van Kalmthout & J Derks). Wolf legal publishers. 2000.

Судалгааны тайлан, бусад материал

1. ХЗҮХ-ийн судалгааны төвөөс 2012 онд хийсэн судалгаа, тайлан.
2. ННФ-оос зарласан бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд “Шоронгоос суллагдсан хүмүүст нийгэмд дасан зохицоход үзүүлэх бодлогын судалгаа”. 2011.
3. Model Codes for post – Conflict criminal Justice volume I model criminal code United states institute of peace press Washington D.C
4. Уголовно-Исполнительный кодекс Российской федераций. 1997.
5. АССРА 20 ун Conference as refort Австралийн Сидней хот. 2000.

Цахим хуудас

1. www.cd.gov.mn
2. www.mojha.gov.mn
3. <http://didacts.ru/termin/socializacija.html>
4. <https://cyberleninka.ru>
5. <http://duisastana.kz/departament/probation/>
6. <http://egov.kz>
7. <http://fsin.su/>

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

Баянхонгор аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Б.Бат-Оргил

Хураангуй:

Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтийн явцад ялтны эрхийг хангах, ялыг үр нөлөөтэй байлгах нөхцөлийг бүрдүүлэх, Монгол Улсын Үндсэн хуулийн хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах үндсэн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Нийтэд тустай ажил хийлгэх ялыг эдлүүлэхдээ ялтныг залхаан цээрлүүлэх гэхээсээ илүү тухайн хүний мэргэжил, чадварт суурилсан, ялтны хувийн байдал, эрүүл мэнд насны онцлогт тохирсон ажлын байрны стандартыг бий болгосноор нийгэмд үр ашигтай, ялтны эрхийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх нөхцөл байдлыг бүрдүүлэх болно.

Түлхүүр үгс: Ял, ялын төрөл, нийтэд тустай ажил хийлгэх ял, хүний эрх, хүний эрхийн зөрчил.

Удиртгал

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталж, түүгээр “Хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлнэ” гэж тунхагласны үр дүнд өөрийн орны өвөрмөц онцлог, үндэсний язгуур ашиг сонирхолд нийцүүлэн батлагдсан хуулиудын нэг бол 1993 онд шинэчлэн найруулж баталсан Монгол Улсын шинэ эрүүгийн хууль байсан билээ.

Уг хуулийн сэтгэлгээний чиглэл, үзэл баримтлал нь өдгөө хөгжингүй гэгдэх улсуудад үүсч хөгжөөд, манай улсад нутагшсан соён гэгээрүүлэх, хүмүүнлэг сэтгэлгээний чиглэл бөгөөд анхны Эрүүгийн эрх зүйн онолын урсгал нь тус чиглэлээр 18-р зууны үед бий болсон¹.

Соён гэгээрүүлэх, хүмүүнлэг сэтгэлгээний онолын урсгал чиглэлийн гол төлөөлөгчдийн нэг Францын нэрт соён гэгээрүүлэгч Ш.Л.Монтескьегийн /1689-1755/ үзэж байснаар: - эрүүгийн хуулийн зорилго нь яллахад бус урьдчилан сэргийлэхэд оршино, - ял хөнгөрүүлэх байр суурийг баримталж, гэмт гадаад үйлдлийн төлөө цээрлүүлэх ёстой болохоос субъектив дан ганц яллагаа байж таарахгүй ... гэх алдарт үгээ хэлж орчин үеийн Эрүүгийн эрх зүйн үндсэн зарчмыг дэвшүүлэн гаргажээ.

Энэ талаар манай нэрт эрдэмтэн хуульчид өөрийн байр суурийг илэрхийлж байв. Тухайлбал: Монголд Улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор Ж.Авхиа өөрийн бүтээлдээ – Бид бүх нөхцөл байдалд ял шийтгэлийг хүндрүүлэх нь гэмт хэргийн бууралттай холбоотой болохыг эрс тэс нотлохыг эрмэлзэхгүй болно ... гэж дурьдсан байна².

Мөн Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор Г.Совд мөн өөрийн бүтээлдээ дурьдаж, эрүүгийн хариуцлага нь эрүүгийн хуулийн хэм хэмжээг

¹ Б.Ганболд “Эрүүгийн эрх зүйд нэвтрэхүй” 2012 он. 28 дахь тал

² Ж.Авхиа “Иргэдийн амь биеийн эсрэг гэмт хэргүүд түүнтэй явуулах тэмцэл” 1982 он. 17 дахь тал

өөрийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээр зөрчсөн этгээд түүнийхээ төлөө төрийн өмнө хариуцлага хүлээх ёстой талаар дурдсан³.

Энэхүү онолын зарчим бүхий үзэл баримтлал хойшид хадгалагдан бэхжиж, улмаар эрүүгийн хуульд 1996, 1999, 2000, 2001 онуудад нэмэлт өөрчлөлт оруулан төгөлдөржүүлж байсаар 2002 онд түүхэндээ цоо шинэ үзэл баримтлалыг хадгалсан эрүүгийн хуулийг баталсан юм.

Энэ эрүүгийн хууль бол 1961 онд батлагдсан социалист үзэл баримтлал бүхий хуульд аажмаар өөрчлөлт оруулан ардчилсан үзлийг суулгаж ирсэн хуулийг халж, эрх зүйн шинэтгэл хийсэн ач холбогдол бүхий хууль болсон.

Энэхүү хууль даруй 15 жилийн хугацаанд хэрэгжиж, 2017 оны 07 сарын 01-ний өдөр хэрэгжиж эхэлсэн 2015 онд батлагдсан шинэ эрүүгийн хуульд халаагаа өгөөд байна.

Судлаач, Монголд Улсын гавьяат хуульч, академич С.Нарангэрэл үзэхдээ Монгол Улсын эрүүгийн хууль нь урьдчилан сэргийлэх нийтлэг зорилтыг хэрэгжүүлнэ. Эрүүгийн эрх зүйн хамгаалалтын гол хэсэг нь эрүүгийн хуулийн тусгай урьдчилан сэргийлэх нөлөөлөл юм гэжээ⁴.

Түүний ийнхүү үзэж, судалж байсанчлан Монгол Улсын эрүүгийн хуулийн үзэл санаа харьцангуй өөрчлөгдөж, 2015 оны эрүүгийн хуулийн зорилгод энэ хуулиар бусдын эрх, эрх чөлөөг хамгаалахаас гадна урьдчилан сэргийлэх зорилготой болохыг хуульчилж өгсөн байна. Өмнөх эрүүгийн хуулиар 7 байсан ялын төрлийг 2015 оны эрүүгийн хуулиар ялын төрлийг 5 байхаар тогтоож өгсөн.

Энэхүү ялын төрөл дундаас Нийтэд тустай ажил хийлгэх ял нь өнөөгийн нөхцөлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, нийгэмд үр нөлөөтэй байдлаар ял эдлүүлэх төрийн бодлогод нийцсэн хуулийн зохицуулалт болсон.

Манай улсын хувьд 2017 оны эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Хорих ял, Торгох ял, Эрх хасах ял, Зорчих эрхийг хязгаарлах ял, Нийтэд тустай ажил хийлгэх ялын төрлүүдийг хуульчлан хэрэгжүүлж байгаа бөгөөд 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр шинэчлэн батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн “Нийтэд тустай ажил хийлгэх” ял нь 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн “Албадан ажил хийлгэх” ялтай утга, агуулгын хувьд нэгэн ижил ялын төрөл болсон. Өмнөх хуультай харьцуулахад “нийтэд тустай ажил хийлгэх” ял нь илүү өргөн хүрээг хамарсан бөгөөд Эрүүгийн хуулийн зорилго, ялын бодлогыг хангах, ялтныг ухамсарлуулах, цалин хөлсгүйгээр төрийн байгууллагад ажиллуулах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг ач холбогдолтой юм.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын нэршил, ойлголт, танин мэдэхүйн үндэслэлийг харьцуулж үзвэл дэлхийн улс орон бүрд өөр өөр хэллэг, нэр томъёогоор илэрхийлж, Эрүүгийн хуульдаа тусгасан байдаг нь анхаарал татаж байна.

³ Г.Совд “эрүүгийн хариуцлага, түүний уламжлал, шинэчлэлийн асуудал” Диссертаци. 1992 он. 4 дэх тал

⁴ С. Нарангэрэл “Монгол Улсын эрүүгийн эрх зүй” ерөнхий анги 1996 он. 14-15 дахь тал

Тухайлбал: Норвеги, Нидерланд, Австри, Литва, Швед зэрэг орнуудад “Нийгэмд ашиг тустай ажил үйлчилгээ эрхлүүлэх ял” (Community Service) гэсэн нэршлээр томьёолж хуульчилсан бол Орос, Украин, Казахстан, Армен, Беларусь, Киргиз, Азербайжан зэрэг ЗХУ-ын бүрэлдэхүүн орнуудад “Заавал ажил хийлгэх ял” (Обязательные работы) гэж нэрлэжээ. Тэгвэл Мексик, Молдав, Латви, Гүрж, Бразил, Испани зэрэг орнуудад “Нийгэмд ач тустай үнэ төлбөргүй хөдөлмөр эрхлүүлэх ял” (Неоплачиваемый труд в пользу общества) гэх зэргээр томьёолж хуульчилжээ.

Судалгаанаас үзэхэд зарим оронд “Хорихгүйгээр албадан ажил хийлгэх ял” гэсэн ялын дэглэмийн онцлог шинжээр нь ялган зааглаж хуульчилсан нь бий. Ялангуяа Франц, Япон, Бельги, Австри зэрэг оронд энэ хэлбэрийн онцлог бүхий ялын зохицуулалтыг тусгасан байдаг.

Дээр дурдсан байдлаас харахад нэр томьёо, нэршлийн хувьд харьцангуй ялгаатай ойлголтоор тэмдэглэн илэрхийлсэн хэдий ч мөн чанарын хувьд уг ялын үндсэн агуулга нь нийтэд ашиг тустай, нийгэмд хэрэгтэй ажил хөдөлмөрийг Эрүүгийн хуульд В.Н.Додонов. Сравнительное уголовное право. Общая часть. М., 2009. с 307-308 бодлогын судалгааны тайлан 19 заасан журмын дагуу эдлүүлэх гэсэн нөхцөлт шинжийг тусгаж байгаагаараа нийтлэг байна⁵.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйлд“Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно... гэж тусгажээ⁶.

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэхэд ажил олгогч байгууллагын үүрэг оролцоо хамгийн гол хүчин зүйл гэдэг нь практикаас харагдаж байна. Тухайлбал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.1-д “Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ.” гэж заасан нь

энэхүү ялыг эдлүүлэх нөхцөл байдлыг хумьж, хязгаарласан шинжтэй заалтыг оруулсан нэг ёсондоо хуулийн хийдэл болсон бөгөөд энэ нь зөвхөн цөөн тооны байгууллагад энэхүү ялыг эдлүүлэх, нөгөө талаараа хүний эрх зөрчигдөх, ялын үр нөлөөтэй байдал алдагдахад хүргэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн “Жагсаалт батлах тухай” тушаалаар Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалтыг баталсан бөгөөд Аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд төрийн 33 байгууллага, Сум, Дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд 17 байгууллагад ажиллуулахаар заасан байна.

Шүүхийн шийтгэх тогтоолд нийтэд тустай ажил хийлгэх байгууллагыг заадаггүй, төрийн эрх бүхий байгууллагаас ялтан ажиллуулах санал ирдэггүй, ялтанд итгэж ажил,

⁵ В.Н.Додонов. Сравнительное уголовное право. Общая часть. М., 2009. с 307-308

⁶ Монгол Улсын Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07

хөдөлмөр эрхлүүлэх үүргээ биелүүлдэггүй, тайлан, мэдээгээ цаг тухай бүр нь гаргаж өгдөггүй зэрэг хүндрэлтэй байдлыг үүсгэдэг билээ.

Жишээ нь: Баянхонгор аймгийн хэмжээнд шүүхээс 2023 оны байдлаар нийт 36 ялтанд холбогдох нийтэд тустай ажил хийлгэх ялын гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч хяналт тавин ажиллуулж байсан боловч тухайн ялыг хэрэгжүүлэх боломж, нөхцөл бүрдэхгүй байгаагаас болж ялтан дахин гэмт хэрэг зөрчилд холбогдох эрсдэл байсаар байна⁷.

Манай улсын хувьд ялтны мэргэжил, боловсролыг харгалзан ажиллах байгууллагыг сонгоно гэж заасан боловч шийтгүүлж буй ялтны 90 орчим хувь нь боловсрол мэргэжил эзэмшээгүй, бичиг, үсэг мэддэггүй байгаа нь ихэвчлэн хотын тохижилт үйлчилгээний газарт цэвэрлэгээ үйлчилгээний ажил хийх байдлаар хязгаарлагдаж байгаа нь тухайн ялтны хувьд хүний эрхийн зөрчил үүсгэсэн нэгээхэн хүндрэлтэй асуудлын нэг болоод байгаа нь тодорхой харагдана.

Шинэчлэн батлагдаж хэрэгжиж буй одоогийн хуульд “Нийтэд тустай ажил хийлгэх ял”-ыг өдөрт 4 цагаар эдлүүлдэг байсныг 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр өдөрт 8 цаг болгон өөрчилсөн нь ялтныг залхаах, сул чөлөөтэй байдал үүсгэх, улмаар дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлснээрээ онцлогтой⁸.

Жагсаалтаар батлагдсан ялтан ажиллуулах эрх бүхий төрийн байгууллага нь хуульд заасан үүргээ бүрэн биелүүлдэггүй, тайлан мэдээ өгөхөөс төвөгшөөдөг, хугацаа хоцроодог, ялтныг ажлын хувцсаар бүрэн хангадаггүй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны тогтсон заавар, дүрэм, журам байдаггүй, ялтан ажиллуулах сонирхол бага байгаа нь анхаарах асуудлын нэг болж байгааг энд зориуд дурдахыг хүссэн бөгөөд энэ нь цаашлаад тухайн ялтны хувьд хүний эрх зөрчигдөж байгаа нэгэн тодорхой нөхцөлийг бий болгож байна.

Өнөөгийн байдлаар дэлхийн 60 гаруй орон Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрэглэж байна. Тухайн орны заримаас дурдвал Их Британи, АНУ, Франц, Голланд, Португаль, Швейцари, Испани, Мексик, Казакстан, Чех гэсэн орнуудад ихээр хэрэглэж байна. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг ихэвчлэн цагаар тооцон хуульчилсан байдаг. Тухайлбал: Орос, Украин, Казакстанд 60-240 цаг, Англи, Франц, Шведэд 40-240 цаг, Чехэд 50-400 цаг, Армэнд 360-1500 цаг байх бөгөөд ихэнх орнуудад өдрийн 4 цагаас дээшгүй байхаар хуульчилсан байна. Энэ нь тухайн этгээд үндсэн ажлаа хийж гэр бүлээ тэжээн тэтгэх, ар гэртээ ямар нэгэн дарамт учруулахгүй байх боломжийг олгодог. Харин гэмт хэргийн шинж байдлаас шалтгаалан авто ослын хэрэг үйлдсэн этгээдэд жолооны багшаар ажиллуулах, үр хүүхдээ асрах үүргээ хэрэгжүүлээгүй бол иргэдэд гэр бүлийн хичээл заалгах байдлаар тэднийг ухамсарлуулан ойлгуулах замаар ялын хэрэгжилтийг хангадаг байна.

⁷ Прокурорын байгууллагын цахим бүртгэл

⁸ Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №24

Дүгнэлт, санал

Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтийн явцад ялтны эрхийг хангах, ялыг үр нөлөөтэй байлгах нөхцөлийг бүрдүүлэх, Монгол Улсын Үндсэн хуулийн хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах үндсэн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Нийтэд тустай ажил хийлгэх ялыг эдлүүлэхдээ ялтныг залхаан цээрлүүлэх гэхээсээ илүү тухайн хүний мэргэжил, чадварт суурилсан, ялтны хувийн байдал, эрүүл мэнд насны онцлогт тохирсон ажлын байрны стандартыг бий болгосноор нийгэмд үр ашигтай, ялтны эрхийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх нөхцөл байдлыг бүрдүүлэх болно гэсэн дүгнэлтээр өөрийн илтгэлийн санаагаа илэрхийлж байна.

Дээрх бүгдээс дүгнэж үзвэл ялын бодлого, түүний үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарах зарим асуудал байгааг олж харж болохоор байна.

Цөөн тооны байгууллагад энэхүү ялыг эдлүүлэх, нөгөө талаараа хүний эрх зөрчигдөх, ялын үр нөлөөтэй байдал алдагдахад хүргэж байгаад анхаарч, цаашид энэхүү ялыг аль ч байгууллагад эдлүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх нь хүнийг албадан хөдөлмөр эрхлүүлэх, зөвхөн цээрлүүлэх бодлого баримтлах бус харин нийгэмд үр ашигтай, ялтны хувийн байдал, эрүүл мэнд насны онцлогт тохирсон ажлын байрны стандартыг бий болгох, хүний мэргэжил, ур чадварыг харгалзсан илүү бодитой бодлого баримтлах шаардлагатай гэж үзлээ.

Цагдаагийн, Эмнэлгийн байгууллагын үүрэг оролцоо, хяналтыг сайжруулах, нэгдсэн зөвлөмж хүргүүлэх, ялтан өвдсөн тохиолдолд чирэгдэлгүйгээр, цаг алдалгүй дүгнэлт гаргаж өгөх шаардлагатай гэж үзэж байна.

Шүүхээс харьяаллын дагуу шилжин ирж байгаа гүйцэтгэх баримт бичигт шаардлагатай тохиолдолд ялтны хүсэлтээр түр оршин сууж байгаа хаягийн дагуу шилжүүлэх талаар хууль, журамд тусгуулах, хувийн хэвшлийн байгууллагад ажиллуулах нөхцөл бололцоог хангах зэрэг саналыг дэвшүүлж байна:

Ашигласан эх сурвалж

1. Б.Ганболд. “Эрүүгийн эрх зүйд нэвтрэхүй”. 2012 он
2. Ж.Авхиа. “Иргэдийн амь биеийн эсрэг гэмт хэргүүд түүнтэй явуулах тэмцэл”. 1982 он
3. Г.Совд. “Эрүүгийн хариуцлага, түүний уламжлал, шинэчлэлийн асуудал”. докторын диссертаци. 1992 он
4. С.Нарангэрэл. “Монгол Улсын эрүүгийн эрх зүй” ерөнхий анги. 1996 он
5. В.Н.Додонов. Сравнительное уголовное право. Общая часть. М., 2009. с 307-308
6. Монгол Улсын Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07
7. Прокурорын байгууллагын цахим бүртгэл
8. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №24
8. www.legalinfo.mn сайт

ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА: ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ

Дархан-Уул аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Л.Энхтайван

Хураангуй:

Хорихоос өөр төрлийн ялын зорилго нь гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийг гэр бүл, нийгэм, хамт олны дунд нь байлгаж, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулан ойлгуулах, өөрийн хөдөлмөрөөр нь нийгэм, иргэнд учирсан хохирлыг барагдуулах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Төр засгаас баримталж буй ялын бодлого, түүнийг хэрэгжүүлэх хууль тогтоомж, бусад шийдвэрүүд нь амьдралд буун хэрэгжихдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх цор ганц эрхтэй байгууллагаар дамжиж байдаг тул ганц хорих ял бус хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа ч нэгэн адил анхаарлын төвд зүй ёсоор байх ёстой асуудал юм.

Дэлхий нийтийн жишиг хандлагаар орчин цагт дийлэнх улс орнууд хорих ялыг хэрэглэх явдлаас эрс татгалзаж, хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэх нь хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийн нэгэн илрэл үнэт зүйл гэж үзэх болов.

Олон улсын хөгжлийн чиг хандлагаас үзэхэд хорих ялын нийгэмд үзүүлэх үр нөлөө нь төдийлөн өндөр байдаггүй ба аль болох хорихоос өөр төрлийн ялыг сонгож, гэмт хэргийн шинж байдлаас нь хамаарч ялыг ялгамжтай оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр гэм буруу, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг баримтлах нийтлэг хандлагатай байна. Харин "хорих" ялыг эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх хандлага эрс хүчтэй давамгайлах болсон байна.

Ял бол нэг талаас шийтгэл, нөгөө талаас итгэл хүлээлгэх, засрал, төлөвшил олгох нийгмийн арга хэмжээ юм¹.

Манай улсын хувьд ч мөн эрүүгийн ялын шинэчлэлт хийж дэлхий нийтийн жишиг үзэл баримтлалын дагуу эрүүгийн хуульд хорихоос өөр төрлийн ялыг сонгох санкцитай байдлаар түлхүү оруулж хуульчилсан нь томоохон дэвшилт билээ.

Түлхүүр үгс: Зорчих эрхийг хязгаарлах ял, цахим бугуйвч, төхөөрөмж, сүлжээ.

¹ Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, шинэчлэлийн асуудал. С.Жанцан. УБ., 2007 он

Удиртгал

Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд юуны өмнө ял шийтгэлийн хэлбэрийг боловсронгуй болгох шаардлагатай.

Ялын бодлого бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хүрээнд ялын оновчтой төрөл, хэлбэрийг хуульчлан тогтоож, сонгон хэрэглэх тухай үзэл баримтлал юм.

Иймд олон нийтийн зүгээс эрүүгийн ял шийтгэлийн бодлогыг илүү хүнлэг, энэрэнгүй, ардчилсан хэлбэрт шилжүүлэх арга замыг тууштай эрэлхийлж эхэлсэн. Эдгээр арга замын нэг нь "нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл" буюу "хорихоос өөр төрлийн ял" юм.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын гол үзэл баримтлал нь ялын бодлогын шинэчлэл бөгөөд заавал хорих ял оногдуулахгүй байх тухай асуудал юм. Дэлхийн бусад улсын жишгийг харвал хорих ял оногдуулахаас илүүтэй гэмт хэрэг үйлдсэн хүнтэй хохирол, хор уршиг, гэм буруугийн асуудлыг судлан үзсэний үндсэн дээр ял оногдуулахгүйгээр бусад төрлийн албадлага, нөлөөлөх арга хэмжээ авах, болохгүй бол хорих ялын тухай асуудал ярьдаг. Ийм учраас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд засрах, гэм хороо арилгах боломж гардаг.

Иймд хорихоос гадна нийтэд тустай ажил хийлгэх, торгох, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах ялын хүрээнд хүмүүст нөлөөлдөг, гэмт хэргийн улмаас учирсан хор хохирлыг нь арилгуулдаг, хүнийг өөрөөр нь өөрчилдөг хөшүүрэг, механизм бий болсон нь дэвшилттэй алхам юм.

Орчин цагт ял нь хорих болон хорихоос өөр төрлийн ял гэж зааглагдаж буй хандлага түгээмэл болсон учир хорихоос өөр төрлийн буюу нийгмээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тусгаарлахгүй шинжтэй ялуудын ялын тогтолцоонд эзлэх байр суурь, онцлог шинжийг тодорхойлох нь чухал байдаг.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр засан хүмүүжүүлэх, аль болох нийгмээс ангид байлгахгүй байх талыг чухалчилж, цээрлэл болон хүмүүжил, нийгэмшлийг хорихоос өөр ялын мөн чанараар мэдрүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилт олон нийтийн ил тод хяналтын дор явагдах нөхцөлийг бүрдүүлэх арга хэрэгслийг эрэлхийлэх нь түгээмэл болж, энэ талаар олон улсын баримт бичгүүд гарч, бусад улс орнуудын сайн туршлага нэвтэрч, улс орон бүр хууль тогтоомжоо шинэчлэх ажилд санаа нэгдэн орсоор байна.²

Үндсэн хэсэг

Монгол Улсын Эрүүгийн хуульд хорихоос өөр дөрвөн төрлийн ял байдаг. Үүнд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах гэсэн ялын төрөл багтдаг.

Дэлхийн олон улс эрүүгийн ялын бодлогоо хүний эрхийг хангах, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлэх, ялын чанга шийтгэлээс үндсэндээ татгалзах,

² Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2021 он

гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох хүрээнд хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг хэрэглэх чиг хандлагатай болжээ.

2015 оны Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлалд "шүүх хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулах өргөн боломжтой, хорих ялын дээд ба доод хэмжээг сунгаж, харьцангуй уян хатан байдлаар тусгана. Ингэснээр "гэмт хэргийн ангилал, шүүхээс оногдуулах ял хоорондоо уялдаагүй, хатуу хязгаарын хүрээнд, гэм бурууд тохирохгүй ял оногдуулдаг" гэсэн шүүмжлэл багасаж, шударгаар хэргийг шийдвэрлэхэд дөхөм болно" гэж авч үзсэн байна.³

Хуулийн үндэслэлтэй болон үндэслэл муутай ялын санкцийг чангаруулах нь бараг бүх тохиолдолд үр дүн багатай. Дан ганц хорих ялтай байсан санкц багасаж, сонгох буюу хорихоос өөр төрлийн ялтай санкц эрс нэмэгдсэн нь гэмт хэрэгтэнд ял оногдуулахдаа цээрлүүлэлтийн арга хэрэгслүүдийг хэмнэж ашиглах зарчимтай холбоотой юм. Хэрэв хатуу ялыг их хэмжээгээр хавтгайруулан ногдуулбал, ялангуяа хорихоос өөр төрлийн ялын нэр хүнд буурч, гэмт хэрэгтэй тэмцэх үр нөлөөтэй хэрэглүүр болж чаддаггүй байна.⁴

Хорих ялын хувьд "хүмүүжүүлэх" ба "цээрлүүлэх" гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэнэ. Цээрлүүлэх хэлбэр нь зөвхөн хуулиар тогтоосон нөхцөл, журам, эрхийн хязгаарлалтын хүрээнд, тодорхой хугацаагаар байлгах мөн чанарыг илэрхийлнэ. Энэ утгаараа хорих ялд хүмүүжлийн гэхээсээ илүүтэй залхаан цээрлүүлэх шинж давамгайлна. Хорих газарт хэрэгжүүлж байгаа хөдөлмөрийн үйл ажиллагаа нь чөлөөт сонголтын бус албадлагын хэлбэрээр явагдана. Хоригдлыг нийгмээс тусгаарлан хүмүүжүүлнэ гэдэг ялангуяа өнөөгийн нөхцөлд боломжгүй байгаа нь практикаас харагдаж байна. Хорих ялд хүнлэг бус шинж чанар давамгайлдаг. Учир нь хорих ял эдлүүлэх дэглэм нь гол төлөв цээрлүүлэх аргад тулгуурлах тул энэ хугацаанд хоригдлын зүгээс аливаа чөлөөт үйлдэл хийх, авьяас чадвараа хөгжүүлэх боломж хязгаарлагддаг.⁵

Эдгээр хүчин зүйлс нь хоригдлын хүмүүжил, зан үйл, сэтгэл санаа, бие бялдар, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ нийгэмшүүлэхэд хүндрэл үүсгэдэг. Энэ нь нийгмийн зүгээс хорих ялыг гол төлөв эергээр хүлээн авдаггүй тул хорих ял эдэлсэн байдал нь хүний амьдралд насан туршийн "хар толбо" болон үлддэг.

Дээрх бүхий л сөрөг үр дагаврыг даван туулах үр дүнтэй арга замд нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл зүй ёсоор тооцогдож байна. Учир нь хорих ялыг бодвол нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн хүмүүжлийн арга барил давамгайлна.

Хорихоос өөр төрлийн ял нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх, түүнчлэн үйлдсэн гэмт үйлдлийг засаж залруулах боломжийг илүү олгодог бөгөөд ялын уламжлалт онолын хандлага буюу зөвхөн цээрлэл үзүүлэх явдлыг бус, нийгэм, олон нийтэд ил тод, нээлттэй байх, тэдний оролцоо, дэмжлэг, тусламжид тулгуурласан хэлбэртэй байхын зэрэгцээ эдийн засаг, нийгмийн үр өгөөжтэй, ял эдлүүлэх тогтолцооны шинэ хэлбэр юм.

³ Эрүүгийн ял, түүний уламжлал, шинэчлэлийн асуудал. Б.Баттулга. УБ., 2006 он

⁴ Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, шинэчлэлийн асуудал. С.Жанцан. УБ., 2007 он

⁵ Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2021 он

Хорихоос өөр төрлийн ял нь ялтны зарим эрхийг тодорхой болзол, нөхцөлтэйгөөр хязгаарлах замаар оноож буй ял шийтгэлийг ойлгоно. Уг ялыг тухайн этгээдийн хувийн зан байдал, ёс суртахууны төлөвшил, үйлдсэн гэмт хэргийн төрөл, нийгэмд учруулсан сөрөг үр дагавар, хохирлын хэмжээ, гэм буруугийн хэлбэр зэрэг олон хүчин зүйлсийг харгалзаж оногдуулна.

Хорихоос өөр төрлийн ял оногдуулахын давуу тал нь хүнлэг ёсны үзэл санаа давамгайлсан, ялтныг засаж хүмүүжүүлэх болон нийгэмшүүлэх боломжтой, эдийн засгийн хувьд хэмнэлттэй байхад оршино.

Ял шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд ялтанд үзүүлэх нөлөөллийн арга хэмжээний агуулга, арга барилыг боловсронгуй болгох, ял шийтгэл хэрэгжүүлж буй орчин нөхцөлийг сайжруулах, ялтныг нийгэмшүүлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Эдгээр шаардлагыг хорих ялаар хангах боломжгүй болох нь олон жилийн практикаас харагдаж байна.

Монгол Улс дахь ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдлаас харахад хорих ял эдлээд суллагдсан этгээд давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй байна. Энэ нь хорих байгууллагаас суллагдсаны дараа үзүүлэх нийгэмшүүлэх ажлын тогтолцоо байхгүй, хууль сахиулах байгууллагуудын хүлээсэн чиг үүрэг тодорхой бус, хорихоос өөр төрлийн ялыг хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоо байхгүй зэрэгтэй холбоотой.⁶

Өөрөөр хэлбэл, ялын тогтолцоо, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлт, гэмт хэргийн гаралт, нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх, гадаадын зарим орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын туршлагаас суралцан, олон улсын чиг хандлага, загварт нийцүүлэх нь зүйтэй.

Тухайлбал: НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45/110 дугаар тогтоолоор "Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм"-ийг 7 бүлэг 23 зүйлтэйгээр батлан гаргасан нь хорих ялаас татгалзах, хорихоос бусад төрлийн ял шийтгэлийг өргөн хэрэглэх нөхцөлийг зарчмын хувьд бүрдүүлсэн чухал зохицуулалт болсон билээ. Энэ дүрэмд хорихоос өөр төрлийн арга хэмжээнд хэрэглэх үндсэн зарчмыг тусгасан бөгөөд дүрмийн гол зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмийн хэвийн амьдралд эргэж ороход нь туслах, хорих ялаас татгалзах, ялын нөлөөг цээрлүүлэхээс илүүтэй дахин гэмт хэрэг үйлдэж давтан гэмт хэрэгтэн болох явдлаас сэргийлэх, төрийн эрх бүхий байгууллагын хяналтад авах замаар хүмүүжүүлэх юм.

Үүнээс гадна хорихоос өөр төрлийн арга хэмжээ үр дүнтэй байгаа тохиолдолд хугацаанаас нь өмнө уг арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох, үр дүнд хүрээгүй тохиолдолд шууд хорих ял хэрэглэхээс зайлсхийн хорихоос өөр төрлийн ялаар солих зэрэг зохицуулалтыг санал болгосон байна.

Дэлхийн олон улс, үндэстэн эрүүгийн эрх зүйн ялын бодлого, түүнийг даган гарах хууль эрх зүйдээ хүний эрхийг хангаж, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлж, ялын чанга шийтгэлээс үндсэндээ татгалзаж, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох, хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг өргөн дэлгэр хэрэглэх чиг хандлагатай байна.

⁶ Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, түүний эрх зүйн зохицуулалт. Б.Солонго. УБ., 2012 он

Манай улсын хувьд мөн ижил хорих ялаас татгалзах, ялтны үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний зан байдалд тохирсон ялыг оновчтойгоор хэрэглэх замаар ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад шинэ төрлийн ял болох зорчих эрхийг хязгаарлах ялыг нэмж, хэрэгжилтийг цахим хэлбэрээр явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Хорихоос өөр төрлийн ял буюу олон улсын эрх зүйд алтернатив ял хэмээн нэрлэгддэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, тусгаарласан байранд тогтоосон хугацаанд хорихгүйгээр тодорхой эрхийн хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгждэг.⁷

Зорчих эрхийг хязгаарлах ял нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг заавал нийгмээс тусгаарлахгүйгээр ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, гэр бүлтэйгээ хамт байх зэрэг суурь эрхээ эдлэх боломжоор нь хангаж, гагцхүү чөлөөтэй зорчих эрхийг нь хязгаарладгаар бусад ялын төрлөөс онцлог.

Дархан-Уул аймгийн прокурорын газрын хэмжээнд хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солиулах тухай дүгнэлт бичсэнийг 2019-өөс 2023 оны байдлаар судалж үзэхэд 2019 онд 7, 2020 онд 29, 2021 онд 23, 2022 онд 23, 2023 онд 25 дүгнэлт үйлдсэн байна. Зорчих эрхийг хязгаар ялаар шийтгүүлсэн ялтан сүүлийн 3 жилийн хугацаанд буюу 2021 онд 11, 2022 онд 13, 2023 онд 12 ялтан хорих ялаар солигдсон. Жил бүр тодорхой түвшинд зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солиулж байгаагийн шалтгааныг тодорхойлохоор ял сольсон хуулийн үндэслэлийг 2023 оны байдлаар судлахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 170.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн тохиолдол 1, 170.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хуулийн 170.1.2, 170.1.4 дэх хэсэгт заасан зөрчлийг давтан гаргасан тохиолдол 3, 170.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны үүргийг 3 сарын хугацаанд хоёр ба түүнээс дээш удаа биелүүлээгүй тохиолдол 6, 170.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан техникийн, эсхүл биечилсэн хяналтаас 24 цагаас илүү хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн тохиолдол 8 байна.⁸

Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтнуудаас түүврийн аргаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 170.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан техникийн, эсхүл биечилсэн хяналтаас 24 цагаас илүү хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн зөрчил их байгаагийн шалтгааныг тодруулахад ихэнх хувийг цахим бугуйвчны цэнэг хурдан дуусдаг, цэнэглэхэд хүндрэлтэй байдаг гэсэн нь ялтанд зүүлгэсэн цахим төхөөрөмж нь цэнэгээ хангалттай барьж чадахгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

БНХАУ-д үйлдвэрлэсэн 2G сүлжээ дэмждэг цахим бугуйвчийг зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашигладаг ба дохио дамжуулах хурд бага, үүрэн холбооны ачааллаас шалтгаалан сүлжээ унах, тодорхойгүй хугацаагаар тасрах,

⁷ Ц.Очгэрэл. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал. "Хууль сахиулах үйл ажиллагаа: Онол, практикийн тулгамдсан асуудал" сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017

⁸ Дархан-Уул аймгийн прокурорын газрын 2019-2023 оны мэдээ, тайлан

байршил буруу заах зэрэг тохиолдол гардаг. Энэ байдал нь зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солиулах үндэслэл болж, ялтны эрхийг зөрчиж байна.

Мөн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан нь цахим бугуйвчийн ашиглалтын төлбөрийг төлдөг зохицуулалтыг халах шаардлагатай.

Ялтан цахим бугуйвч зүүж ял эдлэхдээ өдөрт 1305 төгрөгийг төлөх үүрэг давхар хүлээж байгаа бөгөөд зарим ялтнууд нь төлбөрөө төлж чадахгүй шүүхээр шийдвэрлүүлэх тохиолдол ч цөөнгүй гарч байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2023 онд зорчих эрхийг хязгаарлах ялын ашиглалтын төлбөр төлөөгүй 15 ялтны 6,1 сая төгрөгийг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл өгсөн байна.

Иймд 2G дэмждэг цахим бугуйвч нь өнөөгийн цаг үетэй нийцэхгүй байх тул 3G, 4G дэмждэг цахим бугуйвчийг зорчих эрх хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд түлхүү ашиглах, ашиглалтын төлбөрийг ялтнаас төлүүлэхгүй байх зохицуулалтыг хийх нь зүйтэй байна.

Дүгнэлт

Ял эдлүүлэх энэхүү ажиллагаанд хянах-нийгэмшүүлэх ажлыг зөв хослуулж зохион байгуулснаар гэмт хэрэг дахин үйлдэх явдлыг бууруулахад чухал түлхэц болох юм.⁹

Дэлхийн улс орнууд хүмүүнлэгийн чиглэлийн хүрээнд өөрчлөлт хийж эхэлсэн. Баруун Европын дийлэнх улс орон цаазаар авах ялыг халсан ба албадан ажил хийлгэх, эд хөрөнгийг бүхэлд нь хураах ялыг хязгаарлаж, нийгмийн үйлчилгээ, хөтөлбөрт хамруулах, нөхөн төлбөр оноох ялыг орлуулан сольж ялын бодлогодоо өөрчлөлт оруулсаар байна.

Ял нь гагцхүү Эрүүгийн хуульд тусгалаа олсон байх, ингэхдээ маш тодорхой бөгөөд үндэслэлтэй томъёологдсон, хуулиас гадуур хэнийг ч яллахгүй байх, хүний эрхийг хангах, хүнлэг энэрэнгүй байх, шударга ёсны тогтолцоог бүрдүүлэх, эзнээ олсон, оновчтой, үр нөлөөтэй, тогтвортой, улс орны онцлог, нийтийн эрх, ашиг сонирхолд нийцсэн, ганц нэг нэмэлт, өөрчлөлт төдийгөөр хандах бус төрийн зөв бодлого, шийдвэрт хөтөлбөр болж үзэл баримтлалын хэмжээнд томъёологдож гарах нь хууль ёсны зарчим бүрнээ хэрэгжих, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдлын хувьд манай улсын эрүүгийн эрх зүйн шинэчлэлд нэгэн чухал алхам болно гэж үзэж байна.

Дэлхий дахинаа эрүүгийн ялын бодлого хүмүүнлэг болохын хэрээр түүний мөн чанар, агуулга, зорилго нь улам бүр хувьсан өөрчлөгдөж, эрүү шүүлтээс ангид байх хийгээд хүний бие махбодыг зовоон тарчлаах, нэр төр, алдар хүндийг гутаах агуулга, хэлбэр, зорилго, цээрлүүлэлтийн ялын төрөл, хэлбэр үеэ өнгөрөөжээ.

Өдгөө дэлхийн ихэнх улс орон цаазаар авах ялаас татгалзаж байгаагаар нэгэн адил яг түүний дараагаар хорих ялаас татгалзах буюу зайлсхийх нь цаг хугацааны асуудал болж буйг бид соргоогоор мэдрэх нь эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгод бүрнээ нийцнэ хэмээн үзэж байна.

⁹ Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт. Судалгааны тайлан. УБ., 2022 он

Судалгааны хүрээнд харьцуулан судалсан гадаадын зарим орны гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зорчих эрхийг хязгаарлаж буй байдлыг судлан судлахад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхийн шатанд буюу цагдан хорихгүйгээр таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэхдээ цахим бугуйвч зүүлгэн хяналт тавих хэлбэр байдаг байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд техникийн боломж нөхцөлийг сайтар судлах шаардлагатай байгаа юм. Өөрөөр хэлбэл техник технологийн дэвшилтэд боломжууд нь энэхүү ялыг илүү үр дүнтэй хэрэглэх шинэ шинэ нөхцөл, боломжуудыг бий болгож байгаа юм.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь тухайн хүний өөрийнх нь нийгэмд болон гэр бүлдээ хүлээж байгаа үүрэгтэй салшгүй холбоотой. Нийгэм, хамт олныхоо дунд ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, гэр бүл, үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэх боломж бүрдүүлж байгаа, эдийн засгийн хувьд хэмнэлттэй хэдий ч цахим төхөөрөмж буюу техник хэрэгслээс шалтгаалан ялтан өр төлбөрт орох, цаашлаад шүүхээс оногдуулсан ял нь хорих ялаар солигдох хүртэл тохиолдол гарч байгаад анхаарах шаардлагатай байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд түүнд шаардагдах тоног төхөөрөмжийг сайжруулах, бусад орны туршлага, ололт амжилт, алдаа дутагдлыг сайтар судалж, өөрийн орны онол, практикт нэвтрүүлэх нь хамгийн чухал байна.

Улсын хэмжээнд жилд дунджаар хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан 25000 орчим ялтан, этгээдэд холбогдох шүүхийн шийдвэр хэрэгжүүлэх ажиллагаанд жилд дунджаар 1.1-1.2 тэрбум төгрөг зарцуулагдахаар байгаа бөгөөд энэ нь хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлаас даруй 10-15 дахин бага юм. Тиймээс хорихоос өөр төрлийн, тэр дундаа зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах нь улс орны эдийн засагт ч чухал ач холбогдолтой байна.¹⁰

Дэлхийн улс орнуудын шүүхийн практикт шүүхийн өмнөх, ял эдлүүлэх, хорих ял эдлээд хугацаанаасаа өмнө суллагдах үеүдэд зорчих эрхийг хязгаарлах арга хэмжээг сонгож хэрэглэдэг жишиг нэгэнт тогтжээ. Монгол Улсын хувьд цахим хяналтын системээ шинэчлэн, эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтаа сайжруулсан нөхцөлд дээрхийн адил бүх төрлийн албадлага, таслан сэргийлэх арга хэмжээнд үүнийг хэрэглэх боломжтой гэж үзлээ.

Санал

1. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан нь цахим бугуйвчийн ашиглалтын төлбөрийг төлдөг зохицуулалтыг халах.

2. 3G, 4G дэмждэг цахим бугуйвчийг зорчих эрх хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд түлхүү ашиглах, нэвтрүүлэх.

3. Цахим хяналтын системээ шинэчлэн, эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтаа сайжруулж бүх төрлийн албадлага, таслан сэргийлэх арга хэмжээнд цахим бугуйвч хэрэглэх.

¹⁰ Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт. Судалгааны тайлан. УБ., 2022 он

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
2. Эрүүгийн хууль. 2015 он
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он

Ном, гарын авлага

5. Эрүүгийн ял, түүний уламжлал, шинэчлэлийн асуудал. Б.Баттулга. УБ., 2006 он
6. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, шинэчлэлийн асуудал. С.Жанцан. УБ., 2007 он
7. Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, түүний эрх зүйн зохицуулалт. Б.Солонго. УБ., 2012 он
8. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал. “Хууль сахиулах үйл ажиллагаа: Онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Ц.Очгэрэл. УБ., 2017 он
9. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2021 он
10. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт. Судалгааны тайлан. УБ., 2022 он

Бусад эх сурвалж

11. Дархан-Уул аймгийн прокурорын газрын тайлан, мэдээ. Дархан сум, 2019-2023 он

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СУДАЛГАА

Дорнод аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Ч.Мөнхзул

Хураангуй:

Зорчих эрхийг хязгаарлах ял нь манай улсын Эрүүгийн хуульд шинээр тусган хэрэгжүүлж буй ялын төрөл бөгөөд богино хугацаанд энэ төрлийн ял шийтгэл эдэлж буй хүмүүсийн эрс тоо нэмэгдэж байна. Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байгаа прокурорын хувьд хүн нэг бүрд тавих хяналтын механизмыг оновчтой хэрэглэх, цаашид гарах хүндрэл болон уг ялыг эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийн зөрчил ямар үзүүлэлттэй байгаа хүний эрхийн, ямар төрлийн зөрчил илүү байгааг судалснаар хуульд өөрчлөлт оруулах санал гаргах, хууль тогтоомжийг хэрэглэх журамд өөрчлөлт оруулах зэргээр онолын болон практикийн хэрэглээг судалж дүгнэж ажиллахыг зорилго болголоо. Ингэснээр хүний эрхийн аливаа зөрчлийг гаргахгүй байхад анхаарах юм. Зорчих эрхийг хязгаарлах ялын давуу болон сөрөг талыг судалж тогтоосноор ялын бодлого, ялын үр нөлөө, нийгэмд үзүүлэх эерэг талыг гаргаж ирэхийг зорив.

Илтгэл бичихдээ бодит нөхцөл байдалд зорчих эрхийг хязгаарлах ялын өнөөгийн байдлын тоон мэдээлэл¹, ял эдэлж байгаа хүмүүсээс авсан судалгаа², өөр төрлийн ял шийтгэлтэй харьцуулсан байдлаар ялын талаарх эерэг, сөрөг талууд, ололт амжилтыг тодорхойлох, үр нөлөөг нэмэгдүүлэх, бусдад туршлагаа түгээх, судалгаа шинжилгээний ажилд хувь нэмэр оруулах зорилго агуулан бичиж толилуулж байна.

Түлхүүр үгс:

Хүний эрх, эрүүгийн хариуцлага, ял шийтгэлийн зорилго, хорих ял, хорихоос өөр төрлийн ял, зорчих эрхийг хязгаарлах ял.

Удиртгал

Дэлхий нийтийн эрүүгийн ялын бодлого нь хувьсан өөрчлөгдөж, хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэхийг зорих болсон ба дэлхийн зарим улс орнууд хэрэглээд 40 гаруй жилийн түүхийг туулсан байх бөгөөд одоогоор 40 гаруй улс орон эрүүгийн хуульдаа тусган хэрэгжүүлж байна. Судалгаанаас харахад Дэлхийн улс орнуудад хорихоос өөр төрлийн ял болох зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлэгчдийн тоо өсөн нэмэгдэж байна³.

Манай улсын хувьд зорчих эрхийг хязгаарлах ял нь 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд шинээр нэмэгдсэн ялын төрөл бөгөөд 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн⁴.

¹ Дорнод аймгийн Прокурорын газрын эрүүгийн нөхцөл байдлын судалгаа, 2021, 2022, 2023 онууд

² Илтгэл бичих хүрээнд авсан түүвэр судалгаа

³ Нээлттэй нийгэм форум, Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам, харьцуулсан судалгааны тайлан

⁴ Нээлттэй нийгэм форум, Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам, харьцуулсан судалгааны тайлан

Монгол улсын Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлд Зорчих эрхийг хязгаарлах ялын талаар хуульчлахдаа Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ⁵ гэж хуульчлан заасан байдаг.

Ялын бодлого бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хүрээнд ялын оновчтой төрөл, хэлбэрийг хуульчлан тогтоож, сонгон хэрэглэх тухай үзэл баримтлал юм.

Тэгэхээр манай улсын хууль тогтоомжид шинээр тусган орж ирсэн зорчих эрхийг хязгаарлах ял нь ялын бодлого, тогтолцоонд зарчмын шинжтэй хэд хэдэн өөрчлөлтийг оруулсан гэж үзнэ.

-Ялын бодлогыг зөөлрүүлэх, олон сонголттой, уян хатан болгох, хорих ялыг эцсийн арга хэмжээ болгон оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг түлхүү оногдуулах зэргээр нийгэм, хамт олон, гэр бүлийн дунд нийгэмшүүлэх,

-Олон улсын туршлага, зөвлөмж, хөгжингүй зарим улс орны эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг судалсны үр дүнд зорчих эрхийг хязгаарлах ялын шинэ төрөл нэмсэн. Ингэснээр хорих ял оногдуулах байдлыг багасгаж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр нийгэм хамт олон, гэр бүлийн дунд нийгэмшүүлэх боломж бүрдэнэ гэж үзсэн.

Практик дээр ч энэ үзэл баримтлал, ял эдэлж буй хүний нийгмийн харилцаа, орчны байдлыг өөрчлөхгүйгээр нийгэмшүүлэх нь үр дүнгээ өгч энэ төрлийн ял оногдуулах байдал шүүхийн тогтоолоор өсөн нэмэгдэж байна⁶.

Манай улсын ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдлаас харахад хорих ял эдлээд суллагдсан этгээд дахин гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй байгаа ба энэ нь хорих байгууллагаас суллагдсаны дараа нийгэмшүүлэх ажлын тогтолцоо байхгүй, хууль сахиулах байгууллагуудын хүлээсэн чиг үүрэг тодорхой бус, хорихоос өөр төрлийн ял хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоогүй байгаатай холбоотой байсан бол зорчих эрхийг хязгаарлах ялыг хуульчлан хэрэгжүүлснээр гэмт хэргийн гаралт харьцангуй буурах хандлагатай болсон⁷.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь манай улсад шинэ төрлийн ял бөгөөд практикт хэрэгжүүлсэн цаг хугацаанаас хойших хүний эрхийг хангах, хамгаалахтай холбоотой үүсэж буй дэвшилтэт болон сөрөг талыг судлан илүү сайжруулах, ялын бодлогын нийгэмшүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэхэд орших, түүнчлэн Дорнод аймагт энэ төрлийн ял эдэлж буй ялтны тоо бусад аймгуудаас их байдаг тул цаашдын үйл ажиллагаанд хэрэг болгох зорилгоор энэ сэдвийг сонгон бичих шалтгаан болов.

⁵ Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

⁶ Дорнод аймгийн Прокурорын газрын эрүүгийн нөхцөл байдлын судалгаа, 2021,2022,2023 онууд

⁷ Дорнод аймгийн Прокурорын газрын эрүүгийн нөхцөл байдлын судалгаа, 2021,2022,2023 онууд

Үндсэн хэсэг:**1.Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлснээс хойшх өнөөгийн байдал (Дорнод аймагт):**

Энэхүү судалгааг гаргахдаа тоон мэдээллийн аргыг ашиглан хийв.Дорнод аймаг нь Монгол Улсын зүүн хязгаарт орших бөгөөд БНХАУ, ОХУ-тай хиллэдэг, 84,000 гаруй хүн амтай, аймгийн төв Чойбалсан хотод 54,000 хүн оршин суудаг, 14 сумтай, уул уурхай, нефть олборлолт, агаарын болон төмөр замтай манай улсын томоохон аймгийн нэг юм. Тиймээс гэмт хэргийн гаралтаар нэлээд өндөр үзүүлэлттэй гардаг аймаг юм.

Хүснэгт 1. Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэж эхэлсэн цагаас хойш энэ төрлийн ялын тоон мэдээллийг сонирхуулахад:

№	Утга	2021	2022	2023
1	Нийт ял шийтгүүлсэн хүний тоо	466	453	455
2	Үүнээс Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн хүний тоо	64	113	132
3	Үүнээс эрэгтэй	63	108	110
4	Эмэгтэй	1	5	22
5	Насны байдлаар ангилбал 18-25 нас	10	13	18
6	26-35	30	46	54
7	36-46	13	33	32
8	47-оос дээш	11	21	24
9	Нас барсан үндэслэлээр ШГА дуусгавар болсон	1	-	1
10	Дахин гэмт хэрэг үйлдсэн	1	6	5
11	Ял солиулсан	12	13	17
12	ШГА-г түдгэлзүүлсэн	-	1	1

2021 онд нийт ял шийтгүүлсэн хүний 13.7 хувь нь зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлж байсан бол, 2022 онд 24.9 хувь, 2023 онд 29 хувь болж өссөн үзүүлэлтэй байгаа нь энэ төрлийн ялыг оногдуулах нь хууль хэрэглээнд өсөх хандлагатай, ял эдлэхэд илүү таатай, нийгэмд илүү үр дүнтэй гэдэг талаас нь үнэлж байгаа байх гэж үзсэн. Шинэ төрлийн ялын бодлого нийгэм цаг үетэй нийцсэн, энэрэнгүй, шударга ёсонд тохирсон гэдгийг хэдийн хүлээн зөвшөөрчээ.

2.Хорих ял эдэлсэн болон зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн этгээдийн дахин гэмт хэрэг үйлдсэн байдлын харьцуулсан судалгаа:

Дорнод аймгийн хэмжээнд ял эдэлсэн хүмүүсийн судалгааны тоон мэдээллийг үндэслэн харьцуулсан дүгнэлт хийв.

Хүснэгт № 02.

№	Он	Ялын төрөл	Гэмт хэрэг үйлдсэн хүн	Дахин гэмт хэрэг үйлдсэн хүн	тайлбар
1	2021	Хорих ял	114	10	8.7 хувь
2	2021	Зорчих эрхийг хязгаарлах ял	64	8	12.5 хувь
3	2022	Хорих ял	85	11	12.9 хувь
4	2022	Зорчих эрхийг хязгаарлах ял	113	6	5.3 хувь
5	2023	Хорих ял	76	9	11.8 хувь
6	2023	Зорчих эрхийг хязгаарлах ял	132	5	3.7 хувь

Энэ харьцуулсан судалгааны үр дүнд хорих ял эдэлсэн хүн дахин гэмт хэрэг үйлдэх явдал 8.7-12.9 хувь байгаа бол, зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хүний дахин гэмт хэрэг үйлдэх нь 3.7-12.5 хувь байгаа нь зорчих эрхийг хязгаарлах ялын үр өгөөж нийгмээс тусгаарлахгүй ял эдлүүлэх нь хүний сэтгэл зүй, нийгэмших үйл явцад ямар нэгэн сөрөг үр дагавар бага үүсгэдэг байх талтай гэж судалгааны үр дүнгээр харагдаж байна. Цаашид энэ талаар нарийвчлан өргөн цар хүрээтэй судалж ялын бодлого, хууль зүйн практикт илүү тусгах нь нийгэмд ач холбогдолтой байна.

3. Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж байгаа болон ялаа эдэлж дууссан хүмүүсийн ял эдлэхэд тулгамдсан асуудал, сэтгэл ханамжийн судалгаа, хүний эрхийн зөрчлийн талаар:

Энэхүү судалгааг авахдаа дараах асуултаар асуумжийн арга зүйг ашиглан биечлэн судалгаа хийсэн. Судалгааг бүдүүвчээр үзүүлбэл:

График 1. Нас




График 2. Хүйс




График 3. Боловсролын түвшин




График 4. Мэргэжил






График 5. Хөдөлмөр эрхлэлт




Үндсэн мэдээлэл

График 6. Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлж байсан эсэх, эсхүл одоо ял эдэлж байгаа эсэх




Судалгаанд хамрагдсан 35 хүний 3 нь ял эдэлж дууссан, 32 нь одоо ял эдэлж байгаа болно.

График 7. Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацаа, эдлэх хугацаа




Судалгаанд хамрагдсан хүний зорчих эрхийг хязгаарлах ялын хугацаа 7 сараас 2 жил хүртэл оногдуулсан байдал 54.3 хувь байна.

График 8. Уг ялыг эдлэхэд хүндрэлтэй байсан эсэх




Зорчих эрхийг хязгаарлах ялыг эдлэхэд бусад төрлийн ялаас ялгаатай, хүндрэлтэй эсэх судалгаанд 35 хүнээс 31 хүн нь хүндрэлгүй гэж үзсэн нь ял шийтгэлийн төрлөөс энэ төрлийн ял эдлэх нь хүний эрхийн зөрчил бага, хувь хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр эрүүгийн хариуцлага оногдуулан нийгэмшүүлж байгаа нь эерэг байна гэж дүгнэхээр байна.

График 9. Танд ял эдлэхэд ямар хүндрэл бэрхшээл тулгарсан бэ, хүний эрхийн ямар зөрчил байсан бэ?



Ял эдлэхэд хүндрэл бэрхшээл байгаагүй гэж судалгаанд хамрагдсан 35 хүний 88.6 хувь нь хариулсан бол ямар төрлийн хүний эрхийн зөрчил байсан бэ гэх асуултад 74.3 хувь нь хүндрэл бэрхшээл байгаагүй гэж хариулжээ. Бусад хүндрэл бэрхшээл, хүний эрхийн зөрчил, тулгамдаж буй асуудалд харьцангуй хувь хүнээс өөрөөс нь шалтгаалах хүндрэл тохиолдож байсан гэж дүгнэхээр байна.

График 10. Хорих ял эдлэх, зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх хоёрын аль нь дээр гэж үзэж байна вэ?



Судалгаанд хамрагдсан хүнээс 1 хүн хорих ялыг эдлэх нь дээр гэж хариулсан хариулт нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.5, 6.7 дугаар зүйлийг хэрэглэн хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх заалт хэрэгжүүлэх гэж үзсэн.

График 11. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх явцдаа хөдөлмөр эрхлэх, суралцах, орлого олох боломжтой байсан эсэх





График 12. Зорчих эрхийг хязгаарлах явцад бусад иргэдээс хандах хандлага ямар байсан бэ?



Дээрх судалгаанаас харахад Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах шүүхийн практик харьцангуй нэмэгдсэн мөн эмэгтэйчүүд ч зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлэх явдал нэмэгдсэн ба энэ нь гэр бүл болон нийгэм, хөдөлмөр эрхлэлтийн орчноос холдохгүй, эцэг, эхээ асарч, үр хүүхдээ харж хандаж, өсгөж хүмүүжүүлэх явцдаа ял эдлэх явдал нь эмэгтэйчүүдэд хүндрэл багатай давуу байна.

Гэхдээ судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувьд ял шийтгэл эдэлж байгаадаа сэтгэл тавгүй байдаг болохыг судалгаанаас харж болж байна. Мөн судалгаанд хамрагдсан хүмүүсийн 2.8 хувь нь хорих ял эдлэхийг илүү дээр гэж үзсэн нь Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 6.7 дугаар зүйл, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн ялыг хугацаанаас нь өмнө хөнгөрүүлэх, чөлөөлөх албадлагын арга хэмжээ хэрэглэх боломжгүй байдаг тул хорих ялын энэ төрлийн хөнгөрүүлэх боломжийг илүүд үзсэн байна.

Үүнээс харахад Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг шүүхийн практикт хэрэглэх тохиолдол байхгүй байгаатай холбоотой. Уг хуулийн зохицуулалтыг хэрэглэх журам, тайлбар шаардлагатай байна гэж үзэж байна.

Хорихоос өөр төрлийн ял шийтгэлийн дотроос зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах нь илүү түгээмэл байгаа энэ нөхцөлд ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт, техникийн болон хүний нөөцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага нэн адил тавигдах хэрэгтэй. Учир нь зорчих эрхийг хязгаарлах ял эдлэхэд техникийн болон биечилсэн хяналт тавьж ажилладаг тул нэг шийдвэр гүйцэтгэгчид ногдох ялтны тоо норматив хэмжээнээс хэд дахин илүү ачаалалтай ажиллаж байгаа нь ялтан бүрт хүрч хяналт тавих боломж хязгаарлагдмал болж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахад хүндрэл учрахаар байгаа нь анхаарах асуудлын нэг юм⁸.

Тухайлбал Дорнод аймаг 2022 оны эхний хагас жилийн судалгаагаар нормативаас 5 дахин их гэсэн үзүүлэлттэй гарсан байна.

Дүгнэлт

Манай улсын хувьд зорчих эрхийг хязгаарлах ял нь шинэ төрлийн ял бөгөөд Эрүүгийн хууль (шинэчлэн найруулсан) 2021 оноос хэрэгжиж эхэлснээс хойш өнөөг хүртэл энэ төрлийн ялыг практикт хэрэглэх явдал ялын бодлогын хувьд ямар нэгэн хүндрэл, эргэлзээгүй, хялбар байна.

Зөвхөн 35 хүнээс авсан судалгааны дүнгээс харахад зорчих эрхийг хязгаарлах ялыг эдэлж буй насны хязгаар нь хөдөлмөрийн насны хүмүүс байх (18-47 насны) тул тэдгээр хүмүүсийн ажиллах хүч нь улс оронд хэрэгтэй хөдөлмөрөөс холтгохгүй уг ялыг эдэлж байгаа нь нэг талдаа тун сайшаалтай гэж үзэж байна.

Хорих ялыг эдлэхэд төрөөс нэг хоригдолд ногдох өдрийн дундаж зардал 7231 төгрөг, жилд 2639315 төгрөг (2022 оны байдлаар) гардаг. Гэтэл зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд нэг хоногт ногдох өдрийн дундаж зардал 1305 төгрөг, жилд 476325 төгрөг бөгөөд хорих ял эдлүүлэх зардлаас 81,9 хувиар бага байна. Түүнчлэн зорчих эрхийг хязгаарлах ялын техник, датаны зардлыг ял эдэлж буй хүнээс гаргуулан эргэн төлүүлж байгаа нь зардал улам багасах боломжийг бүрдүүлж байна. Дээрх байдлаас харахад хорих ялын хувьд улсын эдийн засагт алдагдалтай, татвар төлөгчдийн мөнгийг үр ашиггүй зарцуулах нэг шалтгаан болж буй бөгөөд гэмт хэргийн төрөл, нийгмийн аюулын шинж чанар, шүүгдэгчийн хувийн байдал, гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөл зэргийг харгалзан шүүхээс аль болох зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах сонголтыг зөв хэрэглэх, Эрүүгийн хуульд заасан зүйлчлэлийг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн хүмүүсийн боловсролын байдал дийлэнх нь бага, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй байгаа нь гэмт хэрэг үйлдэх шалтгаан нөхцөлийн нэг тул энэ талаар төрийн бодлогыг чиглүүлж, гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, уг арга хэмжээний зардлыг оновчтой, хуваарилж, бодит өгөөжтэй байдлаар сайжруулах шаардлагатай гэж харж байна.

⁸ Нээлттэй нийгэм форум, Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам, харьцуулсан судалгааны тайлан

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 88.5 хувь нь Зорчих эрхийг хязгаарлах ялыг эдлэхэд хүндрэл байхгүй гэж дурдсан байгаа нь нэг талдаа өмнөх нийгмийн амьдралаа үргэлжлүүлэх боломж нь хэвээр байдаг, гэр бүл, хамт олонтойгоо байгаа нь ял эдэлж байна гэдэг айдас бага төрүүлдэг, улмаар амьдралын чанарт төдийлөн хүндээр нөлөөлөхгүй байдал нь хүмүүст хүндрэл бага байх шалтгаан болсон болов уу гэж дүгнэж байна.

Энэ талаар цаашид улсын хэмжээнд нарийвчлан судалгаа хийж үр нөлөөг судлах шаардлагатай гэж үзсэн.

Тухайн ялыг эдлэхдээ гар болон хөлд цахим бугуйвч зүүж байгаа нь “гэмт хэрэг үйлдсэн этгээд, ял эдэлж байна” гэж төдийлөн нийгэмд танигдаагүй байгаагаас гадна энэ төрлийн ижил төхөөрөмж зах зээлд байдаг тул ойролцоо харагдаж сэжиг төрүүлэхгүй байгаа нь бусад иргэдээс хандах хандлагад өөрчлөлт орохгүй хэвийн байдагтай холбоотой гэж дүгнэлээ.

Эцэст нь эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын хүрээнд гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ял нь хүнлэг энэрэнгүй, улсын эдийн засагт хохирол багатай, эргээд гэмт хэргийн гаралтыг бууруулахад аль болох нийгмээс тусгаарлахгүй оногдуулж буй ялын үр өгөөж учраас зорчих эрхийг хязгаарлах ялыг улам боловсронгуй болгож практикт зөвөөр хэрэглэх нь туйлын чухал асуудлын нэг болох талтай тул судалгаа шинжилгээ хийж, засаж залруулж илүү сайжруулж явах нь чухал ач холбогдолтой юм.

Хүнлэг энэрэнгүй, ардчилсан нийгмийг цогцлоох эрхэм зорилгын хүрээнд нийцсэн зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэсэн практик нь зөв зүйтэй шийдэл болж байна гэж дүгнэсэн болно.

Санал

1. Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг шүүхийн болон шийдвэр гүйцэтгэлийн практикт хэрэглэх явдал тохиолдол байхгүй байгаатай холбоотой. Уг хуулийн зохицуулалтыг хэрэглэх журам, тайлбар шаардлагатай байна гэж үзэж байна.

2. Мөн хуулийн 6.7 дугаар зүйлийн үндсэн зохицуулалтыг 5.5 дугаар зүйлтэй уялдуулан нэг мөр болгох шаардлагатай гэж санал оруулж байна.

3. Хорихоос өөр төрлийн ял шийтгэлийн дотроос зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах нь илүү түгээмэл байгаа энэ нөхцөлд ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт, техникийн болон хүний нөөцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага нэн адил тавигдах хэрэгтэй. Техник төхөөрөмж нь чанартай, цэнэгээ удаан хугацаанд хадгалдаг, ялтны бие, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй “GPS”-н байршил хөдөлгөөнийг оновчтой заадаг, мөн нөөц бүрдүүлэх, техникээс шалтгаалсан зөрчлөөс шалтгаалж ял солиулахгүй байх, ялтны эрхийг зөрчихгүй байх;

4. Цаашид нийгмээс тусгаарлахгүй зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулах эрүүгийн хуулийн зүйл заалтыг нэмэгдүүлэх;

5. Зорчих эрхийг хязгаарлах ялаа эдлэх хугацаандаа ажил хөдөлмөр эрхлээгүй үед хөдөлмөрийн дадал олгох мэргэжлийн чиг баримжаа олгох болон эрх зүйн боловсрол олгох нийгэмшүүлэх, сургалтад хамруулах;

6. Цахим төхөөрөмжийн эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд орон нутагт засварлах боломжгүй, интернэтийн хүчин чадал, ачааллаас болж систем гацдаг байдал гаргахгүй байх, хөдөө орон нутагт сүлжээний хамрах хүрээний тархалт зэргийг нэмэгдүүлэх;

7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж бодит үр дүнд хүргэх талаар анхаарч, засаж сайжруулах;

8. Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлж буй талаар дэлгэрэнгүй нэгдсэн судалгаа хийх.

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж:

1. Монгол улсын Үндсэн хууль, 1992 он
2. Эрүүгийн хууль, 2015 он
3. Прокурорын тухай хууль, 2017 он
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль, 2017 он

Судалгааны тайлан, гарын авлага, хэвлэмэл материал:

5. Нээлттэй нийгэм форум, Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам, харьцуулсан судалгааны тайлан, 2022 он
6. Улсын Ерөнхий Прокурорын газрын зөвлөмж, 2023.04.21, 06 тоот
7. Улсын Ерөнхий Прокурорын газрын мэдээлэл, 2023.05.03, 6/20 тоот
8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Д.Загджав, “Өнөөдөр” сонинд өгсөн ярилцлага,
9. Дорнод аймгийн Прокурорын газрын эрүүгийн нөхцөл байдлын судалгаанаас, 2021,2022,2023

Хавсралт:**СУДАЛГААНЫ АСУУМЖ**

Таны амгаланг эрье. Энэхүү судалгаа нь Таны нэр хүнд, ял эдлэхэд цаашид ямар нэгэн байдлаар саад болохгүй бөгөөд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зориулан ашиглагдах болно.

Ерөнхий мэдээлэл: анхааруулга \ нөхөх болон сонгох байдлаар бөглөх\

1. Таны нас

A. 18-25, B. 26-35, B. 36-46, Г. 47-с дээш

2. Таны хүйс

A. Эрэгтэй B. Эмэгтэй

3. Таны боловсрол

A. Дээд, B. Тусгай дунд, B. бүрэн дунд, Г. бүрэн бус дунд,
Д. бага, E. боловсролгүй

4. Таны мэргэжил..... нөхөж бичих

5. Таны хөдөлмөр эрхлэлт

A. Хувийн секторт ажилладаг B. Төрийн байгууллагад
ажилладаг

B. хувиараа хөдөлмөр эрхэлдэг Г. Малчин Д. Ажилгүй

Үндсэн мэдээлэл:

6. Та зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн эсэх (өмнө нь)

A. тийм, B. үгүй

7. Таны зорчих эрхийг хязгаарлах ялыг эдэлсэн хугацаа

A. 1-6 сар

B. 7 сараас дээш -2 жил хүртэл

B. 2 жилээс дээш 5 жил хүртэл

8. Уг ялыг эдлэхэд танд хүндрэлтэй байсан эсэх

A. Тийм B. үгүй

9. Танд ямар бэрхшээл хүндрэл байсан бэ, хүний эрхийн ямар зөрчил танд тулгарсан бэ

.....
.....

10. Хорих ял эдлэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг эдлэхийн аль нь илүү дээр гэж үзэж байна.

А. хорих ял

Б. зорчих эрхийг хязгаарлах ял

11. Зорчих эрхийг хязгаарласан ял эдлэх явцдаа хөдөлмөр эрхлэх, суралцах, орлого олох боломж байсан эсэх

А. тийм

Б. үгүй

12. Зорчих эрхийг хязгаарлах ялыг эдлэх явцад бусад иргэдээс танд хандах хандлага ямар байсан бэ

А. бусад хүмүүс мэдээгүй хэвийн байсан

Б. ялгаатай хандаж гадуурхагдаж байсан

В. хэцүү байсан

Г. Бусад

Судалгаанд хамрагдсан Танд баярлалаа. Амжилт хүсье.

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

Хан-Уул дүүргийн Прокурорын газрын ахлах прокурор С.Солонго

Хураангуй:

Монгол Улсад 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулж эхэлснээс хойш иргэд, олон нийтийн зүгээс ял эдлүүлэх ажиллагааны практикт тухайн ялтныг хянахад ашиглаж буй техникийн шийдэл хангалтгүй, хүрэлцээ муу, улс орныг бүхэлд нь хамарсан хяналтын тогтолцоо сул, ялтны эрх зүйн байдал хангалтгүй зэрэг үзэл, хандлага нэлээд байна.

Иймд ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокуророор ажиллаж байгаагийн хувьд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд гарч буй хүндрэл, бэрхшээл, хяналтын ажлын үр нөлөөг сайжруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүний эрхийг хангах зарим асуудлыг шийдвэрлэх арга замын талаар илтгэл хэлэлцүүлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: Зорчих эрхийг хязгаарлах ял, прокурор, хүний эрх.

Удиртгал

Дэлхийн ихэнх улс орны эрх зүйн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд хорих ялыг зөвхөн хохирогчийн аюулгүй байдалд заналхийлсэн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зэрэг цөөн тохиолдолд хэрэглэх учиртай гэсэн үзэл баримтлал, зарчим давамгайлж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45/110 дугаар тогтоолоор “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм)¹-ийг 7 бүлэг 23 зүйлтэйгээр батлан гаргасан нь хорих ялаас татгалзах, хорихоос бусад төрлийн ял шийтгэлийг өргөн хэрэглэх нөхцөлийг зарчмын хувьд бүрдүүлсэн чухал зохицуулалт болсон.

Токиогийн дүрмийн гол зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг төрийн эрх бүхий байгууллагын хяналтад авах замаар хүмүүжүүлэх, нийгмийн хэвийн амьдралдаа эргэж ороход нь туслах, хорих ялаас татгалзах, ялын нөлөөг цээрлүүлэхээс илүү гэмт хэрэг дахин үйлдэж давтан гэмт хэрэгтэн болохоос сэргийлэхэд чиглэсэн байна.

Монгол Улсын хувьд энэхүү жишиг дүрэмд нэгдсэн бөгөөд Монгол Улсын Олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх учиртай тул манай улс хорихоос өөр төрлийн ял хэрэглэх эрх зүйн орчноо дүрэмд нийцүүлэн сайжруулах шаардлагатай юм².

¹ НҮБ-ын Ерөнхий Ассамблей. “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм). 1990

² Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхэтгэл. УБ., 2012, 159 дэх тал.

Манай улсын хувьд хорих ялаас татгалзах, үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний онцлог байдалд тохирсон ял оногдуулах замаар ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 2015 оны Эрүүгийн хуульд шинэ төрлийн ял болох зорчих эрхийг хязгаарлах ял нэмж, 240 төрлийн гэмт хэрэгт оногдуулж, хэрэгжилтийг нь цахим хэлбэрээр хянах нөхцөл бүрдүүлсэн.

Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжсэнээр Үндсэн хуулиар тунхагласан, ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрхийг дээдлэх тулгуур зарчимд нийцүүлэх, гэмт этгээд ажиллаж хөдөлмөрлөн, гэр бүл, үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэх, учруулсан хохирлоо нөхөн төлөх, хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлыг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой.

Өнөөдрийн байдлаар хоригдолд ногдох өдрийн дундаж зардал 7231 төгрөг буюу жилд 2.639.619 төгрөг байна. Харин зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд ногдох өдрийн дундаж зардал 3313 төгрөг буюу жилд 1.209.173 төгрөг байгаа нь хорих ял эдлүүлэх зардлаас даруй 54.1 хувиар бага байна.³

Үндсэн хэсэг

“Зорчих эрхийг хязгаарлах” гэсэн нэр томъёог судлан үзэхэд “зорчих” гэдэг нь хүн нэг зүгийг чиглэн зорчих, ийш тийш зорчин явах, “эрхийг хязгаарлах” гэдэг нь эрхийг нь багасгах, хэмжээ тогтоох гэсэн утга илэрхийлж байгаагаас дүгнэвэл хүний чөлөөтэй зорчих хөдөлгөөнийг хязгаарлах гэж үзэж болно. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 18 дахь хэсэгт заасан “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих” гэсэн иргэний эрхэд хязгаарлалт тогтоож байгаа нь уг ялын онцлог юм.

Гадаадын зарим оронд “цахим хяналт”, “хөлийн гав”, “радио долгионы төхөөрөмж”, “газар зүйн байршил тодорхойлогч”, “гэрийн хорио” зэрэг нэр томъёо хэрэглэгдэж байгаагаас манай улсын хувьд “зорчих эрхийг хязгаарлах ял” гэж томъёолсон.

Энэхүү ялыг дэлхийн 40 гаруй оронд хэрэглэдэг. Их Британи, Умард Ирландын нэгдсэн Вант улс, Швед, Нидерланд, Норвеги гэх мэт Европын холбооны улсууд 3-12 сарын хугацаатай, БНСУ, Турк гэх мэт Азийн орнууд 3 сараас 30 жилийн хугацаагаар ялыг оногдуулж, хяналт тавьдаг. Өнөөдөр дэлхийн 30 гаруй оронд цахим бугуйвч хэрэглэгдэж байна.

Ялын үндсэн үзэл санаа нь ял шийтгүүлсэн этгээдийг гэрт нь буюу байнга амьдрах газарт нь хорих хэлбэрээр хэрэгждэг. Гэхдээ ялтан цахим гав буюу цахим хяналтын төхөөрөмж бүхий дохио дамжуулах, гаднын нөлөөлөлд тэсвэртэй, зориулалтын бусаар тайлах, суллах боломжгүй төхөөрөмж зүүх үүрэг хүлээн, урьдчилан тогтоосон зам, цагийн хүрээнд ажил, гэр, сургуульдаа явах боломжтой.

Зорчих эрхийг хязгаарлах ялын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр зүй зохистой, зөв амьдралд ороход нь тусалцаа үзүүлэх, гэмт хэрэг

³ Хууль зүй, дотоод хэргийн яам. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд шаардагдах зардлын тооцоо. УБ., 2020, 17 дахь тал.

үйлдсэн хүнийг гэмт хэрэг дахин үйлдэх зан үйлээс нь татгалзуулах, урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хохирогч, бусад хүнийг хамгаалахад оршиж байна.

Монгол улсын Эрүүгийн хуулиар ялын төрөл хэлбэр, зорилгыг тодорхойлсон боловч хэрэгжих механизмыг эрх зүйн хүрээнд бүрэн хангаж чадаагүй, бэлтгэл хангах шаардлагатай байсан тул хэрэгжилтийг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хойшлуулсан.

Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг 240 буюу хөнгөн 121, хүнд 119 гэмт хэрэгт ногдуулахаар тогтоожээ. Мөн зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хорих ялын аль нэгийг сонгож хэрэглэхээр хүнд гэмт хэргийн 119, хөнгөн гэмт хэргийн 57 заалт буюу “хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, “хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”, “өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”, “олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг”, “авлига, албан тушаалын гэмт хэрэг”, “хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг”-т түлхүү ногдуулахаар хуульчилсан байна.

Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлд зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт, түүнийг оногдуулах үндэслэл, уг ялыг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалт тусгасан.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг зохицуулахтай холбоотойгоор Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 7 тогтоол, дүрэм, журам баталсан байна.

- Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 94 дүгээр тогтоолоор батлагдсан “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам”,

- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн А-234/А/103 дугаар тушаалаар батлагдсан “Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”,

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/246 дугаар тушаалаар батлагдсан “Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих тоног төхөөрөмж ашиглах журам”,

- ШШГЕГ-ын даргын 2017 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А/165 дугаар тушаалаар батлагдсан “Хоригдол, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд шагналын хоног олгох, хоригдлыг ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх болон хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох тухай санал гаргах чиг үүрэг бүхий зөвлөлийн дүрэм,

- ШШГЕГ-ын даргын 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/85 дугаар тушаалаар батлагдсан “Цахим хяналт, удирдлагын төвийн ажиллах журам”,

- Цахим хяналт, удирдлагын төвийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, түүнд тавих хяналт, төвийн тоног төхөөрөмж, түүний ашиглалттай холбоотой харилцаа,

- ШГЕГ-ын даргын 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/47 дугаар тушаалаар батлагдсан “Зорчих эрхийг хязгаарлах ялын маягт”,

- ШШГЕГ-ын даргын 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А/91 дугаар тушаалаар батлагдсан “Эрүү, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хяналтын хувийн хэргийг хянан шийдвэрлэх, нэгдсэн бүртгэл хөтлөх үйл ажиллагааны журам” байна.

Дээрх тушаал, шийдвэр нь эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн өдөр тутмын үйл ажиллагаа буюу байгууллагын тайлан мэдээ, судалгаа хөтлөх, зардлыг тооцохтой холбоотой харилцааг зохицуулсан ба ялтны ял эдлэх нөхцөл, журмыг нарийвчлан зохицуулаагүй гэж үзэхээр байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой асуудлыг судлан үзэхэд ялтны хүлээх үүргийн талаар дэлгэрэнгүй тусгаснаас бус эдлэх эрхийг нь орхигдуулсан гэж үзэж болохоор байгаа.

Тухайлбал:

1. Хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт “Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн шийдвэрийг гүйцэтгэх нөхцөл, тоног төхөөрөмжийг тогтооно” гэж заасан нь ялтан гар, хөлийн бугуйвчийг өөрөө сонгох боломжийг хаасан,

2. Хуулийн 173 дугаар зүйлд “Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр өөрчлөхдөө прокурорын зөвшөөрснөөр ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтны зорчих эрхэд тогтоосон хориглолт, хязгаарлалтыг 30 хүртэл хоногийн хугацаанд өөрчилж болно” гэсэн нь ялтан гэнэт тохиолдсон (өвчилсөн, гэр бүлийн гишүүн нас барсан, байгалийн гамшиг, осол г.м.) асуудлаар ажлын бус өдөр, хэнд, хэрхэн хүсэлт гаргах нь тодорхой бус,

3. Хуулийн 175 дугаар зүйлийн 175.1 дэх хэсэгт “Ялтан ял эдлүүлэх журмыг зөрчөөгүй, өөрийн зан үйл, хувийн байдлаараа ял эдлүүлэх ажиллагаанд саад учруулаагүй бол түүнд 1 сард 5 хүртэл хоногийн шагналын хоног олгож болно” гэсэн нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлснийх нь төлөө урамшуулах байдалд хүргэж байна гэж үзэж байна.

Дүгнэлт

Зорчих эрхийг хязгаарлах ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр, хамт олон, гэр бүлийнхээ орчинд суралцах, хөдөлмөрлөх эрхийг нь ханган хэрэгжүүлж буйгаараа ихээхэн ач холбогдолтой байна. Ял эдлүүлэх энэхүү ажиллагаанд хянах-нийгэмшүүлэх ажлыг зөв хослуулж зохион байгуулснаар гэмт хэрэг дахин үйлдэх явдлыг бууруулахад чухал түлхэц болох юм.

Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг 240 төрлийн оногдуулахаар тогтоосон ба шүүхээс уг ялыг оногдуулсан тоо жил ирэх тусам өсөх магадлалтай байгаа тул цахим хяналтыг сайжруулах шаардлага тулгарч байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны хяналтад ашиглаж буй цахим бугуйвч, техникийн бусад хяналт шинжлэх ухаан, технологийн хөгжилтэй уялдан

үргэлж шинэчлэгдэж байгаа энэ үед цахим хяналтын төхөөрөмжийн шинэчлэлт, хүртээмжийг улс орныг бүхэлд нь хамарсан байдлаар зохион байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх нь зүйтэй байна.

Санал

1. Ялтны эдлэх эрхийн талаар тодорхой болгон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 171, 173, 175 зүйлд өөрчлөлт оруулах;

2. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны өдөр тутмын хяналтыг сайжруулахад биечилсэн хяналт хэрэгжүүлэх, алба хаагчийн орон тоо бий болгох, нэмэгдүүлэх;

3. Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж буй этгээдэд шагналын хоног олгох асуудлыг холбогдох хууль, журмаар нарийвчлан зохицуулж өгөх;

4. Ялтан оргосон тохиолдолд оршин суух хаягийг нь олж тогтоон, албадан ирүүлж ялыг хорих ялаар солих асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх хүртэлх хугацаанд саатуулах зохицуулалт бий болгох шаардлагатай байна гэж дүгнэлээ.

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга 2017 он
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

Ном, сурах бичиг:

5. Б.Алтангэрэл, М.Хүрэлбат. “Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ” судалгааны ажлын тайлан.
6. Нээлттэй Нийгэм Форум. “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт. 2022.
7. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45/110 дугаар тогтоолоор “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм).

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АРГА ЗАМ

Нийслэлийн Прокурорын газрын хяналтын прокурор Т.Амарзаяа

Хураангуй:

Зорчих эрхийг хязгаарлах ял нь 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд шинээр тусгагдаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн шинэ төрлийн ял юм. Иймд зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх, хяналт тавихад гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудлыг судалж, дүгнэлт хийх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, ялын үр нөлөөг дээшлүүлэх, хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх, хуульд ойлгомжгүй буюу оновчгүй хэрэглэсэн нэр томъёог тодорхой болгох, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхийг зорьсон.

Түлхүүр үгс: Эрүүгийн хариуцлага, шийтгэл, ял, зорчих эрхийг хязгаарлах ял.

Удиртгал

Монгол Улсын эрүүгийн хариуцлагын тогтолцоонд хорих ял дийлэнх хувийг эзэлдэг. Шүүхийн 2011, 2012 оны шүүн таслах ажиллагааны нэгдсэн мэдээгээр нийт оногдуулсан ялын 77 хувийг хорих ял эзэлж байсан, ял эдлээд суллагдсан хүмүүсийн 47 орчим хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн дүн гарсан, мөн хоригдолд ногдох өдрийн дундаж зардал 7231 төгрөг буюу жилд 2.639.619 төгрөг байна.

Энэ нь хорих ялын үр нөлөө бага, Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх зорилго төдийлөн хангагдахгүй байгаа, зардал өндөртэй ял болохыг харуулсан.

Зорчих эрх хязгаарлах ял оногдуулах тухай хуулийн заалтыг 2015 оны Эрүүгийн хуульд шинээр оруулж ирэх болсон үндэслэл, шаардлага хуулийн үзэл баримтлалыг судалж үзвэл: Хууль тогтоогчид хорих ял биечлэн эдлэх явдлыг багасгах чиглэлд анхаарч гэрийн хорионд байлгах ял гэсэн шинэлэг институтыг оруулснаар хорих ял биечлэн эдлэх явдлыг 20-30 хүртэл хувиар бууруулна гэж тооцоолон, ялын үр нөлөө дээшилнэ гэж үзсэн байна.

2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль батлагдахаас өмнөх 10 жилд дунджаар жилд 7300 орчим хүн хорих ял эдэлж байсан бол 2022 онд 6006 хоригдол ял эдэлсэн нь 1294 буюу 17.7 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь хорих ял биечлэн эдлэх явдлыг багасгах хуулийн үзэл баримтлал хангагдаж байна гэж дүгнэхээр байна.

Харин 2022 онд хорихоос өөр төрлийн ялаар 15480 ялтан шийтгүүлсэн нь өмнөх оноос 2249 буюу 16.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтны судалгаа

Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтан	2021 он	2022 он	Өссөн, буурсан хувь
Нийт ялтан, хуулийн этгээд	13231	15480	2249 буюу 16.9% өссөн

Үүнээс	Торгох	7828	9111	1283 буюу 16.3% өссөн
	Нийтэд тустай ажил	1656	1384	272 буюу 16.4% буурсан
	Зорчих эрх	1690	3079	1389 буюу 45.1% өссөн
	Эрх хасах	2057	1906	151 буюу 7.3% буурсан

Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн хүнд хорихоос өөр төрлийн ял, үүнээс зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах байдал өссөн цаашид ч өсөх хандлагатай байна.

Энэ хэрээр шинээр хэрэгжиж байгаа ялыг хэрэгжүүлэх, ялын биелэлтэд хяналт тавихад тулгарч байгаа хүндрэл бэрхшээлтэй зарим асуудлыг хууль, тогтоомжид бүрэн тусгаагүй, шүүгч, прокурор, шийдвэр гүйцэтгэгч нар нь хуулийн нэг мөр ойлголтгүй, хяналтын тоног, төхөөрөмжид тавигдах стандарт шаардлага хангалтгүй, сүлжээний тархцаас хамааран орон нутагт алслагдмал газарт оршин сууж байгаа хүнд дээрх төрлийн ялыг оногдуулах боломжгүй, оршин сууж байгаа газраасаа хамааран хорих ял эдлэх, гэр бүлээсээ тусдаа амьдрах нөхцөл бүрдэж байна.

Энэхүү илтгэлийн зорилго нь дээрх хүндрэл бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход дүгнэлт санал дэвшүүлэхэд оршино.

Үндсэн хэсэг

Нээлттэй нийгэм форумын дэмжлэгээр 2016 онд хийсэн “Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам” харьцуулсан судалгаа, 2022 онд Дотоод хэргийн их сургуулийн судлаачдын баг хийсэн “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт” судалгааны тайлан байна. Одоогоор докторын диссертацийн ажил гараагүй байна.

Прокурорын байгууллагаас дээрх шинэ төрлийн ялын хэрэгжилтийн талаар хийсэн зарим шалгалт, судалгааны дүнтэй танилцахад:

Өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдаж хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон байдлыг улсын хэмжээнд судалсан судалгаанд зарим шүүхээс хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн солихдоо Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлд зааснаар ялтны зорчих эрхийг хязгаарлах хориглолт, хязгаарлалтыг тогтоогоогүй шийдвэрлэсэн тохиолдлууд нэлээдгүй гарчээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тодорхой биш зүйлийг тодруулахаар прокурор шүүхэд дүгнэлт бичиж шийдвэрлүүлэн, хуулийн нэг мөр хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажилласан байна.

“Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хууль тогтоомжийг хэрэгжилт”-ийг 2021 оны 10 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд судалсан дүнтэй танилцахад зарим шүүхээс ялтны гэрийн хаяг зааж, тухайн хаягаас гарахыг хориглож шийдвэрлэсэн бол гадаад улсын иргэнийг Монгол Улсын хилээр гадагш зорчихыг хязгаарлаж шийдвэрлэжээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ... өөрийн оршин суух газраас явахыг хориглох... гэж заасан ба оршин суух газар гэх ойлголтыг бусад хуульд хэрхэн тодорхойлсныг авч үзвэл:

Иргэний хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно” гэж,

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана” гэж тус тус заасан байна.

Иргэний хууль болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу ялтны зорчих бүсийг тогтоолгохоор улсын яллагч шүүхэд санал тавьж шийдвэрлүүлж хэвших талаар прокурорын газруудад мэдээлэл, зөвлөмж хүргүүлсэн.

“Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг өөрчлөн тогтоосон прокурорын шийдвэрийн хууль зүйн үндэслэл”-ийг 2022 оны 8 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд судалсан байна.

Хүснэгт 2. Прокурорын газруудаас ялтны зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл журмыг өөрчлөн тогтоосон үндэслэлийг хуулийн зүйл, заалтын судалгаа

№	Нэгж прокурорын газар	Хяналтад авагдсан ялтны тоо	Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл журмыг өөрчлөн тогтоосон хуулийн зүйл, заалт						Бүс өөрчилсөн ялтны тоо	Давхардсан тоогоор бүс өөрчилсөн шийдвэрийн тоо
			174.1.1	174.1.2	174.1.3	174.1.4	174.1.5	174.1.6		
1	Баянгол	195	9	32	-	6	-	-	38	47
2	Баянзүрх	339	23	4	3	12	11	4	51	57
3	Сүхбаатар	143	7	14	-	4	2	5	26	32
4	Чингэлтэй	168	10	-	1	23	2	-	34	36
5	Хан-Уул	168	7	3	-	2	1	-	10	13
6	Сонгинохайрхан	355	13	2	1	5	-	1	19	22
7	Багануур	25	1	-	1	1	1	1	4	5
8	Налайх	42	7	-	-	2	-	1	10	10
9	Архангай	98	5	2	-	3	1	-	7	11
10	Баян-Өлгий	60	-	-	1	2	-	-	3	3
12	Баянхонгор	60	-	-	-	-	-	-	-	-
13	Булган	33	1	-	-	-	-	-	1	1
14	Говь-Алтай	28	-	-	-	-	-	-	-	-
15	Говь-Сүмбэр	14	-	-	-	-	-	-	-	-
16	Дархан-Уул	71	4	1	1	4	-	3	11	13
17	Дорноговь	60	2	-	4	-	-	-	6	6
18	Дорнод	82	2	4	-	-	1	-	7	7
19	Дундговь	21	-	-	-	-	-	-	-	-
20	Завхан	59	6	4	-	-	-	1	6	11
21	Орхон	117	6	1	-	-	-	1	7	8
22	Өвөрхангай	80	7	5	-	-	-	-	7	12
23	Өмнөговь	35	-	1	-	2	-	-	4	3 /тогтоолгүй 1/
24	Сэлэнгэ	63	4	1	1	1	1	-	6	8
25	Сүхбаатар аймаг	45	-	-	-	-	-	-	-	-
26	Төв	71	4	1	-	-	1	-	5	6
27	Увс	67	3	1	-	2	-	-	5	6

28	Ховд	35	-	-	-	-	-	-	-	-
29	Хөвсгөл	67	3	7	-	-	-	-	9	10
30	Хэнтий	130	7	2	-	3	-	1	9	13
Нийт		2731	131	85	13	72	21	18	285	340


Прокурор зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтны ял эдлүүлэх нөхцөл журмыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 174 дүгээр зүйлийн 174.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр өөрчлөхдөө 69 ялтны зорчих бүсийг шүүхээс тогтоосон хэмжээнээс өргөжүүлэн тогтоосноос 34 ялтан ялаа бүрэн эдэлж дууссан, ял эдлэхээс зайлсхийсэн үндэслэлээр 4 ялтны ялыг хорих ялаар сольж, 1 ялтан дахин гэмт хэрэг үйлдэж, ялыг хорих ялд нь нэмж нэгтгэн шийдвэрлэсэн дүн гарсан.

Судалгааны үр дүнд 30 ялтны ялтны зорчих бүсийг шүүхээс тогтоосон хэмжээнээс өргөжүүлэн тогтоосон прокурорын шийдвэрийг дээд шатны прокуророос хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 174 дүгээр зүйлийн 174.1 дэх хэсэгт “Дараах тохиолдолд прокурор ахлах шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн ялтны зорчих бүсийг өөрчилж болно:” гэж заасан бөгөөд энэ нь шүүхээс тогтоосон хэмжээгээр нутаг дэвсгэрийн байршлыг өөрчлөхөөр заасан бөгөөд прокурор ялтны зорчих бүсийг шинэчлэн тогтоох талаар хуульчлаагүй байна гэж дүгнэсэн.

“Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтан ял эдэлж байх хугацаандаа гэмт хэрэг, зөрчил үйлдсэн шалтгаан нөхцөл”-ийг 2021, 2022 оны байдлаар улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар судалсан дүнг нэгтгэсэн.

График 1. Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн ялтны тоо:



2021, 2022 онд хяналтад байх хугацаандаа гэмт хэрэг, зөрчил үйлдсэн 659 ялтнаас 360 ялтан буюу 54.6 хувь нь урьд өмнө 1-6 удаа ял шийтгүүлсэн байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан ял эдэлж байх хугацаандаа гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд шүүхээс тогтоосон зорчих чиглэл нөлөөлсөн байдлыг нэгж газруудаас ирүүлсэн судалгаанд үндэслэн нэгтгэхэд гэмт хэрэг үйлдсэн ялтнуудын дийлэнх буюу 56.4 хувийг, зөрчил үйлдсэн ялтнуудын 48.7 хувийг сум, дүүргийн нутаг дэвсгэрт зорчих үүрэг хүлээлгэж шийдвэрлэсэн байна.

График 2. Гэмт хэрэг үйлдсэн ялтанд тогтоосон зорчих бүс





График 3. Зөрчил үйлдсэн ялтанд тогтоосон зорчих бүс



Шүүхээс тогтоосон бүсээс гадна гэмт хэрэг үйлдсэн 21, зөрчил үйлдсэн 14 ялтан байна.

Үйлдэгдсэн гэмт хэргээс судалгаа хийх явцад 12 ялтанд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татагдсан, 10 хүнд холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн, 134 ялтанд холбогдох хэргийг шүүхээр шийдвэрлүүлсэн байна. Шүүх Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд зааснаар 111 ялтны зорчих эрхийг хязгаарлах ялаас эдлээгүй үлдсэн ялыг нэмж нэгтгэн ял оногдуулсан бол 23 ялтны ялыг тусад нь эдлүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд 83 хувьд нь хорих ял оногдуулсан байна.

Дээрх дүгнэлтүүдээс үндэслэн дараах саналуудыг дэвшүүлж байна:

1. Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд шагналын хоног олгох асуудлыг хорих ял эдэлж байгаа хоригдлоос тусад нь олгох журмын зохицуулалттай болох;

2. Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтан дахин гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шүүхээс хорих ял оногдуулахдаа тус тусад нь эдлүүлж болохоор заасан нь хорихоос өөр төрлийн ялын зорилго хангагдахгүй нөхцөл байдал үүсэхээр байх тул хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтан дахин гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ялыг хорих ялд нь нэмж нэгтгэж байх талаар хуульд санал боловсруулах;

3. Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болж, ялтанд цахим бугуйвч зүүсэн өдрөөс эхлэн тоолохоор хуульчилсан тул зөрчлийн тухай хуулиар баривчлах оногдуулсан, эрүүгийн хэрэгт цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан, хорих ялаар шийтгүүлсэн тохиолдолд техникийн

хяналтыг зогсоож, ял эдлүүлэх ажиллагааг түдгэлзүүлэх хуулийн зохицуулалттай болон зэрэг саналыг дэвшүүлж байна.

Ашигласан эх сурвалж

1. Э.Авирмэд, Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. 1997 он
2. Г.Совд, БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. 1973 он
3. 2015 оны Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал
4. Нээлттэй нийгэм форум. “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт” судалгааны тайлан
5. Прокурорын байгууллагаас 2022 онд улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар хийсэн шалгалт, судалгааны дүн
6. Прокурорын байгууллагын 2021, 2022 оны нэгдсэн мэдээ

ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХОРИХ ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛ БИЕЛҮҮЛЭХИЙГ ХОЙШЛУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Увс аймгийн Прокурорын газрын ахлах прокурор С.Нандинцэцэг

Хураангуй:

Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шүүхийн шийдвэрт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавьдаг. Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, засрал төлөвийг олоход нь туслах зорилготой ба шүүхээс өөрт нь болон асран хамгаалагчид үүрэг хүлээлгэдэг онцлогтой. Гэвч тухайн этгээд шүүхээс хүлээлгэсэн үүрэг биелүүлээгүй, тухайн хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд өмнөх хойшлуулсан тогтоолыг хүчингүй болгож, ял хүндрүүлэх сөрөг нөхцөл байдал бий болгодог.

Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах эрх зүйн зохицуулалтыг олон улсын гэрээ, хүүхдийн эрхийн конвенц болон НҮБ-аас хүүхдийн талаар гаргасан үндсэн зарчим, Хүүхдийн эрхийн тухай хуульд нийцүүлэхийн тулд өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж буй тохиолдолд дүн шинжилгээ хийх замаар цаашид боловсронгуй болгоход илтгэлийн зорилго оршино.

Түлхүүр үгс: Өсвөр насны хүн, хүүхэд, шүүхийн шийтгэх тогтоол, тогтоол тогтоол биелүүлэхийг хойшлуулах.

Удиртгал

Орчин үед улс орнууд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахаас зайлсхийх, ялын бус хариуцлага хүлээлгэх, ял оногдуулах шаардлагатай тохиолдолд хорихоос бусад төрлийн ял хэрэглэхэд анхаарал хандуулж улмаар холбогдох хууль тогтоомжууддаа өөрчлөлт оруулж байгаа нь эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн нэгэн жишээ билээ.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дүгээр хэсэгт “...Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална...”, НҮБ-ын 1989 оны Хүүхдийн эрхийн конвенцын 37 дугаар зүйлд “...хүүхдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхгүй байх, 18 насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах буюу суллах боломжгүйгээр бүх насаар нь хорих ял оногдуулахгүй байх, хүүхдийн эрх чөлөөг хууль бусаар буюу дур мэдэн хязгаарлаж болохгүй. Хүүхдийг баривчлах, саатуулах, хорих арга хэмжээг хамгийн богино тохиромжтой хугацаанд эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх талаар тус тус заасан.

Түүнчлэн НҮБ-ын 1985 онд баталсан Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрмийн 17.1 дүгээр зүйлд “Насанд хүрээгүй хүний эрх чөлөө хязгаарлах шийдвэрийн асуудлыг нарийвчлан, хянан хэлэлцсэний дараа энэ хязгаарлалтыг бололцооны хирээр хамгийн багаар тогтооно...17.1-ийн тайлбарын 4 дэх хэсэгт “Хорихоос өөр төрлийн ял хэрэглэх

боломжийг ямагт харгалзах...Насанд хүрээгүй хүний сайн сайхан байдал, ирээдүйг хангах сонирхол ямагт тодорхойлогч хүчин зүйл, харгалзах баримт болно..." гэж заажээ.

Монгол Улс эрх зүйн шинэтгэлийн хүрээнд өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хуульчилсан нь хэдий ч өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан арга хэмжээг хэрэгжүүлэх механизмыг хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулаагүй байна.

Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт зааснаар "Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байх"-аар заасан нь хүүхдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зорилгыг тодорхойлж байна. Энэ зорилго өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоонд хэрэгжихгүй байна.

Тиймээс өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байгааг харгалзан энэхүү сэдвийг сонгон авсан.

Үндсэн хэсэг

Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах тухай ойлголт нь эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ гэсэн нэр томъёотой салшгүй холбоотой. Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ гэсэн нэр томъёо нь Эрүүгийн хуульд 1993 оны 06 дугаар сарын 07-ны нэмэлт өөрчлөлтөөр анх орж ирсэн боловч тухай үед эрүүгийн хариуцлагын төрөл гэж хуульчлагдаагүй байсан.

Монгол улс 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн баталж, уг хуульд анх удаа өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын бие даасан тогтолцоог бүрдүүлсэн нь нэг талаас Монгол улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн, нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны этгээдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хүүхдийн эрхийг хангах боломж нөхцөл тодорхой хэмжээнд бүрдсэн юм.

Монгол Улсын эрүүгийн хуулиар насанд хүрээгүй этгээдэд нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих зэрэг ял оногдуулах, ялын бус хариуцлага болох өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах зэрэг эрүүгийн хариуцлагыг оногдуулахаар хуульчилсан.

Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар олон улсад үүрэг хүлээн нэгдэн орсон гэрээнүүд бол Хүүхдийн эрхийн конвенц, насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх асуудлын талаарх Бээжингийн дүрэм, Эрх чөлөөгөө хасуулсан насанд хүрээгүй хүүхдийн эрхийг хамгаалах талаар Гвана-ийн дүрэм, Нэгдсэн Үндэсний байгууллагын хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм, Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай

холбогдуулан НҮБ-аас гаргасан Эр-Риадын зарчим зэрэг юм. Эдгээр дүрмүүдэд өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын суурь зарчмуудыг тусгасан бөгөөд эдгээрт заасан гол агуулга нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг насанд хүрээгүй этгээдийн онцлогт нийцүүлэн явуулах, хорихоос өөр төрлийн ял нь амжилтгүй болбол хорих ялыг тэр даруй хэрэглэхгүй байх, хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрүүл мэнд, орон байр, боловсрол, ажил хөдөлмөр эрхлэлт болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл зэрэг засгийн газрын болон засгийн газрын бус бие даасан газруудыг өргөжүүлж тэдний хамтын ажиллагааг сайжруулах ажлуудыг хийхийг заасан байна.

Судлаач В.Цэцэнбилэгийн үзсэнээр “...Албадлагын учир нь насанд хүрээгүй этгээдэд болон түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөл хүсэл зоригоос шалтгаалдаг ба хүмүүжлийн арга хэмжээний биелэлт нь төрийн эрх мэдлийн зүгээс хийгддэг...” энэ нь анх удаа хөнгөн болон хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолын биелэлтийг хойшлуулсан тохиолдолд тухай өсвөр насны ялтан болон түүний эцэг, эх, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс зөвшөөрөл авах шаардлагагүйгээр хуульд заасан эрх олгосон төрийн байгууллагаас албадлагаар хэрэгжүүлдэг гэдгийг илэрхийлж байгаа юм.

Судлаач Г.Бадамын үзсэнээр “...Ялын урьдчилан сэргийлэх зорилго нь хэдийгээр субъектив шинжтэй ч гэмт хэрэг үйлдсэн хэрэгт тохирсон ял оногдуулснаар дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх нөгөө талаас нийгмийн бусад гишүүдэд дохио санамж өгөх, болгоомжлол төрүүлэхэд чиглэгдэх учиртай. Нэг үгээр хэлбэл ялын талаарх харьцангуй онолын чиглэлийнхэн ялын урьдчилан сэргийлэх зорилгод илүү ач холбогдол өгдөг... гэж үзсэн нь анх удаа хөнгөн болон хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж өгч байгаагаараа гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх, ялын урьдчилан сэргийлэх зорилгын агуулгад нийцэж байна.

Мөн Эрүүгийн хуулийн 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэлх хугацаагаар хойшлуулж болох ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.” гэж заасан. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг шийтгэх, цээрлүүлэх бус нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх, засрал төлөвийг олоход нь туслах зорилготой ба шүүхээс өөрт нь болон асран хамгаалагчид үүрэг хүлээлгэдэг онцлогтой. Гэвч тухайн этгээд шүүхээс хүлээлгэсэн үүрэг биелүүлээгүй, тухайн хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд өмнөх хойшлуулсан тогтоолыг хүчингүй болгож, ял хүндрүүлэх сөрөг нөхцөл байдал бий болгодог.

Судалгаагаар Монгол улсын хэмжээнд 2018 онд 956 өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдсэнээс 367 өсвөр хүний хорих ялыг хойшлуулсан байна. 2022 онд 1540, 2023 онд 1594 өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдсэн байна. Эндээс үзэхэд хүүхэд гэмт хэрэгт холбогдох тохиолдол жил ирэх тусам өсч буйд дүгнэлт хийх шаардлагатайг харуулж байна.

Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 186 дугаар зүйлд заасны дагуу өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүлээн аваад дараах ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

-Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахад хяналт тавих нөхцөл, журам, эрх, үүргийг нь тайлбарлаж, гарын үсэг зуруулах.

-Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүний хувийн бичиг баримт, онцлог содон тэмдэг, ялтны хувийн байдлын талаарх бусад мэдээллийг хувийн хэрэгт тэмдэглэж, ял эдлэлтийн байдалтай холбоотой бусад баримт бичгийг хавсаргах.

-Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн ялтныг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэнийг дуудан ирүүлж, тэдгээрийг эрх үүрэг, тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд хууль, шүүхийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг танилцуулах.

-Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулах.

-Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүний сахилга, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн талаар хяналтын хувийн хэрэгт 30 хоног тутам тэмдэглэх.

- Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүний албадлагын арга хэмжээ авах хугацаа дуусмагц энэ тухай прокурор, цагдаагийн байгууллага болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэх зэрэг ажиллагааг хийж гүйцэтгэнэ гэж хуульчилсан нь насанд хүрсэн хүнтэй нэг адил хяналт тавихаар байна.

Шийдвэр гүйцэтгэгч тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн засрал хүмүүжлийн байдалд дараах журмаар хяналт тавина. Үүнд:

-Гадаадад зорчих, цагаачлахыг хориглож, оршин суугаа засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийг 7 хоногоос дээш хугацаагаар орхин явах тохиолдолд зөвшөөрөл авах, 30 хоног тутам нэг удаа биечлэн ирж, бүртгүүлэхийг даалгах.

-Оршин суух газар болон эрхлэх ажил, албан тушаал өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр мэдэгдэж байх тухай баталгаа гаргуулах.

-Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүнийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн этгээд болон сум, дүүргийн Засаг даргаас хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх харилцаа мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.

-Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтдаа байлгах хүсэлт гаргасан буюу хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэний хүлээсэн үүргийг биелэлтийг хангуулах.

-Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэл тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хязгаарлалт, үүргийг биелүүлээгүй, эсхүл хяналтаас зайлсхийсэн тохиолдолд албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулах.

-Хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх, эсхүл холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах.

-Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх талаар тогтоолын биелэлтийг нь хойшлуулсан этгээдэд санамж, зөвлөгөө өгөх, ярилцлага зохион байгуулах.

-Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүний зан байдал, үйл ажиллагааны талаар байгууллага, албан тушаалтнаас тодорхойлолт, лавлагаа авах.

-Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн хүндэтгэх шалтгаанаар оршин суух газраа өөрчлөх бол түүний хяналтын хугацааг тооцож, хяналтын хувийн хэргийг шинээр оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлэх зэргээр хяналт тавьж ажиллана.¹

АНУ-д насанд хүрээгүйчүүдийн хорих ялыг тэдэнд зориулж тусгайлан байгуулсан газарт буюу хүмүүжлийн сургуульд эдлүүлдэг. Тэндхийн дэглэм, харуул хамгаалалтын нөхцөл насанд хүрэгчдийнхтэй жишихэд харьцангуй зөөлөн байдаг. Насанд хүрээгүй хоригдлууд нь өдөрт нь шоронгийн байрлалд ажиллаж, сурах бөгөөд шөнө нь гэртээ очиж, хонож болдог байна. Энэ хоригдлуудын хүмүүжилд сайнаар нөлөөлдөг байна.

Герман улсад насанд хүрээгүй ялтны ял эдлэх хугацаанд биелүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж биелэлтийг нь нийгмийн ажилтан хянаж ажилладаг байна. Мөн хүмүүжигчдийг чөлөөт амьдралд орох бэлтгэл хангахын тулд дэглэмийг зөөлрүүлж болох ба суллагдахаас 3 сарын өмнө 7 хоногийн чөлөө олгох, мөн сар бүр 6 хоногийн чөлөө олгож, хорих байгууллагаас гадуур чөлөөтэй явах эрх эдлүүлдэг. Суллагдсан хүмүүсийн 40 хувь нь эхний 5 жилд ямар нэгэн хэмжээгээр давтан зөрчил үйлдэггүй байна.

Франц улсад насанд хүрээгүй хоригдлыг шашин, буяны болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагад ялаа эдлэхийг зөвшөөрдөг онцлогтой.

Оросын Холбооны Улсад насанд хүрээгүй хоригдлыг сурган хүмүүжүүлэх тусгай хөтөлбөр сургалттай байдаг. Тухайлбал эцэг эх, төрийн тусгай байгууллагын хараа хяналтад шилжүүлэх, гэм хорыг арилгах үүрэг хариуцуулах, чөлөөт цагийг нь хязгаарлах зэрэг 3 аргыг түгээмэл хэрэглэдэг байна. Өөрөөр хэлбэл хяналтын гурвалжилсан тогтолцоонд хүүхэд тэдний хараа хяналтаас гардаггүй байна.

¹ Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.,УБ.2017

Шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтан болон албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хяналт тавихдаа насанд хүрсэн хүн болон өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдлаас хамааран хяналтыг ялгамжтай тавих талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, өсвөр насны хүнд дагнасан шийдвэр гүйцэтгэгчтэй болгох хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэхэд прокуророос хяналт тавин ажиллаж байгаа боловч шүүхийн шийтгэх тогоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүнд тавих хяналт эрх зүйн зохицуулалт харьцангуй сул байх тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох журам зэрэг эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хууль тогтоомжийг боловсронгуй болгосноор хүүхдийн эрх хангагдах хууль зүйн болон бусад орчин бүрдэнэ.

Санал

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хууль зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримтлан ажиллаж байгаа боловч өсвөр насны хүнд тавих хяналтыг насанд хүрэгчдээс тусад засрал хүмүүжлийн байдалд тохирсон тусгайлсан зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.

2. Ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын чиглэлээр өсвөр насны хүнд оногдуулсан шүүхийн шийтгэх тогоол биелүүлэхийг хойшлуулсан тохиолдолд насны онцлогт тохирсон сургалт, засрал хүмүүжил, зан төлөвт нөлөөлөх талаар тусгайлсан журам боловсруулах.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч насанд хүрсэн хүн болон өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдлаас хамааран хяналтыг ялгамжтай тавих, тусгайлсан байранд сургалт хүмүүжлийн ажлыг зохион байгуулж, өсвөр насны хүнд хяналт тавих мэргэшсэн алба хаагчийг бэлтгэх.

4. Прокуроруудад өсвөр насны хүнд хэрхэн хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэглээтэй холбогдох сургалт зохион байгуулах.

Ашигласан эх сурвалж

- 1.Монгол Улсын Үндсэн хууль., УБ
- 2.Монгол Улсын Эрүүгийн хууль., УБ.2015 он
- 3.Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.,УБ.2017
- 4."Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц.1989
5. Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх тухай НҮБ-с гаргасан Үндсэн зарчим /Эл Риадын зарчим/.1990
- 6.Монгол Улсын засгийн газар. "Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр". УБ., 1999
- 7.Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалах, УБ., 2011 он
- 8.Хүүхэд ба хууль ёс, УБ., 2008 он
- 9.С.Бямба-Эрдэнэ "Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах эрх зүйн зохицуулалтын зарим асуудал"., УБ. 2021 он
- 10.Б.Досжан "Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, олон улсын жишиг". ,УБ.2020 он
- 11.Ч.Болормаа "Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хүлээлгэх ялын бус эрүүгийн хариуцлагыг боловсронгуй болгох нь"., УБ. 2023 он
- 12.Н.Энхтөр "Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт"., УБ.2018 он
- 13.Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://Legalinfo.mn>
- 14.Шүүхийн шийдвэрийн цахим сан. <https://shuukh.mn>
- 15.Шүүхийн ерөнхий зөвлөлийн албан ёсны сайт,
- 16.<https://www2.1212.mn/>

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ АСУУДАЛ

Говь-Сүмбэр аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Ш.Батсүх

Хураангуй:

Эрүүгийн хариуцлага болон хүний эрхийн талаар дэлхий нийтээрээ анхаарлаа хандуулж олон шинэчлэлтүүдийг хийж байгаатай холбоотойгоор улс орон бүр өөрийн Эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах замаар эрүүгийн хариуцлагын төрөл өөрчлөгдөж байна.

Манай улсын тухайд ч мөн адил эрх зүйн шинэтгэлийг Эрүүгийн хуульдаа удаа дараа хийж гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих ялаас татгалзах, үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний хувийн байдалд тохирсон ял оногдуулах замаар ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 2015 оны Эрүүгийн хуульд шинэ төрлийн ял болох зорчих эрхийг хязгаарлах ялыг нэмж, хэрэгжилтийг нь цахим хэлбэрээр хянах нөхцөлийг бүрдүүлсэн.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн хуульд нэмэгдсэн дээрх “Зорчих эрхийг хязгаарлах ял”-ыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор практикт дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүхээс тогтоосон бүсэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжгүй болсон.

- гамшиг, аюулт үзэгдлийн улмаас шүүхээс тогтоосон газар, байршилд байх боломжгүй болсон¹ тохиолдлууд нийтээр тэмдэглэх баяр, амралтын өдрүүдэд үүсвэл хэнд хэрхэн мэдэгдэж, хэрхэн шийдвэрлэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд болоод холбогдох заавар, журамд нарийвчлан тусгагдаагүй.

Мөн зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг цахим хэлбэрээр хянах буюу ялтанд цахим гав хэрэглэх явцад түүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар нарийвчилсан зохицуулалт холбогдох хуулиуд болоод заавар журмаар зохицуулагдаагүй байна.

Иймд дээрх зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны практикт үүсэж байгаа хүндрэл бэрхшээлийг тодорхойлж холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, заавар журмыг батлан гаргаж хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагатай байна.

Түлхүүр үгс:

Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зорчих эрхийг хязгаарлах ял, тусламж, үйлчилгээ, прокурорын дүгнэлт, нэмж нэгтгэх.

¹ Нээлттэй нийгэм форум “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжил” судалгааны тайлан 2022 он.

Удиртгал

Дэлхийн ихэнх улс орны эрх зүйн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд хорих ялыг зөвхөн хохирогчийн аюулгүй байдалд заналхийлсэн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зэрэг цөөн тохиолдолд хэрэглэх учиртай гэсэн үзэл баримтлал, зарчим давамгайлж байна. Ял эдлүүлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийж үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь их хэмжээний зардал үүсгэж байгаагийн зэрэгцээ суллагдсан хүмүүс нийгмийн орчинд дасан зохицох чадвар муу, гэмт хэрэг дахин үйлдэхээс үл эмээх хандлагатай байгаагаас үүдэн хорих ялыг үр дүн багатай ялын төрөлд тооцдог. Хорихоос өөр төрлийн буюу олон улсад алтернатив ял гэж нэрлэгддэг ял (alternative penalty) нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, тогтоосон хугацаанд хорихгүйгээр тодорхой эрхийн хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгждэг.

Дэлхийн олон улс эрүүгийн ялын бодлогоо хүний эрхийг хангах, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлэх, ялын чанга шийтгэлээс үндсэндээ татгалзах, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох хүрээнд хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг хэрэглэх чиг хандлагатай байна. Манай улсын хувьд хорих ялаас татгалзах, үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний онцлог байдалд тохирсон ял оногдуулах замаар ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 2015 оны Эрүүгийн хуульд шинэ төрлийн ял болох зорчих эрхийг хязгаарлах ял нэмж, хэрэгжилтийг нь цахим хэлбэрээр хянах нөхцөл бүрдүүлсэн. Түүнчлэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөл бүрдүүлнэ” гэх зорилтын хүрээнд “зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем” хөгжүүлэн, ял эдлүүлэх ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна. Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжсэнээр Үндсэн хуулиар тунхагласан, ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрхийг дээдлэх тулгуур зарчимд нийцүүлэх, гэмт этгээд ажиллаж хөдөлмөрлөн, гэр бүл, үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэх, учруулсан хохирлоо нөхөн төлөх, хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлыг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой.²

Манай улс зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлж эхлээд даруй 3 жил болсон хэдий ч энэ хугацаанд ял эдлүүлэх ажиллагааны практикт нэлээдгүй хүндрэл бэрхшээл үүсэж байгаатай холбоотойгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, заавар журмыг шинэчлэн гаргах зэргээр практикт зөв жишгийг тогтоож, нэгдсэн ойлголтод хүргэх шаардлагатай юм.

² Нээлттэй нийгэм форум “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжил” судалгааны тайлан 2022 он.

Судалгааны хэсэг

Эдүгээ пост социалист орнуудын хувьд зорчих эрхийг хязгаарлах ялын чиглэлээр дагнан судалсан судалгааны бүтээл, нэг сэдэвт зохиол ховор байна.

ОХУ-ын хувьд тус улсын Шүүхийн шийдвэрийг 2020 он хүртэл хөгжүүлэх төслийн хүрээнд 2001 оноос эрх хязгаарлах ял хэрэгжүүлэхдээ электрон гавыг мөн хэрэглэх болсон байна. Хэрэгжиж эхлэх үед гадаад орны тоног төхөөрөмжийг хэрэглэж байсан ба 2011 оноос эх орондоо тус тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх болсноор гаднаас худалдан авч байсан зардлаас даруй 4 дахин бага зардлаар үйлдвэрлэх болсон. Улсын хэмжээнд 2013 онд “Электрон мониторинг” хийхэд 109440000 рубль төсөвлөсөн байна.

ОХУ-ын засгийн газраас 2010.03.31-нд № 198 “Хязгаарлах эрхийн ялын төрөлд ялтанг хянах, аудио болон электрон бусад техник, хангамж хэрэгслийн жагсаалт батлах тухай” тогтоол гаргаж, практикт нэвтрүүлсэн. Эрх хязгаарлах ялыг хэрэгжүүлэхдээ аудио болон электрон төхөөрөмжүүдийг ашигладаг.

Электрон гавыг хөл болон гарт зүүж хэрэглэх бөгөөд уг гав нь -100-аас +100 градуст тэсвэрлэж, 5 метрийн гүн бүхий давстай болон цэвэр усанд 15 минут хүртэл хугацаанд ажиллах боломжтой. Энэ нь ялтанд усанд орох, хэвийн амьдрах боломжийг олгож байна. Энэхүү төхөөрөмжийг ОХУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дэргэдэх “Мэдээлэл техникийн хангамжийн төв”-д үйлдвэрлэдэг. Гэвч сүүлийн үед энэ байгууллага нь татан буугдах талаар яригдах болсон. Энэ нь тус байгууллагын дарга асан, хурандаа генерал Александр Реймер болон түүний хамтрагчдын буруутай үйлдлээс болж улсад 2.7 сая рублийн хохирол учирсан байна.

Үүнээс үзэхэд, зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхдээ түүнд шаардагдах тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг бусад орны туршлага, ололт амжилт, алдаа дутагдлыг сайтар судалсны дүнд, өөрийн орны онол, практикт нэвтрүүлэх нь юу юунаас илүү чухал болоод байна.

АНУ болон Европын зарим орнуудын зорчих эрхийг хязгаарлах ялын онцлог

Сүүлийн 20 жилийн хугацаанд цахилгаан хяналтын төхөөрөмж цахим гавын хэрэглээ болон түүнийг ашиглан хяналт тавих хүмүүсийн тоо болон гэрийн хорионд хоригдож байгаа хийгээд зорчих эрхийг хязгаарлах ял, албадлага ногдуулсан хүмүүсийн тоо өссөн байна. АНУ-д гэхэд насанд хүрсэн болон насанд хүрээгүй хүмүүсийг нийгэмд нь хянах нийт хөтөлбөрийн 20 гаруй хувьд нь цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглаж байгаа гэсэн судалгаа байгаа юм. Тухайн улсад зорчих эрхийн хязгаарлалт болон цахилгаан хяналтын төхөөрөмж, цахим гав нь ерөнхийдөө гурван нөхцөлд хэрэглэгдэж байна. Шоронд хоригдохын өмнөх үе, шоронд хорих үе, нөхцөлтэйгөөр суллах үед гэсэн 3 үе байна. Шоронд хоригдохын өмнөх үе шат буюу шүүх хуралдаанаас өмнөх үеийн хяналтад анх удаа гэмт хэрэг үйлдсэн залуучууд хамрагддаг. Шүүхээс шүүх хуралдаанд байлцуулах хүртэл хугацаагаар хяналтад авдаг. Болзолт нөхцөлтэйгөөр суллах үе шатанд засан сайжруулах газраас суллагдаж байгаа этгээдүүдийг хамруулдаг ба зорчих эрхийг хязгаарлаж тэдгээрийг бүрэн суллах хүртэлх хугацаанд цахилгаан хяналтын төхөөрөмж, цахим гавыг хэрэглэн хяналтад байлгадаг.

Зорчих эрхийн хязгаарлалтад байгаа ялтнуудын төрлөөс хамаараад ямар шатны хязгаарлалт, хяналтад байлгах талаарх ажиллагаа нь өөр өөр байдаг. Энэ шатлал нь энгийн хөл хорионы цаг тогтоох болон эрх чөлөө, хөл хөдөлгөөнийг нь бүрэн хязгаарлах гэсэн хоёр шатлалтай. Эхний шатлал буюу хөл хорио нь тухайн этгээдийг тодорхой цагийн турш гэртээ байхыг шаарддаг. Хоёр дахь шатлал нь тухайн этгээдийг гадагш гарахыг урьдчилан зөвшөөрч тодорхой хугацаанаас бусад хугацаанд бүрэн гэртээ байхыг шаарддаг. Гадагш гарахыг урьдчилан зөвшөөрч тодорхойлсон хугацаанд /09:00-19:00 цагийн хооронд гэх мэт/ ажил хөдөлмөр эрхлэх, сургуульд сурах, эмчилгээ хийлгэх, сүмд очих, өмгөөлөгчтэйгөө уулзаж зөвлөгөө авах, шүүх хуралдаанд оролцох болон бусад шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломжуудыг ойлгодог. Хамгийн хүнд зорчих эрхийн хязгаарлалтын хэлбэр нь шүүх хуралдаанд оролцох, эмнэлгийн тусламж авахаас бусад хугацаанд 24 цагийн турш гэртээ хоригдохыг шаарддаг.

Цахилгаан хяналтын төхөөрөмж ашиглан зорчих эрхийг хязгаарлах хяналтыг хэрэгжүүлэх ялыг хэрэглэхэд тодорхой хэд хэдэн ашигтай талууд бий гэж судлаачид үздэг. Зорчих эрхийн хязгаарлалт болон цахилгаан хяналтын төхөөрөмжийг дэмжигчид уг төхөөрөмж, хөтөлбөрүүд нь санхүүгийн хэмнэлттэй, дахин гэмт хэрэг үйлдэх буюу рецидивизмийг бууруулдаг, хорих ялын сонголтод хэлбэрийг бий болгодог, ялтны байрлаж байгаа газрыг цаг тухай бүрд нь зааж өгч хяналт тавих боломжийг олгодог гэх мэт олон ашиг тусыг дурддаг. Үүнээс хамгийн гол ашиг тус нь шоронд хоригдох хүмүүсийн тоог багасгах нөлөө юм. Тухайн ялтан нь хаана ямар аргаар ял эдлэхээ сонгодог. Мөн шоронгийн барилгын тоог нэмэхгүй байх нь ирээдүйд гарах зардал болон ялтныг шоронд хорихтой холбогдон гарах өдөр тутмын болоод шоронгийн буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиргааны хийгээд үйл ажиллагааны зардлыг багасгадаг. Санхүүгийн хэмнэлтийн ашиг тус нь татвар төлөгч нарын мөнгийг хэмнэж, хорих газрын зардал болон тухайн гэмт этгээдүүдэд захиргааны хяналт тавих зардал гэх мэт зардлуудыг хэмнэхэд тусалдаг. Бодит зардлын хэмнэлтийн хувьд авч үзвэл цахилгаан хяналтын төхөөрөмжийн хөтөлбөр нь өдөрт хаана байгаагаас үл хамааран 5.50 доллароос 10 доллар хүртэлх зардал гаргадаг бол хорих газруудад гаргах өдрийн зардал нь нэг хоригдолд 100 доллароос 160 доллар байдаг. Цахилгаан хяналтын төхөөрөмжтэй, төхөөрөмжгүйгээр зорчих эрх нь хязгаарлагдсан гэмт этгээдүүд нь ажил хийж, өөрсдийн хэрэглэж байгаа хяналтын төхөөрөмжийн түрээс болон ашиглалтын зардлыг төлж байгаа нь мөн төсвийн хөрөнгийн хэмнэлтэд ихээхэн дөхөм үзүүлдэг ажээ.

Одоогоор Америкийн Нэгдсэн Улс нь цахилгаан хяналтын төхөөрөмжийг үндсэн хорих ялыг хэлбэрээр ашиглаж байгаа ба энэ нь шоронд хорихоос илүү их хүлээцтэй байдлыг шаарддаг хэдий ч тэнсэн суллахаас илүү хязгаарлалтад байдаг. Эрх зүйн статистикийн хэлтсээс гаргасан судалгаанд 1998 оны үед Америкийн Нэгдсэн Улсад нийт 19677 хүмүүсийг цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглан тэнсэн сулласан байна. Америкийн Нэгдсэн Улсын хойд бүс нутгаар цахилгаан хяналтын төхөөрөмжийг хорих ялын шууд нэгэн сонголтод хэлбэр гэж үздэг. Эхлээд шүүхээс тухайн этгээдийг шоронд хорихоор хорих ялаар шийтгэдэг ба хэрэв гэмт этгээд нь засан сайжирсан, зан үйлийн хувьд зохистой хэмжээнд хүрсэн гэж үзвэл хорих ялын үлдсэн хугацааг гэрийн хорионд эдлэхийг хүлээн зөвшөөрдөг. Нью Сауд Вэйлсд үүнтэй адилаар цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад дор гэрийн хорионд ял эдлэхийг зөвшөөрдөг. Хэдий

ингэж хүлээн зөвшөөрдөг ч гэсэн ялтанд уг сонголт хийх эрх нь хорих ялыг шоронд биечлэн эдэлж эхэлсний дараа нээгддэг.

Америкийн Нэгдсэн Улсад цахилгаан хяналтын төхөөрөмжийг шүүх хуралдаанаас өмнөх процесст хэрэглэж байна. Уг ажиллагаа нь батлан даалтын мөнгө төлөх боломжгүй сэжигтэн, яллагдагчдад зориулсан байдаг. Мөн хэрэг үүсгэснээс хойш 90 хоногийн дотор шүүх хуралдаан болоогүй болон гэмт хэрэг үйлдсэн эсэх нь тодорхойгүй нөхцөлд цахилгаан хяналтын төхөөрөмжийг хэрэглэдэггүй.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс /ИБУИНВУ/-ын бүрэлдэхүүнд багтах Шотландын тухайд 2002 оноос эхлэн зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэж эхэлжээ. Ингэхдээ шүүхээс шоронд хорих ялын сонголтод хэлбэрээр оногдуулах боломжтойгоор хэрэглэж эхэлсэн байна. Шотландад цахим гав, цахилгаан хяналтын төхөөрөмжийн үйлчилгээ, хэрэглээг Засгийн газар болоод хувийн компани хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр явагддаг. 2013 оны 4 сард Шотландын засгийн газраас Серко /Serco/ компанитай байгуулсан гэрээ дуусгавар болж G4S компанитай гэрээлж дараагийн 5 жилд хамтран ажиллахаар болсон байна. Дэлхийн жишгийн дагуу Шотландад цахим гав, цахилгаан хяналтын төхөөрөмжийн хэрэглээ нь шүүхээс өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээ байдлаар хэрэглэгдэх, шүүхээс ял шийтгэл хэлбэрээр оногдуулах болоод ялтан суллагдсаны дараа түүнд тавих хяналтын хэлбэрээр хэрэглэгддэг. Шотландад байршил дамжуулах болон мэдээлэл дамжуулах төхөөрөмжийн тусламжтайгаар тавих хяналт нь дараах төрөлтэй байдаг. Үүнд:

- Эрх чөлөө хасагдсан хүнд тавих хяналт /RLO/
- Зорчих эрх хасагдсан хүнд тавих хяналт /CPO/
- Нөхцөлтэйгөөр сулласан ялтанд тавих хяналт /гэрийн хорионд оруулах эсхүл хяналтын бүсээс гарахгүй байх, тодорхой маршрутаар зорчих нөхцөл тулгах/
- Мансууруулах бодис хэрэглэсэн эсэхэд тавих хяналт /DTTO/ гэх мэт.

Шотландын 2003 оны Эрүүгийн шүүн таслах ажиллагааны актын 40-р зүйлийн дагуу зорчих эрхийг хязгаарлах буюу эрхийн хязгаарлалтын ял, цахим гав, цахилгаан хяналтын төхөөрөмжийг хэрэглэх талаарх шийдвэрийг шүүх гаргадаг.

Бусад эрх зүйн тогтолцоотой улс орнуудад шүүгч нь ерөнхий эрх мэдлийнхээ хүрээнд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглаж байна. Тухайлбал, Тасманийн Хорих ял эдлүүлэх тухай 1997 оны актад шоронд хорих ялыг бүхэлд нь болон хэсэгчлэн зогсоож ялтан засан сайжирсан, тохиромжтой гэж шүүхээс үзвэл цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад гэрийн хорионд байхыг зөвшөөрдөг.

Шүүх хуралдаанаас өмнөх үе шатанд цахилгаан хяналтын төхөөрөмжийг хариуцагчийг батлан даалтад суллах тохиолдолд хэрэглэгддэг. Батлан даалтад гаргах болзол нь шүүх хуралдаанд хариуцагчийг оролцуулах болон дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх гэсэн нөхцөлүүд байдаг ба өөр нэмэлт шахалт, дарамт бүхий үүргийг оногдуулдаггүй. Энэ үе шатны хувьд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ял шийтгэлийн хэлбэрээр ашигладаггүй. Иймд тухайн сэжигтэн, яллагдагчийг заавал хязгаарлах, хорих шаардлага байхгүй бол цахилгаан хяналтын төхөөрөмжийг хяналт тавих зорилгоор ашигладаг.

Батлан даалтын үед дэх цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглах ажиллагаа нь Их Британид 1989 оноос эхэлсэн бөгөөд нийт 50 гаруй сэжигтэн, яллагдагчид уг төхөөрөмжөөр хяналт тавьж байжээ. Уг процесс ажиллагаа нь одоог хүртэл Их Британид ашиглагдаж байна. Жишээлбэл, цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглан хяналт тавих зорилгоор 12-оос 16 настай хариуцагч нарыг суллах ажиллагаа хийгддэг.

Канад Улсад цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтыг ашиглан батлан даалтад суллах эсэх асуудлыг зохицуулсан тусгайлсан хууль тогтоомж байхгүй хэдий ч шүүхээс өөрийн ерөнхий бүрэн эрхийнхээ хүрээнд зарим хариуцагч нарыг гэрийн хорионд байлгаж, цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглахыг зөвшөөрдөг.

Шүүх хуралдаанаас өмнөх үе шатанд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглаж болох хоёр тохиолдолд байдаг. Нэгдэх нь гэр оронгүй этгээдүүдэд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашигладаг. Өнөөгийн байдлаар ихэнх гэр оронгүй хүмүүс нь хорих газар байрлаж байна.

Өмнөд, хойд Австралийн эрх зүйн тогтолцоонд үндсэн ял буюу хорих ялыг цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад дор гэрийн хорионд эдлэхийг зөвшөөрсөн тусгайлсан хууль тогтоомж байдаг. Хойд Австралийн Ял эдлүүлэх тухай 1995 оны актад ялтанг ял эдлэх хугацаанд нь гянданд хорих ажиллагааг зогсоогоод гэрт нь үргэлжлүүлэн үлдсэн ялыг нь эдлүүлж болохыг заасан байдаг. Гэрийн хорионд байгаа ялтанг цахилгаан хяналтын төхөөрөмжийг зүүхийг шаарддаг.

Австралийн Хүний Эрхийн Зөвлөл нь хорих газар байлгахгаас гадна уг хүмүүст цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналт дор байх сонголтыг өгөх ёстой хэмээн зөвлөж байна. Хоёрдох хэрэглээ нь хохирогч, гомдол гаргагчаас гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдийг тусгаарлах, тэдгээрийг урьдчилан хамгаалахын тулд хөл хорио тогтоох, хязгаарлалтын хэлбэрээр ашиглаж байна. Цахилгаан хяналтын төхөөрөмжийн дээрх хоёр хэрэглээний аль аль нь Австрали улсад байдаггүй ч гэсэн орчин үеийн хязгаарлалт болон хяналт тавих шаардлагатай үед уг төхөөрөмжийг ашиглахыг улам ихээр шаардаж байна. Зөвхөн Баруун Австралид шүүх хуралдаанаас өмнө цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглаж болох талаар зохицуулалт байдаг. 1982 оны Батлан даалтын актад шүүхийн шийдвэр гүйцэтгэгч офицерын хяналтын дор 17 наснаас дээш насны сэжигтэн, яллагдагчийг гэрийн хорионд хорихыг хүлээн зөвшөөрдөг. Гэрийн хорионд батлан даалтад суллагдахын тулд дараах материалуудыг бүрдүүлдэг. Нэгдүгээрт Хорих газрын офицероос зөвшөөрөл авна, дараа нь сэжиглэгдэж байгаа этгээд цахилгаан хяналтын төхөөрөмжийг биедээ суурилуулах, эсхүл байрлах газар нь суулгахыг зөвшөөрсөн байх ёстой.

Ихэнх эрх зүйн тогтолцоонд цахилгаан хяналтын төхөөрөмж нь батлан даалтад суллах үед ихэвчлэн хэрэглэгдэж байна. Жишээлбэл, Өмнөд Австралийн 1985 оны батлан даалтын тухай актад батлан даалтад гаргаж байгаа эрх бүхий этгээд нь тухайн хүнийг оршин байрлах газарт нь хараа хяналтдаа байлгаж болохыг зөвшөөрсөн байдаг. Уг зүйл заалтад цахилгаан хяналтын төхөөрөмжийн талаар тодорхойлон заагаагүй байдаг хэдий ч Өмнөд Австралийн Дээд шүүхээс уг заалтыг тайлбарлахдаа эрх бүхий офицер нь цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглаж болохоор тайлбарласан.

Ялтанг ял эдлэх хугацаанаас нь өмнө нийгэмд суллаж байгаа тохиолдолд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашигладаг. Жишээлбэл, Их Британи Улсад хорих ялын хугацаа дуусах дөхөхөөр шоронгоос нийгэмд буцаан шилжүүлэх тохиолдолд цахилгаан хяналтын төхөөрөмжийг хэрэглэдэг.

Мөн Шинэ Зеланд Улсад цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад дор ялтныг хорих ялын хугацаа дуусахаас өмнө гаргадаг тохиолдол нь 1999 оноос эхэлсэн. Технологийн жижиг асуудлууд болон ялтны гэр бүл, хань ижлээс цахилгаан хяналтын төхөөрөмжид үзүүлэх сөрөг хандлагууд байсан хэдий ч уг ажиллагаа маш амжилттай явагдсан байна.

Өмнөд Австралид хорих ял эдлэх сүүлийн 6 сарын хугацаанд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглахыг зөвшөөрдөг. Ялтан нь цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналт дор нийгэмд суллагддаг бөгөөд уламжлалт батлан даалтад тэнсэн суллах ажиллагаа болон хорих ялыг дуусгах аль аль ажиллагаанд нь уг ажиллагаа байдаг байна. Кьюнсландад үүнтэй адилхан программ байдаг ба хорих ялын хугацаа дуусахад ялтныг цахилгаан хяналтын 56 төхөөрөмжийн хяналтад гэрийн хорионд хийдэг. Ялтнууд нь хорих ялын хугацаа дуусахаас өмнө уг программд 3-аас 4-н сарын турш байдаг. Хойд, Өмнөд Австралид ял эдэлсний дараа захиргааны хяналтад ялтныг авахын тулд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашигладаг. Баруун Австралийн 1995 оны Захиргааны хяналтын тухай актад зааснаар тодорхой ялтнуудыг гэрийн хорионд суллахыг зөвшөөрдөг. Тэдгээр ялтнуудыг цахилгаан хяналтын төхөөрөмжийг байрлаж амьдрах газартаа болон биедээ суулгах, суурилуулахыг зөвшөөрсөн байхыг шаарддаг. Мөн Кьюнсландын 2000 оны Засан сайжруулах арга хэмжээний тухай актад ялтанд цахилгаан хяналтын төхөөрөмжийг суулгаад нийгэмд суллах талаарх зохицуулалтыг заасан байдаг.

Нью Сауд Вэйлсийн 1999 оны Гэмт хэргийн тухай актад зааснаар тэнсэн суллах арга хэмжээ авч цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад гэрийн хорионд суллахыг зөвшөөрдөг. Мөн Ялтныг нийгэмжүүлэх тухай 2001 оны актад зааснаар Австралийн төв зөвлөлд мөн цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглах бүрэн эрхийг олгосон байдаг.

Баруун Австралийн Хорих ялын тухай 1995 оны актад шүүх ялтныг ял эдлэх хугацаанд нь онцгой, эрчимтэй хараа хяналтад байлгуулах тухай шийдвэрийг гаргаж болно гэж заасан. Уг шийдвэрийг гаргахын тулд ялтан нь шүүхийн шийдвэрт заасан хараа хяналтад байх ба түүний гэрт эсхүл биед нь цахилгаан хяналтын төхөөрөмжийг суурилуулдаг. Цахилгаан хяналтын төхөөрөмжийн хяналтад байх хугацааг шүүхээс 6 сар ба түүнээс доош хугацаагаар оногдуулж болдог.

Нью Сауд Вэйлсийн хууль тогтоомжид цахилгаан хяналтын төхөөрөмжийн талаар тусгайлсан заалт байхгүй хэдий ч Гэмт хэргийн тухай 1999 оны актад шүүгч шаардлагатай, зохистой гэж үзсэн тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэрийн хорионд ял эдлүүлэхээр шийдвэр гаргаж болно гэж заасан. Практикт цахилгаан хяналтын төхөөрөмжийг гэрийн хорионд байх хугацаанд хэрэглэж байна.³

³ Б.Алтангэрэл, М.Хүрэлбат. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ. 2021 он

Манай Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.5 дугаар зүйлд зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт, гэмт хэрэг үйлдсэн хүнд ялыг оногдуулах, ялыг биелүүлээгүй бол ялтны ялыг хорих ялаар солих, ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заажээ.

“Зорчих эрхийг хязгаарлах” гэсэн нэр томъёог судлахад “зорчих” гэдэг нь хүн нэг зүгийг чиглэн зорчих, ийш тийш зорчин явах, “эрхийг хязгаарлах” гэдэг нь эрхийг нь багасгах, хэмжээ тогтоох⁴ гэсэн утга илэрхийлж байгаагаас дүгнэвэл хүний чөлөөтэй зорчих хөдөлгөөнийг хязгаарлах гэж үзэж болно.

Монгол улсын тухайд зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлж эхэлснээс хойш улсын хэмжээнд 2021 онд 1049 хүнийг зорчих эрх хязгаарлах ялаар шийтгэж байсан бол зөвхөн 2022 оны эхний хагас жилд 1176 хүнд уг ялыг⁵ оногдуулснаас дүгнэхэд энэ ялыг гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах байдал нэмэгдэж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 1.

№	Нутаг дэвсгэр	Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн хүний тоо		Өсөлт, 2021 он 2022 оны эхний бууралт
		2021 он	2022 оны эхний бууралт хагас жил	
1	Улаанбаатар	488	587	+99
2	Архангай	37	55	+18
3	Баян-Өлгий	13	17	+4
4	Баянхонгор	29	29	-
5	Булган	9	39	+30
6	Говь-Алтай	14	9	-5
7	Говь-Сүмбэр	7	3	-4
8	Дархан-Уул	13	27	+14
9	Дорноговь	31	25	-6
10	Дорнод	14	39	+25
11	Дундговь	4	5	+1
12	Завхан	37	23	-14
13	Орхон	87	41	-46
14	Өвөрхангай	19	38	+19
15	Өмнөговь	9	8	-1
16	Сүхбаатар	19	14	-5
17	Сэлэнгэ	13	25	+12
18	Төв	55	71	+16
19	Увс	31	13	-18
20	Ховд	5	25	+18
21	Хөвсгөл	32	22	-10
22	Хэнтий	83	63	-20

Улсын хэмжээнд 2022 онд 3079 хүнд, 2023 од 2934 хүнд тус тус Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж байжээ.⁶

⁴ ШУА. Монгол хэлний их тайлбар толь. 2019.

⁵ Нээлттэй нийгэм форум “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжил” судалгааны тайлан. 2022 он.

⁶ Улсын Ерөнхий прокурорын газрын нэгдсэн мэдээ. 2022-2023 он.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, анхаарах асуудал:

Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах байдал нэмэгдэхийн хэрээр зарим тодорхойгүй асуудлыг тодорхой болгох хэрэгцээ шаардлагатай байна.

Тухайлбал: Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 173 дугаар зүйлийн 173.1 дэх хэсэгт “Дараахь үндэслэлээр прокурорын зөвшөөрснөөр ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтны зорчих эрхэд тогтоосон хориглолт, хязгаарлалтыг 30 хүртэл хоногийн хугацаанд өөрчилж болно.”, 173.1.1. “...гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон;”, “173.1.2. “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүхээс тогтоосон бүсэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжгүй;”, мөн хуулийн 174 дүгээр зүйлийн 174.1. “Дараахь тохиолдолд прокурор ахлах шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн ялтны зорчих бүсийг өөрчилж болно.”, 174.1.6 “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүхээс тогтоосон бүсэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжгүй болсон.”, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино”, гэж тус тус заажээ.

Дээрх хуулийн зохицуулалтуудаас харахад гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, шүүхээс тогтоосон бүсэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжгүй болсны дараа шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн прокуророос бичгээр зөвшөөрөл олгосон тохиолдолд ялтны зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг өөрчлөхөөр хуульчлагджээ.

Гэтэл дээрх дурдсан нөхцөл байдал ялтанд нийтээр амрах амралтын өдрүүд, олон хоногийн нийтээр амрах тэмдэглэлт баярын өдрүүдэд гэнэт үүссэн тохиолдолд хэнд хэрхэн мэдэгдэж, хэзээ, хэрхэн шийдвэр гүйцэтгэгчээс саналаа гаргах, прокурор хэрхэн шийдвэрлэх талаар холбогдох хуулиудад нарийвчлан зохицуулагдаагүйгээс үүдэн ялтны эрүүл мэнд, амь насанд аюул учирч болзошгүй байна.

Түүнчлэн манай улс зорчих эрхийг хязгаарлах ялын биелэлтэд гар, хөлийн цахим гавыг ялтанд зүүх байдлаар хяналт тавьж байгаа бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.2 “Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болж, ялтанд цахим бугуйвч зүүлгэсэн өдрөөс эхлэн тоолно.” Гэж заасны дагуу ялтанд цахим гавыг зүүж, эрх үүргийг тайлбарлаж өгснөөр зорчих эрхийг хязгаарлах ялтай ялтанд тавих хяналт эхэлж байгаа бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 155 дугаар зүйлийн 155.1 “Шийдвэр гүйцэтгэгч дараахь үндэслэлээр эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсонд тооцож, хэргийг хаана.”, 155.1.1 “ялтан шүүхийн шийдвэрээр оногдуулсан чялыг бүрэн эдэлж дууссан”; 155.1.2 “ялтныг өвчний учир хугацаанаас өмнө ялаас чөлөөлсөн”; 155.1.3 “шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээгээр солих тухай шүүхийн шийдвэр гарсан”; 155.1.4 “ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон”; 155.1.5 “ялтанд өршөөл, уучлал үзүүлсэн”; 155.1.6 “ялтан нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсоноос хойш 2 жилийн хугацаа өнгөрсөн”; 155.1.8 “ялтан хэрэг хариуцах

чадваргүй болсон” тохиолдол шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа дуусгавар болохоор хуульчлагджээ.

Гэтэл практикт ялтны цахим гав зүүсэн хэсэгт халах, улайх, цэврүүтэж шарх үүсэх зэрэг нөхцөл байдал бий болоод байна.

Жишээлбэл: Говь-Сүмбэр аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 2024/ШЦТ/08 дугаартай шийтгэх тогтоолоор шүүгдэгч Ч.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад зааснаар 06 сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 01 сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял тус тус оногдуулж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан оногдуулсан ялуудыг нэмж нэгтгэн нийт 07 сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэжээ.

Ялтан Ч.Б-д 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр техникийн хяналтын зааварчилгаа өгч, эрх үүргийг нь танилцуулж түүний зүүн гарын бугуй хэсэгт цахим бугуйвчийг зүүж зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг эхлүүлсэн байна.

Ялтан Ч.Б-ийн зүүн гарын бугуй хэсэгт цахим бугуйвч зүүж өгч ялын биелэлтийг хангуулж эхэлснээс хойш 8 хоногийн дараа буюу 2024 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс (Бямба гараг) эхлэн түүний цахим бугуйвчтай хэсэгт халалт өгч гарын бугуй хэсэгт цэврүүтэж шархалсан нөхцөл байдал бий болсон тул шинэ цахим бугуйвчийг 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр баруун гарын шуу хэсэгт сольж зүүх арга хэмжээ шийдвэр гүйцэтгэгчээс авсан боловч 15 хоногийн дараа дахин дээрх нөхцөл байдал үүссэн байгаа хэдий ч дахин давтан гарах тохиолдолд ямар арга хэмжээ авч хэрхэн ажиллах талаар хууль, зааврын зохицуулалт хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Дээрх нөхцөл байдлуудаас дүгнэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “эрүүл, аюулгүй орчинд амьдрах...эрхтэй”; 6 дахь хэсэгт заасан “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэх хуулийн заалтад нийцүүлэн холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, заавар, журмуудыг шинэчлэн батлах зайлшгүй шаардлага бий болжээ.

Дүгнэлт

Шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зорчих эрх хязгаарлах ял оногдуулахаар гэмт хэрэг үйлдсэн хүнд үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн байдал, хувийн байдал зэргийг харгалзан тухайн төрлийн ялыг түлхүү оногдуулж аль болох хорих ялаас татгалзах бодлогыг барьж байгаа хэдий тухайн төрлийн ял нь манай улсад 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхлээд удаагүй буюу 3 жил болж байна.

Энэ ч утгаараа шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан ялтны оршин суугаа бүс нутагт гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, шүүхээс тогтоосон бүсэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжгүй байдал нийтээр амрах амралтын өдрүүд, олон хоногийн нийтээр амрах тэмдэглэлт баярын өдрүүдэд гэнэт бий болсон тохиолдолд хэнд хэрхэн мэдэгдэх, шийдвэр гүйцэтгэгч хэзээ, хэрхэн саналаа гаргах, прокурор хэрхэн шийдвэрлэх талаар Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, холбогдох заавар, журмуудыг шинэчлэн

батлах зэргээр тодорхой нэгдсэн ойлголттой болох зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна.

Түүнчлэн зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихад ашиглаж байгаа цахим гав тухайн ялтны биеийн онцлог, эрүүл мэндийн байдал зэргээс хамаарч сөрөг үйлчлэл үзүүлж байгаа гэх тохиолдолд түүнийг хэрхэн тогтоох, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг цааш үргэлжлүүлэн явуулах эсэх, цахим гавтай холбоотойгоор ял эдлүүлэх боломжгүй нөхцөл нөхцөл байдалд ялыг өөр төрлийн ялаар сольдог зэрэг хуулийн өөрчлөлтүүдийг хийх хэрэгцээ шаардлагатай байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Энэ хуулийн 174.1.2, 174.1.6 дахь хэсэгт заасан нөхцөл байдал нийтээр амрах амралтын өдрүүд, нийтээр амрах тэмдэглэлт баярын өдрүүдэд гэнэт үүссэн тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчид холбоо мэдээллийн хэрэгслээр урьдчилан мэдэгдэх, боломжгүй тохиолдолд дараагийн ажлын өдөр эхэлмэгц холбогдох баримт, хүсэлтийг гаргана” гэсэн, Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж байгаа тоног төхөөрөмж ялтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн нөхцөл байдал нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд прокурорын дүгнэлтээр нийтэд тустай ажил хийлгэх, торгох ялаар солино” гэсэн заалтыг тус тус шинээр нэмж, холбогдох заавар, журмуудад шинэчлэн баталснаар ялтны эрх хангагдаж, аливаа гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой.

Ашигласан эх сурвалж

Нэг. Хууль, тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Эрүүгийн хууль. 2015 он.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он.
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он.

Хоёр. Сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл

1. ШУА. Монгол хэлний их тайлбар толь. 2019.
2. Б.Алтангэрэл, М.Хүрэлбат. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ. 2021 он
3. Нээлттэй нийгэм форум “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт” судалгааны тайлан. 2022 он.

Гурав. Цахим эх сурвалж

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. www.legalinfo.mn
2. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан. www.shuukh.mn

ХОРИХ ЯЛ ЭДЛЭХЭЭС ХУГАЦААНЫ ӨМНӨ СУЛЛАХ АЖИЛЛАГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ

Архангай аймгийн Прокурорын газрын хяналтын прокурор Б.Сүхбаатар
Хураангуй:

Жилд дунджаар хорих ял эдлээд 1800-3600 орчим хүн суллагддагаас 1300 орчим хүн хугацаанаас өмнө нь суллагдаж төрийн байгууллагын хяналтад орж байна. Түүнчлэн суллагдан гарсны дараа дахин гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, нөхцөлийг судлан үзэхэд хорих ангиас суллагдсан иргэнд тавих хяналт сул, тэдэнд үзүүлэх нийгэмшүүлэх үйлчилгээний зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт муутай байгаа нь харагдаж байна.

Хорих ангиас суллагдсан этгээдэд тавих хяналт нь хоёр үндсэн зорилго агуулдаг. Нэгдүгээрт: Гэмт хэрэг үйлдээд ял шийтгэлээ эдэлсэн хүн нийгэмд эргээд нэгдэх үйл явцад туслах нь буюу нийгэмшүүлэх явдал байдаг бол, хоёрдугаарт: Тэрхүү этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой. Хэрвээ нэгдүгээр зорилгыг биелүүлж чадвал хоёрдугаар зорилго аяндаа биелэх боломжтой. Өөрөөр хэлбэл, нэгэнтээ нийгэмшсэн хүн хяналт тавиагүй байсан ч гэмт хэрэг үйлдэхгүй гэсэн логик аяндаа үүсэх юм.

Түлхүүр үгс: Ял, хорих ял, хугацааны өмнө суллах, ялтан.

Удиртгал

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд ял оногдуулах, ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах агуулгын хүрээнд тодорхой өөрчлөлтүүд ороод байна. Хорих ялын гүйцэтгэлийн үйл ажиллагаанд зарчмын өөрчлөлтүүд орсон ба үүний хэрээр тухайн салбарын тодорхой асуудлыг гүнзгийрүүлэн судлан үзэх хэрэгцээ бий болгосоор байна.

Хугацаанаас өмнө суллах нь “хорих байгууллагын оршин суугчид” гэж нэрлэж болох хүний тоог бууруулах, тэдний, нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх, цаашид нийгэмд дасан зохицоход чухал ач холбогдолтой юм.

Шинэчлэн баталсан Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль ялаас чөлөөлөх, суллах үндэслэлд орсон өөрчлөлтүүд хорих ялаас хугацаанаас өмнө суллах асуудалд анхаарал хандуулсан байна. Үүнтэй зэрэгцэн хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэх явдал ч мөн их байна. Гэвч үүнээс хамааран хорих ялаас хугацаанаас өмнө суллах институтээс татгалзах үндэслэл байхгүй юм. Гэхдээ энэхүү асуудлыг онолын түвшин, практик хэрэгжилтийг боловсронгуй болгох шаардлага бий.

Иймд хоригдлыг хугацааны өмнө суллах үйл ажиллагааны мөн чанарыг нарийн тодорхойлж, уг ажиллагааны онол практикийн ач холбогдлыг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Үндсэн хэсэг

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах салбарыг анх 1855 онд Францын эрүүгийн хуульд хуульчилсан байдаг.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах ажиллагаа нь энэрэнгүй ёсны зарчимд үндэслэсэн байдаг бөгөөд ялын зорилго хугацаанаас өмнө хангагдсан тохиолдолд ялыг цаашид эдлүүлэх шаардлагагүй гэсэн агуулгатай юм. Үүнээс гадна хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах явдал нь хорих байгууллагад хэв журам сахиулах болон хоригдлыг засарч хүмүүжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг юм.

Английн нэрт сэтгэгч Р.Оуэн “Төр нь иргэнээ яллахаас татгалзах ёстой. Ял оноож залхаах нь төрийн үүрэг биш, ял гарцаагүй үед аль болох өршөөн уучлах, гэмт хэрэг хийсэн хүн, байгууллага өөрөө өөрсдийгөө яллах ёстой” хэмээн номлож байсан бол Италийн эрдэмтэн Л.Дольни Оуэний сургаалыг дэмжин “Төр иргэнээ яллан шийтгэж болохгүй харин гэмт хэрэг үйлдэхгүй байх орчныг буй болгох, өрх гэрийн тэргүүн мэт иргэн, харьяатаа засан залруулж байнга асран хамгаалж байх ёстой” гэж номлосон¹.

Харин Платон ялын зорилго нь сэтгэлийн ариусгал бий болгох ба ял хүнийг зовоох тамлах ёсгүй гэж бичсэн байдаг².

Тэгвэл Монтескье, Руссо нарын төлөөлөгчид “Ялын бодлого энэрэнгүй байх ёстой. Ял нь залхаан тарчлаах гэхээсээ илүү дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх, засрал төлөвшилд бодитойгоор нөлөөлөх хөшүүрэг” хэмээн үзэж байв.

Эдгээр нь ял шийтгэл гарцаагүй байх ёс гэдгийг тодорхойлохын зэрэгцээ түүнийг хүнлэг энэрэнгүй байх ёстой болохыг тодорхойлж байна. Нэг үгээр ял шийтгэл нь гэмт хэрэгтний эсрэг чиглэх бус, харин гэмт хэргийн эсрэг чиглэсэн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй болохыг харуулж байна.

Хорих ял бол иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, хоригдолд эрхийн хязгаарлалтаар дамжсан цээрлэл амсуулах, дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг гаргуулахгүй байх, нийгмийн дотор байгаа зарим тогтворгүй хүмүүст урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг хамгийн өргөн хэрэглэгддэг төрийн албадлагын онцгой төрөл гэж ойлгож болох бөгөөд хүнд гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай болох нь тогтоогдсон тохиолдолд шүүх тухайн шүүгдэгчийн эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоон, олон нийтээс тусгаарлах замаар тусгай дэглэм бүхий хорих анги, гянданд албадан байлгадаг цээрлэл агуулсан онцгой арга хэмжээ буюу үндсэн ял юм.

Хорих ял бол хүнийг бие махбод, сэтгэл санааны хувьд зовоох, тарчлаах ялын төрөлд хамаарч байна. Хорих ял нь бусад төрлийн ялтай харьцуулан авч үзвэл:

- 1/ Хоригдол чөлөөтэй зорчин явах эрхээ хязгаарлуулдаг;
- 2/ Олон нийтээс тодорхой хугацаагаар тусгаарлагддаг;
- 3/ Харьцангуй удаан хугацаатай;
- 4/ Төрийн тусгай байгууллага болох хорих ангид хоригддог;

¹ Р.Оюунбадам нар. Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалт. УБ., 2005. 6 дахь тал

² Грекийн сонгодог үеийн философич, математикч. МЭӨ 428/427 – МЭӨ 348/347

5/ Хоригдол хорих ял эдлэх хугацаандаа нийгэм, хамт олон дотор байж эрх чөлөөт иргэдийн нэгэн адил өөрийн эрх дураар ажиллаж, хөдөлмөрлөх, амьдрах эрхгүй байдаг;

6/ Нийгэм, төрийн үйл ажиллагаанд Үндсэн хуульд заасан улс төрийн эрхээ эдэлж, оролцох боломжоо алддаг;

7/ Гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд, найз нөхдөөсөө хагас тусгаарлагддаг;

8/ Хорих ангийн дэглэм, дотоод журамд захирагдах, тэдгээрийг дагаж мөрдөх шаардлагатай болдог;

9/ Иргэн гэхийн оронд хоригдол гэж дуудуулан нэр төрийн хувьд ичгэвтэр байдалд орох зэмлэл хүлээдэг;

10/ Ял шийтгүүлэхийн өмнө ажиллаж, сурч байсан хамт олноосоо тусгаарлагддаг;

11/ Эзэмшсэн мэргэжлийн ажлаа болон дур сонирхолтой, хийхийг хүссэн ажил хөдөлмөр эрхлэх эрхгүй болдог;

12/ Удаан хугацаатай хорих ял шийтгүүлсэн хоригдлын эхнэр, нөхөр гэрлэлтээ цуцлуулах нэхэмжлэл шүүхэд гаргахад маргах эрхгүй болдог;

13/ Хорих ангид ял эдэлж байхдаа хийсэн ажлын хөлсөө өөрөө гардан авах, шууд зарцуулах болон өмч хөрөнгө, эд зүйлээ зориулалтаар зарцуулах, чөлөөтэй ашиглах эрхээ тодорхой хэлбэрээр хязгаарлуулдаг байна.³

Үүнээс үзвэл хорих ял бол гэмт этгээдэд сэтгэл зүй, бие махбодын хатуу цээрлэлийг мэдрүүлдэг хамгийн хүнд ял шийтгэлийн төрөл юм.

Гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй, эмэгтэй, арван дөрвөн насанд хүрсэн хүнд хорих ялыг оногдуулж болохоор Монгол улсын эрүүгийн хуульд тодорхойлсон. Хүний нас, сэтгэхүйн онцлогоос шалтгаалж, бидний дээр дурдсан хорих ял, түүний цээрлэл нь тухайн хувь хүнээс шалтгаалаад хүн бүхэнд өөр өөрөөр нөлөөлөх нь гарцаагүй.

Хууль шүүхийн өмнө хүн бүр тэгш эрхтэй хэдий ч тэдний нас, сэтгэл санаа, орчныг харгалзан үзвэл уг зарчим нь хэр хэмжээнд шударга болохыг ахин нэг эргэн харах хэрэгтэй. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хорих ялыг оногдуулах хэдий ч уг ял нь ямар хүнд хэрхэн нөлөөлж, үр дүн үзүүлэх нь тодорхойгүй зүйл юм. Хорих ял аливаа хүнд үзүүлэх цээрлэл болоод, түүний эрх, эрх чөлөөний хязгаарлалтын хувьд ялын маш хүнд хэлбэр бөгөөд хүний эрхэнд шууд нөлөөтэй болох нь харагдаж байна.

Хүний эрхийн хувьд хорих ялыг авч үзвэл: Монгол улс ардчилсан нийгмийн үнэт зүйлийг эрхэмлэгч улс болохын хувьд хүний эрхийг нийгмийн бүх шатандаа хангах, хамгаалах нь бидний туйлын зорилго юм. Тэгвэл хүний эрх, цаашлаад хорих ял эдлүүлэх ажиллагаа дахь хүний эрхийн талаар цухас дурдах нь уг судалгааны ажилд нэн шаардлагатай.

Харин хорих ял нь ял шийтгэлийн хамгийн хүнд хэлбэр бөгөөд энэ ял шийтгэл нь дээр дурдсан шинжүүдээрээ дамжуулан хүний эрх, эрх чөлөөг хязгаарладаг. Энэхүү

³ Б.Алтангэрэл, Б.Тэмүүлэн. Хорих ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018. 35 дахь тал.

хязгаарлал нь хүний хүсэл зоригийг ч үгүй хийж болох ноцтой төрийн албадлагын арга хэмжээ тул хорих ялд хандах хандлага, хорих ял эдлүүлэх ажиллагааны үзэл баримтлалд ихээхэн анхааралтай хандах хэрэгтэй. Тэгвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа дахь хүний эрхийн тухай асуудал нь нийгмийн эмзэг асуудлуудын нэг болоод байна.

Хууль зүйн үүднээс бид хорих ялыг тодорхой хугацаагаар гэмт этгээдийн эрх, эрх чөлөөг хязгаарлаж байна гэж харах хэдий ч хорих ял бол хоригдлын эрхийг хязгаарлах урт хугацааныхаа туршид хүний хүсэл зориг, ирээдүйдээ итгэх итгэл, мөрөөдлийг үгүй хийсээр байдаг ял шийтгэлийн хамгийн хүнд хэлбэр юм.

Тиймээс энэхүү шийтгэлийн хамгийн хүнд хэлбэрийг хэрэглэхдээ хүнийг хүн байлгах тэрхүү үнэт зүйлийг нь үл сэвтээхийг зорих шаардлагатай ба үүнд хорих ялын зорилго орших юм.

Хорих ял эдэлж байгаа этгээд нь бусдаас өөр төрсөн, онцгой махбодь бус харин шударгаар амьдрах арга замаа төдийлөн олж харж чадаагүй, сэтгэл хөдлөлөө барьж чадаагүй, амархан гомддог, амархан баярладаг, эмзэг сэтгэхүйтэй, ертөнцийг үзэх үзэл хязгаарлагдмал зэрэг онцлогтой хүмүүс байх нь элбэг. Чухам ийм хүмүүсийн ухамсар, хүмүүжил, нийгэмшилд нөлөөлөх арга хэмжээнд онцгой анхаарал хандуулах нь чухал. Учир нь хүн бүхэн хорвоод мэндлэхдээ ижил цэгээс эхэлсэн бүгд ижил онцгой биш боловч хорих ялаар шийтгэгдсэн хүнийг онцгой буюу бусдаас өөр гэмт хэрэгтэн, муу хүн гэх ойлголтыг нийгэм өөрөө бий болгодог.

Харин торгох, эсхүл нийтэд тустай ажил хийлгэх ял нь ялтныг төдийлөн нийгмийн онцгой субъект болгодоггүй, нийгмийн дунд ажиллах, хөдөлмөрлөх боломж олгодог.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах гэдгийг тодорхойлбол: Монгол Улсын Үндсэн хуульд “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” хэмээн тунхагласан байдаг⁴.

Ял бол хүний эрх чөлөөг хязгаарладаг. Харин хорих ял нь шууд утгаараа хүний эрх, эрх чөлөөг хорих байгууллагын дэглэм, зэрэглэлээс хамаарч хязгаарладаг ба ингэхдээ тодорхой хугацааны турш, хэн нэгний хатуу хяналтад үүнийгээ хэрэглэдэг нэгэн албадлагын хэрэгсэл.

Тодорхой хугацаа гэдгийг Монгол Улсын Эрүүгийн хуулиар зургаан сараас 20 жил, 25 жил, эсхүл түүнээс ч удаан байхаар томьёолсон байдаг.

Ингэснээр хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах гэдэг нь хуулиар тодорхойлсон дээрх хугацааг бүрэн эдэлж дуусахаас нь өмнө тухайн гэмт этгээдийг хорих ангиас суллах, сул тавих, чөлөөлөх гэсэн ойлголтыг өөртөө агуулах юм.

Нэг үгээр хэлбэл иргэн “Б” нь эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай болох нь тогтоогдож, 4 жил хорих ял шийтгүүлсэн хэдий ч 4 жилийн хугацаа өнгөрөхөөс өмнө буюу 2 жил 6 сарын хугацаанд хорих ялыг эдлээд хорих ангиас суллагдаж болно гэсэн үг.

⁴ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. 1992. №1

Хүснэгт №01. Улсын хэмжээнд хорих ангиас хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан болон хугацаа дуусч суллагдсан хоригдлын тоо

№	Он	Суллагдсан хоригдлын тоо	Үүнээс хугацааны өмнө суллаж, хяналт тогтоосон хоригдлын тоо
2	2020	2589	1690
3	2021	3692	1182
4	2022	1871	855
5	2023	2361	1120
Нийт		10513	4847

Энэхүү зохицуулалт нь нийгэмд маш олон хандлага, өгүүлэл дагуулдаг. Тухайлбал иргэд хуулиар тодорхой хугацаагаар ял шийтгүүлсэн хэдий ч түүнийгээ бүрэн эдлэлгүй суллагдаж байгаа нь ял завшиж байгаа хэрэг хэмээн үзэх нь олонтой. Хэн нэгний эрхэнд халдчихаад түүнийхээ хариуцлагыг хагас дутуу хүлээх нь шударга бус хэмээдэг.

Гэтэл эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчимд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд эрүүгийн хариуцлагаас зайлсхийх, ял завших явдал гарах ёсгүй. Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим нь хуульд заасан журмын дагуу эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх, ял хойшлуулах, тэнсэх зэрэг журмыг хэрэглэхэд саад болохгүй. Зөвхөн хуульд заасан журмын дагуу эрүүгийн хариуцлага ялаас чөлөөлж, хойшлуулж, тэнсэж байгаа нь энэ зарчимтай нийцэж байгаа хэрэг.

Дээрхээс үзвэл хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах нь ямар ач холбогдолтой зүйл юм бэ гэсэн асуулттай тулгарах болно.

Иймд хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах гэдэг нь дараах мөн чанарыг өөртөө агуулж байна.

1. Хэдий гэмт хэрэг үйлдсэн ч гэсэн тухайн этгээдийг хүн хэмээн хүндэтгэж, түүний хүсэл зоригийг мохоолгүй, хамгаалж буй арга хэмжээ юм. Учир нь хорих ял өөрийн онцлог шинжүүдээрээ хүний эрхийг хязгаарлаад зогсохгүй хүний эрхийн үндэс болсон хүсэл зорилгод нь хүртэл нөлөөлдөг. Жишээ нь шүүхээс хорин жилийн ял шийтгүүлсэн этгээд хэзээ дуусах хорин жил гэж бодно. Сэтгэл санааны хүнд цохилтод орно. Улмаар амьдрах хүсэл, хөгжих, хөдөлмөрлөх, хүсэл зориггүй болох аюултай. Чухам үүнийг даван туулахад уг зохицуулалт нь дэмжлэг үзүүлэх, хүний ёсоор амьдрах хүслийг нь тэтгэгч юм.

2. Ялын бодлого энэрэнгүй байх ёстой. Ял нь залхаан тарчлаах гэхээсээ илүү дахин гэмт хэрэг үйлдэхгүй байхад чиглэгдэнэ. Ялын бодлого хүний эрхийг хэдий хязгаарлаж болох ч түүнийг нь боомилсон зүйл байж болохгүй. Учир нь хүний эрх төрөлхийн шинжтэй зүйл бөгөөд тэрхүү төрөлхийн зүйлийг төрөлхийн бус хуулиар боож, тасдаж үл болох бөгөөд харин түүнийг хөхиүлэн дэмжихэд чиглэгдэх ёстой.

3. Гэмт хэрэг үйлдсэн, алдаж эндсэн нэгэнд дахин боломж бий шүү, гэдгийг сануулж буй арга хэмжээ. Хүн гэмт хэрэгт холбогдох, түүнийг үйлдэх шалтгаан нөхцөл нь маш олон учир шалтгаантай тэр бүрийг хуулиар тогтоож зохицуулна гэдэг боломжгүй мэт. Хүн бүр байгалийн дахин давтагдашгүй бүтээл байдаг тул тэр бүгдийн нэг хэмээн үзэж шийдэх нь өрөөсгөл байдаг. Тиймээс алдаж эндсэн хэн бүхнийг ял шийтгэлээр эцэслэх нь хүмүүнлэг ёсны бус төдийгүй, гэмт этгээдэд харамсалтай юм.

Харин хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах зохицуулалт эрх зүйн хувьд дараах ач холбогдолтой байж болно.

1. Хорих ялыг үр дүнд хүргэх гол ач холбогдолтой. Ял шийтгэл нь тодорхой үр дүнд хүрч, түүний нөлөөний улмаас гэмт хэрэг, гэмт явдал, багасах, гэмт хэргийн талаар үзэх нэг хүний бодол өөрчлөгдөх нь түүний үр дүн юм. Харин хорих ял нь их, бага хугацаатай хэдий ч түүний онцлог шинжүүд нь хамтдаа гэмт этгээдэд дээрх үр дүнг бий болгодог ялын төрөл. Ингэснээрээ дахиж гэмт хэрэг үйлдэхгүй байх, нийгэмд зөвөөр амьдрах чиг шугамаа олох ач холбогдолтой.

2. Ялын шийтгэлийн мөн чанарыг илэрхийлэх ач холбогдолтой. Бид хуулиар гэмт хэргийг тодорхойлж, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлдог бус хүнийг гэмт хэрэгт тооцож, түүнийг хэрхэн яллаж шийтгэх тухай тодорхойлдоггүй. Иймээс гэмт этгээдийн зан байдал, засрал хүмүүжил, хохирлоо төлсөн байдал, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх нөхцөл, түүний нийгэмшил зэргийг харгалзан хорих ялаас хугацааны өмнө сулладаг. Нэг үгээр хэлбэл тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн тэрхүү нөхцөл арилсан бол түүнийг хорьж шийтгэх нь хүнлэг бус хэрэг төдийгүй, ялын шийтгэлийн мөн чанарыг гуйвуулж буй хэрэг юм.

3. Үндсэн хуульд заасан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоох ач холбогдолтой. Хүний эрхийг дээдэлж, түүнийгээ тухайн нийгмийнхээ үнэт зүйл хэмээн үзэж, түүнийг хамгаалах, хангах тогтолцоог бий болгохыг үндсэн хуульдаа тунхагласны хувьд манай улс боломжит бүхий нөхцөлд хэнийг ч буруутай, буруугүй, баян, ядуу, нийгмийн гарал, үндэс угсаа, шашин шүтлэг, хэл, ёс, арьс өнгө, хүйсээр үл харгалзан тэднийг хүн хэмээн үзэж хүндэтгэн, түүний эрх, ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрсөн бодлого явуулах учиртай.

Гэтэл практикт хорих ялаас хугацаанаас өмнө суллах ажиллагааны мөн чанарыг нэн түрүүнд авч үзэлгүй хорих анги дахь хамгийн анхаарал татсан, ажиллах шаардлагатай хоригдлуудаас хурдан салах арга хэрэгсэл болгож байгаа нь учир дутагдалтай.

Мөн хорих ялаас хугацаанаас өмнө суллах шаардлага хангасан хоригдолд тавих нийтлэг шаардлагыг хэлбэрийн төдий авч үзэж, холбогдох материалыг бүрдүүлдэг нь энэ ажиллагааны амин чухал зорилгыг үгүйсгэхэд хүрч байна.

Дээрх байдлаар хүний эрх болон ардчилсан нийгмийн үнэт зүйлийн талаас нь чухал ач холбогдолтой зохицуулалт хэмээн үзэж энэхүү өгүүллээр хорих ялаас хугацаанаас өмнө суллах ажиллагааны ач холбогдол, хоригдолд үзүүлэх эерэг нөлөөг тодорхойлохыг зорилоо.

Дүгнэлт

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах ажиллагааны ач холбогдол, мөн чанарын хүрээнд судлан дүгнэхэд:

1. Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт этгээдийн гэмт зан үйлд нөлөөлөх, тэрхүү зан үйлийн хор уршгийг багасгахад чиглэдэг эрх зүйн тогтолцооны чухал хэсэг юм. Иймд ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах, ял шийтгэлийг хүний эсрэг бус гэмт хэргийн эсрэг чиглэсэн нийгмийн хамгааллын хэрэгсэл байх агуулгыг илэрхийлэгч гол механизм юм.

2. Гэмт этгээдийг хорих, ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт хэрэгтний хүн байх язгуур шинжид халдаж болохгүй бөгөөд хүний хүсэл зоригийг мохоож, зовоон тарчлаах бус харин эсрэгээрээ гэмт зан үйл, хандлагад нь нөлөөлж, нийгэмд эргэн нэгдэх хүсэл, тэмүүллийг нь өдөөн баяжуулахад чиглэсэн арга хэмжээ байх хэрэгтэй.

Хорих ялын гол агуулга нь тухайн гэмт этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой хугацаанд засан хүмүүжүүлж, нийгэмшүүлэн, нийгэмд эргэн нэгтгэхэд чиглэсэн арга хэмжээ байх нь чухал.

3. Хорих ялаас хугацааны өмнө суллах ажиллагааны мөн чанарын хувьд хорих хэрэгцээ шаардлага үгүй болсон тэр цагт нь тухайн этгээдийг хорих байгууллагаас суллах нь хорих ялын үр дүнг хамгийн өндөр байлгаж, дахиж гэмт хэрэг үйлдэхгүй байх нөхцөл эрүүгийн хариуцлагын зорилго хангагдах үндэс суурь болно.

Санал

1. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах ажиллагааны ач холбогдол болон хорих ял эдлүүлэх ажиллагаанд үзүүлэх эерэг нөлөөллийг алба хаагчдад таньж ойлгуулах сургалт явуулах.

2. Хугацаанаас өмнө суллагдсан хүний ялын түүхийг судлан ангилж дахин нийгэмшүүлэх хөтөлбөр, төслийг өргөн хэрэглэх тогтолцоог бий болгох ёстой. Үүнд нутгийн захиргааны байгууллага буюу сум, хороодын Засаг даргын тамгын газрын эсхүл гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын нэг чиг үүрэгт хамааруулан хэрэгжүүлэх боломжтой бөгөөд холбогдох хуулиудад тусган эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай.

3. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллагдсан этгээдийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажил эрхлэлтийг дэмжсэн төрийн бус байгууллага байгуулж, хөтөлбөр хэрэгжүүлэх.

Ашигласан эх сурвалж

1. Монгол улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992. №01
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №24
3. Р.Оюунбадам “Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалт” УБ., 2005 он
4. Б.Алтангэрэл, Б.Тэмүүлэн. “Хорих ял эдлүүлэх ажиллагаа” УБ., 2018 он
5. Грекийн сонгодог үеийн философич, математикч МЭӨ 428/427 – МЭӨ 348/347
6. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://Legalinfo.mn>
7. Шүүхийн шийдвэрийн цахим сан. <https://shuukh.mn>

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ (БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Баянзүрх дүүргийн Прокурорын газрын
ахлах прокурор А.Турдыбек

Хураангуй:

“Зорчих эрхийг хязгаарлах” гэсэн нэр томъёог судлан үзэхэд “зорчих” гэдэг нь хүн нэг зүгийг чиглэн зорчих, ийш тийш зорчин явах, “эрхийг хязгаарлах” гэдэг нь эрхийг нь багасгах, хэмжээ тогтоох, гэсэн утга илэрхийлж байгаагаас дүгнэвэл хүний чөлөөтэй зорчих хөдөлгөөнийг хязгаарлах гэж үзэж болно. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 18 дахь хэсэгт “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно”¹ гэж заасан. Иргэн бүр улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрхтэй бөгөөд иргэний энэ эрхэд хязгаарлалт тогтоож байгаа нь зорчих эрхийг хязгаарлах ялын онцлог юм.

Түлхүүр үгс: Зорчих эрх, эрхийг хязгаарлах, ял эдлүүлэх, хүний эрх.

Эрх зүйн зохицуулалт

Дэлхийн олон улс, үндэстэн эрүүгийн эрх зүйн ялын бодлого, түүнийг даган гарах хууль эрх зүйдээ хүний эрхийг хангаж, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлж, ялын чанга шийтгэлээс үндсэндээ татгалзаж, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох, хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг өргөн дэлгэр хэрэглэх чиг хандлагатай байна.²

Манай улсын хувьд хорих ялаас татгалзах, үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний онцлог байдалд тохирсон ял оногдуулах замаар ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 2015 оны Эрүүгийн хуульд шинэ төрлийн ял болох зорчих эрхийг хязгаарлах ял нэмж, хэрэгжилтийг нь цахим хэлбэрээр хянах нөхцөл бүрдүүлсэн.

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг хүнийг нийгэм, хамт олноос нь тусгаарлалгүйгээр хүмүүжүүлэх, шүүхээс хорих ял ихээр оногдуулж, дийлэнхийг нь биечлэн эдлүүлдэг байдлыг өөрчлөх зорилгоор 2015 оны Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялын шинэ төрлийг нэмж, уг ялыг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар оногдуулахаар зохицуулсан.

2002 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын ялын төрөлд ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ гэж байсан бол 2015 оны шинэчилсэн найруулгаар ял ба албадлагын арга хэмжээ гэж өөрчлөн найруулж, торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, зорчих эрхийг хязгаарлах, хорих гэсэн үндсэн, эрх хасах ялыг нэмэгдэл ялын төрлөөр хуульчилсан байна.

¹ Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992

² Б.Алтангэрэл.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ. 2018

Ийнхүү зорчих эрхийг хязгаарлах ялыг шинээр нэмсэн нь дэлхий дахины эрүүгийн эрх зүйн бодлого цаг үеийн онцлогоос хамаарч хувьсан өөрчлөгдөж, хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэх болсонтой холбоотой байна.

Бусад улсуудтай харьцуулах үзэх нь

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хөрш зэргэлдээ улс, орнуудад ямар байдлаар хэрэгжиж байгаа судлаад үзвэл:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсад /цаашид БНХАУ/ 2010 оноос эхлэн гэмт хэрэг үйлдсэн этгээд хууль сахиулах байгууллагын хяналт, хариуцлагаас зугтах, ял завшихыг оролдох арга хэлбэр улам нарийсаж, оргон зайлах явдал удаа дараа гарах болсон, түүнчлэн оргосон этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо нэмэгдсэн, сэжигтэн, яллагдагч, тэнсэн харгалзсан ялтанд биечлэн хяналт тавих боломжгүй байгаа зэрэг нөхцөл байдлыг харгалзан цахим хяналт тавих эрх зүйн орчин бүрдүүлж, хяналтын тоног төхөөрөмж бүрдүүлсэн байна.³

Улмаар цахим бугуйвч, хяналтын систем нэвтрүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдүүлж хяналт тавих боловсон хүчний асуудлыг шийдвэрлэснээр тус байгууллагын чадавх сайжирч, цахим хяналтыг тасралтгүй тавих нөхцөл, бололцоог бүрдүүлжээ.

Тус улсын Эрүүгийн хуулийн “Цахим бугуйвч хэрэглэх” гэсэн бүлэгт хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтан, өсвөр насны гэмт хэрэгтэн, цагдан хорих шаардлагагүй гэж үзсэн сэжигтэн, яллагдагчид цахим төхөөрөмж ашиглан байршлыг нь тогтоож, хяналт тавих зохицуулалт тусгажээ.

БНХАУ-ын прокурорын байгууллагаас шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүн, хэрэгжилтийг хангах зорилгоор цахим хяналтын үр дүнд шалгалт зохион байгуулж, тогтоосон хэм хэмжээ зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх үндсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг байна.

Оросын Холбооны Улсад /цаашид ОХУ/ 2001 оноос зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд цахим бугуйвч ашиглаж эхэлсэн байна. ОХУ-ын Засгийн газрын 2010 оны 198 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Ялтныг хянах аудио болон электрон техник, хэрэгслийн жагсаалт батлах тухай журам, Хууль зүйн сайдын 2010 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 258 дугаар тушаалаар батлагдсан “Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлэх журам”-аар тус ялыг эдлүүлэх нөхцөл, журмыг зохицуулж байна. Төхөөрөмжийг ОХУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дэргэдэх Мэдээлэл, техникийн хангамжийн төвд үйлдвэрлэдэг байна.

Гадаадын зарим орны гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зорчих эрхийг хязгаарлаж буй байдлыг судлан үзвэл ихэнх оронд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цахим бугуйвч зүүн хяналт тавьж байна. Зарим улс орнуудад зорчих эрхийг хязгаарлахыг таслан сэргийлэх арга хэмжээ болгон хэрэглэх тохиолдол ч байна.

Тулгамдаж буй асуудал

Тус Баянзүрх дүүргийн 2023 оны жилийн мэдээгээр зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн 373 ялтны хувийн хэрэгт хяналт тавьж ажилласнаас 69 буюу 18.4 хувьд нь ял солиулах прокурорын дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлсэн

³ Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт. УБ, 2022

байна. Үүнээс ял сольсон анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг эс зөвшөөрч 9 ялтан давж заалдах гомдол гаргаж, давж заалдах шатны шүүх 8 шийдвэрийг хэвээр үлдээж, 1 шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Харин 2024 оны эхний 2 сарын байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн 172 ялтны хувийн хэрэгт хяналт тавьж ажилласнаас 9 буюу 5.2 хувьд нь ял солиулах прокурорын дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлсэн байна. Үүнээс ял сольсон анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг эс зөвшөөрч 5 ялтан давж заалдах гомдол гаргаж, давж заалдах шатны шүүх хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.⁴

Ялтнуудын давж заалдах гомдлын агуулгаас харахад “...цахим бугуйвч цэнэг муу барьдаг, цахим бугуйвчийг унтраагүй, байнга шөнийн цагт унтардаг...” зэрэг байдлаар цахим бугуйвчийн хэвийн үйл ажиллагаатай холбоотой гомдол гаргажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 168 дугаар зүйлийн 168.1.6 дахь хэсэгт “тогтоосон журмын дагуу зөөврийн хяналтын төхөөрөмжийг биедээ байнга авч явах, бүрэн бүтэн байдлыг нь хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авах, хяналтын төхөөрөмжийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй” гэж заасан.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтнууд нь хяналтын төхөөрөмжийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүргээ биелүүлж байгаа боловч өөрөөс нь үл шалтгаалах байдлаар техникийн саатал гарч, эрх нь зөрчигдөх магадлалтай болж байна. Тухайлбал, цахим бугуйвчийн цэнэг дууссан тохиолдолд дахин цэнэглэхэд төвөгтэй, зориулалтын цэнэглэгчээр бүрэн цэнэглэсэн үедээ цэнэгээ барих хугацаа нь 10-12 цагийн хооронд байдаг тул цэнэглэлтийн хугацаа нь хүний зайлшгүй унтаж амрах цагт таарахыг үгүйсгэхгүй.

Нэгэнт унтарсан цахим бугуйвчийг зориулалтын цэнэглэгчээр бүрэн цэнэглэхэд дунджаар 1 цаг 30 минутын хугацаа зарцуулдаг байна. Энэ хугацаанд ялтныг техникийн хяналтын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг сарниулсан гэж ял солих үндэслэлд хамаарч байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 169 дүгээр зүйлийн 169.1 дэх хэсэгт “Ялтан гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног, төхөөрөмжийн зардлыг хариуцан төлөх үүрэгтэй” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтнуудаас сар бүр интернэтийн дата үйлчилгээ ашигласны төлбөрт 39.150 төгрөг хураан авч байгаа нь зорчих эрхээ хязгаарлуулсан ялтнуудад хүндрэлтэй байгаа, түүнчлэн 1 жилийн хугацаагаар зорчих эрхээ хязгаарлуулсан ялтан жилдээ 469.800 төгрөгийг дата ашигласны төлбөрт төлж байгаа нь ялтанд торгуулийн ял оногдуулсантай дүйцэхүйц хэмжээний төлбөр төлөгдөж байна гэж үзэхээр байна.

Дүгнэлт

Дэлхийн ихэнх улс орны эрх зүйн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байна.

⁴ Баянзүрх дүүргийн прокурорын газрын мэдээ. УБ.2024

Монгол Улсын хэмжээнд хорихоос өөр төрлийн ялыг илүү их өргөн хэмжээнд ашиглан, нийгмийн ач холбогдлыг өсгөх зорилго агуулан эрх зүйн шинэтгэлдээ тусгахаар ажиллаж байгаа билээ. Үүний нэг жишээ бол хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр зорчих эрхийг хязгаарлах ялыг Эрүүгийн хуульдаа тусган нэвтрүүлсэн явдал юм.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Иймд цаашид зорчих эрхийг хязгаарлах ялын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, боловсронгуй болгох үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 169 дүгээр зүйлийн 169.1 дэх хэсэгт “Ялтан гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног, төхөөрөмжийн зардлыг хариуцан төлөх үүрэгтэй” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтнуудаас сар бүр интернэтийн дата үйлчилгээ ашигласны төлбөрт 39.150 төгрөг хураан авч байгаа нь зорчих эрхээ хязгаарлуулсан ялтнуудад хүндрэлтэй байгаа, түүнчлэн 1 жилийн хугацаагаар зорчих эрхээ хязгаарлуулсан ялтан жилдээ 469.800 төгрөгийг дата ашигласны төлбөрт төлж байгаа нь ялтанд торгуулийн ял оногдуулсантай дүйцэхүйц хэмжээний төлбөр төлөгдөж байх тул дата ашигласны төлбөрийг ялтнаас гаргуулахгүй байх.

Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтнуудын дийлэнх нь “...цахим бугуйвч цэнэг муу барьдаг, цахим бугуйвчийг унтраагүй, байнга шөнийн цагт унтардаг ...” зэрэг байдлаар шүүх хуралдаанд тайлбар гаргаж, давж заалдах гомдол гаргаж байна.

Иймд зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд ашиглагдаж буй программ хангамжийн хэвийн нөхцөлийг хангаж цэнэгээ удаан хугацаанд хадгалдаг, бат бөх чанартай, цахим бугуйвч хэрэглээнд нэвтрүүлэх.

Ашигласан эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн Хууль (1992)
2. Монгол Улсын Прокурорын тухай хууль (2017)
3. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2002)
4. Б.Алтангэрэл "Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа" УБ. 2018
5. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт. УБ.2022
6. Баянзүрх дүүргийн Прокурорын газрын мэдээ. УБ.2024

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ЗАРИМ АСУУДЛУУД

Булган аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Г.Эрдэнэбаатар

Хураангуй:

Нийтэд тустай ажил хийлгэх ял эдэлж буй ялтны эрх, зөрчигдөж буй асуудал, нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, цаашид шийдвэрлэх арга замыг тодорхойлох талаар авч үзсэн болно.

Түлхүүр үгс: Нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөө.

Удиртгал

Монгол улс хүнлэг энэрэнгүй нийгэм байгуулах Үндсэн хуулийн үзэл баримтлалаа суурь зарчим болгож цаазаар авах ялыг халж, хорих ялыг илт хязгаарлах, шүүхээс хорихоос өөр төрлийн ялыг хэрэглэх нь өргөжиж, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх нь зүйтэй гэсэн хандлага давамгайлж, 2002, 2015 оны Эрүүгийн хуулиудад энэ талаар тусгагдаж хуулийн байгууллагууд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Өнгөрсөн зууны 80-аад онд дэлхий дахинд эхэлсэн улс төр, нийгэм эдийн засгийн өөрчлөлт нь эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэх давлагааг олон улсад түгээж, 1990-ээд оноос дэлхийн 50 гаруй улс Эрүүгийн хуулиа шинэчлэгдсэн.

Дэлхийн ихэнх улс орон Эрүүгийн хуулийг хүмүүнлэгжүүлэх, гэмт үйлдлийн шинэ төрлүүдийг эрүүжүүлэх чиг хандлага ажиглагдаж байна.¹

Үүний нэгэн адил Монгол Улс 2015 онд Эрүүгийн хуулиа Илтгэгч шинэчлэн баталсан бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.2 дугаар зүйлд хорихоос өөр ялын төрлийг торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих, эрх хасах хэмээн ангилсан байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ. Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно хэмээн хуульчилжээ.

Монгол Улсад өрнөсөн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хорих ялын үр нөлөө нь төдийлөн ач холбогдолтой байдаггүйг хүлээн зөвшөөрч аль болох хорихоос өөр төрлийн ялыг сонгож, гэмт хэргийн шинж байдлаас шалтгаалан ялыг ялгамжтай ногдуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэмд нь байлгаж, гэмт хэргийн хор

¹ Уранцэцэг.Т. Эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүй: Дэлхийн жишиг монголын туршлага. Монголын шүүх. II.түүхэн хөгжлийн тойм, өгүүлэл, нийтлэл. УБ.2016.103 дахь тал

аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг шинээр хуульчлан баталгаажуулсан байна.²

Эрүүгийн хариуцлагын ялын төрөлд нийтэд тустай ажил хийлгэх ялын шинэ төрөл бий болсон нь эрүүгийн хууль тогтоомж, ялын системийг хүмүүнлэг болгож, хувь хүнд боломж олгосон шинэлэг зохицуулалт болсон байна.

Хүний эрхийг хязгаарладаг эрүүгийн хууль тогтоомж нь хүний эрхийн суурь зарчим, хэм хэмжээнд нийцсэн байх нь хүний эрхийг зөрчихгүй байх, ял завшуулахгүй байх боломжийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой билээ. Иймээс энэхүү илтгэлээр нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөө, хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн анхаарах шаардлагатай зарим асуудлыг хөндөж байна.

Үндсэн хэсэг

Нийтэд тустай ажил хийлгэх ялын давуу тал нь гэмт хэрэгтнийг олон нийт, хамт олны дунд байлгаж, тодорхой хяналтын дор нийгэмд ашигтай хөдөлмөр эрхлэх боломжоор хангаж, хуульд заасан цагаар ажиллуулах замаар нийгмээс тусгаарлахгүйгээр ялыг эдлүүлдэг хүмүүнлэг ял юм.

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг эдэлж буй ялтан нь нэг талаараа цалин хөлсгүйгээр өөрийн сонирхсон чиглэлээр хүссэн ажлаа чөлөөтэй сонгох эрхийг нь хязгаарладаг хэдий ч нөгөө талаараа түүнд итгэл үзүүлэн, гэр бүлтэйгээ хамт байж, хөдөлмөрөөр хүмүүжин, амьдралд хэрэгтэй дадлага, туршлага эзэмшин, нийгмийн харилцаанд оролцон нийгэмших боломжийг олгож байдаг онцлогтой.

Харин хорих ял нь нийгэм, эдийн засгийн үр ашиг багатай, зардал ихтэй тул нийтэд тустай ажил хийлгэх ялыг оновчтой, өргөн сонголттойгоор хэрэглэх нь эдийн засгийн төдийгүй, хүмүүжлийн ач холбогдолтой хэмээн үзэж, улс орнууд шүүхийн практикт түгээмэл хэрэглэж байна.

Хорихоос өөр төрлийн ял оногдуулах тохиолдолд гэмт хэргийг бууруулах, зөв дадал, хэвшил суулгах, гэмт хэргийн хор уршиг, үр дагаврыг ойлгуулах, ухамсарлуулах гэх мэт эрүүгийн эрх зүйн тогтолцооны үндсэн зорилгод нийцүүлэн үр өгөөжтэй хэрэгжүүлэх, энэ төрлийн ял шийтгэлийг эдэлж буй хүнд үзүүлэх наад захын хамгаалалтыг тогтоож, хүний эрхийн стандартуудад нийцүүлэх нь практик хэрэгжилт, хэрэглээний хувьд ач холбогдолтой билээ.

Манай орны хувьд өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 2002 оны Эрүүгийн хуульд “Албадан ажил хийлгэх ял”, 2015 онд шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуульд “Нийтэд тустай ажил хийлгэх ял”-ын нэршилтэйгээр тус ялыг ашиглаж байгаа ч хэрэгжүүлэх арга хэлбэрийн хувьд онцын өөрчлөлт ороогүй талаар практикийн алба хаагч, судлаачид дурддаг.

Өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хуулиудад албадан ажил хийлгэх ялын талаар дараах байдлаар зохицуулсан. Үүнд: “Эрүүгийн хууль”-ийн 50 дугаар зүйлд “....хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхээр” хуульчилсан бөгөөд хэрэгжилтийг хэрхэн хангахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай

² Батгэрэл. Я. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2018. 95 дахь тал

хуулийн 96-98 дугаар зүйлд, “Шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 96.2-т “Шийдвэр гүйцэтгэх алба шийтгэх тогтоолыг хүлээж аваад 3 хоногийн дотор сум, дүүргийн Засаг даргад танилцуулж, аль байгууллагад албадан ажил хийлгэхийг тогтоолгон ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавина” гэж тус тус заасан.

Шинээр батлагдсан хуульд дараах байдлаар зохицуулсан.

Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйлийн 5.4.1-д “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ” гэж, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 163 дугаар зүйлийн 163.3-д “Шүүх ялтны мэргэжил, ур чадварыг харгалзан ялтанд тодорхой нийтэд тустай ажлыг хийхээр даалгасан тохиолдолд ялыг шүүхийн шийдвэрт заасан журмын дагуу гүйцэтгэнэ” гэж ялын ойлголт болон хэрэгжилтийг хэрхэн хангах талаар зохицуулсан байна.

Үүнээс үзэхэд:

-Өмнөх хуулийн зохицуулалтаар “....хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхээр тогтоосныг албадан ажил хийлгэх ял гэж”,

-Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд” гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэж...” агуулга болоод ялын зорилго, шинжийн хувьд огт өөр төрлийн байдлаар зохицуулсан ч хэрэгжүүлэх арга хэлбэрийн хувьд адил байна.

Эрүүгийн хуульд үндсэн ялын “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тусгай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ” гэж тодорхойлсон байдаг. Эндээс дүгнэхэд нийтэд тустай ажил хийлгэх ялын гол шинжүүд нь:

- Нийтийн ашиг сонирхол, нийгэмд тустай
- Цалин хөлсгүй
- Шүүхээс тогтоож өгсөн
- Албадлагын шинжтэй байх гэсэн шинжүүд хамаарсан байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй байхаар зохицуулсан.

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрэгжүүлж буй олон улсын жишигт дараах шинэлэг зохицуулалтууд байна. Тухайлбал:

1. Ялтан зөрчил гаргасан тохиолдолд заавал ч үгүй хорих ял оногдуулалгүйгээр засрал хүмүүжил олох хугацаа тогтоон өгч хууль сахиулах байгууллагын хяналтад нийтэд тустай хөдөлмөр эрхлүүлж, иргэн, нийгэмд учруулсан хохирлыг барагдуулах, засран төлөвших боломжтой гэж үзсэн тохиолдолд үргэлжлүүлэн тухайн ялыг бүрэн эдэлсэнд тооцдог .
2. Гэмт этгээд нь шүүхээс тогтоосон хугацаанд албадан хөдөлмөр эрхлэх, засран төлөвших боломжгүй тохиолдолд хорих ялаар солих боломжтой

3. Хорих ялыг эдэлж дуусахаас өмнө хөдөлмөр хийлгүүлэх мэргэжлийн чиг баримжаа олгох, нийгмийн амьдралд дасгах хэлбэрээр ялын бодлогыг ашиглаж байгаа зэрэг нь манай орны нөхцөлд тохирч болохуйц оновчтой жишиг байж болох юм.

Нийтэд тустай ажил хийлгэх ажлыг 720 хүртэлх цаг байхаар тогтоосныг багасгах нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь тухайн ял шийтгүүлсэн этгээд эрхэлсэн ажил төрөлтэй байх тохиолдолд өдөрт 2-оос дээшгүй цагаар ажиллуулах бөгөөд дээрх 720 цаг ажиллах хугацаа нь 360 хоног болж байна. Ял эдлэх хугацаа ийнхүү урт байгаа нь ажил эрхлэхгүй байх шалтаан болох бөгөөд ажил эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй ялтан ажлын байраа хаяж явах, ял эдлэхээс зайлсхийх нөхцөлийг бүрдүүлжээ. Энэ нь тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгтээ гэмшихээс илүү нийтэд тустай ажлыг олон сар хийснээс залхаж, хорих ялаар солиулж 1-3 сар хоригдох нь дээр гэх үзэл бодол үүсэж болзошгүй.

Олон улсын чиг хандлагын хувьд:

Дэлхийн Эрүүгийн загварын хуулийн 56-р бүлэг: Бусад шийтгэлийн хэлбэр болох Нийтэд тустай ажил хийх ялын талаар хуульчилжээ.

- Нийтэд тустай ажил нь үндсэн ялын нэг төрөл.
- Шүүх нэг болон хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгчийг 3 жилээс хэтрэхгүй хорих ялын шийтгэх шийдвэр ногдуулсан бол үндсэн хорих ялыг нийтэд тустай ажил хийх ялаар сольж болно.
- Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорих ялаар солиход ялтны зөвшөөрлийг заавал авсан тохиолдолд хэрэгжүүлнэ.
- Хорих ялыг шүүх нийтэд тустай ажил хийлгэх ялаар солихдоо уг ялын хугацааг тодорхойлох ёстой.
- Нийтэд тустай ажил хийх ялын доод хэмжээ нь 40 цагаас бага байхгүй ба 340 цагаас илүү их байж болохгүй.
- Нийтэд тустай ажлыг гүйцэтгэх хугацаа 6 сараас хэтрэхгүй байна.

Гадаад орнуудын туршлагаас үзэхэд нийгэмд тустай ажил хийлгэх ялын нийт хугацаа өндөр биш, ялтны хувийн байдлыг харгалзан өдөрт, долоо хоногт ажиллах хугацааг альтернатив байдлаар тогтоож өгсөн, мөн ял эдэлж дуусах хугацааг зааж өгсөн байгаа нь ялтан ажил эрхэлдэг байсан ч чөлөөт цагаараа ялаа эдлэх боломжтой, ялтны суурь эрх ашгийг харгалзсан зохицуулалттай байна.

Дэлхийн ихэнх улс орнуудад нийтэд тустай ажил хийлгэх ялын дээд хугацаа 500 хүртэлх цаг байдаг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шүүх дээрх ялыг оногдуулахдаа ялтны мэргэжил, ур чадварыг харгалзан ялтанд тодорхой нийтэд тустай ажлыг хийхээр даалгаж болохоор хуульд заасан бөгөөд шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэхээр хуульчилжээ.

Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэж, шийдвэр гүйцэтгэгч хяналт тавьж ажилладаг байхаар хуульчилж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/85 дугаар тушаалаар “Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалт”-ыг баталсан байх бөгөөд жагсаалтад төрийн өмчийн байгууллагуудын нэрсийн жагсаалтыг гарсан байдаг нь учир дутагдалтай. Үүний оронд ялтны хийж гүйцэтгэх ажлын жагсаалтыг батлахаар заасан бол оновчтой байх байсан болов уу.

Ялтны хийж буй дээрх ажлуудын чухам аль нь нийтэд тустай ажил мөн эсэхийг ялгахад төвөгтэй бөгөөд үүнийг нийтэд тустай ажилд тооцох нь эргэлзээтэй юм. Иймд байгууллагын бус нийтийн тусын тулд хийх ажлын жагсаалтыг гаргаж мөрдүүлэх нь үр дүнтэй байгаа юм.

Толь бичигт “Нийт” гэдгийг “ нийтийн санаа сэтгэл, олон түмэн, олон нийт”, “тус” гэдгийг задалж, “Улс нийгэмд тустай ажил” /улс нийгэмд ашиг тустай, нэмэртэй/, “олон нийтэд тустай хөдөлмөр” /олон нийтэд тус ихтэй, нэмэр болохуйц хөдөлмөр/, “ ашиг тустай /ашигтай, үр нөлөө ихтэй/ гэж тус тус тайлбарласан нь бий.³

“Нийтийн ашиг сонирхолд тустай ямар ажлыг нийтэд тустай ажил” гэх нэгдсэн жагсаалт одоо хэр гараагүй нь хүндрэл учруулж байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын агуулга Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт ерөнхийдөө тайлбарлагдсан байгаа бөгөөд гэмт хэрэг үйлдэж тухайн ялаар шийтгүүлсэн хүмүүс тодорхой хэмжээний эрхийн хязгаарлалтад ч өртдөг. Нийтэд тустай ажил хийлгэх ялын агуулгыг бүрдүүлэгч үндсэн элементүүд нь: 1. Хөдөлмөрлөх буюу ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх хязгаарлагддаг. 2. Цалин хөлс авах эрх хязгаарлагддаг. 3. Амрах эрхэд тодорхой хязгаарлалт тогтоодог юм. Бусад ялаас ялгагдах гол онцлог нь нийтэд тустай ажил хийлгэх ял цагаар тооцогддог цорын ганц ялын төрөл юм.

Мөн нийтэд тустай ажил хийлгэх ял нь эрүүгийн ялын тогтолцоонд тодорхой байр суурь эзэлсэн, ялын хугацааг нь цагаар тооцогддог хорихоос өөр төрлийн үндсэн ялын нэг бөгөөд насанд хүрсэн болон өсвөр насны хүнд оногдуулах боломжтой, тэнсэх, хугацаанаас өмнө суллах, ялын үндсэн хугацааг илүү хөнгөн ялаар солих боломжгүй, харин тухайн ялыг эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд хорих ялаар солих боломжтой байдгаараа онцлог юм.

Нийтийн ашиг сонирхолд тустай ажил гэдгийг зөвхөн хог цэвэрлүүлэх, цас арилгуулах хүрээнд ойлгож болохгүй. Гэмт хэрэг үйлдсэн хүний боловсролын түвшин, мэргэжил, эрхэлж буй ажил, авьяас, чадварыг харгалзан өсвөр насныханд яриа таниулга хийлгэх, лекц уншуулах, олон нийтийг соён гэгээрүүлэх ном бичүүлэх, уран бүтээл туурвиулах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний асаргаа, сувилгаа шаардлагатай хүнийг асруулах, өнчин хүүхдийн асрамжийн газар, номын сан, цэцэрлэгт хүрээлэн зэрэгт туслах ажиллах хэлбэртэй байж болно.

³ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.1966 он

Ялтны хийж гүйцэтгэх ажил бус ялтныг ажиллуулах байгууллагуудын жагсаалтыг гаргаж, баталсан бөгөөд заагдсан албан байгууллагуудад ажиллуулахад тухайн ялтны эзэмшсэн мэргэжил, ур чадварыг харгалзан ажиллуулах талаар хуульчилсан хэдий ч дээрх албан байгууллагын албан хаагчдын орон тоо бүрэн хангагдсан байдаг төдийгүй шүүхээр ял шийтгэгдсэн этгээдийг харж хянан ажиллуулах хүсэл сонирхол төдийлөн байдаггүй байна. Тиймээс нийтэд тустай ял шийтгэгдсэн ялтныг ихэвчлэн орон нутгийн тохижилт үйлчилгээний газарт хандан ажлын байраар хангаж ажиллаж байна.

Түүнчлэн ялтнаар хийлгэж болох бус хийлгэж болохгүй ажлын төрлүүдийн талаар тусгайлан хуульчилсан жагсаалт байхгүйгээс нийтлэг газар шороо, зам талбай цэвэрлэх зэрэг гадаа орчинд ажлын байранд хүйтэн, халуун аль ч улиралд өглөөнөөс үдэш хүртэл цалин хөлсгүй, эрүүл мэндийн хувьд эрсдэлтэй нөхцөлд гүйцэтгэж байгаа нь хүний эрх зөрчигдөх цаашлаад нийтэд тустай ажил хийх ялын үндсэн зорилго хангагдахгүй байх үндэслэлийг бий болгож байгаа юм.

Ялтныг “Цалин хөлсгүй ажиллуулна” гэдгийг урьтал болгож “үнэгүй ажиллах хүч” гэдэг ойлголтоор тэднийг хэн дуртай нь авч ажиллуулах нь хууль бус үйл ажиллагаа мөн. Байнгын ажлын байранд ялтныг ажиллуулах нь хууль зөрчиж буй хэрэг төдийгүй, аж ахуйн нэгж байгууллага цалингийн сангаа хэмнэж, ямар нэг зардал гаргахгүй ажиллах хүчнээр хангагдах гэсэн зүй бус зорилгыг хангахад хүргэдэг. Иймд ялтныг ямар нэг аж ахуйн нэгжүүдэд ажиллуулахаар шилжүүлэхдээ хийлгэх ажилд нь анхаарал хандуулах нь зүйтэй бөгөөд гүйцэтгэлд хяналт тавих субъектийн үйл ажиллагаанаас ихээхэн шалтгаална. Энэ нь юуны өмнө прокурор болон хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэгч албан тушаалтан болох хяналтын байцаагчид хяналт тавина.

Бодит байдалд нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэх ажлын байр нь тухайн орон нутагт хангалттай мэт боловч уг ялын талаарх олон нийтийн ойлголт хангалтгүй, ялтныг ажиллуулах практик туршлага байхгүй, ажил олгогч ялтныг ажиллуулах асуудалд болгоомжлох, сэрэмжлэх байдалтай хандах нь ялын хэрэгжилтэд бэрхшээл учруулж байна. Тиймээс нийтэд тустай ажил хийлгэх ялыг эдлүүлэх болон бусад төрлийн ялаас давуу байдал, ач холбогдол, ялтны гүйцэтгэж буй нийгэмд хэрэгтэй ажлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад үр нөлөөтэй арга хэрэгслээр байнга сурталчлах шаардлагатай юм.

Дүгнэлт

Нийтэд тустай ажил хийлгэх ялын бодлого, хэрэгжилт, хэрэглээ нь хүний эрхтэй салшгүй холбоотой хэрэгжих учраас хүний эрхийн суурь гэрээ конвенцод заасан зарчим хэм хэмжээтэй нийцүүлэх, түүнчлэн сайн туршлага бүхий улс орнуудын чиг хандлага бодлого зохицуулалтыг судлах, боломжит хувилбаруудыг харгалзан үзэж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй байна.

Улс орнуудын сайн жишгээс харахад нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрэглэхдээ гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо барагдуулах боломжийг нээж өгч, энэ чиглэлд тодорхой үүргүүдийг хүлээлгэдэг байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Нийтэд тустай ажил хийлгэх ялтай этгээдэд зан үйлд нөлөөлөх сургалтын үйл ажиллагааг журамлах

Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдийг ялтан бус этгээд гэж өөрчлөн хуульчлах /хүний эрх талаасаа хорих ял эдэлж байгаа этгээдийг хоригдол, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн этгээдийг ялтан гэж нэрлэж байгаа нь хорих ял эдэлж байгаа этгээдээс илүү нэр томьёоны хувд цээрлэл хүртэж байгаа хэлбэр юм./

Тухайн ялаар шийтгэгдсэн этгээдийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс байгаа газарт ялыг эдлүүлэх / Тайлбар: ШШГГ хуулийн 162.6 дахь хэсэгт зааснаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт оршин суух ялтны ял эдлүүлэх ажиллагаанд харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хяналт тавих бөгөөд ял эдлүүлэх ажиллагааны талаар 30 хоног тутам шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бичгээр мэдэгдэнэ” гэж байгаа нь тогтмол тавих хяналт хэрэгжихгүй, ял завших боломжийг бүрдүүлж байна/.

Насанд хүрсэн болон хүрээгүй этгээдийг нийтэд тустай ажил хийлгэх ялыг эдлүүлэхдээ ялгамжтай эдлүүлэх ажиллагаа журамлах

Энэ ялыг шүүхээс оногдуулахдаа шүүгдэгчийн санаа бодлыг харгалзах, тохиролцох боломжийг бүрдүүлэх саналтай байна.

Ашигласан эх сурвалж

1. Эрүүгийн хууль /2002, 2015 он/
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2015 он/
3. Уранцэцэг.Т. “Эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүй: Дэлхийн жишиг монголын туршлага. Монголын шүүх. II.түүхэн хөгжлийн тойм, өгүүлэл, нийтлэл”. УБ.2016.103 дахь тал
4. Батгэрэл. Я.Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2018. 95 дахь тал
5. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.1966 он
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, чиг хандлага. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 2020 он

ЭРХ ХАСАХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Баянзүрх дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Д.Батмөнх

Хураангуй:

Эрх хасах ял эдлүүлэх ажиллагаанд гарч буй хууль хэрэгжилтийн талаарх асуудлыг илрүүлж, хуулийг хэрэглэх явцад илэрч буй зөрүүтэй байдлыг залруулах, үүнтэй холбоотой санал дэвшүүлэн хэлэлцүүлж, шийдвэрлэх арга замыг олоход уг илтгэлийн үндсэн агуулга чиглэгдсэн.

Түлхүүр үгс:

Эрх хасах ял, сар бүрийн бүртгэл хяналт, хууль хэрэглээний зөрүүтэй байдал, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, прокурорын дүгнэлт.

Эрүүгийн хариуцлагын тухайд

Эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүнд үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хохирол, хор уршгийн хэмжээг харгалзан Эрүүгийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлагыг хүлээлгэдэг. Эрүүгийн хариуцлагын гол зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд орших ба Эрүүгийн хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ.

Ялын төрөл¹:

- торгох ял;
- нийтэд тустай ажил хийлгэх ял;
- зорчих эрхийг хязгаарлах ял;
- хорих ял;
- эрх хасах ял.

Эрх хасах ял нь гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зэрэг бусад тодорхой эрхийг нэгээс найм хүртэлх жилийн хугацаагаар, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэгээс арван хоёр хүртэлх жилийн хугацаагаар, эсвэл нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар нь хасаж буюу хориглож буй үйлдэл/шийдвэр юм. Дээрхээс харвал эрх хасах ял нь Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагын нэг төрөл учраас албадан биелүүлэх шинжийг өөртөө агуулна.

¹ “Эрүүгийн хууль” 5.2-р зүйлийн 1 дэх хэсэг, 2015 он

Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх асуудал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Иргэн, Эрүү, Захиргааны шүүхээс гарсан шийдвэрийг биелүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг иргэний, эрүүгийн, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэж ангилдаг.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамаарах эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцад тулгарч буй хууль хэрэглээний зөрүүтэй байдал удаа дараа давтагдаж цаашдаа буруу жишиг тогтож болзошгүй байна.

Эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан эрх зүйн хэм хэмжээг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажилладаг. Дээрх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг ахлах шийдвэр гүйцэтгэгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоол үйлдэж, түүний хувийг прокурорт 5 хоногийн дотор хүргүүлснээр эхэлж², шийдвэр гүйцэтгэгч 30 хоног тутам ялтантай уулзаж ярилцан тэмдэглэл үйлдэж, шаардлагатай лавлагааг авч, бусад байгууллагуудтай хамтран тогтмол хяналт тавьж³, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 155 дугаар зүйлийн 155.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгадаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 153 дугаар зүйлд зааснаар шийдвэр гүйцэтгэгч нь эрх хасах ялаар шийтгүүлсэн этгээдийг хүлээн авч эрх үүрэг танилцуулдаг. Эрх үүрэг танилцуулахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 180 дугаар зүйлийн 180.1 дахь хэсэгт заасны дагуу эрх хасах ялын хэрэгжилтийг хангах хүрээнд 30 хоног тутам шийдвэр гүйцэтгэгчтэй уулзан тайлбар өгч, тэмдэглэл хөтөлдөг болохыг хэлж сануулдаг. Гэвч эрх хасах ялаар шийтгүүлсэн ялтнууд нь сар бүрийн бүртгэл хяналтад тодорхой хугацааны туршид орохгүй байх зөрчлийг нийтлэг гаргадаг. Энэхүү зөрчлийг арилгуулахын тулд шийдвэр гүйцэтгэгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.1 дэх хэсэг⁴т зааснаар эрх хасах ялаас зайлсхийж байгаа зөрчил гаргасан гэж үзэн зөрчлийн хэрэг үүсгэж шийтгэлийн хуудас оногдуулдаг. Гэвч зөрчлийн хэрэг үүсгэж, оногдуулсан шийтгэлийн хуудсыг Нийслэлийн прокурорын газрын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хариуцсан хяналтын прокурор хүчингүй болгох тухай прокурорын дүгнэлт үйлдэж, тэр дүгнэлтэд үндэслэн шүүхээс шийтгэлийн хуудсыг хүчингүй болгох шийдвэрийг нийтлэг гаргаж байгаа нь хууль хэрэглээний зөрүүтэй байдлыг үүсгэж байна.

Тухайлбал, Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 51 дүгээр шийтгэх тогтоолоор Э.О нь Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 2 жилийн нийтийн албанд томилогдох эрх хасах ялаар шийтгэгдсэн. Ялтан Э.О нь 2022 оны 9 дүгээр сараас 2023 оны 8 дугаар

² “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 153 дугаар зүйлийн 153.2 дахь хэсэг, 2017 он

³ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 180 дугаар зүйлийн 180.1 дахь хэсэг, 2017 он

⁴ ШШГТХ 184-р зүйлин 184.1 дахь хэсэг “Ялтан эрх хасах ялаас зайлсхийсэн, эсхүл шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

сарын 31-ний өдрийг хүртэл сар бүрийн бүртгэл хяналтад ороогүй бас шийдвэр гүйцэтгэгч урьдчилан сануулж, ярилцлага хийсээр байхад Монгол улсын хилээр гарч явсан зөрчил гаргасан. Иймд ахлах шийдвэр гүйцэтгэгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.1 дэх хэсэг заасны дагуу ялтны гаргасан зөрчилд зөрчлийн хэрэг үүсгэн, Зөрчлийн тухай хуулийн 15.27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэх хуудас оногдуулсан байна. Үүний дараа эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгуулах тухай прокурорын дүгнэлт гарсан ба уг дүгнэлтэд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 180 дугаар зүйлд зааснаар ялтантай сар бүр уулзах, хяналт тавих шаардлагагүй. Шүүхээс тусгайлан үүрэг хүлээлгээгүй байхад сар бүрийн бүртгэл хяналтад ороогүй гэх үндэслэлээр зөрчлийн хэрэг үүсгэж хүний эрхэнд халдсан.” хэмээн өнгөцхөн дүгнэсэн.

Эндээс харахад ялтанд давуу байдал үүсгэж, ялтан өөрийн хүссэн үедээ ирж болохоор ойлгогдож байгаа нь туйлын харамсалтай. Мөн шүүгчийн захирамжийн үндэслэл хэсэгт ялтан сар бүр бүртгүүлэхгүй байх нь зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага тооцуулах үндэслэл болохгүй буюу ял эдэлж буй ялтанг гэмт үйлдэл, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөлийг шүүхээс тогтоон нийтийн албанд томилогдох эрх хасах ялаар шийтгэсэн байхад ялтан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн сар бүр бүртгүүлэх заалтыг хэрэгжүүлэхгүй байх нь зөв гэж дүгнэсэн нь хууль хэрэглээний хувьд зөрүүтэй, илтэд үндэслэлгүй шийдвэрлэсэн гэж ойлгогдохоор байна.

Дүүргийн прокурорын газрын ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хяналтын прокурор нь эрх хасах ял шийтгүүлсэн ялтны ял эдлэлтийн байдалд хяналт тавихдаа ялтны хувийн хэрэгтэй нэг бүрчлэн танилцаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2017 оны 09 дүгээр сарын 07-ны А/103, А-234 дугаар тушаалаар баталсан “Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-д заасны дагуу эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн тогтоол, эрх үүрэг танилцуулсан баримт, шүүхийн шийдвэр биелүүлэх мэдэгдэл, сар бүр уулзан тэмдэглэл хөтөлж тогтмол хяналт тавьж байгаа эсэхийг шалгаж, үүрэг чиглэл өгдөг. Ингэхдээ сар бүр уулзахгүй байгаа ялтнуудыг дуудаж уулзан тайлбар авах, сар бүр тогтмол хяналт тавихыг даалгадаг. Гэвч Нийслэлийн прокурорын газрын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хариуцсан хяналтын прокурорууд харилцан адилгүй дүгнэлт хийж шийтгэлийн хуудсыг хүчингүй болгож, ялтан сар бүр ирж уулзах шаардлагагүй гэсэн дүгнэлт хийж байгаа нь ял эдлүүлэх ажиллагаанаас ялтан зайлсхийх, үүргээ биелүүлэхгүй байх боломжийг бий болгож байна гэж үзэхээр байна.

Дүгнэлт

Эрүүгийн хариуцлагын гол зорилгын дагуу эрх хасах ял эдэлж байгаа ялтан сар бүр тогтсон хугацаанд ирж ял эдлэлтийн байдалтайгаа холбоотой тайлбар өгч байх ёстой байтал Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хариуцсан хяналтын прокурор болон шүүхээс сар бүр ирэх шаардлагагүй хэмээн хууль хэрэглээг ялгаатай ойлгож, хэрэгжүүлж байгаа нь хуулийг нэг мөр хэрэглэх зарчмыг зөрчиж байна. Үүнээс гадна ял эдлэх хугацаанд ялтан хүссэнээрээ ирж тайлбар өгнө, заавал ирэх шаардлагагүй гэдэг нь эрүүгийн хариуцлагын цээрлүүлэх зорилгыг няцааж буй хэлбэр юм. Мөн ялтан

мэдсээр байж сар бүрийн ярилцлагаас зайлсхийж байгаа нь тухайн ялтанд тавих хяналтыг сулруулж, ялын биелэлтийг хангахад хүндрэл учруулдаг.

Нэгтгэж дүгнэхэд, Шүүх, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийг нэг агуулгаар ойлгож хэрэгжүүлэх ёстой байтал харилцан адилгүй шийдвэрлэж байгаа нь хууль хэрэглээний зөрүүтэй байдлыг үүсгэж байна.

Санал

Дээрх зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн 15.27 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн хуулийн 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 болон 2.2 дахь заалтын дагуу зөрчлийн хэрэг үүсгэн, шийдвэрлэж байх нь зүйтэй байна.

Цаашид хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлж буй асуудлыг энэхүү илтгэлээр хөндөж байгааг минь хүлээн авч, шийдвэрлэж өгнө үү гэх санал хүсэлтийг гаргаж байна.

Ашигласан эх сурвалж

1. Эрүүгийн хууль, 2015 он
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017 он
4. Зөрчлийн тухай хууль, 2017 он
5. Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам, 2017 он

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫН ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АРГА ЗАМ

Баянгол дүүргийн Прокурорын газрын хяналтын прокурор Э.Анударь

Хураангуй:

Энэхүү илтгэлд ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийг хангах, хамгаалахтай холбоотой онол, арга зүй, практик, өнөөгийн байдал, дүр төрхийг хөндсөн, цаашид тулгамдаж буй асуудлыг анхаарч ажиллах болон судалгааны үр дүнгийн талаар санал дүгнэлт багтаасан болно.

Түлхүүр үгс: Ял, ял эдлүүлэх ажиллагаа, нийтэд тустай ажил хийлгэх ял, хүний эрх.

Удиртгал

Хүний эрх нь үндсэн хуулийн болон олон улсын хууль тогтоомжид үндэслэлтэй, хүн бүрийн эрх ашиг, өршөөл, хүндэтгэлийг хангах зарчимд суурилдаг. Ял эдлүүлэх ажиллагаа нь шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үйл ажиллагааны нэг хэсэг бөгөөд энэ процесст хүний эрхийн зөрчил гаргахгүй байх нь нэн чухал ач холбогдолтой.

Ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийн онол ба практикийг хэрэгжүүлэх нь ял шийтгүүлсэн этгээдийн эрх ашгийг хамгаалах, мөн тэднийг нийгмийн харилцаанд оролцоход эерэг өөрчлөлт оруулахад чиглэгддэг ба энэхүү илтгэлээр ял эдлүүлэх ажиллагааг илүү хүний эрхийн хүрээнд хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлууд, түүнд чиглэсэн зөвлөмж, шийдвэрлэх боломжтой арга замуудыг гаргахыг хичээлээ.

Үндсэн хэсэг

1. Ял эдлүүлэх ажиллагааны онол, арга зүй, зарчим, үзэл баримтлал дахь хүний эрхийн асуудал;

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургаадугаар зүйлд прокурорын байгууллагын чиг үүргийг “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”¹ гэж,

Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлд прокурор ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихдаа:

- Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ биелүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;
- Ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн эсэх;
- Ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэх;
- Баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэхийг хянана гэж тус тус тодорхойлсон² байдаг.

¹ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.

² Прокурорын тухай хууль. 2017 он.

Ял эдлүүлэх ажиллагаа нь хууль тогтоомжийн хүрээнд явагдах бөгөөд шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Энэхүү онол нь:

Шийтгэл ба Засал чанар: Ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт этгээдэд оногдуулсан шийтгэлийг хэрэгжүүлэхээс гадна түүнийг нийгмийн харилцаанд эерэг өөрчлөлт оруулахад чиглэсэн байх ёстой. Энэ нь гэмт хэрэгтнийг засах, нийгмийн амьдралд бэлэн болгох зорилготой.

Хүний эрхийн хамгаалалт: Ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь чухал. Энэ нь ял шийтгүүлсэн этгээдийн нууцлал, нэр төрийг хүндэтгэх, мөн тэдний эрх ашгийг хамгаалахыг хэлнэ.

Нийгмийн оролцоо: Ял эдлүүлэх ажиллагаа нь нийгмийн оролцоотой байх ёстой. Энэ нь ял шийтгүүлсэн этгээдийг нийгмийн үйл ажиллагаанд оролцуулах, нийгмийн төсөл, хөтөлбөрт хамруулах зэрэгт чиглэгддэг.

Тогтвортой байдлыг хангах: Нийгмийн амьдралд эргэн оруулахад туслахаас гадна тэднийг дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилготой.

Тэгш байдлыг хангах: Ял эдлүүлэх ажиллагаа нь хуульд заасан тэгш байдлыг хангах ёстой. Энэ нь эрүүгийн хариуцлага оногдуулахдаа бүх этгээдүүдэд адил тэгш нөхцөл байдал үүсгэх зарчимд суурилсан гэхэд дөхнө.

2. Хорих, торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн асуудал;

Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлд “Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.”³ гэж заасан байдаг.

Хорих ялын тухайд авч үзвэл: Хорих ял нь гэмт хэрэгтнүүдэд олгогдох хамгийн хүнд шийтгэл юм. Энэ нь тодорхой хугацаагаар эсвэл бүх насаар нь тэднийг нийгмээс тусгаарлах зорилготой байдаг. Хорих ялын үзэл баримтлал нь нийгмийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх, мөн тэднийг ирээдүйд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг.

Ингэхдээ тухайн хүний холбогдсон гэмт хэргийн байдлыг шударгаар шалгаж, шүүхийн шийдвэрийн тэгш байх зарчмыг хэрэгжүүлэх, хоригдлуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлуудад анхаарах, эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх, амьдрах нөхцөл байдлыг хүний эрхийн стандартуудад нийцүүлэх, гадаад орчинтой харилцах, захидал бичих, утсаар ярих зэрэг эрхүүдийг хязгаарлагдмал байдлаар хангах ёстой.

Торгох ялын тухайд авч үзвэл: Торгох ял нь тухайн этгээдийн хувийн байдал, эрүүл, мэнд, үйлдсэн гэмт хэрэгт нийцүүлэн тодорхой хугацаагаар торгуулж, тэднийг нийгмийн харилцаанд эерэг өөрчлөлт оруулахад чиглэсэн байдаг. Энэ нь гэмт

³ Эрүүгийн хууль. 2015 он.

хэрэгтэнд хоёр дахь боломжийг олгож, ирээдүйд нийгмийн харилцаанд эерэг үүрэг гүйцэтгэхэд туслах зорилготой юм.

Зорчих эрхийг хязгаарлах ялын тухайд авч үзвэл: Гэмт этгээдийг гэр бүл, нийгмийн харилцаанаас тусгаарлалгүй тодорхой хугацаанд, тодорхой байршлуудад зорчих эрхийг хязгаарлагдмал байдалтай байлгаж, тэдэнд хяналт тавихад чиглэгддэг. Нийгмийн аюулгүй байдлыг хангах зорилготой байж болдог.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын тухайд онцлон авч үзвэл: Нийтэд тустай ажил хийлгэх ял нь нийгмийн ашиг сонирхлыг хангах, нийтийн үйл ажиллагаанд эерэг хувь нэмэр оруулах, нийтэд тустай ажил хийх явцад шинэ ур чадвар, хариуцлагын мэдрэмжийг хөгжүүлж, хувийн хүний хөгжилд сайнаар нөлөөлөх, хорих ялын системд дарамт үүсгэхгүй байх зорилготой байдгаараа олон давуу талтай.

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэхдээ ажиллах нөхцөл, цаг хугацаа нь тухайн хүний эрхийн стандартуудад нийцсэн эсэхийг харгалзан үзэж, тэдний нэр төрийг хүндэтгэх, хувийн нууцыг хамгаалахад чиглэсэн байвал тэдний нийгмийн оролцоо, өөрсдийн санал бодлоо цэгцлэх, нийгмийн харилцаанд эерэг үүрэг гүйцэтгэхэд туслах боломжтой.

Хэдий ч хэрэгжүүлэхэд хүндрэлтэй: Нийтэд тустай ажил хийлгэх ялыг зохион байгуулах, хяналт тавих, мөн үр дүнг нь үнэлэх нь цаг хугацаа, нөөц боломж ихээр шаарддаг.

Ял эдлэлтэд харьцангуй бага ач холбогдолтой: Зарим тохиолдолд гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн этгээдүүд нийтэд тустай ажил хийлгэх ялыг хүнд шийтгэл биш гэж үздэг бөгөөд энэ нь тэднийг цээрлүүлэх үр дүнг бууруулдаг.

Нийгмийн харилцааны сөрөг нөлөөлөл: Зарим тохиолдолд ялтнуудыг нийгмийн харилцаанд оролцоход сөрөг нөлөөлөл үзүүлж болдог. Жишээлбэл, тэднийг хүлээн зөвшөөрөлгүй ялгаварлан гадуурхах, нийгмийн харилцаанд дэмжлэг үзүүлэхээс татгалзах байдал үүсдэг.

Үр дүн хэмжихэд хүндрэлтэй: Ял эдлэлтийн байдал, үр дүнг хэмжих нь хүндрэлтэй. Учир нь түүний нөлөөлөл нь удаан хугацаанд илэрдэг бөгөөд заримдаа тодорхойлоход хэцүү байдаг.

Хувь хүний нөхцөл байдалд анхаарахгүй байдал: Нийтэд тустай ажил хийлгэх ял нь ялтны хувийн нөхцөл байдал, хэрэгцээ, урам зоригийг үнэлэхгүй байснаар тэдний нийгмийн харилцаанд эерэг өөрчлөлт оруулах чадвар, сэтгэлзүйг бууруулж магадлалтай. Бусад улс орнуудад нийтэд тустай ажил хийлгэх ял (community service) нь олон янз байдаг бөгөөд тэдгээрийн зарим нь дараах байдлаар хэрэгждэг байна.

Америкийн нэгдсэн улс: Community service in law enforcement гэдэг нь хууль сахиулах агентлагууд нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хууль зүйн боловсрол олгох, болон нийгмийн харилцааг сайжруулах зорилгоор хэрэгжүүлдэг нийгмийн үйлчилгээний хөтөлбөрүүдийг хэлнэ. Энэ нь цагдаагийн газар, шүүхийн байгууллага, бусад хууль сахиулах агентлагуудтай хамтран ажиллахыг хэлнэ. Шүүгчид уламжлал ёсоор бол хөнгөн гэмт хэрэг болон анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүст гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө нийгэмд хүлээсэн өрийг барагдуулахын тулд шүүгдэгчдийг цалингүй олон нийтийн ажил хийлгэх ялаар шийтгэж болдог. Олон нийтийн үйлчилгээ

нь замын хажуугийн хогийг цэвэрлэхээс эхлээд сургууль дээр архи ууж, машин жолоодох аюулын талаар ярих зэрэг олон хэлбэрээр явагддаг. Шүүгчид энэ ялын хувилбарыг олон нийтэд ашигтайгаар ашиглаж, гэмт хэрэгтэнд нөлөөлнө гэж найдаж байна.⁴

Австрали улс: Австралид шүүхээр шийтгүүлсэн этгээдэд олгогддог бөгөөд нийгмийн үйлчилгээ нь хууль зүйн систем, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, болон бусад салбаруудад хэрэгждэг. Жишээ нь Эрүүл мэндийн байгууллагуудад тусламж үзүүлэх, мэдээлэл түгээх, байгалийн гамшигт үзэгдэлд тусламж үзүүлэх, олон нийтийн газруудыг засварлах, нийгмийн төвүүд, асрамжийн газар, асаргаа үйлчилгээ шаардлагатай эмзэг бүлгийн хүмүүст туслалцаа үзүүлэх гэх мэтээр хэрэгжүүлж байна.

Дүгнэлт

Дээрхээс дүгнэхэд нийтэд тустай ажил хийлгэх ял нь нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэн нийтийн үйл ажиллагаанд эерэг хувь нэмэр оруулж, нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтад туслах, ажиллах хүч, хүний нөөцөөр хангах боломжийг бүрдүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих мөн хорих ялын системд дарамт, ачаалал үүсгэхгүй байх зэрэг олон давуу талтай.

Монгол Улсын Нийтэд Тустай Ажил Хийлгэх Ял (Community Service) нь хорих ялын оронд олгодог сонголтын ял юм. Энэ нь ял шийтгүүлсэн этгээдийг нийгэмд эерэг үйлдэл хийхэд уриалж, тэдний буруу үйлдлийг засахад чиглэгдсэн байдаг боловч манай оронд төдийлөн оновчтой оногдуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд нь хяналт тавьж чаддаггүй.

Бүр зарим аймаг, орон нутагт бүр нийтэд тустай ажил хийлгэх ялын төрлийг сонгож хэрэглэдэггүй байдал ажиглагддаг нь нуултгүй юм.

Энэ төрлийн ялыг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэлүүдийг даван туулахын тулд зохион байгуулалт, хяналт, болон үр дүнгийн үнэлгээг сайжруулахад чиглэсэн тодорхой, үр нөлөөтэй ажлыг зохион байгуулах, судалгаа хийх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйлд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шуурхай байдлыг хангах зорилгоор энэ хуульд заасан ажиллагааг гүйцэтгэхэд цахим мэдээллийн сүлжээ ашиглаж болно.”⁵ гэж заасныг хэрэгжүүлж ажиллахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт дэмжлэг үзүүлэн хамтран ажиллавал хөдөө, орон нутгийн алслагдсан газарт ял шийтгүүлсэн этгээдэд тавих шийдвэр гүйцэтгэгчийн хяналт тэр хэмжээгээр сайжрах, төсөв санхүү хэмнэгдэж боломжтой.

2. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхдээ түлхүү оногдуулах, орчин үеийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ажиллах хүний нөөц дутагдалтай байдаг олон нийтийн байгууллагуудад ажиллуулах, ахмад настан, хүүхдийн асрах төвүүдэд туслалцаа үзүүлэх, нийгмийн арга хэмжээнүүдэд оролцуулах зэрэг ажлуудыг хийлгэж болно.

⁴ www.nolo.com

⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он.

Ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд уг ялын хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаснаар нийгмийн хариуцлагыг сурталчлах, ард иргэд, нийгмийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх, хүндлэх, хуулийг дээдлэх итгэл төрүүлэх нь гарцаагүй юм. Мөн нийт иргэд дунд нийгмийн хариуцлагыг ухамсарлуулж, нийгмийн харилцаанд эерэг үүрэг гүйцэтгэхэд чиглүүлэх ба хорих ялыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, нөөц боломжийг тодорхой хувиар бууруулах ашиг тустай.

Ашигласан эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Прокурорын тухай хууль. 2017 он.
3. Эрүүгийн хууль. 2015 он.
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он.
5. www.nolo.com

ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА БА ТҮҮНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТ, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ

Сүхбаатар дүүргийн Прокурорын газрын ахлах прокурор П.Мөнхтуяа

Хураангуй:

Тус илтгэлийн хүрээнд “Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа ба түүнд тавих прокурорын хяналт, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах нь” сэдвийн хүрээнд Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, хэрхэн шийдвэрлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээхэд хэрхэн анхаарах талаар асуудлыг дэвшүүлж байна.

Илтгэлийн хүрээнд улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан гүйцэтгэх баримт бичгийн статистик тоо мэдээ, бодит биелэлтийн хувь хэмжээг харьцуулан судлах, өссөн, буурсан шалтгаан нөхцөлийг тогтоох, зөрчлийн шийтгэл, албадлагын арга хэмжээг бусад улс орнууд хэрхэн хэрэгжүүлж байгаа болон сайн туршлагыг судалж, нэвтрүүлэх талаар санал санаачилгыг дэвшүүлэхэд чиглэн дүгнэсэн болно.

Түлхүүр үгс: Зөрчил, прокурорын хяналт, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, хүний эрх.

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц...хууль зүйн...баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасны дагуу иргэдийн хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг хамгаалахын тулд иргэний болон эрүүгийн, захиргааны, зөрчлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг зайлшгүй биелүүлэх зарчимтай.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.” гэж заасан бөгөөд зөвхөн Улсын дээд шүүх бус бүх шатны шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг заавал биелүүлэх зарчмыг тодотгожээ.

Хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл бөгөөд төгсгөлийн шат юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь шүүхээс гарсан шийдвэрийг албадан биелүүлж, бусдын хуулиар хамгаалагдсан эрх ашгийг бодит байдлаар сэргээхэд оршдог. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэр зэрэг байна.

Шүүхийн шийдвэрийг биелүүлэх, биелүүлээгүй тохиолдолд албадан гүйцэтгэх тухай зохицуулалт нь эрүү, иргэн, захиргааны, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх талаар салбар процессын хуульд зохицуулсан байдаг. Үүнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар /6.1 зүйл/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэж дөрөв ангилан үзнэ.

Шүүхийн тухай хууль /32 дугаар зүйл/: Шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй.

- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /32.1/-д Шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /37.3 дугаар зүйл/-д. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх.
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /12 дугаар зүйл/-д Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль /9.3 дугаар зүйл/-д Шүүгчийн шийтгэл оногдуулсан шийдвэрийг биелүүлэх.¹

Шүүхийн тухай хууль /32.2/ Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол албадан гүйцэтгэнэ.

- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 37.2 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх.
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 12 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх.
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 9.3 дугаар зүйл. Шүүгчийн шийтгэл оногдуулсан шийдвэрийг биелүүлэх.

/32.3/ Шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй бол хариуцлага хүлээлгэнэ.

- Зөрчлийн тухай хууль 15.27 дугаар зүйл. “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх”
- Эрүүгийн хууль 21.7 дугаар зүйл. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх” гэж хуульд тусгасан.

¹ 2 Шүүхийн тухай хууль 32 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх. “32.1.Шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хувь хүн, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй.”, “32.2.Шүүхийн шийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ.”, “32.3.Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

Үндсэн хэсэг

Монгол Улсын Их Хурлаас 2017 онд баталсан Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 17 бүлэг 252 зүйл, 1058 хэсэг, 958 заалттай бөгөөд тус хуулийн тусгай ангид нийт 2300 орчим үйлдлийг зөрчилд тооцож, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах зохицуулалттай байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлд эрх бүхий албан тушаалтан оногдуулсан шийтгэлийн биелэлтийг хариуцах, дээрх шийтгэлийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд 15 хоногийн дотор сайн дураар биелүүлэх, торгох шийтгэлд заасан торгуулийг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр төлөхөөр заасан.

Иргэдийн орлогын түвшин, эрх зүйн ухамсар зэрэг хүчин зүйлээс хамааран эрх бүхий албан тушаалтны хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэж шийтгэл оногдуулсан шийдвэрийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд хуульд заасан хугацаанд сайн дураар биелүүлэхгүй байх, шийтгэлээс зайлсхийх явдал нийтлэг байгаагаас шийтгэл оногдуулсан шийдвэр биелэгдэхгүй удаашрах, хуульд заасан шийтгэлийн үр нөлөө буурах зэрэг сөрөг үр дагавар гарч байгаа нь нийгмийн дэг журам, олон нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх хуулийн зарчим алдагдах явдал юм. ²

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 139 дүгээр зүйлд зааснаар зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл нь:

- торгох шийтгэл оногдуулсан шүүгчийн шийтгэх хуудас;
- баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэр;
- шүүхээс гүйцэтгэх хуудас олгосон зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулан хураан авах тухай шийдвэр;
- хохирол, нөхөн төлбөр гаргуулах тухай шийдвэр;
- албадан эмчилгээ, албадан сургалтад хамруулах тухай шүүхийн шийдвэр;
- гадаадын иргэнийг саатуулах тухай шүүхийн шийдвэрүүдэд зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар заасан.

Өөрөөр хэлбэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 15 дугаар бүлэгт заасан торгох, баривчлах шийтгэлийг оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах, хохирол, нөхөн төлбөр гаргуулах шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн эрх хасах, нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг гүйцэтгэх ажиллагаа хамаарна.

² 5 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 9.3 дугаар зүйлийн 9.3.1 дэх хэсэгт “Шүүгчийн торгох шийтгэл оногдуулсан шийдвэрийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор сайн дураараа биелүүлэх үүрэгтэй.” гэж заасан. 6 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 138 дугаар зүйлийн 138.1 дэх хэсэгт “ шийтгүүлсэн этгээд зөрчлийн хэргийн талаарх хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг хууль болон шийтгэл, албадлагын арга хэмжээ оногдуулах тухай шийдвэрт өөрөөр заагаагүй тохиолдолд нэн даруй биелүүлэх үүрэгтэй.” байхаар заасан байна.

Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан талаар статистик тоо мэдээ
/сүүлийн 5 жилийн байдлаар/

Д/д	Үзүүлэлт	Торгох шийтгэл		Мөнгөн дүн		Албадлагын арга хэмжээ		Зөрчлийн үр дагавар арилгах		Бодит биелэлтийн хувь хэмжээ
		Хүн	Хуулийн этгээд	Хүн	Хуулийн этгээд	Хүн	Хуулийн этгээд	Хүн	Хуулийн этгээд	
1	2019	2019	416	841,268.5	7,525,931.5	38	1	27	10	91.1
2	2020	1921	361	592,168.5	5,401,342.9	49	26	34	11	83.7
3	2021	2073	288	945,292.7	2,692,118.9	137	19	54	16	85.8
4	2022	3098	395	1,653,502.3	3,506,468.3	97	76	21	7	86.9
5	2023	5894	302	1,983,098.8	3,672,797.0	75	46	30	8	92.0

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн статистик тоо мэдээний үзүүлэлтээр сүүлийн 5 жилийн байдлаар улсын хэмжээнд зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 87,6 хувь, гүйцэтгэх баримт бичгийн тоо нэлээдгүй өссөн хэдий ч мөнгөн дүнгийн хувь хэмжээ ижил түвшинд байгаа нь шийтгэлийг албадан биелүүлэх ажиллагааны үр нөлөө, биелэлт хангалтгүй, шийтгэлийг сайн дураар биелүүлэх шинэ арга механизм, оновчтой хувилбарыг бий болгох шаардлагатай байгааг дээрх хүснэгт харуулж байна.

Мөн шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх, түүнийг биелүүлээгүй тохиолдолд албадан биелүүлэх талаар хуульд тусгасан боловч шүүхийн шийдвэрийг санаатайгаар биелүүлээгүй, зайлсхийсэн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх талаар анхаарах, зохицуулалтгүй үлдсэн гэж болохоор асуудал байна.

Ийнхүү шүүхийн шийдвэрийг сайн дураараа заавал биелүүлэх зарчмыг зөрчсөн тохиолдолд хувь хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх ёстой. Зөрчлийн хууль болон эрүүгийн хуульд “шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх, санаатайгаар зайлсхийх тухай” зөрчил, гэмт хэргийг заасан байх боловч дээрх хуулийн заалтад шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй арга, үйлдэл, зорилгыг тоочсон байх нь зарим санаатай үйлдэл, аргыг орхигдуулах, гэмт хэрэг зөрчилд тооцох боломжгүй болгох эрсдэлтэй байна.

Энэ нь иргэн, аж ахуй нэгжийн зөрчигдсөн эрхийг сэргээх, тэдгээрийн эрх, ашгийг хамгаалах боломжийг хязгаарлаж буй хэрэг юм. Иймээс дээрх тодорхойгүй, орхигдуулсан хэм хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалтыг нэмэх, шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс санаатай зайлсхийж байгаа тохиолдолд хүлээлгэх хариуцлагын зохицуулалтыг мөн боловсронгуй болгох шаардлагатай байна.

Иймд Зөрчлийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр тусгагдсан торгуулийг цаг тухайд нь төлсөн тохиолдолд тодорхой хувийг хөнгөлөх зохицуулалт бий болсон

талаар олон нийтэд мэдээлэх, сурталчлан таниулах, энэ талаар эрх бүхий албан тушаалтнуудаас зөрчлийн холбогдогчид тайлбарлан ойлгуулснаар зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд аливаа эрх бүхий байгууллагын шийдвэрийг шуурхай биелүүлэх, эрмэлзлийг төрүүлэх, эрх бүхий албан тушаалтны шийтгэлийн хувь хэмжээ өсөх, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын ачаалал тодорхой хэмжээгээр буурах боломжтой юм.

Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад торгох шийтгэл, албадлагын арга хэмжээг албадан гүйцэтгэхэд хүний эрх, эрх чөлөө, төр, нийтийн ашиг сонирхлыг зөрчиж буй дараах тохиолдлуудад дүгнэлт хийлээ.

Нэг. Бусдын өмчлөлд буй газрыг хохирол нөхөн төлүүлэх зорилгоор гадаадын иргэнд шилжүүлэн өмчлүүлэхээр хөрөнгийн шилжилт хөдөлгөөн хийх эрх бүхий байгууллагуудад даалгах, тухайн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн зургаадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон бусад хуульд заасан болзол, журмаар ашиглуулж болно” гэж заасан байгаагаас дүгнэхэд тухайн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх нь хуульд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийх шаардлагатай болж байна.

Хоёр: Эрх бүхий албан тушаалтнаас “иргэдээс орон сууцныхаа дээвэр хэсэгт холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, батлагдсан зураг төсөлгүйгээр 1 давхар мансард бүхий байгууламж нэмж, өргөтгөлийн барилгын угсралтын ажил гүйцэтгэсэн...” зөрчил үйлдсэн гэж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаар Зөрчлийн тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан зөрчил үйлдсэн гэж дүгнэн торгох шийтгэл, зөвшөөрөлгүй барилга угсралтын ажил гүйцэтгэсэн зөрчлийн үр дагавар арилгах албан даалгавар өгч шийдвэрлэсэн.³

Эрх бүхий албан тушаалтнаас торгох шийтгэл оногдуулсан шийтгэлийн хуудсыг зөрчлийн холбогдогчид танилцуулан гарын үсэг зуруулж, зөрчлийн үр дагавар арилгах талаар албан даалгаврыг танилцуулаагүй, улмаар эрх бүхий албан тушаалтан шийдвэрийн биелэлтийг хангуулахаар зөрчил үйлдсэнээс хойш 4 жилийн хугацаа өнгөрсөн байхад албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргаж, шүүх хүсэлтийг хүлээн авч гүйцэтгэх хуудас бичигдсэнээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан.

Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Зөрчлийн тухай хуулийн 3.7 дугаар зүйлд зөрчлийн үр дагавар арилгах ажиллагаа нь “...эрх бүхий албан тушаалтан зөрчлийн үр дагаврыг арилгах, учирч болзошгүй хохирол, хор уршгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна...”, “...тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол зөрчил илэрсэн өдрөөс үйл ажиллагааг зогсооно...” гэж;

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...эрх бүхий албан тушаалтан өөрийн санаачилгаар, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлээр зөрчлийн үр дагаврыг арилгах зорилгоор ариутгах, хоргүйжүүлэх,

³ 8 Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн Шүүхийн эрүүгийн хэргийн статистик мэдээ. 2016 он.

цэвэршүүлэх, засвар үйлчилгээ хийх, холбогдох бүтээгдэхүүнийг борлуулахыг хориглох, иргэний гүйлгээнээс буцаан татах, хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоох, энэ талаар олон нийтэд зарлан мэдээлэх зэрэг арга хэмжээ авч болно...” гэж тус тус хуульчилсан.

Гэтэл “...зөрчилд холбогдогч нь зөрчлийн үр дагаврыг арилгуулах эрх бүхий албан тушаалтны даалгаврыг биелүүлээгүй, зөрчлийн үр дагаврыг арилгах эрх бүхий албан тушаалтны даалгавартай танилцсан, эс зөвшөөрч шүүхэд гомдол гаргаагүй...” үндэслэлээр “...эрх бүхий албан тушаалтны албан даалгавар... буюу /1 давхар өргөтгөлийн барилгыг буулгаж анхны төлөв байдлаар нь ашиглах/ тогтоосон хугацаанд биелүүлээгүй тул албадан гүйцэтгэх...” гэж хуульд заасан дээрх арга хэмжээнд хамаарахгүй үндэслэлээр шийдвэрлэсэн нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар гүйцэтгэх боломжгүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хүний өмчлөх эрхэд ноцтойгоор халдах, шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд эргэлзээтэй нөхцөл байдал үүсгэж байна.

Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй энэхүү үйлдэл нь цаг хугацааны хувьд биелэгдэх боломжгүй буюу шүүхийн шийдвэрт зааснаар “...барилга угсралтын үйл ажиллагааг 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн хуулийн хэрэгжилтийг хангах хүртэл түр зогсоох...” тухай арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний дотор Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт бичгээр ирүүлэх...” албан даалгаврыг албадан гүйцэтгэхээр шийдвэрлэсэн боловч хэрэгжүүлээгүй нь эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотойгоор албадан гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Албадан гүйцэтгэх ажиллагаа эцэстээ шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төгсдөг тул хүндрэл нь эрх бүхий албан тушаалтан шийтгэл, албадлагын арга хэмжээ оногдуулсан шийдвэр болон биелүүлээгүй тохиолдолд албадан гүйцэтгэх талаар зөрчлийн холбогдогчид ойлгуулан танилцуулдаггүй, энэ талаарх иргэдийн эрх зүйн мэдлэг дутмаг байгаагаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад хүндрэл үүсгэж байна.

Дээрх тохиолдлуудын тухайд зөрчлийн үр дагавар арилгах албадлагын арга хэмжээг эрх бүхий албан тушаалтан өөрийн санаачилгаар, эсхүл Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл бүхий арга хэмжээ авах, тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоох, энэ талаар олон нийтэд зарлан мэдээлэх зэрэг арга хэмжээ авч, хэрэв зөрчлийн үр дагаврыг арилгах тухай эрх бүхий албан тушаалтны даалгаврыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд биелүүлээгүй, эсхүл энэ арга хэмжээний зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлнэ гэж заасан нь тухайн цаг хугацаанд биелэгдэх боломжтойгоор хуульчилсан байхыг бусдын өмчлөл, эзэмшилд байгаа эд хөрөнгө, хөрөнгийн эрхэд халдаж, албадан буулгах ажиллагаа хийлгүүлэх мэтээр шийдвэрийг гүйцэтгүүлэхээр ирүүлсэн нь үндэслэлгүй юм.

Эд юмсын эрх зүйн харилцаанд аливаа тохиролцоо нь зөвхөн хуулиар зөвшөөрөгдсөн агуулгатай байх ёстой. Өөрөөр хэлбэл, эд юмсын эрх зүйн харилцаанд зөвхөн хуульд тусгасан хэлбэрүүд л зөвшөөрөгдөнө.

Иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулах, бусдын хууль ёсны эрх, эрх чөлөөнд халдсан зөрчлийн үр дагаврыг арилгуулах нь зүй ёсны юм.

Орон сууцны барилгын сууц өмчлөгчдөд тухайн сууцны барилгын орших газарт өмчийн ямар эрхтэй байх, бусад этгээдэд өмчлөх эрх нь шилжсэн барилга байгууламжийн өмчийн эрхийн эрх зүйн үндсийг хэрхэн тодорхойлох, учир нь эзэмшил хэмээх ойлголт нь иргэний эрх зүйн шинжлэх ухаанд өмчлөх эрхийн илрэн гарах хэлбэр гуравдагч этгээдэд өмчийн эрхийн талаар мэдээлэл өгөх зорилготой факт юм.

Иймд эзэмшлийг эрхийн хандлагаар бус илүүтэй бодит байдлын хандлагаар тодорхойлдог бөгөөд эзэмшилд шилжүүлэхгүй зөвхөн ашиглах эрхэд шилжүүлнэ гэсэн ойлголт байх нь боломжгүй зүйл гэж үзэхээр байна.

Нийтлэг эрх зүйн орнуудад өмчийн эрхийн төрлүүдийг эзэмшлийн ба эзэмшлийн бус хэмээн ангилдаг. Үүнд:

- ийзмент буюу үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэх зорилгоор өөр үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчийн эрхийг хууль, гэрээнд заасан тохиолдолд тэргүүн ээлжид хязгаартай ашиглах, өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшилсан үйл ажиллагаа явуулахгүй байхыг бусад өмчлөгчид даалгах, сервитутаар эрх нь хязгаарлагдсан өмчлөгчөөс сервитут бүхий талын үл хөдлөх эд хөрөнгийн хувьд зарим эрх хэрэгжүүлэхийг хязгаарлах харилцаа;
- үр ашиг хүртэх эрх;
- зөвшөөрлөөр нэвтрэх эрх буюу газрын эрхийг бусдад шилжүүлэх бус харин бусдын газар дээр тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөх харилцаа, ковенанц буюу өмчийн зэрэг эрхүүдийг хамааруулдаг.

Хууль ёсны өмчлөгчийг хамгаалж, хууль бус эзэмшлээс чөлөөлүүлэх, эзэмшилд саад учруулж буй үйлдлийг зогсоох зэрэг өмчлөл, эзэмшлийг хамгаалах зохицуулалтууд иргэнлэг эрх зүйн системд байдаг.

Ийнхүү өмчлөх эрхийг хамгаалах үндэслэл, шаардлага нь түүний халдашгүй туйлын байдлаар тодорхойлогддог бол эзэмшлийг хамгаалах үндэслэл, шаардлагын талаарх онолын маргаан, тайлбарууд XIX зуунаас өрнөсөөр байна.

Үзэл баримтлалыг авч үзвэл өмчлөгч нь эзэмших жинхэнэ эрхтэй этгээд бөгөөд эзэмшил бол бодит нөхцөл байдал юм.

Харин өмчлөл нь эзэмших хууль нөхцөлийг бий болгож, эд хөрөнгөтэй өөрийн хүссэнээр харьцах буюу бусад бүх этгээдийн халдлагаас хамгаалах эрх юм гэж тайлбарласан.

Манайд үүсээд буй дээрх зөрчилтэй байдлын үндсэн шалтгаан нь эдгээр нөхцөл байдалд тохирсон өмчийн эрхийн төрлийг материаллаг хуульд суулгаж өгөөгүйтэй холбоотой. Тодруулбал, манай улсын Иргэний хуульд нийтийн зориулалттай орон сууцны барилгын сууц өмчлөгчдийн өмчийн эрхийн төрлийг холбогдох хуульд бүрэн төгс хүлээн зөвшөөрч сууц өмчлөгчдийн газрын эрхийг баталгаажуулах цогц зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Ийнхүү зохицуулах боломж Иргэний хуулийн 85.1 дэх хэсгээр бүрэн нээлттэй байна.

Иргэний хуулийн 85.1-д “...Устгах буюу зориулалтыг нь алдагдуулахгүйгээр салгаж үл болох бүрдэл хэсэг нь хуульд заасан тохиолдолд иргэний эрх зүйн харилцааны бие даасан объект болно...” гэж заасан.

Гурав. Зөрчлийн тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийн төрлийг нэмж хуульчилсан.

Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлд “...торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг” байхаар заасан.

Мөн хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “...эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол шийтгэлийн хэмжээг 50 хүртэл хувиар нэмэгдүүлнэ...”, 3.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...зөрчил үйлдсэн хүн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу торгох шийтгэлийг биелүүлээгүй бол шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэнэ...”, 3.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...шүүх нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно...” гэж зааснаас үзэхэд торгох шийтгэлийг нэмэгдүүлсэн хэмжээгээр заасан хэмжээний мөнгөн дүнг нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр солихоор ойлгоно.

Гэтэл хүнд долоон мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээнээс дээш мөнгөн дүн бүхий торгуулийн шийтгэлийг нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр солих тохиолдолд хуульд заасан нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийн дээд хэмжээ болох долоон зуун хорин цагийн хугацаанаас дээш тогтоогдож байна.

Дүгнэлт, санал

- Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг баталгаажуулсан албадан гүйцэтгэх шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой тодорхой биш асуудлыг шийдвэрлүүлэхээр прокурор дүгнэлт үйлдэж шийдвэрлүүлэх хууль, эрх зүйн механизмыг бий болгох;
- Хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр гадаадын иргэнд гэмт хэргийн улмаас учруулсан хохиролд тооцуулахаар бусдын өмчлөл, эзэмшилд байгаа газрыг шилжүүлэхээр шийдвэрлэсэн эрүүгийн болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж буй шүүхийн шийдвэр бий эсэхийг судалж, шүүхийн шийдвэрийн хохирол, хор уршиг нөхөн төлүүлэхтэй холбоотой хэсэгт гарсан тодорхой биш асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээх;
- Зөрчлийн үр дагавар арилгах албадлагын арга хэмжээний биелэлт, үр дүн нь эрх бүхий албан тушаалтан зөвшөөрөлгүйгээр барилга, байгууламж барьсан зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагаа ашиглалтыг зогсоох, тодорхой хугацаанд биелүүлэх хугацаа тогтоож үр дагаврыг арилгуулах, тухайн үр дагавар биелэгдээгүйгээс үүсэх хор уршиг, хариуцлагыг танилцуулах байдлаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны оролцогчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг зөрчихгүйгээр шийдвэрлэхээр хуульчилсан.
- Иймд шүүхээр албадан гүйцэтгүүлэхээр заасан зөрчлийн үр дагавар арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Зөрчлийн тухай хуулийн 3.9 дүгээр зүйл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлд заасан үндэслэл, шаардлагын хүрээнд хэрэгжүүлэх, шүүхийн шийдвэрт хүн, хуулийн этгээдийн өмчлөх эрхэд хууль бусаар халдах мэтээр ойлгож хэрэгжүүлсэн дээрх тохиолдлыг зөвтгүүлэх, зөрчлийн үр дагавар арилгах арга хэмжээг албадан гүйцэтгэх шийдвэрийг сайн дураар биелүүлэхээр тогтоосон хугацаа дууссан

даруид шүүхэд хүсэлт тавьж шийдвэрлүүлэх, шүүх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор шийдвэрлэж, гүйцэтгэх хуудас бичигдэж шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлэх хууль зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах нөхцөл бүрдэнэ.

- Мөн зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх талаар хууль түүнд нийцүүлсэн журам, заавар батлан гаргаж шуурхай хэрэгжүүлснээр ял эдлүүлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчихөөс урьдчилан сэргийлэгдэж, прокурорын хяналтын ажлын үр нөлөө, чанар сайжирна гэсэн дүгнэлтийг тус илтгэлээр дэвшүүлэн тавьж байна.

Ашигласан эх сурвалж

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх албанаас илтгэлтэй холбоотойгоор гаргуулан авсан судалгаа;
2. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль;
3. Харьцуулсан хувийн эрх зүй 2018 он. С.Должин
4. Н.Баярмаа /ЧДИХАШШүүгч/, Газрын эрхийн үндэс: Өмчийн ба үүргийн эрх 2018 он
5. Гадаад орны прокурорын байгууллагын бүтэц, чиг үүргийн талаарх харьцуулсан судалгаа. УЕПГ-ын Сургалт, судалгааны хүрээлэн 2021 он

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

Чингэлтэй дүүргийн Прокурорын газрын ахлах прокурор Х.Жанибек

Хураангуй:

Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар нийтэд тустай ажил хийлгэх ял, ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн онолын үндэслэл, мөн чанар, хууль зүйн агуулга, практик ач холбогдлын талаарх ойлголт, цаашдын хандлагыг тодорхойлж, эрүүгийн эрх зүйн шударга ёсны болон хүмүүнлэг энэрэнгүй ёсны зарчмуудын харилцан хамаарлын хүрээнд авч үзэж эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулахад энэ илтгэлийн зорилго оршино.

Энэхүү илтгэлийг бичихдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч нараас нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх явцад ялтны ялыг хуульд заасны дагуу эдлүүлэхгүй ялтны эрхийг зөрчдөг асуудлыг судлан дүгнэх, Казакстан, ОХУ зэрэг улсуудын эрүүгийн хуулийн зохицуулалттай харьцуулан дүгнэх, ангилан төрөлжүүлэх зэрэг арга зүйг сонгосон юм.

Түлхүүр үгс:

Эрүүгийн хариуцлага, нийтэд тустай ажил хийлгэх ял, ял шийтгэлийн зорилго, ял оногдуулах, ялтны эрх, ялтны эзэмшсэн мэргэжил, ур чадвар, энэрэнгүй ёс, шударга ёс.

Удиртгал

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгон тунхагласан.

Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2: Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ, 3: Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 : Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Арван зургаадугаар зүйл : иргэдийн амьд явах эрхийг тунхагласан.¹

Үндсэн хууль Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод хүний эрх чөлөөг хангах, хүний эрхийн баталгаа, эрхийг нь зөрчихгүй эдлүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн.

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Монгол улсын Эрүүгийн хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний

¹ Монгол Улсын Үндсэн хууль, 1992, УБ.

Монгол Эрүүгийн хууль. УБ. 2021 он.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенци

болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино гэж, Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.

2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримтална.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг хууль бусаар ашиглах, зохих зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно гэж тодорхойлж хуульчилж өгсөн нь ялтны ялыг эдлүүлэхдээ эрхийг зөрчихгүй байх хууль эрх зүйн үндэс суурийг тавьсан гэж үзэж байна.

Үндсэн хэсэг

Монгол улсын Эрүүгийн хуульд Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэж,

Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно гэж,

Ялтан нийтэд тустай ажил хийлгэх ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар солино гэж тус тус тодорхойлсон.

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй гэж хуульчилсан бөгөөд шүүхээс оногдуулсан нийтэд тустай ажил хийлгэх ялыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага эдлүүлдэг.

1. Шийдвэр гүйцэтгэгчээс ялтныг ажиллуулах ажлын байр тухайн тойрогт байхгүй гэсэн үндэслэлээр ялтныг өөр тойрогт шилжүүлэх санал гаргаж ялтны эрхийг зөрчдөг зөрчил.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 162.4 дахь хэсэгт Нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг ял шийтгүүлсэн этгээдийг байнга оршин суугаа хаягийн дагуу гүйцэтгэж, тухайн тойргийн шийдвэр гүйцэтгэгч хяналт тавина, 162.5 дахь хэсэгт Ялтныг ажиллуулах ажлын байр тухайн тойрогт байхгүй, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаан байгаа бол шийдвэр гүйцэтгэгч нь ялтныг өөр тойрогт шилжүүлэн ял эдлүүлэх саналаа ахлах шийдвэр гүйцэтгэгчид танилцуулж, прокурорт хүргүүлж, шийдвэрлүүлнэ гэж заасан.²

Нийслэлийн дүүргүүдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч нараас нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/88 дугаар тушаалаар “нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалтын хавсралтаар батлагдсан нэр дурдсан дүүргийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх 17 байгууллагатай гэрээ байгуулан ажилддаггүй зөвхөн дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨТААҮГ, эсвэл хог хаягдлын цуглуулалт тээвэрлэлт, хот тохижилтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компанитай гэрээ байгуулах төдийхнөөр ялтныг ажлын байрыг хязгаарласнаас ялтныг ажиллуулах ажлын байр тухайн тойрогт байхгүй гэж үндэслэлгүй санал гаргахад хүргэж байна.

Ялтны ялыг үндэслэлгүйгээр өөр тойрогт шилжүүлэн эдлүүлэх нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг ял шийтгүүлсэн этгээдийн байнга оршин суугаа хаягийн дагуу гүйцэтгэх хуулийн заалтыг зөрчиж байгаа, мөн ялтан оршин суугаа хаягийн дагуу нийтэд тустай ажил хийх эрх нь зөрчигдөж байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас дээрх жагсаалтын хавсралтаар батлагдсан нэр дурдсан дүүргийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх 17 байгууллагатай гэрээ байгуулан ажиллахгүй байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ”, 163 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Нийтэд тустай ажил хийлгэх байгууллагыг сонгохдоо ялтны эрүүл мэндийн байдал, эзэмшсэн мэргэжил, ур чадварыг харгалзан ахлах шийдвэр гүйцэтгэгч ажиллуулах байгууллагыг тогтоох заалтыг хэрэгжүүлэн ажиллахгүй байгаатай холбоотой байна.

2. Шийдвэр гүйцэтгэх байгууллага нийтэд тустай ажил хийлгэх ялтны эрүүл мэндийн байдал, эзэмшсэн мэргэжил, ур чадварыг харгалзан эдлүүлэхгүй эрхийг зөрчсөн зөрчил.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ”, 163 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Нийтэд тустай ажил хийлгэх байгууллагыг сонгохдоо ялтны

² Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017, УБ.

эрүүл мэндийн байдал, эзэмшсэн мэргэжил, ур чадварыг харгалзан ахлах шийдвэр гүйцэтгэгч ажиллуулах байгууллагыг тогтооно” гэж заасан байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/88 дугаар тушаалаар “нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалт”-ыг баталж, жагсаалтын хавсралтаар батлагдсан нэр дурдсан дүүргийн засаг даргын эрхлэх асуудлын хүрэн дэх 17 байгууллагад болон Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид нийтэд тустай ажил хийлгэхээр заасан. Шийдвэр гүйцэтгэх байгууллага нь дээрх жагсаалтад нэр дурдсан байгууллагуудтай нийтэд тустай ажил хийлгэх гэрээг байгуулан ажиллаагүйгээс ялтанд дээрх байгууллагад нийтэд тустай ажил хийлгэх талаар мэдээлэл өгдөггүй, мэргэжлийн дагуу нийтэд тустай ажил хийх эрхтэйг тайлбарлаж өгдөггүй нь ялтны эрхийг зөрчиж байгаа нөхцөл байдал тогтоогдож байна.

Дээрх хуулийн агуулгаас үзэхэд ялтанд түүний эрүүл мэндийн байдал, эзэмшсэн мэргэжил, ур чадварыг харгалзан нийтэд тустай ажлыг хийлгэх нь ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зарчимд нийцэж байгаа бөгөөд шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ялыг мэргэжлийн ур чадвар харгалзахгүй хог тээврийн ачигч болон зам талбайн цэвэрлэгээний ажил хийлгүүлж байгаа нь ялтны эрх зүйн байдлыг доордуулж эрхийг нь зөрчиж байна.

График 1. Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2023 оны байдлаар нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны судалгаа /насны байдлаар/




Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цахим сан.

Графикаас харвал 18-39 насны ажил эрхлэх чадвартай ялтнуудын тоо давамгайл байна. Тэдгээр ялтнуудын эзэмшсэн мэргэжил, ур чадварыг харгалзан эрх зүйн байдлыг нь дордуулахгүйгээр тохирсон байгууллагад ажил хийлгэх боломж, бололцоо дутмаг байна. Үүнээс улбаалан энэ төрлийн ялаар шийтгүүлсэн ялтнууд ял солиулах тохиолдол нийтлэг ажиглагдаж байна.

3. Ялтан нийтэд тустай ажлыг хийхдээ тухайн ялтныг ажиллуулж байгаа байгууллага нь нийтэд тустай ажил хийлгэх гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлээгүйгээс ялтны эрх зөрчигддөг явдал түгээмэл байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.4 дэх хэсэгт Шийдвэр гүйцэтгэгч ялтныг ажиллуулах байгууллагатай ялтны нэг өдөрт ажиллах цаг, гүйцэтгэх үүрэг /хөдөлмөрийн норм/, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын хувцсаар хангах, ажиллах нөхцөлийг урьдчилан тохиролцож, гэрээ байгуулна, 163.5 дах хэсэгт “Гэрээнд ялтны ургийн овог, эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүнчлэн ажил хийх цаг, ялтны зан байдал, хүмүүжил, ял эдлэлтийн талаарх тодорхойлолтыг батлагдсан загварын дагуу үйлдэж, гэрээнд заасан хугацаанд ирүүлэх үүргийг тусгана гэж заасан. Гэрээнд ямар ажлыг хэдэн цагаар хийлгэх талаар тодорхой тусгадаггүй, гэрээнд хийх гүйцэтгэх үүрэг /хөдөлмөрийн норм/ ийг тодорхой тусгасан ч нийтэд тустай ажлыг хийлгэж байгаа байгууллага нь ялтнаар янз бүрийн ажил хийлгэж байгаа нь ялтны эрхийг зөрчиж байна.

График 2. 2023 оны байдлаар Чингэлтэй дүүргийн хэмжээнд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн 129 ялтны ялаа эдлэн ажиллаж буй газар



Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цахим сан.

Дээрх графикаас дүгнэвэл энэ төрлийн ялаар шийтгүүлсэн ялтнуудын ялаа эдлэх байгууллага, нийтэд тустай ажлын чиглэл нь зөвхөн цас цэвэрлэх, гудамж, талбай, зам байгууламж цэвэрлэх, хог ачих зэрэг ажлууд байгаа юм. Гэтэл 2023 онд гэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын “Нийтэд тустай ажил хийлгүүлэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалтад заасан бусад байгууллагуудад ялтныг ажиллуулсан тохиолдол байхгүй байгаа нь энэ төрлийн ялаар шийтгүүлсэн хүний эрх зүйн байдлыг дордуулах нэг хүчин зүйл болж байна.

4. Ялтнаас төрийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад гаргасан хүсэлт гомдлыг шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хуульд заасны дагуу шийдвэрлэж ажилладаггүйгээс ялтны эрх зөрчигдөж байна.

Ял эдлүүлэх ажиллагааны явцад ялтан этгээдээс гаргасан гомдол хүсэлтийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэж хариу мэдэгдэх, дээд шатны албан тушаалтан, прокурорт гомдол гаргах эрхийг хангаж ажиллахгүй байгаа нь ялтны эрх зөрчиж байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч нараас ялтнаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад гаргасан гомдол хүсэлтийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу байгууллагын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй гар дээрээс авч ялтны хувийн хэрэгт хийдэг боловч шийдвэрлэж хариу мэдэгдэх, дээд шатны албан тушаалтан, прокурорт гомдол гаргах эрхийг нь тайлбарлаж хангахгүй байгаа нь ялтны эрх зөрчигдөх, шүүхээр ял солиулах асуудлыг хэлэлцэхдээ ялтны эрхийг хангаагүй үндэслэлээр ял солихгүй байх нөхцөл байдалд хүргэхээр байна.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189. 1 дэх хэсэгт Сум, дүүргийн Засаг дарга үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд шүүхээс даалгасан үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх талаар зохих туслалцаа үзүүлж, хамтран ажиллана гэж заасан байна. Хуулийн энэхүү зохицуулалтын хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч нараас нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/88 дугаар тушаалаар “нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалтын хавсралтаар батлагдсан нэр дурдсан дүүргийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх 17 байгууллагатай гэрээ байгуулан ажиллах үүрэгтэй.

Хүснэгт 1. 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Чингэлтэй дүүргийн хэмжээнд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны судалгаа

№	Нас /тоо,хувь/	Хүйс /тоо, хувь/	Боловсрол, мэргэжил /тоо, хувь/	Нийтэд тустай ажлыг хаана эдлүүлсэн /тоо,хувь/
1	18-29 нас-11 30-39 нас-11 40-49 нас-1 50-59 нас- 3	Эр-19 Эм-6	Боловсролгүй- 1 Бага боловсролтой- Бүрэн бус дунд боловсролтой-3 Бүрэн дунд боловсролтой-15 Дээд боловсролтой-3 Тусгай боловсролтой-3	Чингэлтэй дүүргийн ТҮК- “Найши трейд” ХХК-д 24 ялтан, Хайрхан хөгжлийн төв-1 ОНӨТҮГ-1 ялтан тус тус ажиллаж байна.

Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цахим сан.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль:

Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас нийтэд тустай ажил хийлгэх ялыг эдлүүлэх талаар албан бичгээр дээрх жагсаалтад нэр заасан төрийн 17 байгууллагад ханддаг ч дээрх байгууллагын дарга, эрхлэгч, захирал зэрэг удирдах албан тушаалтнууд нь “ялтан” гэдэг утгаар хүлээн авч байгууллагадаа ажиллуулахаас татгалздаг, ажиллуулах боломжгүй талаар хариу өгдөг байна. Тухайн байгууллагад нийтэд тустай ажил хийлгэх юм уу хийлгэх юм уу гэдэг асуудал нь тухайн байгууллагын даргын үзэмжийн асуудал болж төрийн байгууллагын албан хаагчид хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүйгээс ялтны эрх зөрчигдөж байна.

Дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ” гэж заасны дагуу шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/88 дугаар тушаалаар “нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалтын хавсралтаар батлагдсан нэр дурдсан дүүргийн засаг даргын эрхлэх асуудлын хүрэн дэх 17 байгууллагатай гэрээ байгуулахаар ханддаг боловч дээрх байгууллагаас энэ ажлыг хийлгэх сонирхолгүй байдгаас, нөгөө талаар төрийн байгууллагад өөрийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа нь ялтан дээрх байгууллагад ялыг мэргэжил ур чадварын дагуу эдлэх эрхээ эдэлж чадахгүйд хүргэж байна.

Ял эдлүүлэх ажиллагааны явцад ялтан этгээдээс гаргасан гомдол хүсэлтийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэж хариу мэдэгдэх, дээд шатны албан тушаалтан, прокурорт гомдол гаргах эрхийг хангахгүй байгаагаас эрх нь зөрчигдөж байна.

Санал

Энэхүү илтгэлийн сэдвийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/88 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах дүүргийн засаг даргын эрхлэх асуудлын хүрэн байгууллагуудад Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зорилго зорилт, нийтэд тустай ажил хийлгэх ялын агуулга мөн чанар, нийтэд тустай ажлыг зайлшгүй хийлгэх хэрэгцээ шаардлагыг танилцуулан ойлгуулах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, ялтны эрх зөрчигдөхөөс сэргийлэх, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Ялтнаас гаргасан өргөдөл гомдол хүсэлтийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэж байгаа байдлыг 2023 оны

байдлаар улсын хэмжээнд судлан холбогдох арга хэмжээ авах саналыг дэвшүүлж байна.

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын 1986, 2002, 2015 оны Эрүүгийн хуулиуд
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он
4. Казакстан ОХУ-ын Эрүүгийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиуд

Ном, сурах бичиг:

5. Д.Зүмбэрэллхам "Хорихоос өөр төрлийн ял болон хорих ялын альтернатив" 2009 он. УБ.
6. Г. Гантөмөр нар. Эрүүгийн эрх зүй ерөнхий анги (сурах бичиг) УБ. 2022 он
7. О. Батсүх. Эрүүгийн эрх зүй ерөнхий анги. УБ. 2021 он.
8. С. Нарангэрэл. Монгол улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. УБ. 2021 он
9. Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл УБ. 1999 он.
10. Монгол, Орос улсын эрүүгийн хууль. УБ. 2021 он.
11. Улсын Дээд шүүх, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангаас эрхлэн хэвлүүлсэн Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2010 он

Шүүхийн шийдвэр:

12. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 106 дугаартай шийтгэх тогтоол
13. Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол захирамжууд 2020-2023 он
14. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалууд 2020-2023 оны магадлалууд

Цахим эх сурвалж:

15. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://Legalinfo.mn>
16. Шүүхийн шийдвэрийн цахим сан. <https://shuukh.mn>
17. Шүүхийн ерөнхий зөвлөлийн албан ёсны сайт, Judcouncil.mn

Хянасан:

У.Золжаргал /Улсын ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор/

Б.Мөнхдорж /Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Судалгааны албаны дарга, ахлах прокурор, хууль зүйн ухааны доктор, дэд профессор/

Эмхэтгэсэн:

М.Гансүх /Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Судалгааны албаны прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан-шинжээч/

О.Одонзаяа /Улсын ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан-шинжээч/

“Чөлөөт Хэвлэл Сан” хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Цаасны хэмжээ: 176x250/B5

Хэвлэлийн хуудас: 19 х.х

